МОНГОЛЧУУДЫН ТҮҮХ, СОЁЛЫН АТЛАС

НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШЛИЙГ
СУДЛАХ ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛЧУУДЫН ТҮҮХ, СОЁЛЫН АТЛАС

Анхдугаар хэвлэл

Улаанбаатар хот
2004 он

ДДС
902'517 3
Э-66

*Монголын тулгар төр байгуулагдсаны
800 жилийн ойд зориулав.*

© Зохиогчийн зөвшөөрөлгүй атласын зураг, материалыг ашиглах, хувилж, олшруулахыг хуулиар хатуу хориглоно.

ISBN 99929-5-989-4

Агуулга

I бүлэг
1. Газар зүй, ашигт малтмал, байгаль орчин 8-17
2. Ургамлын нөмрөг, түүнийг хамгаалах өв уламжлал 18-25
3. Амьтны аймаг, ахуйн холбогдол 26-37

II бүлэг
4. Нүүдлийн мал аж ахуй 40-53
5. Малын уналга эдэлгээний тоног, хэрэглэл 54-61
6. Тариалангийн үүсэл, хөгжил 62-73

III бүлэг
7. Эртний хүмүүсийн амьдрал, соёлын хөгжил, археологийн дурсгалууд 76-89
8. Нүүдэлчин монголчуудын дэлхийн соёл иргэншлийн хөгжилд гүйцэтгэсэн үүрэг 90-95
9. Монгол нутагт байсан эртний аймаг, улсууд 96-103
10. Их Монгол улс 104-105
11. Эзэнт гүрэн 106-109
12. XIV зууны хоёрдугаар хагасаас XVII зууны Монгол орон 110-115
13. Манжийн үеийн Монгол орон 116-119
14. XX зууны Монгол орон 120-135

IV бүлэг
15. Хүн ам 138-143
16. Хүн амын угсаатны бүрэлдэхүүн, гарлаас 144-159
17. Хувцас 160-173
18. Гэр, орон сууц 174-179
19. Идээ, ундаа 180-185
20. Тоглоом наадгай, үндэсний спорт 186-193

V бүлэг
21. Театрын урлаг 196-203
22. Дуу, хөгжим 204-209
23. Бүжгийн урлаг 210-215
24. Кино урлаг 216-221
25. Циркийн урлаг 222-229

VI бүлэг
26. Уран зураг 232-241
27. Уран баримал 242-255
28. Гоёл чимэглэлийн урлаг 256-267
29. Ном хэвлэлийн урлаг 268-285
30. Хот байгуулалт, архитектурын хөгжил 286-303

VII бүлэг
31. Гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний өв 306-311
32. Бөө мөргөл 312-319
33. Бурханы шашин, соёл 320-333

VIII бүлэг
34. Бичиг үсэг, хэл аялгуу 336-341
35. Аман зохиол 342-344
36. Хуучны уран зохиол 345-349
37. Орчин үеийн уран зохиол 350-353

Contents

Chapter I
1. Geography, mineral resources and the environment 8-17
2. Flora and tradition for the protection 18-25
3. Fauna and the significance 26-37

Chapter II
4. Nomadic livestock husbandry 40-53
5. Equipment and means for riding and working animals 54-61
6. Origin and development of agriculture 62-73

Chapter III
7. Way of living of the ancient peoples, their cultural development and archaeological evidences 76-89
8. Nomadic Mongols role in the development of the world civilization 90-95
9. Ancient tribes and Nation states 96-103
10. Ikh Mongol dynasty 104-105
11. The Mongol Empire 106-109
12. Mongolia (from 2nd half of 14th century to 16th century) 110-115
13. Mongolia during the period of Manchu 116-119
14. Mongolia in 20th century 120-135

Chapter IV
15. Population 138-143
16. About ethnic groups and their origin 144-159
17. Dressing 160-173
18. Ger and dwellings 174-179
19. The edibles and beverages 180-185
20. National games and the three manly sports 186-193

Chapter V
21. Theatre 196-203
22. Folklore 204-209
23. Dancing 210-215
24. Cinema 216-221
25. Circus 222-229

Chapter VI
26. Painting 232-241
27. Sculpture 242-255
28. Decorative arts 256-267
29. Book printing arts (Publication) 268-285
30. Urbanization and Development of architecture 286-303

Chapter VII
31. Philosophy and heritage of socio-political thinking 306-311
32. Shamanism 312-319
33. Buddhism and its culture 320-333

Chapter VIII
34. Script and Dialectics 336-341
35. Oral literature 342-344
36. Ancient literature 345-349
37. Modern literature 350-353

Товчилсон үгс

МҮТМ	-Монголын үндэсний түүхийн музей	МБТМ	-Монголын байгалийн түүхийн музей
МДУМ	-Монголын дүрслэх урлагийн музей	ДГАМ	-Дундговь аймгийн музей
БХОМ	-Богд хааны ордон музей	МТУМ	-Монголын театрын урлагийн музей
МУЗГ	-Монголын уран зургийн галерей	МЦТМ	-Монголын цэргийн түүхийн музей
ЧЛСМ	-Чойжин ламын сүм музей	ААМ	-Архангай аймгийн музей
УТНС	-Улсын төв номын сан		

Редакцийн зөвлөл

Ерөнхий редактор	**А.Цанжид**
Редакцийн зөвлөлийн нарийн бичгийн дарга	**А.Очир**
Редактор	**Б.Энхтүвшин** **О.Шагдарсүрэн** **Х.Сампилдэндэв** **Б.Сумъяа**
Ерөнхий дизайнер	**С.Уранбилэг**
Гэрэл зургийг	**Э.Амарбилиг**
Хэвлэлийн эх, газрын зургийн зохиогч, редактор	**С.Уранбилэг** **Э.Амарбилиг**

Мэндчилгээ

Монгол нутагт 800 000 орчим жилийн тэртээгээс хүн оршин сууж байсан нь судалгаагаар тогтоогдсон байна. Энэ нь монгол орон бол хүн төрөлхтөний эртний өлгий нутгийн нэг мөн гэдгийг харуулж байна.

Монголчуудын өвөг дээдэс мянга мянган жилээр Төв Азийн их хээр талд идээшин аж төрөхдөө,түүх,соёлын арвин их өвийг түүрвин бүтээжээ. Бэлчээрийн мал аж ахуйг голлон эрхэлдэг монголчуудын соёл нь мэдээж нүүдлийн иргэншлийн аймагт багтана. Тэгэхдээ Ази, Европ хоёр тивийн суурин соёл иргэншлийн завсарт нүүдэллэн аж төрдөг монголчууд суурин амьдрал,хот суурины соёлтой танил байсан. Тэд өөрийн хөрш зэргэлдээ суурин ард түмнүүдтэй түүхийн туршдаа байнга харилцан, соёлын талаар харилцан нөлөөлж иржээ. Монголчуудын тэрхүү гадаад харилцаа нь тэдний соёлыг улам баяжуулж,олон талтай өвөрмөц содон шинж төрхтэй болоход нь дөхөм болдог байжээ. Энэ бүхний үр дүнд Төв Азид монгол иргэншил бүрэлдэн цогцолжээ.

Бид "Монголчуудын түүх, соёлын атлас" хэмээх энэ бүтээлд, монгол орны байгаль,цаг уур,ургамал,амьтны аймаг болоод тэдгээрт зохицон хөгжсөн аж ахуй, соёлын өв сангаас дээжлэн үзүүлэхийг зорьсон юм. Мөн Монголчуудын төрийн түүхэн замнал,төр ёсны уламжлал залгамжлалыг ч атласт тусган харуулахыг хичээв. Тэгэхдээ,монголчуудын олон мянган жилийн түүх,соёлын арвин их өвийг ганцхан атласт бүрэн багтаан оруулах боломжоо мэдээж байхгүй юм. Тиймээс түүхийн нэн чухал үйл явдлууд,соёлын гол гол ололт амжилт,монгол угсаатны хөгжлийн онцлог шинж,ёс заншлын өвөрмөц төрх зэргийг аль болох орхигдуулалгүй тусган харуулах нь атласын зохиогчдын зорилго байв.

Зохиогчид эл зорилгодоо хүрэхийн тулд дэлхийн монгол судлал, болоод монголын түүх, соёлын судлалын ололт амжилттай танилцан, тэдгээрт тулгуурлахын зэрэгцээ Монгол улсын музей,номын сан,архивуудын сан хөмрөгт хадгалагдаж буй эх орны түүх,эдийн боловсрол,утга соёлд холбогдох цуглуулга, дурсгалуудыг олж үзэн,атласт аль болох тусган ашиглахыг хичээсэн билээ.

Мөн атласыг үзэх уншихад цэгцтэй дөхөм болгох үүднээс түүнд орсон зүйлүүдийг агуулгын чиглэлээр нь ангилан,бүлгүүдэд хуваагаад,тэдгээрийг түүхийн он дарааллыг баримжаалан байрлуулав.

Анх удаа "Монголчуудын түүх, соёлын атлас"-ыг бүтээх гэсэн бидний оролдлогод эндэж омтгойдсон зүйл байж болно.

Мэргэн уншигч,эрхэм судлаачид санал зөвлөлгөөгөө бидэнд харамгүй ирүүлж, дараа дараагийн маань ажилд дэмжлэг үзүүлнэ гэдэгт найднам.

ЕРӨНХИЙ РЕДАКТОР, ПРОФЕССОР А.ЦАНЖИД



БҮЛЭГ I

- ГАЗАР ЗҮЙ, АШИГТ МАЛТМАЛ, БАЙГАЛЬ ОРЧИН
- УРГАМЛЫН НӨМРӨГ, ТҮҮНИЙГ ХАМГААЛАХ ӨВ УЛАМЖЛАЛ
- АМЬТНЫ АЙМАГ, АХУЙН ХОЛБОГДОЛ

ГАЗАР ЗҮЙ, АШИГТ МАЛТМАЛ, БАЙГАЛЬ ОРЧИН

Монгол улс Ази тивийн төвд, хойд өргөрөгийн 41°35'-52°06', зүүн уртрагийн 87°47'-119°57'-ийн хооронд байрлаж, хойд талаараа ОХУ-тай 3485 км, өмнө талаараа БНХАУ-тай 4676,9 км-ээр тус тус хиллэнэ. Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 1564,1 мянган кв.км бөгөөд нутгийн баруунаас зүүн цэг хүртэл 2392 км, хойноос өмнө цэг хүртэл 1259 км болно. Нутаг дэвсгэрийн хэмжээгээр дэлхийд 17 дугаарт ордог.



Газрын гадарга. Монгол орон далайн түвшнээс дээш дунджаар 1580 м өргөгдсөн, хамгийн өндөр цэг нь 4374 м Хүйтэн уул, хамгийн нам цэг нь 532 м Хөх нуурын хотгор юм. Нутаг дэвсгэр нь томоохон уул нурууд, толгод, тал, хөндий, говийн үзэсгэлэнт газруудаас бүрдэнэ.

Мөсөн голууд Монгол-Алтайн нэн өндөр уулсад хадгалагдан үлдсэн бөгөөд Хөвсгөл, Хангай, Хэнтэй, Алтайн зарим уулсад мөстлийн хотгор гүдгэр үүссэн байдаг.

Мөн түүнчлэн Хөвсгөл, Увс, Буйр, Хар-Ус, Хар, Өгий, Тэлмэн, Дөргөн, Ачит, Үүрэг зэрэг цэнгэг болон давстай нуурууд, Сэлэнгэ, Орхон, Туул, Дэлгэр, Эг, Чулуут, Ховд, Завхан, Тэс, Хэрлэн, Онон, Халхгол, Улз зэрэг олон тооны гол мөрөнтэй.

Монгол орны нутаг дэвсгэрийн гадарга Сибирийн өмнөд уулсаас Төв Азийн тал газарт шилжих шилжилтийн мужид, умард зүгийн хүйтэн чийглэг уур амьсгалаас өмнө зүгийн хэт хуурай уур амьсгалд шилжих алгуур шилжилтийн нөхцөлд бүрэлдэн тогтжээ.

Монгол орон эх газрын нөхцөлд өнө удаан оршиж байсныг нотлох зүйл бол эрт үед нэгдмэл нэг байсан цэрдийн сүүлч палеогены үеийн уудам тэгш гадарга болон эдүгээ уулсын хоорондох хотгоруудаар дарагдмал байдалтай оршиж буй дээрх гадаргатай чацуу эртний өгөршлийн бүрхэвч бүхий хуримтлалын таларxаг газар юм. Орчин үеийн хотгор гүдгэрийн төрх байдалд тектоникийн идэвхжлийн болон бууралтын үеийн хөдөлгөөн, мөн шинэхэн тектоник хөдөлгөөн ул мөрөө тодорхой үлдээсэн байна.

Манай орны газрын гадаргын онцлог шинж бол юуны өмнө төв хэсгээрээ урагшаа цулхийж тогтсон уул нуруудын нуман хэлбэртэй байрлал бөгөөд энэхүү уул нурууд нутгийн баруун хэсэгт баруун хойшоо, төв хэсэгт өргөргийн дагуу буюу түүнтэй ойролцоо, зүүн хэсэгт зүүн хойшоо чиглэсэн байна. Өөр нэг онцлог гэвэл, Хөвсгөл орчмын хотгороос урагш, гол төлөв Монгол орны дунд хэсэгт голдоч дагасан хэд хэдэн шугам ажиглагдаж буй явдал юм. Тэдгээр голдоч дагасан шугамууд нумласан байрлалтай уул нуруудыг огтолсноор тус улсын нутагт хэд хэдэн том хэсэг газар ялгарна. Тухайлбал, баруунаас зүүн тийш Монгол Алтай, Их нууруудын хотгор, Хөвсгөл орчмын уулс, Хангайн уулс, Орхон Сэлэнгийн бэлчир, Хэнтэйн уулс, Монголын Дорнод тал, Их Хянган гэсэн том муж хэсгүүдийг дурдаж болно.

Өргөлт, суултын эдгээр мужийг ялган тогтоох үндэс бол дэлхийн царцдас болон дээд маантийн давхаргад явагддаг үйл явц юм. Царцдасын зузаан болон геофизикийн бусад үзүүлэлт эдгээр муж хэсэг бүрд үлэмж ялгаатай. Гадаргын энэхүү томоохон хэлбэрүүд тектоникийн хөдөлгөөнтэй холбоотой байдаг бол жижиг хэлбэрүүд нь гол, нуур, салхи, мөсөн голын үйл ажиллагаатай холбоотой.

Монгол орны өнөөгийн газрын гадарга нь байгаль орчин бүрэлдэн тогтох чухал хүчин зүйл төдийгүй байгальтай харьцах хүмүүсийн



① Аймаг байгуулагдсан он
② Нутаг дэвсгэрийн хэмжээ (мян. км²)
③ Улаанбаатар хот, аймгийн төвийн хоорондын зай (км)

	①	②	③
1. Архангай	1923	55,3	453
2. Баян-Өлгий	1940	45,7	1636
3. Баянхонгор	1941	116,0	630
4. Булган	1937	48,7	318
5. Говь-Алтай	1931	141,4	1001
6. Говьсүмбэр	1994	5,54	238
7. Дархан-Уул	1994	3,28	219
8. Дорноговь	1931	109,5	463
9. Дорнод	1931	123,6	655
10. Дундговь	1941	74,7	260
11. Завхан	1923	82,5	984
12. Орхон	1994	0,8	371
13. Өвөрхангай	1931	62,9	430
14. Өмнөговь	1931	165,4	553
15. Төв	1923	74,0	43
16. Сүхбаатар	1941	82,3	560
17. Сэлэнгэ	1931	41,2	311
18. Увс	1931	69,6	1336
19. Ховд	1931	76,1	1425
20. Хөвсгөл	1931	100,6	671
21. Хэнтий	1923	80,3	331
22. Улаанбаатар	1639	4,7	-
Бүгд		1 564,1	

1. Говьсүмбэр аймаг
2. Дархан-Уул аймаг
3. Орхон аймаг



харьцаанаас хамаарч газрын гадарга ч тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж байна. Газар нутгийг эзэмших явцад хүний үйл ажиллагаа нуурын эрэг хавийн нам дор газраас өндөр уулын таг орчмын тэгшивтэр газар хүртэлх бараг бүх хэв шинжийн хоттор гүдгэрийг хамарч байдаг юм. Тэр бүх хэв шинжийн гадарга энэхүү үйл ажиллагааны ачааллыг даахын хувьд харилцан адилгүй тул газрыг эзэмшихдээ нарийн бодож боловсруулсан газрын менежментийн дагуу явуулна.

Ашигт малтмал. Монгол орны нутаг дэвсгэр дээр нүүрс, занар, битум, нефть, өнгөт болон үнэт, ховор металл, уран, фосфорит, хайлуур жонш, үнэт болон гоёл чимэглэлийн чулуу, барилгын материалын үйлдвэрийн эрдэс чулуулаг, газрын доорхи ус, рашаан зэрэг 80 гаруй төрлийн ашигт малтмалын орд илрүүлэн ашиглаж байна.

Манай орны эрчим хүчний үндсэн эх булаг нь нүүрс юм. Томоохон нүүрсний ордуудад Таван толгой, Шарын гол, Могойн гол, Багануур, Тэвшийн говь, Шивээ-Овоо, Цайдам, Адуунчулуун орно. Эдгээрээс Өмнөговь аймгийн нутагт орших Таван толгойн коксжих нүүрсний орд нь нөөцийн хэмжээ, чанараараа улс орны болон бүс нутгийн эдийн засгийн хөгжилд цаашид чухал ач холбогдолтой ордын тоонд орно. Зэс, молибдений 100 гаруй орд илрэл мэдэгдэж байгаагаас Эрдэнэтийн овоо, Цагаансуврагын орд газарт хайгуул явуулж нөөцийг нь тогтоожээ. Эрдэнэтийн ооны зэс, молибдений ордыг ашиглах болсноор экспортын бүтээгдэхүүний хэмжээг ихээхэн нэмэгдүүлэв. Цайр, хар тугалганы 30 орчим орд, илрэл одоогоор тогтоогдсоны дотор Төмөртийн овоо, Цав, Улааны орд томоохон нь болно. Нутгийн зүүн бүсэд орших эдгээр ордыг түшиглүүлэн уул уурхайн үйлдвэрийн цогцолбор байгуулж болох юм. Цагаан тугалганы 10 орчим бүлэг шороон орд, илрэлийн нөөцийг хайгуулын ажлаар тогтоогоод байна. Цагаан тугалганы Баян мод, Элстэй, Авдарант зэрэг цөөн тооны жижиг шороон ордуудыг ашиглаж байгаа бөгөөд харин Нарсан хөндлөн, Оорцог овоо зэрэг нь хүдрийн томоохон ордод тооцогддог.

Манай оронд гянтболдыг 1940-өөд оноос эхлэн Бүрэнцогт, Түмэнцогт, Их хайрхан зэрэг судлын ордоос олборлож байсан. Одоо судлагдсан хамгийн том ордод Өндөр цагааны орд орно. Мөн Монгол орны баруун хэсэгт Улаан-Уул, Цунхэг, Ховд гол түүнчлэн Улаанбаатар хотоос холгүй орших Цагаан даваа зэрэг судлын хэд хэдэн ордууд бий. Алтны 120 шахам хүдрийн болон шороон орд, илрэл тогтоогдоод байна.

Хойд Хэнтэй, Баянхонгор, Эрээн давааны бүс алтны нөөцийн нэлээд хэсгийг агуулж байна. Монголд 1990-ээд оноос алтны шороон ордын олборлолт эрчимжиж, Заамар, Бороо-Зуун мод, Ерөө гол, Хүдэр, Байдраг-Өлзийт гол, Жаргалант, Баруун-Урт, Уянга-Тарагт, Түргэн голын хүдрийн дүүргүүдэд алтны шороон ордын ихэнх нь төвлөрч байна. Хүдрийн томоохон ордод Бороо, Тавт, Бумбат, Цагаан цахир уул, Олон-Овоот багтана. Судалгааны одоогийн түвшинд мөнгөний бие даасан 2 орд болон мөнгө агуулсан холимог металлын нэлээд орд, илрэл тогтоогдоод байна. Мөнгөний нөөцийн үндсэн хэсэг нь Асгат, Мөнгөн-Өндөрийн



ордод ногдоно. Хайлуур жонш манай улсын уул уурхайн салбарын экспортын нэг гол бүтээгдэхүүн бөгөөд түүнийг 1940-өөд оноос эхлэн олборлож байна. Хайлуур жоншны том ордууд Дорноговь, Хэнтий аймгийн нутаг Бэрх, Хар-Айраг, Бор-Өндөрийн хүдрийн дүүрэгт багтаж байна. Манай улс фосфоритын үлэмж их нөөцтэй. Хөвсгөл, Бүрэнхаан зэрэг ордууд нь өөрийн орны хэрэгцээг фосфоритын түүхий эдээр бүрэн хангах боломжтой гэж үздэг. Фосфоритын ордыг байгаль орчинд хор хөнөөл учруулахгүйгээр ашиглах дэвшилтэт технологийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Цагаан цав, Өргөн зэрэг газруудад 20 гаруй цеолитын орд, илрэл олдоод байна. Төмрийн хүдрийн 260 гаруй жижиг орд, илрэл мэдэгдэж байгаагаас Баянгол, Төмөр толгойн орд газарт геологи хайгуулын ажил хийгдсэн. Цаашид төмрийн хүдрийн дунд, бага хэмжээний орд нэлээд олдож болох геологийн зүй тогтолтой бөгөөд өөрийн орны хэрэгцээг төмрийн хүдрээр хангах бололцоотой. Ураны судалгааны өнөөгийн түвшинд Дорнод, Гурванбулаг, Мардайн гол, Нэмэр, Хараат, Нарсын ордуудыг олж тогтоогоод байна. Мардайн гол ордыг ашиглаж байгаа бөгөөд цаашид Хараатын ордыг ашиглахаар судалж байна.



Эрдэнэтийн зэс-молибдений үйлдвэр
(Эрдэнэтийн овооны ордын зэс, молибдены хүдэрт үндсэн ашигт малтмалаас гадна мөнгө бүхий 10 гаруй нэр төрлийн эрдэс агуулагдаж байдгийг тогтоожээ.)



Геологийн зүй тогтол, нөөцийн урьдчилсан үнэлгээ, тооцооноос үзэхэд, ниобий, циркон, бериллий, литий зэрэг ховор элементийн ихээхэн нөөцтэй байх боломж бий.

1990 оноос хойш газрын тосны хайгуул судалгааны ажлыг нэлээд эрчимжүүлж байна. Өнөөгийн байдлаар Зүүнбаян, Цагаан элс гэсэн нефтийн 2 жижиг орд, 10 шахам илрэл мэдэгдээд байна. Цаашид Тамсаг, Зүүнбаянгийн сав, Өмнөговийн нутагт ордууд илрүүлэх боломжтой.

Монгол улсын нутаг дэвсгэр дээр эрдсийн баялгийн дээр дурьдсан голлох төрлүүдээс гадна барилгын материалын аж үйлдвэрийн төрөл бүрийн түүхий эдээр өөрийн хэрэгцээг бүрэн хангах бололцоотой.

Одоогоор мэдэгдээд байгаа ашигт малтмалын орд, илрэлүүд гол төлөв газрын гадаргуу дээр их, бага хэмжээгээр ил гарсан бөгөөд газрын гүнд оршиж байгаа орд, илрэлийг цаашид эрж хайх судалгаа шинжилгээний ажил эрчимжин явагдаж байна.

Байгалийн эрдэс, баялгийг ашиглахдаа байгаль орчноо хамгаалах, байгалийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байх асуудалд ихээхэн анхаарах ёстой.

Уур амьсгал. Газарзүйн байршлын онцлог, газрын гадаргын тогтоц, далайн төвшнөөс дээших өндөршил нь тус орны уур амьсгал бүрэлдэн тогтоход нөлөөлжээ. Мөн түүнчлэн нарны цацрагийн үйл явц бол газрын гадарга орчмын агаарын температурын горимыг тодорхойлдог учраас уур амьсгал бүрдүүлэх бас нэгэн чухал хүчин зүйл болдог. Газрын гадаргад ирэх нарны цацрагийн хэмжээ тэнгэрийн хаяанаас дээших нарны өндөр, түүний гийгүүлэх хугацаа болон үүлшилтээс шалтгаална. Тус орны хэмжээнд нар гийгүүлэх хугацаа өргөргөөс болж төдий л их өөрчлөгдөхгүй, харин үүлшилт хойноос урагшлах тутам мэдэгдэхүйц багасдаг учраас нар гийгүүлэх хугацаа урд зүг рүү нэмэгддэг байна. Үүнтэй уялдаж нарны нийлмэл цацраг өмнө зүгийн нутгаар харьцангүй их байхаас гадна зуны улиралд мөн их байна. Монгол орны нөхцөлд газрын гадаргад ирж байгаа нарны шулуун цацрагийн хэмжээ, сарнимал цацрагийнхаас хавьгүй илүү бөгөөд ийнхүү нарны шулуун цацраг их тусч, цэлмэг өдөр олон байдаг нь нарны эрчим хүчийг улс ардын аж ахуйд ашиглах сайхан бололцоог бий болгодог ажээ.

Агаарын орчил урсгал бол уур амьсгал бүрдүүлэх үндсэн хүчин зүйлийн нэг бөгөөд өвөл манай орны баруун хойт хэсэгт Увс нуурын хотгор дээр төв нь байдаг азийн эсрэг циклон тод илэрнэ. Эсрэг циклоны төв орчимд салхины хүч сул буюу заримдаа огт салхигүй байдаг. Агаарын хөдөлгөөн сул, үүлшилт багатай байдгаас агаар хүчтэй хөрч улмаар хөрсийг гүн хөлдөхөд хүргэнэ. Нимгэн тогтсон цасан бүрхэвч хөрсийг дулаанаа алдахаас төдийлөн хамгаалж чадлаггүй байна. Эсрэг циклоны төвөөс зүүн тийшлэх тутам даралтын зөрөө нэмэгдэж салхины хурд ч бас ихсэнэ.



Манай оронд жилийн аль ч улиралд баруун ба хойд зүгийн салхи зонхилно. Хотгор хонхор газар салхины хурд гол төлөв 1 м/сек-ээс хэтэрдэггүй бол задгай хээр талд 2-5 м/сек хурдтай салхи зонхилно. 15 м/сек буюу түүнээс хүчтэй салхи харьцангуй цөөн тохиолдох бөгөөд давтагдал нь хойноос урагшлах тутам ихсэнэ.

Зун бараг нутгийн аль ч хэсэгт өндрийн түвшин 100 м өгсөх тутам агаарын температур 0,5°-0,6°-аар буурна. Харин өвлийн улиралд хонхор, хотгор, салхигүй хөндийд хүйтэн агаар тогтдогоос шалтгаалан агаарын температурын хуваарилалтын тонгоруу бий болж 100 м өгсөх тутам температур 0,8°-аар нэмэгддэг.

Жилийн дундаж температурын 0°-ын ижил утгын шугам өргөргийн дагуу нутгийн бараг төв дундуур өнгөрч олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархсан нутгийн өмнөд хилтэй давхцдаг ажээ. Энэхүү шугамаас хойшхи нутагт өвөл урт, хахир хүйтэн байх ба газрын хөрс 3-4 м хүртэл гүн хөлдөж, 1 м гүн хүртэлх хөрсний температур өвлийн турш -20°С-аас доош байна. Харин түүнээс урагших нутагт хөрсний улирлын хөлдөлтийн гүн 2,5 м хүрч, -20°С-аас бага температур зөвхөн нэгдүгээр сард 10-20 см хүртэлх гүнд ажиглагдана.

Өвөл хүйтэн агаар тунаран тогтдог хотос хонхор газар хамгийн хүйтэн болж нэгдүгээр сарын хоногийн дундаж температур -35°С хүрнэ. Увс нуурын хотгорт үнэмлэхүй хамгийн бага температур (-50,0°С) тэмдэглэгдсэн юм. Зун Монгол орны өмнөд хэсэгт хамгийн их дулаан болж долдугаар сарын хоногийн дундаж температур +25°С хүрдэг бөгөөд үнэмлэхүй хамгийн их температур (+40,8°С) Сайншандад ажиглагджээ.

Жилийн туршид температурын хэлбэлзэл 50°-60° хүрдэг нь Монгол орны уур амьсгал эх газрын эрс тэс шинжтэй болохыг харуулна.

Тус орны тунадасны хуваарилалт газар нутгийн өндөр, ялангуяа чийг авч яваа агаарын урсгалын замд тохиолддог уулс яаж байрласнаас ихээхэн шалтгаалах бөгөөд Монгол-Алтайн уулст зөвхөн 3000 м-ээс дээш өндөрт жилдээ 250-300 мм тунадас унадаг бол ийм хэмжээний хур тунадас Хангайн нуруунд 2000 м, Хөвсгөлийн уулст 1500 м, Хэнтэйн уулст 1000 м-ээс дээш түвшинд тус тус унадаг байна. Иймд манай орны хамгийн чийглэг нутаг бол Хэнтэй, Хөвсгөл орчмын уулс юм. Монгол орны бүх нутагт зуны хур тунадас давамгайлж жилийн нийт тунадасны 60-70%-ийг бүрдүүлнэ.

Жилийн хүйтэн улирлын бүх хур тунадас цас байдалтай орж 10 дугаар сараас 4 дүгээр сарын эх хүртэл уулс цасан бүрхүүлтэй байна. Ууланд цас хамгийн зузаан байдгаас гадна хамгийн удаан тогтоно. Харин говь, хээрийн бүсэд тогтвортой цасан бүрхүүл бараг үүсдэггүй.

Харьцангуй чийгийн хэлбэлзэлийн хувьд намрыг хаврын улиралтай харьцуулахад төдийлөн өндөр байдаггүй. Хавар агаар илүү хуурайшиж 30% ба түүнээс бага харьцангүй чийгтэй өдрүүд тохиолдох бөгөөд ялангуяа өмнө

зүгийн нутагт байн байн ажиглагдана. Цаг агаарын хувьд тааламжтай жилд ч гэсэн тус оронд чийг хангамж, шаардагдах хэвийн хэмжээний зөвхөн 60-70%-тай тэнцүү байдаг.

Уур амьсгал, цаг агаарын онцлог шинж нь хүний идэвхтэй үйл ажиллагаа, ялангуяа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд таатай болон таагүй нөлөөг үзүүлсээр ирсэн билээ. Манай орны хавар, намрын улиралд олонтаа тохиолдох хүчтэй салхи, шороон болон цасан шуурга нь 1-6 цаг үргэлжлэх бөгөөд цасан шуурга их болдог нутагт 12 цаг хүртэл үргэлжлэх толхиолдол ч байдаг.



Гадаргын ус. Монгол орны гол мөрөн Умард мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамаарна. Умард мөсөн далайн ай савд Монголын хамгийн том гол болох Сэлэнгэ мөрний урсгалын эхэн, дунд хэсэг, манай орны нутгаас эх авдаг Енисей мөрний хэсэг багтана. Номхон далайн ай савын усны сүлжээ түрүүчийнхээс сийрэг бөгөөд энэ ай савд багтдаг томхон голуудаас Их Хянганы салбар уулсын хойт хажуугаас урсдаг Халхын гол, Хэнтэйн нурууны зүүн хажуугаас эх авдаг Хэрлэн, Онон, Улз голуудыг нэрлэж болно. Энэ ай савын хамгийн урт гол нь Хэрлэн боловч жилийнхээ урсацын хэмжээгээр тус орны хамгийн их устай Сэлэнгэ мөрний дараа ордог Онон голынхоос нэлээд бага юм. Монгол орны нутгийн гуравны хоёр орчмыг Төв Азийн гадагш урсгалгүй ай сав эзэлнэ. Монгол Алтайгаас эх авдаг Ховд, Хангайн нурууны баруун хажуугаас урсдаг Завхан, Тэс голууд энэ ай савдаа хамгийн том нь юм.

Үүрэг нуур

Тэс гол (Увсын Алтан элс орчим)

Тус орны усны сүлжээ нутгийн хойд ба баруун хэсгийн уулархаг нутагт нягт тул голын системийн ихэнх нь тэнд бүрэлдэн тогтоно. Нутгийн өмнөд, төв, зүүн өмнөд хэсэгт гол горхи цөөн, ус багатайгаас гадна гадагш урсгалгүй

хотгорт орж замхардаг байна. Байнгын урсгалтай 3800 гаруй том жижиг гол мөрөн урсдаг.

Тур зуурын урсгалтай сайр газар сайгүй элбэг тохиолдох боловч олонхи нь говийн хотгоруудыг хүрээлсэн уул нуруудад үүсч, уртаараа хэдэн арван километр хүрэх ч цөөнгүй бий.

Монголын баруун хэсэг буюу Их нууруудын хотгор, Нууруудын хөндийд Увс, Хяргас, Хар-Ус, Хар, Бөөн Цагаан, Орог, Улаан зэрэг томоохон нуур оршино.

Тогтмол урсгалтай голын сүлжээний дундаж нягтшил улсын нийт нутаг дэвсгэрт 0,05 км/км^2 байдаг бөгөөд гол мөрний урсац бүрэлдэхэд хур бороо, газрын доорх ус, цас, мөсөн голын ус аль аль нь оролцох боловч гол мөрний эх тэжээл болохын хувьд тэдгээрийн үүрэг газар бүр харилцан адилгүй юм. Тухайлбал, Монгол Алтайн голуудын урсацыг бүрдүүлэхэд улирлын цас, мөсөн голын ус зонхилдог бол Хангай, Хэнтэйн голуудад хур борооны ус голлоно. Ерөнхийдөө Монгол орны нутагт хойноос урагшаа, баруунаас зүүн тийш гол мөрний тэжээлд хур борооны усны оролцоо ихэсч, цасны усны урсацын үүрэг багасах явдал нийтлэг юм. Голын тэжээлд газрын доорх усны оролцоо 20-40% байдаг ба ус хураах талбайн дундаж өндөр ихсэх тутам түүний эзлэх хувь багасч, гол мөрний тэжээлд цас, борооны ус зонхилох үүргийг гүйцэтгэнэ.

Монгол орны гол мөрний урсац зуны улиралд их байх боловч сар, улирлын урсацын хэмжээ голын усны тэжээлийн онцлогоос голлон хамаарч нутаг бүрт ялгаатай байдаг. Монгол-Алтайн голуудын жилийн урсацын ихэнх хэсэг 7-8 дугаар сард, Хөвсгөлийн баруун хэсэг, Хангайн баруун хойд хажуугийн голуудад 5-6 дугаар саруудад тус тус бүрэлддэг. Хэнтэй, Хангайн голуудад 5 дугаар сараас урсацын хэмжээ нэмэгдэж хамгийн их нь 7, 8 дугаар сард ажиглагдана.

Манай оронд Хөвсгөл, Увс, Хар-Ус, Хар, Дөргөн, Буйр, Бөөн цагаан, Тэлмэн, Өгий, Ачит зэрэг олон тооны цэнгэг болон давстай нуурууд оршдог. Эдгээрийн гарал үүсэл зэргийг усзүйн зургаас харж болно.

Монгол орны ус үндсэндээ цэвэр тунгалаг учраас ахуйн болон үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах бүрэн боломжтой. Монголчууд эртнээс усыг эрхэмлэн хайрлаж цэвэр ариун байлгах, нөөцийг нь барагдуулахгүй байхыг хичээж ирсэн заншилтай билээ. Орчин үед усыг ашиглахын зэрэгцээ түүнийг хамгаалах асуудал онцгой чухлаар тавигдаж байна.

Хөрс нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Газар зүйн хүчин зүйлийн нарийн төвөгтэй харилцан үйлчлэлийн үр дүнд хөрсний өргөрөгийн дагуух бүсүүд зүүнээс баруун тийш үргэлжлэхдээ зарим газар чиглэлээ өөрчилж, өргөн нарийн болж, уулс урагшаа түрж орсон хэсэг буюу ялангуяа уулаас тал газарт эрс огцом шилждэг хэсэгт тасрах тохиодол ч бий. Уул нуруудын хоорондох хөндий хотгорт уулсын



хормойгоос хотгорын төв руу хөрсөн бүрхэвч өөрчлөгдөж хамгийн хуурай төв хэсэгт нь говь, цөлийн хөрс тогтворжиж хойд өргөрөгийн зарим газраар энэхүү хөрс тархсан нь цөөнгүй үзэгдэнэ. Үүний нэг тод жишээ нь Их нууруудын хотгорын хөрсөн бүрхэвч юм. Хөрсний тархалтыг зургаас харж болно.

Монгол оронд хур тунадас голчлон аадар бороонь шинжтэй ордог, түүнчлэн хүчтэй салхи, шороон шуурга байн байн тохиолддог, ялангуяа өвс ногоо ургаж гүйцээгүй, хөрс хуурай байдаг хаврын саруудад салхи ихтэй тул хөрс эвдрэх үзэгдэл түгээмэл байдаг.

Хөрсөн бүрхэвчийн бүрэлдэн тогтох явцад хүний аж ахуйн үйл ажиллагааны үр нөлөө жилээс жилд улам нэмэгдсээр байгаа тул хөрсний нөөцийг зүй зохистой ашиглаж газраас хамгийн их бүтээгдэхүүн авах зорилтыг шийдвэрлэхдээ хөрсийг нөхөн сэргээх болон бусад хамгаалалтын арга хэмжээг авч явуулах нь зүйтэй юм.

Байгаль орчин. Монгол орон байгаль орчин нь харьцангуй унаган төрхөөрөө хадгалагдаж үлдсэн дэлхийн цөөн орны нэг билээ. Энэ нь монголчууд байгалиас шууд хамааралтай бэлчээрийн мал аж ахуй эрхэлж, түүнтэй зохицсон нүүдлийн аж амьдралын хэвшилтэй байсан нь түүхийн урт удаан хугацааны турш байгалиа эрхэмлэн шүтэж, хайрлан хамгаалж ирсэн онцлог байдалтай нягт холбоотой. Эрт дээр үеэс хөх тэнгэр, хөрст дэлхий, онгон хайрхандаа тахилга үйлдэж байсан нь байгаль дэлхийгээ хамгаалах бичигдээгүй хуультай байсныг гэрчилнэ.

Зарим улс орнуудтай харьцуулахад шинжлэх ухаан, техникийн дэвшлийн сөрөг нөлөөнд тэдийлэн ихээр өртөөгүй, хүн ам цөөн, хотжих үйл явц газар аваагүй байгаа нь төрөлх нутаг усаа онгон ариунаар нь хадгалан үлдэхэд хүргэсэн байна.

Хэдий тийм боловч сүүлийн 60 гаруй жилийн дотор эрчим хүч, уул уурхай, ашигт малтмал олборлох, боловсруулах, барилгын материалын болон мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрүүдийг эрчимтэй хөгжүүлж байгаа нь байгаль орчинд өөрчлөлт оруулж байгаа юм.

Ялангуяа улс орон 1990-ээд оноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих болсонтой уялдан үйлдвэржилт, хотжилтын цар хүрээ тэлж, байгалийн нөөцөд түшиглэсэн салбарын эдийн засагт эзлэх хувь хэмжээ өсөн нэмэгдэх хандлагатай боллоо.

Хүмүүс байгалийн нөөц баялагтай зүй зохисгүй харьцсанаас нөөц нь хомсдож, байгаль орчны чанарыг доройтуулж, улмаар экологийн тэнцлийг алдагдуулахад хүргэж байна.

Төр засгаас монгол орны байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрийг хадгалан үлдээх зорилгоор байгалийн бүс бүслүүрийн үндсэн хэв шинжийг төлөөлөх, ховор, ховордсон амьтан, ургамал бүхий үзэсгэлэн төгөлдөр зарим газар нутгийг дархлан хамгаалах замаар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн

"Бага газарын чулуу" (Дундговь аймаг)

Газрын хөрсөнд учруулж байгаа техногений элэгдэл эвдрэл нь геологи хайгуул, ашигт малтмал олборлолт, зам, барилга, хот байгуулалт зэрэг техникийн үйл ажиллагааны шалтгаанаар үүсч байна.

Баруун тоорийн булаг

сүлжээг өргөтгөх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Улаанбаатар хотын өмнө талд орших үзэсгэлэнт Богдхан уулыг 1778 онд онголон дархалсан бөгөөд энэ нь дэлхийн анхны дархан цаазат газруудын нэг юм.

1994 онд УИХ-аас баталсан "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуулийн дагуу манай улсад улсын хамгаалалтад авах газар нутгийг олон улсын жишигт нийцүүлэн дараах байдлаар ангилжээ. Үүнд:

- Дархан цаазат газар
- Байгалийн цогцолборт газар
- Байгалийн нөөц газар
- Дурсгалт газар зэрэг болно.

Улсын хамгаалттай газар

1.Дархан цаазтай газар	**10494283 (га)**
1. Говийн их (А,Б)	5311730
2. Хөх сэрхийн нуруу	65920
3. Богдхан уул	41651
4. Хасагт хайрхан	27448
5. Хан Хэнтэй	1227074
6. Нөмрөг	311205
7. Дорнод монгол	570374
8. Монгол дагуур	103016
9. Отгонтэнгэр	95510
10. Увс нуурын ай сав	712545
11. Говийн бага (А,Б)	1839176
12. Хорьдол сарьдаг	188634

2.Байгалийн цогцолборт газар	**8274111 (га)**
1. Хөвсгөл	838070
2. Хорго-Тэрхийн цагаан нуур	77267
3. Говь гурван сайхан	2694737
4. Горхи-Тэрэлж	293168
5. Алтай таван богд	636161
6. Хангайн нуруу	888455
7. Хар-Ус нуур	850272
8. Ноён хангай	59088
9. Хустайн нуруу	50620
10. Цамбагарав	110960
11. Сийлхэмийн нуруу	140080
12. Хан Хөхий-Хяргас нуур	553350
13. Тарвагатай нуруу	525440
14. Онон-Балж	415752
15. Тужийн нарс	60000
16. Мянган угалзат	80691

3.Байгалийн нөөц газар	**1964271 (га)**
1. Нагалхаан уул	3076
2. Батхаан уул	21850
3. Лхачинвандад уул	58800
4. Булган гол	7657
5. Угтам	46160
6. Шарга Манхан	390071
7. Загийн-Ус	273606
8. Алаг хайрхан	36400
9. Бурхан буудай	52110
10. Эргэлийн зоо	60910
11. Их нарт	43740
12. Хөгнөхаан уул	46990
13. Тосон хулстай	469928
14. Хар ямаат	50594
15. Яхь нуур	251388
16. Дэвэлийн арал	10300

4.Дурсгалт газар	**79305 (га)**
1. Булган уул	1840
2. Уран тогоо-Тулга уул	5800
3. Ээж хайрхан	22475
4. Хүйсийн найман нуур	11500
5. Ганга нуур	32860
6. Сүйхэнт	4830

Баянбүрдийн овоо

Хоргын тогоо
(Архангай аймаг)

Манай орны онгон сайхан байгалийг хамгаалах нь дэлхийн олон улсын байгууллагын анхаарлыг татсаар ирсэн бөгөөд ЮНЕСКО "Дэлхийн өв"-д дараах газруудыг бүртгэн авсан байна. Үүнд байгалийн дурсгалын хувьд:

- Увс нуурын ай сав
- Говийн их цөл
- Говь Гурван сайхан уул
- Хөвсгөл нуур ба бөө мөргөлтэй цаатнуудын нутаг
- Богдхан уул
- Бурханхалдун уул
- Отгон тэнгэр уул

Түүх соёлын дурсгалын хувьд:

- Хархорум хотын туурь
- Эрдэнэзуу
- Төвхөн хийд
- Харбалгас
- Культегин, Билгэ хааны хөшөө
- Цагаан салаагийн хадны зураг
- Хойд цэнхэрийн хадны агуйн зураг
- Амарбаясгалант хийд зэрэг болно.

Д.Доржготов
С.Уранбилэг

УРГАМЛЫН НӨМРӨГ, ТҮҮНИЙГ ХАМГААЛАХ ӨВ УЛАМЖЛАЛ

Монгол орон Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтэй зэрэг томоохон уул нурууд, хэдэн зуун бээр үргэлжлэх өргөн уудам говь, хээртэй. Уул нуруудын өндөр, байгалийн бүс бүслүүр, өргөргийн хуваарилалт, уур амьсгалын хүчин зүйлс янз бүр, тэдгээртэй зохицож ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, ургамалжлын бүтэц нэн өвөрмөц билээ.

Хүрээлэн буй орчныхоо хэвийн байдлыг алдагдуулахгүйгээр онгон сайхан байгалиа эдүгээ хүртэл хэвээр хадгалж XXI зууны босгоор давж буй дэлхийн цөөхөн орны нэг нь Монгол юм. Байгаль бол нүүдэлчин монголчуудын анхны гол шүтээн байсны дотор мод, ургамал томоохон байр эзлэнэ.

Монголчуудын соёл иргэншил байгаль болон ахуйтайгаа холбоотойгоор бүрэлдэн тогтсон ба түүний дотор ургамалаар баялаг монголчуудын түүх соёлыг хэмжих нэгэн хэмжүүр болсоор ирсэн бөгөөд билэгдэл, ёс заншил, хорио цээр, сургаал, хууль цаазтай нягт холбогдож иржээ.

Монгол оронд 128 овогт багтах 662 төрлийн 2823 зүйлийн дээд ургамалтай. Хамгийн олон төрөл, зүйл бүхий овогт Голгэсэртэн, Буурцагтан, Үетэн, Сарнайтан, Байцаатан, Уалжтан, Холдостон тэргүүтэн орно. Манайд ургамлыг 19 бүлэгт хувааж үзэх бөгөөд эдгээрээс хуурайсуу-чулуусаг, хуурайсаг, чийгсэг ургамлууд зонхилдог.

Монгол орны унаган ургамлууд нь нийт ургамлынхаа 10 гаруй хувийг эзлэх буюу 229 зүйл байна. Завсрын унаган ургамлуудыг нэмж үзвэл 342 зүйл байгаа нь ургамлын аймгийн зүйлийн бүрдлийн 14%-тай тэнцэнэ. Амин хэлбэр буюу биежилтийн хувьд тус улсын ургамлын аймагт өвслөг ургамал (31%), модлог ба модожсон ургамал зонхилдог.

Нийт 59 овгийн 191 төрлийн 445 зүйл хөвд бүртгэгдээд байгаагийн 21 овгийн 135 төрлийн 392 зүйл нь навчит хөвд юм. Тэрбээр ус чийгийг нэгэн хэмд барьж, мөнх цэвдгийг хамгаалахаас гадна ойн дулаан, чийгийн тэнцлийг хадгалснаар модны үр ургаж, цухуйц тарах нөхцөлийг хангана. Буриадууд хөвсгөр зузаан хөвдийг дүнзэн байшингийн жийрэг дулаалганд хэрэглэнэ. Монголчууд эртнээс хүлэр хэмээх зүйлийг түлшиндээ хэрэглэж иржээ. Гол мөрний эх болдог их хөвчид хүлрийн хөвд бүхий бамбалзуур намаг цөөнгүй. Ийм намаг нь хүлрийн болон бусад хөвд, мөн уалж хийгээд бусад ургамлын жил жилд үхсэн хагд болон дутуу ялзарсан үндэснээс тогтоно.

Монгол оронд 53 овгийн 174 төрлийн 930 зүйл хаг бүртгэгдээд байгаагаас 12 зүйл нь Монголын улаан номд орсон байна. Хүхрийн исэлд нэн мэдрэмтгий зарим хаг агаарын бохирдлын хэмжээг тогтоох био-илтгүүр болдог.

Манайд 220 зүйл зэв, 65 зүйл харуу, 60 зүйл гуалах, 40 зүйл

Монгол орны үрт ба үндэс бүхий үрцэрт дээд ургамлын ангилалын үндсэн бүлгүүд тэдгээрийн бүтэц бүрэлдэхүүн

№	Ангилалын нэгж	Овгийн тоо	Төрлийн тоо	Зүйл	
				Тоо	Нийт ургамлын аймагт эзлэх хувь (%)
1	Шивэрс хэлбэртэн	3	4	7	0.2
2	Шивэл хэлбэртэн	1	1	9	0.3
3	Ойм хэлбэртэн	10	15	31	11
4	Нарс хэлбэртэн	3	6	22	0.8
5	Замбага хэлбэртэн	111	637	2754	97.6
	Сарааныхан	25	124	581	20.6
	Замбагатныхан	86	513	2173	77.0
	Дүн	128	662	2823	100

Алаг цэцэгт нуга

Нарсан ой

пероноспор багийн мөөг бүртгэгджээ. Макромицет (уутат ба базидат) мөөг 393 зүйл байгаагаас 247 нь малгайт, 99 нь ур, 31 нь дүлий, 16 нь уутат мөөг болно.

Нийт малгайт ба дүлий мөөгийн 3 хувь буюу 90 гаруй зүйл нь хүрээмэг буюу хээрийн цагаан, чидмэг, хусандай, малиг, далбига буюу хар мөөг зэрэг идэшний мөөгүүд юм. Монголчууд цагаан мөөгийг хүнсэндээ илүү хэрэглэдэг байв.

Түүнээс гадна хөрсөн дэх шимэгч бичил биетүүдийн судалгаагаар 96 зүйл бактер, 60 зүйл актиномицет, 30 зүйл мөөг илрүүлээд буй. Энэ бүгдийг нэгтгэн дүгнэвэл Монголд одоогоор 1 хүрээ, 21 овог, 136 төрлийн 838 зүйл мөөг, 160 орчим зүйл бичил биетэн (бактер, актиномицет) мэдэгдээд байна.

Монгол оронд 10 хүрээний 105 овгийн 288 төрлийн, 1534 зүйл, дэд зүйл замаг бүртгэгдээд байгаагаас ус нуурт 917 зүйл, дэд зүйл цахиур замаг, 388 зүйл ногоон замаг, 192 зүйл хөх ногоон замаг бий. Замгийг хүнс тэжээл, бордоо, эмэнд хэрэглэгддэг.

Ногоолой, носток, спирулина, газрын үс, анкистродесиус, сценедесиус зэрэг замгууд цөөнгүй. Газрын үс нь витаминаар баялаг тул эм, хүнсний зориулалтаар дорно дахинд өргөн хэрэглэж иржээ. Газрын үс замгийг их хэмжээгээр түүж хууль бусаар хил дамжуулан худалдаалах замаар байгалийнх нь нөөцийг багасгасан тул байгалийн ургамлын тухай Монгол улсын хууль хийгээд Монголын улаан номонд оруулсан.

Монгол орон байгалийн хэд хэдэн бүс, бүслүүртэй. Дэлхийн бөмбөрцгийн хойт хагаст тохиолддог ургамалжлын бараг бүх бүс, бүслүүр манай орны нутаг дэвсгэр дээр багтдаг. Жишээ болгон үзвэл Хангайн төв нурууны оройгоос урагш улсын хил хүртэлх хэдхэн зуун километр зайд монгол оронд тохиолддог ургамалжлын бүх бүс, бүслүүрийг үзэж болно.

Монголчуудын түүх, соёл, ахуй амьдрал ургамалжлын бүс бүслүүрийн онцлогтой холбоотойгоор бүрэлдэн тогтсон бөгөөд энэ нь угтаа тэдний амьдралын гол эх үүсвэр болсон мал, түүний бэлчээрийн ургамлын орчинзүй, аминзүйтэй холбоотой юм. Монголчуудын ургамал баялгийг ашиглаж ирсэн анхны бөгөөд хамгийн өргөн хүрээтэй хэсэг нь бэлчээр ба өдгөө Монгол оронд малын бэлчээр тэжээлийн 1000 гаруй зүйл ургамал тэмдэглэгдээд байна.

Монголын говь, цөл, тал хээрийн бүсийг "Говь", түүнээс хойших гол ус, ой бүхий нутгийг "Хангай" хэмээн ялгаж ирсэн нь нүүдэлчин монголчуудын олон зуун жилийн мал маллагааны явцад хэвшиж тогтсон ойлголт бөгөөд энэ нь бэлчээрийн ургамлын бүтэц, бүрэлдэхүүн, шимт чанар, улирлын ялгаатай салшгүй холбоотой.

Хавар болоход Хангайд цөн түрж, улмаар энгэр зэвэр газрын ногоо илүү эрт цухуйна. Агь нүдэлж, яргуй гарна. Бусад олон зүйлийн ургамал энэ үед ургаж эхлэхээс гадна малаа эртхэн ногоолохын тулд Хангай руу нүүдэллэнэ. Жилд талдаа 100-200 км нүүх нь энүүхэнд. Говийн томоохон уулсын бэлээр нутагладаг малчид хавар болоход мөн л дээшээ нүүнэ. Түүнийгээ хангайд гарах гэнэ. Намарших тусам улам соргог бэлчээр хөөж нүүдэллэнэ. Хангайнхан царамд зусна. Таг, царамд малын тэжээлд чухал өлөн, бушилз, шивэлз, бутнуур, ботууль, биелэг зэрэг олон сайхан ургамал бий. Нүүх хугацааг зөвхөн өвс ногооны талхагдлын байдал шийддэг. Хангайд нутагтай малчид уул руугаа өгсөж өвөлжөөлөн, зун нь гол горхины хөвөө дагаж зусдаг нь олон зуун жилийн амьдралаар шалгагдсан нүүдэл юм. Зуны улиралд Монгол

Цагаан харгана

Үд өвс

Цангис



Монгол түрүмэг



орны томоохон гол горхины татамд улалж, шивлээ, сорвоо, голын хиаг, хунчир, шимтэглэй, шимэрс, хүнхээл, өлөнгө, согоовор, гиш зэрэг малын бэлчээрийн олон ургамал ээлжлэн цэцэглэнэ. Намаршаад цэцэгт ургамлууд гандах үед улалж, мөн өлөнгө, голын хиаг, согоовор, сорвоо, бутнуур зэрэг үет ургамлуудын арви ихсэж нэг хэсэгтээ л мал тогтоно. Өвлийн улиралд гол горхи дагаж хөндийн жавар хургах ба уул толгодоо өгсөж энгэр ээвэр газарт л өвөлжихөд бололцоотой болж ирдэг. Хүйтний улиралд нүүдэлчин Монголчууд ямагт дулаан тал буюу говь руу нүүдэллэдэг байсан нь мөн л ургамал ногоо, цаг уууртай холбоотой юм. Хангайд сөл тасарч бэлчээрийн улалж, үетэн тэргүүтэн гандаж хатахын цагт говьд өвс ногоо, цаг агаар бараг зунаараа байдаг нь Монгол орон үнэхээр өргөн уудам, газарзүйн олон бүсийн орон гэлтэй. Энэ үед говьд улаан ба бор бударгана, монгол өвс, түнгэ, ерхөг, шаваг төрөл бүрийн шим тэжээлтэй олон ургамал өвлийн эхэн сар хүртэл ногооноороо байна. Жишээлбэл: Гурван Сайханы Ёлын ам, Сэгс Цагаан Богд уулын Цагаан булагт усны гандбадраа өвлийн дунд сард ногооноороо байдаг.


Мөсөн гол

Дархадын хотгор

Цөлийн хээр

Бэлчээрийг улирлын чанартай төдийгүй сар өдрийн дэг хуваарьтай ашиглаж иржээ. Таван хошуу малынхаа онцлог, цаг агаарын байдалд нийцүүлэн бод, бог малын хээл нь хүндэрсэн үеийн, ядарч тамирдсан хийгээд төл малын бэлчээр хэмээн зааглан ашиглаж ирсэн нь нүүдлийн мал аж ахуйн нэг өвөрмөц онцлог, бэлчээрийг муудуулалгүйгээр олон жил тасралтгүй эдлэх шалгарсан арга байлаа. Монголчууд хэдий үед ямар малд юу идүүлэхээ сайн мэднэ. Зуны улиралд тарваган шийртэй газар мал бэлчээрлүүлэхээс дөлдөг бол зуны адаг сараас хавар хүртэл чухам ийм газар мал сүргээ адуулдаг нь хамгийн ердийн хэрэг бүлгээ. Хонь ахарлахаас өмнө хонийг хялгана их шивээлсэн газар бэлчээрлүүлдэггүй, ногоо цухуйх үед шүдэн цагаан, хорон ортууз, дэрсэн хор ихтэй газар мал хариулдаггүй, харгана цэцэглэх цагаар харганагүй газар өвөлжсөн тэмээг байлгадаггүй.

Өнгийн цэцэг алагласан өндөр ургацтай хэсэг газрыг ч болов "ширдэг", "тохой", "хөнжил" хэмээн нэрийдэж, нүдний цөцгий мэт хамгаална.

Монголчууд түүхэн урт хугацаанд ой мод, түүний баялагтай хүйн холбоотой байж ирсэн ба ахуй, зан заншил нь нэн ялангуяа ой модтой холбоотойгоор ихээхэн хэлбэршиж тогтсон байна.

Монгол орны ой мод үндсэндээ уул нуруудыг дагаж ургах бөгөөд ой-ургамалжлын тархалт, бүтэц бүрэлдэхүүн ихээхэн өвөрмөц онцлогтой юм. Тухайлбал, Хангайн нурууны ой д.т.д. 1700-2300 м (өмнөд салбар уулст 2600 м)-т буюу 600-900 м-ийн хэмжээтэй өргөн бүслүүр үүсгэж байхад Хэнтэйд д.т.д. 650-2200 м-т буюу бүтэн хагас км-ийн хэмжээтэй өргөн зурваст тархах бөгөөд бие биеэс ялгагдах дэд бүслүүрүүдийг үүсгэдэг.

Цармын ой, тайга, тайгархаг ой, тайгажуу ой гэсэн дэд бүслүүрүүд байдаг ба дээд зах орчмын зурвас ойг "цармын ой" гэж Монголчууд нэрлэж ирсэн ба унах хур тунадсыг жигд тогтвортой барьж хуваарилах, зохицуулах талаар үнэлж баршгүй ач холбогдолтой. Гол горхины эх нь чухамхүү энд байдаг учир цармын ойн экосистем нь экологийн хувьд нэг улсын төдийгүй олон улсын хэмжээний ач холбогдолтой юм. Тэрчлэн ан амьтны орогнон байрших ая тухтай орчин болдог. Энэ бүслүүрт баавгай ичээгээ засаж, гахай өвөлжиж, хүдэр байнга амьдарч, буга ид халууны үед байрших дуртай. Цаатан ард түмэн чухам энд л амьдран сууна. Энд хаг, хөвд ихтэй бөгөөд цааны гол тэжээл нь хөрсний төрөл бүрийн хаг байна. Түүнийг цаатан ард "шулан" хэмээнэ.

Хөх яргуй

Цармын ой

Алаг баашир

Цармын ойгоос доош хөвч тайга үргэлжлэх бөгөөд бүр зах руугаа мод нь сийрэгжиж аажмаар хээртэй залгана.

Сэгсгэр яргуйжин

Шар яргуй

Жамъянмядаг

Ортууз

Гол гэсэр

Зожир өвс

Тайжийн жинс

Хэнтэй, Хангай, Монгол-Алтайн нурууны захын салбар уулсаар ой, уулын хээртэй зүй ёсоор ээлжлэн солигдож, харилцан хосолсны улмаас уулын ойт хээр гэж нэрлэгдэх хоёрдмол шинжтэй завсрын бүслүүрийг буй болгоно. Энд модод арвин үрлэсэн үе хийгээд цаг уурын тохиромжтой нөхцөл давхацсан жилүүдэд хээр рүү ой мод тэлэн ургах нь бий.

Монгол орны ойг үүсгэгч гол мод нь шинэс, хуш, нарс, хус бөгөөд Хэнтийн баруун хойд хэсэгт гацуур, жодоо бага хэмжээний ой үүсгэнэ. Жодоо бол нарсны овгийн үзэсгэлэнт мод бөгөөд нутгийнхан (дархадууд) жодоог "жоо мод" хэмээнэ. Түүнийг эрт үед "үхэр арц" гэж нэрийдэж байсан нь "Нууц товчоо"-нд үлджээ.

Жодоон тайгын үлдмэл шинжтэй хэсэг бусаг ойн бүлгэмдлүүд Хэнтэйн баруун хойд хэсэг, Хөвсгөлийн бүс нутгийн баруун үзүүрт байдаг нь Монгол орны хувьд ховорт тооцогдоно. Иймээс жодоог "Монгол улсын улаан ном"-д оруулжээ.

Монголчууд эртнээс модыг өргөн хэрэглэж байсан боловч ахуй амьдралын хэрэгцээнээс хэтрүүлж байгаагүй.

Томоохон гол мөрнийг дагаж бургас, улиасан шугуйтай. "Нууц товчоо"-нд Туулын хар шугуй, ой шугуй гэсэн нэрүүд нэлээд байгаа нь Монгол оронд эртнээс бургас улиас арвин ургаж байсны тэмдэг бөгөөд монголчууд тэдгээрийг цэрэг дайны болон ахуй амьдралын хэрэгцээнд өргөн ашиглаж байжээ.

Монголчууд, нэн ялангуяа модгүй газрынхан хэсэг хэсэг бургас, түүний ганц нэг бутыг мод хэмээн хүндэтгэхийн сацуу огт оролдож хөндөж болохгүй хэмээн шүтэж ирсэн байна. Бургасыг монголчууд "монгол мод" гэдэг нь түүний их тархац, өргөн хэрэглээнээс уламжлан гарсан нэр болов уу.

Монголчууд гэрийн модыг шинэс, нарс, бургасаар, хашаа, саравч, тэрэг, чаргыг гол төлөв шинэсээр, авдар сав, ширээ сандал, тавиур зэргийг нарс, хушаар, эмээл болон багажны ишийг хусаар, цай нүдэх уурыг улиасаар хийдэг байв. Түлшинд голдуу хөгшин юмуу шатсан мод, унанги, хуурай гишүүг цэвэрлэх журмаар сонгож, хуурсан холтос, хатаад ойчсон найлзуур салааг (шавдуул) гал асаах төдийд ашиглаж иржээ.

Модыг тайраад хожуул дээр нь хуруу зузаан шороо битүү тавьдаг. Учир нь модны огтолсон хожуулаар дамжин газрын чийг ууршиж хөрс хуурайшина гэж үздэг байв.

Хусанд аянга буудаггүй. Иймээс гэрийн багана, бороотой үед хэрэглэдэг өрхний цондог зэргийг хийдэг. Түүнчлэн уурганы хусыг гүн ойгоос, үзүүрийг нь өтгөн шугуйгаас, тэрэг хийх модыг нарлаг чийглэг задгай газраас авч заншсан ахуйн уламжлалтай. Мөн хусыг ихэд хүндэтгэн үздэгийн нэг илрэл бол түүний үйсэн дээр бүр эртнээс үсэг ном бичиж байсан явдал юм. Мод бутыг хэрэглэх тодорхой зорилго, хэмжээ, цаг хугацааг нь бусад үед хөндөхийг хориглосон хориг даруй мөн.

Тэрчлэн ойролцоо байх бургасны оройг холбон уяж бүрээд сууц болгосныг "эмбүүл" хэмээнэ.

"Нууц товчоо"-нд гарч байгаа модлог ургамлын хийгээд модон эдлэл, багаж хэрэгслийн нэрээс үзвэл монос, цөөрс (жодоо), хайлаас, Кохын бургас, саарал бургас, цагаан яргай, хус, нарс модны талаар бичиж тэмдэглэжээ.

Нарс, хуш, арцыг ариун мод гэж үзэж үндэс ишээр нь халбага, цацал, морины хусуур, хөөрөг хийдэг байна.

Жодоо

Анис

Тэхийн шээг

Нохойн хошуу

Тошлог

Ой тайгад анис, нэрс, үхэр нүд, далан хальс, хад, мойл, долоогоно, улаалзгана, гүзээлзгэнэ, нохойн хошуу зэрэг олон зүйлийн жимст ургамал байх бөгөөд Монголчууд эртнээс хүнсэндээ өргөн хэрэглэж иржээ. Самар, жимсийг боловсорсон үед нь түүж, мод бутанд ямар ч гэмтэл үзүүлдэггүй. Самар түүх хугацааг түрүүчийн боргоцой салхинд унах үеэс тооцож, гувар ишийг нь эсгийгээр зөөлөвчилсний дараа модоор түншиж боргойцой (шошгой)-г буулгана.

"Нууц товчоо"-нд үр жимсийг ахуй амьдралдаа эртнээс ашиглаж байсныг илтгэж "Онон мөрнийг өгсөж уруудаж, олирс мойлыг түүж явж ..." гэж бичсэн нь бий.

Нүүдэлчин соёл иргэншилд хүний үйл ажиллагаа ямагт байгалийн тэнцлийг барих, хүрээлэн буй орчинд экологийн хохирол учруулахгүй, ая тал алдахгүй, аль болохоор харилцан зохицоход чиглэгдэж иржээ. Монголын тулгар төр байгуулагдснаас хойшхи олон хууль цаазын бичигт мод ургамлыг хамгаалах талаар оруулсан байдаг. Анх "Их засаг" хууль гарган байгаль орчин, ан амьтнаа хамгаалах журам мөрдөж эхэлсэн.

"Хүрээний ойр малын хар цагаан зүс ялгах газраас дотогш нойтон мод, мөчир хугалж огтлохыг хориглох" заалтуудыг "Халх журам" хуульд тусгажээ. Хэн хүн нүүсэн нутгийнхаа галыг унтраа, эс унтраавaас шүдлэн морь ав (Халх журам).

Түүхэн уламжлалдаа үндэслэн ой мод, түүний баялгийг хамгаалж байсан бодит жишээ бол Богдхан уулыг 1778 онд, Хан Хэнтэй, Отгонтэнгэр уулыг 1819 онд тус тус дархалжээ. Одоо үед дэлхийн хэмжээнд 1000 гаруй дархалсан газар тэмдэглэгдсэнээс 1861 онд дархалсан Францын Фонтенбог хамгийн анхных гэж тооцсон байдаг. Гэтэл түүхэн сурвалжаас харвал монголчууд 1778 онд Богдхан уулыг албан ёсоор дархалсан тул түүнийг дэлхийн ууган дархан газар гэж үзүүштэй.

Монголчууд ой мод, түүний баялгийг зан үйлийн болон цээрийн өвөрмөц хэлбэрээр хэрэглэж, хамгаалж ирсэн болно.

Ургамлын аливаа нэр газарзүйн нэр болохдоо уг ургамлын элбэг, эс бөгөөс тун ховор, мөн тухайн нутгаас өөр газарт байхгүй тохиолдлыг ургаж байгаа цөөн мод ургамлыг олон болохыг билэгдэн Хайлааст, Зуун модны ам, Мянган тооройн булаг гэх мэт нэрлэх нь бий.

Сондгой ургасан хийгээд сонин хэлбэр дүрс бүхий мод (удган)-ыг эртнээс тайн шүтэж ирсэн бөгөөд Монголын нууц товчоонд "Саглагар мод" нэрээр гардаг.

Саглагар мод нь ой захалсан сондгой мод бөгөөд түүнийг тайж шүтдэг нь ойтой талбайг багасгахгүй гэсэн хэрэг. Монголчууд бусдаас онцгой төрх хэлбэртэй, ганц нэг модыг эртнээс тахин шүтэж, тэнд уламжлалт баяр ёслолоо тэмдэглэж байсан тухай хууч домог зан үйл хэвээр билээ. Жишээлбэл: Сэлэнгийн "Авгай мод", Архангайн

Тоорой

Гүзээлзгэнэ

Далан хальс

"Зуун салаа мод"-ыг аян замын хүмүүс шүтсээр байна. Нэжгээд мод, цөөн хэдэн бут, бяцхан төгөл, өчүүхэн шугуй "Зуун мод" тэргүүтнийг хөндөх нь ихээхэн алдас болно гэж үзнэ.

Хавар мод ногоорч эхлэж байх үед нойтон мод огтлохыг хориглоно. Энэ үед хөрсний чийг ус хөөрч байдгаас хөрсний ус ууршин орчныг хуурайшихаас болгоомжилсон цээр юм. Ташуурын хэмжээнээс илүү буюу таван баримаас илүүтэйгээр ташуурын мод авдаггүй. Мөн бут, ургамал ногоо, жимс жимсгэнэ, мөөг тэргүүтнийг хэрэглэх цаг хугацаа нь болоогүй юм уу, өнгөрсөн үед авдаггүй, хэрэглээнээс илүүг түүдэггүй, үндсээр нь хугалдаггүй заншилтай.

Хүрээний ойр сүм дуганы бараа харагдаж малын бараан бүгээн зүс ялгаран дун бүрээ, хэнгэрэг цангийн дуун сонсогдох газраас дотогш хуурай ба нойтон мод огтолж, мод бутны мөчир хугалах, хөрс газар төнхөж хөндөхийг хориглодог байв.

Галтай холбоотой бүх зан заншил нь хээрийн бэлчээр, ой модыг түймрээс хамгаалахтай дам ба шууд холбогдоно. Хээр гал түлэхээр бол элсэрхэг сайр, цулгай газар, хавтгай том чулуун дээр тусгай хашлага хаалттай, байнга манаатай байлгана.

Мөнгөн дэгдэнэ

Ягаан цээнэ

Аянчин, жинчид, нүүдэлчид гал түймэр гаргах вий гэж цогтой үнс нурмаа шороогоор сайн дарж унтраагаад түүн дээр базаж мушгисан өвс (хялгана) тавиад түүнийгээ чулуугаар дарж орхин түймэр тавиагүйгээ баталгаажуулдаг.

Үнсийг зөв асгах үйл, түүнтэй холбогдсон цээрүүд нь түймэр тавихгүй байхад бүрэн чиглэгдэж байв. Үүнд:

-Нурамтай үнс асгадаггүй, заавал хөргөж цогийг нь унтрааж баймаажаа асгана.

-Үнсийг дамжилж асгадаггүй, яагаад гэвэл хоёр хүний алхаа нийлэхгүй үед үнс нурам савирдаг. Үнс хөнгөхөн байдаг учир чадал нь барагдсан, ядарсан хүмүүс үнсийг дамжилдаг юм гэсэн ёгт утгаар тайлбарладаг боловч энэ нь үнэн чанартаа түймрээс болгоомжилсон хэрэг даруй мөн.

-Үнсийг үдэш асгадаггүй. Энэ нь шөнө түймэр гарвал унтаж байгаа хүмүүс түймрийг анзаарч мэдэлгүй газар авахуулахаас сэрэмжлүүлсэн хэрэг болой.

Арцны урыг төл малд сайн гэж ханын толгойд өлгөдөг. Энэ нь фитонцид их ялгаруулж төл малд өвчин тахал үүсгэгч нянг устгадаг-тай холбоотой аж. Загийг тэнгэрийн дуу, салхи шуурга, төл малд сайн гэж зангилааг нь тооно ханын толгойд зүүж эсвэл гэр дээрээ тавьдаг.

Агчаахай

Гэзэг цэцэг

Ванжингарав

1272-1297 онд Хубилай хааны дэргэд 17 жил Монголд байсан Италийн жуулчин Марко Поло өөрийн тэмдэглэлдээ "Монголчууд өртөө замын хоёр хажуугаар мод тарьсан нь зуны халуунд сүүдэртэй, өвлийн цагт зам алдаж төөрөхгүй таатай юм" гэж бичсэн байдаг нь байгалиа хамгаалан, мод ургуулж байсны баримт юм.

"Хажуу газар ургана гэдэг нь
Хайлаас модны жам юм гэж
Монголчууд энэ модны орчинзүйг дуундаа нарийн тодорхойлжээ.

Түшээтхан аймгийн Түшээтханы хошууны (одоогийн Булган аймгийн Гурванбулаг сум) Өвгөн хийд, Түшээт вангийн хошуу (Дундговь аймгийн Сайхан-Овоо сум)-ын Барим лам Дамцагдоржийн хийд, Говьмэргэн вангийн хошууны (Дорноговь аймгийн Хөвсгөл сум) Цуурайгийн хийдүүдийн туурин дээр одоо ч таримал хайлааснууд ургаж байна. Үүнээс үзэхэд заримыг нь 200 шахам жилийн тэртээгээс тарималжуулжээ.

Ургамал баялгийг ашиглахдаа Монголчууд олон зарчим баримтладаг.

Модожсон үндсийг нь гэмтээхгүйн тулд уулын сонгино, мангир тэргүүтнийг мушгиж түүдэг бол гоёог толгойноос нь доош 3 үеэс хэтрүүлэлгүй ухаж авдаг.

"Эх булингартай бол адаг нь ..." гэсэн зарчмыг хатуу баримтлан горхи булгийн эхэнд шав тэмдэг тавьж, модон овоо босгож сэргийлсэн байдаг. Монголд ургадаг 1000 шахам зүйл эмийн ургамалын 200 гаруй нь орчин үеийн анагаах ухааны эмнэлэгт хэрэглэгдэнэ.

Хүнсний болоод техникийн ургамал тус бүр 200, витаминт хийгээд эфирийн тост ургамал тус бүр 250, кумаринт 60, будагт 125, эдээлэгч бодист 150, флавоноидот 230, апколоидот 280 зүйлээс гадна чимэглэлийн 100, хот суурин цэцэрлэгжүүлэх ба элс тогтоож хөрс бэхжүүлэгч ургамал тус бүр 60 гаруй бий.

Элсний нүүдлээс болгоомжлон элсэрхэг газрын бут, шаваг, элсний суль сульхирыг хүйгээр түүж болохгүйг үр хүүхэддээ сануулсаар ирсэн сайхан уламжлалтай билээ.

Хэн хүнийг эмийн ургамалд хүргэдэггүй, энэ нь зөвхөн эмч домч нарын хэрэг байлаа. Эмийн ургамлын үндсийг ухаж аваад хөрс газрыг нь заавал тэгшилж дагтаршуулдаг.

Вансэмбэрүү

Их саадган цэцэг

Чацаргана

Шар саадган цэцэг

Эм биежин



Тарваган шийр

Их Саадганцэцэг (задын ягаан), Вансэмбэрүү тэргүүтнийг задынх хэмээн нэрлэж, түүнийг авахад хүрвэл эрх мэдэл бүхий хүмүүс уншлага тарины хүчээр уул усны эздийг аргадан учирлаж майхан жодгор барьж баймаажаа сая нохойгоор татуулж тэнгэрт үзүүлэлгүйгээр түүдэг аж. Эх орны ургамал баялгийг энэ мэт хямгадаж ухвар мөчид хүмүүс, наймаачдаас хамгаалж ирсэн түүхтэй билээ.

Ч.Дугаржав
Г.Цэдэндаш
Ч.Санчир
Э.Амарбилиг

АМЬТНЫ АЙМАГ, АХУЙН ХОЛБОГДОЛ

Өнө эртнээс монгол газар нутаг дээр амьдарч ирсэн манай ард түмэн өөрийн орны амьтны аймгийн баялагийг ахуйн хэрэглээ, уламжлалт анагаах ухаандаа ашиглан, тэдгээрийг танин мэдэж, арчлан хамгаалж, тэжээн, өсгөн үржүүлж, ан авд ашиглаж иржээ. Түүгээр ч барахгүй нэрлэж, ангилж ирсэн түүхэн уламжлалтай.

Мал маллан, нүүдэллэж байх эрт үеэс оршин буй нутагт тохиолдож байсан элдэв амьтан, хүмүүсийн хооронд биологийн олон янзын мэдээлэл солилцсоор ирсний зэрэгцээ, эерэг ба сөрөг байдлаар амьдрал ахуйд холбогдсоор өдгөө хүрсэн байна. Айлчин гийчэн ирэх, чоно нохой гүйхийг шаазгай шагшрах, хэрээ гуаглахаас авахуулан мэдэж байсан нь үүний нэг тод жишээ мөн. Байгаль хамгаалал иж бүрнээр нь явуулах ажил монголчуудын дунд эртний уламжлалтай. Өнөө бид өөрийн улсынхаа ихээхэн нутгийг цогцолбор газар болгон хамгаалах ажил зохион байгуулж байна. Гэтэл одоогоос 400 орчим жилийн тэртээ хамгаалагдсан Богдхан уул нийслэл хотын дэргэд дүнхийн оршсоор байгаа бөгөөд тэнд баавгай, чоно, гахай, булга, буга согоо гэх зэрэг олон зүйлийн амьтан хамтдаа хамгаалагдаж байсан нь саяхан.

Түүхийн эрт үед монголын умард ой мод, уул нуруу ихтэй нутгуудад ан агнуур голлон эрхэлдэг нүүдэлчид амьдардаг байсан тухай ном зохиолд бичигдсэн байдаг. Тэдгээрийг голчлон мал малладаг байсан өмнөд нутгийн иргэдээс ялгаварлахын тулд "ойн иргэд" хэмээн нэрлэж байсан байна. Энэ үе манай эриний X зууны орчмын цаг хугацаанд хамаарна гэж бодвол монголчууд өнө эртнээс ан амьтныг амжиргааны нэг үг сурвалж болгон ашиглаж байсан нь тодорхой байна. Тийм учир манай ард түмэн амьтныг зөвхөн таниад зогсохгүй нэршүүлж, нэг зүйл амьтны эр охин, нас хүйсний ялгаагаар нь тусд нь нэрлэж байжээ. Жишээлбэл: тарвагыг гэхэд л бие гүйцсэн эрийг бурхи, бие гүйцсэн эмийг тарч, бие гүйцсэн хөхүүл эмийг нагай, нэг настайг мөндөл, хоёр настайг хотол, гурван настайг шархацар гэх мэт олон янзаар нэрлэдэг. Ийм маягаар агнуурын болон хүнтэй ойр амьдрах олон амьтан нэрлэгдсэн нь монголчуудын ан амьтны талаар өргөн мэдлэгтэйн нэг гэрч юм.

Үүнээс гадна Чингис хааны төр, улсын үйл амьдралын тухай түүхэн баримтыг агуулсан "Нууц товчоон" хэмээх алдарт зохиолд монголчууд загас, шувуу, хөхтөн амьтдыг хэрхэн агнаж, үржүүлж, аж амьдралдаа ашиглаж байсан талаар олон сонирхолтой мэдээ баримт өнөөдрийг хүртэл хадгалагдаж иржээ.

Ан ав бол зөвхөн хэрэглээний зүйл байгаад зогсоогүй тэр үеийн монголын дайчид, цэргийн бэлтгэл сургуулилтад онцгой үүрэгтэй байсан юм. Нум сум харвах ур чадварыг дээшлүүлж давхиут дунд цэцэн мэргэн онох, морийг эрэмгий унах, морин дээрээс ташуураар чоныг хоншоор цохих зэргээр цэрэг эрсийн байлдааны ур чадварыг дээшлүүлэхэд ан авыг чухалд тооцож байжээ. Энэхүү ан авын үе эрчүүдийн хийморь сэргэн дайн дажны дараа алжаал тайлж амрах, байлдах байнгын бэлтгэлтэй байх боломж олж байсан. Эртний монголын хаад, эрхэм дээд түшмэд орд харшийнхаа дэргэд амьтан үржүүлэх газар, усан сан байгуулах зэргээр хотын гоо сайхныг нэмэх, дэлхийн амьтны аймагтай танилцах, өөрийн орны амьтныг үржүүлэх ажлыг зохион байгуулж байжээ. Жишээлбэл: Хархорум хотын туурин дээр эртний хотын хиймэл нуурын үлдэц бий бөгөөд тэнд хун, галуу, нугас зэрэг олон зүйлийн усны шувууд сэлэн зугаацаж, хүмүүсийн нүдийг хужирлаж байсан тухай олонтаа өгүүлдэг. Мөн өнгөрсөн зууны эхээр Богд хаант улсын үед хааны ордны дэргэд амьтны хүрээлэн ч байсан билээ.

Богдхан уул

Чонын авд

Сүүлийн хагас зуун жилд зохиогдсон судалгааны эцсийн дүнд түшиглэн тооцоо хийж үзвэл, одоогийн байдлаар монгол оронд 146 зүйл хөхтөн, 457 зүйл шувуу, 22 зүйл хэвлээр явагч, 8 зүйл хоёр нутагтан, 74 зүйл загас, бусад олон төрлийн амьтад байгаагаас зөвхөн шавж гэхэд 20 шахам мянган зүйлтэй гэж үздэг.

Эдгээр олон янзын амьтдыг ашигтай, ашиггүй хэмээн үзэх, тэдгээрийг яаж ашигладаг талаар бичье гэхэд энэхэн жижиг тоймд багтаахад бэрх. Иймээс монголчууд эдгээр амьтдаас ихээр ашиглаж хэрэглэж байсан ба онцгойлон үздэг амьтдын тухай арай дэлгэрэнгүй сийрүүлэн өгүүлэв.

Монгол түмний хамгийн сайн мэддэг амьтан бол сүүгээр бойжигч буюу хөхтөн амьтан. Зуу гаруй зүйлийн хөхтөн амьтад хэрэглэгдэх байдлаараа амьдралд маш олон талын холбогдолтой. Манай ард түмэн сүүгээр бойжигч амьтнаас сайн чанарын арьс, махан бүтээгдэхүүн олзворлон авдаг. Тэдгээрийн дунд мөн эмчилгээний ба гоо сайхны ач холбогдолтой түүхий эд өгдөг амьтан байхын зэрэгцээ хөдөө аж ахуй, агнуурын аж ахуйд хор нөлөө бүхий амьтан ч олон бий.

Монгол орны амьтны аймгийн талаар, монголчуудын ан амьтантай хэрхэн харьцаж ирсэн тухай эрт үед манай орноор аялан жуулчилж явсан харь орныхон сонирхолтой мэдээ баримт олныг үлдээсэн. Хааны ордны дэргэд 1252-1295 онуудад амьдран сууж асан Вильгельм Рубрук, Марко Поло нар монголчуудын амьд байгальтай, тэр дундаа ан амьтныг хэрхэн авлаж, хамгаалж байсан тухай түүхэн чухал баримтуудыг бичиж үлдээсэн нь бий. Тэднээс хамгийн чухал нь тэр үед Европ дахинд байгаагүй учир гайхагдаж байсан Чингис хааны "Их засаг" хуулин дахь ан амьтан, агнаж ашиглах тухай заалт юм. Уг хуулийн тэрхүү заалтыг хөрвүүлбэл: "Хаад ноёд, хэн боловч ан амьтад үржиж төрдөг III сараас X сар дуустал хугацаанд туулай, буга, шоо буга, зээр гөрөөс агнахыг хориглоно" хэмээжээ. Энэ нь монголчуудын байгаль хамгаалах сэтгэлгээний өв уламжлал төдийгүй байгальтай харьцах соёл эртний уламжлалтай болохыг харуулна.

Монгол орны амьтны аймгийг шинжлэх ухааны үүднээс судлах ажил XYIII зууны эцэс буюу Оросын газар зүйн нийгэмлэгээс Төв Азийн байгаль, нийгмийн үзэгдлийг судлах зорилготой зохиогдож байсан олон удаагийн хайгуулын шинжилгээний ажлуудаас эхлэлтэй гэж үздэг. Тэдгээрээс онцгой байр суурийг Н.М.Пржевальский, П.К.Козлов нарын удирдлагаар зохиогдсон хайгуулын шинжилгээнүүд эзэлдэг юм. Энэ бүх үйл ажиллагааны төрөлд А.Г.Банниковын оруулсан хувь нэмэр бусдаас товойн харагддаг. Тэр цагаас хойш XX зууны дунд үе хүрч байж Монгол орны амьтны аймгийн судалгаа ихээхэн өргөжсөн бөгөөд монгол эрдэмтэд уг судалгааны ажилд гар бие оролцон түрж орж ирсэн байна.

Булган нударгатай дээл

Булган хүрэм

Хөхтнөөс юуны өмнө махан идэшт амьтан монголчуудын аж амьдралд олон талаар холбогдсоор иржээ. Махан идэштнүүдийн дунд 12 зүйл суусар байдаг. Тэд цөм үнэт арьстай. Монгол оронд Хэнтэйн хар, хөвсгөлийн хүрэн булга тархан амьдардаг. Эрт цагаас булгыг өргөн агнаж ихэс дээдсийн малгай титэм хийхэд ашиглагдаж байв. Суусрынхнаас халиу ихээхэн үнэт арьс үстэй амьтан тул дээр үеэс хомхойгоор ашигласны дүнд одоо эрс ховордсон амьтны тоонд ороод байна. Халиуны үс өтгөн ноолууртай, шигүү учир түүний арьсыг үнэт үслэг ангийн арьсны хамгийн дээдэд тооцон "жишиг" болгон үздэг. Өөр нэг онцгой бүтэцтэй суусар бол мангис буюу дорго болно. Түүний бие бүтэц бусдаас өөр намар их таргалдаг учир өөх махыг нь хүнсэнд ашиглахын зэрэгцээ өөх, тосыг нь хүний бие түлэгдэх, шархлаанд түрхэж хэргэлэхийн хамт ходоод гэдэсний гаралтай зарим эмгэг өвчнийг анагаах зорилгоор дотор өөхийг хайлж уудаг байсан байна. Сүүлийн үеийн судалгаагаар доргоны өөхөнд ханаагүй тосны хүчил их агуулагддаг болох нь тогтоогджээ. Ийнхүү ард түмний хэрэглэн заншсан энэ тосны эд эсийг сэргээн анагаах чанар шинжлэх ухааны үндэслэлтэй болжээ.

Дорго

Хадны суусар

Баавгай

Говийн мазаалай

Халиу

Булган малгай

Махчин амьтдын дунд манай оронд хоёр зүйл баавгай байдаг. Эдгээрээс ойн хүрэн баавгай цөөнгүй тохиолдоно. Байгалийн энэ гайхамшигт бүтээл болох баавгайг монгол анчид эртнээс агнаж махыг хүнсэнд, өөх, доньтыг эмчилгээний зүйл болгон ашиглаж иржээ. Анчин хүн баавгай агнасан тохиолдолд жинхэнэ анчин боллоо гэж тооцогдох тул баавгай нь анчин хүний эр зоригийн шалгуур болон хамгаалагдаж байлаа. Харин мазаалай хэмээх элсэн цөлийн баянбүрд даган амьдрах жижгэвтэр баавгай байгалийн түүхийн гайхамшигт дурсгал болон үлдээд өнөөдөр тусгай хамгаалалтад ороод байна.

Махан идэшт амьтдаас нохойн овгийн 5 зүйл монгол оронд амьдардаг. Эдгээрээс манай орон даяар тархсан саарал чоно хүний аж ахуйд чухал холбогдолтой. Чоно юунаас өмнө мал иддэг тул монголын нүүдлийн мал аж ахуйд хохирол учруулагч байгалийн хүчин болдог. Үүнтэй уялдан малчдын дунд чоноос сэргийлэх зан үйлийн олон илрэл тохиолддог. Жишээлэхэд: чоно айлгах зорилгоор гэр хотоо тойруулан хүний дүрстэй мануухайнууд (зарим нутагт айвуул гэнэ) босгоно. Гэр малын ойролцоо чоно бэлтрэглэвэл түүний үүр ноохойг онгичин, бэлтрэг суулихыг цээрлэдэг. Тиймээс ч "чоно үүрэндээ өлзийтэй"

гэдэг ам дамжсан үг гарчээ. Яагаад гэвэл чоно өөрийн үр төлийг хөндүүлэхгүйн тулд айлсан байгаа хотны малыг барихгүй алслан гөрөөлдөг ба энэ нь хүн зэрлэг араатны хооронд өвөрмөц харьцаа тогтдогийг харуулж байна. Хэрэв үүрийг оролдвол чоно "ширүүсэх" буюу хавь орчны малыг олноор урах, барих нь олширдог. Эдгээрээс гадна чоно агнах ажил монгол малчдын хэрэгцээ байсан эртний түүх, уламжлал байдаг. Эртний монголчууд чоны авыг морин цэргийн дадлага сургууль болгодог байсан ба морьтой хүмүүс чоныг хомроголон агнаж морины сайныг шалгах нэг маягийн спорт аялал болдог байжээ. Нохдоос үнэг, хярсыг өвлийн цагт үс хөрс гүйцэх үеэр нь агнаж үс арьсыг олзворлон боловсруулж гоёлын ба дулаан хувцас хийдэг. Үнэг агнах сонирхолтой аргыг монголчууд эртнээс хэрэглэж иржээ. Унтаж байгаа үнэг хүн амьтан ойртон ирснийг мэдвэл нэг хэсэг босохгүй хярж хэвтэн өнгөрөөх нь олонтой байдаг. Иймд морьтой хоёр анчин зэрэгцэн явсаар унтаа үнэгэнд дөхөж очоод тойрч гарах янз үзүүлэн нэг нь мориноосоо бууж үлдэн буудлаг. Мөн шинэ цас орсон өглөө эртлэн босож нүхэнд орсон ба гарсан үнэгний мөрийг тоолон, гарсан мөр цөөн бол нүхэнд үлдсэн үнэгийг сахиж агнана. Монгол оронд тархсан нохойнхноос "шар хорхой" хэмээн нэрлэгдэх цөөвөр чоно устаж цөөрөн байгалийн дурсгалт амьтан болжээ.

Цөөвөр чоно

Үнэг



Шилүүс

Цоохор ирвэс

Хярс

Махан идэштэн дунд мийнхэн чухал байр суурь илэрхийлнэ. Эртний монголын ан авын зургууд дээр зээр гөрөөс бариулахаар цөлийн (дэлт) ирвэс хөтлөсөн эрчүүдийг дүрсэлсэн нь бий. Гэвч манай орны аль ч нутагт тэрхүү цөлийн ирвэс үгүй ба харин Алтай, Хангайн өндөр уулсаар цоохор ирвэс хэмээгдэх нэг зүйл тархаж янгир, аргалаар хооллон амьдарна. Харин эртний монголын хаадад Дунд азийн шах, султан нар найрамдлын бэлэгдэл болгон цөлийн ирвэсийг бэлэглэж байсныг үгүйсгэхийн аргагүй юм. Мийгээс шилүүсийг ард түмэн өргөн агнаж дээлийн дотор, шилүүсэн нудрага хийж байсан түүхтэй. Муурынхны арьс зөөлхөн, хөнгөн гоёмсог байдгаараа бусдаас онцлог юм.

Олон зуун жилийн турш манай ард түмний амьдрал ахуйд чухал байр суурь эзэлж ирсэн хөхтнүүд бол салаа туруутан амьтад билээ. Эрт цагаас ойн иргэд хандгай, буга, бор гөрөөсийг агнан махыг хүнсэндээ хэрэглэж, арьсаар нь гутал, хувцас хийн ашиглаж байсан ба бугын цусан эвэр, чив, согооний хээл, сав, сүүлийг эмийн зүйл болгон ашиглаж байжээ. Хандгайн годоор хийсэн анчин эрийн гутал маш бөх байдаг. Түүний зэрэгцээ цаатан ардууд цаа буга гаршуулан үржүүлж уналга, хөсгөнд хөллөн, мах арьсыг ашигласаар ирсэн нь өнөө үед ч

уламжлагдсаар үлдсэн байна. Бугынхан дотроос хамгийн ихээр агнуурт өртөж байсан амьтны нэг бол хүдэр юм. Эр хүдрийн заарыг авахын тулд хайр найргүй хомроголон агнах, сааль, занга, урхиар авласнаас эрс ховордсон. Өнөөдөр шинжлэх ухааны үүднээс амьтан хамгаалах баримт бичиг болсон Монгол Улсын улаан номонд хүдэр болон олон зүйл амьтныг бүртгэн хамгаалалтад авчээ.

Монгол орны өргөн уудам тал нутгийн унаган амьтны нэг бол цагаан зээр юм. Халиуран ганхах хялгана дундаа шаргалтан идээшлэж байгаа хэдэн мянган зээрийн сүрэг хаашаа зүглэн бэлчээрлэн буйг урьдчилан хэлэх аргагүй. Зээрийн сүрэг нэг нутагт суурьшин бэлчээрлэх нь ховор. Ямагт бэлчээр сэлгэн нүүдэллэж явдаг цагаан зээр, бүсгүй хүн хоёр нутаггүй гэсэн үг ч үүнтэй холбоотой.

Хүдэр

Буга

Хар сүүлт

Янгир

Аргаль

Хандгай

Салаа туруутан амьтдын өөр нэг бүлэг болох тугалмайтнууд, тухайлбал: аргал угалз, янгир ямаа, хар сүүлт зээр тал нутгийн болоод өндөр уулсаар амьдардаг байсан монголчуудын ан авд өртдөг гол амьтан болсоор өдгөөг хүрчээ. Өвлийн цагт хүнсэндээ жийрэг хийх үүднээс агнадаг байсан дээрх амьтдын тоо толгой нэг хэсэг ихээр хорогдож байснаа төрөөс авсан арга хэмжээний дүнд харьцангуй элбэгшиж орчин үед гадаадын анчдын агнах дуртай сонгомол ан болоод байна.

Монгол хүнийг морьгүйгээр төсөөлөх аргагүй. Дэлхий дээр оршин байсан зэрлэг адууны нэг төрөл тахь бол монгол адууны өвөг юм. Битүү туурайтнаас тахь, хулан хоёр өргөн уудам нутгийг туучин, монголын гучин гурван говийг гатлан эзэмшиж байсан нь саяхан. Тэднээс одоо цөөн хулан Алтайн өвөр говьд үлдэж, тахь үгүй болсон нь харамсалтай. Тахь монгол адууны өвөг болох шинжлэх ухааны баталгааны нэг бол өдгөө гадаадын олон оронд гэрийн адуугаар цус сэлбэсэн үлдмэл тахиуд бөгөөд саяхнаас өвгийн нутгийг бараадан монголын тал хээрт нутагшиж байна.

Манай орны олон янзын хөхтнөөс мэрэгчид аж ахуйн холбогдол ихтэй. Нэг талаас ихэнх жижиг мэрэгчид малын бэлчээрийн гол өрсөлдөгч болдгоороо хортой амьтдад тооцогддог. Жишээлбэл: хээр талын хамгийн элбэг амьтны нэг болох өлийн цагаан оготныг энд дурьдаж болно. Харин тарвага, минж зэрэг том биет мэрэгчдийн арьс, махыг ашиглаж ирсэн. Үүнээс Төв Азийн унаган амьтны нэг болох голын шар минж үнэт үст амьтан учир ихээр агнагдсанаас устахын захад хүрчээ. Минжин малгай, минжин нудрага, тэрч байтугай минжин дотортой дээл, хөнжил байсан гээд бодоод үзээрэй. Тиймээс түүнийг хамгаалалтад авч, сэргээн нутагшуулах ажил зохион байгуулж байна. Мөн хэрэм, зурам, жирх зэрэг үслэг ангийн ач холбогдолтой мэрэгч амьтан цөөнгүй бий.

Минж мэрсэн мод

Минжний далан

Зараанаас бусад шавж идэштэн, сарьсан багваахай байгальдаа ихээхэн ач холбогдолтой ч хүний амьдрал, аж ахуйд шууд хэрэглэгддэгүй. Зарааны үсийг эртний ёс заншлаар тотгондоо, хоймортоо хатгаж элдэв муу үйл, хэл амнаас сэргийлдэг хэмээн хэрэглэж ирсэн. Сарьсан багваахайг нисдэг болохоор эртний монголчууд шувуу мэт ойлгох боловч бие нь үс ноостой, араа шүдтэй болохоор араатан хэмээн үзэж, бүрэнхүй шөнөөр нисэх учир ердийн амьтан биш мэт ойлгож байсны хамт "сарьсан багваахай наранд хатна, санаа муут яван хатна" гэх зэргээр түүний хоёрдмол төрхийг урвагч, шарвагч нарын шинжтэй зүйрлүүлэн үзсээр ирсэн.

Шувууны хувьд хөхтнөөс арай өөр байдлаар ашиглагдаж байсан юм. Юуны урьд шувууг тэнгэрийн амьтан хэмээн хүндэтгэх явдал их байсан нь ихэнх монгол хүмүүс шувууны гаралтай түүхий эд бэлтгэн ашиглахыг хязгаарлаж ирсэн байна. Үлгэр туульсад шувууны тухай олонтаа дурьдагддаг ба хангарьд хэмээх хүчирхэг шувуу бол "шувуудын хаан" гэж таван хүчтэний нэг

Хангарьд

болгон цамын бүжигтээ оруулж байсныг түүхийн бичгүүдэд өгүүлнэ. Гэвч манай ард түмэн хэдэн зууны турш шувуу агнан хүнсэндээ хэрэглэх, шувууны өд түүж сумны өд хийх, шувуу хамгаалах ёс заншлаа эрхэмлэсээр иржээ. Шувууны зан араншин, үржил хөгжлийн талаар арвин мэдлэгтэй байсны нэг гэрч бол шувууны үүрэн дээр сүүдрээ тусгавал өндгөө голох, "нуур амгалан бол нугас амгалан" хэмээн ярих зэргээс тод харагдана. Жишээлбэл: Шувууны үүрний дэргэд хүн удаан зогссоноос өндөг хөрч хөврөл саатах учраас шувуу өндгөө хаях тохиолдол байдгийг эртнээс мэддэг байсан юм. Эртний сурвалж бичгүүдээс монголчууд шувуутай харьцах харьцаа ямар байсан тухай олон баримт олж үзэх боломжтой.

Ялангуяа өдрийн ба шөнийн махчин шувуудын холбогдол олон талтай. Манай оронд бүргэд, харцага, шонхор гээд 43 зүйл өдрийн махчин шувуу, шар шувуу, бэгбаатар, ууль гэх мэтийн бүрэнхүй, шөнийн амьдралтай 12 зүйл махчин шувуу байдаг.

Чингис хааны бага ахуйд Өүлэн эх хүүхдүүдээ авч Ононгийн хар шугуй, Бурхан халдун уулнаа орогнож байх үедээ шувуу авлан хүнсэндээ хэрэглэж байжээ. Тэд өвгөдийнхөө туршлагад тулгуурлан харцага тэжээн хур, сойр, нугас галуу бариулж байсан тухай дурьдсан бий. Ер нь шонхор шувуу түүний дотроос цагаан шонхрыг хамгийн хүчирхэг, дайчин болохыг мэддэг байсан төдийгүй эрхэмлэн дээдлэж ирсэн билээ. Цагаан шонхрыг "жадан шонхор" хэмээн нэрлэж алс холын тундр нутгийг зорин Умардын далайн хаяа хүрч шонхор барихаар цэрэглэн хөдөлж, олж ирж байсан тухай монгол орноор жуулчлан явсан хүмүүс өөрийн тэмдэглэлд бичсэн нь бий.

Зэрлэг нугас

Манхан галуу

Хур

Начин шонхор

Цагаан шонхор

Идлэг шонхор

Тасын өд

Монголын хаад ноёд шонхор шувууг үнэт эдлэлийн нэгд тооцож арабын хаад ноёд, шахуудад бэлэг дурсгалын дээд болгон хүргүүлж эв эетэй зэрэгцэн оршихын тэмдэг болгон дипломат үйлдээ ашиглаж байжээ. Тэр ч байтугай Өгөөдэй хааны үед тэр үеийн дэлхий дахинаа домоглон ярилцаж, итгэн шүтэж байсан мөнхийн амьдралын бэлэгдэл хэмээх галт шувуу олж ирүүлэхээр судалгааны анги гарган Зүүн Өмнөд Ази руу жуулчлуулж байсан мэдээ ч байдаг.

Алтай нутгийн иргэд бүргэд тэжээж, арьс үсээр нь малгай, дах, дэхтий хийхийн тулд үнэг, чоно бариулж ирсэн уламжлал одоо ч хадгалагдсаар байгаа билээ. Мөн тэд шар шувууны өдөн дээрх хээг өөрийн шашны номын үсэгтэй дүйлгэн үзэж, эрхэмлэн дээдлэх үүднээс малгайгаа чимэх, гэрийн хоймортоо шар шувууны арьс өлгөх зэргээр ашигласаар байна. Монголчууд түүхийн явцад бусдыг даган дуурайж махчин шувуудаа устгалгүй, харин хамгаалж ирсэн бөгөөд одоо үед Төв Азийн унаган гаралтай ёл, тас, хажир бүргэд, цармын бүргэд гэх мэт олон зүйл махчин шувуудыг үзэхээр манай орны зүг шувуу сонирхогч жуулчдын цуваа хөвөрсөөр байгааг энэхүү баримт харуулна.

Тас

Хажир бүргэд

Бүргэдтэй анчин
(Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сум)

Ёл

Өвөгт тогоруу

Тоодог

Бөднө

Гургуулын өд

Гургуул

Манай оронд тогоруутнаас 8 зүйл тогоруу, хонин тоодог, жороо буюу ямаан тоодог гэх 2 зүйл шувуу тархжээ. Тэднийг биеийн хэмжээ, амьдрах онцлогоос нь шалтгаалан ийнхүү нэрлэсэн байна. Тоодог агнаж махыг амжиргаандаа хэрэглэж байсан бөгөөд тиймээс ч "тоодгийн мах хонин тогоо дүүрнэ" гэдэг хэллэг ам дамжиж ирсэн. Тоодог шувуу монголчуудын түүхтэй олон талаараа холбоотой. "Тоодог хөөрхөн, тогоруу муухай, цам харай"... гэсэн яриа нь эрт үеэс хэлэгдэж ирсэн нь шувуудын үржлийн үеийн араншинг сайн мэддэг байсны нэг жишээ юм.

Монголчууд байгалийн ургамал, амьтны гаралтай олон янзын эмийн бүтээгдэхүүнийг хэрэглэж байсан нь өдүгээ уламжлалт анагаах ухааны суурь болж байна. Тийм бүтээгдэхүүнд тооцогддог хойлгийн махны анагаах чанар орчин үеийн шинжлэх ухаанаар батлагдсан юм. Эртний монголын цэрэг эрс аян дайнд явахын өмнө хойлгийн мах идэх, борцолсон мах олж хадгалах зэргээр бэлтгэл хийж байжээ.

Гомбо бурхан



Хойлог

Хахилаг

Ахууна

Хойлог, хахилаг, ахууна, бор ятууны махыг манай ард түмэн эрт цагаас хүнсэнд хэрэглэхийн хамт ядарсан хүн, малыг тэнхрүүлэх, анагаахын тулд борцолсон болон шинэ махны шөл өгч байсан ба одоо ч хөдөөгийн хүмүүс энэ аргыг хэрэглэж байна. Монгол оронд дээрх шувуудыг оруулаад 12 зүйлийн тахиатан байдаг. Түүнээс хамгийн жижиг биетэй нь бөднө шувуу, гоёмсог нь алтан гургуул юм. Хөвчийн уулсаар хур, сойр зэрэг томоохон биетэй зэрлэг тахианууд элбэг бөгөөд түүнийг ашиглах ихээхэн нөөц бий. Бусад шувуудын түүхэн холбогдол янз бүр.

Хэрээ

Цэн тогоруу

Тухайлбал: бөөгийн шашинд хон хэрээ шувууг тэнгэрийн элч хэмээн эрхэмлэх явдал эрт үеийн ойн иргэдийн дунд байсан. Гэтэл буддын шашны үүднээс авч үзэхэд хэрээ бол Гомбо бурханы дагуул гэж хүндэтгэдэж ирсэн байна. Орчин үед хэрээг үхээрийн шувуу гэж боддог болсон нь Европын гаралтай ойлголт бөгөөд байгаль дахь бодисын эргэлтийг түргэсгэх, байгалийг үхсэн аливаа амьтны бохирдлоос цэвэрлэдэг тэр шувууны үүргийг умартсанаас тэр биз ээ.

Байгаль, "лусын" амьтад өнө эртнээс монголчуудын сонирхлыг татсаар байлаа. Манай ард түмэн мэлхий, бах, гүрвэл могойн тухай өргөн мэдлэгтэй, тэдгээрийг амьдрал ахуйдаа ашиглах арвин туршлагатай юм. Жишээлбэл: Мэлхийн шанаганцрын хар өнгөтэй нь эмийн амьтан мөн гэж эм найруулах, хэрэглэх тухай эртний судар бичгүүдэд өгүүлсэн байдаг. Энэ нь хоёр нутагтан амьтан, түүний дотроос бах буфотоксин зэрэг хорт бодис ялгаруулдаг болохыг мэдэж түүний шанаганцрыг түүн хатааж эмийн жоронд хольж байсны гэрч

Шивэр мэлхий

Бамбай хоншоорт могой

Монгол бах

Цоохор хонин гүрвэл

болно. Монголд одоогийн байдлаар 2 баг 4 овогт багтах 6-8 зүйл хоёр нутагтан тэмдэглэгджээ. Тэдгээрийн ихэнх нь төв азийн унаган гаралтай амьтан юм.

Манай орны мөлхөгчдийг гүрвэл, могойн гэх хоёр салбар багт хуваан үздэг. Монголчууд могойг дээдлэн гэр оронд орсон тохиолдолд толгой дээр нь сүү дусааж, галын шилээгүүрээр өлгөн авч гэрээс холдуулан явах замыг нь заан чиглүүлж орхидог заншилтай. Могойн чуулгантай тааралдсан хүн түүнийг дээдлэн амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байхыг эрхэмлэдэг. Мөн жижиг мэрэгч амьтан, шувуу залгисан могойг илж тэжээлийг гулгиулж чадсан хүн бариач, засалч болдог гэж үздэг. Ихэнх гүрвэлүүдийг нэрлэж тэднээс айх эмээх, цээрлэхийг мэдэхгүйгээр зэрэгцэн амьдарч ирсний хамт зарим гүрвэлийн махыг эмийн анагаах шинжтэй байсныг ч мэдэж амьдрал ахуйдаа хэрэглэж байжээ. Ийм гүрвэлийн тоонд замба зараа буюу замба гүрвэл орох бөгөөд орчин үеийн эрдэмтдийн судалгаагаар энэ гүрвэлийн мах биологийн идэвхит бодисууд байх тул түүний өөх ханаагүй хүчилтэй учир анагаах ач холбогдолтойг тогтоосон байна.

Замба гүрвэл (Замба зараа)

Одоогоос 300 орчим жилийн тэртээ амьтан ургамлын аймгийн ангилалыг монголчууд хийж ирсний дотор загасны 160 гаруй нэрийг эрэгчин, эмэгчин, үр төл, нас хүйсээр нь ялган бичсэн байдаг.

Ховд гол

Эртний монголчууд загас агнуурыг өргөн эрхэлж, барих элдвийн арга хэрэглэж байжээ. Загасыг олон янзаар нэрлэж, өөр хооронд нь ялган таньж, махны чанар, агнах арга барилаар ангилан үзэж байсан нь манай орны гол мөрөн, нуур ус элбэгтэй умрын нутгуудад уламжлагдан үлдсэн бий. Тиймээс гол, нууранд загас агнах, хөндлөн гулд явах үүднээс гуя онгоц хийж ашигладаг байсан бөгөөд ийм завийг одоо ч ард түмэн ашигласаар байна. Загас агнах монголчуудын арга өөрийн онцлогтой бөгөөд тэд хавар загас төрцөө хаяад эргэх үед жижиг голыг бургасан хашлагаар хааж, "ходоод" хийж цуглуулан барих, дэгээ, сэрээ, гувчуур хэрэглэж бамбар асаан намар орой, өвөл барихын хамт манай орны өрнөдийн иргэд загас суйлах гэдэг өвөрмөц арга хэрэглэж байсан байна.

Алтайн сугас

Нохой сугас

Давжаа сугас

Омуль

Нууруудын хөндий ба Их нууруудын хотгорын гадагш урсгалгүй ай савын нуур голын амьтан онц сонирхолтой юм. Энэ савд ордог Увс, Хяргас, Хар-Ус, Бөөнцагаан, Орог зэрэг томоохон шорвог, цэнгэг нууруудад баруун Хөвсгөл, Хангайн өвөр, Алтайн зүүн сугаас эхлэн урсдаг Тэс, Завхан, Ховд, Буянт, Байдраг голууд цутгадаг. Энд тархсан давжаа сугас, нохой сугас, алтайн шар сугас, монгол хадран нь Төв Азийн унаган загас болно.

Тэсийн гол

Өнгөрсөн зууны 50-иад оны дунд үеэр Байгал нуурын омуль загасыг Хөвсгөл нуурт нутагшуулсан нь одоо бие даасан нутгийн амьтан болж улмаар Сэлэнгэ мөрний савын томоохон голуудад тохиолдох агнуурын чухал ач холбогдолтой загас болсон байна.

Хөвсгөл нуур

Монголчуудын байгалийг танин мэдэх ухаан алсаас эхтэй. Монголчууд өнө эртнээс эргэн тойронд тааралдах аливаа сээр нуруугүй амьтныг танин мэдэж ахуйн холбогдолтойг ашиглаж, хортноос сэргийлж, шимэгчидтэй тэмцэж, тэдгээрийг элдвээр нэрлэж, ангилж байсан нь өнөөгийн шинжлэх ухааны судалгааны суурь болж ирсэн нь дамжиггүй. Жишээлбэл: Хорхой, шавж гэж ялган үзсэн нь тэдгээрийн эртний гарал үүсэл холбоотой байсныг харуулаад зогсохгүй тэд юугаараа ялгаатайг ч мэдэж байсны гэрч бол шавжийн авгалдайг хорхойноос эрс өөр гэдгийг илэрхийлж өт, төөлүүр хэмээн нэрлэж байснаас тод харагдана. Мал, нохой хорхойтоход шар сүү хүйтнээр цутган уулгаж туулган эмчилж байсан нь ахуйн уламжлалт арга хэвээр үлджээ. Түүнчлэн хачиг шалзнаас малаа хамгаалах, хамуутсан малд хярвас, тогооны хөөтэй тос түрхэж байсан нь тэдгээр арьсан дор амьдрагч аалз хэлбэртнийг амьсгалуулалгүй бүтээн алах уран аргын нэг байсан гэлтэй.

Зарим шавжийн биед агуулагдах бодисын ашигтай шинжийг мэдэрч эмийн найрлаганд оруулан ашиглаж ирсэн олон жишээ бий. Тийм шавжийн нэг нь өмхий тонгой хэмээх том цох юм. Түүнийг хонины сүүлэнд ороож нарийнтсан, ходоодны хавдартай хүмүүст бүхлээр нь залгиулдаг аргыг хэрэглэж байжээ. Хонины сүүл нь ханаагүй өөхний хүчилтэй тул өлдсөн хүнд тэжээллэг байдал болон олон талаар ашигтай ба дотор нь ороосон цохоос гарах биологийн идэвхит бодис тэрхүү ханаагүй хүчилтэй нэгдэн эмийн үйлчилгээтэй болдог байсан байна.

Зун, намрын налгар цагаар орой мал хотлохын үесэд айл бүхний гадаа аргалын утаа уугиж байх нь хэвийн үзэгдэл. Түүнийг мэдэхгүй гадаадын жуулчин, зорчигчид гайхан асуух нь олонтой. Монголчууд эрт цагаас дэлэнч, шумуул, ялаа хөөх, үргээн зайлуулахад энэ аргыг хэрэглэж ирсэн бөгөөд шавжуудад агаарын таламжгүй орчныг зохиомлоор үүсгэж байгаа нэг маягийн химийн буюу механик арга байжээ. Энэ

Ялаа

мэтчлэн өнө эртнээс бидэнд уламжлагдан ирсэн олон юмны тухай, амьтны аймагтай манай ард түмний амьдрал ахуй ямар холбоотой байсныг өгүүлж дуусашгүй арвин.

Орчин үед монгол орны амьтны аймгийн судалгаа шинжлэх ухааны янз бүрийн чиглэлд улам нарийсан хөгжиж, дэлхийн судалгааны түвшинд хүрснийг өнөө үеийн баримтуудаас олж үзэхэд техник, технологи, мэдээлэл холбооны боломж хангалттай байна.

Ш.Болдбаатар
С.Уранбилэг
Э.Амарбилиг



БҮЛЭГ II

- НҮҮДЛИЙН МАЛ АЖ АХУЙ
- МАЛЫН УНАЛГА ЭДЭЛГЭЭНИЙ ТОНОГ, ХЭРЭГЛЭЛ
- ТАРИАЛАНГИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ



НҮҮДЛИЙН МАЛ АЖ АХУЙ

Монголын нүүдлийн сонгодог хэлбэрийн мал аж ахуй

Монголын нүүдлийн мал аж ахуй бол Монгол улсын үндэсний өвөрмөц баялаг, дэлхийн үнэт өв сан, улс орны тогтвортой хөгжлийн эх сурвалжийн нэг мөн болно. Нүүдлийн мал аж ахуй нь түүхийн тодорхой үед Монгол улсын тусгаар тогтнолын баталгаа, эдийн засгийн тулгуур, хүн амын амьжиргааны гол хэрэгсэл болж байсан. Төв азийн байгаль орчин, уур амьсгалын эрс тэс нөхцөлд урт хугацааны байгалийн шалгарал, малчин түмний олон зууны ардын селекц, мал маллагааны өвөрмөц арга ажиллагааны харилцан нөлөөлөлцлийн үр дүнд биологи, экологийн онцлог шинжит үнэт генофондыг шингээсэн нутгийн таван хошуу мал, эдгээр төрлийн малын бүрэлдүүлсэн дан байгалийн бэлчээрт дулдуйдсан нүүдлийн мал аж ахуй бий болсон түүхтэй.

Монголын нүүдлийн мал аж ахуйг хэдэн мянган жилийн түүхтэй гэж судлаачид үздэг. Монголын мал аж ахуй нь төв ази, монгол орны байгаль цаг уурын нөхцөлд гойд зохицсон, жилийн дөрвөн улиралд дан байгалийн бэлчээрээр өл хоолоо залган амьдрах, үржин төлжих, ашиг шим бүрэлдүүлэх чадвартай юм. Үүнээс гадна нүүдлийн мал аж ахуйн сонгодог чанар нь нутгийн малыг өсгөн үржүүлэх, сонгон шалгаруулах ардын селекци малын ашиг шимийг боловсруулах нүүдэлчдийн хаягдалгүй технологи, малын тоног хэрэгсэл хийх ур ухаан, уналга, ачлага зэрэг ажил эдэлгээнд мал сургах, ашиглах арга ажиллагаа, мөн нүүдлийн амьдралд тохирсон орон сууц, хувцас хунар, хоол хүнсний өвөрмөц байдал, малын өвчин согогийг эмчлэн засдаг ардын мал эмнэлгийн уламжлалт арга ухаан, таван хошуу малыг нэг хотонд харилцан шүтэлцээтэйгээр өсгөн үржүүлдэг зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой.

Монголчуудын нүүдлийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх арга ухаан, байгаль, дэлхий, мал сүргийнхээ аясыг дагаж нүүдэллэн аж төрөх ёс нь нүүдлийн иргэншлийн үүсэн хөгжихийн эх сурвалж болсон аж. Монголчуудын бий болгосон нүүдлийн мал аж ахуй, үүсгэн хөгжүүлсэн нүүдэл иргэншил нь тэднээс хүн төрөлхтний соёл иргэншилд оруулсан чухал хувь нэмэр болно. Нүүдлийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх нь чухамдаа бие даасан томоохон соёл мөн.

"Хэбэй вангийн аж төрөхүйг заасан сургаал болой" хэмээх бүтээлийг 19-р зууны дунд үед Халх даяар хэцүү То ван гэж өргөмжлөгдөн алдаршсан Б.Тогтохтөр туурвисан байна. Бат-Очирын Тогтохтөр (1797-1868) бол XIX зууны монголын нийгэм улс төр, соёлын нэг сод төлөөлөгч бөгөөд Халхын Сэцэн Хан аймгийн Илдэн хошуунд, одоогийн Дорнод аймгийн Халх сумандтөрсөн бөгөөд хошууны захирагч байжээ. Тэрээр монголын нүүдэлчдийн мал аж ахуй эрхэлж ирсэн олон зууны туршлагыг судалж, нямбай ажилласны дүнд бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх арга ухаан, нүүдэлч малчны аж төрөх үйлийг заасан сургаал, номыг зохион туурвисан байна. То вангийн энэхүү сургаал нь 11 зүйлээс бүрдэх боловч зүйл бүрд хэд хэдэн төрлийн утга санаа агуулсан аж. Энэ сургаал нь мал сүргийн тоо толгойг өсгөх, мал маллагааны арга ажиллагааг өөрийн хошууны нөхцөл байдалд тохируулан боловсронгуй, үр өгөөжтэй болгох, ер нь мал аж ахуйн болон малчин өрхийн аж төрөхүйн ухаан, арга ажиллагааны талаархи амин чухал асуудлыг тусгажээ.

То Ван сургаалдаа төрөл бүрийн малын хариулгыг тохируулан маллах, мал нийлүүлэх, төллүүлэх хугацааг оновчтой тогтоохд их анхаарч сургасан нь өнөөг хүртэл малчдад мөрдөгдсөөр байна. Тухайлахад сургаалын 10-р зүйлд "хонийг өдөр шөнө тэнцэхэд хургалахыг бодож хуц нийлүүл" гэсэн нь бэлчээрийн мал маллагааны арга ажиллагааг гярхай ажигласны илрэл бөгөөд энэхүү сургаалын дагуу 19-р зууны дунд үеэс Сэцэн хан аймгийн малчид хонь, ямаагаа хаврын дунд сарын өдөр, шөнө тэнцэх үеэр төллүүлдэг болсон нь эх, төлийн хорогдол багатай, ашигтай хугацаа болох нь малчдын туршлагаар нотлогджээ.

Сэцэн хан аймгийн Илдэн хошууны захирагч Б.Тогтохтөр ван (1797-1868)

Нутгийн монгол малын тоо толгой, тархалт, хариулга, шилэн сонголт, им тамга, үржүүлэг

Төв азийн малчин аймгууд, түүний дотроос монголчууд эрт дээр үеэс хонь, ямаа, үхэр, тэмээ, адуу гэсэн таван хошуу мал өсгөн үржүүлж ирсэн уламжлалтай билээ. Нутгийн монгол мал Төв Азийн өвөрмөц байгаль-орчны нөхцөлд удаан хугацааны байгалийн шалгарал, олон үеийн малчдын шилэн сонголт, мал маллагааны дан байгалийн бэлчээрт дулдуйдсан арга ажиллагааны харилцан нөлөөлөлцлийн үр дүнд бий болжээ. Нутгийн монгол мал Төв Азийн эх газрын эрс тэс байгаль цаг уурын нөхцөлд сайн зохицсон, байгаль орчны сөрөг нөлөөлөлд тэсвэртэй, жилийн эргэх дөрвөн улиралд дан бэлчээрийг шүтэн амьдарч өсөн үржиж, ашиг шим бүтээн үйлдвэрлэх биологи экологи, аж ахуйн онцгой чанарыг өөртөө агуулсан байдаг. Нутгийн монгол малыг төв азийн өндөрлөгийн бэлчээрийн өвс ургамал, ус, хужрыг мах, сүү зэрэг экологийн цэвэр бүтээгдэхүүн болгон хувиргадаг "Амьд фабрик" гэж нэрлэх нь бий.

Ноолуур, арьс шир, ноос, нэхий зэрэг дээд чанарын түүхий эд өгдөг нь монгол малын бас нэг онцлог чанар болно.

Таван хошуу малын толгойн тоо, нийт малд эзлэх хувь. Монгол улсын малын тоо Төв Азийн байгаль, орчны нөхцөл, төр нийгмийн байгууллын онцлог, малчин түмний мал маллагааны арга ажиллагааны байдлаас хамааран тодорхой хүрээнд хэлбэлздэг байна. Түүхийн баримт материалаас үзэхэд Монгол улсын малын тоо 1990 оны эцэс хүртэл 18-25 саяын хооронд хэлбэлзэж байжээ. Мал хамгийн их өссөн 1999 онд 33.5 сая хүрчээ. Энэ онд тэмээ 355.6 мянга, адуу 3.16 сая, үхэр 3.82 сая, хонь 15.19 сая, ямаа 11.03 сая болж байсан ба улсын нийт малын дотор тэмээ 1.05 хувь, адуу 8.4 хувь, үхэр 7.9 хувь, хонь 45.2 хувь, ямаа 32.8 хувийг тус тус эзлэж байв.

Малын тархалт, байршилт. Нутгийн монгол хонь нь бэлчээрийн маллагаанд гойд зохицсон мал, манай орны байгаль, цаг уурын аль ч бүсэд өсөн үрждэг, гэхдээ ойт хээр, тал хээр, говийн бүсийн аймаг суманд илүүтэй тархжээ. Ойт хээрийн бүсэд хонин сүргийн 20 орчим, тал хээрийн бүсэд 38 гаруй, говийн бүсэд 20 гаруй, өндөр уулын бүсэд 9 орчим хувь нь тус тус тархжээ. Тус улсын ямааны 70 гаруй хувь нь говийн болон Алтайн уулархаг бүс нутагт тархан байршилжээ. Үхрийн тархалт жигд биш, өндөр уулын бүсэд нийт үхрийн 27.6 хувь, ойт хээрийн бүсэд 25.2 хувь, тал хээрийн бүсэд 28.8 хувь, Их нууруудын хотгор,Говь-Алтайн бүсэд 12.5 хувь, говийн бүсэд 5 хувь нь тус тус тархжээ. Өндөр уулын бүсэд үржүүлж байгаа үхрийн ихэнхийг сарлаг эзэлдэг байна.

Тэмээний тархалт нэлээд өвөрмөц байдалтай аж. Монгол орны нутаг дэвсгэрийн 40 гаруй хувийг эзэлдэг өргөн уудам цөл, цөлөрхөг бүс нутагт бүх тэмээний 70 шахам хувь нь байршдаг ба их нууруудын хотгорт 19.5 хувь, Дорнодын тал, мөн өндөр уулсын ба ойт хээрийн бүс нутагт нийт тэмээний 7-5 хувь нь тархсан байна. Манай орны нийт адууны 19.3 хувь нь өндөр уулын бүсэд, 17.8 хувь нь ойт хээрийн бүсэд, 30.5 хувь нь тал хээрийн бүсэд, 14 хувь нь Их нууруудын хотгор, Говь-Алтайн бүсэд, 18.9 хувь нь говийн бүсэд тус тус тархан байршжээ.

Хуц, ухныг шилэн сонгох. Малчид хуц, ухныг шилэн сонгохдоо удмын байдлыг харгалзахын зэрэгцээ биеийн галбир хийцийг их шинждэг байна. Галбирын шинжүүдэд хуцны толгой хүнд, бүдүүн биш эцэнхийвтэр, хамар монхордуу, хүзүү бүдүүн байх зэрэг шинж ордог. Мөн хуцны цээж өргөн, гүн, ууц, нуруу урт тэгш, гэдсээр тавиу лагс биетэй, төмсөг хуухнаг нь зөв байрлалтай, чац урт, хөл чийрэг цэх тавилтай, борви тэнүүн байх шаардлагатай болно.

Монгол омгийн ухна

Удам угсаа сайтай, ашиг шим арвинтай ямааны төлөөр *ухна* тавина. Ухна нь гэдэс хэвэл сайтай, ноос ноолуурын гарц арвин байвал зохино. Малчид уртавтар хошуутай, урт ясархаг чацтай ухнын төл бойжилтоор сайн, торнилт түргэнтэй гэж үздэг. Хуцны зүс цагаан, ухнын зүс бараан байх нь зохимжтой гэдэг.

Монгол үүлдрийн хуц

Бух сонгон тавих нь. Нутгийн *монгол бухыг* урт биш өргөн духтай, зоримог шинжийн занттар, том биш толгойтой, эвэр бахим, богино, хүзүү бүдүүн, булчин мах зузаан, цээж өргөн, гүн сэрвээтэй, хондлой шулуун, өргөн, уртавтар, ташаан толгой тэгш, бөгс гуя бөөрөнхий, зангирсан хатуу булчинтай, урд хөл эгц, борви уужим, тахим нь ойрхон биш, гэдэс хэтэрхий тавиун биш хийц галбиртай байвал зохино гэж үздэг. Эвэр нь богино хоорондын зай нь хол тавиу байхыг бас харгалздаг байна.

Монгол үүлдрийн бух

Буур шилэн сонгох нь. Буур тавих тайлагийг шилэн сонгохдоо биеэр том, ноос үс өтгөн, өвдөг зогдор урт, өтгөн, хар мах сайтай, уужим бөхтэй, цээж өргөн, хондлой тэгш зузаан, гуя бүдүүн том, тавхай том, сайран тавхай сайтай, хумс том хурц, монхор хоншоортой, шүд жижиг цагаан, нүд том, бүлтгэрдүү, харц зөөлөн, авир дөлгөөн номхон байх зэрэг шинжийг харгалздаг.

Монгол үүлдрийн тэмээд

Азарга сонгон тавих нь. Малчид *азарга тавих, үрээг* сонгохдоо удам угсаа, биеийн галбир хийц, хэвшил, уналга эдэлгээний болон хурдлах чадвар зэргийг шинждэг. Азарга тавих үрээний толгой хатингардуу, магнай тэнэгэр, чих урт, хамрын нүх уужим, зовхи зузаан, сормуус урт, цээж өргөн, мундаа сэрвээ өндөр, хавирганы матаас сайн, нуруу шулуун, зоогоороо ялимгүй бөгтрөгтэй, хөлийн гишгэлт зөв тэгш, туурай хомбон хэлбэртэй, хурц ирмэгтэй, өсгий зузаан, борви тэнүүн, сагаг босоо, шилбэ бүдүүвтэр, туурай зузаан, гэдэс хэвлий тавиун байх нь зохистой гэж үздэг.

Монгол адууны ... (caption)

Ардын селекц нь эзэн малын хэрэгцээгээр эх малыг шилэн сонгохдоо мөн онцгой анхаарч жил бүр төллөдөг, сайн үр төл өгдөг, бие томтой, ноос ихтэй, сүү шим арвинтай эх малыг, малчдын хэлдгээр нүд булаасан, хайр татсан, сор чимэг болсон малаа сүрэгт үлдээн үржүүлж малынхаа удмын нөөц, чанарыг арвижуулан сайжруулдаг уламжлалтай билээ.

Мал тамгалах, имлэх ёсон. Нүүдэлч малчид мал олонтой байх учир эрт дээр үеэс малаа айл, саахалтын болон өөр отог, хошууны малаас ялган таних ба өмчийн тэмдэг болгон тамга, им хэрэглэж ирсэн уламжлалтай. Адуу малд тэмдэг болгон хайрах төмөр хэрэгслийг *тамга*, хайрах үйлдлийг тамгалах, малын чихийг хагалж огтлон тэмдэглэсэн тэмдгийг им, чих хагалан цуулах, огтлон тайрах үйлдлийг имлэх гэдэг.

Тамга, им нь өмчийн тэмдэг төдийгүй, дансны үүрэг гүйцэтгэдэг аж. Монголын малчин өрх айл эрт дээр үеэс, өвөг дээдсээс уламжлан ирсэн өөрийн гэсэн тамгатай, имтэй байжээ. Мал тамгалах, имлэх нь нүүдэлчдийн өвөрмөц соёл болно. Малын тамга олон хэлбэртэй.

Харин им тэмдгийг малчид голдуу бог мал, хааяа тэмээ, үхэрт тавьдаг ба хоёр чихний аль нэгийг буюу хоёуланг имлэдэг байна. Им мөн олон янз байдаг.



Малд эрт үеэс хэрэглэсээр ирсэн тамганы хэлбэр, хээ

1. Нүдэнтэй загалмай тамга
2. Шүргэлтэй гурвалжин
3. Саран дэвсгэртэй охь
4. Дөрвөлжин тамга
5. Хүдэсэлсэн охь
6. Загалмай тамга
7. Чөдөрсөн буюу гурвалжин тамга
8. Хэнгэрэгтэй саран дэвсгэртэй дөрвөлжин тамга
9. Отгон тамга
10. Сэрээ тамга
11. Гурвалжин охь
12. Нүдэнтэй гурвалжин буюу чөдөрсөн тамга
13. Саран дэвсгэртэй Гурвалжин буюу чөдөрсөн
14. Сам тамга
15. Галтай ал
16. Дугуй хүрээтэй буруу харсан үйлэн тамга
17. Буйлан тамга
18. Шүргэлт сар
19. Алхан тамга
20. Чандман тамга
21. Жимстэй алхан тамга
22. Нум сумын тамга
23. Саран дэвсгэртэй гал тамга
24. Зөв эргэсэн хас тамга
25. Холбоо охь
26. Шүргэлтэй зөв тамга
27. Босоо дөрвөлжин тамга
28. Арвай тамга
29. Түүхэй тамга
30. Буруу харсан түүхэй
31. Доошоо харсан хомбуу тамга
32. Гурвалжин сар нар
33. Дан саран тамга
34. Ац тамга
35. Гурван хүйтэн чандман тамга
36. Дугуй хүрээтэй алхан тамга
37. Зуухан тамга
38. Өрөө охин тамга
39. Лансан тамга
40. Эрдэнэ тамга



Малын имний хээ

1. Сүйх цоорхой
2. Тайрмал
3. Шүдэтэй тайрмал
4. Тэвшин им
5. Ухаж им
6. Хагалбар им
7. Холбоо хагалбар им
8. Хэмдээн им
9. Эрсэн хэмдээн
10. Цуулбар, зэв цуулбар
11. Цоолбор им
12. Цоргио им
13. Цэцэг им
14. Шөргөлжсөн им
15. Ташуу тайрмал
16. Дөрвөлжин цоолбор
17. Үзүүр хугалбар им
18. Аман цоорхой
19. Гохлон цоорхой
20. Эргэсэн гохлон цоорхой
21. Сүйхтэй гохлон цоорхой
22. Долоо цоорхой
23. Дөрвөлжин оньтой долоо
24. Зүрх цоорхой
25. Онь цоорхой
26. Дөрвөлжин онь
27. Арвансан ухаан онь
28. Сам им
29. Сэй им

Нутгийн монгол хонь, түүний үүлдэр, омгууд

Монгол оронд эрт дээр үеэс үржүүлж ирсэн уламжлалт таван хошуу малын дотор хонь толгойн тоогоор болон таваарын бүтээгдэхүүнээр тэргүүн байр эзэлдэг. Дэлхийн орнуудын дотор Монгол улс хонины аж ахуй хөгжсөн оронд тооцогддог ба хонины тоогоор дэлхийд 20-р байранд, 100 хүнд ноогдох байдлаар 3-р байранд ордог.

Халх хонь зоологийн ангилалаар богино өөхөн сүүлт хонины бүлэгт багтдаг, галбирын согоггүй, чийрэг бие цогцостой, толгой хөнгөн, ялимгүй монхордуу хамартай, хуц нь ихэвчлэн эвэртэй, эм хонь эвэргүй, дунд зэрэг урт, махлаг хүзүүтэй, тэгш өргөн зоо нуруутай, борвиндоо хүртэл унжсан дугираг хэлбэрийн том сүүлтэй, тэр нь махир буюу шулуун үзүүртэй байдаг. Монгол хонины цээж өргөн, гүн, хөл тэгш зөв гишгэлтэй, алхаа нь чанга, туруу нь бат бөх, мах булчин сайн хөгжсөн мал болно. Монгол хонины биеийн үндсэн хэмжээнүүд нь оршин амьдардаг байгалийн бүс, биеийн галбир хийцээс хамааран ихээхэн хэлбэлзэлтэй байдаг. Нас гүйцсэн монгол (халх) хонины амьдын жин 42.9-61.5 кг, хуцных 67.5-75.0 кг-ын хооронд хэлбэлздэг. Эм хонь 1.0-1.4 кг, хуц 1.4-2.0 кг бүдүүн ноос өгдөг. Нутгийн хонины дотор олон тооны шилмэл үүлдэр, омгийн хонийг ялган үздэг ба тархалт, тодорхой бүс нутагт зохицсон байдал, ашиг шимийн үзүүлэлтээр нутгийн монгол хониноос ялгагддаг.

Халх хонины хуц

Байдраг үүлдрийн хонь. 1940 оны сүүлч 1950 оны эхэн үеэс эхлэн нутгийн чамаар хонины дотор үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүйн дагуу

Байдраг хонины хуц

30 гаруй жил явуулсны үр дүнд 1983 онд Байдраг хонь үүлдэр болон батлагдсан. Энэ хонийг Баянхонгор аймгийн Жаргалант суманд голлон үржүүлдэг бөгөөд үндсэн ашиг шим нь хивсний зориулалттай урт бүдүүвтэр ноос бөгөөд хивснээс гадна сайн чанарын долгион хөнжил, бүтээлэг, ноосон бүс бараа, нэхмэл, сүлжмэл хувцас хийхэд нэн тохиромжтой. Байдраг хонь бие томтой, чийрэг, бэлчээр ашиглахдаа сайн мал болно. Байдраг үүлдрийн хонины бүдүүн хуцны амьдын жин 69.5 кг, ноосны гарц 2850 гр, эм хонины амьдын жин 52.7 кг, ноосны гарц 1970 гр, ноосны урт 20-25 см байдаг.

Баяд үүлдрийн хонь. 1966 оноос эхлэн Баяд үүлдрийн хонийг өөр дотор нь цэврээр үржүүлэх үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны

Баяд хонины хуц

үндэслэлтэй явуулсны үр дүнд мах-ноосны чиглэлийн бүдүүвтэр ноост баяд үүлдрийн хонийг бий болгосон байна. Бүдүүн хуцны амьдын жин 68.5 кг, ноосны гарц 2.2 кг, эм хонины амьдын жин 58.5 кг, ноосны гарц 1.8 кг байдаг. Баяд үүлдрийн хонины амьдын жин монгол хониныхоос 15-18 хувиар, ноосны гарц 38-45 хувиар илүү болно. Ноос нь ширүүн, ямаан үс ихтэй. Энэ хонины бусад хониноос ялгарах гол онцлог нь бэлчээр ашиглах болон амьдрах чадвар сайтайд оршино.

Баяд омгийн хонийг 1991 онд үүлдэр болгон баталсан. Баяд омгийн хонины цөм сүргийг Увс аймгийн Малчин, Зүүнговь, Тэс, Хяргас суманд үржүүлдэг. Увс аймгийн хонины үндэс сайжруулагч болгон ашиглаж байна.

Говь-Алтай үүлдрийн хонь. Говь-Алтай үүлдрийн хонийг өөр дотор нь цэврээр сонгон үржүүлэх аргаар мах-ноосны чиглэлийн бүдүүвтэр ноост Говь-Алтай үүлдрийн хонийг бий болгожээ. Энэ үүлдрийн хонины бүдүүн хуцны амьдын жин 70.0 кг, ноосны гарц 3.0 кг, төлгөн хуц 61.0 кг, ноосны гарц 2.0 кг, эм хонины амьдын жин 58 кг, ноосны гарц 2.1 кг, охин төлөгний амьдын жин 46 кг, ноосны гарц 1.7 кг болно.

Говь-Алтай хонины хуц

Говь-Алтай үүлдрийн хонины гол онцлог нь аж ахуй, биологийн ашигтай шинж чанараа үр төлдөө баттай дамжуулах чадвар бөгөөд монгол хонины мах, ноосны ашиг шимийн хэмжээ, чанарыг нэгэн зэрэгт сайжруулдагт оршино.

Говь-Алтай үүлдрийн хонины цөм сүргийг Говь-Алтай аймгийн Бугат, Цээл суманд үржүүлдэг. Говь-Алтай хонийг 1991 онд үүлдэр болгон баталсан.

Керей үүлдрийн хонь. Баруун Монголын (казахын) ууцан сүүлт омгийн хонин сүрэгт сүүлийн 30-аад жилд явуулсан үржил селекцийн ажлын дүнд Баян-Өлгий аймгийн байгаль, экологийн нөхцөлд гойд зохицсон мах-өөх-ноосны Керей үүлдрийн хонь бий болсон бөгөөд 1999 онд бие даасан үүлдрээр

Керей хонины хуц

баталсан болно. Керей үүлдрийн хонь ууцан сүүлтэй, улаан, бор хүрэн зүстэй, ширүүн ноостой мал бөгөөд бүдүүн хуцны амьдын жин дунджаар 74.5 кг, ноосны гарц 1.8 кг, эм хонины амьдын жин 57, 6 кг, ноосны гарц 1.4 кг болно.

Дархад омгийн хонь. Энэ омгийн хонийг Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ, Улаан-Уул, Баянзүрх сумын нутагт өндөр уул, тайгын бүсэд үржүүлж ирсэн дархад хонь цас ихтэй, уулын бэлчээрт идээшилж сурсан бөгөөд биеийн хөдөлгөөн сайн, хөл чийрэг, бөх бат туруутай, цас хагалж идээшлэхдээ сайн мал. Дархад хонины хуцны биеийн масс намар 68.8 кг, эм хониных 50.9 кг, охин төлөгнийх 43.9 кг, хуц 1.76 кг, эм хонь 1.54 кг, охин төлөг 1.02 кг ноос өгдөг ноосны бүрэлдэхүүнд ноолуур 87.0-89.9 хувийг эзэлдэг.

Дархад хонины хуц

Барга омгийн хонь. Энэ омгийн хонийг Дорнод аймгийн Хөлөнбуйр, Гурванзагал сумaнд голлон үржүүлдэг. Барга омгийн хонины хуцны биеийн масс намар 69.54 кг, эм хониных 51.74 кг, охин төлөгнийх 45.19 кг байдаг. Барга хонины хуц 1.4 (0.7-2.0) кг, эм хонь 1.22 (0.7-2.3), охин төлөг 1.1 (0.5-1.2) кг ноос өгдөг. Ноосны бүрэлдэхүүнд ноолуур 75.5 хувийг эзэлдэг.

Барга хонины хуц

Тамир үүлдрийн хэсгийн хонь. Хангайн өндөр уулын бүсийн

Тамир хонины хуц

монгол хонийг баяд, байдраг, говь-алтай үүлдрээр эрлийзжүүлж гарсан тохиромжтой хэвшлийн хонийг "өөр дотор" нь үржүүлж гаргасан. Тамир хонь өндөр уулын бэлчээр сайн ашигладаг, чийрэг бие бялдартай, нутгийн хониноос биеэр том, ямаан үс багатай бүдүүвтэр ноостой. Үржлийн хуц 60 кг, эм хонь 50 кг жин татаж, хуцнаас 2.0 кг, эм хониноос 1.6 кг ноос авна. Ноосондоо ноолуур 83.0, завсрын үс 10.8, сор үс 1.2, ямаан үс 5.0 хувь байх ба ноолуур 7-8 см, сор үс 15-16 см урттай. 100 эхээс 105 хурга төрнө. Энэ хонь хөдөлгөөн сайтай, өвөл хаварт цас малтаж идээшилдэг, бага турж онд ордог ба зун намарт бэлчээрээр сайн тарга хүч авдаг биологийн онцлогтой болно.

Хотонт хонь

Хотонт хонь. Монгол хонины дотор нугалмын тоогоор илүү генотип байгааг илрүүлж түүний удамших зүй тогтлыг судалж уг шинж хонины галбир, ашиг шимд сайнаар нөлөөлдгийг судлан тогтоосны үндсэн дээр сээр нурууны нугалам, хавирга илүүтэй хонийг сонгон шилж, өөр хооронд нь нийлүүлэх, удамшлыг нь бататгах замаар тохиромжтой ижил эвсэл үрт илүү нугаламтай Хотонт үүлдрийн хэвшлийн хонийг бий болгосон юм.

Хотонт үржлийн хэсгийн хонины амьдын жин дунджаар үржлийн хуцных 68.2, төлгөн хуцных 54.1 кг, эм хониных 53.1 кг, охин төлөгнийх 43.2 кг татдаг. Эр хонины нядлагын жин 38.7 кг, нядлагын гарц 54.6 хувь, эм хонины нядлагын жин 25.3 кг, нядлагын гарц 49.1 хувь, арьсны талбай 123 хав. дөр. дм.

Хотонт хонь тухайн нутагт үржүүлдэг жирийн хоньтой харьцуулахад 1-2 нугалам, хавирга илүү, бие том, уртавтар, хуцны жин 9.8 кг, эм хониных 8.4 кг, охин төлөг 6.9 кг -аар давуу аж. Зориудын селекцийн аргаар гаргасан "Хотонт" үржлийн хэсгийн хонийг Архангай аймгийн Хотонт сумaнд үржүүлдэг.

Монгол оронд бий болгосон хонины арвин ашиг шимт шинэ үүлдэр, үүлдрийн хэсгүүд. Гадаадын арвин ашиг шимт үүлдрүүдийг нутгийн хонийг сайжруулагчаар ашиглан эрлийзжүүлэг явуулж улмаар дотор нь үржүүлж шилэн сонгох болон сайн үүлдрийн хуцаар хээлтүүлэх зэрэг үржил селекцийн нарийн төлөвлөгөө, зорилготой ажил явуулсны үр дүнд манай оронд хонины арвин ашиг шимт хэд хэдэн, шинэ үүлдэр, үүлдрийн хэсгийг сүүлийн жилүүдэд бий болгожээ. Тэдгээрээс дурдвал:

Орхоны нарийвтар ноост хонь бол манай орны анхны арвин шимт үүлдрийн мал болно. Нутгийн шилмэл хонийг перкос, цыгай, алтай үүлдрийн хуцаар хээлтүүлэн нарийвтар болон нарийн ноост эрлийз хонь гарган авч улмаар төрөл бүрийн эрлийз хонийг өөр хооронд нь үржүүлэх, дотор нь шилэн сонголт хийх замаар нарийвтар ноост тохиромжтой хэвшлийн хонь гарган авч цаашид сайжруулах замаар Орхон үүлдрийн хонийг бий болгосон ба 1961 онд нарийвтар ноост хонины үүлдэр болгон баталсан юм.

Орхон үүлдрийн хонь бие цогцос чийрэг, бэлчээрийн маллагаанд сайн зохицсон бөгөөд хуцны намрын жин 80-90 кг, эм хониных 55-60 кг, охин төлөгнийх 45-50 кг хүрдэг. Орхон хонь дунджаар 3.5 кг

Орхон хонь

нарийвтар ноос өгдөг. Хуцны ноосны гарц 6 кг, охин төлөгнийх 3.6, эм хониных 3.8 кг, 1 дүгээр ангийн эм хониных 4.3 кг байдаг. Орхон хонины ноосны нарийны чанар 58-56 хувь бөгөөд төлөрхөг чанар сайнтай, ихэрлэл 5-10 хувьд хүрдэг.

Хангай үүлдрийн нарийн ноост хонь. Энэ хонийг бий болгоход Алтай, Ставрополь үүлдрийн нарийн ноост болон бүдүүн ноост монгол хонийг ашиглах зэргээр үүлдэр гаргах эрлийзжүүлгийн аргыг хэрэглэж тохиромжтой хэвшлийн шаардлага хангасныг нь "өөр дотор" нь үржүүлэх аргаар 30 гаруй жилийн туршид явуулсан шургуу хөдөлмөрийн үр дүнд бий болгосон бөгөөд 1990 онд нарийн ноост Хангай үүлдрээр батлагдсан байна.

Хангай хонины хуц

Хангай хонины бүдүүн хуцны амьдын жин 85-90 кг, ноосны гарц 4.1-6.9 кг, төлгөн хуцны амьдын жин 50-55 кг, ноосны гарц 3.3-5.5 кг, эм хонины амьдын жин 55-60 кг, ноосны гарц 3.1-4.3 кг, охин төлөг 44-48 кг юм. Энэ хонь 60-64 чанарын ноос өгдөг. Ноосны урт 6.5-10 см, нарийн нь 18.0-25.0 мкм (микрон) болно.

Хангай үүлдрийн хонины гол онцлог нь манай орны ойт хээрийн бүсийн байгаль, цаг уурт бэлчээрийн маллагааны нөхцөлд сайтар зохицсон, нарийн ноос өгдөг байна. Хангай үүлдрийн хонийг Сэлэнгэ аймгийн Цагаан нуур, Булган аймгийн Орхон суманд үржүүлж байна. Төлөрхөг чанар сайтай, ихэрлэлт 4-5 хувь аж.

Тал нутгийн цагаан үүлдрийн хонь. Дорнод талын нутгийн бүдүүн ноост өөхөн сүүлт хонины ноосны гарц чанарыг сайжруулж, нутгийн байгаль, цаг уур, бэлчээр тэжээллэгийн нөхцөлд зохицсон мах, ноосны чиглэлийн нарийвтар ноост хонь бий болгох туршилт, судалгаа үйлдвэрлэлийн ажлыг Сүхбаатар аймгийн Асгат, Хэнтий аймгийн Хэрлэн сумдад явуулж эхэлсэн түүхтэй.

Талын цагаан үүлдрийн хонь

Энэ үүлдрийн хонийг бий болгоход Алтай, Өвөр байгаль, Цыгай зэрэг үүлдрүүдийг ашиглаж тохиромжтой хэвшлийн шаардлага хангасныг нь "өөр дотор нь" үржүүлэх замаар үржил, ашиг шимт чанарыг бататган, бие даасан үүлдрийн хэмжээнд хүргэсэн байна.

Тал нутгийн цагаан үүлдрийн хонины бүдүүн хуцны амьдын жин 72.1, ноосны гарц 4.0-6.0 кг, төлгөн хуцны амьдын жин 48.3 кг, ноосны гарц 2.6-3.6 кг, эм хонины амьдын жин 53.4 кг, ноосны гарц 2.5-3.5 кг, охин төлөгний амьдын жин 43.7 кг, ноосны гарц 2.3-3.0 кг байдаг. Тал нутгийн цагаан үүлдрийн хонины амьдын жин монгол хониныхоос 8-15 хувиар, ноосны гарц 2-3 дахин илүү төдийгүй, ноос нь 50-58 дугаар чанарын нарийвтар ноос болно.

"Талын цагаан" үүлдрийн хонийг 1993 онд үүлдрээр баталсан, одоо Хэнтий аймгийн Хэрлэн сумандуржүүлж байна.

Торгууд үүлдрийн хэсгийн хонь. Ховд аймгийн Булган сумандaд 1957 оноос эхлэн нутгийн ууцан сүүлт хонийг Сараджин үүлдрийн хуцаар

Торгууд хонь

эрлийзжүүлж, I, II үеийн эрлийз дотроос тохиромжтой хэвшлийн хонийг шилэн авч "өөр дотор" нь үржүүлэх аргаар мах-өөх-ноосны чиглэлийн бүдүүвтэр ноостой, ууцан сүүлт торгууд хонийг бий болгосон түүхтэй. Торгууд үүлдрийн хонь амьдын жингээр нутгийн монгол хониноос 15.9-17.7 хувиар, ноосны гарцаар 31-50 хувиар илүү бөгөөд бүдүүвтэр ноостой.

Үндсэн ашиг шим нь бүдүүн хуцны амьдын жин 84-89, ноосны гарц 2.5-2.8 кг, төлгөн хуцны амьдын жин 58-62 кг, ноосны гарц 2.2-2.6 кг, эм хонины амьдын жин 62-66 кг, ноосны гарц 2.0-2.5 кг, охин төлөгний амьдын жин 53-56 кг, ноосны гарц 1.5-1.6 кг байдаг. Торгууд үүлдрийн хэсгийн хонийг Ховд аймгийн Булган суманд голлон үржүүлдэг.

Жаргалант хонь. Нутгийн монгол, Алтай, Орхон үүлдрийн хонины оролцоотойгоор бий болгосон эрлийз хонийг Грузины нарийн ноост өөхөн сүүлт хуцаар 2 дугаар үе хүртэл шингээх эрлийзжүүлэгт оруулж, нарийвтар ноос, өөхөн сүүлний хослолоор тохиромжтой хэвшлийн шаардлага хангасан хонийг "өөр дотор нь" үржүүлж үржил, ашиг шимийг нь бататган сайжруулах аргыг хэрэглэн энэ "Жаргалант" үржлийн хэсгийн хонийг гарган авчээ.

Жаргалант хонины хуц

Нас гүйцсэн хуцны амьдын жин 62-68 кг, ноосны гарц 3.5 кг, эм хонины амьдын жин 50-52 кг, ноосны гарц 2.5 кг, охин төлөг 38-43 кг, ноосны гарц 2 кг байдаг. Мах-ноосны чиглэлийн нарийвтар ноост өөхөн сүүлт Жаргалант хонийг 1989 онд үржлийн хэсгээр баталсан. Жаргалант үржлийн хэсгийн хонийг Төв аймгийн Жаргалант суманд үржүүлж байна.

Ерөө хонь. Энэ хонийг бий болгох үржлийн ажлыг 1968 оноос эхлэн Сэлэнгэ аймгийн Ерөөгийн САА-д үржүүлж байсан эрлийз хонийг түшиглэн Куйбышев, Романи-марш үүлдрүүдийг ашиглан үүлдэр гаргах эрлийзжүүлгийн аргыг хэрэглэж Ерөө үүлдрийн хэсгийн хонийг гаргажээ. Энэ үүлдрийн хэсгийн хуцны амьдын жин 80-90 кг, ноосны гарц 6.5 кг, эм хонь 55-60 кг жин дарж, ноосны гарц 3.2 кг, охин төлөг 45-47 кг жин дарж 3.1 кг ноос өгдөг байна. Ноосны урт нь 13-16 см, 50-56 чанарын ноостой. Ноос нь урт учраас сүлжмэлийн үйлдвэрийн гол түүхий эд болдог. Мах-ноосны чиглэлийн урт нарийвтар ноост Ерөө үүлдрийн хэсгийн хонийг Сэлэнгэ аймгийн Ерөө суманд үржүүлж байгаа бөгөөд энэ хонины аж ахуй биологийн ашигтай шинж чанарыг нь бататган сайжруулах зорилгоор тодорхой тооны цөм сүргийн хонийг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнд үржүүлж байна.

Ерөө хонь

Сүмбэр хонь. Монгол үүлдрийн хонийг каракул хуцаар 3 дугаар үе хүртэл цус шингээх эрлийзжүүлэг явуулж тохиромжтой хэвшлийн шаардлага хангасан хэсгийг "өөр дотор нь" үржүүлэх аргыг голчлон хэрэглэж хурганы арьсны чиглэлийн хонийг бий болгосон байна.

Сүмбэр үүлдрийн хонины бүдүүн хуц 68-72 кг, ноосны гарц 2.6 кг, төлгөн хуц 50-54 кг, ноосны гарц 2 кг, эм хонины амьдын жин 50-58 кг, ноосны гарц 1.8 кг, охин төлөгний амьдын жин 40-48 кг, ноосны гарц 1.6 кг байдаг.

Сүмбэр хонь нь монгол орны байгаль, цаг уур, бэлчээрийн маллагаанд гойд зохицсон хурганы буржгар арьс өгөх чадвартайгаар онцлог юм. Энэ үүлдрийн хонийг Говьсүмбэр аймагт үржүүлж байна.

Сүмбэр каракуль хонь

Нутгийн монгол ямаа, түүний үүлдэр омгууд

Нутгийн монгол ямаа бол Азийн ноолуурын хэв шинжийн мал бөгөөд монгол ямааны бие бялдар чийрэг, галбирын согоггүй, бие харьцангуй уртавтар, навтгардуу, хондлой өндөртэй, цээжин бие булчингийн хөгжил сайнтай. Толгой хөнгөн, хошуу шөвгөр, эр, эм хүйсний ялгаа сайн илэрсэн, ихэнх нь эвэртэй байдаг. Монгол ямаа бие жижигтэй, биеийн масс нь дунджаар 35.6 кг хүрдэг. Монгол ямаа ноолуурын нарийн, урт, өтгөн, бат бөх жигдлэг чанарын үзүүлэлтээр дэлхийд чанартай түүхий эдэд тооцогддог. Монгол эм ямаа дунджаар 230 грамм, ноолуур өгдөг. Ноолуурын нарийн 13.09-16.05 микрон (мкм), урт нь 47-66.0 мм болно.

Монгол ямаа

Нутгийн ямааны дотор хэд хэдэн үүлдрийн хэсэг, омгийн ямааг ялган үздэг. Тэдгээрээс товч өгүүлье.

Алтайн улаан үүлдрийн хэсгийн ямаа. Алтайн улаан ямаа монгол орны Алтайн өвөр говь, Алтайн нурууны байгаль,цаг уур, бэлчээрийн маллагаанд зохицсон, тэсвэр сайтай, галбирын согоггүй, яс, булчин, хөл мөч, туурай хэвийн хөгжилтэй, ясжилт сайнтай, чийрэг бие цогцостой, наран эвэртэй, улаан, цайвар улаан, хүрэн улаан, улаан бор зүстэй байдаг.

Намар бүдүүн ухна 60.0-64.0, борлон ухна 36.0, бүдүүн эм ямаа 49.0-53.0 кг, охин шүдлэн 27.0-30.0 кг жинтэй, бүдүүн ухна 460.0, борлон ухна 250.0, эр ямаа 600 грамм ноолуурын гарцтай, дунджаар 6.0 см урт, 13.6-15.2 мкм нарийнтай цайвар өнгийн ноолууртай.

Алтайн улаан ямааг Ховд аймгийн Алтай суманд цэвэрээр үржүүлж зэргэлдээ сумдын монгол ямаанд сайжруулагчаар ашиглаж байна. 2003 онд үүлдрийн хэсгээр батлагджээ.

Алтайн Улаан ямаа

Баяндэлгэрийн улаан ямаа. Энэ омгийн ямаа нь тал хээр, говь, цөлөрхөг нутгийн бэлчээрийн маллагаанд зохицсон мал. Бие цогцос чийрэг, болхидуу, навтгардуу, лагс биетэй, галбирын согоггүй, цайвар шаргал, улаан шаргал, үзмэн хүрэн зүстэй. Намар үржлийн бүдүүн ухна 60-65, борлон ухна 35.0, эм ямаа 46.0, эм борлон 31-32 кг жинтэй, бүдүүн ухна 300-350, борлон ухна 240-250, эм ямаа 340, охин борлон 240-250 грамм ноолуурын гарцтай, ноолуур нь тод цайвар өнгөтэй, 12-15 микрон нарийнтай байна. Энэхүү улаан ямааг Сүхбаатар аймгийн Баяндэлгэр суманд цэвэрээр үржүүлж бусад аймаг, сумын ямаанд сайжруулагчаар ашиглаж байна.

Увсын Улаан ямаа

Увсын "Өлгийн улаан" омгийн ямаа. Их нууруудын хотгорын бэлчээрийн маллагаанд зохицсон, тэсвэр сайтай, намар бүдүүн ухна 56.0, эм ямаа 44.0 кг, цөм сүргийн шилмэл бүдүүн ухна 80 кг, эм ямаа 50.0 жинтэй, бүдүүн ухна 350-450 гр, эм ямаа 320-360 грамм ноолуурын гарцтай, тохиромжтой хэвшлийн ямааны ноолуур хялгасны харьцаа 55-65, ноолуурын нарийн 14-17 мкм, урт нь 4.5-6.0 см цайвар өнгөтэй байдаг. Ямааны үндсэн зүс нь улаан. Өлгийн улаан омгийн ямааг Увс аймгийн Өлгий суманд цэврээр үржүүлж бусад аймаг, сумдын монгол ямаанд сайжруулагчаар ашиглаж байна

"Эрчим" омгийн хар ямаа. "Эрчим" ямааг үржүүлдэг нутаг нь Хөвсгөлийн Эрчмийн нурууны өвөр бие, өндөр уулын нутаг болно. "Эрчим" ямаа тэсвэртэй, чийрэг бие цогцостой, том, лагс биетэй, ясжилт сайнтай, хар зүстэй.

Намар дунджаар бүдүүн ухна 58.0, эм ямаа 42.0 кг, шүдлэн ухна 37.0, охин борлон 33.0 кг жинтэй, бүдүүн ухна 350, шүдлэн ухна 250.0, эм ямаа 285.0, охин борлон 230.0 грамм ноолуурын гарцтай, 13.9-14.7 мкм нарийнтай цайвар өнгийн ноолууртай. "Эрчим" ямааг Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд цэврээр үржүүлж бусад аймаг, сумдын монгол ямаанд сайжруулагчаар ашиглаж байна.

"Буурал" омгийн ямаа

Завханы "Буурал" омгийн ямаа. Их нууруудын хотгор орчмын элсэрхэг зөөлөн хөрстэй, говирхуу нутгийн бэлчээрийн маллагаанд зохицсон, тэсвэртэй, хар бууралдуу зүстэй, толгой, хөл зэрэг биеийн зарим хэсэгт цагаан, улаан шаргал зурвас толботой байдаг.

Намар бүдүүн ухна 53.0, эм ямаа 37.0 кг жинтэй, бүдүүн ухна 350 г, эм ямаа 360 грамм ноолуурын гарцтай, 15-16 мкм нарийнтай цайвар саарал өнгийн ноолууртай. Буурал омгийн ямааг Завхан аймгийн Дөрвөлжин суманд цэврээр үржүүлж бусад аймаг, сумдын монгол ямаанд сайжруулагчаар ашиглаж байна.

Залаа жинстийн цагаан омгийн ямаа. Монгол орны говь, цөлөрхөг нутгийн бэлчээрийн маллагаанд зохицсон тэсвэр сайнтай, галбирын согоггүй, хөл, мөч, эвэр туурай хэвийн сайн хөгжилтэй, ясжилт сайнтай, богиновтор чацтай, биерхүү, чийрэг бие цогцостой, их бие, хүзүү, толгой, хөл мөч, гэдэсний урт хялгас, ноолуур ургадаг хэсгүүдэд цагаанаас өөр өнгийн толбогүй, нүдний зовхи бараан, хүрэн бор, хар өнгөтэй, наран гэдэргээ хэлбэрийн дунд зэргийн хэмжээтэй эвэртэй, цагаан зүстэй ямаа болно.



"Залаа жинстийн цагаан" ямаа

Намар бүдүүн ухна 58.0, бүдүүн эм ямаа 40.0 кг, шүдлэн ухна 33.0, охин шүдлэн 29.0 кг амьдын жинтэй, бүдүүн ухна 378.0, борлон ухна 250.0, охин борлон 263.0 грамм ноолуурын гарцтай, 4.5 см урт, 14.5-15.5 мкм нарийнтай цагаан өнгийн ноолууртай.

"Залаа жинстийн цагаан" омгийн ямааг Баянхонгор аймгийн Шинэжинст суманд цэврээр үржүүлж байна.

Говьгурван сайхан үүлдрийн ямаа. Монгол ямааны ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор Оросын холбооны улсаас авчирсан Дон хавийн үүлдрийн ухнаар говийн аймгуудын нутгийн монгол ямааг 2 дугаар үе хүртэл эрлийзжүүлж гарсан тохиромжтой хэвшлийн шаардлага хангасан ямааг өөр дотор нь үржүүлэх аргаар ноолуурын чиглэлийн ямаа бий болгосноор 1971 онд Говьгурвансайхан үүлдрээр баталжээ. Говьгурвансайхан үүлдрийн ямаа, өвөл, хавар бор саарал, зун намар хар зүстэй, бор саарал өнгийн ноолууртай.

Говьгурван сайхан үүлдрийн ямаа

Намар энэ үүлдрийн бүдүүн ухна 55.0, бүдүүн эм ямаа 40.0 кг жинтэй, үржлийн бүдүүн ухна 600-800, эм ямаа 400-500, борлон 320-350 грамм ноолуурын гарцтай, нийт үсэнд ноолуур 71.5-82.3 хувийг эзэлж ноолуурын урт 9.0 см, голч нь 16-19 мкм бараандуу бор, бор шаргал өнгөтэй байдаг. Говьгурвансайхан үүлдрийг Өмнөговь аймгийн Булган суманд цэврээр үржүүлж бусийн ямааг сайжруулагчаар ашиглаж байна.

"Уулын бор" үүлдрийн хэсэг. Баян-Өлгий аймгийн нутгийн ямааг Оросын Холбооны Улсын уулархаг Алтай үүлдрийн ухнаар хоёрдугаар үе хүртэл эрлийзжүүлж тохиромжтой хэвшлийн шаардлага хангасан ямааг өөр дотор нь шилэн сонгож үржүүлэх замаар ноолуурын чиглэлийн "Уулын бор" үүлдрийн ямааг бий болгожээ. Энэ үүлдрийн хэсгийн ямаа тэсвэр сайнтай, сайжруулагч үүлдрийн ашиг шимт шинжийг хадгалж чадсан, өсөлт сайтай, бие томтой, чийрэг бие цогцостой, хар зүстэй, бараандуу ноолууртай, жилийн турш бэлчээрийн маллагаанд байдаг.

Уулын бор ямаа

Намар бүдүүн ухна 62.0, эм ямаа 43.0 кг, шүдлэн ямаа 33.5 кг жинтэй, бүдүүн ухна 740.0, эм ямаа 540.0,

охин шүдлэн ямаа 340 грамм ноолуурын гарцтай, нийт үсний 70-80 хувийг ноолуур эзэлж, ноолуурын урт 7-9.0 см, голч 17-20 мкм байх бөгөөд завсрын үс 16-26 хувийг эзэлдэг.

"Уулын бор" үүлдрийн хэсгийн ямааг Баян-Өлгий аймгийн Баян нуур, Дэлүүн, Булган суманд цэврээр үржүүлж, бусийн сумын ямаанд сайжруулагчаар ашиглаж байна.

"Өнжүүл" үржлийн хэсгийн ямаа. 1962 оны үеэс хуучин нэрээр Зөвлөлт улсаас авч ирсэн ноосны чиглэлийн үүлдрийн ухнаар нутгийн монгол ямааны II, III үе хүртэл эрлүүзжүүлж тохиромжтой хэвшлийн шаардлага хангасан ямаанд шилэлт, тохируулгын сонголт хийж өөр дотор нь үржүүлэх замаар ноосны чиглэлийн ямаа буй болгосныг ноосны чиглэлийн Өнжүүл үржлийн хэсгээр баталжээ. Энэ үржлийн хэсгийн ямаа бэлчээрийн маллагаанд зохицсон чийрэг бие цогцостой, галбирын түгээмэл согоггүй, биеийн хойт хэсэг өндөрдүү, торгомсог, гялалзсан цагаан өнгийн ноостой, бэлчээрээр таргалах чадвар сайтай, махан ашиг шим арвинтай, мах нь чанар сайтай, амтлаг байна.



Өнжүүлийн цагаан ямаа

Намар "Өнжүүл" үржлийн хэсгийн ухна 55-60, эм ямаа 30-40, шүдлэн ухна 29-34.0, шүдлэн эм ямаа 26-34.0 кг жинтэй, бүдүүн ухна 1.5-2.0, эм ямаа 1.1, борлон ухна 0.7-0.8, охин борлон 0.6 кг ноосны гарцтай, ноос нь угаасаа үзүүр хүртэл жигд тогтсон долгион маягийн атриатай, гялалзсан цагаан өнгийн, 18-25 см урт, бат бөх чанарын ноостой байна. Өнжүүл үржлийн хэсгийн ямааг Төв аймгийн Баян-Өнжүүл суманд цэврээр үржүүлж байна.

Тулман хөхт ямаа бол нутгийн монгол ямааны нэг шилмэл омог. Энэ ямаа галбир хийцийн нэлээд хатингардуу, туранхайвтар, толгой богино, хөнгөн, уртавтар, нарийн хүзүүтэй, сэрвээ тэгш, нуруу шулуун, цээж гүнзгий, хөл чийрэг, ясархаг, хойд хоёр хөл ялимгүй гадагш хандсан, хэвэл нь цавь орчмоор цүлхийсэн том, дэлэн хөх сайн хөгжсөн, багтаамж ихтэй аж. Тулман хөхт ямааны үндсэн ашиг шим нь сүү болно. Энэ ямааны саалийн хэмжээ саалийн аль ч сард нутгийн монгол ямааныхаас 2 дахин илүү байдаг.

Хоногт дунджаар 800 грмм гаруй, саалийн хугацаанд 100 гаруй л сүү өгдөг. Ид саалийн үед 6-8-р сард 1 л гаруй сүү өгдөг ямаа цөөнгүй тохиолддог. Тулман хөхт ямаа Говь-Алтай, Баянхонгор аймгийн говийн сумуудад голдуу тархжээ.

Нутгийн монгол үхэр, сарлаг, махны үхрийн омог үүлдэр

Нутгийн монгол үхэр биеийн галбир хийц болон дотоод цогцосын хувьд бусад үүлдрийн үхрээс эрс ялгаатай. Нутгийн монгол үхэрт толгой хөнгөн, жижиг, дух богинохон, өргөн, хамар хянган, бага зэрэг хотгор, хоншоор нарийн, дагз сэртэнгүй, голдуу хомбон эвэртэй, хоёр эврийн хоорондох зай бага, хүзүү богино, бүдүүн, омруу сайн хөгжсөн, сэрвээ намхан, цээж өргөн гүн, нуруу тэгш өргөн чийрэг, ахар ууц, хондлой намхан зэрэг шинж илэрдэг. Харин бөгсөн тал нь унжуу хавчиг, шувтан зэрэг галбирын согог олонтоо тохиолддог. Гэдэс хэвлийн сайн хөгжсөн, урд хөл богино, тавьц өргөн, зөв гишгэлттэй, харин хойд хөл цэх, шулуун тавьцтай боловч борвио хавирсан майга буюу суунги гишгэлттэй байх нь тохиолддог. Дэлэн хөх жижиг, сахлаг өтгөн үстэй, бие бялдрын ерөнхий шинж байдал нягт, чийрэг цул, чанга,

Монгол үүлдрийн бух

бүдүүн пагдгар, арьс хөрслөг зузаан, үс нь сахлаг, яс нь бөх бат аж. Монгол үхэр биеийн галбир хийцээр махны хэв маягийн үхэрт ойртож очдог байна. Монгол үнээний амьдын жин 280-300 кг, бухных 360-450 кг хүрдэг. Дан бэлчээрийн маллагааны нөхцөлд тугалаар нь ивэлгэн саахад монгол үнээний саам саалийн хугацаанд 300-400 литр, 4-5 хувийн тослогтой сүү өгдөг.

Сарлаг чийрэг бие цогцостой, галбир хийц сайтай, толгой том, дух өргөн, хотгордуу, хошуу урт, товгордуу, хар хамрын толио жижиг, нимгэн зөөлөн, хамрын нүх нарийхан сортон, уруул нимгэн, хөдөлгөөн сайнтай, нүдний аяга товгор, чих богино, хулгардуу, голдуу эвэргүй байдаг. Сарлагийн хүзүү богино, багалзуураараа нарийхан, хүзүү уг тийшээгээ нэлээд

Сарлагийн сүрэг

өргөн, хүзүүний арьсны атираа жижиг, шалан байдаггүй, мөн сээрний сэртэн урт бөгөөд эгц босоо байдгаас сэрвээ овгор өндөр, нуруу хондлой харьцангүй намхан, ташаа богино, бөгс шувтан, хэвэл бага, дээр суусан өтгөн сахлаг богиновтор сүүлтэй, хөл, ялангуяа урд хөл богинохон чийрэг, туурай жижиг бөх бат, хойд хөл сариудуу болно. Сарлагийн хүйсний ялгаа тод илэрсэн, бух нь бие томтой, савга, ноолуур ихтэй байдаг. Нас бие гүйцсэн сарлагийн бүдүүн үнээний намрын жин 280, бухных 450 кг хүрдэг. Сарлагийн үнээ саалийн хугацаанд 500-700 литр, 6-7 хувийн тослогтой, өтгөн сүү өгдөг.

Хайнаг биеийн гадаад галбир хийцээр монгол үхэр, сарлагийн дундаж байдлыг хадгалсан, чийрэг, том бие цогцостой мал. Монгол үхрээс 120-иод, сарлагаас 150 гаруй кг-аар илүү жин дардаг. Хайнагийн үнээ 800-1000 литр сүү өгдөг. Сарлагийн үнээг монголын

(үхрийн) бухаар хээлтүүлэхэд гарсан эрлийзийг "Саран" хайнаг гэдэг.

Сүрэг хайнаг

Дорнод монголын мухар улаан үхэр бол монгол үхрийн шилдэг омогт тооцогддог ба бие томтой, махны хэвшлийн шинж сайн илэрсэн мал болно. Энэ хэвшлийн үхэр бие чийрэг, нягт, махны үхрийн галбир хийцтэй, үнээний биеийн жин 370-400 кг, үржлийн бухных 550-600 кг хүрдэг аж. Энэ омгийн үхрийг өсвөр насанд нь шахаж бордоход биеийн масс нь 18 сартайд нь 300-320 кг хүрдэг байна. Энэ үхрийг Дорнод аймгийн Халх гол, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд үржүүлж нутгийн үхрийн махны ашиг шим сайжруулагчаар ашиглаж байна.

Дорнод монголын мухар улаан үхэр

Сэлэнгэ үүлдрийн махны үхэр бол нутгийн монгол үхрийг (үнээг) махны хэвшлийн Казахийн цагаан толгойт үүлдрийн бухаар сайжруулан эрлийз үхэр гарган авч улмаар ийм үхрийг амьдын жин махлаг шинж, чацархаг байдлаар нь сонгон шалгаруулж махны тохиромжтой хэвшлийн удам үүсгэх замаар махны Сэлэнгэ үүлдрийг бий болгосон юм.

Сэлэнгэ үүлдрийн нас бие гүйцсэн үнээ 470 кг жин, бух 668-770 кг хүрдэг байна. Сэлэнгэ үүлдрийн үхрийн гол цөм нь Булган аймгийн Сэлэнгэ сум, Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Архангай аймгийн Түвшрүүлэх сум болно. Энэ үүлдрийг Архангай, Булган аймгуудад өсгөн үржүүлж байна.

Сэлэнгэ үүлдрийн үхэр

Монгол тэмээ, түүний омгууд

Монгол орон хоёр бөхт тэмээний уугуул нутаг бөгөөд дэлхийн нийт хоёр бөхт тэмээний 30 хувь нь манай улсад байдаг. Монголын бактериан шулуун шөмбөгөр хошуутай, өргөн духтай, богино хөнгөн толгойтой, дээд тал нь салаа, доодох нь бага зэрэг унжуу уруултай, хамрын нүх жижиг, урт, чих богино зузаан, хөдөлгөөн сайтай, хүзүү урт, гэдгэр, хөдөлгөөн сайнтай, сэрвээ өргөн урт, цээж хэнхдэг гүн, өргөн, их бие урт, бөх өндөр, уужим зайтай, нуруу урт, өргөн шулуун, хавирга урт өргөн, матаас сайтай, ууц хондлой хөгжил сайн, сүүл богинохон, уг руугаа бүдүүн, хөл мөч шулуун, чийрэг, уужим тавилттай, ул таваг, хумсны хэлбэр нь зөв, хэвийн хөгжилтэй, сайрууд сайн хөгжсөн зэрэг галбирын онцлогтой мал болно. Монгол тэмээний нас бие гүйцсэн ингэ намар 528.1 ±0.49, ат 621.0±1.1 кг жин дардаг байна.

Монгол тэмээний дотор ханын хэцийн хүрэн, галбын говийн улаан зэрэг шилмэл омгийн тэмээг ялган үздэг.

Тэмээн сүрэг

Ханын хэцийн хүрэн омгийн тэмээ. Энэ омгийн тэмээ бие томтой, амьдын жин ихтэй, арвин ноостой, ачаа даах чадал сайтай-гаараа говь нутагт алдартай аж. Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Шовгон үнэгээ, Ханын хэц, Улаан нуур, Онгийн голын адагийн сав нутагт энэ тэмээг өсгөн үржүүлж ирсэн ба 1970-аад оноос энд тэмээний үржлийн ферм байгуулж энэ тэмээний биологи, аж ахуйн чанарыг судлан батжуулах судалгаа, үржлийн селекцийн ажлыг өргөн хүрээтэй явуулж "Ханын хэцийн хүрэн" омгийн тэмээг бий болгожээ. Энэ омгийн тэмээний 75 гаруй хувь нь хүрэн зүстэй. Энэ омгийн тэмээ ерөнхийдөө өндөр зэгзгэр, лагс биш, уналганд илүү тохирсон галбиртай аж. Сүргийн дунджаар ингэний ноосны гарц 5.5 кг, буурных 7.5 кг хүрдэг.

Ханын хэцийн хүрэн тэмээ

Галбын говийн улаан тэмээ. Эрт дээр үеэс Галбын говь нутаг буюу Түшээ хан аймгийн Говь мэргэн хошуу улаан зүсний бие томтой, сайхан тэмээтэй гэж алдаршжээ. Галбын говийн тэмээний биологи, аж ахуйн онцлогийг нухацтай судлах зорилгоор энэ нутагт 1976 онд улсын үржлийн ферм байгуулан нутгийн шилмэл омгийн тэмээний ашигтай чанаруудыг улам батжуулах судалгаа хийх болон тоо толгойг нь өсгөх үржил селекцийн ажлыг нарийн төлөвлөгөө, тодорхой зорилготой явуулж улмаар Галбын говийн улаан тэмээний омгийг бий болгосон байна. Сүргийн дунджаар ингэний ноосны гарц 5.5 кг, буурных 10.5 кг болно. Буурны амьдын жин дунджаар 659 кг, ингэнийх 568.5 кг аж. Одоо Галбын говийн улаан омгийн тэмээг Өмнөговь аймгийн Ханбогд суманд голчлон үржүүлдэг ба энэ омгийн буурыг говийн аймгуудын тэмээн сүргийн бие бялдрыг томосгох, ноосны гарцыг нэмэгдүүлэхэд сайжруулагчаар ашиглаж байна.

Галбын говийн улаан тэмээ

Төхөм тунгалагийн буюу Төгрөгийн хос зогдортой тэмээ. Энэ омгийн тэмээг Говь-Алтай аймгийн Төгрөг суманд Монгол Алтай, Говь-Алтайн нурууны дагуу нутагт үржүүлдэг. Дотор нь ноосорхог, биерхэг, тохиромжтой гэсэн хэд хэдэн хэвшлийг ялган үздэг. Энэ омгийн тэмээний гол онцлог бол хоолой, шилнээс гадна хүзүүний хоёр талаар давхар зогдортой байдаг явдал юм. Энэ омгийн тэмээний ноосны гарц сүргийн дунджаар 5.6-5.8 кг болно.

Төгрөгийн хос зогдортой тэмээ

Монгол адуу түүний шилдэг омог, хэвшлүүд

Монголчуудын нүүдлийн амьдралд адуу ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг, уналга, холбоо, тээврийн гол мал байв. Нүүдэлч малчны бүх амьдрал морьтой холбоотой, морь бол монгол хүний үнэнч хань. Иймээс тэд адуу, морийг эрт дээр үеэс эрхэмлэн хүндэлж хурдан, хатирч, жороо морь сонгон шалгаруулж уралдуулан морин спорт хөгжүүлж ирсэн уламжлалтай.

Монгол адуу бол галбир хийц, бие бялдрын хувьд биеэ даасан өвөрмөц хэв шинжтэй, дан бэлчээрийн маллагаанд гойд зохицсон үүлдрийн мал гэж судлаачид үздэг. Монгол адуу бие жижиг, уртаашаа сунгуу, толгой болхи том, чих богино, нүд жижиг, хүзүү богино бүдүүн, цээж өргөн гүн, нуруу харьцангуй урт шулуун, хондлой налуу, хөл богино чийрэг, яс бүдүүнтэй, шөрмөс бат бэх сайн галбир хийцтэй, чийрэг бие цогцостой мал болно. Нас бие гүйцсэн монгол адууны биеийн жин 290-360 кг-ын хооронд хэлбэлздэг.

Монгол үүлдрийн адууг өсгөн үржүүлдэг бүс нутгийн байгаль, экологийн онцлог, бие галбирынх нь хийцийн байдлаас хамааран дотор нь уулын, ойн, тал хээрийн, говийн адуу гэж хэд хэдэн хэв шинжид ангилдаг нь бий. Бас монгол адууны дотор галширын, тэсийн голын, мянгадын, дархадын цагаан адуу гэсэн омог, хэвшлийг ялган үздэг.

Галширын адуу. Энэ адууг Цэцэн хан аймгийн Хардал жанжин бэйсийн хошуунд одоогоос 100 гаруй жилийн өмнө ардын селекцээр бий болгожээ.

Галширын адууг одоо Хэнтий аймгийн Галшир суманд цэврээр үржүүлж байгаагаас гадна мөн аймгийн Дархан, Баянхутаг, Төв аймгийн Баянцагаан, Баянжаргалан, Баян сумдад тархжээ. Энэ омгийн адуу тал хээрийн бүс нутагт гойд зохицсон бөгөөд хурдан удам, угшлын адууны бие бялдар, галбир хийцтэй, тухайлбал бие жижгэвтэр нарийхан, толгой хөнгөн, хараа хурц, чих том биш босоо, хөлийн шөрмөс тод бүдүүн, туурай нь бат бэх зэрэг галбирын онцгой шинжүүдтэй аж. Сүүлийн жилүүдэд Галширын хурдан удмын шилдэг азарга, гүүгээр тал хээр нутгийн адуун сүргийг сайжруулах үржлийн ажлын чиглэл баримтлах боллоо.

Галширын хурдан удмын азарга

Тэсийн голын адуу. Энэ омгийн адууг Тэсийн голын сав нутагт Хөвсгөл, Завхан, Увс аймгийн нутгуудад үржүүлдэг.Тэсийн голын адуу бие томтой, мах ихтэй, уналга эдэлгээний чадвар сайн, хурдан зэрэг сайн чанаруудаар нутгийн жирийн монгол адуунаас ялгагддаг. Тус адуу нь Тэсийн голың сав газрын байгаль, орчны нөхцөлд тухайлбал өвөл цас их унадаг, хасах 50 хэм хүртэл хүйтэрдэг, зун нь их халуун, элсэрхэг зөөлөн хөрстэй нутагт сайн зохицсон мал бөгөөд бие том, чацархаг, урт өтгөн дэл сүүлтэй, сахлаг хөөвөртэй, том далбагар туурай, цээжин бие, хөл мөч сайн хөгжсөн, хурданы шинж илэрсэн байдаг.

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан Уул, Завханы Баянтэс, Баян-Уул, Увс аймгийн Зүүнговь, Тэс суманд энэ адууг цэврээр үржүүлж байна.

Тэсийн голын адуу

Дархадын адуу. Энэ омгийн адуу нь дээр үеэс Хөвсгөл, Саяны 2300-2500 м өргөгдсөн, өвөл 40-60 см цас унадаг, хасах 50 хэм хүртэл хүйтэрдэг тайгын эрс тэс нөхцөл бүхий бүс нутагт дан бэлчээр ашиглан өсч, үржиж амьдарч иржээ. Дархад адуу тэсвэр хатуужлаар сайн, чадал тэнхээ ихтэй, уналга эдэлгээ их даадаг, бие чийрэг, бат бэх, ул туурай сайтай мал болно. Дархад адууны зүс голдуу цагаан цайвар, борлог байдаг.

Одоо энэ адууг Хөвсгөлийн Ринчинлхүмбэ, Улаан уул, Баянзүрх сумдад зонхилон цэврээр үржүүлж байна.

Дархад адуу

Мянгад адуу. Энэ адуу нь нутгийн монгол адууны нэг, омог хэвшилд тооцогддог ба Ховд аймгийн Мянгад, Дөргөн, Алтан Хөхий, Их нууруудын хотгорын байгаль цаг уурын эрс тэс нөхцөл бүхий өвөрмөц бүс нутагт үржүүлдэг. Мянгад адуу цээж өргөн, гүн, нуруу шулуун, хондлой бөөрөнхий, сахлаг өтгөн сүүлтэй, толгой харьцангуй том, хамар монхор, хамрын нүх уужим, хавирга матаас сайтай, яс бат бөх, шөрмөс их тод, цомбон туурайтай. Мянгад адуу бие томтой, нас бие гүйцсэн гүү 340-360 кг, азарга 350-370 кг жин дардаг.

Мянгад адууны азарга

Ардын мал эмнэлэг

Монголын нүүдэлч малчид олон зууны туршид дан байгалийн бэлчээрт дулдуйдсан нүүдлийн мал аж ахуй эрхлэн хөтлөх явцдаа малын элдэв эмгэг согогийг анагаан засах алив хор, хордлогыг тайлан илааршуулах талаар ихээхэн мэдлэг, туршлага хуримтлуулж ардын мал эмнэлгийг үүсгэн бий болгожээ.

Голдуу арчилгаа, маллагаа, уналга эдэлгээний горим алдагдсанаас бэлчээрийн монгол малд элдэв ургамлын хордлого, бэртэнгэ: яс хугарах, үе мултрах, шөрмөс, булчин сунах, тасрах адуу зоо нуруугаа авах, жилбэндэх, тэмээ зоостох, амруутах, улдах, үхэр дэлүүтэх, бог малын түүдэгтэх, доголох зэрэг эмгэг согогийг малчин ардууд дээр үеэс анагаан засаж ирсэн уламжлалтай. Ардын мал эмнэлгийн гол арга нь эмийн ургамлын ханд уулгах, ийм шингэнээр шарх, шалбархай, бэртэнгийг шавших, судас ханах, мэдрэлийн судал, цэгүүдийг хатгах, яс хугарах, үе мултрахад чиг мод барьж боох зэрэг байжээ. Малчид манай оронд ургадаг 800 гаруй зүйлийн эмийн ургамлуудыг сайн таньдаг, эмийн ургамлуудаар шингэн (ханд), хуурай (нунтаг) хэлбэрийн эмийн бэлдмэлүүдийг бэлтгэж хэрэглэдэг байжээ. Малчид малын бие бүтцийн талаар нарийн мэдлэгтэй цусны судас, мэдрэлийн судал, цэгүүдийн байршлыг сайн мэддэг, энэ мэдлэгээ ханах, хатгах засалд ашигладаг байжээ.

Мал засах, хөнгөлөх. Мал засах, хөнгөлөх ажиллагаа нь чухмыг хэлбэл малын бие бүтцийн нарийн мэдлэг шаардсан мал эмнэлгийн мэс заслын ухааны өвөрмөц ажилбар бөгөөд энэ ажилбарыг малчид дээр үеэс бие даан хийж иржээ. Бух хөнгөлөх, азарга үрээ агтлах, буур засах, бог мал хөнгөлөхөд ардын мал эмнэлгийн баримтлаж ирсэн гол зарчим бол шарх бага гаргах, бохирдохоос сэргийлэх, цус алдахад хүргэхгүй байх явдал бөгөөд хурга, ишиг, бяруу хөнгөлөхдөө хуухнагны арьсыг өчүүхэн хэмжээтэй огтлон зүсэж, тэр нүхээр нь баруун, зүүн төмсөгийг нь ээлжлэн сугалан авч, шархны амсрыг сайтар аваачин нааж нийлүүлдэг бол үрээ, тайлагийн төмсөгний судас, хөвчирхийг савслагаар хавчиж улмаар төмсгийг эрчлэн мушгих замаар таслан авч үлдсэн шархыг улайсгасан төмрөөр хайран цус алдалт болон шарх бохирдохоос сэргийлдэг байна. Мал хөнгөлөх ардын арга эдүгээ хүртэл орон нутагт ашиглагдсаар байна.

Соёнготох. Үрээ адууг агталсны дараах хүндрэлийг тийнхүү нэрлэнэ. Засааны арьс хавдах, өвчүү өехийн орчмоор хавдах, хуухнагаас цус гарах, доголох, тэжээл усандаа дургүй болох шинж тэмдэг илэрнэ.

Үхэр, хонины махны шөл өгөх, салхигүй газар уях, тэжээлийг сайжруулах арга хэмжээ авна. Шинэс модны давирхайгаар утвал сайн гэдэг. Бөгсөн биеийг битүү хучин, аргалын цогон дээр хар модны давирхай тавьж шархыг утах, тарваганы тос, төлөгч өвсний ханд өгөх, засааг буцалгаж шөлийг өгөх гэх мэт засал хийнэ. Цус их гарвал хоёр чихний угаар боож цаг хэртэй байлгавал цус тогтоно. Энэ нь рефлекс эмчилгээний арга юм.

Юмдүүжин (согоо суман), барагшуны ханд өгвөл нэн сайн. Говь нутагт барагжамба хэмээх ургамлын ханд өгч засал хийдэг. Бас орсон буурны шилний булчирхайгаас ялгардаг шүүрлийг устай найруулж өгвөл ашигтай гэж үздэг.

Адуу жилбэнтэх. Эдэлгээний ба уяа сойлгоны гам алдаснаас адуу эмгэг согогийг олохыг малчид ерөнхийд нь жилбэн гэж нэрлэдэг. Жилбэнг дотор нь усан, тосон, наран, ташуурын жилбэн гэж ангилдаг. Жилбэнтсэн адуу өнгө зүсээ алдаж өвс тэжээлдээ дургүй, турахаас гадна бусад төрлийн өвчин эмгэгт амархан нэрвэгддэг.

Усан жилбэн голдуу хавар, хатуу хахир цагт буруу эдэлснээс, тосон жилбэн намар цагт тарган адуунд уяа сойлго тохироогүй гам алдсанаас болж тусдаг аж. Жилбэнтсэн адууны нуруу хавдах, нэвчин цоорох нь олонтоо аж. Жилбэнтсэн адууг эмчлэхдээ арчилгаа маллагааг сайн тохируулахаас гадна хөх дарь, баавгайн доньт, түлсэн шар будаа, шар тос, малын цөс, цагаан мөөг зэргийг өгдөг. Бас хонины ясны шөл, гөлөглөн байгаа бургасны дол, хар модны нялх боргоцойны чанамал, бас сүүлний гол, сүүлний угийн судас, хааны судас, ороо хар, хар хонгоны судас зэргийг хатгадаг.

Тэмээ зоостох. Тэмээний багалзуур хоолонд зоос хэмээх дугираг улаан яр гарахыг зоостох гэнэ. Зоостсон тэмээнд шүлсээ гоожуулах, хөөсрөх зэрэг шинж илэрнэ. Өвс тэжээлээ идэхээ больж богино хугацаанд эцэж турна. Улаан толбон яруудыг хусан шалбалж цус гарган давс нунтаглан үрж эмчилэн анагаадаг. Улаан өвсний ханд цутгаж өгнө, мөн хэлний доодох хоёр хар судсыг хатгадаг байна.

Үхэр дэлүүтэх. Энэ нь дэлүүний өвчин биш, харин тэжээл боловсруулах эрхтнүүдэд хатгалга үүсгэдэг олон янзын өвчний нэг болно. Дэлүүтсэн үхэр тогтвор алдаж байн байн хэвтэж босох, бөөрөн биеэ үнэртэх, гэдсээ хайрах, газар дэвслэх хөрвөөхөөс гадна зарим үед чацга алдана. Дэлүүтсэн үхрийн дэлэнгээс урагшаа явсан судасны дагуу тэмтрэхэд хуруу ором хонхор байх бөгөөд тэр хонхор уруу нь шөвгөөр хатгаж шөвгөө тэр дор нь авалгүй хэсэг зуур орхидог байна.

Адуу, тэмээ, үхрийн гурван өвчнөөр төлөөлүүлэн ардын эмнэлгийн анагаан засах арга барилаас өгүүлэхэд энд эмчилгээний гол аргын нэг нь судас ханах засал болох нь тодорхой байна.

М.Төморжав

С.Уранбилэг





МАЛЫН УНАЛГА ЭДЭЛГЭЭНИЙ ТОНОГ, ХЭРЭГСЭЛ

Төв Азийн нүүдэлчин монголчуудын өвөг дээдэс өлгий нутагтаа ан амьтан гаршуулж малжих суурийг тавьж эхэлсэн цагаас эхлэн малыг арчлах, ашиг шим, зүтгэх хүчийг ашиглахад зориулсан олон төрлийн тоног хэрэгслийг сэдэн бүтээж боловсронгуй болгож иржээ. Малын тоног хэрэгслийг хэрэглээнийхээ чиглэлээр урлан бүтээж малыг арчлан, зүтгэх хүчийг ашиглах нөхцөл бололцоог бүрдүүлсэн нь нийгмийн ахуй амьдралд чухал нөлөө үзүүлжээ.

Өвгөд дээдсийн бүтээн боловсронгуй болгож ирсэн их өв сан бэлчээрийн мал аж ахуй эрхэлсэн монголчуудын мал маллагааны явцад олсон том амжилтын нэг байжээ.

Төрөл бүрийн малын тоног хэрэгслийг хэрэглэгдэх байдлаар нь:

Мал барих, бэхлэх, залж жолоодох, уналгын малын тоног хэрэгсэл, нуруу ачааны хэрэгсэл, хөллөгөөний хэрэгсэл, арчилгааны хэрэгсэл гэх зэргээр ангилж болно.

Адууг барих хэрэгсэл

Хүн төрөлхтөн амьтны үр зулзага, өндөг ангаахай, загас жараахай идэж амьдрахын зэрэгцээ шархтсан ан, амьтныг хоргодох агуй, нүх, эрэг хадны ангалд хашиж хоргодоох, том амьтныг газар ухаж модны мөчир, өвс, зэгсээр өнгөлж гэнэдүүлж нүхэн бүдрэгт унагаж зүг бүрээс нь довтлож агнадаг байсан аргаас тоног хэрэгслэлийн тусламжтай барих аргыг сэдэн түүнд хэрэглэгдэх хэрэгслийг хийх болжээ. Тэр цагаас өнөө хүртэл малыг барихдаа бугуйл, уургыг сэдэн бүтээжээ. Монголчууд бүх төрлийн бод малыг бугуйлаар барихын зэрэгцээ адуунд бас уургыг хэрэглэж иржээ.

Бугуйл. Энэ хэрэгсэл аль ч оронд их бага хэмжээгээр хэрэглэгдэх бөгөөд дэлхийд алдартай бугуйл хийдэг улс орон цөөнгүй байгаагийн нэг нь монголын нүүдэлчдийн сэдэн бүтээсэн бугуйл юм. Монголын олон үндэстэн ястнууд бугуйлыг харилцан адилгүй хэрэглэдэг. Бугуйл хийж хэрэглэх талаар гарамгай нутаг нь баруун монголчууд, Хөвсгөлийн баруун хойд хэсгийнхэн юм. Төв халхын хэсгээр бугуйл уургыг хослуулан хэрэглэдэг. Дорнод монголчууд уургыг голлон хэрэглэнэ. Тэд уурга хийх талаар гайхамшигт туршлагатай хүмүүс бөгөөд харин бугуйл хийх арга ажиллагааны хувьд баруун монголчууд давуу юм. Монголын олон ястнуудын хэрэглэдэг чөдөр нь алган гогцоотой, зангидмал гогцоотой, битүү төмөр цагариг гогцоотой, бод малын нүд, чих, хүйсний ширийг дугуйлж засаж хийсэн зэрэг дөрвөн төрлийн гогцоотой байдаг бол бугуйл нь дан суран сүлжмэл цээжтэй, их бие цээж нь бүхэлдээ сүлжмэл, журамласан зэрэг гурван янз байна. Манай орны адуучид бугуйлын уртыг ойролцоогоор 9-12 алдаар хийх боловч судалгааны явцад ажиглалт хийж 100 гаруй хүний ойролцооны алдыг хэмжиж дунджийг гаргасны үндсэн дээр бугуйлын уртыг 9 алдаар хэмжүүр болгон авлаа. Бугуйл заавал бат бөх байх шаардлагатайг үндэслэн манай адуучид үхрийн ширийг бугуйл хийх

Бугуйл

зориулалтаар зүсэхдээ үхрийн дагзны сэртэнгээс сүүлний уг хүртэл түүш урт, нимгэн цавь, сугны хэсгээс дээгүүр ээлж дараалан зүснэ. Бугуйлыг 3 см өргөн сураар хийх тул зүсэхдээ 3.5-4 см өргөн зүсэж татаж элдэхэд 3 см өргөн болно. Чөдрийн алган гогцоотой бугуйл бат бөхөөс гадна морь боохоод чагт мултлан сулладаг онцлогтой. Мал бугуйлдахад түүний зүтгэх хүч гогцоонд төвлөрөх тул гогцоог буюу их биеийг сүлжиж хийх нь шилдэг арга юм.

Уурга, хуйв. Монголын нүүдэлчид адууг гаршуулсан цагаас бугуйл уургыг хэрэглэж иржээ. Уургыг монголын нутаг бүр хэрэглэх боловч Дорнод монголынхон бусад нутгаас харьцангүй их хэрэглэж байна.

Монголчуудын уургын бүтэц адилхан боловч Дорнод монголынхон уурга хийх талаар асар их туршлага хуримтлуулжээ. Уурга нь цээж, бөгс, булцуу, чөмөг зэргээс бүрддэг. Уургын бөгсийг хус модоор, цээжийг хөнгөн зулзаган бургасаар хийнэ. Уурга хийх модыг сонгохдоо аль болох тахир муруй багатай, яр, овон товонгүй, мод сонгож бэлтгэн муруй тахирыг эгцэлхийн тулд чийгтэй шороонд булж тахир муруй дээр нь чулуу тавьж 3-6 сар хүртэл засаж тэгшилдэг. Гэтэл сүүлийн үед манай адуучид уурганы мод эгцлэх залуур гэдэг их, бага, дунд гурван ташуу нүхтэй мод сэдэн бүтээжээ.

Тэр нүхний хамгийн жижигт цээжийг, чөмөг хэсгийг дунд нүхэнд, хамгийн том нүхэнд бөгсний тахирыг тус тус хийж зална. Залахын өмнө гадаа гал түлж дөлийг унтраан цог дээр нь уурганы модны тахир муруй хэсгийг алсаас шарж уян хатан болгоод нүхэнд хөшиж эгцэлнэ.



Уурга, хуйвны бүтэц

Уурганы эд ангийн бүтэц, хэмжээ

1. Цээжний урт -1.5 м
2. Бөгсний урт -5.5 м
3. Цээж, бөгсний залгаа, тагнайн зөрлөг тус бүр -20 см
4. Уургын чөмөгний бөгс хэсгийн (бүдүүн) диаметр -6 см
5. Чөмөгний дунд хэсгийн диаметр -4 см
6. Толгойд залгагдах хэсгийн диаметр -3.5 см
7. Бөгсний булцууны урт -5 см
8. Булцууны бүдүүн (диаметр) -7 см орчим байна.

Морь уургалан барихын тулд сүргийн дотроос уургач морь сонгож бэлтгэхдээ шүдлэн наснаас нь эхлэн уургалах морийг алдалгүй дагаж хөөж уургалсны дараа хойд хоёр хөл дээр нь хүчийг төвлөрүүлж сууж чаддаг болгож сургана. Хэнтий мэт уурга голлон хэрэглэдэг нутгийнхан сайн уургач бэлтгэхийн тулд жил бүр "шургуулга хийх" гэдэг нэртэй хавь ойрын хүмүүс цугларч морь уургалах тэмцээн явуулдаг уламжлалтай. Энэ уламжлалаар залуучуудад морь уургалж сургах арга туршлага эзэмшүүлдэг.

Хуйв. Хуйв нь уурганы чухал хэсгийн нэг бөгөөд хийхдээ ооны хүзүү юм уу, бог малын арьс, бодын хээлийн арьсыг бяслагийн шар усанд хийж идээ авахуулаад 0.8-1 см өргөн зүсэж хоймсон, гурамсан эрчтэй томж уургын толгойн бэхлэх хэсэгт нь угтвар сэжим нэртэй гогцоо гаргаж түүний зангилаанаас гогцоолдон томж хийдэг.

Хуйвны бүтэц нь: 1. их бие, 2. угтвар сэжим, 3. бөгсний уяа буюу савхаг зэргээс бүрдэнэ.

Морь уургалж буй байдал

Адууны хөл бэхэлгээний хэрэгсэл

Монгол овогтон адууны ашиг шим, зүтгэх хүчийг ашиглахын тулд дээс, олс, ургамлын зүйл, сур зэргээр хийсэн нарийн оосроор урд хоёр хөлийг холбон туших аргаас алга, хаатай дан, давхар сур, үдмэл тушаа хийх аргад сурчээ. Энэ арга нь тушааг боловсронгуй болгосон төдийгүй чөдөр буй болоход чухлаар нөлөөлжээ. Хожим нь морио хулгай дээрэмд алдахгүйн тул суран тушааг төмөр гав тушаа болгон шинэчилжээ. Монголчуудын эрт үед урлан бүтээсэн төмөр гав тушааны хэд хэдэн хэлбэр байгаа бөгөөд эдгээр тушааны төрлүүдийг орчин үед баруун монголчууд хадгалан үлджээ.

Чөдөр. Энэ хэрэгсэл адууны хөл бэхэлгээний хэрэгслийн хамгийн боловсронгуй болсон нь бөгөөд тушаанаас гаралтай болох нь судалгааны явцад ажиглагдаж байна. Адууны урд хоёр хөлийг холбон бэхлэх бэхэлгээ амьдралд төдийлэн тохиромжтой биш байснаас гурван хөлийг холбож бэхлэх аргыг сэдэн тушаанд сум, хаа нэмж чөдөр үүсчээ. Тэр цагаас өнөө хүртэл монголын нүүдэлчид дан, давхар суран чөдөр, үдмэл, дан буюу гурамсан томмол, гөрмөл, сүлжмэл олон төрлийн хийцтэй, алх, цахилдган зангилаат чөдрүүдийг хийж хэрэглэж иржээ. Монголчууд чөдөр хийхдээ өсвөр насны адуу, нас гүйцсэн адууны гэсэн хоёр янзын хэмжээтэй хийж байна.



Чөдөр

Морины төмөр тушаа
XX зуун
(УТМ)

Аргамжаа. Монголын нүүдэлчид морийг хараат байдалдаа байлгаж хэрэгцээт үедээ унаж, эдэлж байхын тулд аргамжаа хэрэглэж иржээ. Аргамжааны гол зорилго нь морийг чөлөөт хөдөлгөөнд байлгаж өвс идүүлэх зорилготой бэхэлгээ юм.

Аргамжаа дулаан, хүйтэн улирлын зориулалттай байдаг: Дулаан улиралд аргамжихдаа модон гадастай байдаг нь мод газрын чийг татах тул газарт ороод хөөж бүдүүрэн газраас сугарах нь бага байдгийг малчид эрт үеэс мэджээ. Өвлийн аргамжааны үзүүрт чөдрийн алга, хаа хийж түүнийхээ дотор талыг эсгий, үстэй арьсаар бүрж морины хөл хайрахаас хамгаалсан дулаалга хийдэг.

Морь, өвс идэхийн тулд аргамжаанд эргэж тойрох тул аргамжаа ороолдох, эрч нь харихаас хамгаалж аргамжих олс, дээсний дунд эргэдэг эргүүлэг хийдэг. Аргамжааны үзүүрт алга хийдэг нь хөлд уясан уяа морины хөдөлгөөнд татагдан чавцарч тайлахад бэрхшээлтэй болдгоос чөдрийн алган гогцоо зөвхөн чагт мултарснаар морь аргамжаанаас суллагдана. Өвс идүүлэхдээ ургацын байдлыг харгалзан морь аргамжих газраа сонгон ургамал тачир хүрэлцээгүй бол аргамжаа шөнө 1-2 удаа сэлгэх шаардлагатай. Аргамжааны уртыг аргамжих орчны ургацтай уялдуулах боловч монголчууд дунджаар 10-15 м урт дээс, олсоор аргамжиж заншжээ.

Уналгын адууны тоног хэрэгсэл

Залж жолоодох хэрэгсэл. Адууны залж жолоодох хэрэгсэл нь толгойгоор бэхлэх бэхэлгээний үүргийг гүйцэтгэнэ. Энэ хэрэгслийн бүрэлдэхүүнд хазаар, ногт хамрагдана. Хазаар, ногт хийх ширийг үхрийн зоо нурууны ширээр хийх ба сурыг зүсэхдээ дагзны сэртэнгээс сүүлний уг хүртэл тууш уртын дагуу нимгэн цавь, суганаас дээгүүр зүсэж цагаан идээний шар усанд юм уу цагаанд хийж идээлэн 3.5-4 см өргөн жигд тэгш зүсэж татаж элдэхэд 3 см болно. Монголчууд адууг гаршуулсан эхний үед морийг хүзүүгээр оосорлон унаж байжээ. Хүзүүгээр уналга, эдэлгээний малыг залж жолоодоход тохиромжгүй байснаас биеийн хөдөлгөөний чухал эрхтэн болох толгойн хэсгийг ногтлон жолоодох болж ногт эхлээд үүсчээ. Ногтоор адууг залах бас л тохиромжгүй байснаас уналгын адууны аманд ганц хөндлөн яс, чулуун амгай хийж хазаарын анхны хэлбэр бий болжээ. Ганц амгай залж

Аргамж, богоч

Мөнгөн хазаар
(УТМ)

жолоодоход тохиромжгүй байснаас гурвалжин хэлбэртэй болжээ. Амгай хэдүйгээр боловсронгуй болсон ч малын аманд зуулгахад тохиромжгүй байсан учир хоёр ширхэг хөдөлгөөнтэй амгай хийж улмаар чагт хэлбэрийн зуузай бий болж уналгын адуут залж жолоодох чухал эд анги нэмэгджээ. Тэр цагаас дэгрээ, чагтан ба дугуй зуузайг өнөө хүртэл хэрэглэж иржээ. Сүүлийн үед хазаарыг гоёмсог үзэмжтэй болгохын тулд зуузайд гурван загас, очир, тоонолж, хас хээтэй хийж улмаар дугуй цагирагийн төвд нь шигтгээ хийх болжээ. Хазаарын төмөр хэрэгсэлд хүрлийн үеэс эхлэн гоёл чимэглэл хийсэн байдаг.

Булшнаас олдсон янз бүрийн металл хэрэгсэлд хээ чимэг тавьсан, товруу бэлчрийг янз бүрийн дүрстэй хийсэн үзмэрүүд багагүй олджээ. Монголын олон үндэстэн, ястны хазаарын ерөнхий хэлбэр бүтэц ойролцоо ч бас өөр өөр өвөрмөц хэлбэрүүд олон байдаг. Баруун монголын зарим ястнууд хазаарт хонхон ба гархин шигшрэг хийдэг. Шигшрэгтэй хазаарын хэлбэр нэлээд өөр бүтэцтэй байдаг. Эрт үед зуузайд 3-аас доошгүй гархин шигшрэг хийдэг байсан бол сүүлдээ сагалдрагыг мөнгөөр тоноглон түүнд зориуд төмөр сэнж хийж тэр сэнжнээс 3-10 ширхэг мушигмал буюу шулуун ган төмрөөр хийсэн гархи хийдэг болжээ. Хазаарыг хоёр жолоотой хийж нэг жолоог морины хүзүүн дээр тохируулан богино хийж түүнийг мөнгөөр тоноглон олон ган шигшрэг хийж, нөгөө жолоог урт хийж морийг залж жолоодоход ашиглаж байжээ. Дорнод монголынхон буюу төв халхынхан гоёлын хазаарыг 5-7 ширхэг хээтэй мөнгөн товруутай, сурыг хүрэвдэн бөөрөнхийлж толгой хэсэгт битүү мөнгөн бөгж хийх буюу эсвэл сийрэг зайтай бөгжөөр чимж хийнэ. Баруун монголчууд хазаарт нам товруунаас гадна хавтгай мөнгөн чимэг хадаж чимдэг бол төв халхын хэсгээр голдуу шовгор товруутай хийдэг. Зарим нутагт долоон цэнгийн цагаан мөнгөөр товруу хийнэ. Хурдан морины хазаарт янз бүрийн товруу чимэг хийдэггүй. Монгол хазаар бусад орныхоос ялгаатай нь тус тусдаа үүрэгтэй жолоо, цулбуур байдаг бол бусад орны хазаар ганц жолоотой байдаг. Хазаарт байдаг нэг онцлог зүйл нь духны даруулга юм. Энэ даруулга монголд эрт үеэс хэрэглэгдэж иржээ. Хазаар нь дан суран, давхар суран, тоног чимэгтэй зэрэг олон янз байна.

Монгол эмээл

Төв азийн монголчууд морь унахдаа морины нуруун дээр мал, амьтны арьс тохож зайдлан унаж бөгс холгохоос хамгаалж байжээ. Ингэж морь унахад хүний биед ядаргаатай, хөл унжиж чилэх зэрэг тохирмжгүй байснаас эмээлийн эд ангийн бүтцийг алгуур сайжруулжээ. Эмээлийн анхны хэлбэр нь тохом байгаад түүнд өнөөгийн уралдааны болон сойж хонох моринд хэрэглэдэг агтавч нэмээд хожим нь өнөөгийн тэмээний тохошны маюуз шиг хоёр тал руу нь амьтны үс чихэж зузаалсан маюуз нэмжээ. Эдгээр нь хүний суудлын тохиромжтой нөхцөлийг бүрдүүлж чадаагүй тул эмээлийн анхны хэлбэрийн нэг болох эрвээлжин эмээл бий болжээ.

Агтавч бий болсон нь эрвээлжин эмээлийн болон өнөөгийн эмээлийн хавтас бий болох эх суурийг тавьжээ. Агтавчийг томсгон өргөсгөж эмээлийн хавтас бий болж түүн дээр эрвээлжин эмээл болон өөр хэлбэрийн бүүрэг нэмж өнөөгийн эмээл үүсчээ. Хойд, урд бүүргийг хавтсанд суулгаж голд нь суудлын загасыг хүний бөгс, морины нурууны онцлогт тохируулан хийж эмээлийн модны анхны хэлбэр бий болжээ. Эрт үеэс эдүүгээ хүртэл монголын нүүдэлчид одоо мэдэгдэж байгаагаар 350 гаруй нэр төрлийн эмээлийн хэлбэр сэдэн бүтээж иржээ. Монгол эмээлийн хэлбэрт олон янзын өөрчлөлт орж байсны нэг нь XII зууны үеийн том, намхан, дугуй бүүрэгтэй эмээл юм. Энэ эмээл Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас олджээ. Монгол эмээлийн нэг өвөрмөц онцлог хийц бүхий эмээл нь Өвөр монголын Ордос, Говь-Алтай аймгийн Хөхморьт сумаас олдсон. Тэр нь XYI зууны үед мөнгөөр угалз, болон бусад хээ цутгаж түүнийгээ хооронд нь нийлүүлэн маш бат бөх гагнаж дээрээс нь алт шарж хийсэн эмээл юм. Түүнчлэн Өвөр монголоос олдсон цул алтыг хээтэй хэвд цутгаж хийсэн алтан эмээл, алтан дөрөө гэх мэт манай төрийн түшээ цэргийн жанжны эмээлүүд, Баян-Өлгий аймгийн музейд байгаа мөнгөн тоногтой урд, хойт бүүргийн толинд мөнгөн нууханд шүр, оюу мэт эрдэнийн үнэт чулуу шигтгэж хийсэн эмээл, Богд хааны музейд байгаа VIII Богд Живзундамба

Мөнгөн тоногтой эмээл, хазаар, суман ташуур (М УТМ)

Агваанлувсангийн эмээл зэрэг хүний гайхамшигт ухаанаар бүтсэн олон төрлийн эмээл бий.

Эмээл хүний суудлын тохиромжтой нөхцлийг бүрдүүлдэг Монголын байгаль цаг уурын эрс тэс ширүүн нөхцөлд том үстэй дээл, үстэй өмд өмсөн суух, хүүхэд дүүрч явахад зориулагдсан том суудалтайгаас гадна алс хол ан, гөрөө хийх, аян дайнд явахад суудлын тохируулга болоод зогсохгүй хээр хоноход 1-2 хүний дэр, дэвсгэр болдгоороо онцлогтой юм. Тийм ч учраас хаан төрийн есөн билэг эрдэнийн нэг нь эмээл ажээ. Эмээлд илүү зүйл гэж байхгүй. Бүүрэг нь хүний гэдэс давсаг хамгаалахаас гадна сэрүүн улиралд дээлийн хормой хумин багтааж бөгс, ууц нуруу хамгаалахад шахаж хашиж өгнө. Хавтас нь морины нуруун дээрээс дарах даралтын хүндийг хавирганы толгой нуруунд жигд хуваарилж өгнө. Дэвс нь суудлын загас мод болон хавтас хүний бөгс нухаж холгохоос хамгаалсан зөөлөвч болно. Найман ганзага нь моринд тохсон даалин богц, бусад зүйл савлах, унжих зэргээс хамгаалсан даруулга болдог. Олонцог нь дөрөөний сур хүний хөл нухахаас хамгаална. Дөрөө нь

морины нуруунд авиран гарах, морь унагч хүний хөл унжиж чилэхээс хамгаалсан хагас сойлт юм.

Олом, жирэм эмээлийг морины нуруунд дарж тогтооход зориулагдана. Хөлсөвч, тохом нь эмээл, морины бие хоёрын хооронд зөөлөвч болно. Орчин үед хэрэглэж байгаа эмээлийн хамгийн шилдэг нь 1930-аад оны үед Сайн ноён хан аймгийн Далайчойнхор вангийн хошууны Самбуу дарханы урлан бүтээсэн өвгөн самбуу хийцийн эмээл юм. Энэ эмээлийг нутаг бүр авч хэрэглэхдээ бага зэрэг өөрчлөлт оруулж хийснээс хадаасан самбуу, бүлтгэр самбуу, боржигон самбуу гэх мэт олон хэлбэр бий болжээ. Эдгээрээс гадна суудал сайтай барга, тонжил, чойр, үзэмчин, казах, буриад, тува, дөрвөд гэх мэт өвөрмөц хийцийн эмээлүүд хэрэглэж байна.

Дорнод монгол эмээл

Адууны хөллөгөөний хэрэгсэл

Монголчууд малаас үхрийн дараа адууг гаршуулж, уналга, хөллөгөөнд хэрэглэхдээ түүнд тохирсон тоног хэрэгсэл сэдэн бүтээж боловсронгуй болгожээ. Адууны хөллөгөөний хэрэгслийн бүрэлдэхүүнд жааванз түүний зөөлөвч, тууянз, шоохой, дааюу хэрэглэнэ. Эдгээрийн эд ангийн бүтцийн нэгжүүд цөм тодорхой хэмжээ харьцаатай, тус бүрдээ тодорхой зориулалттай байдаг.

Жааванз. Анх арьс шир элдэж дугуй хэлбэртэй болгож голд нь малын толгой багтах нүх гаргаж, хоёр оосор хийж тэрэг, чаргатай холбожээ. Энэ нь газрын уруу явахад сугардаг байснаас тууянз гэдэг зузаалга нэмжээ.

Халх маягийн жааванз, тууянз

Жааванз зузаалга тууянзтай болсон ч малын биеийн аль нэг цэгт дарж холгодог болохоор жааванзыг хийжээ. Энэ хэрэгсэл хүний хэрэглээний шаардлагыг хангасан тул орчин үед хүртэл хэрэглэгдэж байна.

Жааванзын гол үүрэг нь ачааг биеийн хүчээр чирэхэд гол төв болж өгөхөөс гадна мөрөнд очих даралтын хүчийг хүзүүнд жигд хуваарилж өгөх үүрэгтэй. Жааванз дээд үзүүртээ холбож уях шилэвч гэдэг сур бэхлэх хэрчлээстэй, дунджаар 60 см орчим урт мод бөгөөд гол хэсгээрээ 10 см бүдүүн, хоёр үзүүр тал руугаа алсаасаа нарийсгаж зассан 4 см диаметртэй хоёр гуя мод юм. Шил хэсгийг холбож уясан шилэвч сур, эрүүн доогуур холбосон боодой суруудаас бүрдэнэ. Үүний шилэвч нь байнгын холбоо бөгөөд эрүүн дор холбодог боодой гэгдэх холбоо жааванзыг хавчиж чангалах, сулруулахад зориулагдсан хөдөлгөөнтэй байна. Жааванзын гуя модны тууянз зөөлөвчинд холбох тал хавтгайдуу байна. Жааванзыг тэрэгний гартай холбох 3 см өргөнтэй, 3 метр урт гогцоо чих сур байна. Чих сурыг хийхдээ тэрэгний өндөр намд тохируулан хоёр гуяыг тус бүр 2 цоолж сураа сүвлэн гогцоолдож сүлжээ зангилаагаар зангидаж уяна. Жааванзны зөөлөвч болох тууянзыг бог малын элдэж зөөлрүүлсэн арьс, савхиар хийж дотор нь өвс багцлан чихэж жааванзны модны хэлбэрт тохируулан гол хэсгийг бүдүүн, хоёр захыг нарийн 1.7 м урт, гол хэсгээрээ 30 см, үзүүр хэсгээрээ 20 см диамертэй хийнэ.

Шоохой. Малын хүзүүгээр ачаа чирүүлэхэд хүнд учир ачааны хүндийн хагасыг нуруунд үүрүүлэх зорилгоор шоохойг зохион бүтээжээ. Шоохой босоо, хэвтээ хоёр янз байдаг. Үүний босоо хэлбэрийг голлон хэрэглэж байна. Шоохойн бүтэц нь хавтас, хойд урд бүүрэг, зөөлөвчөөс бүрдэнэ. Хойд, урд бүүргийн өндөр нь 30 см, өргөн нь 40 см, хавтасны урт 35 см, өргөн нь 15 см, хавтас хоорондох зай 10 см байна. Шоохойн хавтасны зөөлөвчийг зөөлөн эсгий, зузаалагатай хилэн, цэмбээр хийнэ. Шоохойн олом, жирэм эмээлийнхтэй адил, шоохойг малын нуруунд тогтоож өгнө. Шоохойг тэрэгтэй холбох, дарж өгөх үүрэгтэй 4-5 см өргөн сурыг дааюу гэдэг. Дааюу чирэх ачааны хүндийг нуруунд шилжүүлэхээс гадна донсолгоог зохицуулж өгнө. Тус улсад жааванз, тууянзаас гадна буриад хомут өргөн хэрэглэдэг.

Шоохой (МҮТМ)



Хомут
1.Чих сур 2.Дуга ба нум 3.Нуруу, сур
4.Нуруувч 5.Ташаавч 6.Хондлойвч
7.Чих, сурны бурхэвч

Буйл, бурантаг. Төв азийн нүүдэлчид тэмээг уналга, эдэлгээнд ашиглахдаа юуны өмнө анх толгойг ногтолж унажээ. Ногт тэмээг дуртай зүгтээ залахад тохиромжгүй байснаас хамрыг цоолж буйлалжээ. Дөр, бурантаг тэмээний хамар сэтлэх зэргээр тохиромжгүй байснаас буйл гэж нэрлэгдэх мод бий болжээ. Тэмээний буйл зөвхөн эдэлгээний зориулалттай байсан бол хожим нь хүндэтгэлийн буйл бий болжээ.

Тэмээн сүрэг түм хүрэхэд буурандаа мөнгөн буйл зүүдэг байсны гадна хүндэт зочинд мөнгөн буйлтай цагаан тэмээгээр бэлэг барьдаг байжээ.

Мөнгөн буйл

Энэ ёслол өнөө хүртэл уламжлагдан ирж тэмээн сүргээ өсгөсөн малчид аж ахуйн нэгжүүдийг шагнадаг хэвээр байна. Ажил эдэлгээний тэмээнд хэрэглэдэг буйлыг манай малчид олон янзаар хийж байгаа нь цөм тодорхой зориулалттай билээ. Орчин үед тэмээнд ац, мөөг, саран буйл, тагил, чагт, өнчин ацтай буйл гэх зэрэг олон хэлбэрийн буйл байгаагийн дээр бурантаг иддэг, хаздаг тэмээнд гууж гэж нэрлэгдэх 40-45 см урт модыг буйл, бурантагийн дунд хийж өгдөг. Үүнийгээ гуужтай бурантаг гэнэ. Зэлэнд эргэдэг тэмээнд залгаагаараа эргэдэг эргүүлэгтэй бурантаг хийх зэргээр тэмээний залж жолоодох хэрэгсэл дэвшин хөгжиж иржээ. Манай оронд ацан буйлыг түгээмэл хэрэглэж байна.

Модон буйл, бурантаг
(МҮТМ)

Тэмээг бурантаглахдаа хамрыг заасан цэгт цоолно. Үүний тулд хамрын нүхэнд хуруу шургуулж үзэхэд үсэрхэг хонхор байдаг. Цоолохдоо яг энэ хонхорыг нэвт хатган цоолж буйллаад, 7-14 хонуулаад хамрыг эдгэмэгц сургана. Манай тэмээчид буйлны уртыг эрхий хурууг оруулж хэмжсэн үзүүр баримаар хэмждэг. Энэ нь 12 см юм.

Уналгын тэмээний тохош. Тэмээний зүтгэх хүчийг ашиглах явцад эдэлгээнийхээ чиглэлээр ашиглах онцлогтоо тохируулан, олон янзын тоног хэрэгсэл хийсний нэг нь уналгын тохош юм. Монголын тэмээчид уналгын тэмээний тохошийг эсгий ширмэл, хивсэн нэхмэл, эсгийг бөсөөр өнгөлж ширэх зэргээр хийхээс гадна Говь-Алтайн Цээл, Алтай сумууд зулзаган дэрс халаж, багцлан утсаар хэрж холбон, гадуур нь бөсөөр бүрж тохош хийдэг. Тохош нь гөлөм, мааюуз, бөхөвч олом, дөрөө зэргээс бүрдэнэ. Тохошны эд ангийн бүтэц, түүний нэр томъёо 15 нэгж хэсгээс бүрдэнэ.

Тэмээний нуруу ачааны хэрэгсэл. Тэмээг аль ч улс оронд уналгын чиглэлээр ашиглахаас гадна нуруу ачих, тэргэнд хөллөх зэргээр ашиглаж иржээ. Манай оронд тэмээг ачих нь эрт үеэс уламжилж юм.

Тэмээний хивсэн тохош
XX зуун
(МҮТМ)

Монголчуудын зарим нутагт тэрэг хэрэглэх боломжгүй уулын бүс болон бартаат газар тэмээний нуруу ачих аргыг өргөн хэрэглэж иржээ. Тэмээний нуруу ачааны хэрэгсэл шат, бамбай, бөхний ороолт, ширдэг, хэрсэн зэргээс бүрдэнэ.

1. Шат гэдэг нь тэмээний хомыг хавчин тогтоох мод юм. Шат их бие, сээр, нуруунаас бүрдэнэ. Шатыг ямар ч модоор хийж болох боловч бат бөхийн хувьд сонгомол мод нь хус юм.

2. Бөхний ороолт ширдэг нь тэмээний хомонд хоёр ширхэг байдаг. Үүний нэгийг хойд бөхний ард хайчилж нугалан бөхний хоёр талаар явуулж, нөгөө ширдгийг урд бөхний голд хайчлан нугалж хойш нь чиглүүлж хоёр ширдгийн уулзварын зөрлөгийг зүүн талын ташаа, баруун талын далан дээр зөрж уулзахаар тохируулна.

3. Бамбай. Нэг тэмээнд хоёр байдаг. Бамбай хом шат бүхэлдээ ачааны хүндийг нуруунд жигд хуваарилан өгөх үүрэгтэй бамбай зузаан байх шаардлагатай учраас түүнийг 2-3 давхар зузаан эсгийгээр хийнэ.

4. Хэрсэн гэдэг нь хоёр шатыг бөхнөөс дээш сугарахаас хамгаалсан холбоо юм. Хэрсэн нь хоёр шатыг холбон байрлуулах тул түүнийг бат бөх, тэмээний бие урж нухахгүй байлгах зорилгоор бага зэрэг хялгас хольсон зөөлөн ноос

томж хошлончилж хийнэ. Тэмээний нуруу ачааны хэрэгсэлд чухал ач холбогдолтой нэг хэрэгсэл нь хүн мод юм. Хүн модыг хэвтэж байгаа тэмээний нурууны өндөрт тохируулан хийж газар тулах хэсэгт ацтай буюу эсвэл хавтгай богино банз хадаж хийнэ. Энэ нь ганц хүн тэмээний нуруу ачихад зориулагдсан чухал хэрэгсэл юм.

Тэмээний хөллөгөөний хэрэгсэл. Тэмээг хөллөхөд монголчууд энгийн ба олмон хөллөвөр хэрэглэж байна. Энгийн хөллөврийн нийт урт нь 180 см, дөрөөлөх орчмын өргөн 40 см, нумын өргөн 25 см, бөхөвчний хушуувчны өргөн 40 см, хошуувчны урт нь 1 м байна. Тэмээний хөллөвөр адууныхаас ялгагдах онцлог нь ачааг ууц, цээжээр чирэхэд зориулагджээ. Хөллөврийн урд нум нь урт, хойд нум арай богино эсгий хэрэгсэлтэй бөгөөд тэмээний бие бүтцийн онцлогт тохируулан сэдэн бүтээжээ. Хөллөврийг тэмээний урд бөхөнд углаад их бага насны тэмээнд тохируулахын тулд найман түдүүл хадаж түүнд хавтгай сур шургуулан ихэсгэж, багасгах саалтуур хийжээ. Хөллөврийн дөрөөлөх хэсэгт амгүй бат бөх том төмөр цагариг хийдэг. Энэ цагариг хөллөвөр нь дарж бэхлэх, олом, тэрэгний аралд холбох, чих, сур бэхлэх зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

Чих сурны өргөн 3.5-4 см байна. Хөллөврийг тэрэгтэй холбох гол төв нь дөрөөлөхийн хэсэг учраас түүнд савхи, арьс, берзент зэргийг тавьж ширж бэхэлдэг. Олмон хөллөвөр тэмээнд хөнгөн, ачааны даралтыг зохистой хуваарилахаас гадна аль ч насны тэмээнд тохирно.



Ц.Даваахүү "Сургийн мэнд" (1988 он)
(МУЗГ)

Үхрийг залж жолоодох хэрэгсэл. Үхэр залж жолоодох хэрэглэлийн анхдагч нь эрүүвч байсан бололтой. Эрүүвч гэдэг нь үхрийн дагз, эрүүг бүхэлд нь ороосон цулбууртай битүү гогцоо юм. Эрүүвчийг эрт үеэс өнөөг хүртэл үхэрт анжис хөллөдөг тариачид хэрэглэсээр байна. Үхрийг залж жолоодох хэрэгсэл бусад ажлын малынхаас олон төрөл байна. Эдгээрийн хэлбэр, эд ангийн бүтцийн хэмжээ харилцан адилгүй байдаг.

1. Үхрийн залж жолоодох хэрэгслийг хэрэглэхийн өмнө хавар ялааны нислэг эхэлж шарханд өт цацахаас өмнө хамрыг шор буюу сүвэгч гэгдэх мод, шөвгөн төмрөөр цоолж сүйх буюу гархи гэж нэрлэгддэг 35 см урт ноос юм уу нохойн ноосоор томсон дээсэн гархи хийж 7-14 хонуулаад дөрлөж сурган унах, ачих, хөллөх зэргээр эдэлгээнд оруулна. Нохойн ноосоор сүйх хийхэд үхрийн хамар баалж идээлдэггүй сайн талтай.

2. Дөр гэдэг нь хамрын цоолсон нүхээр оосорлон залж жолоодох хэрэгсэл юм. Дөрний урт нь 2-2.5 м хоймсон, гурамсан эрчилсэн дээс юм.

3. Чөрх нь үхрийг хөллөгөөнд холбоход хэрэглэдэг хэрэгсэл. Чөрхний хэлбэр нь дух, дагзанд угласан битүү гогцоо бөгөөд тархинд углагдах гогцоог "тархи", дух руу унжих цулбуурыг сум гэдэг. Дух, дагзанд углагдах гогцооны баруун талын шанаанд сагалдаргатай бөгөөд сагалдрагыг эрүүн доогуур татаж зүүн талын шанаанд уяж бэхэлнэ. Чөрхний тархины урт дундажаар 40-50 см, сум нь 2.5 м урт байна. Чөрхний онцлог нь хөллөгөөнд угсарсан үхэр хажуу тийшээ хадуурахгүй эгц явахад зориулагдана. Дан чөрхөөр үхрийг жолоодохоос гадна дөртэй хослуулан хэрэглэнэ. Сагалдарганы урт нь 70 см байдаг.

4. Эвэрдий. Энэ хэрэгсэл нь эвэртэй үхрийн хоёр эвэрний угаар оосорлож чагтлах гогцоо, цулбуураас бүрдэнэ. Эвэрдийн эвэр ороох хэсгийн дээсний өргөн 3 см-аас доошгүй байна. Эвэрдийн гогцооны нэг үзүүрт 5 см урт чагт, нөгөө үзүүрт 8 см урт хөхөн гогцоо хийж эврийг ороон чагтлана. Эвэрдийн цулбуурын урт 2-2.5 м урт байна. Гогцооны урт нь 62 см байна.

5. Үхрийн ногт дөрөөс өмнө үүссэн болох нь тодорхой. Үхрийн ногтыг Хөвсгөл аймгийнхан "Түүшин" гэж нэрлэдэг. Ногтны эд ангийн бүтцийн хэмжээ нь хамар 35 см, сагалдарганы урт 70 см, цулбуурын урт 220 см байдаг. Үхрийг унахад зориулалтын эмээл гэж байдаггүй. Морины эмээлийн урд оломыг хөмөлдөргөлж татаад тохмын оронд гудас юм уу өөр том талбайтай эсгий тохож эмээллэнэ.



Үхрийн хөллөгөөний хэрэгсэл. Монголын нүүдэлчид бод малын дотроос үхрийг анх гаршуулж ашиг шим, зүтгэх хүчийг ашиглажээ. Үхрийг унах, нуруу ачих, тэрэгт хөллөх явцдаа түүний бие бүтцийн галбирт тохируулан янз бүрийн тоног хэрэгсэл сэдэн бүтээж боловсронгуй болгожээ.

Үхрийн хөллөгөөний хэрэгслийг эрт үеэс хэрэглэж байжээ. Монголчууд үхрийг хөллөгөөнд өргөн ашиглаж байсан баримт олон байгаагийн заримыг дурдвал МЭӨ 3-р мянган жилийн тэртээ Хүннү нар үхэр хөллөдөг боловсронгуй тэрэгтэй байсан мэдээ бий. YIII-IX зууны үед Хятан нар үхэр тэрэг өргөн хэрэглэж байсан, XII-XIII зууны үед 1-300 шард хөллөдөг гэр тэрэгтэй байжээ. Энэ тэргийг харсан жуулчин Марко Поло, Рубрик, Плано Карпин нар тэмдэглэлдээ тодорхой бичсэн байдаг. Үхэр хөллөхөд буулга, шоохой, хударга, тохом хэрэглэдэг.

Ч.Сонгино
С.Уранбилэг
Э.Амарбилиг

ТАРИАЛАНГИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Түүхчилсэн тойм. Монгол орны хувьд газар тариалан маш эрт үүссэн боловч эдийн засгийн гол салбар нь бэлчээрийн мал аж ахуй байсаар иржээ.

Археологийн судалгааны малталт, түүхийн сурвалж бичиг, Монгол газар ирж байсан гадаадын жуулчдын тэмдэглэл зэргээс үзэхэд Монгол нутагт бүр шинэ чулуун зэвсгийн үеэс тариалангийн ул суурь тавигджээ.

Дорнод аймгийн Матад сум болон Туулын хөндий дагуух Гачуурт, Лүнгийн орчмоос археологийн малталтаар гарсан тариа цайруулах, хальслах зориулалттай чулуун тогоо, чулуун нүдүүрийг шинэ чулуун зэвсгийн тариаланд ашиглаж байсан хөдөлмөрийн багаж зэвсэг гэж түүхчид үзэж байна. Яг ийм багаж зэвсэг Өмнөговь аймгийн Төгрөг, Ширээт зэрэг газруудаас олдсоныг газар тариалан үүсч хүн амын хүнсний хэрэгцээн дэх ач холбогдол ихэсч байсны гэрч гэж үздэг.

Өнөөгийн Монгол орны нутаг дэвсгэр дээр тариалан эрхэлж байсныг батлах дараачийн үеийн баримт бол хадны зураг болохыг түүхчид хүлээн зөвшөөрчээ. Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Бичигт хаданд анжис хөллөсөн үхрээр газар хагалж буй зураг байдаг.

Хүннүгийн үеийн булш бунхнаас олдож байгаа арвай, бог будааны үр бол тэр үед буюу одоогоос 1000 гаруй жилийн өмнө тариаланг эрхэлсээр л байсныг гэрчлэх тодорхой баримт мөнөөр барахгүй зарим эрдэмтдийн таамаглаж байгаагаар бог будаа Монголын нутгаас гаралтай байж ч болох талтай байна.

Бичигт хадан дээрх анжис хөллөсөн үхрийн дүрс

Монголын тариалангийн тухай бичиж тэмдэглэсэн хамгийн эртний баримт нь 1212 онд Чингис хааны буулгасан зарлиг юм.

Хаан Монголын их гүрний ерөнхийлөн захирах яамны баруун гарын чансан Чангай сайдад үүрэг өгч, Алтайн нурууны ард тариа тариулж байжээ. Сайд тариа тариулж хааны зарлигийг ёсоор болгох явцад олон мянган хүн бүхий суурьшмал амьдрал буй болсон байна.

Түүхэнд Чангайн балгас гэдэг нэрээр тэмдэглэгддэг энэ газар тухайн үедээ Монголын нэгэн соёлын төв байжээ. Энд тариалах талбайн хэмжээг тогтмол нэмэгдүүлсээр 1302 онд ихээхэн ургац аваад 1314, 1321 онуудад тус бүр таван суваг нэмж байгуулсан байна. Хүмүүс амьжиргаа сайтай газар руу татагддаг болохоор богино хугацаанд олон хүнтэй болж зөвхөн 1320 онд ядуу амьдралтай 2000 хүн тэнд суурьшин тариалан эрхэлдэг болжээ.

Энэ үед Монголд нийтдээ 4648 өрх айл 6400 хувиар буюу ойролцоогоор 60000-аад га талбайд тариа тарьж ихээхэн ургац авч байсан ч тухайн үеийн хүнсний хэрэгцээний өчүүхэн хэсэг байлаа.

Чингис хааны урилгаар 1221 онд Монголд ирсэн Чан Чунь бумбын тэмдэглэлд Хэрлэн мөрний хоёр эргээр өндөр бургас, нягт ургасан шар цэцгээр дүүрэн, мөн тариалангийн талбай энд тэнд үзэгдэж, монголчууд хасарваань, чавга тэргүүтнээр будаа арилжиж байсныг бичсэн байна.

Мөн XIII зуунд монгол орноор явж өнгөрсөн хятадын жуулчин Чжан Дэ-Хэй "Замын тэмдэглэл"-дээ Хархорины орчимд ногоо тарьсан талбайг шуудуугаар усалж, Хэрлэнгийн эрэг дагуу тарианы талбай тааралдаж байсан тухай өгүүлжээ.



Чингис хаан тариа тарих зарлиг буулгасны түүхч Сайшаал бүтээлдээ бичжээ.

Түүхч-эрдэмтэд монголчуудын хоол хүнсэндээ гурил, будаа хэрэглэж заншсаныг тэдний тариалан эрхэлж ирсний баримт гэж үздэг.

Хубилай хааны дэргэд 1279-1289 онд алба хашиж түүний элч төлөөлөгчөөр олон газар явсан Ромын харъяат Марко Поло аяны тэмдэглэлдээ тариа их ургаж үнэ нь хямдарсан жилд их хаан өөрийн сан хөмрөгөөс хөрөнгө гарган худалдаж аваад ган гачиг тохиолдсон үед албат харъяатууддаа хишиг болгон хүртээдэг, хүмүүс тэр тариаг хүнсэнд хэрэглэхээс гадна тарьдаг байсан тухай дурьджээ.

1246 онд Монголд ирсэн европын жуулчин Плано Карпини … тэд бүх ургацыг хураан эзнийхээ

тарианы санд нийлүүлэх бөгөөд эзэн нь тэдэнд хөрөнгө болон хүнсэнд элбэг дэлбэг хэрэглэж хүрэхүйц амуу будаа өгдөг. Өглөө хоол иддэггүй, зөвхөн будаатай цай 1-2 аягыг уудаг гэжээ.

Францын ван IX Людовикийн явуулсан Гильом Рубрук 1254 онд Хархорин хотод ирээд монголчуудын тухай бичихдээ: Хар хорир хот эргэн тойрон шавар хэрэмтэй бөгөөд дөрвөн хаалгатай. Зүүн хаалганы дэргэд шар будаа, амуу тариа худалддаг байсан тухай тэмдэглэсэн.

Эдгээр баримтуудаас үзэхэд, монголчууд бүр XII зууны эхэн үе гэхэд л гурил, будааг хүнсэндээ өргөн хэрэглэж байсан нь батлагдана.

Чингис ба түүний дараачийн гурван хааны үед нэлээд эрчимтэй хөгжсөн тариалангийн үйлдвэрлэл XV-XVII зуунд уналтанд орж эхэлсэн байна.

Хэдийгээр ийм хүнд бэрхшээлтэй тулгарсан ч тариалан бүрмөсөн алга болчихолгүй ямар нэгэн хэмжээгээр үргэлжилсээр байлаа.

Эртний тариалангийн голомт газрууд

Монгол орны нутаг дэвсгэр нь хөрс уур амьсгалын нөхцөлөөр өөр хоорондоо эрс ялгаатай ойт хээр, хээр, говь, цөлийн бүсүүд зэрэгцэн оршдогоороо ихээхэн онцлогтой.

Ургамал ургалтын хугацаанд ихэнхдээ хурц нартай, халуун өдрүүд үргэлжилж хур тунадас бага унадаг учраас ургац бүрэлдэн тогтоход сөрөг нөлөө үзүүлэх явдал ойр ойрхон давтагддаг. Ийм нөхцөлд тогтвортой ургац авах цорын ганц арга бол усалгаа хийх явдал юм. Тариалан эрхэлдэг олон улс орон энэ зарчмаас гажиж чаддаггүй болохоор манай өвөг дээдэс ус хүрэлцээтэй газарт л тариа тарьдаг байжээ.

Оросын эрдэмтэн П.Ф.Кононков "Монголчууд эрт дээр үеэс усалгаатай тариалан эрхэлж байсан нь одоо тус улсын нутаг дэвсгэр дээр хааяагүй тохиолддог суваг шуудууны ул мөрийг харахад л тодорхой байдаг" гэж бичсэн юм.

Гол мөрний хөндийнүүдийн дагуух ус элбэгтэй нутгуудад тавааргаг чанартай тариаланг, горхи, булаг, шанд, худаг зэрэг усны нөөцөөр хомсхон газарт ихэнхдээ өрхийн хэрэгцээний зориулалтаар тариалан эрхэлдэг байжээ. Жилд унах тунадасны хэмжээтэй уялдуулан Орхон-Сэлэнгийн сав газарт ургалтын хугацаанд 1-2 удаа, Их нууруудын хотгор, Алтайн ар хоолойд 4-5 удаа, говь ба цөлийн бүсүүдэд 5-7 удаа усалгаа хийдгээс үзэхэд ардын тариалангийн туршлагад тулгуулан усалгааны тодорхой бүсчлэлийг бий болгосон байна.

Баруун монголын тариаланд баримталдаг усалгааны норм, горимыг ажиглахад таримлынхаа өсөлт хөгжилтийн эмзэг үе шатуудад ус чийгийг хүрэлцээтэй өгөх зарчим барьдаг байсан бололтой. Иймучраас хэдийд усалгаа хийхийг нэрээр нь мэдэж болдог. Үүнд:

1. Газар ус. Үүнийг тариа тарихаас өмнө өгдөг. Ийм учраас тариаг биш, газрыг нь усалж буй хэрэг.

2. Хар шороон усыг тариа нилэнхүйдээ соёолж эхэлсэн боловч газрынхаа өнгийг булааж амжаагүй байхад өгнө

3. Тэвэг усыг тарианы бутлалтаас шилбэлэлт буюу гол хатгаланд шилжих үед өгнө. Энэ үед тарианы навч олшрон тэвгэрхүү дүрстэй болсон байдаг учраас ингэж нэрлэсэн гэдэг.

4. Гэзэг усыг тарианы түрүүлэлтийн шатанд буюу нөхөрт гараагүй хүүхний гэзэгтэй төсөөтэй болсон үед өгдөг.

5. Хадуур усыг тарианы болц гүйцээд хадахад бэлэн болсон үед асгаралтаас хамгаалах зорилгоор өгнө.

XIX зууны эхээр монголд ирсэн Москвагийн худалдааны экспедицийн агрономч Ф.И. Морозов "Автономит монголын нутаг дэвсгэр дээр усалгаагүйгээр тариалан эрхлэх боломж бараг байхгүй. Иймболохоор тарианыхаа талбайд гадаргуугийн усалгаа хийдэг" гэж бичсэн байна.

Оросын эрдэмтэн В.Ф.Шубин Монгол орны нутагт эртний тариалангийн дөрвөн голомт газар байгааг тодорхойлжээ.

Эдгээр голомт газруудыг тус бүрт нь авч үзье.

Орхон-Сэлэнгийн сав газар дахь эртний тариалангийн ул мөрүүд

Хангайн нурууны араас Хэнтэйн нурууны өвөр хүртэл үргэлжилсэн энэ уудам газар нь манай орны эрт, эдүгээгийн тариалангийн гол бүс нутаг юм. Энд Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Архангай аймгуудын нутаг бүтнээрээ, Өвөрхангай, Төв аймгуудын хойд хэсэг багтана.

Орхон голд цутгадаг Хараа, Ерөө, Тамир, Сэлэнгэ мөрөнд цутгадаг Чулуут, Хануй, Идэр, Эг, Дэлгэр мөрөн гээд Монгол орны амьд байгалийн судас болсон гол мөрнүүдийн усанд түшиглэн дээр үеэс тариалан эрхэлсээр иржээ.

Монголын их гүрний нийслэл Хархорин, Халх монголын соён гэгээрүүлэгч Цогт хун тайжийн ордон, Амарбаясгалант хийд, Их хүрээ зэрэг түүх соёлын гол газрууд байгуулагдсан нь тариалан хөгжиж суурьшмал амьдрал бий болсонтой салшгүй холбоотой юм. 1586 оноос эхлэн байгуулагдсан Эрдэнэзуугийн орчимд Орхон голоос суваг татаж тариа тарьж байсан тухай түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдсэн байдаг. Хөгшин Орхоноос Баруун хүрээний хийдийн чиглэлд 25 км зайтай газарт гидротехникийн ямар ч барилга байгууламж барилгүй энгийн аргаар голын усыг гольдролоос нь гарган тариа тарьж байсны ул мөр болох балгас, суваг шуудуу, чулуун бул, чулуун тээрэм одоо хүртэл байсаар байна.

Уйгурын үед хамаарагдах Чин толгойн балгасны ба Харбухын горхины эрэг дээрх Хадаасангийн цайзны малталтаас олдсон чулуун уур, нүдүүр, моръ, шараар эргүүлдэг том тээрэм зэрэг нь эдгээр газруудад эрт үед тариалан эрхэлж байсны баримт юм. Хадаасангийн суваг шуудууны таталт, хамар далан хийсэн байдлаар нь хүнсний ногоо тарьж байсан гэж үзжээ.

Туул голын эрэг дээрх Цогт тайжийн цагаан ордны оромноос чулуун тээрэм, тариа цайруулдаг бул олдсон боловч тарианы талбай, усалгааны суваг шуудууны ул мөр олдоогүй нь тариагаа өөр газарт тариад тэнд зөвхөн цайруулах, тээрэмдэх ажлыг хийж байсан гэсэн дүгнэлтэнд хүрчээ.

Мөн Архангай ба Өгийнуурын хооронд 35-40 км үргэлжилсэн

Тоглохын тал гэдэг сайхан тэгш тал хойгуураа Тамирын хөндийтэй нийлсэн байдаг. Эндээс олдсон чулуун булыг хэзээ нэгэн цагт, зарим эрдэмтэд уйгурын үед тариа тарьж байсны гэрч хэмээн үздэг.

Тоглохын тал дахь чулуун бул

Сэлэнгийн Хараа, Ерөө, Эзвэн, Бургалтай зэрэг ихэнх гол горхинуудын ойр орчимд усалгааны суваг шуудуунууд байнга тааралддаг. Тэдгээрийн нэг хэсэг нь гол горхиноос ус гаргаж авсан хүнсний ногооны талбайд тогтмол усалгаа хийх зориулалттай байхад нөгөө хэсэг нь хаврын цасны усыг ашиг-лан үр тарианы талбайд цэнэг усалгаа, өөрөөр хэлвэл, жилд ганц л удаа услахад чиглэгдсэн байна.

Эзвэн голын орчим газар нь далайн түвшнээс дээш 720-730 метр өндөрт оршдог, үржил шим сайтай, усалгаа хийх боломжтой учраас буудай, бог будаа, өргөст хэмх гэх мэт олон төрлийн үр тариа, хүнсний ногоо тарихад боловсорч гүйцдэг байна. 1940-өөд оны эхээр усалгаатай талбайд тарьсан буудай 32.0 ц/га, хошуу будаа, арвай 40-45 ц/га ургац авч байжээ.

Орхон-Сэлэнгийн сав газар дахь эртний тариалангийн бас нэг голомт газар бол Хараа ба түүнд цутгадаг жижиг гол горхинуудыг түшиглэн тариа, хүнсний ногоо тарьдаг газрууд юм.

1818 онд Бээжин-Их хүрээ-Хиагтаар явж өнгөрсөн Оросын шашны төлөөлөгч Иакинф Бичурин тэмдэглэлдээ Бороо, Баянгол, Хараа, Шарын гол, Ибцигийн хөндийнүүдэд тариа, ногооны талбай, хагалсан газар, хог ургамалтай гар аргаар тэмцэж байгаа хүмүүс тааралдаж байсныг дурьджээ. Энэ хүний бичсэнээс үзэхэд, одоогийн Төв аймгийн Борнуур сумаас эхлээд улсын хил хүртэл тариалангийн талбай тааралдсаар байсан байна.

Үүнээс хойш удалгүй Хиагт-Хаалганыг дамжин тэмээн жингээр Бээжин хүртэл аялсан Палладий (1859) Хараа голын сав орчим дахь Ноён уулын өвөөр тарианы талбай, усалгааны суваг шуудуу, шавар байшингууд тааралдаж байсныг бичээд, суурьшилтай амьдрал байна гэсэн дүгнэлт хийжээ.

Эдгээр хүмүүсийн тэмдэглэлд бичигдсэн газар, усны нэрийг харахад одоо Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Сүхбаатар зэрэг манай улсын хүн ам олноор төвлөрсөн томоохон хот суурингуудыг бүтээгдэхүүнээрээ хангадаг газар тариалангийн үйлдвэрлэлийн гол район нь эртний

Голын усыг сувгаар авсан байдал.

тариалангийн томоохон голомт газар болж байна.

Бэлчээрийн мал аж ахуй ба тариалангийн хооронд үүссэн харилцааг зохицуулах хууль эрхийн акт монголд зохиогджээ. Халх журам нэрт энэхүү хуулийг XVIII зууны эхээр боловсруулж мөрдөж эхэлсэн байна. "Халх журам"-д өвс хадлан, тариаг малаас хамгаалах, хөрөнгө будаа, усалгааны суваг шуудууны тухай бүлгүүд орсон нь малын тэжээл, тариа ногооны талаар монголын төр нэлээд эрт үеэс анхаарч ирснийг харуулж байна.

Орхон-Сэлэнгийн сав нутагт хоёр төрлийн усалгааны системийг хэрэглэж иржээ. Усыг авах эх үүсвэр ба усалгаа хийх хугацаагаараа ялгаатай энэ хоёр системийн алиныг хэрэглэх нь таримлынхаа төрөл зүйлээс хамаарна. Үүнд:

1.Гол горхины усыг сувгаар авч тарилтын өмнөөс эхлээд ургалтын хугацааны турш тодорхой үе шатуудаар өгдөг усалгааг голдуу хүнсний ногооны талбайд хэрэглэдэг. Тэгэхдээ усыг Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө, Тамир, Чулуут зэрэг том голуудаас биш, тэдгээрт цутгадаг жижиг гол, горхинуудаас авсан байдаг. Энэ нь жижиг голууд урсгал түргэнтэй, байрлалаар өндөрт оршдог болохоороо гольдролоос нь гаргахад хялбар бас услах талбайн хэмжээ том байдгаар тайлбарлагдана.

2.Уулсын хормойгоор их урт шуудуу татаж хаврын цасны усыг хуримтлуулан цэнэг усалгаа хийх аргыг үр тарианы талбайд хэрэглэнэ. Усалгааны ийм системд толгойн барилга гэж байхгүй, шуудуу нь цасан бүрхэвч зузаан тогтдог аль нэг газраас эхэлдгээрээ онцлогтой. Энд усны тогтмол эх үүсвэр байдаггүй учраас тарилтын өмнө ганц л удаа усална.

Баруун монгол дахь эртний тариалангийн голомт газрууд

Увсын Хархираа, Түргэн, Хангил-цаг, Ховдын Буянт, Булган, Дарви, Говь-Алтайн Бигэр, Шарга, Ха-лиун, Цогт, Чандмань, Завханы Улиастай зэрэг олон зууны турш тариалан эрхэлж удмын тариачидтай болсон нутгууд олон бий.

Түүхийн эх сурвалжуудад тэмдэглэснээр Хархираагийн тариалангийн эх үүсвэрийг Ойрдын хаан Галдан бошгот тавьжээ. Тэр 1685 оны үед Ойрдын нутгийг зүүн тийш нь Ховдын гол хүртэл тэлээд цэрэг армиа хоол хүнсээр хангахын тулд мал аж ахуйн зэрэгцээгээр тариа тариулж эхэлсэн байна. Галдан бошготын Хархираагийн голоос татсан сувгийг нутгийн иргэд "Бошигтын бух" гэж нэрлэдэг бөгөөд ул мөр нь одоо хүртэл байгаа ажээ.

Баруун Монгол хур тунадас багатай нутаг учраас үр тариаг дээр өгүүлснээр таван удаа усалдаг боловч аль нэгэн усалгааны үеэр таарч бороо орвол усалгааг хийхгүй байж болдог. Тэнд усыг хатуу байдалтай үед нь хуримтлуулж нөөцлөөд хавар талбайгаа усалдаг нэн өвөрмөц арга байдаг бөгөөд түүнийгээ "Мөсөн бух" гэж нэрлэнэ.

Мөсөн бухын давуу тал нь усыг өвлийн цагаар хуримтлуулдаг. Хуримтлуулсан усаа үр ашигтай зарцуулж чаддагт оршино. Одоо манайд хэрэглэж буй энгийн ба инженерийн хийцтэй уcлалтын системүүдэд хавар толгойн барилга гэсэхийг хүлээсээр байтал санд хуримтлуулсан ус нь ууршиж дуусдаг. Бас тарилтын хугацаа өнгөрчихөж байгааг харахад манай нөхцөлд тийм ч тохиромжтой биш юм.

Оросын эрдэмтэн В.Ф.Шубин Хархираагийн уcлалтын системийг эхнээс нь сайн бодож хийсэн таван сувагтай тэдгээрээр Улаангомын хөндий дэх тариа, ногоог усална. 50 км үргэлжилсэн төв сувгаар Тээлийн ам орчмын 3500-аад га талбайг услах боломжтой. Цаад дөрвөн сувагны гурав нь 18-30 км урт мөн л тариа, ногооны талбайг услахад зориулагдсан. Харин нэг нь Улаангомын оршин суугчдыг усаар хангахад чиглэгдсэн болохыг тодорхойлжээ.

Хархираа, Тагнын уулсаас Увс нуурын хонхор руу буусан Түргэн, Сагил, Боршоон голуудын эрэг дагуу тариа тарьдаг айл өрх олон байсан байна. Эдгээрийн зарим нь морин ба усан тээрэмтэй тавaарлаг чанартай үйлдвэрлэл явуулдаг байжээ. Түргэний гол дээр усан тээрэм, Сагил сумын Хар мод гэдэг газарт морин тээрэм байсны ул мөрийг саяхан болтол нутгийн хүмүүс очиж сонирхож байжээ.

Алтайн нуруу хойноосоо урагшлах тутам гол горхиуд цөөрч, ус нь багасдаг боловч тэр хэмжээндээ тохирсон жижиг талбайнууд бүхий тархай тариалан үргэлжилсээр Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутаг Хүрхрээ хүрнэ.

Ховдын Буянтаас урагш гурван Цэнхэр, Зэрэг, Хойд гол, Ховхор, Говь-Алтайн Төгрөг, Халиун, Бигэр, Цогт, Чандмань сумуудад гол горхийн усыг түшиглэсэн өрхийн тариалантай газрууд олон бий.

Энэ бүсэд тариалан хөгжих явцад тогтсон таван усалгааны зарчмыг ерөнхийдөө баримталдаг боловч дээр өгүүлснээр тухайн үеийн цаг агаарын нөхцөлөөс хамаарч ургалтын хугацаанд хийх усалгааны тоо хэлбэлзэлтэй байдаг.

Мэн-Гу-Ю-Му-Цзи буюу нүүдэлчин монголчуудын тухай тэмдэглэл хэмээх хятадын сурвалж бичигт Улаангомын үржил шимт хөрс, цаг агаарын тохиромжтой нөхцөлийн ачаар буудайн арвин ургац авсан, харин сайрын торгуудууд Булган гол дахь тариалангийн газрыг 2600 му хүртэл өргөтгөснийг тэмдэглэсэн нь эдгээр нутгуудад дээр үеэс тариалантай байсны гэрч болно.

Тухайн үед мэдээлж байснаар, Ховдын тариалан 1776 оноос эхлэн жил дараалан нэг суулга хөрөнгө цацаад 10-20 суулга ургац авч байсан бол 1785 оноос ургац буурч 5-6 суулгаас хэтрэхгүй болсон байна. Үүнийг удаан хугацаагаар ашигласны уршгаар газар турсны үр дагавар гэж үзээд амрааж атаршуулах, бордох, өргөн мөрөөр тарих болон агро-техникийн бусад аргууд хэрэглэж ургацыг 15-20 суулгад хүргэж байжээ.

Ховдын тариалан олон арван жилийн турш тогтвортой арвин ургац авсаар ирсэн удмын тариачидтайгаараа алдаршсан нутаг юм.

Г.Н.Потанины экспедицэд оролцож явсан байрзүйн зурагчин Орлов 1879-1880 онд Ховдын тариалангийн газрыг судлаад усалгаа, арчилгаат сайн хийдгийн ачаар буудай, бог будааны арвин ургац авч байгааг цохон тэмдэглэжээ.

Мөн 1917 онд цаг агаарын тохиромжтой нөхцөл бүрдэж Буянт голын адаг дахь сангийн тарианы газар дунджаар жилд 1 десятин талбайгаас буудай 75, арвай 70, хошуу будаа 65 пүү ургац авч байсныг тэр үед мэдээлсэн байна.

Баруун монголд ургуулсан тариагаар нутаг усныхаа гурилын хэрэгцээг хангаад зогсохгүй Улиастайд авчирч борлуулдаг байжээ. 1880 онд Улаангомд том тээрэм 2 байсан бол 1912 онд морин ба усан тээрмийн тоо 30 хүрч байсан байна. Ингэж гурилын үйлдвэрлэл нэмэгдсэнээр уг бүтээгдэхүүнийг хятадын Шинжаан, Бархөл, Хами хотуудад гаргаж байсан тухай мэдээ бий.

Баруун Монголд нэг шуудай хөрөнгө цацаад 10-15 шуудай тариа авбал тааруухан, 35-40 шуудайг авбал арвин ургац хураасанд тооцдог байна. Үүнийг га-д шилжүүлбэл 10-40 ц/га ургац авдаг гэсэн үг юм.

Хөрөнгө будааг хадгалдаг дэхт

Эртний тариалангийн голомт газруудаас баруун монголын ялгагдах нэг онцлог нь хөрөнгө будаагаа ялгах хадгалахад их анхаардаг. Тариаг салхинд хийсгэн жингээр нь ялгаад магнай тал буюу хамгийн хүнд хэсгийг дараа жил тарих хөрөнгө болгон авч үлддэг. Ингэж ялган авсан хөрөнгөө дэхт хэмээх саванд хийгээд амбаарт хадгална. Дэхт гэдэг нь үхэр, ямааны битүү өвчсөн арьсыг эдэлж хийсэн оёдолгүй тулам юм. Буудай, арвайн

үрийг ийм саванд хадгалахад муудах, соёололт нь буурах явдал гардаггүй байна.

Дорнод монгол дахь эртний тариалангийн голомт газрууд

Манай орны дорнод бүс нь газрын гадаргуу, хөрсний чанараараа газар тариаланд баруун монголоос илүү тохиромжтой боловч чийгийн хангамж муу, услах боломжтой газар бага учраас нэлээд хязгаарлагдмал хүрээнд тариалан эрхэлж иржээ. Энэ бүсэд эртний тариалангийн голомт газрууд Онон, Улзын хөндий, Хэрлэн, Халх голуудын эрэг, дэнжээр оршино.

XIII-XIY зуунд Чингис хаан ба түүнийг залгамжлагчдын хийсэн аян дайны үеэр хятад, дундад Азиас уран дархчуудыг авчирч суурьшуулсан нь Улз, Онон, Хэрлэн голуудаар тариалан эрчимтэй хөгжихөд нөлөөлснийг түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн байна.

Хятадын жуулчин Чжан Дэ-Хэй монголоор явсан тухай "Замын тэмдэглэл"-дээ, Хэрлэн мөрний эргээр шавар дээвэртэй байшинд амьдардаг Монгол, Хятад хүмүүс таарaлдаж, тэдний орчин тойронд хагалсан газар, тариан талбай харагдаж байсныг бичжээ.

Дорнод Монголд тариалан хөгжүүлэх үйлсэд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж явсан өвөг дээдэс олон нь мэдээж. Эдгээрийн дотроос Цэцэн ханы То ван хэмээн түүхэнд алдаршсан Тогтохтөрийн хувь нэмэр их ажээ.

Түүний шийдвэрээр Халх гол, Хавцал, Гүнцэл, Гангийн тал болон бусад олон газарт ихээхэн талбайг хагалж арвай, гич, хөх тариа тарьж байжээ. То ван эдгээр таримлуудын ургацыг хураaж усан тээрмээр тээрэмдэн гурил хийгээд хошууныхаа хэрэгцээг хангаснаар барахгүй зэргэлдээх хошуудад ч өгдөг байсан байна.

Тэр бог будаа тарьж тээрэмдээд, хүүхдээ цатгадаггүй хөхүүл эхчүүдэд өгч хөхөнд нь сүү оруулдаг байсныг нутгийн хүмүүс одоо ч ярьдаг.

Өнөөгийн Халх гол сумын нутаг Гүү, Азарга, Ташгай, Баянгол, Арбулдруу хэмээх газруудад То ван бог будаа тариулж байжээ.

То вангийн сургаалийн бичмэл эх ээс

Халх голын хөндий дэх Их бурхантын орчимд То вангийн номын зуны өргөө байсан бөгөөд тэнд усан тээрмийн чулуу одоо ч байгаа юм.

Дорнод Монголд тариа дээр үеэс өргөн хэрэгцээт бүтээгдэхүүн байсныг гэрчлэх шууд бус баталгаа бол татварт будаа авдаг байсан явдал юм. Үүнд 20 толгой үхэр тутамд нэг тогоо тариагаар бодож татвар ноогдуулдаг байжээ.

Дорнод Монголын хойд хэсэг Улз, Онон голуудын хөндийд таримлын нэр төрөл нь Халх голынхоос нэлээд ялгаатай, хошуу будаа, төмс, шар лууван, мохоор тарьдаг байжээ.

XYIII зуунд явж өнгөрсөн жуулчид Онон, Улз голуудын тариачин хүмүүс Европ маягийн нэг корпустай анжсаар газар хагалж, төмөр шүдтэй модон борной хэрэглэдэг тухай тэмдэглэснээс үзэхэд эдгээр баримтууд нэлээд хожуу үеийнх болотлой.

Саяхан болтол одоогийн Дорнод аймгийн төвийн ойролцоо Хэрлэн гол дээр чигир тавьж усыг аваад ногоо тарьж байжээ. Чигир гэдэг нь голын усыг эргэдэг хүрдний тусламжтайгаар хутгаж аваад гольдролоос нь гаргадаг төхөөрөмж юм. Усны урсгалаар эргэх хөдөлгөөнд ордог энэ төхөөрөмжөөр бага хэмжээний талбайг л усална.

Мөн 1940-өөд онд Улзын гол дээр Дорнодын Баян-Уул, Хэнтийн Норовлин сумуудын заaг нутаг Мөст гэдэг газарт усан тээрэм ажиллуулдаг байжээ.

Улз голын хөндийд өргөн бөгөөд мод, бут багатай хар хүрэн хөрс бүхий газрууд хэсэг хэсгээрээ таарaлддаг. Ийм газруудад нэлээд эртнээс төмсийг услалгүй тарьж заншсан байна.

Сүүл үеэс Ононгийн хөндийд Дадал, Баян-Адарга сумуудын зарим нутагт буудай, хошуу будаа, арвай тарьж боломжийн ургац авч эхэлжээ. 1940-өөд оноос Норовлин суманд усалгаатай талбайд тарьсан буудайн ургац 20-25ц/га байжээ.

Хэрлэн гол дээр 1940-өөд оны үед ажиллаж байсан чигир

Дээрх эрт, эдүгээгийн баримтуудаас үзэхэд, Дорнод Монголд усалгаатай тариалан эрхлэх түүхэн уламжлалтай, энэ талаар баримтлах технологийн үндэс суурь буй болсон, таримлын нэр төрөл ч нэлээд тодорхой байгаа нь ойлгомжтой байна.

Атар газрыг эзэмшсэнээс хойш усалгаатай ба усалгаагүй нөхцөлд үр тариа, төмс хүнсний ногоо, тэжээл, техникийн зарим ургамлуудыг тарьж туршаад зохих үр дүнгүүдийг гаргажээ. Усалгааны асуудлыг шийдсэн цагт Дорнод Монгол манай орны газар тариалангийн хоёр дахь том район болж болох ирээдүйтэй гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Говийн ба цөлийн бүсэн дэх эртний тариалангийн голомт газрууд

Говийн бүсэнд баруун ба баруун өмнө зүг рүү урсдаг Заг, Байдраг, Түй, Таац, Завхан, Онгийн голуудын адаг болон булаг шандуудыг түшиглүүлэн бага хэмжээтэй боловч эрт дээр үеэс тариа тарьдаг болсон газрууд олон бий.

Говьд өрхийн тариалангаас гадна таваарлаг чанартай юмуу томоохон төвлөрсөн хэрэгцээ хангах зорилгоор харьцангуй их хэмжээний талбайд тариалалт хийдэг газрууд ч байжээ.

Галдан бошгот 1696 онд Онгийн голын сав газар Буурцагийн хөндийд тариа тариулж байсны ул мөр одоо хүртэл арилаагүй байна. Энэ үед Галдан бошгот манжтай байлдаж байсан учраас цэргийнхээ хоол хүнсэнд зориулан ийнхүү тариулжээ.

Баянхонгор аймагт Бөөнцагаан нуураас дээш Байдрагийн гол өгсөөд 30 орчим км зайтай орших Хөх эрэг, Бор толгойд өнө эртнээс тариа тарьсаар ирсэн газар юм. Тэнд үр тариа, буурцагт ургамал, хүнсний ногоо зэрэг олон төрлийн ургамлыг одоо ч тарьж байна.

Б.Дорж мээрэн

XYIII зууны сүүлч, XIX зууны эхэнд амьдарч байсан Б.Дорж мээрэн одоогийн Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Борзонгийн говь дахь Бяруухайн булагт арвай тарьж тэмээн тээрмээр гурил хийгээд нутаг усны хүмүүсийнхээ хэрэгцээг хангаж байснаар барахгүй Нийслэл хүрээнд авчирч борлуулдаг байсан байна.

Хожим Богд хаант Монгол улсын Сангийн яамны сайд байсан энэ хүн хоёр төрийн үед газар тариаланд зүтгэж явсан түүхэнд үлдэх гавъяатай хүмүүсийн нэг юм. Буниабазарын Дорж Сангийн яамны сайд байхдаа Сэлэнгийн Зүүнхараа, Ховдын Буянтад Сангийн тариа нэртэй томоохон аж ахуйнуудыг байгуулаад, Засгийн газартаа асуудал тавьж татвараас чөлөөлүүлж байсан байна.

Говь-Алтай аймгийн Шаргын голд тариалангаар дагнаж амьдардаг олон айл өрх байсан бөгөөд тэд суурин амьдралтай хүмүүс юм.

Өмнөговь аймгийн Даланзадгад, Дорноговь аймгийн Сайншанд суманд нэлээд эрт үеэс тарьдаг байсан тухай мэдээ байдаг.

Модон анжис

Засагт хан аймгийн Шаргын голын адаг, Хүвүүр Зайлганы гол, Бигэр, Хүрхрээ, Захуй, Зарам, Сайн Ноён хан аймгийн Буянт зэрэг газруудад эрт үеэс тариа тарьсаар ирснийг тэмдэглэжээ.

Алтайн өвөрговийн Элст мянган, Баянтоорой, Ээж хайрхны хаяа, Лигийн гол, Эхийн гол гэх мэт Баянбүрдийн тариалантай газрууд олон бий.

Модон анжис

Баянтоорой, Эхийн гол, Лигийн голууд усны хүрэлцээ харьцангуй сайтай учраас нэлээд том хэмжээний талбайд тариа тарьдаг байна. Лигийн гол, Эхийн голд анх Цагаанбар гүн ноён тариа тариулсан тухай домог байдаг. Харин түүхийн сурвалж бичигт тэр хүний тариа тариулж байсныг тэмдэглэсэн боловч чухам анхдагч нь хэн болох талаар тодорхой баримт алга.

Говийн баянбүрдүүдийн Тариаланд үр тарианаас гадна хүнсний ногоо, гуатан ургамлыг тарихад тохиромжтой. Баянтоорой, Эхийн голд өргөст хэмх, улаан лоолийг үрээр нь тариалж арвин ургац авдаг. Наяад оны эхээр Эхийн голд нэг ширхэг тарвасны жин 22 кг хүрч байсан удаа бий.

Тариалангийн багаж, тоног хэрэгсэл

Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрхлэхэд бусад салбаруудын нэгэн адил ажлын онцлогт тохирсон багаж, тоног хэрэгсэл шаардагдана. Ийм хөдөлмөрийн багаж зэвсэггүйгээр уг үйлдвэрлэлийг явуулах боломжгүй юм.

Манай ардын тариалангийн багаж зэвсгийг голдуу нутаг орондоо байдаг материалыг ашиглан тэр ажилд мэргэшсэн дадлага туршлагатай цөөхөн хүн хийдэг байжээ. Бэлчээрийн мал аж ахуйд түшиглэн жилийн дөрвөн улиралд нүүдэллэж амьдардаг хүмүүст тариалангийн багаж зэвсгээр дагнан ажилладаг төвлөрсөн үйлдвэрлэл буй болох нөхцөл байхгүй учраас дан гар аргаар хийдэг байжээ.

Ингэж хийсэн багаж нь овор багатай ачаад явахад хөнгөн, голдуу мод, шир, суран материал хэрэглэдэг учраас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөө багатай, ялангуяа хөрсний бичил организмын үйл ажиллагаа болон агрегат бүтцэд харьцангуй бага нөлөөлдөг байна.

Тариаланд хэрэглэгддэг багаж зэвсгийг зориулалтаар нь 4 ангилж болно.

1.Хөрс боловсруулалт ба усалгааны зориулалттай:

-Анжис
-Бул
-Борной
-Илүүр
-Хүрз
-Зээтүү

Модоор сүлжиж хийсэн борной

2. Ургац хураахад зориулагдсан:
-Хадуур
-Тармуур
-Сэлгүүр
-Сэрээ
-Хүрз
-Араг
-Цан
-Шар
-Хунз

Хүрз, ац, савар, араг

3. Цэвэрлэгээнд зориулагдсан:
-Муцан
-Савар
-Цайлуур
-Шүүр

Шар будааны цайлуур (шигшүүр)

4. Хэмжиж, хадгалахад зориулагдсан:
-Дүү
-Хайсан
-Дэхт
-Тулам
-Уурхай

Дүү (тариа хэмжигч)

5. Боловсруулахад зориулагдсан:
-Тээрэм
-Шигшүүр
-Цохи
-Цохиур
-Уур
-Нүдүүр.

Гар тээрэм

Уур, нүдүүр

Цохи, цохиур

Морин тээрэм

Эдгээр багаж зэвсгүүд нь ур хийц, хэмжээ, хөдөлмөрийн бүтээмжээрээ харилцан адилгүй юм. Жишээлбэл, тээрэм гэхэд л гар, морин, усан гэж 3 янз байсан бөгөөд гар тээрэм нь өрхийн хэрэгцээг хангахад зориулагддаг байхад нөгөө хоёр нь товарлаг чанартай аж ахуйд хэрэглэгддэг байжээ.

Ийм учраас гар тээрэм айл бүрт, морин тээрэм нэг суурин юмуу хэд хэдэн хот айлын хэрэгцээг хангадаг, хэд хэдэн хошууны дунд нэг усан тээрэм ажилладаг байсан байна.

Бидэнд олдож байгаа мэдээгээр 1940-өөд оны үед манай улсад том, бага хүчин чадалтай 30 орчим усан тээрэм ажиллуулдаг байсны хамгийн том нь Зүүнхараад байжээ.

Өвөл гол хөлдөж усан тээрм ажиллахаа байсан үед түүний дэргэд байгуулсан 22 морин тээрмийг ажиллуулж үйлдвэрлэлээ зогсоолгүй явуулдаг байсан байна.

Морин ба усан тээрэм товарлаг чанартай үйлдвэрлэл учраас гурилыг шигшиж дугаарладаг тусгай төхөөрөмжтэй, түүнийгээ шаа гэж нэрлэнэ. Тээрэм эргүүлж буй морийг байнга явуулдаг хүн хөлөөрөө шаа гишгэн гурилаа шигшдэг зохион байгуулалттай учраас нэг жижигхэн байшинд хоёуланг нь байрлуулна.

Дээр дурьдсан багаж зэвсэг, хэмжүүрүүд нь тодорхой зориулалттайгаар барахгүй хүчин чадал, норм, бүтээмжтэй, хэрэгцээгээ хангаж, үүргээ гүйцэтгэсээр иржээ.

Өнөөгийн өндөр хөгжилтэй орнууд ч тухайн үедээ хөдөлмөрийн иймэрхүү багаж зэвсгээр тариалан эрхэлж байсан нь тэдний хойшид хөгжих замыг тавьж өгсөн гэдэг. Тэгэхээр бид ардын тариалангийн тоног хэрэглэлийг зөвхөн түүх дурсгалын зүйл төдийгүй манай өвөг дээдсийн оюун ухаан хүч хөдөлмөр шингэсэн үнэ цэнэтэй бүтээл гэж үзэх ёстой.

Тарималын нэр төрөл, сорт

Аливаа улс орны хөрс, уур амьсгалын нөхцөл, тариалангийн түүх, хүнсний бүтцийг тарималын нэр төрөл, сортоор тодорхойлох боломжтой юм.

Уур амьсгалын таатай нөхцөлд тарималын нэр төрөл олширч, хоол хүнсний бүтцэд олон төрлийн бүтээгдэхүүн оролцсон байдаг бол нутгийн сортууд тариалангийн түүх, хөгжлийн түвшинг илэрхийлдэг.

Монгол орны тариалангийн голомт газруудыг харахад тарималын нэр төрөл нутгийн өндөр, нам буюу босоо бүслүүрээс нэлээд хамааралтай байна. Хангайн нуруунаас буусан Тамир, Хануй, Хүнүйн голууд болон Сэлэнгэ мөрний эхээр арвай тарьж байхад тэдгээрээс доош орших Хөвсгөлийн Рашаант, Их Уул, Тариалангаас эхлээд үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарьж байна.

Алтайн нурууны Булган, Үенч, Буянт, Ховд голуудын эхэнд мөн л арвай, адаг руу нь арав гаруй нэр төрлийн үр тариа, буурцагт ба гуатан ургамал тарьдаг.

Хэнтийн нуруунд орших Төв аймгийн Мөнгөнморьт сумын төв орчимд дөчөөд оны үед арвай тарьдаг байжээ. Гэтэл одоо тэндээс доош Хэрлэн голын хөндий дагуу зуу гаруй км зайтай оршдог Хэрлэнбаян-Улаанд тэжээлийн олон ургамлыг тарьж туршихад бүгд ургаж боловсорсон байна.

Хөвсгөлд Хатгалаас урагш арвай, түүнээс доош Эг ба Үүрийн голуудын уулзвар дахь Эрдэнэбулган сумын нутагт буудай, хошуу будаа болон бусад тарималууд боловсорч зарим жилд 20-30 ц/га ургац авчээ.

Арвайн тариалан эрхэлдэг дээрх газрууд нь жилд 250-270 мм тунадастай, далайн түвшнээс дээш 1200-1400 метр өндөрт оршдог.

Монгол Алтайн нурууны төгсгөл рүү Говь-Алтай аймгийн Тонхил, Чандмань, Эрдэнэ, Шарга зэрэг сумуудад Алтайн ар, өвөр рүү буусан жижиг голуудын хөндий, бэл, амуудаар арвай тарьж байсан ба одоо тарьж буй газрууд цөөнгүй байдаг бөгөөд тэд 1400 метрээс дээш өндөрт байрладаг боловч тунадасны хувьд Хангай, Хэнтий, Хөвсгөлийнхөөс бага юм.

1931-1932 онд баруун Монголд В.И.Барановын удирдлагаар хийсэн ЗХУ-ын (хуучин нэрээр) Шинжлэх ухааны академийн экспедицийн тайланд далайн түвшнээс дээш 1800 м өндөрт арвай боловсорч байсныг тэмдэглэжээ. Мөн тэнд буудай тарьдаг хамгийн өндөр газар нь 1300-1350 м бол Хангайн нурууны ард 48-р өргөргөөс урагш оршдог Түвшрүүлэхэд 1500-1600 метрт буудай боловсордог байна.

Монгол оронд нэлээд эртнээс таригдсаар ирсэн өөр нэг ургамал бол хошуу будаа юм. Өнөөгийн Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Увс, Хэнтий аймгуудын нутагт хошуу будааг тэжээлд зориулан бага хэмжээний талбайд тарьсаар ирсэн ба одоо ч тарьж байна. Буудай ургаж байгаа газарт хошуу будааг тарьж болно гэсэн ойлголт зөв байсныг сорилтын үр дүн бататгаж өглөө.

Хүнс, тэжээл, агротехникийн чухал ач холбогдолтой тарималуудаас вандуйг баруун монголын зарим нутагт бага хэмжээгээр тарьж хүнсэнд хэрэглэхээс гадна буудай, арвай зэрэг бусад тарималын ургацыг нэмэгдүүлэхийн тулд тэдэнтэй хольж тарьдаг.

Мөн сүм хийдийн хэрэгцээнд зориулан дангаар нь тарихын зэрэгцээ арвай, буудайтай хольж тариад хураасны дараа үрийг нь ялгаж авдаг байсан байна.

Төмс, хүнсний ногоог Их хүрээ, Заяын баалюу, Улиастай, Ховд, Улаангом, Хиагт зэрэг хүн ам олонтой төв суурин газруудад тарьдаг нь зах зээлийн шаардлага байлаа.

Уур амьсгалын эрс тэс нөхцөлд оршдог манай оронд тарималын нэр төрөл ихээхэн хязгаарлагдмал байдаг нь дээрх баримтуудаас тодорхой байна. Гэвч тэр цөөхөн тооны тарималын унаган сортууд харьцангуй элбэг. Ялангуяа арвай, буудайн нутгийн сортууд газар тариалангийн зарим бүсүүдээс олдсон ба одоо ч олдсоор байгаа нь эдгээрийг нэлээд эрт үеэс тариалсаар ирсний баталгаа юм.

Сорт гаргахад багагүй хугацаа шаардагддаг, тэртусмаа нутгийн сорт бүй болгох ажил олон арван жилийн турш үргэлжилдэг онцлогтой.

Монгол орны нутгийн усалгаагүй нөхцөлд тарьдаг үр тарианы сортуудын нийтлэг шинж нь ургалтын хугацаа богино, дунд зэргийн ургацтай боловч шаг уурын нөхцөлөөс хамаарч дээш доошоо хэлбэлзэх хэмжээгээрээ харьцангуй бага байдагт оршино. Ийм сортын тоонд буудайн Хараа, арвайн Нудум, Алаг-Эрдэнэ, бог будааны Бургалтай багтана.

Харин усалгаатай талбайд тарьдаг буудайн цагаан дэглий сорт, сагилын хүрэн, арвайн бөгтөр хөх, хөх мөндрүүш, бужигар цагаан зэрэг цуглуулгууд бутлалт сайтай, олон үр өгдөг, боловсорч гүйцсэн үедээ амархан цайрдаг зэрэг биологи, аж ахуйн онцлогтой.

Профессор Н.Г.Хорошилов 1958 онд баруун аймгуудаар судалгаа хийж яваад Увс аймгийн Сагил суманд нүцгэн урт арвайн нэг үрээс 53 ширхэг түрүүтэй иш үүссэн байхыг үзжээ. Энэ эрдэмтэн өөрийнхөө судалгааны хүрээнд хамааргдсан нутгаас зөөлөн буудайн 28, хатуу буудайн 1, тагнайт буудайн 10 омог байгааг илрүүлжээ.

Эдгээрээс гадна хар, цагаан өнгөтэй вандуй, хальстай, хальсгүй хошуу будаа гэх мэт хараажаар эрс ялгаатай цуглуулга нэлээд байгааг генетикийн үүднээс ялгах, хэр зэрэг элбэг таригддаг, юунд зориулагдсан болохыг тодорхойлох, Архангайн Түвшрүүлэхээс олдсон үхэр буудай манайхаас өөр улс оронд байдаг эсэхийг эцэслэн тогтоох шаардлагатай байна. Үр тарианаас гадна төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн нутгийн сортууд цөөнгүй байгааг дурьдах хэрэгтэй. Үүнд:

Төмсний шийр-6, Завхан-35, сармисны Ховд, Улиастай, байцааны Хургалаг, дун ногооны Сувд, улаан луувангийн Алтанбулаг, жууцайн Хараа, батум сонгины Алтай, үхэр сүүлний Сэлэнгэ, чацарганын Чандмань, Улаангом, тарвасны Буянт зэргийг нэрлэж болно.

Бидний өвөг дээдсийн оюун ухаан, хүч хөдөлмөрөөр бүй болсон эдгээр бүтээлүүд бол зөвхөн монголчуудаар барахгүй бусад улс үндэстэн ч хүртэх ёстой хүнсний нөөц юм. Гадаад орнуудад манай нутгийн сортуудыг тарихын зэрэгцээгээр бас селекцийн эх материал болгож ашиглаж шинэ сортуудыг гаргаж байна.

Зөвлөлт холбоот улс оршин тогтож байх үед манай нутгийн сортыг эрлийзжүүлэх замаар усалгаатай нөхцөлд тарьдаг Саянская 55 гэдэг буудайн шинэ сортыг гаргаж авчээ. Энэ сортыг одоо манайтай хил залгаа оршдог, хөрс уур амьсгалын нөхцөлөөр адил төстэй Тува, Хакаст тарьж байна.



Монголын нутаг дэвсгэр дээгүүр Дорнод, Улаанбаатар, Ховдыг дайрч өнгөрдөг 48-р өргөргөөс урагш хур тунадас бага унадаг, ус-ны нөөц ховор учраас өргөн уудам газарт тариалан эрхлэх боломжгүй юм. Гэвч энэ хэсэгт багтаж буй Алтайн ар ба өвөр говиуд дулааны хангамж сайтай болохоор горхи, булаг, шандыг ашиглан өрхийн хэрэгцээний үйлдвэрлэл явуулдаг газар нэлээд байсан нь үр тарианы нутгийн сорт, дээжүүд буй болоход ихээхэн түлхэц өгчээ. Үүнээс гадна Богд хаант Монгол Улсын үед сүм хийдийн тариалан нэлээд эрчимтэй хөгжиж жас жав бүхэн өөрийн үртэй болж байснаар барахгүй нут-гийнхаа хөрс, цаг уурыг сайн мэд-дэг мэргэшсэн тариачидтай болж байсан байна.

Тэд хөрөнгө будааг сонгохдоо ургацын хэмжээнээс гадна бүтээг-дэхүүний чанарт бас анхаарч байжээ.

Уургийн агууламжаар манайд байтугай дэлхийд дээгүүр орох дээжийг Говь-Алтай аймгийн Халиун сумаас олсон бөгөөд цаана нь их, бага ямар нэгэн хэмжээний нөөц байгаагүйгээс үзэхэд нутгийн сорт байгаад устсан байж болох юм.

Зургаадай арвай

Бужгар арвай

Нутгийн зөөлөн буудай

Тагнайт буудай

Үхэр буудай

Ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулж хүнсэнд хэрэглэдэг уламжлалт арга

Үр тариа

Арвай, буудайг хүнсэнд хэрэглэхдээ эхлээд цан дээр хийсэн цэвэрлэгээгээр ялгараагүй хальс, иш, навчны үлдэгдэл болон нарийн шороо тоосыг арилгаж угаадаг. Угаасан тариагаа нимгэн үеэр дэлгэн тарааж сайн хатаасны дараа хуурч болгоно. Хууралтаар тарианы ширхэг бүхэнд хөндлөн хагархай үүссэн байх ёстой. Ингэж болгосон тариаг төмөр саванд хийж хөргөөд гар тээрмээр тээрэмдэж болсон гурил хийнэ.

Болсон гурилыг авч явахад хөнгөн, шингэц сайтай, өөг бас муудаж чанараа алддаггүй учраас ихэвчлэн аян жингийн хүнс болгож хэрэглэнэ. Түүний тэжээллэг чанарыг сайжруулах зорилгоор хонины сүүлтэй хольж ууранд нүдээд нэгэн өвөрмөц хүнс хийдэг. Ийм хүнсийг Баяд, Дүрвэд, Торгуудууд анчу, Халх хүмүүс багсарсан гурил гэж нэрлэдэг.

Баруун аймгийн ахмад хүмүүс өөрсдөө хальстай арвайн гурил идээд хүүхэд залуучуудыг нүцгэн үрт арвайн гурилаар хооллох дэглэм барьдаг. Энэ нь нүцгэн үрт арвайн гурил уураг ихтэй учраас хүүхэд залуучуудын өсөлт торнилт, бяр чадалд эерэг нөлөөтэй бол хальстай арвайн эслэг насжуу хүний ходоодны ажиллагааг сайжруулдагтай холбоотой юм. Чингис хааны цэрэг хүнсэндээ арвайн гурилыг голдуу хэрэглэдэг байсан нь ийм олон талын ач холбогдол-той байжээ. Болсон гурилыг хүн-сэнд дарах, нухах, бургиулах гэж гурван янзаар хэрэглэдэг байна.

Хуурсан буудай, арвайг тээрэмдэхгүйгээр малын дотор өөхтэй хольж товлоод идэж болдог бөгөөд үүнийг залуу хүмүүсийн шүдэнд сайн гэж ярьцгаадаг.

Буудайг ахиухан хэмжээний талбайд тарьж тавааралаг чанартай үйлдвэрлэл явуулдаг газруудад морин ба усан тээрэм ажиллуулж түүхий гурил хийдэг байв.

Бог будааг хүнсэнд хэрэглэдэг хамгийн түгээмэл арга нь чангаамал юм. Чангаамал хийхэд нэгдүгээрт сортыг зөв сонгож авах, хоёрдугаарт чаналт ба хууралтыг тохируулах явдал чухал ач холбогдолтой. Булган, Сэлэнгэ, Халх голд чангаамал хийхэд тохиромжтой тусгай сортуудыг тарьдаг байсан бололтой. Жишээлбэл, Сэлэнгэд мулцаг ухаа нэртэй хархүрэн юмуу ногооновтор өнгө бүхий нутгийн үрийг сонгон авч чангаамал хийдэг байжээ.

Сонгож авсан үрээ цэвэрлэж угаагаад нэг шанага будаанд 1,5 шанага ус ноогдохоор тооцож чанана.

Чаналтын явцад ус багассаар 2/3 хувь орчим болоод ирсэн үеэс эхлэн будаагаа жигд хутган эргүүлж аль нэгэн хэсэгтээ хэтэртэл чанагдахаас сэргийлдэг байна. Цаашид ус багасан чанаж байгаа будааны хальс хагарч ангайсаар нийтдээ жигдэрч зөөлөн болсон үед нь шүүж гаргаад тосолсон ширмэн тогоонд хуурна. Хуурах үедээ байнга хутгаж хөдөлгөх хэрэгтэй. Ингэхгүй бол доод хэсэгтээ түлэгдэж дээд тал түүхийгээрээ үлдээд хар алаг өнгөтэй, хүнсний Шаардлага хангахгүй чангаамал болно.

Хуурсан будаагаа ууранд бага багаар хийж няцлахгүйгээр зөөлөн нүдэхэд хар хальс нь мултардаг байна. Мултарч сугарсан хальсыг үрнээс нь салгахын тулд ялдгар түмпэн юмуу тавагт хийж дэвэх эсвэл шигшихийг алагшуулах гэнэ.

Алагшуулсан будаагаа дахин ууранд хийж түрүүчийн адил нүдэхэд шар хальс нь мултардаг бөгөөд үүнийг мөн л дэвж, шигшин цэвэрлэнэ. Ийнхүү хальслах, няцарсан хэсгийг нь салгах ажлыг 2-3 удаа давтан хийдэг бөгөөд сүүлчийнхийг нь цайлгах гэнэ. Харин гурван удаа давтагдвал завсрын цэвэрлэгээг дундлах гэж ярьдаг.

Чангаамлыг шүд бэхжүүлэх, нярай хүүхэд хөхүүлдэг сүү багатай эхчүүдэд хөхөнд нь сүү оруулдаг байна.

Бог будааг комбайнаар хураадаг, машинаар цэвэрлэдэг болсон өнөө үед цайруулах ба үтрэмд цэвэрлэх явцад гадуур хальс нь бүрэн салж түүхийгээрээ алагшсаныг түүхий будаа гэнэ. Үүнийг цайд хийх, агшаах, сүүнд чанах зэрэг янз бүрийн аргаар хүнсэнд хэрэглэхээс гадна дээр хэлсэнчлэн эмчилгээ, сувилгааны чиглэлээр ашигласаар иржээ.

Вандуйг арвай, буудайтай хамт хуураад тээрэмдэж хүнсэнд хэрэглэдэг нь уургийн хэмжээг нэмэгдүүлж, гурилын чанарыг сайжруулдаг өрхийн нөхцөлд тохирсон арга юм. Үүнийг тавааралаг чанартай үйлдвэрлэл явуулахад тохируулан механикжуулах, боловсронгуй болгох шаардлагатай. Өнөөгийн гурилын үйлдвэрүүдэд ийм аргуудыг хэрэглэж байгаа боловч нүсэр том учраас үнэ өртөг өндөртэй байна.

Төмс хүнсний ногоог ихэвчлэн гэрийнхээ шалан доогуур зоорь малтаад түүндээ хадгалж заншсан, тэр нь тусгай галлагаа, дулаалга хэрэглэдэггүй, зардал багатай арга юм. Харин жимс жимсгэний голдуу боловсорч гүйцсэн үед нь түүж идэх бас зарим тохиолдолд хатааж хэрэглэдэг байжээ.

Монголчууд таримлаас гадна эрт дээр үеэс зэрлэг ургамлыг түүж хүнсэндээ хэрэглэсээр иржээ. Нууц товчоонд:

Гоо төрсөн Өүлэн Эх
Гох дээлээ бүсэлж явж
Гол завыг өгсөж уруудаж
Гогод, мангирыг түүн явж
Хутагтан хөвүүдээ тэжээж өсгөв
Зарчимтай төрсөн үжин эхийн
Затгас төмсөөр тэжээсэн хөвүүд
Засгийн сайд болж өсөв хэмээн тэмдэглэснээс үзэхэд, дээрх ургамлуудыг дангаар нь хэрэглэх үе ч тулгарч байсан бололтой. Энд сонгинолог ургамлыг хүнсэнд хэрэглэх явдал говь, хангайн алинд нь ч түгээмэл байсныг гэрчилж байна.

Цагаан төмсийг өрөмтэй хольж идэхээс гадна бас дангаар нь ч хүнсэнд хэрэглэдэг. Харин хатаах юмуу нөөшлөх зэргээр боловсруулах, хадгалах арга байсан эсэх асуудал нь одоогоор мэдэгдээгүй байгаа нь энэ ургамлын биохимийн бүтэцтэй холбоотой байж ч болох юм. Ийм учраас цаашид судлах, тарималжуулах талаар анхаарах асуудлуудын нэг гэж үзвэл зохино.

Гурил, гурилан бүтээгдэхүүн болгож хэрэглэдэг зэрлэг ургамлуудаас говь, хээрийн бүсэд нэлээд элбэг тархсан нь суль, сулхир юм. Гол төлөв элс, элсэрхэг хөрсөнд ургадаг эдгээр ургамлуудын үрийг боловсорч гүйцсэн үед нь гараар түүж хатаагаад арвай, буудайн нэгэн адил хуурч тээрэмдэн гурил хийнэ.

Сулийн гурилыг нухаж, дарж идэхээс гадна өрөмний цөцгийн дээр нь үрж зузаалаад идэхэд маш сайхан амттай байдаг.

Монголчуудын түгээмэл хэрэглэдэг хүнсний нэг чухал бүтээгдэхүүн нь сонгинолог ургамал болохыг дээр хэлсэн. Зэрлэг сонгиныг намар түүж савлаад авдрын хоорондох зай руу тавьчихдаг. Өвөл хичнээн удаа хөлдөж, гэссэн ч тэр муудна гэж байхгүй. Ямар ч нөхцөлд гарган ирээд хөшиглөхөд нулимс асгаруулан, хамар цоргиж байдгаараа нүүдэлчдийн хэрэгцээнд жинхэнэ тохирсон бүтээгдэхүүн. Зэрлэг сонгиноор хоол амтлахаас гадна бас зуух тулганд цог дотор булж болгоод дангаар нь иддэг явдал бий. Харин энэ тохиолдолд хүнсэнд биш эмчилгээний зориулалтаар хэрэглэж хий ханиалгыг дардаг байна.

Мангир, хөмүүл, халиарыг түүж ирсэн даруйдаа угааж цэвэрлэн давстай хольж нүдэхэд хар ногоон өнгөтэй, чанамалархуу маягийн атлаа шүүслэгдүү бүтээгдэхүүн болдог. Үүнийг паалантай саванд дарж байгаад хоол амтлагч болгож хэрэглэхэд нэлээд удаан хугацаагаар хадгалагддагаараа давуу талтай юм.

Монголчууд хоол амтлагчийг нэг өвөрмөц аргаар хадгалдаг бөгөөд тэр нь сонгинолог ургамлыг цагаан идээтэй хольж хатаагаад урт удаан хугацааны турш хэрэглэдэг явдал юм.

Говийн ба баруун аймгийн малчид хөмүүл, сонгиныг түүгээд аарцтай хольж хуруудбарин хатаадаг. Түүнийгээ уут саванд хадгалж байгаад нүдэж нунтаглан өвөл, хаварт хярамцаг, бусад шөлтэй хоолонд хийж иддэг байна.

Сонгино, мангир, хөмүүл, халиараар бууз, банш, хуушуур, шөлтэй хоолыг амтлахаас гадна малын гэдэс дотор, толгой, гадар махыг гүзээ, олгойд битүү чанахдаа тодорхой жороор хэрэглэж сайхан үнэр, амт оруулдаг.

Хонины толгойг ингэж гүзээнд битүү чанахыг халхууд шаз, дотор махыг олгойд хийж чанахыг буриадууд эрээлж гэж нэрлэдэг.

Мөн настай хүмүүс бүхэл мах идэхдээ дээрх сонгинолог ургамлыг жижиглэн хэрчээд халуун шөлтэй аяганд давстай хамт хийж хутгаад дүрлэг болгож хэрэглэдэг. Ингэснээр хоол амт орж шингэц нь сайжирдаг байна.

Суль

Цулхир

Төрөл бүрийн жимс

Цагаан төмс

Ардын хувьсгалаас хойш газар тариалангийн үйлдвэрлэлийг өргөтгөх бодлогыг тууштай үргэлжлүүлжээ. 1924 оны 11-р сарын 26-нд эхэлсэн Улсын анхдугаар их хурал дээр Сангийн яамны сайд Б.Дорж тавьсан илтгэлдээ "Манай монголчууд хэдээнээс тариаланг эрхэлж ирсэн ч хэрэгцээнийхээ ихэнхийг хилийн чанадаас зөөх, манай нутагт амьдарч буй гадаадын хүмүүсээс худалдан авах замаар гурил будаагаа залгуулж байна. Ийм учраас ямар нэгэн татваргүйгээр тариаланг эрхлэх шийдвэр, хууль гаргаж Сангийн яамны сан хөмрөг гадаадын хүмүүсийн гарт очдогийг болиулах хэрэгтэй. Ингэснээр манай хөгжил түргэн ахих болно. Бид ард түмнээ тариалангийн ажилд сургах, урамшуулах, удирдах хэрэгтэй" гэжээ.

Үүний дагуу 1937-1938 онд өвс хадах морин станцуудыг 1940 оноос сангийн аж ахуйнуудыг байгуулж тариалангийн хүнд хүчир ажлыг механикжуулж эхэлсэн байна.

1942 онд хуралдсан Монгол Ардын Хувьсгалт намын Төв хорооны бүгд хурал, Улсын бага хурлын XXV чуулганаас тариалангийн нийт талбайг 69,0 мянган га-д хүргэх зорилтыг дэвшүүлсэн байна. Ингээд 1943 онд улсын хэмжээгээр эргэлтийн талбай 74-75 мянган га-д хүрч үр тарианы хэрэгцээний нэлээд хэсгийг өөрийн бүтээгдэхүүнээр хангах түвшинд хүрчээ.

Энэ үед эхэлсэн дэлхийн II дайны уршгаар манай орны эдийн засаг сульдан цаашаа ахих байтугай хүрсэн түвшиндээ тогтоход ч бэрхтэй болсон юм. Ингэж үүсэн хүндрэл бэрхшээл дайн дууссанаас хойш ч манай орны эдийн засгийн бүх салбарыг удаан хугацаагаар чөдөрлөн саатуулжээ.

1943 оноос хойш 15 жилийн дараа буюу 1957 онд 20 сангийн аж ахуй, 66 өвс хадах морин станц болон тариа тарьдаг хөдөө аж ахуйн нэгдлүүд 83,2 мянган га талбайд үйлдвэрлэл явуулж үр тариа 50-иад мянга, төмс хүнсний ногоо 20 гаруй мянга, тэжээлийн ургамал 12,0 мянган тонныг хураан авчээ.

Атар газрыг эзэмшсэн нь 1959 онд хуралдсан МАХН-ын Төв хорооны 3-р бүгд хурлаас атар газрыг эзэмших тухай түүхэн шийдвэр гаргаж эргэлтийн талбай 265,5 мянган га-д хүргэсний үр дүнд 1960 онд 256,5 мянган тонн үр тариа аваад Монгол Улсын түүхэнд анх удаа гурилын хэрэгцээг өөрийн бүтээгдэхүүнээр хангасан тэмдэглэлт үйл явдал болжээ.

Газар тариаланг хөгжүүлэх ажил цаашид улам далайцтай хийгдсээр нийгэм-эдийн засгийн шинэ тогтолцооны өмнө нэг хүнд ногдох үр тариа 415 кг, төмс 77 кг, хүнсний ногоо 29,5 кг-д хүрсэн юм.

Атар газрыг эзэмшсэнээр зөвхөн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдээд зогсоогүй хөдөө нутгийн нүүр царай үндсээрээ өөрчлөгдөн цахилгаан гэрэл, техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан олон арван төв суурин, сургууль, эмнэлэг, шинжлэх ухааны байгууллагууд бий болсон. Эдгээрийг дагаад хөдөөд шинэ шинэ мэргэжлүүд, ажлын байрууд олширч улс ардын аж ахуйг бүхэлд нь хамарсан томоохон хувьсал болсон юм.

Монголчуудын олон зууны турш мөрөөдөхийн төдий явж ирсэн энэ ажил хэрэгжих үед улс орныг толгойлж байсан Ю.Цэдэнбал, гардаж гүйцэтгэсэн Ц.Лоохууз болон тэдний удирдлагад ажиллаж байсан олон хүний үйл хэрэг түүхэнд үлдэх ёстой.

Манай оронд газар тариалангийн мэргэжилтэн бэлтгэх, Шинжлэх ухааныг хөгжүүлэхэд 20-р зуунд оршин тогтнож байсан ЗХУ ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Тэнд бэлтгэгдэж ирсэн агроном, инженерүүд, газар зохион байгуулагчид, эдийн засагчид, хөрс судлагчид мэргэжлийн байгууллагын янз бүрийн шатанд алба хашиж бодлого боловсруулах, боловсруулсан асуудлуудыг хэрэгжүүлэх ажлыг ЗХУ-ын мэргэжилтнүүдтэй хамтран хийсэн юм.

1953 онд тус станцыг Зүүнхараад шилжүүлэн газар тариалангийн судалгааг нэлээд өргөн хүрээнд

Үр тарианы агуулах

хийж байгаад жараад оны эхээр зөвхөн энэ чиглэлээр ажиллуулах шийдвэр гарч ургамал газар тариалангийн туршлага станц, 1963 онд эрдэм шинжилгээний хүрээлэн болгожээ.

1955 онд Шаамарт жимсний станц, 1960 онд Халх голд хөдөө аж ахуйн туршлага станцууд байгуулагдаж газар тариалангийн судалгааны ажлыг аль болохоор хөрс уур амьсгалын бүсүүдийг бүрэн хамааруулж хийх зорилго тавьсан байна.

Манай эрдэмтэд энэ хугацаанд таримал ургамлын агротехник, сорт судалгаа, хөрс элдэншүүлэлт, ээлжлэн тариалах систем, хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах технологи, хог ургамал өвчин хортонтой тэмцэх, эрдэс шим бордоог хэрэглэх хугацаа, тунг тогтоох гэх мэт гол гол асуудлаар өргөн хүрээтэй судалгаа хийж газар тариалангийн бүхэл бүтэн системийг боловсруулжээ. Үүний зэрэгцээгээр гадаадын арвин ургацтай сортуудыг нутагшуулсан байна. Монгол оронд газар тариалангийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд тэр үеийн ЗХУ-ын эрдэмтэд ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Ингэж шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхийн ачаар нэгж талбайгаас авах үр тариа 12-13 ц/га, төмс, хүнсний ногоо 150-200 ц/га-д хүрч газар тариалангийн бүтээгдэхүүнийг гадаадаас авдаг байснаа гадаадад гаргадаг орон болжээ.

Б.Дорж
Э.Амарбилиг





БҮЛЭГ III

- ЭРТНИЙ ХҮМҮҮСИЙН АМЬДРАЛ, СОЁЛЫН ХӨГЖИЛ, АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД
- НҮҮДЭЛЧИН МОНГОЛЧУУДЫН ДЭЛХИЙН СОЁЛ ИРГЭНШЛИЙН ХӨГЖИЛД ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ
- МОНГОЛ НУТАГТ БАЙСАН ЭРТНИЙ АЙМАГ, УЛСУУД
- ИХ МОНГОЛ УЛС
- ЭЗЭНТ ГҮРЭН
- XIV ЗУУНЫ ХОЁРДУГААР ХАГАСААС XVII ЗУУНЫ МОНГОЛ ОРОН
- МАНЖИЙН ҮЕИЙН МОНГОЛ ОРОН
- XX ЗУУНЫ МОНГОЛ ОРОН

ЭРТНИЙ ХҮМҮҮСИЙН АМЬДРАЛ, СОЁЛЫН ХӨГЖИЛ, АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

Эрт дээр үеийн хүний бууц Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй, мөн аймгийн Өлзийт сумын Нарийн гол, Шинэжинст сумын Босго, Өмнөговь аймгийн Булган сумын Цахиуртын хөндий, Ховд аймгийн Алтай сумын Барлагийн гол, Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ярх уул, мөн аймгийн Хулд сумын төвийн дэргэд, Дэлгэрцогт сумын Ёроол говь, Дорноговь аймгийн Сайншандын орчим зэрэг нэлээд газраас олджээ. Энэ нь Монгол орон бол хүн төрөлхтний өлгий нутаг мөн болохыг гэрчлэн харуулдаг байна.

Чулуун зэвсгийн үе

Доод палеолит
(800.000-100.000 жил)

Өнөөгийн Монгол улсын нутгаас илрүүлэн олж судалсан, хүний гараар хийгдсэн чулуун зэвсгийн дурсгалуудын хамгийн эртнийх нь палеолитын доод үед буюу одоогоос 750.000-800.000 жилийн тэртээд холбогдоно. Тэдгээр бууцнаас зануу, болоржин, хасын хольцтой шар, хар, цайвар цахиурлаг чулуунаас цуулсан залтас, гурван талт хажуугийн цуулдас, ялтсан хянгар, нэг чулууг нөгөөгөөр цохиж залтас авч байсан үлдэц чулуу, голын хайрган чулууг хөндлөн хагалж хийсэн хугадас зэвсэг, гурвалжин хэлбэрийн гилбэр мэс, хоёр талаас нь засан үзүүр мэс зэрэг тэр үеийн хүний ахуй амьдралдаа өдөр тутам хэрэглэж байсан чулуун зэвсэг олдсон байна. Ийнхүү доод палеолитын үед Монгол нутагт оршин амьдарч байсан хүний хөдөлмөрийн гол зэвсэг нь гилбэр ба мэсэн зэвсэг байсан бөгөөд тэдгээр нь цохих, цавчих, хэрчих, хусах зэрэг олон үйлд хэрэглэгдэж байжээ. Тэр үеийн хүн эдгээр үндсэн зэвсгээс гадна бүхэл чулуунаас хэлтэлж авсан хурц ирмэгтэй зузаан, нимгэн залтас, ялтас, мөн арслан заан, савгат хирс зэрэг аварга том амьтны яс, модон бороохой, шийдэм зэргийг ашиглаж байжээ.

Нутаг орондоо бэлэн байгаа материалыг чадамгай ашиглан түүгээр тоогоор цөөн ч өдөр тутмын хэрэгцээг хангаж байсан чулуун эдлэл зэрэг хуучин чулуун зэвсэгтний соёлын дурсгалууд нь манай ард түмний түүхэн хөгжлийн түрүүч нь даруй долоон зуун мянга гаруй жилийн өмнө нэгэнт эхэлсэнийг харуулах бөгөөд хүний нэн эртнээс нутагласан бүс нутгийн нэг нь Монгол орон болохын гэрч болно.

Монгол орны нутгаас олдсон доод палеолитын үеийн хамгийн эртний дурсгал нь Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг Уран хайрхан уулын орчмын Нарийн голын хөндийгөөс олдсон бүлэг дурсгалууд билээ. Эндээс палеолитын доод, дунд, дээд үеүдэд холбогдох 47 бууц, суурин илрүүлэн олсон.

Эдгээрийн 12 нь палеолитын доод үед холбогдохоос гадна 4 нь дархны газар байжээ хэмээн үзэж болмоор байгаа билээ. Өгүүлэн бүхий дархны газруудын дотроос хамгийн сонирхолтой бөгөөд эртнийх нь "Нарийн гол-17Б" бууц юм. Эндээс саарал ногоон өнгийн, бүдүүн ширхэгтэй цахиурын төрлийн чулуугаар хийгдэж, байгалийн хүчтэй элэгдэлд орсоны шинж бүхий 212 чулуун эдлэлүүд олдсон. Тэдгээрийн гадаргуу нь нэн эртний шинжтэй болохыг судлаачид онцлон анхаарч үзжээ. Эдгээр чулуун эдлэлийн цуглуулгын дотор цохилтын нэг талбайтай, цуулалтын хэд хэдэн талтай үлдэцүүд нэлээд тоотойгоор олдсон билээ. Ийм төрлийн хажуугаас нь залтас болон ялтас цуулан авч байсны ор бүхий үлдэцүүд ховор байдгийн зэрэгцээ леваллуан төрхийн үлдэцтэй харьцуулахад завсрын шинжтэй байдаг. Хөндлөн огтлолоороо чоно хэлбэрийн гилбэр зэвсэг олдсон нь нэн сонирхолтой.

Сүүлийн үед хийгдсэн харьцуулсан судалгааны ажлын явцад энэхүү суурингийн чулуун эдлэлүүд нь плейстоцений доод үед буюу 800.000 жилийн тэртээд хамаарч болох бүрэн боломжтой юм.

Монгол орны нутгаас олдсон доод палеолитын үеийн хамгийн том дурсгал нь хуучин чулуун зэвсгийн доод үед хамаарах олон соёлт давхарга бүхий Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутагт орших Цагаан агуй юм.

Цагаан агуй

Энэхүү агуйн 11-р давхаргын доод хэсгээс авсан хоёр дээжинд хийсэн эртний соронзоншлын туйл тогтоох шинжилгээний дүнд уг давхарга нь Матуямын он цаг (730 мянган)-тай давхцаж байгааг тодорхойлжээ.

Ярх уулын хуучин чулуун зэвсгийн бууцны зарим олдвор

Монгол орны нутгаас олдсон дараагийн томоохон дурсгал нь Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Ярх уулын дэргэдээс олдсон доод палеолитын үеийн суурин юм. Энэ нь одоогоос 300 мянга орчим жилийн өмнөх үед холбогдох чулуун зэвсгийн дархны газар бөгөөд хасын хольцтой шаргал өнгийн цахиурын төрлийн чулуугаар хийсэн олон төрлийн зэвсэг байгаагийн дотор чулуун эдлэл хийх бэлдэц чулуунаас цуулсан залтсууд, хөндлөн огтлолоор гурвалжин хэлбэрийн хатуу хутган цуулдас, цохилтын нэг ба хоёр талбайт үлдэц, хянгар, хусуурын төрлийн зүйлс олон байгаагаас хамгийн сонирхолтой нь гилбэр ба үзүүр мэсэн зэвсгүүд юм. Эдгээр нь хийсэн арга барил болон бусад бүхий л шинжээрээ Өмнөд Ази, Европ, Африкийн доод палеолитын ашеллийн хэмээх үед өргөн тархсан гилбэр ба үзүүр мэсэн зэвсгүүдтэй ижил байна. Уг гилбэр зэвсгүүд нь нэлээд баргилдуу, хоёр хажуугийн хавтгай талыг ялтаслан цуулж зассанаас гадна ирэн талыг хоёр талаас нь ээлжлэн цохиж гаргасан зэрэг нь европын гилбэртэй адил долгио иртэй болжээ.

Хоёр талаас нь зассан нөгөө үзүүр мэсэн зэвсгүүд нь европын доод палеолитын микок гэгдэх дурсгалуудтай адилавтар бөгөөд

Гилбир
(Өмнөговь аймгийн Булган сумын Цахиуртын хөндий)

гилбэр зэвсгээ бодвол арай нимгэн, хавтгайдуу хэмжээгээр бага болно.

Монгол орны палеолитын эхэн үеийн дотоод хөгжлийг харуулах Ярхын дурсгалын нэг онцлог нь энэхүү гилбэр ба үзүүр мэсэн зэвсэг үйлдэж эзэмшигчид нь өрнө зүгийн доод палеолитын үеийн хүний нэг адил чулууг засаж, түүгээр хоёр талаас нь янзалж ирлэсэн зэвсэг хийх өөрийн тогтсон арга барилтай байсан юм.

Монгол орны нутгаас олдсон ашеллийн үеийн дараагийн томоохон суурин нь Өмнөговь аймгийн хамгийн урд зах, улсын хилийн ойролцоо орших Оцон Мааньтын чулуун зэвсгийн суурин юм. Оцон Мааньтын чулуун зэвсгийн эдлэлүүдийг хар саарал өнгийн чулуугаар хийжээ.

Оцон мааньтын чулуун зэвсгийн суурингийн олдвор

Оцон Мааньтаас олдсон дугуйдуу хэлбэрийн үлдэц, гонзгойдуу үлдэцүүд нь их эртний шинжтэй бөгөөд тийм хэлбэрийн үлдэц Европ, Өмнөд Ази, Африкт доод палеолитоос дунд палеолитэд шилжих шилжилтийн үед элбэг тохиолддог юм. Гонзгойдуу хэлбэрийн ялтсаас маш нямбай зөөлөн цохилтоор товгор артай тэгш ирмэгтэй урт зууван гурвалжин ялтас цуулж авдаг байжээ. Энэ нь тус улсын нутаг дэвсгэрт амьдарч байсан эртний дархчууд бие биетэйгээ харилцан хамааралгүйгээр ашеллийн үед шилжсэн болохыг нь харуулж байна.

Монгол орны нутгаас олдсон палеолитын үеийн томоохон дурсгалуудын нэг нь Өвөрхангай аймгийн Богд, Өмнөговь аймгийн Булган сумдын нутгийн зааг "Цахиуртын хөндий"-н суурин юм. Ойролцоогоор 10.000 $м^2$ талбай эзлэх энэ суурин нь газрын хөрсөн дээрээ хуучин чулуун зэвсгийн доод шатнаас эхлэн шинэ чулуун зэвсгийн үеийн эхэн үеийг хамарсан хэдэн зуун мянган дурсгалыг агуулдаг. Он цагийн хувьд асар өргөн үеийг хамарсан дурсгал бүхий ийм газар Монгол, Төв Ази тэдийгүй дэлхийд урьд өмнө тохиолдож байсангүй. Эл сууринг 1995 онд Монгол-Орос-Америкийн хамтарсан "Монголын чулуун зэвсгийн үе" төслийн хээрийн шинжилгээний ажлын үеэр хийгдсэн хайгуулын явцад анх олж илрүүлсэн юм.

Цахиуртын хөндийн хуучин чулуун зэвсгийн үеийн суурин нь Говийн Алтайн нурууны зүүн-өмнөд төгсгөлийн төв хэсэгт буюу Арц богд, Гурвансайханы нуруудын дундах нам дор газарт орших газар зүйн хувьд элсэн манхан, дов, гүвээ, жалга, гуу, гүн ангал зэрэгцэн оршсон нэлээд сонирхолтой тогтоц билээ.

Эртний хүн хөдөлмөрийн зэвсгээ хийхэд энэ хөндийн цахиурын төрлийн чулуулгийг ашиглаж байсан бололтой шинж тэмдэг илт ажиглагдана. Энэ нь эндэхийн өнгөн хөрсөн дээрхи чулуулаг ямарваа нэгэн байдлаар хүний гараар анхдагч хагаралд орсон байгаагаар нотлогдож байна. Чулуун зэвсгийн дурсгалуудын хадгалагдан үлдсэн байдлыг байгалийн элэгдэлд орсон хэмжээгээр нь хүчтэй, дунд, сулавтар элэгдэлд орсон гэж гурав ангилан үзэж болно.

Цахиуртын хөндийн энэхүү суурин газрыг дурсгал агуулж буй байдлаар чулуун зэвсгийн үеийн "дарханы газар" хэмээн үзвэл хуучин чулуун зэвсгийн доод шатнаас дунд чулуун зэвсгийн сүүл, шинэ чулуун зэвсгийн түрүү үе хүртэлх хугацааны чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга технологийг бүхэлд нь судалж болох юм.

Дунд палеолитын үе (МЭӨ 100.000-40.000 жил)

Доод палеолитоос дунд палеолитод шилжих үе нь дөрөвдөгч галав (антропогени)-т дэлхий нийтийн хэмжээнд гарсан томоохон өөрчлөлт болох эх газрын мөстлөгийн төгсгөлтэй давхацсан бөгөөд Европ, Ази, Умард Америкийн ихэнх хэсэг мөсөн хучлагатай болжээ.

Дөрөвдөгч галавын цаг агаарын энэхүү өөрчлөлт нь амьтан ургамлын аймагт зохих нөлөө үзүүлжээ. Галавын эхэн үед сээр нуруугүй бараг бүх амьтан одоогийн хэлбэр төрхөө олсон бол сээр нуруутан амьтдаас дөрөвдөгч галавын дунд үед дулаан нөхцөлд амьдардаг савагт хирс, эртний заан, агуйн арслан зэрэг амьтад мөхөж, сүүл үед нь хүйтэнд тэсвэртэй арслан заан, сахлаг үстэй хирс, заарт үхэр, цаа буга, туйлын ятуу өргөн тархсанаас гадна далд урт ургамал ихэд дэлгэрсэн байна. Эдгээр амьтдын ясны үлдэгдэл Испани, Итали, Дорнод Сибирь, Умард Америк зэрэг олон газраас олджээ.

Дөрөвдөгч галавын эхэн үеэс өнөөгийн Монгол улсын нутаг эх газрын хуурайдуу уур амьсгалтай, хур тунадасаар харьцангүй бага байсан тул Европ, Умард Америкийг бодвол мөстлөг зөвхөн томоохон уул нуруудаар хязгаарлагдаж байсан гэж судлаачид үздэг. Тухайлбал Монгол Алтай, Хангайн нурууны салбар уулс, Хөвсгөл, Хэнтийн уулсын өндөрлөг хэсгээр мөстлөгийн тодорхой ул мөр үлджээ.

Ийнхүү дунд палеолитын үед цаг агаарын эрс өөрчлөлтийн улмаас ургамал амьтдын аймагт өөрчлөлт гараад зогссонгүй, хүний бие махбодь, оюун ухаан хувьсан өөрчлөгдөж ирсэн бөгөөд энэ үеийн хүнийг Неандерталь төрхийн хэмээн Германы нутгаас анх олдсон газрынх нь нэрээр шинжлэх ухаанд нэрлэж заншсан.

Дунд палеолитын үндсэн зэвсэг нь таргил үлдэцнээс өргөн залтас цуулан авч түүний ир ирмэгийг нь дахин засаж хийсэн гурвалжин мэс ба хянгар юм. Хурц ирмэгтэй гурвалжин мэсийг хутганы зориулалтаар, нимгэн мэсийг мод, ясанд суулгаж жад маягаар хэрэглэж байснаас гадна хянгарыг арьс шир янзлах, мод, ясан эдлэл хийхэд голчлон ашиглаж байсан байна.

Арц богдын дунд палеолитын үеийн суурингийн олдвор

Үүний зэрэгцээ гурвалжин залтас, өргөн урт ялтасыг ирлэж бяцхан мэс буюу аж ахуйн олон үйлд хэрэглэж болох бусад зэвсэг хийх болсон.

Монгол орны нутаг дэвсгэрээс дунд палеолитын үеийн бууц суурин, дархны газрууд Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Орхон I, Орхон VII (9,10-р давхрага), Богд сумын нутаг Арц богд, Баянхонгор аймгийн Богд сумын нутаг Аргалант I, Орог нуур I, II, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оцон Мааньт, Баян-Өлгий аймгийн Алтан цөгц сумын нутаг Алтан цөгц, Олон нуур I, II, Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойд Цэнхэрийн гол I, II, III, Баралгийн гол I, II зэрэг томоохон дурсгалууд хамаарна.

Палеолитын дунд үе (мустье)-д холбогдох хамгийн эртний олдвор бүхий суурин нь Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын нутаг Олон нуур-1, Ховд аймгийн Манхан сумын нутагт орших Баралгийн гол-1 юм. Энэ үед Монгол нутагт чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн хоёр үндсэн арга зонхилж байсан гэж үздэг бөгөөд энэ нь леваллуан ба шүдэлсэн мустьен үйлдвэрлэлийн арга юм.

Леваллуан үйлдвэрлэлийн аргыг илэрхийлж байгаа томоохон дурсгал нь Орог нуур 1, 2-р суурин юм. Эндээс жинхэнэ мустье маягийн гурван талт үлдэц, леваллуа аргаар цуулалт хийсэн шовхдуу үлдэц, өргөн урт ялтас, баргил дугуй үлдэц зэрэг чулуун зэвсгийн зүйлс олджээ.

Мустьен (шүдэлсэн) үйлдвэрлэлийн аргаар хийгдсэн олдворууд Орхон VII суурингийн 1-3-р малтлагаас ихээхэн хэмжээгээр олдсон. Энэхүү суурин олон соёлт давхарга бүхий суурин юм.

Орхон VII-суурингийн хамгийн доод давхарга нь мустьен үед буюу 62-58 мянган жилд холбогдох бол, галын őром бүхий дунд үе нь 45-50 мянган жил, бусад дээд талын соёлт давхаргууд нь 40-20 мянган жилд хамаарах нь нэгэнт тогтоогдоод байна.

Монгол орны дунд палеолитын үеийн томоохон дурсгалын нэг нь Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Арц Богдын нурууны зүүн үзүүрт орших дархны газар юм. Энд хэдэн арван мянган жилийн турш эртний хүмүүс суурьшин амьдарч 12 км урт, 8 км өргөн талбайд улаан хасын төрлийн чулуугаар янз бүрийн зэвсэг багаж үйлдэж байжээ.

Арц богдын суурин дархны газар нь нэн эртний хүний чулуугаар зэвсэг багаж хийх арга барил хэрхэн хөгжсөн, түүхий эд материалаа яаж сонгож, ашиглаж байсан зэрэг чулуун зэвсгийн шат дараалсан хөгжлийн шинж төрхийг бүрэн илтгэн харуулж чадахуйц гайхамшигт дурсгал юм.

Түүнчлэн Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Рашаан хадны суурингийн малтлагаас дунд палеолитын үед өргөн тархсан дугуй үлдэц, тэгш өнцөгт ба гадаад төрхөөрөө шовхдуу маягийн үлдцүүд, уртлаг цуулдас, ялтас, хянгар зэрэг эдлэлээс гадна жинхэнэ мустье төрхийн суурь хэсгийг нь сайтар тэгшлэж зассан, цохилтын талбай нь налуу, ялтас цуулах зориулалт бүхий үлдцүүд хэд хэд олдсон юм.

Рашаан хадны суурингийн зэвсгийн суурингийн зарим олдвор

Мөн энэ үед холбогдох томоохон дурсгал нь Өмнөговь аймгийн нутаг, улсын хилийн ойролцоох Оцон-Мааньтын бууц юм. Эндээс олдсон зэвсгийн зүйлс дотроос дугуй ба гонзгойдуу хэлбэрийн үлдэц нь хамгийн эртний шинжтэй

бөгөөд Европ, Өмнөд Ази, Африкт дунд палеолитын үед элбэг тохиолддог. Гонзгойдуу хэлбэрийн үлдэцнээс маш нямбай зөөлөн цохилтоор товгор артай, тэгш ирмэгтэй, урт зууван гурвалжин ялтас цуулж авдаг байжээ. Ийм ялтаснууд Оцон-Мааньтын бууцнаас олон тоогоор олдсон байна. Дээрх үлдэц, ялтас нь Европ, Африкт ашелийн үед үүсч мустьен үед хөгжлийнхөө дээд цэгт хүрсэн леваллуан хэмээгдэх чулуун зэвсэг хийдэг арга техникээр хийгдсэн байна.

сүүл, дээд палеолитын эхэн үед Монгол Алтай, Сибирийн бүс нутагт түгээмэл дэлгэрсэн гэж үздэг юм.

Дунд палеолитын үед чулуун зэвсгээс гадна түүнтэй холбогдсон өдөр тутмын үйл ажиллагаанд том амьтдын ясыг бага зэрэг засаж зэвсэг хийх, модон саваанытүзүүрийг галд түлж хатууруулан жадны оронд хэрэглэх, том бөөрөнхий чулууг дүүгүүр болгон ашиглах явдал байжээ.

Дунд палеолитын үед гал гаргаж хэрэглэж сурсан явдал нь энэ үеийн хүний хөгжилд хамгийн чухал түлхэц болсон бөгөөд галыг

Баралгийн гол-I-ийн дунд палеолитын үеийн зарим олдвор

Ховд аймгийн Манхан сумын нутагт Алтайн нурууны ар биеэс Хойт, Урд, Дунд гурван Цэнхэрийн гол эх авч урсах ба тэрхүү Гурван голын бэлчир орчимд дунд палеолитын үеийн чулуун зэвсгүүд элбэг байдаг. Чулуун эдлэлийн дотор бэлдэц, үлдэц, цуулдас нилээд хувийг эзэлж байгаа нь энд анхан шатны боловсруулалт хийж байсныг харуулж байгаа юм. Эндээс янз бүрийн хэлбэр хэмжээтэй цуулдасыг ашиглаж хийсэн хусуур зэвсэг, ирэлсэн ялтас болон бусад зэвсгийн шинж чанартай олдворууд олдсон нь мустьен үеийн үйлдвэрлэлийн онцлогийг бүрэн илэрхийлж байна. Мөн Ховд аймгийн Алтай сумын нутагт орших Баралгийн гол-1 суурин нь дунд палеолитын үед холбогдох чухал дурсгалын тоонд орно. Энд чулууг хагалж төрөл бүрийн зэвсэг үйлдэж байсны ул мөр тодорхой үлдсэн бөгөөд леваллуа маягийн залтас, ялтас цуулсан үлдэц, хурц мэс, хусуурууд, өвөрмөц хэлбэрийн зэвсгүүд нилээд олджээ. Ер нь чулуун зэвсэг үйлдвэрлэлийн "леваллаун" арга нь дунд палеолитын

механик аргаар гаргаж чадах болсон чухам энэ үеэс хүйсээр хөдөлмөрлөх ялгаа улам эрчимтэй болж үр хүүхдээ асрах, ургамлын үр үндэс түүх зэрэг гэр зуурын ажлыг эрхэлж байсан эмэгтэйчүүдэд гал голомтоо сахих шинэ үүрэг нэмэгджээ.

Галын ачаар хүн оромж суућаа дулаацуулах, гэрэлтүүлэх, араатан амьтдыг айлгаж түүнээс биеэ хамгаалах, ан амьтдыг бүслэн хөөж авлахдаа гал хэрэглэх болсон нь ангийн нэг төрөл зэвсэг болсон төдийгүй уураг, өөх тос элбэгтэй том амьтдын махыг галд ямар нэг хэмжээгээр болгож идэх болсон нь хүний бие бялдрын өсөлтийг түргэтгэж, амьдралын бүхий л үйл ажиллагааг дээшлүүлэхэд чухал түлхэц болсонд оршино.

Цаг агаар нэгэнт сэрүүн болсон тул байгалийн бэлэн оромж агуй хонгил буюу хадны нөмрийг нар салхи, бороо хурын уснаас хамгаалах чулуун хана босгох, ан гөрөөсний арьс ширээр онгорхой цоорхойг битүүлэх зэрэг хаалт хашлага хийх, суућны шаланд өвс хагд, амьтны арьс дэвсэх мэтээр засаж янзлан орогнох болсон байна.

Дээд палеолитын үе (МЭӨ 40 000 -15 000 жил) Дээд палеолитын үе нь дэлхий нийтийг хамарсан мөстлөгийн эцсийн шатанд холбогдоно. Тухайн үед хур тунадас эрс багассны улмаас тус орны томоохон уул нуруудаар, дунд палеолитын үед тогтсон мөсөн хучлага тал хөндий рүү бууж одоогийн Онон, Хэрлэн, Туул, Сэлэнгэ, Орхон зэрэг их гол мөрнүүд усаар улам арвижин орчин үеийн урсгалын горимтой болсон гэж үздэг байна.

Цаг агаар хуурайшин, эх газрын уур амьсгалтай болсон энэхүү нөхцөлд арслан заан, хирс зэрэг урьдын том амьтдын зэрэгцээ зэрлэг адуу, үхэр, буга, янгир, аргал угалз, бөхөн, цагаан үнэг, тэмээн хяруул зэрэг амьтад хөршлөн амьдарч байсан нь палеонтологийн судалгаагаар тогтоогдсон. Эдгээр амьтдын ясны үлдэгдэл Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг Бугантын голын баруун эрэг, мөн аймгийн Ингэттолгой, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын сав, Төв аймгийн Жаргалант сумын нутаг Хар Ямаат уул, түүнчлэн Улаанбаатарын ойролцоо, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Хөвсгөл зэрэг аймгуудын нутгаас олджээ.

Энэ үеийн хүний үйл амьдралын ул мөр болох чулуун зэвсгийн зүйлс манай орны өнцөг булан бүрд түгээмэл байдаг бөгөөд тухайлбал Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Мойлтын ам, Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Рашаан хад, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг Их Булган, Улаанбаатар хотын ойролцоох Сонгино уул, Буянт ухаа, Архангай аймгийн Цэцэрлэг хотын орчим, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын сав Дөрөлж 1, 2, Баян-Өлгий, Ховд аймгийн нутаг Монгол Алтайн нурууны салбар Ховд-14, Баяннуур-13, Манхан-5, Бугат-2, Алтай-1 түүнчлэн Орхон, Сэлэнгэ, Туул, Онон, Хэрлэн зэрэг томоохон гол мөрнүүдийн ай сав аар олон арван бууц суурин, дархны газрууд илэрсэн юм.

Дээд палеолитын эхэн үеийн нэг онцгой чухал хүчин зүйл бол хүний бие бялдарт гарсан чанарын том өөрчлөлт юм. Хүний гавлын яс томорч, дух өндөржиж ирсэн нь мичин хүний морфологийн үлдэц олох хөмсөгний ясны товгорыг

арилгаж, хэл ярианы аппарат өөрчлөгдсөнтэй холбогдон эрүүний яс одоогийнхтой адил болж орчин үеийн хүн бий болжээ.

Энэ үед чулуун зэвсгийг шинэ арга барилаар хийдэг болсон. Ингэхдээ мустьен үеийн дугариг таргил үлдэцээс гурвалжин хэлбэрийн болхи залтас хэлтэлж авдаг байсан бол гонзгой хэлбэрийн үлдэцээс нимгэн урт хутган ялтас тал бүрээс нь уртааш нь цуулж түүнийхээ ирмэгийг нэг ба хоёр талаас нь дахин холтчин засаж хурц ир гаргадаг болсон байна. Чулууг цуулах ба сэтлэн ирлэх болсон нь тэр үед чулуун зэвсэг хийх үйл ажиллагаанд гарсан нэг ёсны шинэ оньсон арга байжээ.

Дунд палеолитын үед хэрэглэж байсан чулуун зэвсэг бүрмөсөн шахагдаж гараагүйгээр үл барам тэдгээрийг улам боловсронгуй хийх болсоноос гадна эсгүүр, цоолтуур, үзүүр мэс, тал дугариг үзүүр хусууранцар, жижиг сүх, ангийн цохиурт жад шинээр бий болж, хянгар, хутга зэрэг бусад зэвсгийн төрөл олширч чанар нь урьдаас эрс сайжирчээ. Огтлох, цоолох, зүсэх зэрэг үйлдэлд зориулсан хөнгөн багаж зэвсэг энэ үед мод ба ясан бариултай болсон байна.

Палеолитын дээд шатанд хүн ийнхүү олон төрлийн зэвсэг багаж хийж, эзэмших болсон нь түүний амь зуух үндсэн сурвалж ан агналтыг улам боловсронгуй болгож, тодорхой газарт удаан хугацаагаар оршин суух боломжтой болжээ. Үүний жишээ нь палеолитоос мезолитын үеийг дуустал ойролцоогоор 20 гаруй мянган жил хүн тасралтгүй оршин сууж байсан олон соёлт давхарга бүхий Мойлтын ам, Рашаан хадны суурингууд юм.

Мойлтын амны суурин нь Монгол улсын төдийгүй, Төв Азийн хэмжээнд онц сонирхолтойд тооцогддог бөгөөд түүхийн урт удаан хугацааны турш хүн амьдран сууж байсныг гэрчлэх хэдэн мянган чулуун багаж, зэвсгийн зүйлс илрэн гарсан юм. Уг суурингийн соёлт давхаргын зузаан нь 1,5-2 м бөгөөд дээд палеолитын түрүү үеэс эхлэн мезолит ба неолитын эхэн үеийг дэс дараалан хамарсан дөрвөн соёлт давхаргатай юм.

Малтлагын явцад тухайн үеийн хүний хөдөлмөрийн үйл ажиллагааны ахиц дэвшлийг тодорхой харуулсан олон зуун чулуун эдлэлийн зүйлс, үлдэц, хугадас маягийн цавчих зэвсэг, хянгар, хусуур, цоолтуур, хутга, үзүүр мэс зэргээс гадна ирлэж зассан, засаагүй олон тооны залтас, ялтас олдсон.

Хусуур
(Рашаан хад)

Хэдийгээр зэвсгийн дийлэнх хувийг хайрган чулуугаар хийсэн боловч леваллуа маягийн хоёр талбайт үлдцийг тохируулан засаж улмаар цохих талбайг цуулах уртрагтай тэгшлэн дээд палеолитын нэг ба хоёр талбайт гонзгой үлдэц болгон хувиргасан байв. Үлдцийг ийнхүү эвтэй засаж ашиглах болсон нь түүнээс ялтас цуулахад хялбар болж, цуулсан ялтас нь зөв талтай, авсаархан, хэрэглэхэд илүү зохицсон эдлэл болон хувирчээ.

Говийн үлдэц
(Рашаан хад)

Монголын дээд палеолитын үеийн соёлт давхрага бүхий томоохон дурсгал болох Рашаан хадны суурин нь Хэнтий аймгийн

Рашаан хад
(Хэнтий аймгийн Батширээт сум)

Зуухын суурингаас олдсон үлдэц
(Баянхонгор аймгийн Баянлиг сум)

Батширээт сумын нутаг, Биндэр уулын зүүн урд хормойд оршино.Энэхүү чулуун зэвсгийн сууринд малтлага хийсэн нийт талбайн хэмжээ 60м² бөгөөд хэдэн удаагийн малтлагаас гарсан олон мянган чулуун зэвсгийн олдворыг боловсруулах явцад палеолитоос эхлэн шат дараалан хөгжсөн үйлдвэрлэлийн үйл явцын шинж төрх, онцлог, нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлох боломжтой болсон юм. Энэ суурингаас олдсон тал саран хэлбэртэй хусуур, гурвалжин мэс зэрэг нь Мойлтын амны палеолитын олон соёлт давхарга бүхий суурингаас олддог зэвсгүүдтэй хэлбэр төрх, хэмжээ, хийсэн арга барил, бүхий л талаараа ижил байгааг судлаачид тогтоосон юм.

Рашаан хадны суурин нь бүхэлдээ мустьен дунд үеэс мезолитын сүүл үе хүртэл чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн дэвшингүй аажим хөгжлийг тодорхой харуулдаг бөгөөд тухайлбал, малтлагын хамгийн доод давхрагаас харьцангуй томоохон залтас, нэг ба хоёр талт леваллуа маягийн үлдэц, дугуй үлдэц, үзүүр мэс, баргил тууш ялтас зэрэг дунд палеолитын зэвсэг олдсон бол I, II давхрагад дээд палеолитын үеийн бүхий л үйлдвэрлэлийн аргыг харуулах олдворууд хамгийн олон тоотой байжээ.

Эдгээрээс гадна дээд палеолитын үеийн томоохон дурсгалуудын тоонд Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Орхон-1, Орхон-VII (1-8-р давхрага), Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг Их Булган (Туйн гол-У) зэрэг суурин дархны газрууд зүй ёсоор орно. Эдгээрт явуулсан малтлага судалгаа болон хөрснөөс авсан дээжинд хийсэн лабораторийн шинжилгээ нь Монгол орны палеолитын үеийн дурсгалуудын он цагийн хамаарлыг тодруулахад чухал ач холбогдолтой болсон юм.

Орхон-1-ийн хөрсний 4-5-р давхаргаас авсан дээжинд хийсэн лабораторийн шинжилгээгээр эдгээр давхаргын он цаг нь 34400±600, 38600±800 жилийн өмнөх үед холбогдох нь тогтоогдсон байна.

Үүний дараагийн үед холбогдох нь Туйн голын хөндийн дурсгал бөгөөд он цаг нь 35-28 мянган жилийн хооронд юм. Сүүлийн жилүүдэд умард Монголын бүс нутгаас анх удаа соёлт давхрага бүхий томоохон суурин илрүүлэн судалж байгаа нь Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хантай багийн нутаг Эг, Сэлэнгийн бэлчирийн ойролцоо орших Дөрөлж 1, 2 юм. Малтлагаас гарсан зарим дээжинд хийсэн лабораторийн шинжилгээний дүнд энэхүү суурин нь 29.910±310, 29.540±390 жилийн өмнөх үед хамаарч байна.

Дээд палеолитын эцэст дэлхий нийтийн хэмжээнд гарсан нэг томоохон үйл явц бол орчин үеийн гол гурван арьстны ялгаа тогтсон явдал юм.

Хожуу палеолитын эхэн буюу геологийн үечлэлээр дээд плейстоцены хоёрдугаар хагаст мичин хүнээс зарчмын ялгаа бүхий орчин үеийн хүн буй болсноор, хүн амын өсөлт эрс нэмэгдэж, урьд өмнө зэлүүд байсан Европын умард хэсэг, Умард Америк зэрэгт шилжин суух бололцоог олгожээ. Ийнхүү шинэ газар орныг эрчимтэй эзэмшиж эхэлсэн нь европ, негр, монгол төрхийн гурван үндсэн арьстны ялгаа гарахад газарзүйн орчны хувьд шийдвэрлэх хүчин зүйл болж орчин үеийн арьстны ялгаа бүхий төвүүдтэй тохирох болсон байна.

Мезолитын үе (15000-8000 жил). Чулуун зэвсгийн дараагийн үеийг мезолит гэх ба тэр нь палеолитоос неолит буюу шинэ чулуун зэвсгийн үед шилжих шилжилтийн үе болно.

Энэ үед Умард Ази, Өрнөд ба Дорнод Европод түрж орсон их мөстлөгийн үе нэгэнт дуусаж цаг агаар эрс зөөлөрч Умард Азийн их ойт бүс, Төв Азийн байгаль газар зүйн байдал, амьтан ургамлын аймаг орчин үеийн төрхийг олсон байна.

Байгаль газар зүйн байдал өөрчлөгдөхийн зэрэгцээ чулуун зэвсэг хийх арга барил цаашид улам сайжирч дээд палеолитын үеийн зэвсгийн хамт ур хийц сайтай бичил чулуун зэвсэг хийх явдал зонхилох болжээ. Бага хэмжээний үлдцээс нарийн жижиг ялтас цуулан авч хажуу талыг нь зориуд ирлэн мод ясаар хийсэн ишинд түүнийг суулгаж бэхэлсэн зуулга зэвсэг, ялтас ба ялтсан залтсаар хийсэн хусуур, хутган ялтсаар хийсэн үзүүр мэс, сумны ялтсан зэв хэрэглэх болсон байна.

Мезолитын үед хүний эд, оюуны соёл, аж ахуйд өмнөх үеэс чанарын шинэ өөрчлөлт гарч энэ үеийн хүн байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг эзэмшихээс гадна газар тариалан, мал аж ахуй буюу үйлдвэрлэх аж ахуйд дэвшин орох эх суурийг тавьсан байна. Тухайлбал, энэ үед гарсан нэг онцлог шинж нь дээр дурдсан зүймэл зэвсгээс гадна нум сумыг анх удаа зохиосон явдал болно.

Дорнод аймгийн Халхгол сумын Хэрээ уул, Чойбалсан хотын эрэг Хэрлэн голын баруун эрэг, Өвөрхангай аймгийн Мойлтын ам (I үе), Хэнтий аймгийн Рашаан хад (II-III үе), Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших Чихэн агуй, Өмнөговь аймгийн Булган сумын Баруун, Зүүн хайрхан уул, Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дулааны говь болон Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар аймгийн зарим газраас мезолитын үеийн урьд өмнө мэдэгдээгүй дурсгалыг илрүүлэн судалжээ.

Эдгээрийн дотроос Чихэн агуйн дурсгалыг Монгол-Орос-Америкийн чулуун зэвсэг судлаачид 1997-2000 онд малтан шинжилж чухал үр дүнд хүрсэн юм. Агуй нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын төвөөс хойш 30 км-т, Баян-Өндөр сумын нутагт оршино. Агуйн ам нь зүүн өмнө зүг хандсан бөгөөд өдрийн ихэнх хугацаанд нарны гэрэл сайн тусах ба үүд рүүгээ налуу. Урт нь 9,5 м, өргөн нь 5 м, өндөр нь 2 м, харьцангуй том биш боловч уулын өвөр наран талд орших, дэргэдээ булагтай, ан амьтан шахаж агнах, хадан ганганд ойр орших хүн амьдрахад туйлын тохиромжтой нөхцөл бүхий агуй юм. Эл агуйг малтан судлах явцад ихээхэн хэмжээний чулуун зэвсгийн зүйл, урт удаан хугацаанд гал түлж байсан ором, амьтны яс болон ургамлын үлдэгдэл бүхий хүний амьдралын ул мөрийг хадгалсан дөрвөн соёлт давхарга илэрсэн.

Эдгээр давхаргаас анхдагч болон хоёр дахь шатны боловсруулалт хийгдсэн олон төрлийн хэдэн мянган чулуун зэвсгийн дурсгал олдсон юм. Тэдгээр нь өөрийн өвөрмөц онцлог, ангиллын хувьд бичил ялтсан зэвсгийн төрөлд хамаарах бөгөөд ер нь ялтсан зэвсэг энэ суурингийн гол шинж байжээ. Цөөн тооны хусууруудыг хийхэд том хэмжээний ялтас болон ялтсан залтсыг ашигласнаас бусад тохиолдолд жижиг ялтсуудаар зэвсгээ хийж байжээ. Мөн энд

амьдарч байсан хүмүүс зуулга ир бүхий зэвсэг хийхийг гол зорилгоо болгож, элсэрхэг цахиурт чулуу, хас, маныг өргөн ашиглаж байсан аж.

Дөрөвдүгээр соёлт давхаргын чулуун дэвсгийн зүйлс нь хийц байдал, хэмжээ, материалын хувьд эрс ялгаатай бөгөөд он цагийн хувьд мустьен дээд үед холбогдох



Зуулга ир

Хутга
(Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Чихэн агуй)

боломжтой гэж судлаачид үзжээ. Энэ нь Орог нуурын суурингийн олдвор болон "Орхон-1" суурингийн доод үеийн дурсгалтай (38,600±800 жилээр он цагийг нь тогтоосон) ихэд төстэй байжээ.

Эхний гурван давхаргын он цагийг гал голомтны үлдэгдлээс авсан нүүрсэнд хийсэн радио нүүрстөрөгчийн шинжилгээгээр тогтооход нэгдүгээр давхарга нь 8.055±155, хоёрдугаар нь 8.940±100, гуравдугаар нь 11.160±160 жилээр баттай тогтоогдсон нь эрдэм шинжилгээний их ач холбогдолтой юм.

Учир нь урьд өмнө Монгол нутгаас олдож байсан эндэхтэй адил арга технологиор үйлдсэн шаантган үлдэц, ялтсан зуулга иртэй зэвсэг бүхий нээлттэй суурингуудын дурсгалыг он цагийнх нь хувьд шинэ чулуун зэвсгийн үед хамааруулан үзэж, 6-7 мянган жилээс хэтрүүлэхгүйгээр тогтоож байв. Харин Чихэн агуйд хийсэн малтлага судалгааны дүнд Монгол оронд бичил чулуун зэвсгийн үйлдвэрлэл хуучин чулуун зэвсгийн дээд үеийн төгсгөлд бий болжээ гэж үзэх боломжийг олгосон билээ.



Сумын зэв
(Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Чихэн агуй)

Мезолитын соёлын бүхий л үндсэн үзүүлэлтийг илэрхийлсэн өөр нэгэн том дурсгал нь цэвэр мезолитын бууц болох Хэрээ уулын суурин болно.

Хэрээ уулын бууцыг малтахад хүрэн ба цайвар хүрэн цахиураар хийсэн говийн үлдэц, түүнийг хийхэд зориулсан бэлдэц, ялтас ба ялтсан залтсаар хийсэн гөвгөр иртэй дөрвөлжиндүү хусуур, хавтгай хар занарлаг чулуугаар хийж нэг талыг нь ирлэсэн нутгийн өвөрмөц эдлэл болох хутга (хянгар), хутган ялтасаар хийсэн булангийн ба шөвгөн эсгүүр, үлдэц чулууг засах үед хагарсан хажуу ба хотгор цуулдас, захыг нь сэлтлэн ирлэсэн буюу ирлээгүй гурвалжин хэлбэрийн том жижиг хутган ялтас, говийн үлдэцнээс цуулсан бичил ялтас, хугадас маягийн эдлэлүүд болон сайтар засаж янзалбал үлдэц болж болохоор хайрга ба цахиурлаг хугадас маягийн чулуу зэрэг зэвсгийн зүйлс олджээ.

Эдгээрээс огт өөр зэвсгийн зүйл Хэрлэн голын IX бууцнаас илэрсэн нь малтлагын явцад саарал, цайвар шар, ногоон өнгийн ялтсаар хийсэн нилээд тооны сумны зэв гарсан билээ. Ийм төрлийн сумны ялтсан зэв Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Гүрмийн нуур, Батхаан уул, Дорноговь аймгийн Дулааны говь зэрэг газраас олдсон байна.

Дээр өгүүлсэн суурин газруудын нэг нь, Дорноговийн Эрдэнэ сумын төвөөс баруун урагш 50 км-д Дулааны говь хэмээх элсэн довцгууд, загийн шугуйтай хотгор газар билээ. Эргэн тойрон уулаар хүрээлэгдсэн энэ газар бол эртний нуурын сав билээ. Энэхүү дурсгалыг судалсаны үр дүнд археологи, палеонтологийн үлдэгдэл олдворыг агуулсан хөрсний 12 соёлт давхаргыг илрүүлэн олсон байна.

Дулааны говиос олдсон чулуун зэвсгийн дотроос хамгийн олон тоотойгоор олдсон нь сумны зэв билээ. Эндээс нийтдээ сумын 20 ширхэг зэв олдсоныг хэлбэр төрхийнх нь хувь ангилбал, ялтсан зууван урт зэв зургаа, навчин хэлбэрийн зэв нэг, гурвалжин хэлбэрийн зэв 13 ширхэг болж байна.

Дээрх бууц суурингуудаас олдсон төрөл бүрийн эдлэлийн дотроос дээд палеолитын эцсээс буй болж, неолитын түрүү үеийг хүртэл хэрэглэгдэж байсан говийн үлдэц нь Монголын мезолитын үеийн хүн амын угсаатны өвөрмөц тодорхой илэрхийлэл болж байгаа юм. Говийн үлдцийн тархсан газар нутгийг үзэхэд тэр нь баруун зүгт Дорнод Памир, умар зүг Якут, дорно зүгт Япон хүртэл тархсан байна

Ийнхүү Монголын мезолитын соёлын үндсэн гол хэрэглэгдэхүүн, зэр зэвсэг дурдсан газар нутагт тархсан нь Төв Азийн гүнээс Сибирь, Берингийн хоолойг дамжин Умард Америк, улмаар Японы арлууд хүртэл хүн нүүдэллэн очиж нутагласан буюу угсаатны шилжилт явагдсаны гэрч юм.

Энэ үед зуулга эдлэл тогтонги нэг хэвийн болж, нум сум гарч, модон эдлэл хийх тусгай зориулалттай зэвсэг бий болсон нь агнуурын ажлыг ихэд хөнгөлж хүмүүс палеолитын үеийнхтэй адил үйлдвэрлэлийн хамтлагт нэгдэхээ бараг больж зэрлэг үр тариаг гар хадуураар хадаж ан амьтдыг нум сумаар агнадаг цөөн тооны хамтлагаар солигдсон байна. Харин мезолитын төгсгөлийн шатанд ан агнуурын шинэ хэлбэр болох загасчлах ажил буй болж сэрээ, дэгээ, амьтны сүүлээр сүлжиж хийсэн тороор загас агнан суурин амьдралд шилжих болсонтой холбогдон хүмүүс дахин олон хүн бүхий овог болон нэгдэх болжээ.

Неолитын үе (8000-3000 жил)

Олон мянган жил үргэлжилсэн чулуун зэвсгийн эцсийн томоохон үе бол неолит юм.

Ойролцоогоор 8.000 жилийн тэртээгээс неолитын үе эхэлдэг боловч түүний төгсгөл нь газар бүр харилцан адилгүй байдаг ба төмөрлөг зэвсэгт шилжих хүртэлх үеийг хамарсан энэ үеийн хүний аж ахуйн гол шинж нь ан гөрөө хийх, ургамлын үр үндэс түүх зэрэг байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг шууд хэрэглэх нь эрс хязгаарлагдаж мезолитын үед эхлэлийн төдий байсан үйлдвэрлэхүй аж ахуй ба өөрөөр хэлбэл газар тариалан, мал аж ахуй эрхлэх ажилд шилжсэн явдал юм.

Неолитын үед чулуугаар зэвсэг хийх дадлага туршлага, арга ухаан өмнөх үеэс улам илүү хөгжиж ахуй амьдралын аливаа хэрэгцээнд олон төрөл эдлэлийг маш нарийн хийцтэй үйлдэх болжээ. Ялтасыг шовгор үлдэцний бүх талаас уртааш нь цуулах болсон тул тэр нь зөв талт урт хутган хэлбэртэй болсон байна.

Дээд палеолит, мезолитын үед хөгжсөн сэлтлэн ирлэх арга барилаар хийж урьд өмнө өргөн хэрэглэж байсан хутга, эсгүүр, хянгар, хусуур, шөвөг, сумны зэв зэрэг зэвсэг хэвээр байсан боловч тэдгээрийн хэлбэр, төрөл олширч ур хийц нь эрс сайжран ир ирмэг нь хурц болжээ. Үүний зэрэгцээ жижиг дугариг бичил хусуур, тэгш суурьтай сумны зэв, хутга ба жадны зуулга ир, дугариг ба зууван хэлбэртэй зээрэнцэг маягийн эдлэл, сүх, ооль, цүүц зэрэг зэвсгийн зүйлс шинээр бий болсон байна. Дээрх зэвсгүүдийг гол төлөв хаш, хас, мана болон өнгө бүрийн цахиураар, сүх зэрэг том эдлэлийг ногоовтор буюу саарал өнгийн цахиурлаг чулуу, гүрмэн занараар хийх болсон нь тэдгээрийг бөх хатуу чанартай болгожээ.

Чулуун эдлэл хийхэд гарсан энэ үеийн нэг гол онцлог нь чулууг сайтар зүлгэж билүүдэх, өнгөлөх, өрөмдөж цоолох аргыг сэдэж олсонд оршино. Ийм аргаар гол төлөв сүх, ооль хийдэг байсан бөгөөд Монгол улсын нутгаас (Говь-Алтай, Баянхонгор, Дорнод) олдсон сүхний дундаж урт нь 11-12 см, өргөн нь 5-6 см, зузаан нь 2,5-3 см байна.

Неолитын үеийн хүний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний бас нэг чухал шинэ ололт нь шавар ваар, сав бүтээн хийж хэрэглэх болсон явдал юм. Тус орны неолитын бууц сууринаас шавар сав суулганы үлдэгдэл нилээд олддог бөгөөд тэр нь өндгөн ёроолтой, гол төлөв улбар шар гадаргуутай, гадаргуу нь нэлдээ сүлжмэл хээтэй байна.

Дээр дурдсан төрөл бүрийн зэвсэг, ваар сав бүхий тэр үеийн хүний бууц суурин Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Хэнтий зэрэг ер нь тус орны ихэнх нутгаас олджээ. Эдгээрээс Баян-Өлгий аймгийн Сагсайн голын сав дагууд орших 12 суурин газар, Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутагт орших Зуух, Өмнөговь аймгийн Булган сумын Баянзаг, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт орших Устай, Бургастай, Дорнод аймгийн Тамсагбулагийн дурсгалуудыг бусдаас төлөөлүүлэн авч үзэж болно.

Монгол орны нутгаас шинэ чулуун зэвсгийн үед холбогдох хэдэн зуун бууц, суурин, дархны газар илрүүлэн олсоны дотор үлэмж хэмжээний баялаг олдвортойн нэг нь Зуухын неолитын суурин юм. Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутагт орших энэ суурин нь сумын төвөөс Өвөрхангай аймгийн Богд сумын төв орох замын дагуу тааралдах Хатан суудалын уулнаас 25 км зайтай газарт оршино.

Энд хийсэн судалгааны ажлын үр дүнд эндээс археологийн дурсгал бүхий дөрвөн суурин газар олдсоны нэг нь хуучин чулуун зэвсгийн дээд үеийн, хоёр нь шинэ чулуун зэвсгийн үеийн, нэг нь хүрэл зэвсгийн түрүү үеийн дурсгалтай байв.

Дугуй чулуун хүрээт хиргисүүр
(Дархан-Уул аймаг)

Шинэ чулуун зэвсгийн дурсгал бүхий хэсгээс нийтдээ 8567 ширхэг чулуун зэвсгийн төрөл бүрийн дурсгалууд (үлдэц, ялтас, залтас, хусуур хутга, хутган ялтас, сумны зэв, жадны үзүүр, тариа цайруулах зорилгоор ашигладаг самбар чулуу, нухуур чулуу зэрэг), амьтдын 22 ширхэг яс, цөөн тооны цацагт хяруулын өндөгний хальс, шавар ваар савны хагархай олджээ. Эдгээр чулуун зэвсгүүдийг улаан болон шар өнгийн хас, мана, цахиур, хайрга, элсэнцэр чулуугаар хийжээ.

Зуухын сууринаас олдсон нэгэн сонирхолтой олдвор бол байгалийн ямарваа нэгэн элэгдэлд ороогүй урьд өмнө Монголын нутагт тааралдаж байгаагүй, цагаан саарал өнгийн цахиурлаг чулуугаар хийсэн том хэмжээний жадны үзүүр юм (173х77х33 мм). Ерөнхий хэлбэр нь навчин хэлбэрийн сумны зэвийг санагдуулам гүдгэр гадаргатай ямарваа нэгэн ир суулгаагүй суурьтай энэ жадны үзүүр нь хоёр талдаа, хоёр захаасаа сайтар ирлэгдсэн байна. Ирний төрөл нь шаталсан тэгш бус хэмт ир болно. Харин нэг сонирхолтой нь жадны үзүүрийн хоёр талын төвийн гүдгэр талбайнууд огт хөндөгдөөгүй байгалийнхаа төрхөөр хадгалагдан үлджээ.

Баянзагийн суурин
(Өмнөговь аймгийн Булган сум)

Өмнөговь аймгийн Булган сумын нутагт орших Баянзагийн суурин нь Монгол нутгаас олдсон хамгийн анхны чулуун зэвсгийн дурсгалт газруудын нэг юм. Энд оршин суугчид неолитын үеийн гол шинж бүхий чулуун зэвсэг хийх бүх арга барилыг бүрэн эзэмшсэн байна. Тухайлбал, чулууг билүүдэн засаж чаддаг байсан ба гонзгой үлдэцнээс хутганцар нимгэн ялтас цуулан авч зуулга ир, нарийн ирлэсэн сумны зэв, төрөл бүрийн хэмжээ хэлбэрийн хусуур хийдэг байжээ. Ан гөрөө хийх гол зэвсэг нь нум сум байв. Гоёл чимэглэлийн зүйлээс тэмээн хяруулын өндөгний хальсаар хийсэн сувс мөн олдсон байна. Шавар ваар сав нь өндгөн хэлбэртэй, шувтан ёроолтой, гадаргыг улаан будгаар будаж, заримдаа улаан дэвсгэр дээр хар будгаар хээ угалз тавих болжээ. Мөн анхны болхи тариалан эрхлэж байсны баримт болох үр тариа цайруулах хавтгай самбар чулуу, нухуур, нүдүүр элбэг олдож буй нь неолитын сүүл үед тэнд оршин суугчдын аж ахуйд чанарын том өөрчлөлт гарсаны гэрч юм.

Монгол орны нутгаас олдсон неолитын үеийн өөр нэгэн томоохон суурин нь Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт орших Устай Бургастайн суурин юм. Эндээс нийт 62 үлдэц, 3 бэлдэц болон цөөн тооны зэвсгийн зүйлс, 1200 залтас, 464 ялтас олдсон. Зөвхөн эндээс найман төрлийн үлдэц олдсон явдал нь уг суурин газарт оршин амьдарч байсан хүмүүс нь нэлээд хөгжингүй шатанд шилжсэн болохыг харуулж байгаа юм.

Дорнод аймгийн Тамсагбулагт неолитын үеийн хүний булш, сууц бүхий суурингуудыг нээж судалсан нь манай орны төдийгүй Төв, Умард Азийн чулуун зэвсгийн судлалд онцгой байр суурь эзлэх дурсгал болно.

Эндээс гол төлөв цахиур, хас, бөсөл, заримдаа манаар хийсэн олон талт шовгордуу үлдэц, үлдэц-хусуур, эсгүүр, хутга, ховилтой яс ба модонд суулгах зуулга ир, цоолтуур буюу шөвөг, хусуур, сайтар зүлгэж өнгөлсөн сүх, хоёр талаас нь зассан сумны зэв элбэг олдсон байна. Чулуун зэвсгээс гадна ясаар сумны зэв, жад, ховилтой ховилгүй хутга зэргийг хийж байжээ. Ваар сав нь нэлээд зузаан, хөх өнгөтэй, гадна талд нь гүн нарийн хос зураас хээтэй байна. Ийм сав суулганы зүйл Төв, Умард, Дорнод Азийн мөн үеийн дурсгалуудад огт үгүй учир нутгийн хийц бололтой. Ан агнах, загасчлахын хамт эгэл тариалан эрхлэх болсон нь хүн амын зарим хэсгийг суурьшмал амьдралд шилжихэд чухал түлхэц болжээ. Үүний тодорхой гэрч нь Тамсагбулагийн суурин бөгөөд тэнд хэдэн арван сууц бүхий овгийн «хороолол» буй болсон явдал юм. Энд 5 сууц малтсаны нэг нь эвдэрч хөндөгдөөгүй бүрэн бүтэн байсан ба урт нь 7 м 60 см, өргөн нь 5 м 60 см буюу нийт 42,5 $м^2$ талбайтай байв. Ийм сууцыг төв хэсэг болон хаягаар нь эргэн тойрон модон багана суулгаж, багануудын оройг дээвэртэй нь холбон бэхлэж бүслүүрдэн холбосон байдаг байна. Шал нь тэгшхэн, дөрвөлжин хэлбэртэй. Сууцанд үүд байгаагүй нь дээвэрт нүх гаргаж тусгайлан бэлдсэн шатаар орж гарч байсан бололтой.

Төрөл бүрийн чулуу, ясан эдлэлээс гадна сууцыг малтахад гарсан хамгийн сонин олдвор нь хүний булш юм. Тэрхүү хүнийг сууцны хойд хананы шалны дор хоёр хөлийг нь өвдгөөр нь дээш эвхэж, гарыг нь унжуулан суугаагаар оршуулжээ. Нэгэнт суугаа байдлаар биеийг нь эвхэснээс толгой нь духаараа хоёр өвдгөө түшсэн байна. МЭӨ IV-III мянган жилд холбогдох 15 орчим насны, 1,20 м өндөр, монгол төрхийн эмэгтэй хүнийг оршуулахдаа 200 гаруй сувсан зүүлт, 20 гаруй бугын соёогоор хийсэн зүүлт, бог малын чөмөгний ясан гэртэй, дотроо 1 ширхэг нарийн хурц үзүүртэй ясан зүү, 20 см урт, 2,5 см өргөн ясан хутга хоёрыг (нэг нь хажуу ирмэгээрээ зуулга ир суулгах нарийхан ховилтой) тус тус дагалдуулан тавьжээ.

Ер нь неолитын үед хүмүүс суурьшин амьдарч байсны өөр нэгэн баталгаа нь Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос зүүн тийш 17 км-т Хэрлэн голын урд биед орших Баруун Өлзийтийн хоёр буудал, суурин газрууд юм. Эхний суурин нь Баруун Өлзийт руу шахаж тогтсон өндөр дэнж дээрээс олдсон. Эндээс 30 орчим үлдэц, олон тооны хусуур, хутган ялтас, хянгар, ойл, хусуур (хашаар хийсэн) зэвсэг гарсан байна. Хоёр дахь суурин нь эхнийхээс нэг км орчим зайтай орших ба тэндээс 30м- 40м х300м-400м талбайгаас олон тооны чулуун зэвсэг олдсоны дотор үлдэцүүд, хутган ялтас, ялтсан залтсаар хийсэн зэвсгүүд, булан хусуур, баргил залтсаар хийсэн хянгар, ирлэсэн ялтсан зуулга ир, түүнчлэн үр тариа цайруулдаг самбар чулуу олдсон байна. Баруун Өлзийтөөс зүүн тийш, голын дагууд гурван хэсэг газраас неолитын олдворууд олдсоны дотор зууван дугуй буюу дугуй хэлбэрийн гал голомтын ор 0,5-1,2 м голчтой 0,1-0,4 м зузаантай бөгөөд заримдаа зургаа хүртлэх голомт нэг дороос хамт хоорондоо ойрхон зайтай байрласан байжээ. Голомтуудын дэргэдээс ихэвчлэн үлдэц, хусуур, ойл-хусуур зэвсэг, булан хусуур, залтас ялтас, хутган залтас, том, жижиг амьтдын яс, олдсон байна. Баруун Өлзийтийн суурингаас хэд хэдэн гал голомтын ор хамт нэг дороос олдсон нь

сонирхолтой боловч сууцны ор мөр илэрч олдоогүй тул нэг томоохон сууцанд хэд хэдэн гал голомт байв уу, эсвэл олон жижиг сууц тус бүрдээ нэг нэг гал голомттой байв уу гэдэг бас сонирхолтой юм. Неолитын үед тус оронд оршин суугчид нас барсан хүнээ булж оршуулдаг ба оршуулгын зан үйл нь өвөрмөц байжээ.

Дээр дурдсан Тамсагбулаг дахь сууцны шалан доороос олдсон хүний булшнаас гадна түүний ойролцоо бас нэг булш, Дорнод аймгийн Булган сумын Норовлин уул, Чойбалсан хотын эсрэг талд Хэрлэнгийн баруун эрэг дэх Мөргөцөг, Зүүн Өлзийт уулын хооронд, мөн тэнд орших Баруун Өлзийтууланд тус бүр нэжгээд булш олдсоноос бүхий л тохиолдолд хүнийг цооног нүхэнд суугаа байдлаар атийлган оршуулсан байв.

Баянзагийн суурингийн олдвор

Эдгээр булшнаас нэлээд баялаг олдвортой нь Дорнод аймгийн Булган сумын нутагт орших Норовлингийн булш юм. 1,6 м-ийн гүнд өвдгөөр нь дээш эвхэж суугаа байдлаар оршуулсан монгол төрхийн хүний бүх биеийн дагуу ялангуяа толгой хавьд нь 1,5-2 мм диаметр бүхий 3000 орчим сувс байсан нь уг хүний дээл малгайд хадаж байсан бололтой.Мөн оршуулганд хүний нүүрний дүрс бүхий цайвар өнгийн чулуугаар хийсэн 22,5 см урт чулуун онго, 43 см урт хоёр талдаа зуулга чулуун иртэй ясан чинжаал хутга, гахай, хүдрийн соёогоор хийсэн ясан зүүлт, гахай, зарааны дүрстэй танан чимэг, дугуй ба сар хэлбэрийн гоёл чимэглэлийн зүйл, 10,5 см урт захыг нь ирлээгүй хос хутган ялтас, хоёр захыг нь сэлтлэн ирлэж зассан 6ш жижиг хутган ялтас зэргийг дагалдуулан тавьсан байжээ. Норовлингийн булшны оршуулгын зан үйлтэй холбоотой бас нэг сонирхолтой зүйл бол хүнээ оршуулахын өмнө ухсан нүхэнд болон хүнээ оршуулсаны дараа түүний дээр их хэмжээний улаан зосон будаг цацсан явдал юм. Ийнхүү неолитын үеийн оршуулганд зос хийсэн тохиолдол Дорнод аймгийн Зүүн Өлзийт уулын булшинд мөн ажиглагдсан бөгөөд энэ нь зосоор цусыг төлөөлүүлсэн ба хүний хойд насны тухай ойлголттой шууд холбоотой болно.

Энеолитын үе

Хүмүүс эртнээс өөрсдийн хэрэглэж байсан багаж зэвсгийг улам сайжруулан хөгжүүлсээр ирсэн бөгөөд неолитын сүүл үеэс зэсээр багаж зэвсэг хийх болжээ. Зэс зэвсэг үйлдвэрлэлд нэвтэрсэн энэхүү зурвас үеийг хүн төрөлхтний түүхэнд энеолитын буюу зэс чулууны үе хэмээн нэрлэдэг.

Монгол оронд оршин суугчид Евразийн нүүдэлчдийн нэгэн адил ойролцоогоор МЭӨ III мянган жилийн эхэнд энеолитын үеийг дамжсан.

Манай орны Өмнөговь, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Баянхонгор, Төв зэрэг аймгийн нутгаас эртний зэс малтаж байсан уурхай, ухмалууд олджээ. Үүний зэрэгцээ Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой, Зэлт зэрэг газруудад буй эрт үед зэс малтаж байсан ухмалуудын орчмоос зэсийн хүдэр ухаж авахдаа ашиглаж байсан голоороо гурив ховил бүхий чулуун муна, алх, бахим нүдүүр олноор олдсон нь тухайн үеийн зэсийн хүдэр олборлолтын дүр зургийг нэхэн сэргээхэд ач холбогдол болохуйц эд өлгийн зүйлс билээ.

Ховд аймгийн Манхан сумын нутгаас энеолитын үед холбогдох аргаль угалзны толгойг маш урнаар сийлсэн том жижиг хоёр чулуун эдлэл олдсон нь тухайн үеийн урлагийн ховор сонин дурсгал юм.

Энеолитын үед холбогдох хадны зургууд дүрслэл, дүрсэлсэн арга барилын хувьд өвөрмөц байдаг. Энэ үед холбогдох зургийн тоонд Архангай аймгийн нутаг Чулуут голын хөндийн хаданд дүрслэгдсэн зургууд багтана.

Хүрэл зэвсгийн үе

МЭӨ II мянган жилийн тэртээгээс Евразийн хээр тал нутагт хүрлээр хийсэн эдлэл өргөн тархаж эхэлжээ.

Ойролцоогор МЭӨ II мянган жилийн тэртээ зэсийг цагаан тугалга, хар тугалгатай хольж хайлуулан хүрэл гэдэг шинэ холимог төмөрлөгийг гарган авч үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүрэл зэвсгийн үе эхэлсэн. Хүрэл зэвсэгт шилжсэн үе нь эдийн соёлд гарсан хувьсгал байгаад зогсоогүй аж ахуй, нийгмийн харилцаанд ч үндсэн өөрчлөлт гаргасан юм.

Хүрэл зэвсгийн үйлдвэрлэл явуулж байсны дурсгал болох хүдэр авдаг уурхай, хүрэл хайлуулдаг байсан зуух, хүрэл эдлэл цутгадаг хэв манай орны нутгаас нэлээд тоогоор олддог нь Монгол орон нь Төв Ази дахь хүрлийн үеийн төвүүдийн нэг байсныг нотлох баримт болж байгаа юм.

Тухайн үед ихэвчлэн хүхэржсэн хүдрийг гарган авч боловсруулдаг байжээ. Хүдрийн нөөцөөсөө

шалттаалан уурхайн хэлбэр хэмжээ нь харилцан адилгүй байв. Хүдрийг юуны түрүүн алхаар цохиж жижиглэж авдаг байсан бололтой. Хагалагдахгүй хатуу газрынхыг гал түлж халаагаад, усаар хөргөж хагалж авдаг байжээ.

Ийнхүү төмөрлөг зэвсэг үйлдвэрлэлд нэвтэрсэн нь тухайн үеийн хүмүүсийн амьдрал төдийгүй нийгмийн хөгжилд гарсан түүхэн үйл явц байлаа.

Хүзүүний чимэг
(Өвөрхангай аймгийн Богд сумын дөрвөлжин булш)

Хүний яс ил гарсан байдал
(Хэнтий аймгийн Батширээт сум)

Хүрэл сух, загас
(Өмнөговь аймгийн Булган сум, Төгрөг ширээ)

Дөрвөлжин булш. Дөрвөлжин булш нь Монголын хүрэл зэвсгийн үеийн археологийн томоохон дурсгалын нэг юм. Дөрвөлжин булш жижиг толгодын орой шил, даваа хөтөл дээр ганц нэг, хоёр гурваараа тохиолдохоос гадна тэднийг гол төлөв уулын энгэр, бэл, аманд мөн тэгш талын дунд нэг дор арваас хэдэн арав хүртэл тоотой хэсэг бүлгээр нь барьж байгуулсан байдаг. Дөрвөлжин булш дорнод Монголын талаас Алтайн уулс, Байгал нуураас говь хүртэл өргөн тархсан археологийн томоохон дурсгал юм. Энэхүү булшийг үлдээгсэдийг бүхэл бүтэн нэгдмэл соёлд хамруулан авч үзсэн нь ч байдаг.

Дөрвөлжин булшийг оршуулгын зан үйл, ёслолын зориулалтаар нь а)оршуулагын байгууламж, б)тахилгын байгууламж гэж ерөнхийд нь хоёр ангилан авч үздэг.

Дөрвөлжин булшийг тусгай хэмжээтэй, тогтож заншсан хэлбэрээр тодорхой дэс дараатай нарийн зохион байгуулалттай үйлддэг байжээ.

Дөрвөлжин булшны зохион байгуулалтыг авч үзвэл, хайрцаглан хийсэн нимгэн хавтгай чулуун авсанд хүнээ оршуулж, том зузаан хавтгай чулуунуудаар дарж таглан шороогоор булаад дээр нь хавтгай чулууг босгон эгнүүлэн дөрвөлжлөн зоож, дотор гадна хаяаг нь арай багавтар чулуугаар дарж бэхэлсэн байдаг. Хүнийхээ толгойг ихэвчлэн нар мандах зүг буюу зүүн зүг харуулан цэх байдалтайгаар дээш харуулан 50-150 см-ийн гүнд оршуулж, зарим цахиур чулуун зэвсгийн зүйл, хүрэл хутга, сумны зэв, хүрэл товч, товруу, морь малын дүрстэй хүрэл чимэг, хагас товгор хүрэл чимгүүд, модоор сийлсэн шувууны толгой, үсний алтан сүлбээр, шавар ваар, зэс, хүрэл хайлуулдаг чулуун шанага зэрэг олон төрлийн эд өлгийн зүйлс, малын толгой, чөмөг, дал болон бусад зүйлийг дагалдуулан тавьсан байдаг. Гол төлөв хүнийхээ толгой дор дэр болгон хавтгай чулуу тавьдаг байжээ. Дөрвөлжин булшны гаднах ерөнхий хэмжээ дунджаар 1,5 х 2,5 м-ээс 2,5 х 4,5 м байдаг ч Монгол орны төвийн бүс нутагт энэхүү дунджаас харьцангүй том булш ч тааралддаг байна.

Дөрвөлжин булшны дараас ил гарсан байдал
(Хэнтий аймгийн Батширээт сум)

Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшнаас илрэн олдож буй эд өлгийн зүйлсийг ерөнхийд нь зэр зэвсэг, байлдааны хэрэглэл, аж ахуй, хөдөлмөрийн багаж хэрэглэл, гоёл чимэглэлийн зүйлс хэмээн төрөлжүүлэн хуваан авч үздэг.

Дөрвөлжин булш нь Монгол улсын нутаг болон Өвөр Байгалын нутагт голчлон тархсан дурсгал бөгөөд Манжуур, Өвөрмонгол, Шинжааны нутагт бас тодорхой хэмжээгээр мэдэгдэж байна. Дөрвөлжин булшийг малтан шинжлэх ажлыг манай улсын нутагт Төв аймгийн Хэрлэн, Туул голын сав газар, Өвөрхангай аймгийн Орхоны хөндий, Богд сумын Тэвш уул, Дундговь аймгийн өмнөд хэсэг, Хэнтий аймгийн Хэрлэн, Онон, Хурх голын сав, Булган аймгийн Эгийн голын сав, Дорнод Монголын тэгш тал болох Сүхбаатар аймгийн Мөнххаан, Эрдэнэцагаан сумдын нутаг, Дорнот аймгийн Баяндун, Цагаан овоо, Сэргэлэн, Гурван загал, Баян-Уул, Дашбалбар сумдын нутагт явуулж, 500 гаруй дөрвөлжин булшийг малтан судалсан.

Сүүлийн жилүүдэд явуулсан археологийн малтлагаас гарсан, хүрэл зэвсгийн үеийн зэр зэвсэг, байлдааны хэрэгсэлийн талаар шинэ мэдээлэл өгсөн олдворууд бол Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын 2 дөрвөлжин булшийг малтахад олдсон хоёр хүрэл дуулга юм.

Монгол орноос их хэмжээгээр олддог зэр зэвсгийн төрлийн нэг сумны хүрэл зэв дөрвөлжин булшны малтлагаас цөөвтөр тоотой олдсон ба харин түүврээр олон тоотой олджээ. Зэвийг хоёр ба гурван хянгат, хавтгай онгит, шилбэт гэх мэтээр хэлбэр төрхөөр нь ангилан үздэг. Хүрэл зэвүүд нь олон төрөл байдаг бөгөөд хол, ойрын, хөнгөн, хүнд, шархдуулах зэрэг ялгаатай байжээ. Мөн түүнчлэн хүрэл зэвсгийн төгсгөл үед хүрэл толгойтой төмөр шилбэтэй зэвийг хийх болсон байна. Үүнээс гадна мөн ясаар хийсэн зэвүүд дөрвөлжин булшнаас олддог байна.

Монгол орны хүрлийн үеийн гоёл чимэглэлийн зүйлсийн олдвор дотроос хамгийн сонин содон олдвор бол Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш ууланд малтсан дөрвөн хажуу хана нь дотогшоо хүнхэр дөрвөлжин булшнаас гарсан аргалийн толгойн хэлбэртэй хоёр алтан сүлбээр юм. Энэхүү хоёр сүлбээр ур хийцийн хувьд тун ойролцоо боловч нэгэнд нь 6, нөгөөд нь 8 шигтгээний нуух байна.

Дөрвөлжин булшнаас олон тоотойгоор олдсон эдлэл бол янз бүрийн хэлбэр хэмжээ дүрслэлтэй хүрэл товруунууд юм. Хувцасны болон бүсний чимэг болох хүрэл товруунууд нь хийгдсэн байдлаараа чимэглэлтэй, чимэглэлгүй хэмээн хоёр хуваагддаг.

Чимэглэлтэй товруунуудад голчлон ан амьтан, буга, баавгай, морь, чоно, шувуу зэргийг дүрсэлсэн байхаас гадна төрөл бүрийн хээ угалзыг чимэг болгон дүрсэлж байжээ.

Дүрслэлийн хоёр дахь аргыг нь амьтныг загварчлан дүрслэх арга хэмээн нэрлэдэг. Евразийн хээр талын бүс нутагт хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн дүрслэх урлагт ***амьтныг загварчлан дүрслэх арга*** өргөн тархжээ.

Дөрвөлжин булштай төстэй боловч хүний оршуулгагүй, тахилга ёслолын байгууламж тааралддаг. Тахилгын энэхүү байгууламж нь олон тоогоороо байгаа дөрвөлжин булшны ойролцоо голчлон байдаг байна. Энэхүү байгууламжид адуу малыг хойлоглон тавьсны зэрэгцээ зарим эд өлгийн зүйлс тухайлбал ваар сав суулга зэргийг тавьдаг байжээ. Хойлго үйлдсэн малын толгойн тавьсан чиг нь дөрвөлжин булшинд нас барагчтай хамт тавьсан малын толгойн чигтэй адил байдаг байна.

Хиргисүүр. Хиргисүүр нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн өвөрмөц дурсгал юм. Манай орны нутаг дэвсгэрт хиргисүүр маш өргөн хэмжээгээр тархсан байдаг бөгөөд харин бусад булшуудыг бодвол харьцангуй бага малтан судлагдсан ажээ.

Хиргисүүрийг үйлдэгчид нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн нүүдэлчид байсан гэдэг нь түүний дөрвөлжин булш, буган хөшөөтэй нэг дор нэгэн цогцолбор болон оршин байдгаас илэрхий.

Хиргисүүр
(Булган аймгийн Бүрэгхангай сум)

Манай орны нутаг дэвсгэр дээр байгаа хиргисүүрүүд нь гаднах хэлбэр төрх зохион байгуулалтын хувьд янз бүр байдаг. Судлаачид Монгол орны төв болон баруун бүс нутагт даруй гуч орчим төрлийн хиргисүүр байгааг тэмдэглэсэн байна. Гэхдээ энэ бүгдэд зохион байгуулалтын нэгдмэл арга ажиглагддаг. Энэ нь юуны түрүүнд бүх хиргисүүрүүд том хэмжээний дугуй овгор чулуун дараастай байдагт оршино. Уг дараасаа тойруулан чулуу эгнүүлэн зоож дугуй, дөрвөлжин хүрээ татсан байдаг бөгөөд энэ хүрээний дотор болон гадна талаар чулуу овоолон шигтгэсэн олон тооны дөрвөлжин, дугуй жижиг байгууламжуудыг байгуулсан байдаг. Зарим хиргисүүрүүдийн хүрээ нь давхар байх ч тохиолдол байдаг.

2001 онд Монгол-Бельгийн хамтарсан археологийн экспедици Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг Харбухын голын баруун эрэгт нэгэн хиргисүүрийг малтан шинжилсэн юм. Энэ хиргисүүр нь гадна талаараа 25x27 м хэмжээтэй дөрвөлжин хүрээтэй. 9 м голдоч бүхий овоолсон чулуун дараастай байсан бөгөөд гадна хүрээний зүүн талд хоёр эгнээ 8 чулуун дагуул байгууламжтай. Зүүн талд мөн 5 дагуул байгууламжтай байлаа. Зүүн талын дагуул байгууламжуудыг малтан үзэхэд 30-50 см-ийн гүнд нэг нэг адууны толгойг хиргисүүр луу харуулан тавьсан байна. Хиргисүүрийг малтах явцад дараас чулууны дороос газар ухалгүй өнгөн хөрсөн дээр тавьж дээрээс нь чулуугаар дарсан хүний оршуулга илэрчээ. Хүнээ толгойг нь баруун тийш хандуулан тэнэгэр байдалтай дээш харуулан хэвтүүлж оршуулсан байна. Хүнээ дагалдуулан тавьсан ямар нэгэн эд өлгийн зүйлс олдоогүй боловч дараас чулуут цэвэрлэх явцад чулууны завсар хоорондоос гайхалтай сайн хадгалагдсан хүрэл ооль олдсон билээ.

Буган хөшөө. Буган хөшөө бол Монгол болон Төв Азийн нутаг дэвсгэр дээр хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед оршин сууж байсан овог аймгийн түүх соёлын гайхамшигтай дурсгалын нэг билээ.

Гонзгой урт чулууг засч, гурав зааглан, оройн хэсэгт нар сар, доогуур нь олон эгнээ хонхор, эх биеийг ороолгон төв хэсэгт сүрэг бугыг загварчилсан байдалтайгаар ихэд сүрлэг сийлж, бас доогуур нь бүс татан зэр зэвсгийг зүүсэн байдалтай дүрсэлсэн хөшөө чулууг буган хөшөө хэмээн нэрлэдэг.

Баян-Өлгий аймгийн Арал толгойн хадан дахь бугын зураг

Буган хөшөө голдуу 1-4 м гаруй өндөр, 20-50 см зузаан, 30-80 см өргөн хэмжээтэй бөгөөд түүнийг үйлдэхдээ цоолбор, сийлбэр, уран баримлын аргуудыг хэрэглэсэн гэж хэлж болно. Буган хөшөөг хэлбэр төрхийн хувьд үндсэн гурван төрөлд хуваан авч үздэг. Үүнд:

хөшөөний бүснээс зүүж хутга, билүү, чинжаал хутга, жад, нум, сум, саадаг, байлдааны зээтүү, сүх, бамбай зэрэг зэр зэвсгийн зүйлсийг дүрслэх бөгөөд тэдний заримыг гоёж чимэн дээр нь хээ зураас, дугуй, дөрвөлжин, хонхортой цохиж гаргасан байдаг.

Хоёр дахь төрлийн буган хөшөө Монгол улсын баруун талын Увс, Хөвсгөл, Ховд, Баян-Өлгий аймгуудын нутагт илүү тархсан байдаг. Тухайлбал, Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын нутаг Дөрөлжийн ам, Цагаан-Уул сумын нутаг Хөшөөт, Архангай аймгийн Их Тамир сумын нутаг Алтансандал уул, Тариат сумын Хурын ам, Ховд аймгийн Дарви сумын нутаг Чулуутын огтрох, Мөнххайрхан сумын Төлөгин ам, Мөст сумын Бодончийн гол, Увс аймгийн Бөхмөрөн сумын Наран бэл, Баадайн ам зэрэг газрууддаас олджээ.

Бичигтийн амны хадны зураг (Баянхонгор аймгийн Баянлиг сум)

Буган чулуун хөшөө

Хөшөөнөө дайчин эрийн зэвсэг болох чинжаал хутга, билүү, байлдааны алх, нум, хоромсого, жад, бамбай, толь дүрслэхээс гадна хөшөөний бүсийг олон төрлийн хээгээр чимсэн байдаг ба мөн бугын дүрсний оронд буюу завсар зайд адуу ирвэс, янгир, зээр зэрэг амьтад хааяа дүрсэлсэн байдаг.

Ази, Европ тивийн хээр талын бүс нутагт хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед өргөн тархсан түүх соёлын гайхамшигт дурсгал болох буган хөшөөг эрдэмтэд 100 орчим жилийн тэртээгээс судалж энэ завсар 700 орчим буган хөшөөг олж илрүүлжээ. Эдгээрээс хамгийн их буюу 550 орчим нь Монгол улсын нутгаас олджээ.

Нэгдүгээрт: Монгол-Өвөрбайгалын бугын загварчилсан дүрст бүхий буган хөшөө

Хоёрдугаарт: Саян-Алтайн амьтны "бодит" дүрст буган хөшөө

Гуравдугаарт: Ази-Европын амьтны дүрсгүй буган хөшөө хэмээн ангилдаг байна.

Эхний төрөлд хамаарах буган хөшөө тооны хувьд хамгийн олон байдаг бөгөөд манай орны Архангай, Өвөрхангай, Завхан, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Төв, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий, Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн нутагт олдоод байгаа боловч гол шигүү тархсан төв нь Хангай, Хэнтийн уулсын орчмын нутаг юм.

Буган хөшөөний нэг талд бугын оронд адууг дүрсэлсэн хөшөө Архангай аймгийн нутаг Алтан сандлаас олдсон. Буган чулуун

Буган хөшөөний гурав дахь, өвөрмөц төрөл болох буга болон амьтдын дүрсгүй, харин нар сар, зэр зэвсэг, бүс зэргийг дүрсэлсэн хөшөө Монгол улсын баруун аймгуудын нутгаар цөөвтөр боловч тархсан байдаг.

Эрдэмтэд Төв Азийн нутагт өргөн тархсан дөрвөлжин булштай, буган хөшөөг он цагийн хувьд холбогдуулан авч үздэг хэдий ч дөрвөлжин булшийг үйлдэхэд буган хөшөөг авч ашигласан тохиолдол элбэг байгаа нь энэ хоёр дурсгалын он цагийн ялгааг харуулах чухал хэрэглэгдэхүүн болно. Тухайлбал, Архангай аймгийн Их Тамир сумын Баянцагаан голын адаг, Алтан сандал уулын бэл, Батцэнгэл сумын Шивэртийн ам, Эрдэнэмандал сумын Хөшөөн тал, Хөвсгөл

аймгийн Бүрэнтогтох сумын Хядагийн эх, Мөрөн хотын орчим Дэлгэр мөрний хөндий, Галт сумын Нүхтийн ам, Булган аймгийн Орхон сумын төв, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Шатар чулуу, Хэнтий аймгийн Дунд Жаргалантын гол зэрэг олон газар буй дөрвөлжин булшны өнцөгт буган хөшөөг босгож байсан төдийгүй, булшны хана болон түүний сийлбэрүүдийг далд ортол булж суулган, бүр хэвтүүлэн ашигласан нь илэрчээ. Булган аймгийн Орхон сумын Баруун могой, Архангай аймгийн Батцэнгэл сумын Хөрөөгийн үзүүр, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Бат-Өлзий сумын нутаг, Баянхонгор аймгийн Жаргалант сумын Бугат зэрэг олон газраас олдсон хүрэл зэвсгийн үеийн хадны зурагт буган хөшөөн дээр бугыг дүрсэлдэгтэй адил амьтныг загварчлан дүрслэх аргын хэд хэдэн барилаар бугыг дүрсэлсэн байгаа нь буган хөшөөний он цагийг урагшлуулан авч үзэх бас нэг чухал хэрэглэгдэхүүн юм.

Буган хөшөөнөө буганаас гадна металл зэр зэвсгийг олонтой дүрсэлсэн байдгаас түүнийг металл зэвсэг үйлдвэрлэлд нэвтэрч, үйлдвэрлэхүй хүчин улам эрчимтэй хөгжсөнөөр, хүй нэгдлийн овгийн байгууллын дотоод зохион байгуулалтад үндсэн өөрчлөлт оруулж, эцгийн эрхт ёс тогтсон тэр үед дайчин эр хүнд зориулан босгосон хөшөө гэж үзэх онолын үндэслэл байна.

Буган хөшөөний гарал үүслийн асуудал нэг мөр шийдэгдээгүй боловч хүрэл зэвсгийн дунд үед Монгол улсын нутагт үүсэн бүтээгдэж цаашид Тува, Байгалийн наад бие нутгаар тархсан нь буган хөшөөний тархалт зэргээс тодорхой харагдаж байна. Түүнчлэн Төв Азийн нутагт 700 орчим буган хөшөө мэдэгдэж байгаагийн 80 орчим хувь нь Монгол улсын нутагт байгаа явдал нь ч үүний баталгаа болох юм.

Буган хөшөө хэмээх гайхамшигт дурсгал анх Монголын төв нутагт хүрэл зэвсгийн дунд үед үүсч төмөр зэвсгийн түрүү гэхэд Монгол нутаг даяар түгэн дэлгэрч цаашдаа одоогийн Тува, Байгал нуурын наад бие хүртэл өргөн тархсан ба улмаар Казахстан, Дундад Ази, Оренбургийн муж, Умарт Кавказ, Эльба мөрний сав хүртэл цөөн тоогоор нэвтэрсэн нүүдэлчдийн дурсгал юм.

Төмөр зэвсгийн түрүү үе

Чандманий соёл. Хүн төрөлхтний дамжин туулж ирсэн чулуун зэвсэг, хүрэл зэвсгийн үеийг бодоход төмөр зэвсгийн үе богино юм. Үнэн хэрэгтээ төмөр одоо хүртэл үйлдвэрлэлийн чухал үндсэн түүхий эд хэвээрээ байна. Төмөр зэвсгийн үйлдвэрлэл дэлхийн орон бүрт харилцан адилгүй өөр өөр хугацаанд тархсан байна.

Монгол нутагт оршин сууж байсан овог аймгууд МЭӨ VII-III зууны үед төмөр зэвсгийн түрүү үеийг дамжин туулсан юм. Энэ үед хүмүүс төмрийн хүдрийг хайлуулах аргыг эзэмшиж төмрөөр хөдөлмөрийн багаж зэвсэг, байлдааны зэр зэвсэг хийх болжээ. Хүрэл зэвсгийг хийдэг зэс, ялангуяа түүний найрлагад ордог цагаан тугалганы орд ховор байдаг бол төмрийн хүдрийн орд тэр тусмаа төмрийн бор хүдрийн орд элбэг тархсан байдаг.

Монгол оронд төмөр зэвсэг үйлдвэрлэлд нэвтрэн, аж ахуйн багаж, байлдааны зэр зэвсгийг хийхэд эхлээд хүрэл төмрийг хослон хэрэглэж байгаад сүүлдээ гол төлөв төмрөөр хийх болсон боловч хүрлээр хийсэн зэвсэг багажийг хэрэгцээнээс бүрэн шахан гаргаж чадаагүй байжээ. Тухайлбал, Өмнөговь аймгийн нутаг Борзонгийн говиос үзүүр талыг хүрлээр, шилбийг төмрөөр цутгаж хийсэн сумын зэв олонтаа олдож байгаа нь эртний хүн төмрийг хайлуулж хэрэглэх болсон төдийгүй мөн хүрлийг хайлан хэрэглэж байсныг харуулж буй дурсгал юм.

Д.Цэвээндорж
С.Уранбилэг

Хүрэл чинжаал, хутга, хөдөлмөрийн багаж зэвсэг

Хүрэл толь

Хүрэл янгир

Тэмээн толгойн дүрстэй хүрэл чимэг

Увс аймгийн Чандмань уулын булшнаас гарсан олдвор

НҮҮДЭЛЧИН МОНГОЛЧУУДЫН ДЭЛХИЙН СОЁЛ ИРГЭНШЛИЙН ХӨГЖИЛД ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

Монгол нутагт найман зуун мянган жилийн тэртээгээс хүн нутаглаж, Мезолитын үед малыг гаршуулан, 6-5 мянган жилийн тэртээгээс мал аж ахуйг амьдрал ахуйн гол тулгуур болгон, улмаар монголчууд өргөн уудам нутагтаа байгаль цаг уурын эргэлт давталтаар нүүдэллэн амьдрах болсон юм.

Энэ үеэс нүүдэлчдийн өвөрмөц соёл үүсэн хөгжиж нүүдлийн иргэншил бүрэлдэн тогтсон билээ.

Нүүдлийн мал аж ахуйн хөдөлгөөнт, тэсвэрт, тогтвортой хөгжил нь байгаль-хүн-малын гурвалсан холбоонд суурилсан амьдрал ахуй, оюун сэтгэлгээ, үйл ажиллагаанаас шууд шалтгаалж ирсэн бөгөөд түүхэн хөгжлийн явцад дэлхийн соёл иргэншлийн хөгжилд нэн ялангуяа суурин соёл иргэншилд түлхэц өгч, иргэншил хоорондын солилцоо, харилцан уялдаа, бие биеэ нөхөн хөгжих үйл явцад эерэг нөлөө үзүүлсэн байна.

Нүүдэлчин Монголчуудын өвөг хүмүүний шилжилт хөдөлгөөний явцад монголжуу төрхтнийг бүрдүүлэн түгээсний дээр соёлын олон төрөл байдал буй болон бүрэлдэхэд төв Азийн нүүдэлчдийн цөм болох хувьдаа түүхэн үүрэг гүйцэтгэсэн юм.

Соёлын тархалтад гол үүрэг гүйцэтгэсэн Африкийн нүүдэлчдийн Европ болон умард

руу чиглэсэн, төв азийн нүүдэлчдийн ойрхи дорнод руу чиглэсэн, хойд хятадын нүүдэлчдийн зүүн хойт ази, австрали руу чиглэсэн нүүдлийн чиглэлийг тус тус зургаас харж болно. Эдгээр 3 гол чиглэлийн нүүдэл шилжилтийн дунд дэлхийн нүүдэлчдийн зонхилох бүлэг болох далайн, тариачин, цаатан, талын нүүдэлчид, тайгын анчид, загасчин нүүдэлчид бүрэлдэн бий болсон.

Өнөөгийн нүүдэлчдийн газар зүйн байрлалыг хүснэгтээр харуулбал дараахь байдалтай байна.

Бүс нутаг	Нүүдлийн соёл иргэншилтэй улсууд	Нийт хүн амд эзлэх нүүдэлчид (%-иар)	Тухайн бүс нутгийн хүн амд эзлэх нийт нүүдэлчдийн тоо
Ази болон далайн орнууд	20	11	20,7
Африк	25	5,9	56,7
Америк	5	0,3	3,4
Евразиаа	5	0,2	-
Европ	5	0,15	-
Нийт	63	1,3	-

Газрын зурагт тэдгээрийн тархалтыг харуулбал:

Нүүдэлчин Монголчуудын дэлхийн соёл иргэншлийн хөгжилд гүйцэтгэсэн үүрэг

Дэлхийн соёл иргэншлийн хөгжил, түүнд Монголчуудын эзлэх хувь жинг дор дурьдсан хүснэгтээс харж болно.

Дэлхийн соёл иргэншлийн товчоон

Соёл иргэншил үүсэн бий болсон цаг үе /МТӨ 1000/	*Иргэншлийн сонгодог эрин /МТ 500 он хүртэл/*	*Иргэншлийн сонгодог хөгжлийн дараах эрин /МЭ 500 МЭ 1200/*	*МТ-ын эхэн үе /1400-1750/*	*Аж үйлдвэржилтийн эрин үе /1750-1914/*	*Барууны соёл иргэншлийн тэлэлтийн үе /1914-1999/*	*Даяарчлал соёл иргэншлийн харилцан зөвшилцлийн эрин үе /2000-/*
-Homo Sapience анх үүссэн -Нохойг гэршүүлсэн -Бусад амьтдыг гэршүүлсэн - Шинэ чулуун зэвсгийн үе -Хойд Хятадын соёл -Ойрхи Дорнодын шинэчлэл, Хүрлийн үеийн бүтээл, хадны сүг зураг - Египедийн соёл иргэншил -Мезоамерикийн соёл иргэншил -Персийн эзэнт гүрэн -Суурин газар тариалан эрхлэлт	-Японы суурьшил -Германы суурьшил -Грекийн хот улсууд -Энэтхэгийн соёл -Хятадын сонгодог соёл -Хятад- Грекийн сонгодог философи -Македоны Александр хаан -Маурын хаант улс -Нарны систем ба усан тээрэм -Цаас ба луужин -Ромын эзэнт гүрэн **-Нүүдэлчдийн соёл** -Хан болон Тан гүрнүүдийн соёл	-Миссиппийн соёл -Толлекийн хаант улс -Математик, одон орны нээлт, ололт -Кушаны эзэнт гүрэн -Киевийн Орос -Хятадын эзэнт гүрэн **-Монголын Эзэнт Гүрэн** -Юань гүрэн -Торгоны зам -Солонос, Хятад, Вьетнам дахь Хятадын соёлын тархалт -Зүүн Европ дахь соёл иргэншлийн хөгжил -Африкийн соёл иргэншил -Баруун Европ дахь шинэ соёл иргэншлийн үүсэл -Мезоамерикийн соёл иргэншил	-Оттоманы эзэнт улс -Хятадын Мин улсын соёл -Колумбийн аялал -Төр улсуудын хөгжил цэцэглэлт -Европын худалдааны шинэчлэл -Европын шинжлэх ухааны хувьсгал -Европ дахь улс төрийн хувьсгал -Британи, Франц, Данийн колоничлал -Орос дахь Петрийн шинэчлэл -Америкийн хувьсгал -Европийн анхны хэвлэх үйлдвэр -Коперникийн нээлт -Латин Америкийн соёл иргэншил - Лалын соёл -Африкийн боолын худалдаа -Ази дахь Европийн соёлын нөлөө -Японы нээлттэй хаалганы бодлого	-Баруун Европын хүн амын өсөлт -Аж үйлдвэрийн хувьсгал -Наполеон ба Францын хувьсгал -Латин Америк дахь тусгаар тогтнолын хөдөлгөөн -Английн боловсролын тэлэлт -Оттоман эзэнт улсын шинэтгэл -Венийн суурьшил -Япон дахь Мейжийн өөрчлөлт -Америк, Баруун Европын хүн амын залуужилт -Худалдааны экспортод тулгуурласан Латин Америкийн эдийн засгийн өсөлт -Оросын аж үйлдвэржилт -Панамын суваг -Улс төрийн шинэчлэлт -Холбооны улсууд -Утга зохиол урлагийн романтизм -Импресионизм -Библийн сургаалийн шинэчлэлт -Боолчлолыг халсан -Дэлхийн I дайн	-Оросын хувьсгал -Хамтралжуулалт -АНУ-ын шинэ хандлага -Дэлхийн II дайн -Атомийн бөмбөгийн нээлт -Маршалын төлөвлөгөө -НҮБ байгуулагдсан -Хятадын коммунист болон соёлын хувьсгал -Варшавийн гэрээ -НАТО, ЕЭЗН -АНУ дахь иргэний эрх чөлөө - Колонийн задрал -Ази, Африк, далайн улс орнуудын тусгаар тогтнол -ЗХУ-ын задрал -Европын эдийн засгийн шинэтгэлийн өргөжилт -Өмнөд Африкийн ардчилалын хөгжил	-Даяарчлалын хөгжил -Олон улсын хамтын ажиллагаа -Мэдээллийн сүлжээ -Екологийн тогтвортой хөгжлийг хангах -Технологийн хувьсгал -Мэдээллийн нийгэм -Мэдлэгийн нийгэм -Үндэсний соёлын бие даасан байдал -Бүс нутгийн интеграци -Соёл иргэншлүүдийн зөвшилцөл -2001 оны 9 сарын 11-нд АНУ-д болсон террорист халдлага

Нүүдэлчин Монголчууд дэлхийн соёл иргэншлийн хөгжилд хоёр их түрэлт хийсэн бөгөөд энэ нь Хүнну гүрэн, Их монгол улс, Монголын эзэнт гүрний хөгжлийн үед хамаарагдана.

Алдарт торгоны замыг хамгаалж, дэлхийн худалдааны сүлжээг өргөжүүлэн хөгжүүлсэн Хүнну гүрэн хятадын Их цагаан хэрэмд тулж байсныг "Иргэншлийн түүх" атласт (ОХУ-д 2000 онд хэвлэгдэн гарсан.)-т дүрслэн үзүүлжээ.

Тэд хятадын баруун хэсгээс төв азийн уулархаг бүсийг хөндлөн туулж Мезопотамийн соёл иргэншилт төвүүдэд хүрч чадсан билээ.

"Торгоны зам" газрын зурагт үзүүлсэн алдарт торгоны зам нь ром, лалын шашинт улс орнууд, баруун европыг хооронд нь холбон түүний дагуу орших ази, африк, арабын шинэ шинэ хотуудыг бий болгож түүнчлэн будда, лал, даос болон христийн шашинт улс үндэстнүүдийн хөгжил цэцэглэлтэд өөрийн хувь нэмрийг оруулсан юм.

Нүүдэлчин Монголчуудын дэлхийн соёл иргэншлийн хөгжилд гүйцэтгэсэн үүрэг



Хүннүчүүдийн үед хэрэглэгдэж байсан хэл хуур, ширмэл ширдэг (уг ширдэгний зургийг "Гоёл чимэглэлийн урлаг" бүлэгт үзүүлсэн) зэрэг нь тэр үеийн нүүдэлчдийн урлаг, соёлын ололтыг харуулдаг билээ. Монгол үндэстэн төгс бүрэлдэн, төрт ёс боловсрон хөгжсөн Их Монгол улсын үеэс дэлхийн иргэншлийн хөгжилд нүүдэлчин монголчууд түүхэн үүрэг гүйцэтгэсэн юм.

Хүннүгийн үеийн хэл хуур
(Төв аймгийн Алтан булаг сум, Морин толгой)

Монголчууд төрийн бичигтэй болж, засаг захиргааны хуваарь тогтож, өөрийн нийслэл хотыг



байгуулсан нь нүүдэлчдийн иргэншсэн улс бүрэлдсэнийг гэрчилнэ.

Их засаг хууль нь Их монгол улсын дээд хууль байсан бөгөөд хаан өргөмжлөх ёс, гадаад улс оронтой харилцах журам, улсын их хуралдай, ард иргэдийн албан үүрэг, дархлах ёс, эр цэрэг, ав хомрого, санхүү, алба гувчуур, эрүү, иргэний хууль, гэр бүл, өвлөх эрхийн тухай тус тус тодорхой зааж өгсөн ажээ.

Хэдийгээр өнөөдрийн бидэнд түүх болон уламжлагдаж ирээгүй боловч Чингис хаан өөрийн улсыг байгуулж төрийн тамгатай болсон нь тодорхой юм. Гүег хаанаас Францын ван, Ромын Пап ламд 1248 онд илгээсэн бичигт үлдсэн тамганы дардсыг үндэслэн "Мөнх тэнгэрийн хүчин дор Их монгол улсын далай хааны зарлиг, Ил бүлхэ бүх иргэнд хүрвээс биширтүгэй, аюутугай" гэсэн дардсыг эрдэмтэд Өгөөдэй хаанаас эхлэн хэрэглэж ирсэн төрийн тамга гэж үздэг билээ.

Их монгол улсын улс төрийн төв-нийслэлийг Хүннү гүрний үеэс нийслэл нь байрлаж байсан Орхоны хөндийд байгуулсан билээ. Чингисхаан "Хорум-а сагуух балгасун" буюу Их Монгол улсын нийслэлийг 1220 онд байгуулсан байна.

Ийнхүү Их монгол улсын үед монголын нүүдэлчдийн төр ёсны сонгодог уламжлалыг авч гэхийн ухаанаар хөгжүүлсэн нь зөвхөн монголчуудын төдийгүй энэхүү төр ёсноос үүдсэн төрийн бодлого үйл ажиллагаа дэлхийн соёл иргэншлийн хөгжилд өөрийн нөлөөгөө үзүүлэхэд хүргэсэн нь дамжигтүй.

Чингис хааны байгуулсан Их Монгол улс иргэншсэн нийгмийн үндсэн гол шаардлагуудтай бүрэн нийцэж байгаа юм. Өөрөөр хэлбэл дэлхийн талыг эзэгнэсэн Монголын эзэнт гүрэн нь орчин үеийн иргэншлийн үндсэн стандарт болох доорх нөхцөлүүдийг бүрэн хангасан байжээ. Үүнд:

-"Иргэншсэн" улс амь нас, нэр төр ба өмч хөрөнгө гэх мэт үндсэн эрх болон ялангуяа гадны хүний аялал жуулчлал, худалдаа арилжаа ба шашин шүтлэгийн эрх чөлөөтэй байдлыг хангах,

-"Иргэншсэн" улс өөрийгөө хамгаалах чадвартай болон төрийн албыг үр ашигтай явуулах зохион байгуулалт бүхий улс төрийн механизмтай байх,

-"Иргэншсэн" улс нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйг, дайнтай холбогдох хуулиудыг оролцуулаад мөрдөх болон тухайн орны хуулийн эрх мэдэлд байгаа гадны иргэн ба өөрсдийн хүмүүсийн эрх зүйн шударга ёсыг хангах хуулиуд нийтлэх дотоодын шүүх, дүрэм журмын тогтолцоог байгуулах,

- "Иргэншсэн" улс байнгын ба зөв зохистой дипломат харилцаа холбоо тогтоож хадгалснаар олон улсын тогтолцооны үүрэг хариуцлагыг биелүүлэх зэрэг юм.



Монголчууд өөрийн эзэнт гүрний нутгийг сүлжлэн морин өртөө байгуулсан тэр үедээ хамгийн шуурхай харилцаа холбооны хэрэгсэл байлаа. Өрнө, дорны худалдаачид, жуулчид, лам хувраг, улс төр, цэргийн хүмүүс тэр өртөөгөөр дамжин нэвтэрч Ази, Европ хоёр тивийн харилцаа Монголын эзэнт гүрний цагт урьд үзэгдээгүйгээр өргөжин идэвхжсэн

юм. Мөн Европын худалдаачид хуурай замын зэрэгцээ бас Персийн боомтоор дамжин Энэтхэг, Хятадад хүрэх, оросын худалдаачид Азовын тэнгисээр дамжин Итали, Газрын дундад тэнгис, Бага Азид нэвтрэх шинэ шинэ усан замууд нээгдсэн байна. Өрнөдийн эд бараа дорнодод дорнын эд таваар өрнөдөд нэвтрэхийн зэрэгцээ бас зоосон болон цаасан мөнгө гүйлгээнд орох нь нэмэгдэн, худалдаа, гар үйлдвэрлэлийн хот, боомтууд бүй болсоор байжээ. Монголын эзэнт гүрэнд худалдаа наймааг чөлөөтэй явуулах бодлого баримталж байсан нь олон соёл хоорондоо шүтэлцэн барилдах, олон үндэстэн ястны харилцаа холбоо идэвхижихэд чухал нөлөө үзүүлжээ. Энэ утгаараа Европ, Ази болон Ойрхи дорнодын ихэнхийг холбож байсан Монголын эзэнт гүрний нутаг дэвсгэр дээрх өртөөний хийгээд худалдааны зам нь тухайн үеийн дэлхийн бөмбөрцгийн зүүн тал дахь олон соёл иргэншлүүдийн хоорондох гүүр болж байв.

Шинэ хоол хүнс, нээлт бүтээлүүд, шинэ үзэл санаа зөвхөн энэ замаар дамжиж байсныг түүх гэрчилнэ. Тэр үеийн Хар Хорум хотод эзэнт гүрний бүх нутгаас ухаантан мэргэд, урлаг боловсролын төлөөлөгчид, дархчуул, гар урчуудыг цуглуулж байлаа.

Францын дорно дахины судлаач Ж.Де.Гинт "Их эргэлтийг үүдэж, тэрхүү эргэлт нь хожим бидний мэдэх бүх эзэнт гүрнээс хамгийн өргөн цараатай эзэнт гүрний байгуулж, хууль цаазны цэцэн мэргэнийг түгээн дэлгэрүүлэхийг эрмэлзэгч ард түмнийг иргэншээгүй хэмээн яаж хэлж болох билээ" гэж бичсэн билээ.

ЮНЕСКО морин хуурыг дэлхийн биет бус соёлын өвд бүртгэжээ.

Дэлхийн боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага ЮНЕСКО-оос дэлхийн соёлын өвд оруулсан нүүдэлчин монголчуудын утга соёлын бүтээлүүдийг үнэлсээр байгаа билээ.



Б.Шарав "Монголын нэг өдөр"

ЮНЕСКО-оос Монголын Нууц Товчоо зохиолыг дэлхийн утга зохиолын хосгүй бүтээл болохыг үнэлсэний дээр Монголын морин хуурыг дэлхийн биет бус соёлын өвд бүртгэсэн. ЮНЕСКО-ийн төв байранд XX зууны Монгол зураач М.Шаравын "Монголын нэг өдөр" бүтээл өнгө ялгаран Монголчуудын нүүдэлчдийн амьдралыг тольдож байдаг билээ.

Б.Энхтүвшин
С.Уранбилэг

МОНГОЛ НУТАГТ БАЙСАН ЭРТНИЙ АЙМАГ, УЛСУУД

МЭӨ III дахь мянган жилийн тэртээгээс Төв Азийн нутагт олон нүүдэлчин овог, аймгууд нутагласаар иржээ. Тэдгээр овог аймгуудыг эртний Хятадын түүх сударт Ди, Жун, Гүй, Ху, Дунху, Хүннү, Юэжчи, Динлин гэх зэргээр тэмдэглэсэн байдаг. Тэдний дунд төр улс, бичиг үсэг хараахан үүсээгүй байсан боловч өөрсдийн өвөрмөц соёлтой нүүдэлчин, малчин, анчин аймгууд байв. Дээрх аймгуудаас хожмын монгол, түрэг, манж-тунгус угсааны олон овог аймгууд салбарлан гарчээ.

МЭӨ III зууны үед Төв Азийн эртний нүүдэлчин аймгуудын нийгэм нь хүй нэгдлийн байгууллын эцсийн шатанд дэвшин гарч, нүүдэлчдийн төр улс, соёл иргэншил үүсэн бүрэлдэх түүхэн цаг үед тулж иржээ.

Хүннү. Хүннү нар бол Монголчуудын эртний удам бөгөөд Төв Азийн түүхэнд гүн ул мөрөө үлдээсэн нүүдэлчин аймаг юм. Хүннү нар нь МЭӨ III зууны үед хүчирхэгжин мандаж, Төв Азийн эртний нүүдэлчин аймгуудын дундаас анх удаа өөрсдийн төр улсыг байгуулсан билээ. МЭӨ 209 онд Хүннү аймгуудын зонхилогч Модун шаньюй гэгч Хүннүгийн 24 аймгийг нэгтгэн захирч, Хүннү улсыг үндэслэн байгуулжээ. Хүннүгийн төрийг барьж агсан хэсэг нь Монголчуудын өвөг учир тэдний байгуулсан төрийг Монголын нүүдэлчдийн анхны төр улс гэж үздэг. Хүннү улсын хаан Модуны өргөө нь Хангайн нуруу, Орхоны хөндийд байжээ. Модуны үед Хүннү улс ихэд хүчирхэгжин Төв Азийн нүүдэлчдийн эзэнт гүрний зиндаанд хүрч, Хятадын Хан улстай өрсөлдөн тэмцэлдэх болжээ. Модун шаньюйд ялагдсан Хан улсын хаан Гао-ди МЭӨ 198 онд Модунтай ургийн холбоо тогтоож, найрамдлын гэрээ байгуулж байв. Уг гэрээ ёсоор Хүннү гүрэн, Хан улс хоёр бие даасан, эн сацуу хоёр эзэнт гүрэн гэдгийг харилцан хүлээн зөвшөөрсөн ажээ.

Хүннүгийн нутаг дэвсгэр нь өмнө зүг Цагаан хэрмээс умар зүгт Байгал нуур, баруунш Ил Тарвагатай, дорно зүгт Солонгос хүрч байв. Хүннү гүрэн нь дотоодын тэмцэл самуун болоод Хан улсын арга явуулга зэргээс болж, МЭ 53 онд 2 хэсэг болон хуваагдаад, улмаар МЭ 93 онд Сяньбид эзэлэгдэн мөхсөн байна.

Хүннүгийн нийгмийн бүтцэд сурвалжит язгууртны давхраа ноёлж байсан боловч ураг төрлийн байгуулал, овог аймгийн ахлагчдын нэр нөлөө бас хадгалагдсаар байжээ. Хүннү улс нь төв, зүүн, баруун гэсэн 3 хэсэгт хуваагдаж, аравтын зохион байгуулалттай байжээ. Улсын төв хэсгийг шаньюй өөрөө, зүүн, баруун гарыг хааны томилсон вангууд захирч байв. Хүннүгийн төрийн байгууллын эл онцлог нь хожмын монгол, түрэг угсааны нүүдэлчин улсуудад уламжлагдан үлджээ.

Хүннүгийн аж ахуй, эдийн засгийн байгууллын үндэс нь бэлчээр ус, мал сүрэгт тулгуурласан нүүдлийн мал аж ахуй байв. Түүнээс гадна ан агнуур нь Хүннүгийн эдийн засагт багагүй үүрэгтэй байжээ. Хүннү улсад тариалан бас эрхэлж байжээ.

Хүннү нар бөө мөргөлтэй байв. Тэнгэрийн хүү гэгддэг шаньюй өглөө наранд, үдэш саранд мөргөдөг байжээ. Мөн язгууртнууд нь жил бүрийн хавар, намарт шаньюйн ордонд цугларч, өвөг дээдэс, тэнгэр газартаа мөргөж,

Хүннүгийн үеийн ваар, бусний арал (МҮТМ)

тахил өргөдөг байжээ.Хүннү нар Төв азийн нүүдэлчдийн утга соёлын хөгжилд оруулсан том хувь нэмэр бол бичиг үсэгтэй болсон явдал юм. Тэрхүү бичиг нь арамей нарын бичгийг өөрсдийн хэл яриандаа тааруулан нэн эртний овог аймгийн тамга тэмдэгээр баяжуулсан байжээ.

Өнөөгийн Монгол улсын нутаг нь Хүннү гүрний газар нутгийн цөм болж байсан тул хүннү нарын түүх, соёлын арвин баялаг дурсгал Монголд хадгалагдан үлджээ. Хүннүгийн эд өлгийн дурсгалын нэг онцлог бол хүн мал, араатан амьтны дүрсийг төрөл бүрийн арга барилаар, янз бүрийн эдээр дүрслэх явдал байв. Хүннүгийн соёл нь Монгол нутаг дахь урьд үеийн хүрэл, төмрийн үеийн соёлыг уламжлан урагш ахиулж, хойч үеийнхээ нүүдэлчдийн соёлд гүнзгий ул мөрөө үлдээсэн аж. Түүнчлэн Хүннүгийн түүх, соёлын дурсгалуудад хөрш зэргэлдээ нүүдэлчид болоод Хятад, Солонгос, Дундад Ази, Грек-Бактрийн суурьшмал иргэншилтэй өргөн харилцаж явсны ул мөр хадгалагдан үлдсэн байдаг.



Сяньби. Хүннүгийн дараа монгол нутагт МЭ I зууны сүүлчээр эртний дунху нарын угсааны Сяньби нар ноёрхлоо тогтоожээ. Сяньби нь Хүннү гүрний бүрэлдэхүүнд багтаж явсан Төв Азийн нүүдэлчин монгол угсааны овог, аймгуудаас бүрдэж байжээ. МЭ 150-иад оны үед Сяньбийн цэргийн эрхтний хүү Таньшихуай Сяньби аймгуудыг нэгтгэн захирчээ. Улмаар хуучин Хүннү улсын газар нутгийг бараг бүгдийг эзэлж авчээ. Тэр цагаас хойш Хүннүгийн үлдэгдэл хүн ам болоод Сяньбийн төрөл угсааны Ухуань аймгийн хүн ам Сяньби нэрийн дор явах болж, Сяньбийн хүч чадал нь нэмэгдсэн байна. Сяньби улс Хүннүгийн адил өрнөд, дорнод, төв 3 хэсэг болж, нийт 12 зонхилогчид хуваагдан захирагдаж байжээ. МЭ III зууны дундуур Сяньби аймгийн холбоо задарч, хэдэн тусгаар аймаг болон салжээ. Тэдгээрээс Сяньбийн угсааны Муюн, Тоба зэрэг аймгууд одоогийн Өвөр Монгол, Хойд Хятадын нутагт өөрсдийн төр улсыг байгуулж, нэлээд хугацаанд оршин тогтносоор байжээ.

Сяньби улсын эдийн засгийн үндэс нь Хүннүгийн адил нүүдлийн мал аж ахуй байжээ. Мөн сяньби нар ан гөрөө эрхэлж, олзны хятадуудаар тариа тариулдаг байсан аж. Сяньбийн нийгмийн байгууллалд овгийн байгууллын үлдэц багагүй байсан боловч тэдний дунд нийгмийн ялгарал гүнзгийрч, төр ёс, соёл иргэншлийн хөгжилд нь ихээхэн дэвшил гарч байв. Сяньби улс байгуулагдсаны дараа бичиг үсэг үүсч, утга соёл, эдийн боловсролын хөгжилд нь нэлээд ахиц гарсан байна. Сяньбийн бичиг үсэг нь Хүннүгийн адил модон дээр сийлж бичдэг эртний бичгийн нэг хэлбэр байжээ.

Сяньби нар Хүннүгийн адилаар амьтдын нэрт 12 жилийн хуанли хэрэглэж байв. Мөн тэд дуу хөгжим, шүлэгт ихэд дуртай байж. Эртний зарим сяньби дууны үг нь хятад орчуулгаар бидний үед уламжлагдан ирсэн байдаг. Сяньби нар нь тэнгэр газар, онгон савдаг, өвөг дээдсээ шүтэн биширэх бөө

мөргөлтэй байв. Тэдний дунд бөө удган, мэргэч төлөгч нар ихээхэн нэр нөлөөтэй байжээ. Сяньби нар гэрлэхдээ, хүргэн нь хадмын гэрт 2 жил суух ёстой байв. Сяньби нарын оршуулгын ёслолын нэг онцлог бол нас барсан хүний сүнсийг харж сахиулахаар нохой дагуулж оршуулдаг байсан явдал юм. Сяньби нар нүүдэл хийх ба цэрэг мордох, баяр ёслолын үеэр гурвалсан морин тэрэг хэрэглэдэг байжээ. Сяньби улсын хааныг өргөмжлөхдөө хар эсгий дээр 7 хүн хааныг түшин суулгаж, өргөж залдаг байсан нь хожмын монголчуудын хаан өргөмжлөх заншилд уламжлагдан үлджээ.



Жужан. Жужан нар нь Монголын нутагт төвлөсөн өөрийн улсыг байгуулж, Төв Азийн түүхэнд нэрээ үлдээсэн нүүдэлчин аймгуудын бүрдэл юм. Жужан хэмээх нэр нь IV зууны үеэс түүхэнд тэмдэглэгдэх болсон ажээ. Тэд Дунхугийн угсааны Сяньби нарын удмын аймгууд болон Хүннү нарын үлдэгдэл монгол аймгуудаас гаралтай байжээ. МЭ IV-V зууны заагт үеэр Жужаны язгууртнуудын дотроос Шэлүнь гэгч товойн гарч, хөрш улс аймгуудыг эрхшээлдээ оруулж, Жужан улсыг үндэслэжээ. Тэрбээр МЭ 402 онд биеэ "Жужан Дэүдэй хаган" хэмээн зарлаж, хаан ширээнд суусан байна. Жужан улсын хааны өргөө нь Хангай уулын хавьд байжээ. Улсын хил нь умар зүгт Байгал нуур, өмнө зүгт Их элсэн говь, баруун зүгт Харшаар, зүүн зүгт Солонгос хүрч байв. Жужан улс нь урьдын нүүдэлчдийн уламжлал ёсоор баруун, зүүн жигүүр, төв гэсэн 3 хэсэгт хуваагдаж, аравтын тогтолцоогоор зохион байгуулагдсан байжээ. Шэлүнь нас барсанаас хойш Жужан улс 140 орчим жил оршин тогтнож байгаад дотоодын хямрал, түрэг аймгуудын бослого зэргээс болж, МЭ 555 онд мөхсөн байна.

Жужан улс нь өмнөх нүүдэлчдээс улсуудын нийгмээс хөгжлийн хувьд урагшилж, нийгмийн ялгарал хүчтэй явагдаж байжээ. Жужаны сурвалжит язгууртнууд улсын тэргүүн-хаан, дэүдэй, гэжогай, гэмэнгай, чилян, чуло гэх зэрэг цол чимэг хэрэглэж байв.

Жужан нар хүннү, сяньби нарын адил бичиг үсэгтэй байв. Мөн гадагш харилцахдаа хятад бичиг хэрэглэж байсан мэдээ буй. Жужанд ном эрдэмтэй хүмүүс олон байж, тэднийгээ бишрэн хүндэлдэг байж. Жужан нар бусад нүүдэлчдийн адил тэнгэр газрыг онголон шүтэх бөө мөргөлтэй байв. Гэхдээ тэдний дунд хожимхон бурхны шашин дэлгэрч, бүр төрийн шашны хэмжээнд хүрч байсан явдал нь тэдний соёлын нэг онцлог болно.

Жужан нарын зан заншил нь үндсэндээ сяньби нартай адил байжээ. Тэд дорно зүгийг эрхэмлэж, гэрээ тийш нь харуулан барьдаг. Мөн жужан нарт эцэг нь буюу ах дүүс нь нас барвал хүү буюу ах, дүү нь хойд эх, бэргэнтэйгээ гэрлэдэг улирах гэрлэлтийн ёс (левират) байсан аж. Энэ ёс нь хожмын монголчуудад бас байсан билээ. Ер нь жужан нарын зан заншил, төр ёсны уламжлалын олон зүйл

хожмын нүүдэлчин монголчуудад уламжлан ирсэн байна. Тийнхүү жужан нар нь монголчуудтай угсаа гарал, түүх, соёлын талаар холбоотой монгол угсаатны соёлын нийтлэгт хамаарагдах ард түмэн байжээ.



Түрэг. Монгол нутагт Жужаны дараа Түрэг угсааны аймгууд ноёрхлоо тогтоож, төр улсаа байгуулж байв. Түрэг аймгууд нь эрт цагт Хүннү гүрний бүрэлдэхүүнд багтдаг байжээ Жужан улсын үед тэд Алтайн уулсаар нутаглан төмөр хайлуулж, жужан нарт алба барьдаг байв. МЭ VI зууны дундуур Түрэг аймгийн зонхилогч Буман Жужан улсын харьяанд байсан олон овог аймгийг нэгтгэж, биеэ "Эл" хаан өргөмжилж, Түрэгийн хант улсыг байгуулжээ. Түрэг улс нь зуу гаруй жил оршин тогтнож байгаад Тан улсын эрхшээл нөлөөнд орж, 50 гаруй жил болжээ. VI зууны сүүлчээр Түрэгийн язгууртнууд Кутулуг, Тоньюкук нараар удирдуулсан том бослого гарч, Түрэгийн хант улсыг сэргээн байгуулсан байна. Тэр цагаас хойш Түрэгийн хант улс тусгаар тогтнолоо хамгаалж, Хятадын Тан улстай өрсөлдөн тэмцсээр байжээ. Гэвч 745 онд Түрэг улсын дотоод хямрал гүнзгийрсэн үеэр уйгур аймгууд бослого гаргаж, Түрэг улсыг мөхөөжээ.

Түрэгийн төр улсын тэргүүнийг хан гэх бөгөөд язгууртнууд нь ябгу, шад, буюрук, дархан гэх мэт цол хэрэглэдэг байв. Түрэг улс нь нүүдэлчдийн уламжлал ёсоор зүүн, баруун, төв гэсэн 3 хэсгээс бүрдэж байв. Баруун жигүүрийг нь тардуш, зүүн жигүүрийг нь төлөс хэмээн нэрлэдэг байжээ.

Түрэгүүд Төв Азийн нүүдэлчдийн уламжлалт соёлыг хөгжүүлж, эдийн болон утга соёлын өв санг үлдээжээ. Түрэгийн соёлын түүхэнд гарсан том амжилт бол "Орхон Енисейн бичиг" хэмээн алдаршсан 38 үсэг бүхий авианы бичгийг зохион хэрэглэсэн явдал юм. Уг бичгийн үүслийг эрдэмтэд эртний согд бичиг болоод Төв Азийн эртний нүүдэлчдийн овог аймгийн тамга тэмдэгтэй холбон

Түрэгийн үеийн эдлэл (ҮТМ)

үздэг. Монгол улсын нутгаас Түрэгийн руни бичгийн дурсгал нийт 50 гаруй олдоод байна. Тэдгээрээс Билгэ хан, Куль-Тегин, Тоньюкук зэрэг алдартай язгууртны дурсгалд зориулсан гэрэлт хөшөөдийн бичээсийг дурдаж болно.

Монгол улсын нутагт хадгалагдан үлдсэн Түрэгийн эд өлгийн дурсгалын нэг хэсэг бол булш оршуулга, тахилын байгууламжууд юм. Түрэгүүд анхандаа үхэгсдийг оршуулахдаа, амьд ахуйдаа хэрэглэж байсан эд зүйлс, хүлэг морьдынх нь хамт шатааж чандарладаг байжээ.



Хожим нь нүх ухаж, газарт булж оршуулах болжээ. Мөн нас барагчдад зориулан тахилын онгон үйлдэж, шүтлэгийн зан үйл гүйцэтгэдэг байжээ. Түрэгийн ихэс язгууртанд зориулсан сүрлэг том тахилын онгоны тоонд Куль-Тегин, Тоньюкукын цогцолбор дурсгалуудыг дурдаж болно.

Эртний түрэгүүдийн дүр царай, гэзэг үс, хувцас хэрэглэлийн зүйлсийг тодруулахад Түрэгийн үеийн хүн чулуун хөшөөд чухал сурвалж болдог. Өдгөө Монгол улсын нутгаас Түрэгийн үед холбогдох хүн чулуу 400 гаруй олдоод буй. Тэдгээр хүн чулууг боржин буюу гантиг чулуугаар урлан хийдэг байжээ. Түрэгүүд үндсэндээ бөө мөргөлийг шүтдэг байв. Гэхдээ тэдний дунд буддын болон загалмайтны шашны нөлөө нэвтэрч байсан бололтой.

Уйгур бол эртний алтай хэлний бүлэгт багтах түрэг угсааны нүүдэлчин ард түмэн юм. Эртний хятад сурвалжид уйгуруудын өвөг дээдсийг МЭӨ III зууны үеэс Динлин, Дили, Тэлэ, улмаар V зууны үеэс Уйгур (Хуйху) хэмээн нэрлэх болжээ. Мөн тэд өндөр дугуйтай тэрэг хэрэглэдэг байсан учир гаогюй буюу өндөр тэрэгтнүүд гэж нэрлэгдэх нь ч байв.

VIII зууны дундуур Пейло хэмээх ханы үед уйгурууд Түрэгийн хант улсыг мөхөөж, Уйгур улсыг байгуулжээ. Уйгурын ханы орд өргөө нь Орхон голын хөндийд Байбалык (Хар балгас) хэмээх хот байжээ. Пейлогийн дараа хан суусан Моюнчур (747-759)-ын үед Уйгур улс хүчирхэгжиж, газар нутгаа өргөтгөсөн байна. Уйгурын газар нутаг умар зүгт Байгал нуур, өмнө зүгт Их элсэн говь хүртэлх өргөн

Хар балгас орчмоос олдсон уйгурын үеийн олдворууд (МҮТМ)

уудам болжээ. Уйгурын хант улс 840 онд Енисейн киргизүүдэд цохигдон бутарч, тэдний зарим нь Дорнод Туркестайд очиж, шинэ улс байгуулсан ажээ.

Уйгурууд Монгол нутагт тогтож байсан олон аймаг, улсын соёлыг залган хөгжүүлжээ. Уйгурын соёлын том амжилт бол өөрсдийн бичиг үсэгтэй болж, ном зохиол туурвин, гадаад хэлнээс судар шастир орчуулж байсан явдал мөн. Уйгурууд эхэн үедээ түрэг бичиг хэрэглэж байсны ул мөр нь Сэлэнгийн чулуу, Сүүжийн бичээс гэгдсэн дурсгалууд юм. Уйгурууд төр улсаа байгуулсны дараа соёлын харилцаа нь өргөжиж, бусад өндөр соёлтой улс орнуудаас соёлын нөлөөг нь тусган авч байв. Уйгурын соёлд согд нарын нөлөө багагүй байсан ажээ.Тухайлбал, уйгурууд согд бичгийг авч, өөрийн хэлний аялгуунд зохицуулан хэрэглэсэн нь түүхэнд уйгур бичиг хэмээн алдаршжээ.

Уйгурчууд хот балгад барьж байгуулах талаар бусад нүүдэлчдээс нэлээд урагш ахисан байжээ. Мөн тэд манихейн шашныг дэлгэрүүлж, согд гар урчуудыг ашиглан сүм дуган барьдаг байжээ. Ер нь Уйгурын соёлд нүүдэлчдийн хуучин уламжлалыг хадгалахын зэрэгцээ хот суурин соёлын нөлөө урьд нүүдэлчдийнхээс илүүхэн тусч байснаараа онцлогтой юм.



Уйгурын мэргэлчин

Хятан. нар нь эртний дунху нараас гаралтай бөгөөд монголчуудтай нийтлэг нэг гаралтай юм. Хятан хэмээх угсаатны нэр анх МЭ IV зууны сүүл үеэс түүхэнд нэр тэмдэглэгдэх болсон ажээ. 917 онд Хятаны тэргүүлэгч Амбагян 3 жил тутам тэргүүлэгчийг сонгодог журмыг зөрчин, Хятаны хаан ширээг үе улиран залгамжлах болгов. Мөн Хятаны хуучин 8 аймгийг үндэс болгож, Хятан улсыг байгуулжээ. Улмаар Амбагян болон түүнийг залгамжлагчид хөрш зэргэлдээ нүүдэлчид болон Хойд Хятадын 16



муж улсыг эзлэн авчээ. Тэр үеэс Хятан улс их гүрний зиндаанд хүрч, улсаа Их Ляо улс хэмээн нэрлэх болов. Хятан гүрэнд нийт 50 гаруй аймаг, улс багтсан бөгөөд тэдгээр нь өмнөд, умард, гадаад гэж хуваагддаг байжээ. Улсын нутаг дэвсгэр нь дорнод далайгаас Алтайн уулс хүртэл, Туул голоос Хятадын цагаан хэрэм хүртэл өргөжижээ. Гэвч Хятан гүрэнд эзлэгдсэн зүрчид аймгийнхан 1118-1125 онд Хятадын Сүн улстай хүч хавсран Хятан гүрнийг мөхөөжээ.

Хятан гүрний хүн ам нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, соёлын хөгжлөөр харилцан адилгүй, нүүдлийн болоод суурьшмал хоёр янзын амьдралтай иргэдээс бүрэлдэж байв. Тиймээс Хятан гүрэнд мал аж ахуй, газар тариалан, худалдаа арилжаа, гар үйлдвэр нь бүс нутаг бүрийн онцлогтой хөгжиж байжээ.

Хятан нарын эдийн болон оюуны боловсрол нь урьдах нүүдэлчин аймаг, улсуудаас нэлээд урагш ахисан байжээ. Хятаны соёл нь нүүдэлчдийн соёлыг суурьшсан тариаланчдын соёлтой холбосон нэлээд содон шинжтэй байсан аж. Хятаны нутгийн төв, өмнөд, зүүн өмнөд хэсэгт оршин суугчдын дунд хот балгад, сүм дуган, суврага, чулуун гүүр зэргийг барих арга ухаан нэлээд хөгжиж байв. VIII-X зууны үед газар тариалан, гар урлалын хөгжлийг дагаад нэхмэл сургалт, тариалангийн арга ухаан, яламургуулах, хүр үржүүлэх зэрэг мэдлэг дэлгэрч байжээ.

Хятаны соёл боловсролын хөгжилд гарсан том ололт нь Их, бага бичгүүдийг зохион хэрэглэсэн явдал болно. Хятаны Их бичгийг 920 онд Амбагяны ач хүү Лубугу, эрдэмтэн Тулюйбу хоёр хятад бичгээс үлгэр авч зохиожээ. Харин Амбагяны хүү Елюй Тэла (Жүндүхүн) уйгур бичгээс үлгэрлэн зохиосон бичиг нь Хятаны Бага бичиг хэмээн алдаршжээ. X зуунаас Хятанд шүлэг магтаал, дуу, тэмдэглэл зэрэг утга зохиолын олон төрөл хөгжиж байв. Хятан гүрэнд хятан, хятад гэсэн эрдмийн хоёр хүрээлэн байсан ажээ. Хятан гүрний үед улсын албан түүх, шастир зохиох ажил амжилттай хөгжиж, олон алдартай түүхчид төрөн гарч байв. Бас хятанчууд нутгийнхаа газрын зургийг зохиож, тайлбарыг хийсэн явдал нь газар зүйн ухааны хувьд чухал зүйл болжээ. Хятан нарын үндсэн шүтлэг нь бөө мөргөл байсан боловч будда, күнз, даосын сургаалтнууд бий болж байв. Хятан гүрний гадаад харилцаанд соёлын харилцаа чухал байр эзэлж байжээ. Хятан нар гадаад орнуудад ном судраар бэлэг явуулж, гаднаас мөн бичиг судрын зүйлсийг хүлээн авдаг байсан ажээ. Хятан гүрэн Төв Ази, Дорнод Азийн уудам нутагт амьдран суусан монгол, хамниган зэрэг аймаг угсаатны нийгэм, соёлын хөгжилд чухал нөлөө үзүүлсэн билээ.

Хятан хүний хөрөг (МҮТМ)

Хятаны үеийн барилгын материал X-XII зуун (МҮТМ)

XI-XII зууны монгол аймаг, ханлигууд. XI-XII зууны үед монгол нутаг дээр оршин тогтнож байсан монгол угсааны овог аймаг, ханлигуудын нийгмийн хөгжилд нэлээд ахиц гарч, зарим нь төр улсын шинжтэй болж иржээ. Судлаачид эл үеийн монгол аймгуудыг "ойн иргэн" ба "хээрийн нүүдэлчин" хэмээн ангилсан байдаг. Ойн аймгууд нь загасчин, анчин байсан бол "хээрийн нүүдэлчин" нь малчид байв. Тэдгээрээс малчин аймгууд нь нийгмийн хөгжлийн хувьд давуу, тоогоор олон байжээ. Ойн аймгууд Алтайн өмнөд хэсгийн ой тайгаар нутаглаж, загас барьж, ан гөрөө хийж аж төрдөг байв.

XII зууны үед Монголын том аймаг, ханлигийн нэгдлийн тоонд Хамаг Монгол, Жалайр, Тайчууд, Хэрээд, Мэргэд, Найман зэрэг харьцангуй бие даасан байдалтай аймгууд ордог байжээ. Хамаг монголчууд Онон, Хэрлэн, Туул гурван мөрний саваар; Жалайр Онон мөрний хөндийгөөр; Тайчууд Онон, Хэрлэн, Сэлэнгэ мөрний эхээр; Хэрэйдүүд Хангай, Хэнтийн нуруу, Орхоны хөндийгөөр; Найман аймаг Алтай, Хангайн уулсаар; Мэргэд аймаг Сэлэнгэ мөрний саваар тус тус нутаглаж байв. Харин Байгал нуураас хойш Хорь түмэд, Баргуд, Булгачин, Хэрэмчин, Урианхад, Тэлэнгүт аймаг; Найман гол дагуу Ойрад аймаг нутаглаж байжээ. Дээрх аймаг, ханлигуудаас Хамаг Монгол нь аажимдаа бусад монгол угсааны аймаг, ханлигуудаа манлайлан дагуулах шинжтэй болж иржээ. Хамаг Монгол нь Нирун, Дарлигин хэмээх хоёр гол овог, аймгаас бүрдэж байжээ. Монгол аймгуудаас тоогоор үлэмж, нөлөөтэй нь Хэрээд аймаг болж байв. Харин Найман аймаг нь монгол аймгуудын дотроос хамгийн соёлтой нь байжээ. Найманы эрхтэн мэдэлтэн нар уйгур бичээч хэрэглэдэг төдийгүй уйгур хэл бичигт боловсорсон найман хүн ч олон байсан аж. Цэргийн хүч чадал дайнч байдлаараа Мэргэд аймаг ялгарч байсан бол хүн амаар цөөн нь Онгуд аймаг болж байв.

Монголчууд хэдийгээр тархай бутархай олон аймаг байсан боловч XII-XIII зууны зааг дээр тэдний аж төрлийн байдал, хэл, хэв заншил,соёлд адил төсөөтэй зүйл олон байжээ. Тэдгээр аймгуудын шүтлэг нь тэдний нийгмийн харилцааг тусгаж, овог аймгийн нэр хүндийг дэмжин байсан бөө мөргөл байжээ. Монголын малчин аймгуудын үндсэн баялаг нь адуу, хонь, үхэр байжээ. Монгол аймгууд зэргэлдээ Хятад, Дундад Азийн суурьшсан улстай харилцахдаа тэднээс хэрэгцээтэй бараагаа адуу, малаар арилжиж авдаг байжээ.

Тэр цагт монголчууд хүрээгээр нүүдэллэдэг байв. Сурвалжийн мэдээгээр, нэг хүрээнд мянгаад өрх багтдаг байжээ. Хүрээ нь аажмаар задарч, оронд нь айлаар нүүдэллэх нь хүрээлэн нүүдэллэхээс илүү оновчтой болж иржээ. Нийгмийн ялгарал малчдын дунд гарахын хирээр тухайн аймгийн баялаг айл өрхийн хүч чадал нь нэмэгджээ. Улмаар тэд ээн хаад, нөхөр (торгон цэрэг)-ийн хүчинд тулгуурлан, эдийн засгийн хүчээ ихэсгэхийг эрмэлзэх болжээ. Тийнхүү XII зууны сүүлч гэхэд монгол аймаг, ханлигуудын хоорондын байнгын тэмцэл эцэс болж, Монголын нэгдсэн улс байгуулагдах түүхэн цаг үе тулж иржээ.

Н.Хатанбаатар
С.Уранбилэг

ИХ МОНГОЛ УЛС

1206 онд Чингис хаан монгол туургатан аймгуудыг нэгтгэсэн Их Монгол улсыг байгуулсан нь монголчуудын түүхэнд болсон онцгой тэмдэглэлт үйл явдал байв.

Чингис хаан (1162-1227)

Урьд нь монгол аймаг, ханлиг улсууд төрийн нэгдсэн захиргаагүй тархай, бутархай оршиж байсан юм. Дорно зүгт Хянганаас, өрнө зүгт Алтай уул, өмнөд Их Цагаан хэрмээс умардад Байгал нуур хүртэлх өргөн уудам нутагт тархан суусан монголчууд тухайн үед тус бүр өөр өөрийн жижиг тэргүүлэгчтэй, хоорондоо хямрал тэмцэлтэй, хэдэн ханлиг улс, олон аймгуудад хуваагдсан байв. Тэдний тархай бутархай байдал нь улс төрийн тусгаар тогтнолыг хэврэгшүүлж, соёл аж ахуйн нийтлэг бүрэлдэн тогтоход нь саад төвөгтэй байв.

Монгол угсааны аймаг, ханлигуудын удирдагчдын дундаас XII зууны сүүлчээр Тэмүжин улс төрийн үйл ажиллагаа, цэргийн чадвараараа товойн гарч, монгол туургатныг нэгтгэн, нэгэн төрийн жолоонд оруулах үйл ажиллагаа явуулж эхлэв. Тэмүжин бол язгуурын монголчуудын Хамаг монголын ханлигийн тэргүүлэгч Есүхэй баатрын ууган хүү бөгөөд 1162 онд төржээ. Тэр бага балчиртаа эцгээсээ хагацан, өнчин ядуугийн гачаалыг амсч, бусдын довтолгоонд өртөн, хүчирхийллийн учир утгыг биеэр мэдэрч хатуужин өссөн нэгэн байв.

Одтой тэнгэр орчиж
Олон улс байлдаж
Орондоо унтах завгүй
Олзлолдож булаалдаж

байсан тэр хямралт цагт бусадтай харилцаа тогтоож, холбоотой болох нь улс төрийн тавцанд гарч ирэх чухал нөхцөл байв. Тэр юуны өмнө өөрийн хүчийг зузаатгахын тулд тухайн үедээ хүчирхэгт тооцогдож агсан Хэрээдийн тэргүүн Тогорилтой холбоо тогтоожээ. Түүний эн тэргүүний зорилго нь өөрийн эцгийн тэргүүлж агсан Хамаг монголын ханлигийг сэргээн тогтоох явдал байв. Хамаг Монголын ханлигт багтсан аймаг, овгууд Есүхэйг нас барсны дараа Тэмүжин, түүний ах, дүү нарыг орхиж, тархан явсан байжээ.

1180-аад онд тэрбээр Тогорил, Жамуха нартай хамтран гурван мэргэдэд довтлон, түүнийг бут цохиж, урьд тэдэнд олзлогдоод байсан өөрийн Бөртэ хатныг бусад хүмүүсийн хамт эргүүлэн авчээ. Үүний дараа тэрбээр урьд нь хамаг Монголын ханлигт багтаж агсан Жадран аймгийн нэлээд хэсгийг өөртөө татаж чадсан байна. Тайчууд аймгийн олныг эрхшээлдээ буцаан оруулж авсан байна. Тийнхүү 1189 он болоход Хамаг Монголын ханлигийг сэргээн байгуулсан Тэмүжин түүний ханд өргөмжлөгджээ.

Хар Зүрхний Хөх нуурт болсон тэрхүү хуралдайн үеэр мөн Тэмүжинд Чингис хан цол өргөмжилжээ.

Тэмүжин Хамаг Монгол ханлигийг дахин сэргээснийхээ дараа хэрээдийн Тогорил зэрэг холбоотныхоо тусламжтайгаар монгол аймаг, ханлигийг нэгтгэх үйлст зориг шулуудав. Тэр олон бэрхшээл, дайн байлдааныг туулан байж, 1206 он болоход монгол туургатныг нэгтгэж, бүх монголын хаан ширээнд суусан байна. Тэрбээр улсаа Их Монгол улс хэмээн нэрийдэв.



Чингис хааныг хаан ширээнд залж буй ёслол.XIV зууны үеийн перс зураг (Францын Үндэсний номын сан)

Чингис хаан болоод, улсынхаа дотоод засаг, засаглалыг жигдрүүлэн тогтооход юуны өмнө анхаарлаа хандуулав. Тэрбээр бүх улсын иргэдийг мянганы тогтолцоонд оруулж, 95 мянгат байгуулсан байна. Мянгатуудаас бүрдсэн улсаа төвийн түмэн, баруун түмэн, зүүн түмэн хэмээн гурван том хэсэгт хуваажээ. Мянгат нь ойролцоогоор арван аравтаас

бүрдэх бөгөөд түмэн нь арван мянгатаас бүрджээ. Мянгат нь урьдын ханлиг улс, аймгуудын үеийн захиргааны байгууламжийг үндсээр нь эвдэн, цэрэг-засаг захиргааны хосолсон шатлан захирах тогтолцоог буй болгож чаджээ. Тэгэхдээ энэ нь цоо шинэ зүйл бас биш юм. Хүннү улсын үеэс нүүдэлчдийн хэрэглэж ирсэн аравтын тогтолцоог шинэчлэж, тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан хэрэглэсэн хэрэг юм.

Зуут, мянгатын ноёдоор Чингис хаанд хүчин зүтгэсэн, илтгэлт нөхдөө өргөмжилсөн байна. Мянгатын ноёд нь Их хааны гол түшиг тулгуур нь болов. Тэд цэргийн эрхтэн тэдийгүй, иргэний засаг захиргааны тэргүүн нар байв.

Мянгатуудыг байгуулснаар урьдын овог, аймгийн удирдагчдын эрх мэдэл, хүч нөлөөг хязгаарлаж, хаан өөрийн вассалуудыг буй болгож чадсан байна. Энэ байгуулалт нь тухайн үеийн төр улсын хүчин чадлыг нэг жолоонд зангидан, идэрхэг, цэрэглэг байлгахад үлэмж үүрэг гүйцэтгэжээ. Нөгөө талаар мянгатын тогтолцоо нь аян дайн хийхэд тэдийгүй тэр үеийн монголчуудын эдийн засгийн үндэс болж агсан мал аж ахуйг хөтлөн эрхлэхэд тохиромжтой зохион байгуулалтын хэлбэр байжээ. Учир нь нүүдлийн мал аж ахуй нь уудам бэлчээрт шүтэн, байнга нутаг сэлгэхийг шаардаж байдаг. Гэтэл мянгатууд нь нь төр улсын нэгдсэн тогтолцоо мөн байсан тул бэлчээр сэлгэн нүүдэллэн малжих нөхцөлийг улсаас зохицуулах боломжоор өргөн олгож байжээ.

Мянгатын ноёд өөрийн мянганы доторхи бэлчээрийг хуваарилах, харъяат хүмүүсээс албан татварыг хураан улсад нийлүүлэх зэрэг төрийн албадлагын аппаратын төлөөний хүний үүргийг гүйцэтгэж байв.

Чингис хаан мянганы тогтолцоог буй болгохдоо, хаан төрийн эрхийг бататгах, эв нэгдлийг бэхжүүлэх, эдийн хүчин чадлыг бүрэн дайчлахыг зорьж байжээ. Мянгат нь дотоод, гадаад хэмээн хоёр ялгаатай байсан бөгөөд дотоод мянган гэдэг нь хишигтэн цэргүүдээс бүрдэнэ. Гадаад мянган гэдэг нь ердийн малчин ардуудыг мянгалсанаа тийнхүү нэрлэжээ. Дотоод мянган буюу хишигтэн цэрэг нь Их Монгол улсын төрийн гол мөхлөг нь болж байв.



Дотоод мянган нь хаан тэргүүтэй талын язгууртны төрийг тогтоон барьж, хамгаалж байх гол хүчин нь байв. Шадар хишигтэн нь анхандаа, нэгэн түмэн хүнээс бүрдэж байв. Түүний найман мянга нь торгууд, хоёр мянга нь хэвтүүл, хорчин нар байж. Чингис хаан хишигтэнийг байгуулахдаа, голдуу талын язгууртан мянгат, зуут, аравтын ноёдын хүүхэд залуучуудаас бүрдүүлжээ. Тэд бие бялдар сайтай, гавшгай, дайчин шалмаг байх ёстой. Хишигтэн цэргийг хэрэгцээтэй бүхнээр хангах нь харъяат мянгат, зуутын гол үүрэг байв. Хишигтэн нар тайван цагт Их хааны өргөө, хааны биеийг өдөр шөнөгүй ээлжлэн манаж хамгаалах, дайны үед их цэргийн гол цөм нь болж хатгалдан байлдах үндсэн үүрэгтэй байжээ. Чингис хаанаас өөр хэн ч тэднийг захирах, шийтгэх эрхгүй ажээ. Тийм онцгой эрх дарх бүхий шадар хишигтэн цэргийг буй болгосон нь Их Монгол улсыг бат бэх, хүчирхэг байлгахад чиглэгджээ.

Чингис хааны шууд удирдлагаар "Сэцэдийн зөвлөл", "Их хуралдай" зэрэг байгууллагыг бас байгуулсан байжээ. Сэцэдийн зөвлөл нь зөвлөх эрхтэй байсан бол, Их хуралдайгаар дайтах, хаан өргөмжлөх зэрэг төрийн онцгой чухал хэргийг хэлэлцэж шийдвэрлэдэг. Тэр үеийн Их хуралдайд өнөөгийн парламентын зарим элемент байжээ. Гэвч түүнийг парламенттай шууд адилтгаж үл болно.

Тэр үеийн Их монгол улсын гол хууль нь "Их Засаг" юм. Тэр нь их хааны болон Их Монгол улсын эрх дарх, хаан өргөмжлөх, их хуралдайг зарлах, гадаад улсуудтай харилцах, иргэдийн эрх, үүрэг, цэрэглэх, ан ав хийх, санхүү, алба татвар, гэр бүл, өв өвлөх зэрэг эрх зүйн ихээхэн зүйлийг багтаасан байв. Их Засаг нь тухайн үедээ нэлээд төгөлдөржсөн хууль байжээ.

Өмнөдөд Хятадын Их цагаан хэрмээс умардад Байгал далай хүртэл, дорнодод Хянганы нуруунаас, өрнөдөд Алтай уулыг довтлох өргөн уудам нутгийг эзэлсэн Их Монгол улс байгуулагдсанаар, монголчуудын урьдын улс төрийн тархай бутархай байдал эцэс болж, монгол туургатан нэгэн хүчирхэг төрийн жолоонд оржээ. Энэ нь нийт монголчуудын улс төр, газар нутгийн нэгдэл буй болох чухал нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Мөн түүнчлэн Их Монгол улс байгуулагдсан нь монголчуудын соёлын нийтлэг буй болох хийгээд улмаар монгол угсаатан бүрэлдэн хөгжихөд мэдэгдэхүйц түлхэц болж өгчээ. Их Монгол улс нь цаашид Чингис хаан, түүний залгамжлагчид Ази, Европ хоёр тивийг дамнасан цэрэг-улс төр, эдийн засгийн өргөн бодлого, үйл ажиллагаа явуулах гол бааз суурь нь болж өгсөн байна.

А.Очир
С.Уранбилэг

ЭЗЭНТ ГҮРЭН

Чингис хаан XIII зууны эхэнд Их Монгол улсыг байгуулж төвхнүүлсэний дараа Ази, Европ хоёр тивийг дамнасан өргөн цар хүрээтэй аян дайнд мордсон байна. Тэр аян дайны нэг гол зорилго нь шинэ байгуулагдсан Их Монгол улсын гадаад аюулгүй байдлыг хамгаалан бэхжүүлэх, улмаар түүний нутаг дэвсгэрийг өргөтгөн, хүчирхэг том гүрэн болгож, монголын эрх баригсадын улс төр, эдийн засгийн эрх мэдлийг өргөтгөх явдал байв.

Монголын эрх баригсад мэдээжээр, тухайн үед Их Монгол улсад ямар нэг хэлбэрээр дайсагнан хандсан, түүний эсрэг эвсэл холбоо байгуулахыг оролдсон, түүнийг үл тоомсорлон, эсэргүүцэгч этгээдүүдтэй нь ил далдуур сүлбээлдсэн улс орнуудад эхний ээлжинд довтолсон байна. Тийнхүү тэд юуны өмнө Тангудын Ся улс, Зөрчидийн Алтан улс, Хорезмын хаант улсыг байлдан эрхшээлдээ оруулахыг эрмэлзэжээ.

Чингис хааныг эсэргүүцэгч этгээд Хэрээдийн зарим нь зугатан очиж, хоргодон агсан Тангудын Ся улсад 1205 онд довтолсон боловч уг дайныг түр хойшлуулаад дараа нь 1207 онд үргэлжлүүлжээ. Тийнхүү монголын цэрэг өөрийн хилийн баруун өмнө залгааны Ся улсад цөмрөн орж, түүний олон хот балгадыг түргэн зуур бүсэлжээ. Тангудын эрх баригсад монголчуудын эсрэг тэмцэлдээ холбоотон болгохыг хүсэн найдаж агсан Зөрчидийн Алтан улсад элч довтолгон, Чингисийн эсрэг хамтран тэмцэхийг гуйсан боловч эс бүтжээ. Тангудын хаан сандрахдаа, Чингис хаанд их бэлэг сэлт өргөн, Их Монгол улсад жил бүр алба өргөж байхыг илтгэн бууж өгчээ.

Тийнхүү Их Монгол улс Тангуд улсыг хараат орон болгосон нь түүний Зөрчидийн Алтан улстай хамтран Монголын эсрэг холбоолон тэмцэх санаархлыг тас цохиж чадсан байна. Бас цаашдын аян дайнд Тангудын цэрэг, эдийн засаг, зэр зэвсгийн нөөцийг ашиглах боломжийг олжээ.

Чингис хаан дипломат арга хэрэглэн, 1209 онд Дорнод Туркестаны уйгуруудыг буулган авчээ.

Тэрбээр дараагийн ээлжинд Умард Хятадыг эзэгнэн оршиж агсан Зөрчидийн Алтан улсыг довтлох бэлтгэлээ базаагаад, 1211 оны 3-р сард их цэргээ аван хөдөлжээ. 1210 онд Алтан улс Чингис хаанд элч зарж, түүнийг Алтан улсад алба барьж хараат байхыг шаардан шахамдуулсан нь чухамдаа Их Монгол улсын тусгаар байдлыг хүлээн зөвшөөрөхгүй байгаагийн илрэл болсон тул түүнийг Чингис хаан яаралтай довтлон байлдахад хүргэсэн байна. Чингис хаан нөгөө талаар монголчуудтай удам гарваль нэгтэй Хятан нарыг Алтан улс эрхшээн дарлаж агсныг чөлөөлөх зорилго бас тавьжээ.

Монгол цэргийн хүч айсуйг сонссон Алтан улсын хаан тэдэнтэй гэрээ хэлэлцэл байгуулах нэрийдлээр цаг хожихыг оролдсон боловч эс бүтжээ. Алдарт Зэв жанжны цэрэг шууд Чуулалт хаалгаар дайран, Цавчаал боомтыг авсан нь Алтан улсад хүчтэй цохилт болсон байна. 1211 онд Чингис хааны цэрэг Алтан улсын 30 000 цэргийг одоогийн Хэбэй мужид бут цохиж, дараа жил нь тэндэхийн олон бэхлэлт, боомтыг эзлэн авчээ. Алтан улсын эрхшээлд агсан Хятаны тэргүүлэгч Елюй-Люгэ Чингис хаантай хамсран, Зөрчид улсын эсрэг амжилттай тэмцжээ. Алтан улсын хаан Тангудтай хамтран, Чингис хааны эсрэг тэмцэхийг оролдсон боловч монголчууд урьд нь тангудыг хараат болгож чадсан тул түүний оролдлого бүтэхгүй байв.1213 онд Чингис хаан их цэргээ 3 хуваан, гурван замаар Алтан улсад хүчтэй довтолж, түүний нийслэл агсан Бээжин хотыг бүслэн авчээ. Шахамдан сандарсан Алтан улс бэлэг, өөрийн охиноо 500 хөвгүүд охидын хамт өгч найрамдахыг хүсчээ. Тийнхүү Алтан улс Чингис хааны хараат болж, Монгол цэрэг буцсан байна.

Чингис хаан үүний дараа

Чингис хааны цэргийн довтолгоон (Перс зураг)

Хятадын Сүн улсад элч зарж, найрамдалтай харилцахыг хүсчээ. Гэтэл түүний элчийг замд нь Алтан улс саатуулсны зэрэгцээ тэд өөрийн нийслэлийг урагш нь Кайфынд шилжүүлэн, далдуур дайнд бэлтгэж байв. Үүнийг мэдсэн Чингис хаан 1214 онд Алтан улсад дахин довтолж, Бээжин хотыг бүслэн, улмаар түүнийг эзлэн авч, цааш нь давшин байлдав. Гэвч Чингис хаан зарим цэргийн хамт нутагтаа буцахаар болж, Алтан улсыг байлдах ажлыг Мухулай жанжинд хариуцуулан үлдээжээ.

Чингис хааны Алтан улсыг орхин гэдрэг буцсан шалтгаан нь Дундад Азид довтлох бэлтгэл хийж, цаг алдалгүй тийш нь дайлах чухал шаардлага гарсантай холбоотой аж.

Ер нь Чингис хаан тэргүүтэй монголын байлдан дагуулагчдын тэр үеийн цэрэг дайны нэг чухал тактик бол эсэргүүцэгч этгээдүүдийн хүчийг нэгтгэхгүй, тус тусад нь байлгаж цохих, урьд нь эзлэгдсэн болон хараат болсон орнуудын цэрэг, эдийн засгийн нөөц боломжийг дараагийн этгээдүүдийг дайлахад өргөн ашиглах явдал байв. Энэ нь тэдний байлдааны амжилтын нэг үндэс болж байлаа. Ар талаа бэхлэх, өндөр сонор сэрэмжтэй байх нь мөн тэдний нэг онцлог шинж юм.

Чингис хаан Хорезмд довтлохын өмнө Их Монгол улс Хорезм хоёрын завсарт оршин агсан Хар Хятан (баруун Ляо) улсыг дайлжээ. Чингис хааныг эсэргүүцэгч этгээд Найманы Даян ханы хүү Хүчүлүг үлдэгдэл цэргийнхээ хамт Хар Хятанд зугатан очоод түүний хааныг түлхэн унагаад өөрөө хаан суугаад, хүчээ бэхжүүлэн, улмаар Хорезмын эрх баригсадтай холбоо тогтоон, Чингис хааны эсрэг үйл ажиллагаа идэвхитэй явуулж байсан юм.

Тиймээс Чингис хаан юуны өмнө өөрийнх нь эсрэг чиглэсэн Хар Хятан улсын тэр үйл ажиллагааг таслан зогсоох нь нэн чухал байлаа.

Чингис хаан 1218 онд Зэв жанжнаар удирдуулсан хоёр түмэн цэргийг Хар Хятан улсыг дайлаар илгээв. Зэв жанжин цэргүүд болон Хар Хятаны иргэдэд хандан, аливаа хүн дуртай шашнаа шүтэх эрхтэй, монголын цэрэг энгийн номхон ард иргэдийг ерөөс дээрэмдэн тонохгүй, аливаа үймээн самуун, хулгай дээрмийг илбэн тохинуулах болно хэмээн зар тараажээ. Тэр үеийн Хар Хятан улсын үндсэн хүн ард нь лал шүтлэгтэй, харин Хүчүлүг нарын эрх баригсад нь бурханы шашинтай байсны дээр харь газрын Хүчүлүгийн ноёрхолд нутгийнхан дургүй байсан нь Зэв жанжны ухуулга, бодлогыг хүн ардын ихэнхи нь хүлээн авахад нөлөөлжээ. Тийнхүү монголын цэрэг төдий л удалгүй Хар Хятаныг эзлэн авчээ.

Монголчууд Хятаныг эзлэн авснаар Хорезмтай шууд нүүр тулсан байна.

Хорезм улс нь Аму-Дарьяа мөрний хөндий одоогийн Афганистан, Бухар, Ираны баруун хэсгийг эзлэн, Хятад хийгээд Газрын дундад тэнгис, Энэтхэг хийгээд

өмнөд Оросыг холбосон худалдааны зам дээр хөндөлсөн байв. Чингис хааны илгээсэн 450 хүнтэй, 500 тэмээн ачаатай худалдаачдыг Хорезмын Отрар хотынхон барьж алсан нь монголчууд Хорезмд довтлох шууд шалтаг болсон байна. Чингис хааны удирдсан монголын их цэрэг 1219-1224 онд Хорезмд довтлон, Отрар, Бенакент, Ходжент, Бухар, Заридк, Нур, Зарешан, Ургенч, Самарканд, Балх, Мерб, Ниша-Пур зэрэг хотуудыг нь эзлэн, Хорезм улсыг буулган авсан байна. Хорезм улсын жанжин, цэргүүдийн дотроос монголчуудын эсрэг эцсээ хүртэл баатарлагаар тулалдсан хүн бол Мухамедийн хүү Желал-ад-Дин юм. Тэрбээр Шихихутагийн удирдсан 30000 цэргийг цөөн хүчээр цохин ухруулсан ч Чингис хааны удирдсан их цэрэгт аргагүй хүчин мөхөсдөн, Энэтхэг рүү зугатан, Инд мөрнийг мориор туулан гарч, Энэтхэгээр дамжин, Перст хүрч, улмаар 1231 он хүртэл тэмцлээ үргэлжлүүлсээр байжээ.

Чингис хаан Желал-ад-Динийг жинхэнэ эрэлхэг баатар хэмээн өндөр үнэлж, түүнээс үлгэр авахыг цэрэг дайчиддаа сануулж байсан гэдэг.

Зэв, Сүбээдэй нарын удирдсан цэрэг 1220 оны үед Азербайжанд хүрч улмаар дараа жил нь Гүржид нэвтрэн, 60 000 цэрэгтэй Гүржийн Лаша хааныг бут цохиод, Кавказыг давж, 1223 онд Калка гол дээр Оросын вангуудын цэрэгтэй тулалдан бут цохиод цааш нь Булгарт цөмрөн довтлоод буцсан байна.

Гэхдээ Чингис хааны үндэс суурийг нь тавьж, Ази, Европ хоёр тивийг дамнан оршиж байсан Монголын Эзэнт гүрний хил хязгаарын дотор улс төр, эдийн засаг, соёлын шинэ шинэ үзэгдлүүд үүсэн бүй болж байсныг эрдэмтэд бас нотлон өгүүлсэн байдаг.

Монголчууд эзэнт гүрний нутгийг сүлжсэн морин өртөө байгуулсан нь чухам тэр үедээ хамгийн шуурхай харилцаа холбооны хэрэгсэл байлаа. Өрнө, дорны худалдаачид, жуулчид, лам хувраг, улс төр, цэргийн хүмүүс өртөөгөөр дамжин нэвтэрч, Ази, Европ хоёр тивийн харилцаа Монголын Эзэнт гүрний үед урьд үзэгдээгүйгээр өргөжсөн юм. Мөн Европын худалдаачид хуурай замын зэрэгцээ бас Персийн булангийн усан боомтоор дамжин, Энэтхэг, Хятадад хүрэх, Оросын худалдаачид Азовын тэнгисээр дамжин Итали, Газрын дундад тэнгис, Бага Азид нэвтрэх шинэ шинэ усан замууд нээгдсэн байна. Өрнөдийн эд бараа дорнодод, дорны эд бараа тавaар өрнөдөд нэвтрэхийн зэрэгцээ бас зоосон болон цаасан мөнгө гүйлгээнд орох нь нэмэгдэж, худалдаа, гар үйлдвэрлэлийн хот, боомтууд шинээр бүй болсоор байжээ.

Монголын хаадын ивээл дор шинэ хот тосгодууд босч, олон орон судлалын төвүүд үүсэн, олон улсын эрдэмтэд тэнд ажиллаж байв. Ил хаан Өлзийт (1304-1311), Абу (1316-

Өгөөдэй хаан

1325) нарын үед баригдсан уран гоёмсог, тансаг сайхан барилгууд одоо ч Персийн уран барилгын гайхамшигт дурсгал хэмээн үнэлэгдсээр байна.

Тэр үеийн монголчуудын боловсруулан хэрэглэж байсан хууль, цаазууд эзлэгдсэн орнуудын хуулийн мэдлэг боловсролд нааштай нөлөө үзүүлж, зарим оронд газар тариалан монголын эрх баригчдын ивээлээр өргөжин хөгжиж байжээ.

Нэгэн түүхч Москвагийн вангийн нэр хүнд өссөн нь, Москва агуу их болсон нь, Алтан ордны улсад хотын соёл хөгжиж, уран

Монгол цэргийн дайралт
(Рашид-ад-Дин)

Хубилай хаан

Ази, Евопын олон орон нэгэн хүчирхэг төрийн жолоонд орсноор, тэдний урьдын өөр хоорондын тэмцэл хямрал, хуваагдмал байдал эцэс болж, өрнө, дорнын улс төр, соёл, худалдааны харилцаа эрс өргөжсөн юм.

Чингис хааны үндэслэн байгуулсан Монгол гүрэн нь өрнө, дорно дахиныг холбож, аж ахуй, соёл, хүмүүнлэгийн талаар нэгдэн, соёл иргэншлийн интеграци шинэ дэвшилд шилжин хөгжих нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тийнхүү Чингис хаан болон түүнийг залгамжлагчдын байгуулсан Монгол гүрэн дэлхий дахины



Монголын эзэнт гүрний нийслэл Хар хорум дахь асар (Рашид-ад-Дин)

дархны ажил, худалдаа өргөжиж байсан нь чухамдаа Монголын хаадын үйл ажиллагаатай холбоотой хэмээн тэмдэглэсэн нь санаандгүй хэрэг биш юм. Тухайн үед дэлхийд тэргүүлж байсан монгол цэргийн хатуу чанд зохион байгуулалт, байлдааны арга техник, бодлого, тактик олон оронд нөлөөлж, цэргийн салбарт шинэ зүйлүүд бий болж, цаашдын ул мөрөө үлдээсэн байна. Дэлхийн том шашнууд чухам тэр үеэс бие биетэйгээ өргөн танилцаж, нэгэн хотод христос, лал, бурханы шашин, даосизмын сүмүүд хамт зэрэгцэн оршиж, шүтэн бишрэх эрх чөлөө нээлттэй байсныг жуулчид гайхан тэмдэглэж байсан нь бидний үед уламжлан иржээ.



Хубилай хааны хатан Цэвэр

түүхэнд үлэмжхэн үүрэг гүйцэтгэж, өөрийн баларшгүй ул мөрийг үлдээжээ.

Чингис хаан бол Монголын төдийгүй дэлхий дахины түүхэнд мөнхрөн орсон улс төрийн сод зүтгэлтэн, цэргийн гарамгай жанжин гэдгийг түүх нэгэнт зөвшөөрөн хүлээжээ. Тэр нүүдэлчин монголчуудын нэрийг ч бас түүхэнд тэмдэглүүлсэн гавьяатай.

Нэрт түүхч Р.Груссе "Чингис хаан бол монголчуудыг дэлхийн түүхэнд эргэлт буцалтгүй оруулж өгсөн юм. Энэ бол түүний угсаа гарал нэгтнийхээ өмнө байгуулсан гавъяа юм" гэж үнэлжээ. Тэгээд ч Чингис, Монгол гэдэг хоёр нэр түүхийн туршид холбоотой явж, ертөнцийн чихнээ хамтдаа дуурсжээ. дуурсжээ. Дэлхийн соёлт хүн хэн боловч монгол хүнийг Чингисийн үр сад гэж үзэж, эртний сурвалжит үндэстэн хэмээн хүндэтгэдгийг бид мэдсээр байна. Чингис хаан бол монголчуудын сүр сүлд нь, бэлэг тэмдэг нь болон мөнхөрчээ.

А.Очир
С.Уранбилэг

XIV ЗУУНЫ ХОЁРДУГААР ХАГАСААС XVII ЗУУНЫ МОНГОЛ ОРОН

Хятадад төвлөрөн тогтнож агсан Монголын Юань улс (1262-1368) унаснаар Монголын эрх баригчид эх нутагтаа буцаж иржээ. Тэр үеэс Монголын феодалын бутрал хэмээн нэрлэгдсэн түүхийн нэгэн зурвас үе эхэлсэн байна. Монгол орон дотоод, гадаадаа хямрал зөрчилтэй, улс төрийн амьдрал төдий л тогтворгүй байсан нь тэр цагийн нэгэн онцлог шинж болж байв.

Хятад дахь ноёрхлоо алдсан Монголын эрх баригсад анхандаа өөрсдийн урьдын эрх мэдлээ сэргээхийг оролдсон боловч тэр нь бүтэлгүй болсон төдийгүй харин Хятадын Мин улсын түрэмгийлэл, цэргийн цохилтод өртөх болсон байна. 1372 онд Хятадын 15 000 цэрэг Монголд довтлон цөмөрч байсан бол, 1380 онд Мингийн их цэрэг Хар хорум хотыг шатаан түйвээсэн байна. Мин улсын эрх баригчид Монголын эрх баригсдыг цэрэг зэвсгийн болон дипломатын янз бүрийн аргаар шахан дарамталж, улмаар тус орныг эрхшээлдээ оруулахыг санаархаж байлаа.

Хятадын эрх баригсад зорилгодоо хүрэхийн тулд Монголчуудын дотоодын зөрчлийг өөртөө ашигтайгаар эргүүлэх, тэдний хооронд яс хаяж тэмцэлдүүлэн, хүчийг нь сулруулах, тэдний тархай бутархай байдлыг даамжруулахыг оролдож байв. 1409 оны Ойрад, Зүүн Монголын байлдаанд Хятадын цэрэг Ойрадад туслан Зүүн Монголыг цохиж байсан бол, 1413 онд тэд Зүүн Монголд туслан Ойрадын цэргийг цохилцож байжээ.

Энэ нь Монголчууд нэгэн төрийн захиргаанд орж, хүчээ нэгтгэхээс болгоомжлон, аль хүч нь өсч буй хэсгийг нь нөгөөтэй нь хамтран цохиж доройтуулах гэсэн хятадын эрх баригсдын бодлогын илрэл юм. Тэгэвч Монголчууд тусгаар тогтнолоо амжилттай хамгаалж байсан төдийгүй бас янз бүрийн шалтгаанаар хятадын хил хязгаарт үе үе цөмрөн довтолдог байв.

Тэр үеийн Монголчууд нь Хятадтай эдийн засгийн талаар өргөн харилцаж, суурин орны эд барааг мал, малаас гардаг түүхий эдээр сольж авахыг ихээхэн сонирхдог байж. Гэтэл Хятадын эрх баригсад өөрийн оронд очих Монголын худалдаачдын тоог хязгаарлах, хилийн боомтын худалдааг хаах, Монголын мал, түүхий эдийн үнийг бууруулах зэргээр дарамт шахалт үзүүлж байлаа. Энэ нь Монголчууд Хятадын хилд довтлох бас нэг шалтгаан болно.

1449 онд Монголын цэргийн гарамгай жанжин Т.Эсэн тайш Хятадын хаан Ин Цзунгийн удирдсан их цэргийг бүслэн бут цохиод Ин Цзун хааныг шадар туслах зарим жанждынх нь хамт байлдааны талбарт олзлон авсан нь түүхэнд ховорхон үзэгддэг тохиолдол байлаа.

Олон жил үргэлжилсэн Монголын улс төрийн хямрал бутрал нь Батмөнх (1464-1543) хааны үед намжиж, бүх Монгол нэгэн төрийн жолоонд орсон байна.

Батмөнх 1480 онд хаан ширээнд сууж, Мандухай хатны хамт бүх Монголчуудыг нэгтгэх үйлсэд хүчин зүтгэж, юуны өмнө, зүүн Монголын эв эеийг засч нэгтгэснийхээ дараа дөрвөн Ойрадыг байлдан захиргаандаа оруулжээ. Урьдын төрийн засаг засаглалд Батмөнх хаан зарим өөрчлөлт хийж, тайжийн тушаалын оронд жононг тавьж, Зүүн Монголын зуун түмнийг хаан өөрөө, баруун түмнийг жонон захирдаг болгов.

Тэр үед зүүн гурван түмэнд Цахар, Халх, Урианхай; баруун гурван түмэнд Ордос, Түмэд тус бүр нэжгээд түмэн; Юншээбү, Харчин, Асуд нийлээд нэг түмэд болж явав.

Тухайн үед хэдийгээр Монгол орон улс төрийн хямралтай, тархай бутархайдуу оршиж байсан боловч түүний эдийн засаг, соёл нь урагшлан хөгжиж, нийгмийн амьдралд нь шинэ шинэ үзэгдлүүд гарсаар байжээ. Тэрхүү шинэ содон зүйлс нь чухамдаа Монголын нийгмийн дотоод хөгжлийн үр дүнд буй болж байсныг цохон тэмдэглэвэл зохино.



XIV-XVI зууны үеийн сумны зэв, жадны үзүүр
Өвөрхангай, Хархорин
(МҮТМ)

Монголын эзэнт гүрний үед Монголын эрх баригсад, ноёдууд эзлэгдсэн орнуудын ард түмнээс үлэмжхэн эд баялгийг татварлан авч, өөрсдийн хэрэгцээгээ хангадаг байв. Гэтэл эзэнт улс унаснаар харь орнуудаас авч байсан тэрхүү татвар үгүй болж, Монголын эрх баригсад, ноёдууд чухамдаа дотоодынхоо эдийн засгийн чадамжинд голлон тулгуурлахаас өөр аргагүй болсон байна. Энэхүү нөхцөл байдал нь тэднийг улс орныхоо эдийн засгийг өөд нь татаж, аж ахуйгаа үр ашигтай, хэлбэрээр хөтлөн явуулахад түлхжээ.

XIV зууны үеийн цэргийн хувцас

Тэд бас Хятад болоод, Дундад Азийн орнуудтай худалдаа-эдийн засгийн харилцааг өргөтгөхийн хамт дотооддоо газар тариалангийн ажлыг урьдахаас нэмэгдүүлэх, гар үйлдвэрлэлийг өргөтгөхөд анхаарч байв. Тэрчлэн тухайн үед ан гөрөө нь мал аж ахуйн дараа орох чухал салбар болж, түүний эдийн засгийн ач холбогдол өсчээ.

Малчин монголчууд мал, түүнээс гарах ашиг шимийг сайтар боловсруулан, түүгээрээ амьдралын хэрэгцээгээ голлон хангаж байлаа. Малын үс ноос, арьс ширийг боловсруулан, гэрийн бүрээс, янз бүрийн хувцас хунар, мал аж ахуйн төрөл бүрийн тоног хэрэгсэл үйлдвэрлэн хэрэглэх нь өргөжижээ.

XIII-XIV зууны дунд үеийн Монголын нийгмийн зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь мянганы тогтолцоо байсан бол XV зууны эхнээс отог хэмээх шинэ зүйл буй болсон байна. Отог нь тодорхой газар нутаг, түүн дээрх малчин ардууд, тэдний мал хөрөнгөөс бүрдэж байв. Отгууд нь тухайн үеийн Монголын том ноёдын эзэмшил юм. Тиймээс тэдгээрийг тэр ноёны отог, энэ тайжийн отог хэмээн нэрийдэгдэж байв. Нэг отог нь хүн амын хувьд 1-5 угсаатны бүлэг буюу аймгаас бүрдэж байсан бөгөөд түүний эзний нэр нөлөө, улс төрийн байр суурьнаас хамаараад отгийн газар нутаг, хүн амын хэмжээ харилцан адилгүй байжээ.

Отог нь басхүү тухайн үеийн Монголын газар эзэмшиж эдэлбэрлэх гол хэлбэр, засаг захиргааны томоохон нэгжийн үүргийг давхар гүйцэтгэж байснаараа онцлог юм. Отгийн эзэд нь өөрийн отогт багтсан малчин ардуудаас татвар авдаг бөгөөд тэрхүү татварын хэмжээ нь тухайн хүн ам, мал сүргийн тоо, эдийн засгийн чадамжаас хамаарна.

Эзэн ноёд нь өөрийн отгийн газар нутаг, хүн ам, хөрөнгө чинээг нэмэгдүүлэхийн төлөө эрмэлзэн, бусад чадвар мөхөс ноёдын харьяат ардууд болон газар нутгийг булаацалдан, дайтах нь ч цөөнгүй байжээ.

Тийнхүү отгийн эздийн эдийн засгийн хүчин чадал өссөнөөс тэд харьцангуй биеэ дааж оршихийг эрмэлзэх нь нэмэгдэж байжээ. Энэ байдал нь тус тусдаа албат харьяат бүхий олон ноёдыг буй болгосноор Монгол орныг улс төрийн тархай бутархай байдалд оруулахад дөхөм болсон байна.

Отог мэдсэн ноёдын улс төрийн нэр нөлөө ч нэмэгдэж, улмаар их хааны төвлөрсөн засаглалд тэр бүр захирагдахыг хүсэхгүй болсоор байв. Энэ нь тухайн үеийн Монгол улсын улс төрийн эв нэгдэлд харшлах болжээ.

Тэр үед харьцангуй богино хугацаанд олон хаад солигдож байв. Тэдгээр хаадын зарим нь улс орноо бүрэн дүүрэн төвлөрүүлэн захирч, хүчийг нь зангидаж хараахан чадахгүй байлаа. Энэ үеийг Монголын түүхэнд *бага хаадын үе* хэмээх нь буй. Тийнхүү бага хаад гарч ирсэн нь Монгол орон улс төрийн бутралд автсаны нэг шинж тэмдэг нь байв. Том ноёд их хааны төвлөрсөн засаглалаас аль болохоор зайлахыг оролдон агсан тэр үеийг басхүү Монголын бутралын үе гэж нэрлэсэн нь буй.

XVI зуунаас Монголын нийгэмд үзэгдсэн нэгэн содон зүйл бол бурхны шашин нэлээд эрчимтэй дэлгэрсэн явдал юм. Тухайн үед урьдын бөөгийн мөргөлийг халах, бурхны шашныг дэлгэрүүлэхэд чиглэсэн хууль цаазууд батлагдан гарч, шашны зүтгэлтэн, мяндагтан нарын эрх мэдлийг бататган бэхжүүлж байжээ.

Шашин дэлгэрсэнтэй холбогдон Монголд хүрээ, хийд, бусад суурин газрууд шинээр үүсэн буй болж, аажимдаа тэдний тоо олширч байв. Тиймэрхүү хүрээ хийд, хот суурингуудын зарим нь өдгөө уламжилж ирсэн байна. Үүнд: Хөх хот, Хар бух балгас, Эрдэнэ-Зуу, Тарнын өвгөн хийд, Сарьдагийн хийд, Цогтын цагаан байшин зэргийг дурьдаж болно.

Бурхны шашин монголд орж ирсэнийг дагалдан, Энэтхэг, Түвэдийн их, бага арван ухаан нэвтэрч, Монголчууд тэдгээртэй танилцан, дорно дахины олон салбар ухаанд суралцаж байв.



XIV-XV зууны үеийн хүрэл чимэглэл
Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум, Арцат
(МҮТМ)



XIV-XV зууны үеийн монгол цэргийн
сумны үйсэн хоромсого, нум, сум
(МҮТМ)

Ялангуяа шашны олон зуун ном зохиолыг монголчлон, тэдгээрийг гар бичмэлээр болон модон бараар хэвлэн, тараан агсан нь энэтхэг-түвдээс гаралтай хүн, мал эмнэлэг, одон зурхай, цаг тооллын мэдлэг, бурхны шашны гүн ухаан Монголд нэвтрэн идээшихэд дөхөм үзүүлсэн байна.

Тухайн үед монголчуудын дотроос Хорчины Аюуш гүүш, Халхын Цогт тайж, Хөх хотын Ширээт гүүш цорж



зэрэг эрдэм боловсролтой хүмүүс төрөн гарч, төвөд хэлнээс ном зохиол орчуулж, бас өөрсдөө зохиол бүтээлээ туурвиж байв. Монголын 35 хэлмэрч хүч хавсран, Гунгаа-Одсэр хэмээх эрдэмтний удирдлагаар "Ганжуур" хэмээх их хүндтэй судрыг Төвөд хэлнээс орчуулж, 1628-1629 онд 113 боть болгон нийтэлжээ.

Монголчууд энэтхэг-төвэдийн гаралтай бурханы шашны соёлын зүйлийг тэр чигээр нь хуулбарлан авч хэрэглэсэнгүй түүнийг монгол аж амьдралд тохируулан, өөрсдийн соёлын өвөрмөц байдалтай уялдуулан идээшүүлж байлаа. Тиймээс монголд дэлгэрч, идээшлийг олсон бурханы шашны нэлээд зүйлс нь яг тэр энэтхэг-төвэдийн унаган төрхөөрөө бус, түүний монголжсон хувилбар маягтай болж хөгжсөн байна.

XVI-XVII зууны үед монголчуудын бичгийн соёлд үзэгдсэн нэг сонирхолтой зүйл бол хус модны үйсийг тусгайлан боловсруулан, цаас мэт болгоод түүн дээр ном бичдэг технологи нэлээд өргөн дэлгэрч байсан явдал юм. Тийнхүү үйсэн дээр бичсэн номууд Монгол улсын Булган аймгийн Дашинчилэн сум, Увс аймгийн Бөхмөрөн сум, Өвөр Монголын Олон сүм зэрэг газраас олдсон байна.

Тэр цагт Монголд уран зураг, баримлын урлаг хөгжиж байв. Тэдгээрийн ихэнх нь бурханы шашны сэдэв агуулга бүхий аж. Сүм, дуган, хийдэд ханын зураг, чимэглэл хийх нь элбэгшиж, голдуу шороон будгаар янз бүрийн бурхад, шашны домгийн сэдэвт уран зургууд зурдаг байжээ. Тэрчлэн урчууд цутгуурын урлагийг хөгжүүлж, олон арван гайхамшигтай бүтээл туурвисаны зарим нь манай үед хүрэлцэн иржээ. Тэдний дундаас Занабазар (1635-1723) өөрийн гэх цутгуурын урлагийн сургуулийг бүй болгож чадсан нь хожим уламжлагдсан байна.

XVI-XVII зууны үед монголчууд өөрсдийн түүхийг бичих ажил эрчимжин, "Цагаан түүх", "Лу Алтай товч", "Шар тууж", "Эрдэнийн товч", "Алтай товч", "Эрдэнийн тунамал нэрт судар" зэрэг зохиолууд туурвисан нь бидний үед хүрэлцэн ирсэн байна.

Тэр үеийн Монголын түүх бичлэгт бурханы шашны нөлөө тусч байсан боловч дээрх зохиолууд нь тухайн цагийн монгочуудын нийгэм, улс төрийн амьдрал болон оюун санааны хөгжлийг танин мэдэхэд чухал хэрэглэгдхүүн болж байна.

Зүүнгар хаант улс. XIII зууны сүүлчээр Зүүнгар хаант улсыг монгол угсааны ойрадууд байгуулж, төрийн эрхийг нь барьж байв. Ойрадууд XII-XIII зууны эхэнд Байгаль нуурын баруун, Хөвсгөл нуурын зүүн хойд захаар ой хөвчийн ангуучин аймгууд, тал хээрийн монголчуудын завсар хооронд нутаглаж байжээ.

1207 онд Чингис хааны ахмад хүү Зүчи ойн иргэдийг дагуулахад, Ойрадын ноён Хутуга бэхи түмэн Ойрадаа дагуулан уггаж ирсэнд, Чингис хаан талархан өөрийн охин Чэйхэнийг түүний ууган хүү Иналчид, удаах хүү Төрөлчид нь Зүчийн охин Холуйханыг хатан болгож өгсөнөөр худ бололцжээ. Чингис хаан Ойрадуудыг бие даасан

дөрвөн мянган болгож, Их монгол улсын баруун жигүүрийн түмэнд оруулж, мянганы ноёдоор Хутуга бэхи нарыг томилсон тэр үеэс гэднийг дөрвөн Ойрад хэмээн нэрлэх болжээ. Ойрад гэх нэрийг судлаачид "Ойн ард" гэсэн үгнээс гаралтай хэмээн үздэг.

Ойрадууд XIII зууны II хагасаас Завхан, Хүнгүй гол, Алтайн зүүн биеээр нутаглах болжээ.

Монголын Юань гүрэн унасны дараа Ойрадуудын баруун хэсэг нь Доголон төмөр хааны харъяанд хэсэг хугацаанд орсон боловч, тэдний ихэнх нь Зүүн монголтой илүү дөт харилцаатай байсан юм.

XV зууны эхээр Ойрадад Махамуд, Батболд, Тайван нарын томоохон ноёд хүчирхэгжин биеэ даасан бодлого явуулахыг оролдов. Тэр цагт Хятадын Мин улс Ойрадыг Зүүн монголын эсрэг турхирч хагаралдуулах бодлого явуулж байжээ. Мин улс Ойрадын талд цэргээр тусалж, Онон голд Зүүн монголын цэргийг цохиж байсан бол, 1414 онд Хэрлэн голд болсон тулалдаанд Зүүн монголд туслах нэрийдлээр цэрэг оруулж, Ойрадын цэргийг цохиж байжээ. Гэвч Ойрадын хүч өссөөр байв.

XV зууны дундаас Ойрадын хүн амын бүрэлдэхүүн болон газар нутгийн хувьд зарим өөрчлөлтүүд гарч, Баатуд, Ар монгол, Асуд, Барга, Буриад зэрэг аймгууд тэдний дотор үзэгдэх болжээ. Тэр цагт Ойрадууд Завхан голоос баруун тийш Алтайн уул, Эрчисийн эх, Бархөл, Хами, Ордосын баруун хойгуур тархан нутаглах болов.

XVI зууны үеэс Ойрадад чуулган хэмээх өвөрмөц байгууллага буй болсон бөгөөд энэ нь Ойрадын эрх баригчдын зөвлөлдөх байгууллага байжээ. Ойрадын цэрэг ерөнхийдөө чуулган даргын мэдэлд байдаг боловч шаардлагатай үед тусгай хүмүүсээр цэрэг удирдуулж, өрлөг, хошууч зэрэг цол хүртээж, зарим тохиолдолд уг цолыг үе улируулдаг байв.

XVII зууны үед Ойрадад гарсан томоохон үйл явдлуудын нэг бол Торгууд, Хошууд, Дөрвөд аймгийн ихэнх нь Ижил мөрөн, Баруун Сибирь, Хөх нуур, Түвэд зэрэг газар руу алслан нүүсэн явдал байлаа. Энэ явц нь Алтай нутагтаа үлдэгсдийн олонхи болох Цорос аймаг түүний ноёдын нэр нөлөө өсөхөд түлхэц болжээ. Цоросын тэргүүлэгч Эрдэнэбаатар хунтайж өмнө нь гадагш нүүж одогсодтой ч харилцаагаа таслалгүй тэднийг Ойрадын чуулганд оролцуулж, холбоотон хэвээр байхыг эрмэлзэлж байв.

Тэр үест нийт монголын түүхэнд гарсан нэг шинэ зүйл бол 1640 оны Монгол-Ойрадын хамтарсан чуулганаар "Их цааз" хэмээх хуулийг баталсан явдал юм. Энэ хууль нь Монгол оронд бурханы шашиныг дэлгэрүүлэн хөгжүүлж, улсын шашин болгосныг нийтэд зарлах, бөө мөргөлийг халахыг хуульчилсан байв.

Эрдэнэбаатар хунтайж болон түүнийг залгамжлагч Сэнгэ нарын үед Ойрадын дотоод байдал намжихын сацуу гадаад харилцаа харьцангуй тогтворжиж, суурин газар, сүм хийд баригдаж, газар тариалан эрхлэх болсон төдийгүй гадаадын худалдаачид ч үзэгддэг болжээ.

Галдан Бошигт хаан (1644-1697)

Ойрадын эрх баригч Сэнгэ өөрийн эх ондоотой дүү Цэцэн, Зодов нарт 1671 онд хорлогдсон нь Түвэдэд шавилан сууж байсан Сэнгийн төрсөн дүү Галданг (1644-1697) буцаж ирэхэд хүргэжээ. Галдан эргэж ирмэгц эрчимтэй ажилласны дүнд, 1676 онд Ойрадыг нэгтгэн өөрөө Зүүн гар улсын хаан ширээнд суусан байна. Галдан хаан суусныхаа дараа олон шинэ арга хэмжээ авч явуулсны нэг нь 1678 онд Зүүнгарын засаг захиргааг шинэчлэн чангатгаж, нэг отгоос нөгөөд дураараа шилжихийг хориглосон хууль гаргасан нь "Галдан хунтайжийн захиа зарлиг" хэмээн алдаршжээ. Мөн Галдан Ойрадад Бурханы шашныг гүнзгийрүүлэн бэхжүүлэхэд анхаарч Гагба, Ламарим 2 жас, мөн бусад сүм хийд байгуулсан байна. Түүний үед Зүүнгарт анх удаа зоос цутган хэрэглэжээ.

Ойрадын хаант улс нь төр ёсны бэлэг тэмдэгүүд, тогтсон ёс журамтай байжээ. Галдан бошгот хаан тод, дөрвөлжин, түвэд үсгийн гурван зүйл тамгатай бөгөөд тэдгээрийг учир ялгаатай хэрэглэдэг байсан аж. Түүний дараагийн Цэвээнравдан хаан ч уламжлалыг залган, төрийн тамгыг улаан шунхаар дардаг байв. Зүүнгар улсын хааны тамга нь дугираг хэлбэртэй алтаар хийсэн байдаг. Зайсангаас доошхи хүмүүс нь мөнгө, зэс, төмөр, цагаан тугалгаар тамга үйлдэн хэрэглэдэг байжээ.

Зүүнгарын хаан Галдан, Цэвээнравдан, Галданцэрэн нар тусгаар тогтнолоо хамгаалахын төлөө тууштай тэмцэж байсан юм. Эдгээр хаадын үед Орос, Түвэд болон Дундад азийн зарим улс, Хятад, Манжтай харилцаж худалдааны хөсөг олноор илгээж байв.

Ойрадууд засаг захиргааны зохион байгуулалтын хувьд XIII-XIV зууны үед уламжлалт аравтын системтэй байсан бөгөөд нийгмийн харилцаа цаашид хөгжих явцад том ноёдын эдийн засгийн хүчин нэмэгдэхийн хирээр тэдний бие даах эрмэлзэл өссөөр байлаа. Энэ хандлага нь хуучин аравтлан захирах тогтолцоог сулруулж, XV зууны эхэн гэхэд Ойрадууд харьцангуй бие даасан хэдэн том хэсэгт хуваагджээ. Ингэхдээ гол төлөв урьд нь дөрвөн мянган болж явсанаараа хуваагдсан бололтой. Хэсэг бүрийг нь толгойлсон гол аймгийн нэрээр нь тэднийг нэрлэж байв. Ойрадын бүрэлдэхүүнд байсан тэр дөрвөн хэсэг нь хоорондоо цусан төрлийн холбоогүй, харин газар нутгийн нэгдлээр бэхжсэн ноёнт улсын шинжтэй байжээ.

XVI зууны эцсээр нийт Ойрад дөчин хошуунаас бүрэлдэж, баруун, зүүн хоёр гарт хуваагдаж явжээ. Тэр цагт Ойрадын баруун гарт нь Хошуудын таван хошуу, Торгуудын таван хошуу, Хойдын таван хошуу, Жирэдийн таван хошуу зүүн гарт нь Цоросын арван хошуу, Ширасын таван хошуу, Махасын таван хошуу ордог байв. Ойрадууд ингэж хоёр гарт хуваагдаж явсанаас Зүүнгар гэдэг нэр үүсчээ. Тэр үеийн Ойрадын хошуудын хэмжээ, хүн амын тоо,

эдийн засгийн хүчин чадал адилгүй байсан боловч хошуу нь газар эзэмшлийн үндсэн хэлбэр болж байжээ. Ойрадын Зүүн гарыг толгойлж явсан Цоросын ноёд Ойрадын хаант улсыг байгуулаад, түүнийгээ өөрсдийн багтдаг газрын нэрээр Зүүнгар хэмээн нэрлэжээ.

Тэд нүүдлийн мал аж ахуйг голлон эрхэлж, газар тариаланг тодорхой хэмжээгээр хөгжүүлж байв. Эрдэнэбаатарын үеэс янз бүрийн тариа, ногоо тариалж байсан нь Цэвээнравдан, Галданцэрэн нарын үед нэлээд өргөжжээ. Зүүнгарын ноёд Аксу, Яркенд, Кашгар, Турфан зэрэг хот суурин эрхшээлдээ оруулснаа ашиглан, тэндээс тариачдыг авчран Или, Бор тал, Цагаан ус, Эрчис голын сав дагуу тариа, ногоо тариулахаас гадна өөрсдөө ч газар хагалж, улаан буудай, хоног аму, арвай, шар будаа тарьж байсан байна. Гол төлөв суурин орноос авчирсан хүмүүсээс бүрдсэн 3000 шахам өрхтэй нэг отгоор хааны хэрэгцээний тариа, ногоог тариулж байжээ.

Зүүнгар улсад гар урлал нилээд хөгжиж, цаг үеийн байдлаас болж хуяг, дуулга, илд, жад, буу, сум хийхэд ихээхэн анхаарч, Швед, Орос гаралтай олзлогдогсдыг ашиглан гурван янзын буу цутгуулж байснаас гадна зэс, мөнгөөр ахуйн хэрэгцээний болон гоёлын янз бүрийн эдлэл хийж чаддаг байсан аж.

Зүүнгар улсын хааны харъяат эзэмшлийг отог гэх ба отог бүр тус тусдаа нэртэй байлаа. Отогийн тоо XVII зууны үед 12 байсан бол XVIII зууны дунд үе гэхэд 24 болтлоо өсчээ. Отгийг зайсан захирах бөгөөд тухайн отгийн хүн ам, газар нутгийн хэмжээнээс шалтгаалан нэг отгийг 1-3 зайсан мэдэж байжээ. Отогийн гол үүрэг бол элдэв албан татварыг хаанд тушаах явдал байв.

Мөн XVIII зууны тэргүүн хагаст ихэнхи нь Хотон, Турфан дархчуулаас бүрдсэн 1000 орчим өрхтэй цэргийн зэр зэвсэг хийдэг нэг отог байгуулсан нь буучин отог хэмээн нэрлэгдэж явжээ.

Цэвээнравдан бас Оросоос хүмүүс авчран гар урлалын ажил хийлгэж, арьс шир, нэхий боловсруулж, бичгийн цаас үйлдэж, цэмбэ, ёрог нэхэж байжээ. Хааны орд өргөөг засаж сэлбэх, зарим хэрэгцээт эдлэлийг хийх үүрэг бүхий 3000 орчим өрхтэй Урад (урчууд) гэх отог байсан тухай мэдээ бий.

Зүүнгар улс нь хэдэн том аймгаас бүрэлдэж байсан бөгөөд хэсэг бүрийг нь том ноёд толгойлно. Тийм том ноёд, тайж нарын эзэмшлийг анги гэнэ. XVIII зууны эцсээр Зүүнгарт 21 анги байсны 6 Цорос аймагт, 4 нь Дөрвөд аймагт, 1 нь Хошуудад, 8 нь Хойд аймагт, 2 нь Торгууд аймагт байжээ.

XVIII зууны тэргүүн хагасын үед Зүүнгарын нийт хүн ам нь 600 000 орчим, өрх нь 200 000 орчим байсан байна. Эдгээр хүмүүс нь хэд хэдэн давхраанд хуваагдаж байжээ. Ойрадын язгууртан нар нь Цорос, Хошууд, Торгууд, Хойд, Жирэд, Шарс, Махас долоон овгоос төрөн гардаг байв. Тэдгээрийн дотор тоогоороо ч, нөлөөгөөрөө ч Цоросын ноёд тэргүүн байр эзэлж байв. Дөрвөдийн ноёд нь Цоросоос салбарласан учир мөн үүнд багтана. Цорос нар нь угтаа Бөртэ чоны удам Дуба сохорын угсаа, Хошуудын язгууртан нар Чингисийн дүү Хасарын угсааныхан, Торгууд нар Хэрэйдийн Тоорил ханы үр хойч байсан билээ.

Зүүн гар улсын дээд давхрааны нэг хэсгийг том лам нар бүрдүүлж байжээ. Тэд ихэвчлэн ноёдын гэрээс гаралтай хүмүүс бөгөөд шашин сүм хийдийн үйл ажиллагааг удирдан зохицуулж, хуваарьт нутаг эзэмшин, мал сүргээ ардуудаар хариулган өсгүүлж байв. Ойрадад шашин хүчтэй дэлгэрсэн XVII зууны үест лам нар болон сүм хийдийн тоо олширч, Зүүнгарын аймаг бүр өөртөө тусгай хүрээтэй, зарим том аймаг нь хэд хэдэн хүрээтэй байснаас хамгийн том, нэр хүндтэй нь Цоросын Алтан гулз (угалз) хүрээ байжээ. XVIII зууны үед Зүүнгарын нийт лам нар 6000 гаруй болоод байсан нь барагцаагаар тус улсын зуун хүн тутмын нэг нь лам байжээ. Том сүм хийд, лам нарын эзэмшлийг жас хэмээн нэрлэж, түүнийг зайсан нар захирч, бэлчээр нутаг хуваарилах, татвар хураах хутагт хувилгаадад нийлүүлэх ажлыг хариуцна. Зүүнгар улсад нийт бие даасан 9 жас байсны тав нь Зүүнгар улс байгуулагдсаны дараахан буй болсон бол дөрөв нь хожим XVIII зууны эхэн үед нэмэгдсэн байна. Эдгээр есөн жасыг арваад зайсан захирч байжээ. Лам нар улсын аливаа албан татвараас чөлөөлөгддөг байсан тул лам болох хүсэлтэй ардууд ч олон байв.

Ойрадын эрдэмтэн лам Намхайжамц (1599-1662) 1648 онд Тод үсгийг зохиож, өөрийн шавь нарын хамт түвэд хэлнээс хэдэн олон судар номыг монголчлон, тод бичгээр бичиж, бас барлан тархаасан байна. Намхайцамж шавь нарын хамт тод бичгийн утга зохиолыг үндэслэн буй болгосон байна.

Зүүнгар улсын хаан Галданцэрэнг нас барсны дараа тус улсын дотоодод хаан ширээний төлөөх тэмцэл хүчтэй явагдаж эхэлсэн бөгөөд энэ зуурт Галданцэрэнгийн хүү Цэвээндоржнамжил, Ламдаржаа болон түүний дүү Даваач нар хаан ширээнд ээлж дараалан суусан боловч дорвитой амжилтыг олсонгүй явсаар 1755-1758 онд Зүүнгарын хаант улс Манжийн түрэмгийлэгчдэд эзлэгдсэн юм.

Тийнхүү Зүүнгар хаант улс байгуулагдан оршин тогтнох хугацаанд Ойрадын нийгэм, үйлдвэрлэл, соёл мэдэгдэхүйц ахиц олж, улмаар Ойрад Монголчуудын улс төр, газар нутаг, соёл, угсаатны нийтлэг бүрэлдэн хөгжихөд түлхэц болжээ.

А.Очир
С.Уранбилэг

МАНЖИЙН ЭРХШЭЭЛИЙН ҮЕИЙН МОНГОЛ ОРОН

XVII зуун бол Төв азийн олон улсын харилцаа нарийн төвөгтэй, зөрчил тэмцэл ихтэй үе байв. Уг зууны эхээр Манж Чин улс байгуулагдан бэхжмэгцээ Хятадын Мин улс, Монгол улс, Төвөд зэрэг орныг эзлэх түрэмгий бодлого явуулж эхлэв.

Тэр цагт Орос улс Сибирийг эзлэхэд үлэмж анхаарал тавьж, улмаар Монголчуудын хойноос шахан түрсээр байлаа. Энэхүү эгзэгтэй цагт Монгол орон улс төрийн бутралд автан, Өвөр Монгол, Халх Монгол, Ойрад буюу Баруун Монгол хэмээх гурван хэсэгт хуваагдаад байсан төдийгүй, өөр хоорондоо ч тэмцэл зөрчилтэй байв. Монголын улс төрийн зүтгэлтнүүд тус орны тусгаар тогтнолд нүүрлэн ирсэн Манжийн түрэмгийллийн эсрэг тэмцэлд хүчээ нэгтгэхийг оролдсон боловч төдий л бүтэмжтэй болохгүй байв.

Монголын сүүлчийн их хаан Лигдэн хутагт Өвөр Монгол, Халх Монголчуудыг нэгтгэхийг оролдсон боловч салан тусгаарлах сонирхолтой ноёд түүнд захирагдахгүй байв. Өвөр Монголын зарим ноёд Халхыг түшин нүүдэллэх, зарим нь манжид дагаар орох зэргээр бутран сарниж байв. 1632 онд Манжийн хаан Цахарт довтлон түүнийг эзлэн авчээ. Лигдэн хааны сүүлчийн тулгуур хүч болж агсан Цахар Манжид эзлэгдсэн нь түүнд хүчтэй цохилт болов. Лигдэн Хөх нуурт очиж, хүчээ сэлбэхээр зорьж явaад 1634 онд замдаа нас барж, 1636 онд Өвөр Монгол Чин улсад эзлэгдэв.

Тэр үед Халх, Ойрад Монголчууд өөрсдийн эв нэгдлийг бэхжүүлэн, бурханы шашны тугийн доор нэгдэхийг оролдон, 1639 онд Г.Занабазарыг Монголын бурханы шашны тэргүүнээр өргөмжлөн, 1640 онд Халх-Ойрадын хамтарсан «Их цааз» хэмээх хуулийг батламжлан, хуучин бөөгийн мөргөлийг халж, бурханы шашныг улсын шашин болгож хуульчлав.

Бүх Ойрадыг нэгтгэн, түүний хаан ширээнд 1676 онд суусан Галдан Халх, Зүүнгар улсын нэгдсэн хүчээр Манжийн түрэмгийллийн эсрэг тэмцэхийг зорьж байв. Гэвч Галдангийн Халхтай тайван замаар хүчээ нэгтгэх оролдлого амжилтгүй болсонд тэрбээр Халхыг цэргийн хүчээр нэгтгэхээр 1688 онд Халхад довтолсон байна. Гэтэл Халхчууд Чин улсын хязгаарт зугатан ороод, Манж улсад дагажээ. Тийнхүү 1691 онд Манжийн хаан Халхчуудыг өөрийн харъяат болгосноо албан ёсоор зарлав.

Халхчуудыг харъяандаа оруулсан Манжийн хаан Өвөр Монгол, Барга, Халхын цэрэг, эдийн засгийн хүч чадамжийг дайчлан, Галдангийн эсрэг довтолж, 1696 онд түүний гол хүчийг бут цохисон бөгөөд 1697 онд Галдан нас баржээ. Манж нар 1755-1758 онд Зүүнгар хаант улсыг байлдан эрхшээлдээ оруулан авав. Манжийн эрх баригсад урьд нь эзлэн авсан улс орнуудын, түүний дотор Монголчуудын цэрэг, эдийн засгийн хүчийг дараачийн хэсгийг нь түрэмгийлэн эзлэхэд дайчлан ашиглах замаар зорилгодоо хүрсэн байна. Энэ бол тэр үеийн Монголчуудын улс төрийн эв нэгдэл сул, удирдагч нар нь бие биеэ ойлгож, улс орныхоо тусгаар тогтнолын төлөө нэг шугам дээр тууштай зогсч чадаагүйн харгай, Монголчуудын түүхэнд тохиолдсон гашуун сургамж юм.

Чин гүрний эрх баригсад Монгол орныг эзлэн авмагцаа өөрийн засаг захиргаа тогтоосон байна. Тэд юуны өмнө өөрийн төлөөний сайд, жанжны газруудыг байгуулж, Монголчуудыг захирах болжээ. Их Хүрээнд суусан манж сайдын газар Халхын Сэцэн хан, Түшээт хан хоёр аймаг, тэдний нутаг дахь харуул, өртөөдийг; Улиастайн Манж жанжны газар Засагт хан, Сайн ноён хоёр аймаг, тэдний нутаг дахь өртөө, харуулуудыг; Ховдын сайдын газар нь Ховдын хязгаарын Монголчууд болоод, Тува нарыг эрхлэн захирдаг байв. Тэрчлэн дээрх Манж сайд, жанжны газрууд нь өөрсдийн шийдвэрлэж чадахгүй асуудлыг Бээжин дэх Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яаманд тавьж шийдвэрлүүлдэг аж. Гадаад Монголын Төрийг Засах

Манж Чин улсын үеийн тамганууд
(МҮТМ)



Явдлын Яам нь Манжийн төрийн Монголын асуудлыг эрхэлсэн дээд байгууллага нь байв.

Манжийн эрхшээлийн үеийн Монголын засаг захиргааны үндсэн нэгж нь хошуу юм. Хошууд нь тухайн аймгийнхаа чуулганд харъяалагдана. Аймгийн чуулган нь нэг аймгийн эрх барих дээд байгууллага бөгөөд 3 жилд нэг удаа хуралдаж, аливаа хуримтлагдсан асуудлуудыг шийдвэрлэнэ. Аймгийн чуулганы дарга нар нь мөн 3 жилээр ээлжлэн томилогдож ажиллана. Тийнхүү Монголын ноёд Манжийн эрхшээлийн үед улс орноо удирдах эрх мэдлээ алдаад, зөвхөн өөр өөрийн хошууг Манжийн тогтоосон хуулийн хүрээнд болзолт байдлаар захирагч нар болон хувирчээ. Хошууны дотор сум хэмээх бага нэгж байсан бөгөөд нэг сумыг 150 өрхөөр байгуулдаг байв.

Манжийн хаанаас тусгайлан тамга олгосон шавь захирах эрх бүхий хутагтууд тэр үеийн Монголд нэлээд олон байв. Тэдгээрийн хамгийн нэр нөлөө бүхий нь Живзундамба хутагт юм. Живзундамбын шавь нар нь өөрийн тусгай нутагтай байсан бөгөөд бусад тамгатай хутагтуудын шавь нар нь тухайн хошууны нутагт багтдаг байжээ. Тамгатай хутагтуудын засаг захиргааны үндсэн нэгж нь отог юм. Отогууд нь тухайн хутагтын хэрэгцээний бүх зүйлийг бэлтгэн нийлүүлэх үүрэгтэй бөгөөд харин улсын чанартай албан татвараас чөлөөлөгдөнө. Зайсан хэмээх албан тушаалтан отогуудыг газар дээр нь захирч, хутагтад нийлүүлэх эд зүйлсийг хөөн гаргуулна. Тэр үеийн сүм хийдийн аж ахуйн зохион байгуулалтын хэлбэр нь жас байв. Манжийн төрийн албанаас чөлөөлөгдсөн жасууд мал аж ахуй, газар тариалан, худалдаа, мөнгө хүүлэл, жин тээвэр эрхлэж байв.

Тэр үеийн Манжийн алба татварууд нь Монголчуудын амьдралыг доройтуулагч хүчин зүйлийн нэг болж байв. Тэрхүү алба татварыг Монголчууд эд хөрөнгөөр болон биеийн хүчээр гүйцэлдүүлнэ. Эрчүүдийг цэрэгт татах, өртөө,

харуулд гэр бүлийн хамтаар дайчлан суулгах, Манжийн хааны мал сүргийг адгуулгах болон орон нутаг дахь Манжийн засаг захиргааны зардал зэрэг олон албыг Манж нар Монголчуудаар гүйцэтгүүлж байв.

Манжийн эрхшээлийн үед Монголчууд уламжлалт нүүдлийн мал аж ахуйгаа голлон эрхэлж байлаа. Монголчууд мал аж ахуйг хөтлөх ажилд шинэ арга технологи нэвтрүүлэх, зарим туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд анхааран, аж ахуйгаа өөд татахыг чармайж байв. Тухайн үед Сэцэн хан Артсэд, засаг ноён Тогтохтөр, Пүрэвжав нарын хүмүүс малын үүлдэр угсааг сайжруулах, шилмэл үүлдэр бий болгох, мал маллах арга ухаан, аж ахуй хөтлөлтөнд шинэ арга барил нэвтрүүлэх талаар шинэлэг зүйлсийг хийж байлаа.

Манжийн эрхшээлийн сүүл үед дотоодын зах зээл дээр ангийн үс, эмийн үнэт түүхий эдийн үнэ ханш нэмэгдэхийн зэрэгцээ ангийн буу зэвсэг, багаж хэрэгсэл элбэгшсэн нь ан агнуурын ажилд ахиц гаргахад нөлөөлжээ.

XIX зууны сүүлчээр Монголд орон нутгийн шинжтэй мөнгөн тэмдэгтүүд гарч, гүйлгээнд үзэгдэх болов.

Монголчууд эртнээс газар тариалан бага сага эрхэлж ирсэн боловч Манжийн эрхшээлийн үед урьдахаас илүү өргөн эрхлэх болж тариалах талбай хийгээд хураан авах ургац ч нэмэгдсэн юм. Гол төлөв Хятад иргэд Монголд ирж газар хагалан тариа тарьж байсан ч нутгийн Монгол иргэд, Оросууд ч тариа тарих болжээ. Хэдийгээр газар тариалангийн ажилд ахиц гарсан боловч аж ахуйн бие даасан салбар болтлоо хөгжиж чадаагүй, туслах аж ахуйн шинжтэй байлаа.

Тэр үед Монголын эдийн засагт үзэгдсэн нэг шинэ зүйл бол гадаадын худалдаачид олноор нэвтрэн ирж, худалдаа, арилжаа хийдэг болсон явдал юм. Монгол дахь гадаадын худалдаачдын дотор Хятадын худалдаа онцгой байр эзэлж байв. Манжийн эрх баригсад 1720 онд Их Хүрээнд Хятад худалдаачдын хэрэг эрхлэх Жургааны Зангийн газрыг байгуулжээ. Хятад худалдаачид Монголчуудад бараагаа өндөр хүүтэй зээлдүүлж Монголчуудыг төлж баршгүй өрөнд унагаж байв. Манжийн алба нь Хятад худалдаачдад Монголчууд өр тавих бас нэг хүчин зүйл болж байжээ.

Манжийн үеийн тамганы хайрцаг, эмээл (МҮТМ)

Хятад худалдаачид худалдаа хийхийн сацуу мөнгө хүүлж байв. Сүлдээ Манж сайд ч энэ хэрэгт оролцон, худалдаачидтай сүлдбэлдэн Монголчуудыг мөлжих болжээ. Хятадын худалдаа, мөнгө хүүллийн үр дүнд Монголын мал аж ахуйн хөгжил саатаж, зээлсэн өрийн төлбөрт олон мал одож байлаа.

Тухайн үед Хятадын худалдаачдаас гадна Европ, Америкийн худалдаачид Монголд үйл ажиллагаагаа явуулж байв. Түүнчлэн Монголын зарим чинээлэг баячууд, худалдаачид Орос, Хятадын хотуудад очин түүхий эдээ борлуулж, хэрэгцээт зүйлсээ авчран худалдаа хийж байсан ч Хятад худалдаачид өөрсдийн давуу байдлаа ашиглан, шинээр төрж байсан Монгол худалдаачдад янз бүрийн дарамт шахалт үзүүлдэг байжээ.

Хятад болон Оросын худалдааны үйл ажиллагаа нь Монголын эдэлхүүний аж ахуйг задлан, тавaар мөнгөний харилцааны эхлэлийг тавьж, Монгол орон дэлхийн зах зээлийн харилцаанд татагдан ороход түлхэц болж, Европын соёл иргэншилтэй Монголчуудыг танилцахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна. Гэвч Монголын зах зээл гадаадын худалдаачдын гарт орж, Монгол орон эдийн засгийн хувьд тэдний хараат болж, түүхий эд

нийлүүлэгч болж хувирсан нь үндэсний эдийн засгийн цаашдын хөгжилд сөрөг үр дагаврыг авчирсан байна.

Өгүүлэн буй үед Монголд анхан шатны бичиг үсгийн сургуулиудыг байгуулж Манж, Хятад, Монгол бичиг зааж Монгол дахь Манжийн засаг захиргааны бичээч, түшмэдийг бэлтгэж байв. Харин тэр үеийн боловсролын салбарт шашны боловсрол олгох сургуулиуд ноёлж байлаа. Их Хүрээнд Дүйнхор зурхайн дацан, Буддын гүн ухааны гоман игчааны Дашчоймбол дацан, Эмчийн дацан, Жүдийн дацан, Гунгаачойлин дацан зэрэг шашны сургуулиудыг байгуулан тэдгээрт шашны эрдэм эзэмшүүлж, Энэтхэгийн Их, Бага таван ухааныг зааж байв. Энэхүү дацангууд нь Энэтхэг, Төвдийн шашин, соёл, мэдлэг ухааны олон салбар Монголд түгэн дэлгэрэх үүд хаалга болж байв. Эдгээр дацангуудад тусгай шүүлэг шалгалтуудыг авч, тэнцсэн лам нарт шашны мяндаг цол олгож байлаа. Эндээс авъяас билэгт олон мэргэд төрөн гарч, дуун ухаан, шалгадаг ухаан, зохист аялгуу, тэжээхүйн ухаан, зурхай зэрэгт мэргэшиж, өөрсдийн зохиол бүтээлээ туурвиж, Түвэд, Хятад, Манж хэлнээс зохиол бүтээлүүдийг хөрвүүлж байв. Мөн Монголчуудын дотор янз бүрийн толь бичиг зохиох ажилд дэвшил гарч, Монгол хэлний тайлбар толь, Хятад, Манж, Түвэд зэрэг олон хэлний толь бичгүүд зохиогдож байлаа.

Манжийн эрхшээлийн үед шарын шашин хүчтэй дэлгэрч, Монголчуудын уугуул шашин болох бөө мөргөлийг халж, Монголчуудын нийгэм, соёлын амьдралд онцгой байр суурь эзлэх болов. Монголын хүрээ хийдүүд соёл урлаг, боловсролын төв болсноор суурин газрууд олшрон нүүдлийн соёл иргэншлийн хэв төрхийг тодорхой хэмжээгээр өөрчилж эхлэв. Манжийн төрөөс шашныг дэмжиж байсны үр дүнд лам нарын тоо нэмэгдэж, сүүлдээ шашны дэг жаяг нэн суларч Монголын нийгмийн бүтцэд лам нарын эзлэх хувь ихэссэн нь хүн амын өсөлтөд төдийгүй нийгмийн үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлсөн юм.

Хэдийгээр Монголчууд харийн эрхшээлд байсан боловч өөрсдийн түүхийг зохион бичих явдлыг умарталгүй үргэлжлүүлсээр байв. Зохиол бүтээлээ Монгол хэлээр төдийгүй бусад хэл дээр туурвих нь нэлээд байлаа. Манжийн эрхшээлийн хүнд бэрх нөхцлөөс улбаалан төрт ёсны уламжлал, улс орны эв нэгдлийг эрхэмлэн санагалзаж, Чингис хааны байгуулсан хүчирхэг Монгол улсын түүхийг түлхүү бичиж байв. Тухайн үед монголын түүх бичлэг урьдах үеийнхээс нэлээд хөгжиж, түүх судалгааны арга барил сайжран, хэрэглэх сурвалж бичгийн тоо нэмэгдэж, шүүмжлэлт чиг хандлага бий болсныг судлаачид тэмдэглэжээ.

XIX зуунд суурин газар олширч, сүм хийд нэмэгдэхийн сацуу уран барилгад өөрчлөлт гарч, монголын уран барилга өөрийн хөгжлийнхөө явцад үндэсний өвөрмөц шинж төрх, нүүдлийн ахуйн уламжлалтай холбоотойгоор суурьшмал аж амьдралд тохируулан монгол дархчуудын ур ухаанаар баригдаж байв. Түүнчлэн энэтхэг, түвэд, хятадын уран барилгын нөлөө орж ирж байлаа.

Түвэд, хятадын уран барилгын нөлөөгөөр монгол-түвэд, монгол-хятад, хятад, түвэд, энэтхэг маягийн уламжлалыг хадгалсан холимог шинжтэй барилгууд нэлээд баригдаж байсныг судлаачид тэмдэглэжээ.

Манжийн эрхшээлийн үе нь манай ард түмний түүхэнд тохиолдсон хамгийн хүнд хэцүү үе байсан боловч монголчууд өөрсдийн цуцалтгүй хөдөлмөрөөрөө аж ахуй соёлоо урагшлуулан хөгжүүлсээр XX зуунтай золгосон байна.

А.Очир

С.Уранбилэг
Э.Амарбилиг



Манжийн үеийн худалдаачдын хэрэглэж байсан данс (МҮТМ)

XX ЗУУНЫ МОНГОЛ ОРОН

Хүн төрөлхтний түүхэнд гайхамшиг хийгээд гай зовлонгийн аль алиныг авчирсан XX зуун Монголд ч нэгэн адил гүн гүнзгий ул мөрөө үлдээсэн юм. Монгол орон XX зууны дэлхий дахины олон үйл явдлаас ангид бус, харин оролцогч, гэрч нь байж улс үндэстний хувьд сэргэн мандаж, нийгэм төрийн байгууллаа шинэчлэн, урагш давшин хөгжсөний хувьд, өөрийн түүхээрээ дэлхийн түүхийг бүтээлцсэн юм. Ази тивийн зүрхэнд орших Монгол орон тус бүс нутагт колонийн дэглэмийг унагасан анхдагч улс болж, хүн төрөлхтнөөс хэн нь ч урьд өмнө замнаагүй, зөвхөн онолын хувьд төсөөлөгдөж байсан нийгмийн байгуулал - "социализмыг" буй болгох туршилтыг хэрэгжүүлэн, хөгжлөөр буурай орнуудад нэгэн үе үлгэр болж байсан бол 1990-ээд оноос түүхэн сонголт хийж, Азийн социалист орнуудын дундаас мөн л эн түрүүнд ардчилалын замыг сонгон авсан билээ. Монгол орон, монголчуудын түүхийн олон үйл явдал дэлхийн сонорыг мялааж, анхаарлыг татсаар ирсэн XX зууны Монголын түүхийн хөлөгт та бүхэн морилон тухалж, энэхүү гайхалтай ард түмний ойрхи цагийн түүхээр аялахыг урьж байна.

Хүн төрөлхтөн XX зуунд хөл тавьсан үед Монгол нь Манж Чин улсын харъяат байсан боловч үеэ өнгөрөөн суларч ганхсан ээзн улсынхаа хараанд байхаасаа илүүтэйгээр дэлхийн болон бүс нутгийн улс төрийн бодлого, үйл ажиллагаа тодорхойлогч томоохон гүрнүүдийн анхааралд хэдийнээ өртөж, тэдний нөлөө сонирхлын бүсэд багтсан байв. Үүний нөлөөгөөр Монголын нийгмийн гүнд зах зээлийн харилцааны үр хөврөл үүсэн тэрлэж, гадаадын сонин хачин зүйлс монголчуудыг гайхшруулан, тэд өөрсдийн хоцрогдлыг улам бүр ойлгож, хүчирхэг улсуудын хаялга, дэмжлэгээр хөгжил дэвшилд хүрэхийг илтэд эрмэлзэх болсон ч цаг үе, нөхцөл байдал төдий л тохиромжгүй байсаар 1911 онд тулж ирсэн түүхтэй.



Наймдугаар Богд Жавзундамба хутагт хатан Дондогдуламын хамт
(Лаан баримал, УТМ)

Их Хүрээний монголчууд
1913 он

Их Хүрээний гудамж

Их Хүрээний ээл дээр

Чин улсын "Шинэ засгийн бодлого" эхэлж, монголчуудын үндэс угсааг таслан шашныг мөхөөхөд чиглэсэн үйл ажиллагаа идэвхижсэн нь монголчуудыг улс үндэснийхээ төлөө тэмцэлд босгов. Олон зууны туршид хаяа залгаж найрсагаар зэрэгцэн суусны хувьд Халхын ноёдын төлөөлөгчид Хаант Оросоос дэмжлэг олж, Чин гүрний төлөөлөгч амбаныг нутагт нь буцаан, тэдний захиргааг халж, харийн ноёрхлоос ангижирсанаа зарлав. Улмаар 1911 оны 11 дүгээр сарын 29-нд тусгаар тогтсоноо тунхаглаж, Богд Живзундамбыг их хаанд өргөмжлөн, улсын нэрийг Монгол хэмээн, төрт ёсны илэрхийлэл болсон соёмбот тугаа мандуулав.

Чин Ван Ханддорж тэргүүтэй Монголын төлөөлөгчид хаант Оросод
(1912 оны зэс)

Богд хаант Монгол улсын төрийн далбаа

Богд хаант Монгол улсын төрийн тамга

Хиагтын гурван улсын гэрээний үеэр

Монгол улс колонийн ёсноос ангижирч, шинээр сэргэн мандсан нь бодит зүйл болов. Өгүүлэн буй үед тусгаар тогтнолоо бататган улс гэрээ бэхжүүлэх зорилт нэн тэргүүнд тавигдаж, Монгол улс эрх чөлөөгөө хамгаалан, өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө идэвхийлэн тэмцсэн ч улс хоорондын харилцаанд хүчний зарчим үйлчилж байсан нөхцөлд хөрш улсуудын далд бодлого, хавсайдалтад өртөн тусгаар байдлаа автономын эрхээр сольж, улмаар түүнийгээ ч алдахад хүрсэн юм.

Тийнхүү Монгол улсын гадаад бодлогын идэвхи чармайлт хүчинд автагдан бууран ч тусгаар улсын хийгээд автономитын он жилүүд нь монгол үндэстний хувьд ор хоосон өнгөрсөнгүй. Монголын тусгаар тогтнолын сэргэлт нь улс орны өмнө хөгжлийн шинэ төлөвийг нээсэн юм. Монголын нийгэмд дэвшилт ардчилсан үзэл нэвтрэн, эрх чөлөөг амссан монголчуудын тэргүүний хэсэг хөгжлийг эрмэлзэн, дэлхийн бусад орнуудаас сурч мэдэх, тэдний үлгэр жишээр төр улсаа төвхнүүлэхийг зорьж анхны үр дүнд хүрсэн юм.

Тухайн цагийн нийгмийн шинэчлэлийн дотроос бодит үр дүнд хүрсэн нэн чухал арга хэмжээ бол төрийн сургуулийн уламжлалыг сэргээн иргэний боловсролыг хөгжүүлсэн явдал юм. Монгол оронд анх удаа иргэний боловс-ролын 60 гаруй бага сургууль байгуулагдан, шинэ соргог үзлийн индэр болсон "Шинэ толь", "Нийслэл хүрээний сонин бичиг" зэрэг тогтмол хэвлэлүүд буй болж, "Монгол үсгийн цагаан толгой", "Оюун түлхүүр"," Цаасан шувууны үлгэр, "Гадаад улсын товч түүх" зэрэг унших болон сурах бичгийг хэвлэн гаргав. Монголчуудын үндэсний ухамсар, мэдрэмж дээшилж, эх түүхээ зохиох,үндэсний хууль цаазаа боловсруулах ажлыг эхэлж, "Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир" хэмээх 11 дэвтэр төрийн албан түүх болон "Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг" 65 дэвтрийг зохиожээ.

Нийгмийн сэтгэлгээний өөрчлөл-тийн нэгэн тод жишээ нь аман зохиол, зураг, урлагт шүүмжлэлт хандлага дэлгэрсэн явдал мөн.

Монголын нийгмийн янз бүрийн давхрагын амьдрал ахуйг харуулсан Б.Шаравын "Монголын нэг өдөр" хэмээх алдарт зураг нь тухайн цагийн Монголын дүр төрхийг илтгэнэ.

Орос улсаар дамжин монгол ахуйд шинэ зүйлүүд нэвтэрч байсны тоонд Орос-монголын хэвлэлийн хороо, цахилгаан гэрлийн болон телефон утасны хороо, буу засах газар орно. Нүүдэлч монголчуудын амьдралд суурьших явц урьд өмнөхөөс идэвхжин, сүм хийд, суурин газар бараадан амьдрах хандлага нэмэгдэв.

Тусгаар улсаа байгуулснаар эдийн засгийн сэтгэлгээний шинэ үе эхэлж, тухайн цагийн аж ахуй, эдийн засагт зарим нэгэн өөрчлөлт гарсан юм. Үндэсний баялаг болох малыг эрүүлжүүлэх замаар ашиг шимийг дээшлүүлэх, түүхий эдийг боловсруулахад анхаарал тавихын зэрэгцээгээр газар тариаланг хөгжүүлэх, ан агнуур байгалийн баялагийг ашиглах, уламжлалт үйлдвэрлэлийг сэргээхийг эрмэлзэж байв. Гэвч эдгээр шинэчлэл өөрчлөлтүүд нь хөрөнгө санхүүгийн бололцоо хийгээд улс төрийн үйл явдлын нөлөөгөөр саарч олиггой үр дүнд хүрсэнгүй.

Харин тусгаар тогтнолын сүүлчийн найдвар байсан



Жүгдэр "XX зууны эхэн үеийн Их хүрээ" (БХОМ)

автономит засгаа устгуулсны дараагаар түүнийг сэргээн босгохын төлөө монголчуудын үүсгэсэн үндэсний хөдөлгөөн 1921 оны хувьсгал болон өргөжин ялснаар XX зууны Монголын түүхэнд шинэ үе эхэлж, тус оронд нийгэм эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлт хийгдэх бодит нөхцөл бүй болов.

Тухайн үеийн гол зорилго нь Монгол орон хэмжээгүй эрхт ёноос сонгож байгуулах ардчилсан засаглалд шилжиж, дэлхийн бусад орнуудын нэгэн адил хөгжиж дэвшихийг чухал болгон, улс орондоо нийгэм-эдийн засгийн гүн гүнзгий шинэчлэл хийхэд оршиж байлаа.

Улс орныг харийн эзэрхэгчүүдээс бүрэн чөлөөлж, Ардын эрхтэй хэмжээт цаазат засагтай Монгол улсыг гадаад улс оронд зөвшөөрүүлэхийн төлөө чармайн тэмцсний дунд монголын гадаад байдал бэхжин, дотоодод үймээн самуунгүй болсон нь нийгмийн өөрчлөлтийг эхлэх үндэс суурь болов. Бүр үндэсний ардчилсан хувьсгал ялсан үеэс "... монгол үндэстний ард амьтны үүрдийн жаргал ба урагш давшихыг гол болгосон" төр засгаас нийгмийн амьдралын бүхий л

Д.Сүхбаатар улаан цэргийн дарга нарын дунд (1921 он)

Б.Гомбосүрэн " Шинэ төрийн ээд ирлээ" (1963 он)

Анхдугаар Их хурлын тэргүүлэгчид
(1924 оны 12 дугаар сар)

төр ёсны түүхэнд анх удаагаа нийгмийн олонхийн гарт засгийг эрхийг шилжүүлэв. Нийтийн жишгээр сонгож байгуулах засгийг явуулах болж, 1924 онд анхдугаар Үндсэн хуулийг батлан, Бүгд найрамдах улсыг тунхаглав. Улс төрийн шинжтэй өөрчлөлтүүдийн зэрэгцээгээр эдийн засаг, соёлын салбарт ч ахиц дэвшил гарч эхлэв.

Улаанбаатар хотод байгуулагдсан улгэр жишээ бага сургууль
(1925 он)

салбарт өөрчлөлтийг хийж эхэлсэн билээ. Тухайн үеийн хөгжилтэй орнуудын түвшингээс доогуур байсан Монголын нийгмийн шинэчлэл нь "Мориноосоо буулгүй дэлхий ертөнцийг эзлэхэд амархан, мориноосоо буугаад төрийг төвхнүүлэхэд хэцүү" хэмээх сургаал үгсийг эрхгүй санагдуулсан хүнд бэрх зорилт байв.

Үндэсний ардчилсан хувьсгалын эхний жилүүдэд нийгмийн амьдралын улс төрийн хүрээнд жинхэнэ эргэлт гарч, олон зууны турш оршин тогтносон хамжлагат ёсыг үүрд устган, монголын

Анхны бага сургуулийн сурагчид
(1923 он)



Хошууны тэнхмийн хүүхдүүд
(1927 он)

Тухайн үеийн эдийн засгийн бодлогын гол чиглэл нь ардын хувийн аж ахуйтны сонирхлыг нийгмийн эрх ашигтай хослуулах замаар мал сүргийн тоог олшруулахад оршиж байв. Үндэсний баялаг болсон малын тоо толгой аажмаар өсөн нэмэгдэж, 1932 онд 16,2 сая байсан бол 1940 онд 26 сая болж өсчээ. Нийгмийн эдийн засгийн шинэ салбарын эх суурь болсон аж үйлдвэрийн комбинат, Хатгалын ноос угаах үйлдвэр шинээр байгуулагдаж, Ардын засгийн анхны жилүүдэд шинэ төрийн мэдэлд очсон үйлдвэрүүд өргөжин, мал аж ахуйн түүхий эдийг үндэсний үйлдвэрт боловсруулж байв.

Анхны яармаг худалдаа

Монголын харилцан туслах хоршооны дэлгүүр
(1920-иод оны үе)

Монголын харилцан туслалцах хоршооны байр
(1920-иод оны үе)



Ерөөгийн модны үйлдвэр
(1920-иод оны үе)

Эрчим хүч, барилга, уул уурхайн үйлдвэрлэл хийгээд, радио холбоо, авто өртөө буй болж, төмөр замын эхлэл тавигдав. Соёл, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбарт амжилт олж, хувьсгалт уран зохиол, театр, кино буй болов. Бичиг үсгийн кампани өрнөж, сүм хийдэд бус, сургууль танхимаар боловсрол эзэмшүүлэх бодлогыг тууштай баримтлан хэрэгжүүлсний дүнд 1934 онд нийт хүн амын 5.6 хувь бичигтэй байсан бол 1940 онд 20.8 хувь болж нэмэгджээ.

Соёл боловсролын хүрээний өөрчлөлт монгол хүний гадаад дүр төрхийг ч мөн өөрчлөв. Хот суурин газрын албан хаагчид, сэхээтнүүд европ хувцас өмсөн, шинэ цагийн сонин хачин зүйлсийг амьдрал ахуйдаа нэвтрүүлэх болжээ. 1934 онд Монголын радио хороо байгуулагдсанаар холбоожуулах ажил ахиц гарч 1940 онд бүх аймагт радио нэвтрүүлэг хүлээн авч, дамжуулах станц байгуулагдав.

Европ эмнэлэгт ажиллаж байсан лам нар

Анхны европ эмнэлэг-цэргийн эмнэлэг (1920 он)

Урианхайн бага сургууль
(1938)он

Монголын харилцаа холбооны газар
(1930-аад он)

Бичиг үсгийн бүлгэм
(1930-аад он)


Анхны кино аппарат
(1930-аад он)

Гэвч үндэсний ардчилсан шинэчлэлийг гадаад хүчин зүйлийн нөлөө дарамтын дор нийгмийн гишүүдээ ялгаварлан үзэх ангич бодлого, албадлагын аргаар хэрэгжүүлсний улмаас нийгмийн амьдралд сөрөг үйл явдал ч мөн гарав. Хэд хэдэн аймгийг хамарсан зэвсэгт бослого гарч, олон мянган иргэд нутаг орноо орхин дүрвэж, нийгмийн сэтгэхүйд шинэ төр засгийн бодлогод эргэлзэх хандлага буй болов. Түүнчлэн гадны хүчний шууд оролцоотойгоор олон арван мянган хүнийг түүний дотор нам, төр, цэргийн удирдлагад ажиллаж байсан хүмүүсийг улс төрийн хилс хэрэгт татан хэлмэгдүүлж, амь насыг нь хохироожээ. 1930-аас 1940 онд тусгай комисс, Онцгой бүрэн эрхт комисс, шүүхийн шийдвэрээр нийтдээ 37574 хүнийг шийтгэсэн гэсэн тоо бүртгэл буй. Энэ бүхэн нь ХХ зууны Монголын түүхийн нэгэн гунигт хуудас болон үлдсэн ч эдүгээ Монголын төр эл үйл явдлын уршгийг залруулах талаар онцгой анхаарч, хэлмэгсдийн нэр төрийг сэргээх, тэдний үр хүүхдэд нөхөн олговор, дурсгалын музей, хөшөө дурсгал байгуулж, жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдрийг хэлмэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр болгон тэмдэглэх болжээ.

Хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан хөшөө

Анхны Үндсэн хууль

Боловсролын хөгжил

"Хувьсгалт монгол" танкийн бригад

Улаанбаатар-Наушкийн төмөр замын нээлт

"Монгол ард" онгоцны эскадриль

Холбоо, харилцааны хөгжил

Монголын нийгэм нь улс төрийн хоморголон хэлмэгдүүлэлт, Халх голын дайн зэрэг зовиур бэрхшээлийг амсаар 1940-өөд онтой золгосон юм. 1940 онд МАХН-ын Х ба Улсын VIII их хурал хуралдаж, намын мөрийн хөтөлбөр, шинэ Үндсэн хуулийг батлан, нийгэм журамд шилжих урьдач нөхцлийг хангах зорилт дэвшүүлэн тавьжээ. Чухам энэ үеэс Монгол орон хэн ч урьд өмнө хүрч байгаагүй "социалист нийгэм"-ийг байгуулах туршилтад өртөн, түүхэн хөгжлийн тодорхой үе шатыг туулсан билээ.

Дэлхийн дайны үед Монгол улс эдийн засаг, нийгмийн амьдралаа дайны нөхцөлд зохицуулан, зөвлөлтийн ард түмэнд туслах хөдөлгөөнийг зохион байгуулж, фронтын гүн ар тал болж байлаа. Дайны төгсгөлөөр БНМАУ японы милитаризмыг бут цохих тэмцэлд чадлын хирээр оролцож, даян дэлхийд энх тайван тогтоох үйл хэрэгт хувь нэмрээ оруулсан юм.

1945 оны II сард Ялтад хуралдсан ЗХУ, АНУ, Их Британии засгийн газрын тэргүүн нарын бага хурлаар ЗХУ-ын саналын дагуу Гадаад Монголын статускво-г хэвээр байлгахаар тогтсон нь тус улсын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх үндэс болсон юм.

Крымын Бага хурал (1945 он)

Үүний дараагаар тусгаар тогтнолын төлөө бүх нийтийн санал хураалт 1945 оны X сарын 20-нд болж, сонгуулийн насны бүх иргэдийн 98,4 хувь буюу 487409 хүн оролцон, улс орныхоо тусгаар тогтнолын төлөө гарын үсгээ зурав. Санал хураалтын энэ дүнг манай орны тусгаар тогтнолыг үл зөвшөөрөн, өөрийн нутаг дэвсгэрийн хэсэг хэмээн үзсээр ирсэн хятадын засгийн газар хүлээн зөвшөөрөв.

Хадлан хадаж байгаа нь

Малчин айл

БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай бүх нийтийн санал хураалт (1945 оны 10-р сарын 20)

Атар эзэмшсэн нь

Малчны хашаа (1956 он)

Монгол улсын нэр хүнд олон улсын тавцан дээр өсч, дэлхийн дайны дараагаар европын ардын ардчилсан орнуудтай, 1950-иад оноос шинэ тутам тусгаар тогтносон Энэтхэг, Индонез, Бирм, Гвинеи, Кампучи, Балба зэрэг Ази, Африкийн олон улс оронтой дипломат харилцаа тогтоов.

Дэлхийн II дайны дараа тус улс энх тайван бүтээн байгуулалтад шилжин оржээ. 1954 онд хуралдсан МАХН-ын XII их хурал "социализмыг дэлгэрэнгүй байгуулах" үзэл санаа дэвшүүлж, нам, төрийн улс төр, нийгэм эдийн засгийн бүхий л бодлого, үйл ажиллагаа эл зорилтод захирагдах болжээ.

Улс орны эдийн засгаас хувийн хэвшлийг бүр мөсөн шахаж, улс, хоршооллын сектор улам бүр бэхжих болов. Ардын хувийн аж ахуйтныг 1959 оны эцэс гэхэд хоршооллож, атар газар эзэмшиж эхлэв.

Хөнгөн хүнсний болон уул уурхайн үйлдвэрүүдийг шинээр байгуулах буюу шинэчлэн тоноглосноор БНМАУ-ын хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болж, улмаар 1960-аад оноос аж үйлдвэр хөдөө аж ахуйн орон болох зорилт тавив. Үйлдвэрийн байршилд өөрчлөлт гарч, Дарханд аж үйлдвэрийн районыг бий болгожээ.

1934 онд анхны том үйлдвэр аж үйлдвэрийн комбинат ашиглалтад орсон.

Хүн амын бичиг үсэг үл мэдэх явдлыг үндсэнд нь арилгаж, боловсролын бүхэл бүтэн систем тогтжээ. Хүн ам эрүүлжин өсч, орчин үеийн эмнэлгийн үйлчилгээг хүртэн мэдрэх болсон байна. Энэ үе бол монголын ард түмний бүтээн байгуулалтын төлөө шаргуу хөдөлмөрлөсөн он жилүүд байлаа.

Төмөр зам

Улаанбаатар хотын цахилгаан станцын нэгэн цехэд



Их барилга, бүтээн байгуулалтын хэсгээс

БНМАУ-ыг социалист болон Ази, Африкийн тусгаар тогтносон нэлээд улсууд хүлээн Зөвшөөрсөнөөр олон улсын харилцааны түгжигдмэл байдлаас гарч, гадаад харилцаа өргөжив. 1961 онд БНМАУ Нэгдсэн Үндэстний байгууллагын гишүүн болж, хууль ёсны эрхээ эдэлсэн байна.

1960-аад оны дунд үеэс Монгол улсад социализм байгуулж дуусгах зорилт дэвшүүлэн тавьжээ. 1965-1989 он хүртэл тус улсын нийгмийн амьдралын бүх хүрээнд нэлээд өөрчлөлт гарч, улс төрийн системийн цөм нь төр бус, эрх баригч МАХН болж, Үндсэн хуулиараа баталгаажуулсан байна.

БНМАУ хэдийгээр 100 шахам оронтой дипломат харилцаа тогтоосон боловч, бодит байдал дээр гадаад харилцаа нь зөвхөн социалист хүрээгээр хязгаарлагдаж байлаа.

Бүгд Найрамдах Монгол Ард улс НҮБ-д элсэв. (1961 оны 10-р сарын 20)

Өгүүлэн буй үеийн эдийн засгийн хөгжлийн гол агуулга нь социализмын материал-техникийн бааз байгуулахад буюу, БНМАУ-ыг аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгоход оршиж байв. 1962 онд БНМАУ нь Азийн социалист орнуудын дотроос анх түрүүнд ЭЗХТЗ-д гишүүнээр элссэн ба улмаар "Социалист эдийн засгийн интеграцийн цогцолбор программ"-д (1971) багтан эдийн засгийнхаа хөгжлийг хурдасгаж, үр ашгийг нь дээшлүүлэх зорилтыг бололцооны хирээр хэрэгжүүлсэн байна. 1960 оноос хойшхи гуч шахам жилд тус улсыг аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгох зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө авч хэрэгжүүлсэн олон арга хэмжээний дунд эдийн засгийн гол гол үзүүлэлтүүд өсөн нэмэгдэж, салбарын бүтэц, байршилт өөрчлөгдөв.

Түлш эрчим хүч, уул уурхайн үйлдвэрүүдийг түлхүү хөгжүүлэх бодлого баримталсаны дунд Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Бага нуур зэрэг үйлдвэрийн шинэ хотууд босч, хэд хэдэн том цахилгаан станц, уул уурхайн үйлдвэр ашиглалтанд оров. 1980-аад

оны сүүлч гэхэд тус улсын үндэсний орлогын бүтцэд аж үйлдвэр 40 шахам хувийг эзлэх болжээ. Хөнгөн хүнсний үйлдвэр өргөжин хөгжиж, бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэж, чанар чансаа сайжрав. 1980-аад оны сүүлчээр Монголын зөөлөн савхи, ноолууран болон хивс зэрэг бүтээгдэхүүн дэлхийн хэмжээнд хүрсэн юм.

Дархан хотын нэхий эдлэлийн үйлдвэр

Аж үйлдвэр хийгээд бусад салбарын хөгжилтэй холбоотойгоор хөдөө аж ахуйн эзлэх хувь 1960 оноос бага зэрэг буурсан хэдий ч газар тариалан бие даасан салбарын хэмжээнд хүрч хөгжсөнөөр улс орны талх тарианы хэрэгцээг бүрэн хангах чадвартай болсон нь том амжилт байв.

Телевизийн нэвтрүүлгийн танхимд

1980-аад оны сүүлч гэхэд улс ардын аж ахуй, соёлын салбарт ажиллагч таван хүн тутмын нэг нь дээд, тусгай дунд боловсролтой болсон байв. Социализмыг байгуулахын төлөө он жилүүдэд радио цэг, радиостанцын тоо эрс нэмэгдэж, 1967 оноос телевизийн нэтрүүлэг хүлээн авч үзэх болов.

Гэсэн хэдий ч Монгол улс нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол гол үзүүлэлтээрээ дэлхийн хөгжингүй орнуудаас үлэмж доогуур байсан нь хөгжлийн "социалист зам" мухардмал байдалд орж, хүч бололцоогоо шавхсан хэрэг болов. 1989 оны эцсээс Монгол оронд ардчилал, шинэчлэлийн төлөө хөдөлгөөн хүчтэй өрнөж, нийгмийн амьдралын бүх хүрээг өөрчлөх үйл явц эхэлсэн юм.

Энэ үед манай орны улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөж, нийгмийн сэтгэл зүй маш тогтворгүй болсон байв. Энэ үйл явц нь гадаад дотоод хүчин зүйлээр нөхцөлдөж байлаа. 1980-аад оны дунд үеэс социалист систем задрах шинж тэмдэг илэрч, Дорнод Европын социалист гэгдэж байсан орнуудад ардчилал шинэчлэлийн үйл явц ил болсонтой зэрэгцэн БНМАУ-тай оршихуйн маш олон сэжмээр, түүний дотор үзэл суртлын бат нягт холбоосоор гагнагдсан ЗСБНХУ-д өөрчлөн байгуулалт өрнөж эхлэв. 1989 оны эцсээр болсон Прагийн зөөлөн хувьсгал, Берлиний ханыг нураасан, Бухарестын цааз ял зэрэг Төв ба Зүүн Европыг донсолгосон улс төрийн газар хөдлөлтүүд нь бодит социализм Өрнөдтэй өрсөлдөхдөө соёл, нийгэм, эдийн засаг, зохион байгуулалтын тогтолцооны хувьд ялагдал хүлээснийг илрэл болов. Мөн хуучин социалист орнуудад эрх чөлөөний тухай үзэл санааг жагсаал цуглаанаар илэрхийлж, тэдгээр нь нийт ард түмний дэмжлэгийг хүлээн, шинээр гарсан хөдөлгөөн холбоод нь улс төрийн намууд болтлоо өсч торнив.

Энэхүү явдал Монголд мөн давтагдаж ардчиллын үйл явц өрнөн, олон ургалч үзэл дэлгэрсний илрэл болсон шинэ намууд үүсэв.

Өгүүлэн буй үед "Цагийн толь" сонин гаргаж байсан УБДС-ийн оюутнууд, МУЭ-ийн Соёлын төв ордны улс төр сонирхогчдын "Орчлон" клуб, улс төрийн "Шинэ үе" бүлгийнхэн , "Залуу эдийн засагчдын клуб" зэрэг бүлгэм, байгууллага бий болж, 1989 оны XI сарын сүүлээр хуралдсан Залуу уран бүтээлчдийн улсын II зөвлөлгөөнд оролцогсод нийгмийн байдлыг хурцаар шүүмжлэн, шинэчлэлтийн үйлсийн төлөө шинэ байгууллага Монголын Ардчилсан Холбоог үүсгэхээ зарлажээ.

Улс төрийн өлсгөлөн
МоАХ, АСХ, ШДХ, МОХ нийгмийг ардчлах, улс төрийн тогтолцоог өөрчлөх шаардлага тавьж, дээрх байгууллагуудын хэсэг гишүүд улс төрийн өлсгөлөн зарлав.

Монголын Ардчилсан намын байр

1990-ээд оны улс төрийн тэмцлийн явцад Монголын ногоонтны холбоо (МНХ), Монголын сүсэгтний холбоо (МСХ), Монголын малчин тариачны холбоо (ММТХ), Монголын ажилчны нэгдсэн холбоо (МАжНХ) үүсэж, тэдгээрийн суурин дээр Монголын ардчилсан нам, Монголын социал-демократ нам, Монголын үндэсний дэвшлийн нам, Монголын чөлөөт хөдөлмөрийн нам байгуулагдав.

Монгол Ардын Хувьсгалт Намын байр

Ерөнхийлөгч Н.Багабанди

Дурдан буй үеийн эдийн засгийн шинэчлэлийн гол агуулга нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих явдал байлаа. Энэ хугацаанд үнэ чөлөөлөх, өмч хувьчлах, банкны тогтолцоог шинэчлэн өөрчлөх, эдийн засгийн гадаад харилцааг либеральчлах зэрэг арга хэмжээг авчээ.

1990 онд анх удаа олон намын тогтолцооны үндсэн дээр ардчилсан сонгууль явуулж, улмаар анхны байнгын ажиллагаатай парламент-Улсын Бага Хурал байгуулагдан, шилжилтийн зурвас үед Эвслийн засгийн газрыг байгуулж ажиллажээ. Мөн Монгол улсын төрийн тэргүүн-Ерөнхийлөгчийн институтыг бий болгон хэрэгжүүлсэн байна.

Тэр цагаас хойш төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага Улсын Их хурлыг 1992, 1996, 2000 онд тус тус чөлөөт ардчилсан сонгуулийн үндсэн дээр сонгон бүрдүүллээ. Төрийн тэргүүн Ерөнхийлөгчөө бүх ард түмнээр сонгох болов. Манай нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан эрх зүйн шинэчлэл хийж, Монгол улс нээлттэй гадаад бодлого явуулах боллоо.

Ерөнхий сайд Н.Энхбаяр

УИХ-ын дарга С.Төмөр-Очир

Улсын Их Хурлын чуулган

1992 оны 1 дүгээр сард ардчилал, хүний эрхийн дэлхийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм, хэмжээг гүнзгий тусгасан ардчилсан Үндсэн хуулийг баталж, Монгол улс парламентын Бүгд Найрамдах улс болов.

Монгол орон улам бүр нээлттэй болсоноор гадаадын хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж, хамтарсан үйлдвэр аж ахуйн газрууд олноор байгуулагдав. Монгол улсын эдийн засагт дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны зээл, хандивлагч орнуудын тусламж чухал үүрэг гүйцэтгэж байна. Мэдээлэл харилцааны салбарт мэдэгдэхүйц амжилт олов. Орчин цагийн холбооны сүлжээ өргөжиж, харилцаа холбооны хамгийн шуурхай хэрэгсэл болсон үүрэн телефоны үйлчилгээ нэвтэрч, хүн амын бүх давхрагад түгэн тархав. Эдүгээ Монгол улс нь дэлхийн 200 улстай шуудан, 13 оронтой буухиа шуудан сонингоор харилцаж байна.

Монгол улсын төр засаг нийгмийн салбарт хүн төвтэй хөгжлийн дэлхий нийтийн үзэл баримтлалыг хөгжүүлэхийг зорихын хамт иргэн бүрт чөлөөтэй сэтгэж, үзэл бодлоо өргөн илэрхийлэх боломж олголоо. Нийгмийн даатгалын шинэ тогтолцоог бий болгож, түүний эрх зүйн үндсийг бүрдүүлэв. Үүний хамт шилжилтийн үеийн сөрөг үзэгдэл, нийгмийн хурц асуудал ч бас байв. Ийнхүү XX зуунд монголчууд олон сорилтыг даван туулж, тусгаар тогтнолоо бататган бэхжүүлж, олон улсын тавцанд өөрийгөө хүлээн зөвшөөрүүлж, НҮБ-д элсэн, дэлхийн болон бүс нутгийн үйл хэрэгт идэвхийлэн оролцогч тусгаар тогтносон, бүрэн эрхт улс болж, нийгмийн хөгжилдөө багагүй дэвшилд хүрсэн билээ.



Монголын хөрөнгийн бирж

"Монголын цахилгаан холбоо" компани

XX зууны Монголын нийгмийн өөрчлөлтийн маргашгүй үр дүн бол хүн ам зүй, нийгмийн ахуй, иргэншил, соёл боловсролын хүрээнд гарсан хувьсгал байлаа. 1910-аад оны дунд үед Монголын засгийн газраас хүн амынхаа төлөв байдал, чиг хандлагыг судлах ажлыг анх хийснээс хойш олон өөрчлөлт гарав. Монголын хүн ам 642 000-аар тоологдож, өвчин эмгэгт нэрвэгдэж, орчин цагийн боловсон эмнэлгийг мэдэхгүй, эх, хүүхдийн эндэгдэл ердийн үзэгдэл болж, сөнөж мөхөж яваа үндэстэн хэмээгдэж байсан цаг эдүгээ түүх болон улирч, бүр 1940 онд цагаан бурхан хэмээх аюулт өвчнийг бүр мөсөн устгасан Азийн анхны орон болсон бол 1960 он гэхэд гадныхны хачирхан гайхаж байсан өнгөний өвчнийг устгаж, хүн амаа эрүүлжүүлэх талаар бодитой үр дүнд хүрсэн юм. Эдүгээ Монгол улс 10000 хүнд ногдох эмч, эмнэлгийн ажилтан, эмнэлэг үйлчилгээний үзүүлэлтээр дэлхийд дээгүүр орж байна. Хөгжлийн шинэ үед эрүүл мэндийн салбарт хувийн хэвшлийн болон гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан эмнэлгүүд бий болов.

Улсын клиникийн төв эмнэлэг

Оношлогоо, эмчилгээний шинэ аргууд нэвтэрч, уламжлалт ба орчин цагийн анагаахын мэдлэг ухааныг хослон эзэмшсэн манай эрдэмтэд, эмч нар анагаахын олон салбарт дэлхийн түвшний хэмжээнд эмчилгээ үйлчилгээг хийж байна.

Монголын хүн ам 0,5 саяас 2 сая 474.5 мянга болон өсч, хүн амын бүтцэд хүүхэд, 35 хүртэлх насны залуучууд талаас илүү хувийг эзэлж байгаа нь монголчууд залуу үндэстэн болохыг илтгэнэ.

XX зууны эхэнд нүүдэлчдийн үр сад өрсөлдөөнт соёл иргэншилд удахгүй уусан үгүй болно хэмээн бичиж байсан тэр үйл явдал болсонгүйгээр үл барам харин ч нүүдэл, суурьшмал иргэншил хосолсон барууншсан нийгэм болон хөгжиж байгааг өнөөгийн Монголын ахуй байдал, хөгжлийн дүр зураг харуулна. XVII зуунаас хойш бараг зогсонги болсон хот суурингийн хөгжил XX зуунд дахин сэргэж, 1960-аад оноос хотжилтын үйл явц түргэсэж, томоохон цогцолбор хотууд байгуулагдсан нь монголчуудын иргэншлийн түүхэнд гарсан чухал өөрчлөлт байлаа. Эдүгээ ганцхан нийслэл Улаанбаатарт 846.000 хүн буюу хүн амын гуравны нэг нь оршин сууж байна.



Манай баясгалант хойч үе

Хотжилттой орчин цагийн ахуйн хамтаар Монгол хүн сансарт нисч, шинжлэх ухааны нээлт гарган, дэлхийн сонгодог дуурь, балет, хөгжим жүжгийг үндэснийхээ театрт тоглож, үндэсний соёлоо баяжуулж, дэлхийн тавцанд спортын өндөр амжилт үзүүлж байна.

БНМАУ-ын сансрын нисгэгч Ж.Гүррагчаа
ЗСБНХУ-ын сансрын нисгэгч В.Жанибеков

Орчин цагийн Монголыг илэрхийлэх нэн чухал үзүүлэлт нь боловсролын өндөр түвшин юм. Хэдийгээр 1990-ээд оныг хүртэл зөвлөлт загварын систем ноёрхож байсан ч социализмын гэгдэх он жилүүдэд монголчуудын олсон хамгийн том амжилт бол боловсрол шинжлэх ухааны хөгжилт мөн. Бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах, иргэдээ боловсролтой болгох талаар төрөөс явуулсан олон жилийн тууштай, дэс дараатай бодлогын дүнд 1956 он гэхэд хүн амын 72,2 %, сургуулийн насны хүүхдийн 93% нь бичигтэн болсон байв. Тийм ч учраас өрнөдийн зарим эрдэмтэд 1940-1950-иад оныг Монголын боловсролын салбарт хувьсгал гарсан үе гэж нэрлэж байсан билээ. Социализмын гэгдэх үед тус улсад иргэний боловсрол бага, дунд, дээд (тусгай) гэсэн шатлалаар амьдралд бодитой хэрэгжиж, нийгмийн бүх гишүүд сурч боловсрох бүрэн эрхээр хангагдаж, түүнийгээ үнэ төлбөргүй олж авч байлаа. Анхны их сургууль дэлхийн II дайны хүнд бэрх жилүүдэд, 1942 онд байгуулагдаж, 1990 оныг хүртэл Монгол Улсын Их сургууль, Анагаах ухааны дээд сургууль, Хөдөө аж ахуйн дээд сургууль, Улсын багшийн их

Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их сургууль

сургууль, Цагдаагийн дээд сургууль, Политехникийн дээд сургууль зэрэг арваад дээд сургууль байсан бол эдүгээ төрийн өмчийн ба хувийн 180 гаруй сургуульд 106000 оюутнууд төрөл бүрийн мэргэжлээр суралцаж, тэдгээрийн үйл ажиллагаанд онцгой үүрэгтэй "Монголын их, дээд сургуулийн консорциум" байгуулагдав.

Өнөөгийн Монгол улсын боловсролын тогтолцооны нэг онцлог нь боловсролыг зөвхөн албан сургалтаар төдийгүй албан бус замаар хэрэгжүүлж байгаад оршино. Улс төрийн боловсрол олгоход анхаарах болж, Удирдлагын болон Улс төрийн боловсролын академи байгуулагдав. Ийнхүү орчин цагийн боловсролын тогтолцоо үүсч хөгжсөн 80 гаруйхан жилийн хугацаанд насанд хүрсэн хүн амыг үндсэнд нь бичигтэн болгосон Монгол улсын туршлагыг дэлхий дахин үнэлж байдаг билээ.

Тийм ч учраас НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 57-р чуулган Монгол улсын санаачлагаар 2003-2012 онд "Бүх нийтээр бичигтэн болох НҮБ-ийн 10 жил"-ийг зарлан хэрэгжүүлж эхэллээ.

Радио, телевизийн нэвтрүүлэг хүлээн авах "Орбит станц"

1921 оны намар байгуулагдсан Монголын судар бичгийн хүрээлэнгийн анхны байр



Радио, телевизийн нэвтрүүлэг хүлээн авах "Орбит станц"-ийн антен



Чингис хааны цогцолбор (Хэнтий аймаг)

XX зууны Монголд орчин цагийн шинжлэх ухааны бүхэл бүтэн тогтолцоо төлөвшин хөгжлөө. Монголын шинжлэх ухааны анхны байгууллага 1921 онд Судар бичгийн хүрээлэн нэртэйгээр байгуулагдан, улмаар 1961 онд Шинжлэх ухааны академи болон өргөжсөнөөр түүхийн харьцангуй богино хугацаанд шинжлэх ухааны олон салбарт багагүй үр дүнд хүрсэн юм. Монголын Геологи, минералоги, биологи, мал эмнэлэг, экологи, билчээр судлал зэрэг салбаруудын эрдэмтдийн арваад бүтээл шинжлэх ухааны нээлтийн хэмжээнд үнэлэгдэж, сансрын физикийн судалгааны үр дүнг монгол хүн сансарт нисэхэд ашиглаж байлаа.

Энэ зуунд монголын эрдэмтэд Үндэсний атлас, Монголын нэвтэрхий толь (2 боть), Монголын улаан номыг бүтээж, улсын түүхээ 3 ба 5 ботиор туурвиж, эх орны байгаль экологийн нөхцөлд зохицсон шинэ үүлдрийн мал, хөдөө аж ахуйн таримлын шинэ сорт, техник технологийг гаргасаар байгаа нь Монголын шинжлэх ухааны ололт мөн. Өнөөгийн нийгмийн сэтгэхүй, монголчуудын оюун санаанд гарсан олон өөрчлөлтийн нэг нь олон жилийн турш нэрийг нь дуудахаас ч эмээж байсан их Чингис хааныхаа нэр төрийг сэргээн, хөшөө дурсгалыг босгож, түүх шастирыг нь бичих болсон явдал мөн. Тэртээх 1962 онд Чингис хааны 840 жилийн ойг тэмдэглэн буруутан болж байсан явдал түүхийн хуудаснаа үлдэж, үндэсний дэвшилтэд бүхнээ сэргээхийг оролдож багагүй амжилтыг олжээ. Чингис гэдэг нэрийг хүн бүр чөлөөтэй дуудах болж, их ойд нь зориулсан олон талын цогц арга хэмжээг засгийн газар тэргүүлэн зохион байгуулж, Чингис хааны цогцолборын суурь тавьж, ном зохиол бичиж, урлагийн бүтээл туурвижээ. Их хааны нэрээр нэрлэгдсэн зочид буудал, зоогийн газар, тэр ч бүү хэл идээ сархад үйлдвэрлэжээ. Энэ дашрамд "Вашингтон пост" сониноос Монголын их хаан Чингисийг хоёрдахь мянганы тэргүүн хүнээр тодруулсаныг дурдууштай.

Нэгэн үе тариа хадгалах газар ба барааны агуулахын үүрэг гүйцэтгэж, хөсөр орхигдсон сүм хийдийг 1990-ээд оны өөрчлөлтөөс хойш сэргээн, шашин шүтэх эрхийг олон түмэнд жинхэнэ ёсоор нь эдлүүлэх болсоноор эдүгээ Монгол нутагт уламжлалт бурханы шашны зэрэгцээгээр Христийн болон бусад шашнууд нэвтэрч, хүн амын тодорхой хэсэг, нэн ялангуяа залуучууд шүтэж бишрэх болжээ. Шинэ шашин нэвтрэхийн хирээр уламжлалт шашны сүм хийд шинээр баригдан, бага насны хүүхдүүд хийдэд шавилан суух, шашны сургуульд орж суралцах нь нэмэгдэв. Түүнчлэн түвэд эмнэлгийн дацан сургууль байгуулагдав.

Дээрхийн гэгээн Далай лам МУИС-ийн Хүндэт доктор цол хүртэх ёслолын ажиллагаан дээр (2002 он)

Томоохон хийдүүдийг сэргээн засварлаж, байнгын үйл ажиллагаатай болгосоны тоонд Эрдэнэ зуу, Гандантэгчлэн хийд орох бөгөөд тэдгээр нь жуулчид, сонирхогчдын очдог, олны хөл үл тасрах томоохон газрууд болов. Эдгээр сүм хийдүүд нь дорно дахины уламжлалт барилгын уран гоё хийц, загвараараа гайхагдахын зэрэгцээгээр тэдгээрт алт, мөнгө, хүрлээр цутгаж хийсэн түмэн зүйлийн бурхад, шашны эд зүйлс, мөн зураг, зээгт наамал хадгалагдаж байна.

Лам, хуврагууд

Бурхны шашны дэлгэрэлтийн энэ үед Монгол оронд Далай лам хэдэнтээ айлчилж, сургаал номлолоо айлдав. Монголчууд өөрийн соёлынхоо үнэт зүйлсийг сэргээн шүтэх болсоны нэг нь Мэгжиджанрайсаг бурхан бөгөөд түүнийг шинээр бүтээх ажил ардчилалын жилүүдэд хийгджээ.

Ийнхүү XX зуунд Монгол орны нүүр царайг танигдашгүй болтлоо өөрчлөгдөн, орчин үеийн улс болов. Хөгжлийн шинэ сонголт хийсэн монголчууд ирээдүйгээ өөдрөгөөр харж, хүн төрөлхтөнтэй хөл нийлүүлэн шинэ зуунд алхан орлоо.

Н.Хишигт

С.Уранбилэг
Э.Амарбилиг

БҮЛЭГ IV

- ХҮН АМ
- ХҮН АМЫН УГСААТНЫ БҮРЭЛДЭХҮҮН, ГАРЛААС
- ХУВЦАС
- ГЭР ОРОН, СУУЦ
- ИДЭЭ, УНДАА
- ТОГЛООМ НААДГАЙ, ҮНДЭСНИЙ СПОРТ

ХҮН АМ

Төв ази, түүний дотор Монгол орон бол хүн төрөлхтөн анх үүссэн дэлхийн өлгий нутгуудын нэг мөн.

Тус орон газрын хэвлийдээ хийгээд хөрсөн дээрээ маш эртний гарваль бүхий соёл иргэншлийн хөгжлөө илтгэсэн олон үеийн түүх, соёлын нэн арвин дурсгалтайгаараа гайхагддаг орон.

Монгол нутгаас олдсон нэн эртний дурсгал бол "Шаамар хүн" юм. Орхон голын хөндийд орших Сэлэнгэ аймгийн Шаамар нутгаас геологичид 1975 онд 11 сая жилийн өмнөөс эхэлсэн плиоцен галавын үеийн ургамал, амьтны үлдэгдэл бүхий давхаргаас нэн эртний мичин хүний дунд чөмөг, эрүүний яс илрүүлэн олж, нарийвчлан судлаад, 3 сая орчим жилийн өмнөх үед холбогдуулж, хүн төрлийн мичин хүн (гоминид) Монголд байсныг тогтоожээ.

Монгол орны нутаг дэвсгэрт 750000-800000 жилээс цааш буюу палеолитын доод шатны элэр цагаас хүний өвөг дээдэс амьдарч байжээ. Хэдийгээр палеоантропологийн олдвор хараахан илрээгүй боловч илрүүлсэн неолитын үеийн олдворуудад краниологи, палеодемографийн судлагаа хийсэн. Судалгаанаас үзвэл неолитын үед өнөөгийн Монгол орны баруун ба баруун өмнөд хэсгээр антропологийн хэв шинжээрээ Тува, Минусын хотгорын орчмоор орших байсан кроманьон буюу өвөг Европ төрхтөнтэй төслөг хүйн овгууд,Төв ба Дорнод Монголын нутгаар Амур мөрөн, Өвөр Байгалын орчмын палеоази буюу сонгомол монгол төрхтөнтэй ойролцоо хүйн овгийнхон амьдарч байжээ. Палеолитын сүүлчээр Төв азид үүсч бүрэлдсэн эх газрын монголжуу арьстангууд нь неолитын үе болоход илүү монгол төрхтэй болсоор байсныг тэдний бууц суурингаас илрүүлсэн хүний ясанд хийсэн краниологийн судалгаа харуулжээ.

Монголчуудын гарал үүсэл, удамшлын түүхэн хөгжлийг мөшгөн судласан генетикийн эрдэмтэд "Монгол төрхтнүүдийн гарал үүсэл нь Монгол төвтэй Төв ази мөн" гэж тогтоожээ. Өөрөөр хэлбэл, Монгол үндэстний удмын сан маш эртнийх, Монголчууд нүүдэллэж ирээгүй, энэ нутагт амьдарч байсан эртний хүнээс гарал үүсэлтэй гэдгийг генетикийн судалгаагаар нотолжээ.

Иймээс Монголчууд хүн төрхийн хувьд дээд палеолитын эцсээр дэлхийн нийтийн хэмжээнд ялгарч гарсан европиед, нигероид, монголоид гэсэн гурван их арьстны монголиод их арьстны умард салаа, Төв азийн хэв маягт багтдаг, Алтай овгийн хэлтэнд хамаарагддаг. Монгол хэмээх нэрийг олон утгаар тайлбарладаг ч "Мон" гэсэн газрын нэр нэгэн ураг элгэн болохыг заасан "эл" гэсэн хоёр үсэгтэй нийлж, "монгол" хэмээх нэр бүтжээ. Мөн эрт үеэс ямагт нум сум агсан ан гөрөө хийн явах учир "Хор улс" буюу "Нум сум агсагсад", жилийн дөрвөн улиралд бэлчээр усны соргогийг даган нүүдэллэн аж төрдөг учраас "Нүүдэлчид", орон сууцны онцлогоор нь "Эсгий туургатан", түүнчлэн Монгол хэмээх нэрийг тодотгон, мөнх хөх тэнгэрийн болон хүүхэд нь хондлой дээрээ хөх толботой төрдөг угсаатны содон шинжээр нь "Хөх монгол", аливаад дийлдэшгүй, ариун чанд, бат бэх, өөдрөг бадрангуйг бэлгэдэж, малгайн орой дээрээ улаан залаа эрхэмлэн залдаг учраас "Улаан залаат монголчууд" ч гэдэг.

Чингис хаан 1206 онд Их Монгол улсыг байгуулсан нь Монгол улсын түүхэнд гарсан том дэвшилтэд үзэгдэл бөгөөд монголын төдийгүй дэлхийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Нүүдэлчдийн хүчирхэг төр улс байгуулагдсанаар нэгдмэл хил хязгаар, нутаг дэвсгэр,хүн ам, эдийн засаг бий болж, монгол хэл, бичиг, соёл найрсан төгөлдөржиж, улмаар үндэсний нэгдмэл үзэл ухамсар, сэтгэлгээ, бахархал батжин, монгол угсаатан бүрэлдэн төлөвших үйл явцад түүхэн шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ.

Тэнгэрийн орны хүмүүс гэгддэг Монголчуудын хамгийн хамгийнаас сонирхуулбал:

Монголчуудын дотроос өнгөрсөн мянган жилийн дэлхийн хамгийн манлай шилдэг хүнээр тодорсон Их Монгол улсыг эмхлэн байгуулж, Эзэнт Их гүрнийг үндэслэсэн төр,нийгэм, цэргийн гарамгай зүтгэлтэн Чингис хаан (1162-1227), есөн өрлөг тэргүүтэн төрийн их мэргэд, нүүдэлчдийн соёлын сэргэн мандлын нэрт төлөөлөгч, алдарт уран баримал Өндөр гэгээн Занабазар (1635-1724) тэргүүтэн шашин ном, урлаг соёлын дэлхийн хийгээд дорнын билигтнүүд олон төрөн гарчээ.

2001 оны 1 сарын 1-ний байдлаар Монголд 100-108 хүртэлх өндөр настан 42 байсны 34 нь эмэгтэйчүүд байна. Хамгийн өндөр настан нь 117 нас зооглосон Өмнөговь аймгийн Манлай сумын уугуул эмэгтэй Дэлгэр (1861-1978) юм. Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын малчин В.Долгор гуай 1993 онд 100 настайдаа багийнхаа эмэгтэй даамчдын аварга болж байжээ.

Хамгийн өндөр хүн Архангай аймгийн Батцэнгэл сумын уугуул Ц.Шаравжамц (2 м 75 см), өндөр хэмээх Гонгор (2 м 64 см). 1913 онд Гонгорт хийж өгсөн дээлэнд 45 ширхэг хурганы арьс орсон гэдэг. XIX зууны алдарт бөх Өсөхбаяр аваргад 60 гаруй насалж, мах мяраа ихэд шуугдсан үед нь хийж өгсөн зодогны ханцуйны үзүүрээс нөгөөд хүртэлх бараг 2 м, захны голоос хормой хүртэл 0.5 м, далбааны суганы хооронд 70 гаруй см, ханцуйны бугуйн өргөн 11:14 см, бүдүүн булчингийн орчмын ханцуйны өргөн 20:25 см байгаа нь их том биетэй бөх болох нь мэдэгдэнэ. Насанд хүрсэн хамгийн



жижиг хүн болох Дорнод аймгийн Чойбалсан сумын Сүмбэр багийн иргэн Ж.Ичинхорлоогийн биеийн жин 30 кг, өндөр 90 см. Тэрбээр 1971, 1977 онд 2,5 кг; 2,9 кг жинтэй хоёр хүүхэд төрүүлж, 1995 онд ачтай болсон ба нэртэй уран үйлч юм.

Хоёр ташаандаа нэжгээд даага сугадаад алхчихдаг Сайн ноён хан аймгийн Ачит гүний хошууны Шалхаан заан хэмээх Даваацэрэн, залуудаа 4 ханатай гэрээ үүрээд 40 гаруй км хол нүүж, дал гаруй насандаа 70 кг шуудай гурил гурвыг үүрээд 600-аад метр явж байсан Өмнөговь аймгийн Номгон сумын өндөр Магсар, гагц өөрийн биеэр нас гүйцсэн атан тэмээний толгойг сугандаа хавчуулаад буйлладаг Цогт овоо сумын малчин эмэгтэй Г.Цэнд зэрэг их бяр тэнхээтэн олон байжээ.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын харъяат гүйдэг Гэндэн, Төв аймгийн Бүрэн сумын Дээнэн, Завхан аймгийн Отгонтэнгэрийн хурдан Аюуш, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын малчин гүйдэг Даш зэрэг хурдан хүмүүс байсны дотор одоогийн Өмнөговь аймгийн Номгон сумын харъяат Барамын Шагдар гэгч Нийслэл хүрээнээс 800 гаруй км хол орших Хөрхийн ууланд 5-6 хоногийн дотор гүйгээд хүрдэг, усанд орсон зээрийн сүргийг хөөж гүйцээд барьдаг байсан гэдэг.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын ард уран Монхоорой нэг ч төмөр хийц оруулалгүйгээр хулсан зүүтэй үйлийн машин бүтээсэн нь өдгөө Баруун-Урт хотын музейд буй. Ийм маягийн үйлийн машиныг XX зууны эхээр жигүүртний адил далавч зохион бүтээж агаараар нисэхийг анхлан санаачилсан шүхэрчин Гэлэнхүү мөн хийж байжээ. Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын дархан Цэдэнхүү 1966 онд 36 өргөстэй 10 түлхүүртэй монгол цоож урласан нь ОНСМ (Орон нутаг судлах музей)-д байдаг.

Аман домгоос гадна бичгийн сурвалжид ер бусын монгол хүний тухай дурдсан байдгийн жишээ нь МНТ-нд "Торголжин баяны хоёр хөвгүүний нэг Дува сохор магнай дундаа ганц нүдтэй, гурван нүүдлийн газар хардаг" гэж өгүүлдэг.

Хубилай сэцэн хаан цанаар гулгадаг, Богд Живзундамба хутагт хаан төрөл бүрийн сонин хачин, ан амьтан, жигүүртэн, ховор нандин зүйл цуглуулах хоббитой байжээ.

Монголын олон ястны дунд ч өвөрмөц содон зан үйл байдгаас, урианхай эмэгтэйчүүд гэзгээ 40 салаа, эрэгтэйчүүд 4 салаа сүлждэг уламжлал саяхан болтол байсан бол буриад, мянгад, ялангуяа халх эмэгтэйчүүд үгалз чимэг ихтэй, ур ухаан шалгасан жижиг хэт хутгаар гангалдаг байжээ.

Монголын хүн амын өсөлт хөгжилтөнд түүхийн аль ч цаг үед улс оронд болоод дэлхий дахинд өрнөсөн байгалийн ба нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын олон хүчин зүйл их бага хэмжээгээр нөлөөлсөөр ирсэн байна.

Дэлхийн хүн амын дөнгөж 8 хувь нь далайн түвшнээс дээш 1000 метрийн өндөрт амьдардаг бол монголын хүн амын 90 хувь нь д.т.дээш 1000-2000 метрийн өндөрт амьдардаг. Монголчуудын бие мах бодь, зан төрх, ухамсар, сэтгэлгээ, гоо зүй, бэлгэдэл, эрхэмнэл, шүтлэг бишрэл зэрэгт байгаль орчин, эрхлэх аж ахуйн өвөрмөц онцлог шингэмэл байдаг.

Монгол угсаатан түүхэн хувь заяаны эрхээр өдгөө Монгол улсаас гадна ази, европ, америк тивийн олон оронд аж төрж байгаагаас хамгийн олон 3.6 сая нь БНХАУ-д, 0.5 сая нь ОХУ-д, 0.03 сая нь Афганистан улсад болон Европ, америк тивийн бусад улс оронд аж төрдөг.

Монгол улс янз бүрийн түүхэн цаг үед хүн амаа бүртгэн тоолсоор иржээ. 1247 оны тооллогоор 2 сая орчим, Юань гүрний үед 2.5 сая байсан ажээ.

Манжийн ноёрхлын үед хүн амын тооллого явуулж байсан боловч бодитой нэгдсэн судалгаа бараг хийгдээгүй.

Харин Богд хаант Монгол улсын засгийн газар 1918 онд хүн ам, мал хөрөнгийн албан ёсны тооллого явуулсан. Тэр үед монгол хүн ам хагас саяас ялимгүй илүү (542,5 мян.) байжээ.

Статистикийн баримтаас үзвэл, манай улсын хүн ам 1925 онд 647.5 мян, 1935 онд 738.2 мян, 1944 онд 759.1 мян, 1956 онд 845,5 мян, 1963 онд 1017,1 мян, 1969 онд 1197,6 мянга, 1979 онд 1595,0 мян, 1989 онд 2044.0 мянга[7] болтлоо өсжээ.

2000 онд явуулсан хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс үзвэл, Монгол улсын байнгын оршин суугч 2373493 хүн байна.

Түүнээс 1177981 нь эрэгтэйчүүд, 1195512 нь эмэгтэйчүүд байна.1989 оны тооллогоор суурин хүн амын тоо 2043954 байсан бол 1989-2000 оны хоорондох 11 жилд хүн ам 16,1 хувиар өсчээ. өөрөөр хэлбэл, хүн амын жилийн дундаж өсөлт 1,4 хувь болж, энэ нь урьд өмнөх тооллого хоорондын өсөлтийн хувьтай харьцуулахад нэлээд доогуур үзүүлэлт юм. 1956 оноос хүн амын жилийн дундаж өсөлт огцом нэмэгдэж, 1989 он хүртэл 2,5 хувиас дээш өсөлттэй байжээ. 1944-2000 онд хүн амын жилийн дундаж өсөлт 1,4 хувь байв.



Хүйсийн харьцаа бага багаар буурч байгаа бөгөөд энэ нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү, мөн зарим талаар гадаадад шилжин явагсдын дунд эрэгтэйчүүд давамгайлж байгаагаас шалтгаалж байна.

Хүн амын суурьшилтын судалгааны дүнгээс үзвэл, өмнөд болон зүүн бүс нутгийг бодвол Улаанбаатар хот, төвийн болон баруун бүс нутагт хүн ам илүү нягт суурьшсан байна. Нийт хүн амын бараг гуравны хоёр нь буюу 3 хүн тутмын нэг нь Улаанбаатар хотод, 60-аас илүү хувь нь төвийн бүс нутаг (Улаанбаатар хот ороод)-т амьдарч байна. Хүн амын нягтрал арай илүү нутагт Улаанбаатар хотоос гадна Дархан-Уул, Орхон, Архангай, Өвөрхангай аймаг, мөн Төв болон Сэлэнгэ аймгийн төмөр замын дагуух харьцангуй хөгжсөн суурин газрууд багтаж байна. Нийт хүн амын бараг 18 хувь нь Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймгуудыг багтаасан баруун бүс нутагт амьдарч байна. Харин хүн амын 20-иос бага хувь нь хүн ам сийрэг суурьшсан өмнөд болон зүүн бүс нутагт амьдарч байна. Нийслэл хотоос гадна Хөвсгөл, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Архангай аймаг хамгийн олон хүн амтай бол өмнөд бүсийн Говьсүмбэр, Өмнөговь Дорноговь, Дундговь аймгууд хамгийн бага хүн амтай байна.

Сүүлийн 30-аад жил Монгол улсад хотжих хандлага улам нэмэгдсэн нь хүн амын суурьшилтад хүчтэй нөлөөлсөн. Нийслэл хот болон томоохон хот, суурин газрууд нь үйлдвэр аж ахуйн болон эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны ялангуяа ажлын байр бий болгох төв болж буй нь хөдөөнөөс хүмүүсийг татаж, хотжилтын үйл явцыг өргөжүүлсээр байна.

2000 онд нийт хүн амын 57 хувь буюу 1345 000 хүн хотод, өөрөөр хэлбэл, нийслэл Улаанбаатар хот, 21 аймгийн төв, суурин газруудад амьдарч байна.

Аймгууд хотжилтын түвшний хувьд хоорондоо нэлээд ялгаатай байна. Аймгуудад хотын дэд бүтэц, тухайлбал, боловсролын янз бүрийн түвшний сургууль, үйлдвэр харилцаа холбоо харьцангуй илүү хөгжсөн нь 1989-2000 оны хооронд шилжигсдийг нэмэгдүүлж, аймгийн хүн амд хотын хүн амын эзлэх хувийн жинг өсгөжээ. Хамгийн хотжилт өндөртэй аймгуудад төмөр замын дагуу Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Сэлэнгэ болон Дорнод аймаг орж байна. 2000 оны байдлаар дээрх аймгийн хүн амын талаас илүү хувь нь хотод амьдарч буй нь хотжих үйл явц үргэлжилж байгааг

харуулна. Харин хүн ам ихтэй, төмөр замгүй Архангай, Өвөрхангай зэрэг аймгийн хүн амын 80 гаруй хувь хөдөөд амьдарч буй нь ийм бүс нутагт хотжилт бус байгаль, нутаг дэвсгэрийн таатай нөхцөлөөс шалтгаалжээ. Мөн нийслэл хот өргөжиж, хил хязгаар тэлэгдсэн ч Төв аймгийн хөдөөгийн шинж төрх хэвээрээ хадгалагдсан байна. 40000-аас дээш хүн амтай хотуудад Улаанбаатар (846,0 мян.), Эрдэнэт (91,0 мян), Дархан (80,0 мян.), Чойбалсан (50,0 мян.) зэрэг хотууд орж байгаа юм.

Хэдийгээр хүн амын суурьшилт сийрэг, цөөн хүн амтай боловч зүүн бүс нутагт хотжилт харьцангуй өндөр байгаа юм. Харин баруун бүс нутагт хүн ам олон, суурьшлын хувьд тийм ч сийрэг биш боловч хотжилтын түвшин хамгийн доогуур байна. Төвийн болон өмнөд бүс нутагт хүн амын тоо, суурьшлын төрхөөрөө адилгүй ч, хотжилтын түвшин адил байна. Аймгууд хот, суурин газрын шинж чанарын хувьд нэлээд ялгаатай бөгөөд төвийн бүсийн томоохон аймгийн төв, хот суурин газраас өмнөд болон зүүн бүс нутгийн аймгийн төв, тосгон нь дэд бүтэц ба бусад нөхцөлөөрөө сул байна.

Хүн амын нягтрал. 2002 онд монгол улсын нэг квадрат километр нутаг дэвсгэрт 1,58 хүн ногдож байгаа нь дэлхийн сийрэг суурьшилтай орны тоонд орж байна.

Томоохон хот суурин газарт чиглэсэн шилжих хөдөлгөөнөөр хотжилт багатай олон аймгийн хүн амын өсөлт дунджаас доогуур, хүн амын нягтрал 1989-2002 оны хугацаанд маш бага өсч, зарим аймагт буурсан байна.

Хүн амын өсөлт. Хүн амын өсөлт нь тухайн улс орны нийгэм, улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, эрүүлийг хамгаалах, соёл боловсролын хөгжил дэвшлээс ихээхэн шалтгаалдаг. Хүн амын өсөлтөд нөлөөлдөг гол хүчин зүйлс нь хүн амын ердийн цэвэр өсөлт, гадаад шилжих хөдөлгөөн болно. 1918-1935, 1935-1944 оны тооллого хоорондын хүн амын өсөлт бага байгаа нь дэлхийн нэг хоёрдугаар дайн, Монгол оронд өрнөсөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, 1911 оны болон 1921 оны хувьсгал, харийн түрэмгийлэл, зүүнтний алдаа завхралаас үүдэн гадаадад дайжсан дурвэлт, 1932 оны бослого тэмцэл, 1930-аад оны их хэлмэгдүүлэлт, хүн амын дунд тархсан өвчлөлтийн улмаас нас баралт ихэсч төрөлт буурсан зэрэг нийгэм улс төрийн олон хүчин зүйлээс шалтгаалжээ. 1956-аас 1989 оны хооронд хүн амын жилийн дундаж өсөлт 2,5-3,0 хувьтай харьцангуй бага хэлбэлзэлтэй байжээ. Харин 1989-2000 оны тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлт 1,4 болсон нь 1979-1989 оны хоорондох өсөлтөөс 1,1 пунктээр буурчээ.1989 оноос төрөлт буурч, 1000 хүнд ногдох төрөлтийн түвшин 1989 онд 36,5



байсан бол 1999 онд 20,4 болж, 40 гаруй хувиар буурчээ. Энэ нь шилжилтийн үеийн эдийн засгийн хүндрэл бэрхшээл, хүн амын амьжиргааны түвшний доройтол, эмэгтэйчүүд жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл өргөн ашигладаг болсонтой холбоотой. Түүнчлэн 1990 оны эхээр хатуу хяналтын дор хийгддэг байсан үр хөндөлтийг чөлөөтэй болгосон зэрэг олон хүчин зүйл нөлөөлжээ. Мөн гадаадад шилжих хөдөлгөөн нэмэгдэж, 1989 онд Монгол улсад ажиллаж амьдарч байсан хуучин Зөвлөлт Холбоот Улсын 50 гаруй мянган иргэн нутаг буцаж, 1992 оноос 60 гаруй мянган казах иргэд Казахстан улсад хөдөлмөрийн гэрээтэй ажилллахаар шилжин суурьшсаны зэрэгцээ олон мянган залуучууд гадаадад гарч хөдөлмөр эрхэлж, суралцах болсонтой холбоотой гэж мэргэжилтнүүд үздэг.

1989-2000 оны хүн амын жилийн дундаж өсөлтийг өмнөх арван жилийнхтэй харьцуулахад зөвхөн Архангай (0,86-гаас 1,27), Хөвсгөл (1,41-ээс 1,43) аймагт нэмэгдэж, бусад аймагт, Улаанбаатар хотын хувьд буурсан байна. Өөрөөр хэлбэл, дурдсан хоёр аймгийн хүн ам 1989-2000 онд нэмэгдсэн ч 1979-1989 оныхтой харьцуулахад өсөлтийн хувь доогуур, харин Дорноговь, Дорнод, Төв, Хэнтий, Дархан-Уул аймгийн хүн ам 1989-2000 онд буурсан байна.

Сүүлийн 11 жилд аймаг, нийслэлийн хүн амын өсөлтөд шилжих хөдөлгөөн голлох нөлөө үзүүлжээ. Улаанбаатар хот, Орхон, Булган, Хөвсгөл аймгуудын хүн амын жилийн дундаж өсөлт улсын дунджаас дээгүүр байна.

1989-2000 оны тооллогын хугацаанд хүн амын өсөлтийг тодорхойлдог төрөлт, нас баралт аймаг, нийслэлээр төдий л ялгаагүй. Харин Дорноговь аймгийн хүн ам жилд дунджаар 1,1 хувиар буурч, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан аймгуудын хүн ам бараг өсөөгүй байна. Энэ нь 1989 оноос хойш хүн амын дотоод болон гадаад шилжих хөдөлгөөн нэмэгдэж, эдгээр аймгуудаас олон тооны шилжин явсантай холбоотой ажээ.

Хүн амын нас, хүйсийн бүтцийн хувьд 2000 оны тооллогоор ажиглагдсан насны бүтцийн хувьд хамгийн онцлог шинж бол 0-4 ба 5-9 насны хүн амын тоо 10-14 насныхантай харьцуулахад буурсан явдал юм.



Насны бүтцийг харуулсан дээрх хүснэгтээс үзэхэд, гол өөрчлөлт нь сүүлийн 30 жилд 15-64 насны буюу хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь тогтвортой нэмэгдэж харин 0-14 насны хүүхдийн эзлэх хувь буурч байгаа явдал юм.

Хүн ам зүйн судалгаанд хүйсийн харьцаа нас ахих тутам мэдэгдэхүйцээр буурахыг хэвийн үзэгдэл гэж үздэг бөгөөд төрөх үеийн хүйсийн харьцаа дэлхийн аль ч оронд 104-106-ийн хооронд байдаг зүй тогтолтой. Энэ зүй тогтолтой харьцуулахад 0-4 насны бүлэгт хүйсийн харьцаа 102 байгаа нь харьцангуй доогуур үзүүлэлт ажээ. Хүйсийн харьцаа нас ахих тутам буурч байгаа нь эрэгтэйчүүдийн дунд нас баралт харьцангуй илүү байгаатай холбоотой. Судалгаанаас үзвэл насны бүлэг дэх хүйсийн харьцаа нь төрөх үеийн хүйсийн харьцаа, нас баралтаас гадна хүйсийн ялгаатай шилжих хөдөлгөөнөөс мөн шалтгаалжбайна.

Хүн амын насны бүтэц

Насны бүлэг (оноор)	1979 (%-иар)	1989 (%-иар)	2000 (%-иар)
Бүгд	100.0	100.0	100.0
0-14 насны	44.3	41.9	35.8
15-64 насны	50.7	54.1	60.7
65-аас дээш	5.0	4.0	3.5

Гэрлэлт. Гэрлэлтийн хувьд ч зарим өөрчлөлт гарсан бөгөөд огт гэрлээгүй хүмүүсийн эзлэх хувь 1979 оны тооллогоор 23 хувь байсан бол 2000 онд 33 хувь болж өссөн явдал юм. Энэ нь залуучууд хожуу гэрлэдэг болсонтой холбоотой. 1989 оны тооллогооос хойшхи хугацаанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас хойшилж, 2 жил хагасаар нэмэгджээ. Мөн гэрлэлтээ цуцалсан ба тусгаарласан хүний эзлэх хувь өсч, бэлбэсэн хүн амын эзлэх хувь буурсан үзүүлэлт нь гэрлэлтэд гарсан сонирхолтой үзэгдэл юм.

Монгол улсад байнга оршин суудаг хүн амын тоо
(харъяалал, угсаатны бүлэг, хүйсээр
2000 оны байдлаар)

Угсаатны бүлэг	Бүгд	Хүйсээр	
		эрэгтэй	эмэгтэй
Бүгд	2.373.493	1.177.981	1.195.512
Монгол улсын харъяат	2.365.269	1.173.407	1.191.862
үүнээс			
Монгол угсаатан			
Халх	1.934.674	956.667	978.007
Дөрвөд	66.706	33.566	33.140
Буриад	40.620	20.217	20.403
Баяд	50.824	25.795	25.029
Дарьганга	31.908	16.240	15.669
Урианхай	25.183	12.620	12.563
Захчин	29.766	14.949	14.817
Дархад	19.019	9.315	9.704
Торгууд	12.628	6.340	6.288
Өлд	14.634	7.397	7.237
Мянгад	6.082	3.019	3.063
Барга	2.506	1.293	1.213
Үзэмчин	2.386	1.221	1.165
Харчин	266	141	125
Цахар	123	66	57
Хотгойд	7.237	3.719	3.518
Элжигэн	151	73	78
Цаатан	303	152	151
Хамниган	565	294	271
Хошууд	183	92	91
Сартуул	1.540	767	773
Хорчин	150	89	61
Халимаг	5	3	2
Түрэг угсаатан			
Казах	102.983	51.869	51.114
Хотон	9.014	4.537	4.477
Тува	4.778	2.373	2.405
Чантуу	380	217	163
Бусад			
Орос	158	75	83
Хятад	173	114	59
Монголын харъяат	323	187	136
Гадаадын харъяат	8.128	4.517	3.611
Харъяалалгүй	96	57	39

Харъяалал, угсаатны бүлгүүд. 2000 оны тооллогоор Монгол улсад байнга оршин сууж байгаа хүн амын 99 хувь нь Монгол улсын харъяат байна. Үлдсэн хүн амын ихэнх (8128) нь монгол улсад оршин сууж буй гадаадын иргэд, мөн аль ч улсын харъяалалгүй цөөн тооны хүмүүс байна.

Гадаадын 30 гаруй орны хүн Монгол улсад байнга оршин сууж байна. Гадаадын харъяат нийт иргэдийн 42 хувийг орос, 25 хувийг хятад гаралтай иргэд тус тус эзэлж байна.

1989 оны тооллогын үед нийт хүн амын 2.8 хувь буюу 57 мянган гадаадын иргэд байсан бол 2000 онд хүн амын 0.3 хувь болжээ. Гадаадын иргэдийн тооны огцом бууралт ЗХУ-ын (хуучнаар) харъяат иргэдийн 1989 оноос хойшхи шилжин явалтаас голлон шалтгаалсан бөгөөд 2000 оны байдлаар ОХУ-ын харъяат 3.4 мянган иргэн, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан бусад улсын цөөн хүн амьдарч байна.

Хүн амын боловсролын ерөнхий түвшин сайжирч, 10 түүнээс дээш насны хүн амд дээд боловсролтой хүний эзлэх хувь 1989 онд 7.0 хувь байсан бол 2000 онд 7.6 хувь, дунд болон техник мэргэжлийн боловсролтой хүний эзлэх хувь 42.9 байснаа 49.8 хувь болж өсч харин боловсролгүй, бага боловсролтны эзлэх хувь буурсан байна. Дээд болон багаас дээш боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс давах болов.

Монгол улсын 15, түүнээс дээш насны хүн амын 97.8 хувь нь бичиг үсэг мэдэж байгаа нь олон улсын стандарт түвшинтэй харьцуулахад өндөр байна.

Д.Дашбадрах
С.Уранбилэг

ХҮН АМЫН УГСААТНЫ БҮРЭЛДЭХҮҮН, ГАРЛААС

Монгол улсын хүн ам 2000 оны байдлаар 2 365 269 байв. Тус улсын хүн амын 90 орчим хувь нь монголчууд, 8 хувь орчим нь түрэг угсаатны салбараас бүрдэж байна. Тэрчлэн монголжсон тунгүүс гаралтай, хамниган хэмээх цөөн хүмүүс бий. Монгол улсын хүн амыг бүрдүүлж буй эл угсаатны бүлгүүдийг тус бүрд нь товч танилцуулъя.



Халх нь монголын хүн амын 80 гаруй хувийг эзэлдэг. Халхчууд 2000 онд 1934674 хүнтэй байв. Халх хэмээх нэр нь XV-XVI зууны сүүл хүртэл улс төрийн утгаар хэрэглэгдэж байснаа XVII зууны эхнээс угсаатны нэр болсон. Тэр цагаас Халх нэрийн доор угсаатны хэдэн бүлэг багтан явжээ.

Жалайр нь анх X зууны үеэс түүхэнд нэр гарсан бөгөөд монгол, түрэг, тунгүүс овгуудаас бүрэлдсэн холимог угсаатай аймаг байв. Тэд XI зуунаас Хамаг Монголын эрх баригсадын хараат болж, XII зууны эцэст Чингисийн 13 хүрээний нэг нь болж, Их Монгол улсыг байгуулахад туслан оролцож мянган мянгалахад 7 мянган болж, зарим нь алтан ургийн ноёдын мэдэлд орсон байна. Алтан ургийнхны эзэмшилд очсон Жалайр нар нь XVI зууны сүүлчээс Халхын бүрэлдэхүүнд багтан, өдгөөгийн Говь-Алтай, Баянхонгор, Дорнод зэрэг аймагт ихэнх нь нутагшжээ.

Олхонуд бол X зуунд нэр нь гарсан язгуурын монгол аймаг. XIII зууны эхэнд эх Өгэлүн хатны эзэмшилд очиж, улмаар XVI зууны сүүлчээс Ар Халхын бүрэлдхүүнд багтан өдгөө Говь-Алтай аймгийн Баян-Уул, Хөхморьт, Жаргалан, Ховд аймгийн Дарви сумын үндсэн хүн ам нь болжээ.

Халх эмэгтэй, эрэгтэй хоёр
(Да хүрээ
1920-иод он)

Халх эхнэрийн толгойн гоёл
(МҮТМ)

Хатан хүний дээл
(МҮТМ)

Халх эрчүүдийн эдэлж хэрэглэдэг хэт хутга, бэл, гаанс, тамхины уут, соёо цохиуур
(МҮТМ)


ЖАЛАЙР ЯСТНУУДЫН БАЙРШЛЫН ЗУРАГ
УЛААНБААТАР
Улаангом
Өлгий
Ховд
Улиастай
Алтай
Мөрөн
Булган
Эрдэнэт
Цэцэрлэг
Баянхонгор
Арвайхээр
Зуунмод
Мандалговь
Сайншанд
Зүүнбаян
Даланзадгад
Өндөрхаан
Чойбалсан
Баруун-урт
Халхгол
Чойр
ГОВЬ-АЛТАЙ
БАЯНХОНГОР
ДУНДГОВЬ
ДОРНОГОВЬ
ӨМНӨГОВЬ
СҮХБААТАР
Масштаб 1:11 500 000
Томъёолсон тэмдэг
Жалайр овгийн тархац
Улсын хил
Аймгийн хил
Улсын нийслэл
Аймгийн төв
Хот, суурин газар


ОЛХОНУД БА ХӨХИЙД ЯСТНУУДЫН БАЙРШЛЫН ЗУРАГ
УЛААНБААТАР
Улаангом
Өлгий
Ховд
Улиастай
Алтай
Мөрөн
Булган
Эрдэнэт
Цэцэрлэг
Баянхонгор
Арвайхээр
Зуунмод
Мандалговь
Сайншанд
Зүүнбаян
Даланзадгад
Өндөрхаан
Чойбалсан
Баруун-урт
Халхгол
Чойр
ГОВЬ-АЛТАЙ
БАЯНХОНГОР
ДУНДГОВЬ
ДОРНОГОВЬ
ӨМНӨГОВЬ
СҮХБААТАР
Масштаб 1:11 500 000
Томъёолсон тэмдэг
Олхонуд бөөнөөр суурьшиж буй нутаг
Олхонуд овгийн тархац
Хөхийд бөөнөөр суурьшиж буй нутаг
Хөхийд овгийн тархац
Улсын хил
Аймгийн хил
Улсын нийслэл
Аймгийн төв
Хот, суурин газар

Бэсуд нь XI зууны эцсээр тайчуудаас салбарлан гарчээ. XIII зууны эхэнд Отчигины эзэмшилд очсоноос хойш халхын бүрэлдэхүүнд багтан, XVI зуунд Хангай уулаар нутаглан явснаа XVII зууны эхээр Алтайн зүүн урд хэсэгт суурьшин, өдгөөгийн Говь-Алтай аймгийн ихэнх, Баянхонгор аймгийн өмнө зүгийн сумдын хүн амыг бүрдүүлжээ.

Элжигин нь Хятан (X-XII зуун) улсын үед хонхэрээд, боржигин, барга зэргээс үүссэн аймаг. Элжигин гэдэг үг нь албан тушаалын нэрээс үүсч, угсаатны нэр болжээ. XII зууны эцэст Чингисийн 13 хүрээний нэг байв. XVII зуунд Ар халхын бүрэлдэхүүнд багтаж, XVIII зууны эхэнд баруун тийш нүүдэллэн, Хан Хөхүй ууланд хүрч нутаглан, одоогийн Увс аймгийн Өндөрхангай, Цагаанхайрхан, Зүүнхангай сум бүхэлдээ, Баруунтуруун сумын зарим хүн ам нь болжээ.

Горлос нь угтаа Хорь түмэдээс гаралтай юм. Тэд эрт цагт Баргужин хавь нутгаас Хэнтий ууланд иржээ. Тэр цагаас Хэнтий уул, Хянганы нурууны орчмоор Хонхэрээд, Ихэрс зэрэг аймагтай залган нутаглаж, улмаар Хамаг Монголын ноёдын хараат явжээ. Мянган мянгалсан цагт нэг хэсэг нь Өгэлүн эхийн эзэмшилд багтсан нь Халхын бүрэлдэхүүнд оржээ. Тэд XVII зууны үед Туул, Орхон голын дунд урсгалаар нутаглан байв. Горлос нар Халхын Түшээт хан аймгийн үндсэн хүн амыг бүрдүүлсэн аж.

Хиргис нь угтаа түрэг угсааны монголжсон аймаг, Енисей мөрний эхээр нутагласан хиргисийн зарим нь XIII зууны эхээр Их Монгол улсын захиргаанд орж захирагдан монголжсон байна. Тэд алтан ургийн ноёдын эрхшээлд явсаар Ар Халхын бүрэлдэхүүнд багтаж, Халхын Сайн ноён хан аймагт их төлөв нь нутаглаж суурьшжээ.

Хүрээ, хороо, цоохор хэмээх угсаатны бүлгүүд нь хожимхон цэрэг, аж ахуйн зохион байгуулалтаас үүсчээ. Тэдний ихэнх нь Халхын Сэцэн хан аймгийн зүүн 3 хошуунаас бусад хошуудын хүн амыг голлон бүрдүүлж, Монгол улсын зүүн хэсэгт суурьшсан байна.

Хатагин нь X зууны үед Алунгоо хатны бутач хүү Буха Хатаги, түүний үр сад, тэдний эзэмшил нараас анх үүсчээ. Тэд Хэрлэн, Онон, Туул гурван гол, Хэнтий уулаар нутаглан явав. XII зууны үед хатагин нар Халхгол орчмоор нутаглаж агснаа Их Монгол улсад багтан, Тулуйн удмын ноёдод захирагдсан байна. Тэд Халхгол хавиар нутагласаар Халхын бүрэлдэхүүнд оржээ.

Тэд Халхын Сэцэн хан аймгийн хатагин гурван хошуу гэгдэх болсон аж. Хатагин нар өдгөөгийн Дорнод аймгийн Матад, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар, Баруун-Урт сумандих төлөв нь суурьшжээ.

Хөхүйд нь XV зуунаас өмнө үүсэн буй болсон угсаатны бага бүлэг. Тэд Тулуйн угсааны ноёдод захирагдаж явсаар Халхын арын долоон отгийн бүрэлдэхүүнд багтаж Халхгол, Дорнодын талаар нутагласаар Хатагины бүрэлдэхүүнд багтжээ. Тэд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумaнд голлон нутаглажээ.

Сартуул нь XIII зууны үед Бухар, Ургенч зэрэг газруудаас олзлогдон монгол нутагт ирж монголжсон түрэг аймаг юм. Тэд алтан ургийн ноёдод захирагдан явсаар XVI зууны сүүл үед Халхын бүрэлдэхүүнд орж, Хангайн уулын баруун хэсгээр нутаглан, Халхын Засагт хан аймгийн Сэцэн засгийн хошууг бүрдүүлсээр одоогийн Завхан




ГОРЛОС (ХУРЛУД, ХУРЛАГАД) БА ХИРЭГҮД (ХИРГИС) ЯСТНУУДЫН БАЙРШЛЫН ЗУРАГ
Масштаб 1:11 500 000
Томъёолсон тэмдэг
Горлос (хурлуд, хурлагад) овгийн тархац
Хирэгүд (хиргис) овгийн тархац
Улсын хил
Аймгийн хил
Улсын нийслэл
Аймгийн төв
Хот, суурин газар
УЛААНБААТАР
ГОВЬ-АЛТАЙ
БАЯНХОНГОР
ӨМНӨГОВЬ
ДУНДГОВЬ
ДОРНОГОВЬ
СҮХБААТАР
Мандалговь
Сайншанд
Даланзадгад
Улиастай
Мөрөн
Булган
Баянхонгор
Арвайхээр
Зуунмод


ЦООХОР БА ХОЙД ЯСТНУУДЫН БАЙРШЛЫН ЗУРАГ
Масштаб 1:11 500 000
Томъёолсон тэмдэг
Цоохор овгийн тархац
Хойд бөөнөөр суурьшиж буй нутаг
Хойд овгийн тархац
Улсын хил
Аймгийн хил
Улсын нийслэл
Аймгийн төв
Хот, суурин газар
УЛААНБААТАР
ГОВЬ-АЛТАЙ
БАЯНХОНГОР
ӨМНӨГОВЬ
ДУНДГОВЬ
ДОРНОГОВЬ
СҮХБААТАР
Мандалговь
Сайншанд
Даланзадгад
Улиастай
Мөрөн
Булган
Баянхонгор
Арвайхээр
Зуунмод
Чойбалсан
Баруун-Урт


ХАТАГИН ЯСТНУУДЫН БАЙРШЛЫН ЗУРАГ
УЛААНБААТАР
Улаангом
Өлгий
Ховд
Улиастай
Алтай
Мөрөн
Булган
Баянхонгор
Арвайхээр
Мандалговь
Даланзадгад
Сайншанд
Зуунбаян
Өндөрхаан
Чойбалсан
Баруун-Урт
ГОВЬ-АЛТАЙ
БАЯНХОНГОР
ДУНДГОВЬ
ДОРНОГОВЬ
ӨМНӨГОВЬ
СҮХБААТАР
Масштаб 1:11 500 000
Т о м ъ ё о л с о н т э м д э г
Хатагин бөөнөөр суурьшиж буй нутаг
Хатагин овгийн тархац
Улсын хил
Аймгийн хил
Улсын нийслэл
Аймгийн төв
Хот, суурин газар

САРТУУЛ ЯСТНУУДЫН БАЙРШЛЫН ЗУРАГ
УЛААНБААТАР
Улаангом
Өлгий
Ховд
Улиастай
Алтай
Мөрөн
Булган
Баянхонгор
Арвайхээр
Мандалговь
Даланзадгад
Сайншанд
Зуунбаян
ГОВЬ-АЛТАЙ
БАЯНХОНГОР
ДУНДГОВЬ
ДОРНОГОВЬ
ӨМНӨГОВЬ
СҮХБААТАР
Масштаб 1:11 500 000
Т о м ъ ё о л с о н т э м д э г
Сартуул бөөнөөр суурьшиж буй нутаг
Сартуул овгийн тархац
Улсын хил
Аймгийн хил
Улсын нийслэл
Аймгийн төв
Хот, суурин газар

аймгийн Цэцэн-Уул, Завханмандал, Ургамал, Түдэвтэй, Сантмаргац, Сонгино, Эрдэнэхайрхан, Дөрвөлжин сум бүхэлдээ, Увс аймгийн Завхан сумын зүүн хэсэгт суурьшжээ.

Урианхан нь угтаа эртний Кумоси буюу Си аймгийн үр хойчис бололтой. Кумоси нар нь Сяньби, Хятан нартай удмын холбоотой, монгол угсааны аймаг байв.

Алтайн Урианхай айл (Ховд аймаг. 1928 он)

Урианхай хэмээх угсаатны нэр X зуунаас түүхэнд гарч, тэд Хятан улсад алба барьж явсан байна. Урианханы зарим нь X зууны үед Хэнтэй ууланд нутаглажээ. XIII зууны эхэнд Их Монгол улс байгуулагдахад урианхан нар таван мянган болсноос үзвэл тэд хүн ам олонтой байжээ. Тэр таван мянганы нэг нь Хэнтэй ууланд агсан монголын хаадын хориг (оршуулга)-ийг сахидаг байж. Түүнийг удачи (отчи)-ийн мянган хэмээнэ. Тэд XV-XVI зууны тэргүүн хагаст зүүн Монголын зургаан түмний нэг нь гэгддэг болов. Урианхан түмний нэг хэсэг нь Халх түмний дотор оржээ. Тэд XVI зууны эхээр баруун тийшлэн, Хангайн уулаар хэсэг нутагласнаа XVII зууны эхээр Алтайд хүрч суурьшин, Халхын Засагт хан аймгийн захиргаанд оржээ. Манжийн эрхшээлийн үед уг урианхай нар Дайчин засгийн хошуу, Дархан засгийн хошуу хэмээх хоёр хошуу болж явснаар одоогийн Говь-Алтай аймгийн Тонхил, Төгрөг, Цээл, Алтай, Бугат, Ховд аймгийн Цэцэг сумыг байгуулжээ.

Урьдын Халхын арын долоон отгийн хүн амаас үүссэн халхчуудын бүрэлдэхүүнд хожим нь бас угсаатны өөр бага бүлгүүд орж, тэдний угсаа соёлын хөгжилд оролцсон аж. Тэдгээр угсаатны бүлгүүдээс хотгойд, өөлд, хойд нарыг дурдаж болно.

Хотгойд нь Хөвсгөл аймгийн

Алтайн Урианхай эрэгтэй, эмэгтэй хоёр (Ховд аймаг. 1928 он)

Цэцэрлэг, Цагаан-Уул, Арбулаг, Бүрэнтогтох, Төмөрбулаг, Түнэл, Их-Уул, Завхан аймгийн Нөмрөг, Түдэвтэй, Баянхайрхан, Баянтэс, Тэс, Тэлмэн суманд хотгойд нар сууж байна. 2000 оны байдлаар хотгойдууд 7237 хүнтэй байв.

Хотгойд нар нь XV-XVIII зууны дунд үед Ойрад, Халхчуудаас бүрэлдэн тогтсон угсаатны бүлэг юм. Хотгойд нар XX зууны эхэн хүртэл Халх-Ойрадын завсрын аялгуугаар ярьдаг байсан бөгөөд өдгөө ч тэдний аман аялгуу, үгсийн санд нь ойрад аялгууны ул мөр үлдсэн байна. Тэдний хуримын ёс, хүн оршуулах зэрэг зан үйл, хувцас хунар, өмсгөл зүүсгэл зэрэг нь төв



халхчуудаас ялгаатай байв. Хотгойдын тэр орон нутгийн шинжтэй соёлын өвөрмөц зүйл нь халхчуудын нөлөөний хүрээнд хожимхон бүрэлдэн буй болжээ.

Өөлд. Халхын доторхи өөлд нь ойрадын тасархай юм. Манжийн түрэмгийллийг эсэргүүцсэн Галдан хаан 1696 онд Тэрэлжийн Зуунмодны газарт Манжийн цэрэгт цохигдсоны дараа түүний харьяат нарын зарим нь бутран сарнив. Чин улсын эрх баригсад ч Галдангийн харьяат нарыг янз бүрийн аргаар өөртөө татаж 1697 онд Галдангийн нэгэн жанжин Данжилыг, 1702 онд бас нэг жанжин Равданг харьяат ардынх нь хамт Манжид оруулан аваад хоёр хошуу болгон зохиогоод анхандаа Түй, Заг, Байдраг голуудаар нутаглуулж агсанаа 1730-аад онд тэднийг Зүүнгар улсын нутгаас холтгон Халхгол, Буйр нуурын орчинд аваачин суулгав.

Чин улсын эрх баригсад Зүүн гар хаант улсыг байлдан эзэлсэнийхээ дараа 1761 онд тэднийг дахин баруун тийш нүүлгэн, Орхон голын дунд урсгал, Өгий нуурын хавиар суулгаад, Халхын Сайн ноён хан аймагт захируулжээ. Тэгж Халхын төв нутагт ойрад хүн амаас бүрдсэн хоёр хошуу буй болсон аж.

1918 оны үед өөлд хоёр хошуунд 700 орчим өрх, 2300 шахам хүн ам байжээ. Эл хоёр хошууны хүн ам нь одоогийн Архангай аймгийн Өлзийт сумыг бүхэлдээ, Өгийнуур, Хотонт, Батцэнгэл сумын зарим хүн амыг бүрдүүлжээ. Энэ өөлдүүд нь олон зуун жил халхчуудын дунд суусаар халхжин, урьдын ёс заншил, аман аялгууны зүйлээ мартсан боловч настайчууд нь өөрсдийгөө ойрад гаралтай гэдгээ мэддэг байна.

Хойд нь Ойрадын язгуурын аймаг юм. XII зууны сүүлч XIII зууны эхэн үед тэднийг Хутуга Бэхи ноён захирч явав. XIII зууны сүүлчээр хойд аймаг Байгалын баруун бие, Хөвсгөл нуур орчмын нутгаас баруун тийшлэн, улмаар XV зуунд Алтайн уул хавьд очжээ.

Тэд XVII-XVIII зууны дунд үед цагаан туг, их мянган, өл түмэн, алаг гулз (угалз) хэмээх дөрвөн том овгоос голлон бүрэлдэж байжээ.

Хойдын зарим нь XVII зууны эхэн үеэр Хөх нуур, Ижил мөрөнд нүүжээ. Нутагтаа үлдсэн хойдын зарим нь Галдан Бошигтыг дагалдан Манжийн түрэмгийллийг эсэргүүцсэн дайнд оролцжээ. Тэд Манжид эзлэгдсэнд Чин гүрний эрх баригсад тэднийг Халхын Засагт хан аймагт багтаан захиргаж, нэгэн хошуу болгож, Шаргын нуур, Шаргын голоор нутаглуулан суулгасан нь одоо Говь–Алтай аймгийн Шарга суманд буй.

Чингэж Халхын дотор хойд буй болж, он удсаар тэд өөрсдийн ойрад аман аялгуу, ёс заншлын зүйлээ их төлөв гээж мартжээ. Гэвч тэд өөрсдийгөө ойрад гаралтай гэдгээ ухамсарладаг байна.

Монгол улсын баруун хэсгийн хүн амын тодорхой хэсгийг ойрадууд бүрдүүлж байна. Тэд бол эртний ойн иргэдийн үр хойчис бөгөөд XVII зууны сүүлчээр Зүүнгар хаант улсыг байгуулалцан түүний бүрэлдэхүүнд багтаж явсан билээ.

Баяд нь Увс аймгийн Зүүнговь, Тэс, Хяргас, Малчин, Наранбулаг суманд бөөнөөрөө, Бууунтуруун суманд элжигин халхчуудтай, Наранбулаг суманд дөрвөдтэй хольцолдон сууна. Баядууд 2000 оны байдлаар 50824 хүнтэй байв.

Баяд нь эрт цагт түүхийн тавцанд нэр нь гарсан Монголын томхон аймгийн нэг. Хүннү улсын Маодунь шаньюй манай тооллын өмнөх III зуунд Баян аймгийг байлдан эрхшээлдээ оруулж байж. Баяд хэмээх нэр нь баян гэдэг үгийн олны хэлбэр болно.

IX-XI зууны үед баяд нь олон салбартай, хүн ам олонтой байв. Тэр үед Сэлэнгэ мөрний сав дагуу одоогийн Хиагт, Бүрэн хан уул



хавиар нутаглагсдыг Хээрийн баяд, Жид голоор нутаглагсдыг Жидийн баяд хэмээдэг байв. XII зууны үед Хэнтэй уул, Хөлөн, Буйр нуурын орчмоор нутагласан баяд нь баяд-дуклад, баяд-горлос, чаншиуд-баяд, баяд-хиад гэх салбаруудтай байжээ.

Баяд нар XII зууны эцэс XIII зууны эхэн үед Тэмүжин Хамаг Монгол, Их Монгол улсыг байгуулахад түүнд туслан арван гурван хүрээнийх нь нэг болж явжээ.

Баядуудын зарим нь XIII зуунд ойрадуудтай хамт баруун тийш нүүдэллэн Хангай уулын баруун хэсэг, Дэлгэр мөрний дунд урсгал, Завхан голоор нутаглаж явснаа дараа нь Алтайд хүрч, Зүүнгар хаант улсын бүрэлдэхүүнд багтсан байна.

XVIII зууны дундуур Чин гүрний эрх баригсад Зүүнгар хаант улсыг эзлэх үед тэндэхийн баяд, дөрвөдийн ихэнх нь Эрчис гол хавь нутгаасаа зүүн тийш нүүдэллэн улмаар Алтайн уулыг Үенч, Бодонгоор давж, Халхын нутагт орж ирэхэд Чин улсын эрх баригсад 1754 онд Сайн заяатын чуулган гэгчийг байгуулан тэднийг түүнд харьяалуулан захируулжээ. Тэр үед баядууд Сайн заяатын чуулганы 11 хошууг бүрдүүлжээ. Тэднийг Тэс голын доод урсгал, Бөөрөг дэл элс, Тохой, Нарийны гол, Хан хөхий уулын ар, Бор хайрхан, Тогтохын шилээр нутаглуулан суулгасан нь одоо ч тэндээ суусаар байна.

Баядууд тууль арвинтай, туульчид олонтой юм. М.Парчин, Увхийн Батаа, Хүрхэрээ Харцага, Ганган Мятай, Замбал нарын туульчдын хайлдаг "Хан харанхуй", "Дайны хүрэл", "Бум эрдэнэ", "Хүлэг эрдэнэ" зэрэг баядын олон баатарлаг тууль дэлхий дахины тууль судлаачдын анхаарлыг татаж, нийтийн соёлын эрдэнэсийн санд өөрийн байр суурийг эзэлжээ.

Дөрвөд. Монгол улсын Увс аймгийн Бөхмөрөн, Давст, Сагил,

Дөрвөд хүмүүс
(Увс аймаг, 1928 он)

Өлгий, Өмнөговь, Ховд; Ховд аймгийн Дөргөн суманд дөрвөд нар бөөнөөрөө, Увс аймгийн Наранбулаг, Завхан, Тариалан; Баян-Өлгий аймгийн Ногооннуур суманд баяд, сартуул, хотон, хасаг нартай хамт аж төрж байна. Монгол улсын дөрвөдүүдийн хүн ам 2000 онд 66706 байв.

Дөрвөд нь язгуурын монголчуудын бүрэлдэхүүнд багтаж явсан эртний аймаг. X зууны үед аж төрж агсан Дува сохор ноёны дөрвөн хүүгийн үр удам, тэдний харьяат нараас анх дөрвөд аймаг үүсвэрлэн бүй болсон аж.

Дөрвөд эрэгтэй, эмэгтэй
Увс аймаг (1939 он)

XII зууны үед дөрвөд нар Халхгол хавиар Татар, Салжиуд аймагтай зах залган нутаглаж байгаад 1206 онд Их Монгол улсын захирганд багтан, Төвийн болон баруун жигүүрийн түмэнд захирагджээ.

Тэд хожим нь Алтай ууланд хүрч Эрчис мөрний эхэн, дунд урсгалаар нутаглажээ. Нэгэн үе Монголын хаан сууж агсан Эсэн (1407-1454) хаан өөрийн хүү Борнагалд Дөрвөдийг өгч захируулжээ. Тэр цагаас дөрвөд нар Ойрадын нэгэн аймаг хэмээгдэж байснаа XVI зууны эхэн үеэс Ойрадын гол дөрвөн аймгийн тоонд орсон байна.

Дөрвөдийн зарим нь 1620-иод оны сүүлчээр хошуудтай хамт Хөхнуур, Түвэдэд нүүдэллэсэн бол зарим нь бас XVII зууны эхээр Ойрадын зарим хэсэг Ижил мөрөн тийш нүүх үед тэдэнтэй цуг явсан байна. Нутагтаа үлдсэн дөрвөд нар Зүүнгар хаант улсыг байгуулахад идэвхтэй оролцон, түүний гол цөм хэсэг нь болсон байна. XVIII зууны дунд үеэр Манж Чин улс Зүүнгар улсыг эзлэх үед дөрвөдийн зарим нь зүүн тийш нүүдэллэн явсаар эцэст нь Увс нуур, Хархираа уул, Хар-Ус нуур хавьд нутаглан суужээ. Тэр үед Монголд эрхшээлээ тогтоож байсан Чин улсын эрх баригсад 2000 гаруй хүн амтай дөрвөдүүдийг 3 хошуу болгон, Сайн заяатын чуулганд багтаан захируулжээ.

Дөрвөдийн дундаас Буурал Сэсрэн, Баглаа, Хайнзан, Зодов нарын алдарт тууль, үлгэрчид төрөн гарчээ.

Захчин. Ховд аймгийн Алтай, Манхан, Зэрэг,Үенч суманд бөөнөөрөө, Мөст суманд урианхай нартай хамт сууж байна. Тэд 2000 онд 29766 хүнтэй байв.

Захчин нар нь XVII зууны эцэс XVIII зууны эхэн хагаст Зүүнгар хаант улсын хилийг харгалзан хамгаалагсдаас бүрэлдэн бүй болжээ. Зүүнгар улсын Галдан хаан (1671-1698) Ойрадын тайж нарын эзэмшлүүдээс хэсэг өрхийг татан авч, өөрийн улсын хилийг харгалзуулан суулгажээ. Энэ хэрэг явдал 1670-аад оны эхэн үеэр болжээ. Тэрхүү хил харгалзагсад XVIII зууны эхэн хагаст Зүүнгар улсын Киргиз, Дундад Азийн хотон, уйгур угсааны зарим улс, Халхтай хил савладаг нутгийн дагуу Тэнгэр уулын ар, Эрээн хавирга, Их, бага Жултас, Булингар, Өрөнгө, Булган, Чингэл гол, Цагаан тохой зэрэг газруудаар цувран сууж, улсынхаа хилийг сахин хамгаалж байжээ. Тэд нутгийн зах хязгаарт сууж, хил харгалздаг учир захчин нэр үүсэн байна.

XVIII зууны дунд үед Зүүнгар улсад 20 гаруй отог байсны нэг нь захчин отог юм. Тэр цагт захчин нар бүгд 2000 гаруй өрхөөс бүрдэж байсан бөгөөд хааны томилсон гурван зайсан тэднийг хуваан захирдаг байв.

Манж нар XVIII зууны дунд үеэр Зүүнгар хаант улсыг байлдан эзлэх үедээ Халх, Ойрадын хилийн дагуу сууж агсан захчин нарын зарим хэсгийг эзлэн аваад, нэг хошуу болгон зохион байгуулаад, Улиастайн манж жанжны газарт захируулжээ. Манж нар Зүүнгар хаант улсыг байлдан эзлэх явцдаа 2000 гаруй өрхтэй захчин отгийн хүн амын ихэнхийг хядаж, янз бүрийн нутгуудад сарниулан цацаад, үлдсэн 600 орчим өрх захчиныг Улиастайн жанжинд анхлан захируулж агснаа 1777 оноос Ховдын манж сайдын газарт захируулан, одоогийн нутагт нь суулгаад 1778 онд түүнийг хоёр хошуу болгон хуваасан байна.

Захчин нар нь XVIII зууны сүүлчээс эхлэн, баруун талаараа торгууд, баруун хойгуураа Алтайн урианхай, хойт талаараа Ховдын тариачин, өөлд, зүүнээрээ Засагт хан аймгийн урианхай нартай зах залган нутагласаар өдгөө хүрчээ.

Өөлд. Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд сууна. Тэд Цамбагарав уулын өмнөд бэл, Ховд голын баруун биеэр нутаглана. XV зууны наяад оны сүүлээр цорос, дөрвөд нараас өөлд хэмээх угсаатны бүлэг үүссэн хэмээн зарим сурвалжид дурдсан буй.

Манж Чин улсын түрэмгийллийг эсэргүүцсэн Галдан Бошигт хааны тэмцлийн үед

Захчин бүсгүйчүүд
Ховд аймаг (1930-аад он)

өөлдүүд Манж чин улсад эзлэгдэн, Орхон голын хөндий, Өгий нуур хавьд суулгасныг өмнө өгүүлсэн билээ. Тэдгээр өөлдүүдийн зарим нь

1764 онд Ховд голын хөндийд нүүн очиж суурьшсан аж. Тэднийг 1764 оноос нэгэн хошуу болгон Ховдын манж сайдад харьяалуулсан нь өдгөөгийн Эрдэнэбүрэн сумын өөлд юм.

Өөлдүүд нь халхчуудын дотор хэсэг хугацаанд суусан боловч өдгөө ойрад аман аялгуу, ёс заншил, эдийн соёлын зүйлээ хадгалж иржээ.

Өөлд эмэгтэй (Ховд аймаг Эрдэнэ-бүрэн сум. 1928 он)

Өөлд эмэгтэй хүүхдийн хамт (Ховд аймгийн Эрдэнэ-бүрэн сум . 1928 он)

Торгууд. Ховд аймгийн Булган суманд бөөнөөрөө сууж, Ховд голын хөндий, Алтайн өврөөр нутаглана. Монгол улсын торгуудууд 2000 онд 12628 хүнтэй байв.

Торгууд нь анхандаа ноёд, вангуудын орд өргөө, бие хамгаалах торгон цэргээс үүссэн аж. XII зууны сүүл үеэр Хэрээд аймгийн ван Тогорил тийм торгон цэрэгтэй байсан нь XIII зууны эхээр Их Монгол улсын голын түмэнд багтан орсон байна. Тэднийг тухайн үед Тогорил вангийн удмын ноёд захирч явжээ.

1420-иод оны үед Тогорилын удмын ноён Амгалан өөрийн харьяат торгууд нарыг аван Зүүн Монголоос нүүдэллэж, Ойрадын Тогоон тайшийг түшиж очсон аж. Тийнхүү тэр цагаас Ойрадын бүрэлдэхүүнд торгууд хэмээх аймаг буй болжээ. Торгууд нар анхандаа хүч нөлөө багатай боловч яваандаа эдийн засаг нь өсч хүн ам нь олшрохын хирээр нөлөө нь нэмэгдэн XVI зуунаас Ойрадын тэргүүлэх дөрвөн аймгийн нэг болсон байна. XVII зууны эхээр тэдний ихэнх нь баруун тийш нүүдэллэн Ижил мөрөнд хүрч, Халимаг нэр зүүж, тэнд нутагласан аж. Ижил руу нүүлгүй, Алтай нутагт үлдсэн торгууд нарын зарим нь бас хошууд нартай хамт Хөхнуурт нүүн очиж суусан байна.

XVIII зууны дундуур Манж Чин улсын эрх баригсад Зүүнгар хаант улсыг байлдан эзлэх үед Ойрадын дотор багтаж явсан торгуудын ихэнх нь Ижил мөрөн лүү зугтан очоод, урьд нь тэнд очсон торгууд, дөрвөд нартай хамт хэсэг хугацаанд нутаглан байгаад, 1771 онд тэдний зарим нь Алтай нутагтаа буцаж иржээ. Манжийн эрх баригсад тэдний олонхыг нь өдгөөгийн Шинжианд бас заримыг нь гурван хошуу болгон Ховд, Чингэл голоор нутаглуулан Ховдын Манж сайдын газарт захируулжээ. Эл гурван хошууны хоёр нь торгууд, нэг нь хошууд нараас бүрдэж байв. Хошуудын нэгэн хошуу нь хүн амаар цөөн байсан бөгөөд 230 гаруй жилийн туршид торгууд нарын дунд суусаар, тэдэнд уусаад, өдгөө настайчууд нь өөрсдийгөө хошууд хэмээдэг боловч аман аялгуу, ёс заншил, бусад зүйлээрээ торгуудаас ялгарах зүйлгүй болжээ. Эл гурван хошууг нэгтгэн 1931 онд Ховд аймгийн Булган сумыг байгуулсан нь өдгөө ч хэвээр байна.

Алтайн урианхай. Ховд аймгийн Мөнххайрхан, Дуут суманд бөөнөөрөө, мөн аймгийн Мөст суманд захчин нартай, Баян-Өлгий аймгийн Алтай, Булган, Бугат зэрэг сумдад казак нартай хамт сууна. Монгол улсын урианхай нарын тоо 2000 онд 25183 байв.

Алтайн урианхай нар нь XII-XIIIзууны эхээр өдгөөгийн Хэнтий уул, түүний хойт хэсгээр нутаглаж явсан урианхан нарын тасархай бололтой. XIII зууны үеийн Хубилай, Аригбөх нарын тэмцлийн үед урианхайн зарим хэсэг нь баруун тийш нүүдэллэн Ойрадын бүрэлдэхүүнд багтсан байна. Тэд цорос ноёдод захирагдан Зүүнгар улсын хойт хэсэг Алтайн уулаар нутаглаж байж. XVIII зууны эхээр Чин улсын эрх баригсад тэднийг эрхшээлдээ оруулан аваад монгол хэлт урианхай

Урианхай ястнууд цоор, домбор, хуур хөгжмөөр тоглож байгаа нь (Ховд аймаг. 1928 он)

нарыг дөрвөн хошуу болгоод Алтайд суулган, Ховд дахь манж сайдын газарт захируулжээ. Тэд тэр цагаас Манжийн төрд ангийн үс, махаар алба барьсаар XX зуунтай золгосон байна. Эл урианхай нар нь урдуураа торгууд, зүүн, зүүн өмнөд этгээдээрээ захчин, хойгуураа өөлд нартай зах залган нутаглаж иржээ.

Урианхай нар тууль, тууль-чдаараа нэрд гарчээ. Ачилдай, Жилкэр, Буян, Чойсүрэн, Оролмаа, Авирмэд нарын нэрт туульчид төрөн гарчээ. Тэдгээр туульчид "Эрийн сайн хэцүү бэрх", "Зул алдар хаан", "Хаан цэцэн зурхайч", "Талын хар бодон", "Хүдэр мөнгөн тэмнэ", "Хүрэл алтан дөш", "Наран хан

хөвгүүн", "Бужин даваа", "Баян цагаан өвгөн", "Эзэн улаан бодон", "Аргил цагаан өвгөн" зэрэг олон баатарлаг тууль хайлдаг байв.

Мянгад. Ховд аймгийн Мянгад суманд бөөнөөрөө сууна. 2000 онд мянгадын хүн ам 6082 байв.

Мянгад нь XVIII зууны эхэн хагаст Хотгойдын бүрэлдэхүүнд багтаж, түүний нэгэн отог болж явжээ. Манж Чин улсын эрх баригсад XVIII зууны эхэн үед Хотгойдыг эзлэн аваад, тэднийг таван хошуунд хуваан зохион байгуулахад мянгад нарын дийлэнх нь Засагт хан аймгийн Далай засгийн хошуунд багтан оржээ. Уг хошууны ноён Доржцэдэн тэднээс алба татвар их татаж зовоосон учир Ховд голын хойд хөндий, Алтан Хөхүй ууланд нүүн очиж суужээ. Тийнхүү тэд 1766 оноос Ховдод суусан манж амбанд захирагдсан нэгэн хошуу болсон аж.

Мянгад эхнэр.
(Ховд аймаг, Мянгад сум. 1930-аад он)

Мянгад нар өмнөд талаараа өөлд, халх, хойт болон зүүн талаараа дөрвөд нартай зах нийлэн суусаар он үджээ. Тэдний нэр нь мянганы тогтолцоо зонхилж агсан XIII-XIV зууны эхэн үед монгол хэлний мянга хэмээх тооны нэр үгээс үүссэн бололтой. Мянгад нар угтаа монголчуудаас гаралтай бөгөөд түүхийн янз бүрийн үед тэдэнтэй зах залган нутаглаж явсан тува зэрэг түрэг аймгуудын нөлөө тусч, зарим түрэг овог тэдний бүрэлдэхүүнд оролцсон байна.

Буриад. Булган аймгийн Тэшиг; Дорнод аймгийн Баяндун, Баян-Уул, Дашбалбар, Цагаан-Овоо; Сэлэнгэ аймгийн Ерөө; Төв аймгийн Мөнгөнморьт; Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр, Ханх; Хэнтий аймгийн Батширээт, Биндэр, Дадал, Норовлин, Баян-Адарга суманд буриадууд сууж байна. 2000 онд буриадын хүн ам 40620 байв.

Буриад эмэгтэй.
(Дорнод аймаг. 1940-өөд он)

Монгол улсын буриадууд нь XX зууны эхэн үеэр Орос улсын нутгаас нүүдэллэн ирж суурьшсан юм. Буриад нь дотроо хэдэн салбараас бүрдсэн монгол угсаатны нэгэн салаа юм. Тэд эртнээс Дундад Сибирийн өмнөд хэсгээр нутаглан мал адгуулж, ан агнан аж төрж, язгуурын монголчууд, тэдний өвөг дээдэстэй ойр дөт харилцаар иржээ.

XIII зууны эхэн үед Их Монгол улсыг байгуулахад буриад аймгууд түүний харьяанд орж захирагдсан байна. Тэр цагаас хойш тэд Монголын эрх баригсдын харьяанд захирагдан яваад, XVII зууны сүүлчээр Хаант Оросын харьяанд оржээ.

Буриад эмэгтэйн малгайн гоёл

XX зууны эхээр Монгол улсад нүүдэллэн ирсэн буриадын хурлын газрыг 1922 онд, орон нутгийн захиргааг 1923 онд байгуулж, Ерөө гол, Хэрлэн гол, Онон гол, Улз гол, Халх гол, Нөмрөг голын буриад хошуу хэмээх зургаан хошуунд хуваан захиргасан байна. Дараа нь 1920-иод оны дундаас 1930-аад оны сүүл үеийн засаг захиргааны шинэчлэлийн үед тэд дээр дурдсан сумдад орж захирагджээ.

Буриад нь Хорь, Ага, Сэлэнгэ, Ихэрид-Булгад, Түнхэн Алайрын буриад гэхчлэн хэдэн салбартай юм. Тэдгээрийн аль алинаас нь Монгол улсад ямар нэг хэмжээгээр нүүдэллэн ирсэн аж. Хэнтий аймгийн Батширээт, Биндэр, Дадал, Норовлин суманд ихэвчлэн хори буриад, Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Дашбалбар суманд голдуу агын буриад сууна. Агын буриад нь угтаа хорь буриадын нэгэн хэсэг юм.

Сэлэнгэ аймгийн Ерөө суманд бөөндүү, Алтанбулаг, Шаамар, Сүхбаатар зэрэгт халхчуудтай хамт буй буриадууд нь Сэлэнгийн буриадууд юм. Сэлэнгийн буриад нь XVII зууны цагт Халх нутгаас ойн гарагсдаас голлон бүрэлдэж тогтсон ажээ.

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр, Ханх; Булган аймгийн Тэшиг суманд суугсад нь Түнхэний буюу баруун буриадууд юм. Түнхэн, Алайрын буриадууд нь XVII-XVIII зууны тэргүүн хагасын үед Ойрад, Халхын зарим овгуудаас бүрэлдэж, хожимхон буй болсон юм.

Монгол улс дахь буриадууд нь өдгөө хүртэл өөрийн аман аялгуу, ёс заншлын зүйлийг хадгалж байна. Харин хувцас хунар зэрэг эдийн соёлын зүйлээ нэлээд гээж, монголжиж байна.

Барга. Дорнод аймгийн Хөлөнбуйр, Гурванзагал суманд сууж байна. Барга нар нь Хори буриадтай гарлын холбоотой аймаг. Түүхэн домогт, Байгал нуур орчимд Баргабаатар гэгч аж төрж агсан бөгөөд тэр 3 хүү төрүүлсэн. Ууган хүү Элиудараас тургуд (торгууд?), дэд хүү Буриадайгаас булгад-ихэрид хоёр, отгон хүү Хоридойгоос хори буриад овогтон үүссэн гэнэ.

Өдгөөгөөс 1400 орчим жилийн өмнөх үйл явдалтай холбогдон, нанхиад түүхэнд, Баегу хэмээх аймгийн нэр гардгийг судлаачид барга бололтой хэмээнэ. Тэднийг эртний Түрэгийн дурсгалд байырку хэмээн тэмдэглэжээ.

Баегу буюу Байырку нар VI-VII зууны үед Түрэгийн захиргаанд орж, Теле аймагтай хамт Туул голоос умарш нутаглаж явав. VIII зуунаас хойш тэд урьдын Байгал нуурын орчимд нутаглан, Мэргэд, Хори, язгуурын монголчуудтай ойр харилцаж байв.

XII зууны сүүл, XIII зууны эхэнд барга нь хори, тулас (теле), тумаут (түмэд) нартай хамтдаа нэгэн аймгийн холбоонд багтаж байв. XIII зууны эхэнд тэд Их Монгол улсын

захиргаанд орж, зарим нь урагш нүүдэллэн Их говийн урдуур нутаглаж байгаад, XIV зууны дунд үеэс Зүүн Монголд харьяалагдан, Ордосоос хойш нутаглан явснаа XVI зууны сүүлээр зүүн тийш нүүдэллэн, Хөлөн, Бойр, Эргүнэ Мөрөн, Хянганы нурууны хавиар нутаглан, ихэнх хэсэг нь Халх түмний хараанд оржээ. Хянганы нуруу хавиар нутагласан барга нар нь 1694 онд Манж Чин улсын захиргаанд орж, 1732 онд Хөлөн, Бойр нуурын орчинд нүүн ирж суурьшжээ.

Халхын харьяанд агсан барга нарын ихэнх нь мөн 1733 онд бас Хөлөн, Бойрын орчинд нүүн очиж, урьд жил нь тэнд ирж суусан барга нартайгаа хамт нутаглах болов. Хөлөн Бойрт 1732 онд очсон баргыг хуучин барга, дараа жил нь очигсдыг шинэ барга хэмээн нэрийддэг болжээ.

1911 онд Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн тунхагласны дараа 1915 онд Манлай баатар Ж.Дамдинсүрэн нар өөрсдийн харьяат барга нарыг Монгол улсад авчирсанд нэгэн хошуу болгоод, Сэцэн хан аймагт харьяалуулсан нь өдгөөгийн Гурванзагал сумын барга нар аж.

1946 онд Шаарийбуу гэдэг хүн Хөлөн Бойроос хэсэг баргыг нүүлгэн, Монгол улсад авчирсан нь одоогийн Хөлөнбойр сумынхан юм. Дээрх хоёр сумын барга нар нь угтаа Халхын харьяанд явсан шинэ барга нараас нүүдэллэн иржээ.

Барга нар нь хэдийгээр Хори буриадтай гарлын ойр холбоотой боловч түүхийн урт хугацаанд хори нараас тусдаа, халх, солон нартай хамт нутагласаар орон нутгийн шинжтэй соёлын хүрээг бүй болгосон байна. Тиймээс тэдний дээл, хувцас, орон сууц, ёс заншил, аман аялгуу зэрэг нь өөрийн өвөрмөц онцлогтой ажээ.

Дээр дурдсан Халх, Ойрад, Буриадуудаас өөр зарим аймгууд ч Монгол улсын оршин суугсдын бүрэлдэхүүнд багтаж байна. Тэдгээрт дархад, дарьганга, үзэмчин нар орж байна.

Дархад. Хөвсгөл аймгийн Ринчинлхүмбэ, Улаан-Уул, Цагаан-нуур, Баянзүрх суманд сууна.

Дархад нь XVII зууны эцсээс үүсч буй болжээ. 1688 онд Засагт хан аймгийн ноён Гэлэг өөрийн харьяат хүмүүсээс Өндөр гэгээн Занабазарт шавь болгон өгчээ. Тэрхүү шавь нараас өдгөөгийн дархадын үүсэл тавигдав.Дархад нар нь үүсч буй болсоноос хойш XX зууны эхэн хүртэл Жибзундамба хутагтуудын харьяат шавь гэгдэж явав. Тэдний засаг захиргааны нэгж нь отог байсан бөгөөд тэдний хүн, мал нь өсч ирсэн учир XIX зууны дунд үеэс зүүн, баруун, дунд гурван отог хуваагдан, отог бүр нэжгээд даргад захирагддаг болжээ. Отгийн даргын доор шүүлэнгэ, хиа тушаалтан ажиллаж байлаа.

Дархад нар 1788 онд нэг отог, 3223 хүн, 120011 малтай байсан бол 1924 онд 6175 ам, 95753 малтай байжээ. 2000 онд дархадын 4 сум 19019 хүн амтай байв.

Дархадын аман аялгуу нь баруун монголчуудын аялгуунд ойр бөгөөд халх, буриадын нөлөө туссан хэмээн судлаачид дүгнэжээ.

Дарьганга. Сүхбаатар аймгийн Асгат, Баяндэлгэр, Дарьганга, Наран, Онгон, Түвшинширээ, Уулбаян, Халзан суманд сууна. Дарьганга нар нь хожимхон үүсч буй болсон угсаатны бүлэг юм. 1697 онд Манж хааны шийдвэрээр Дарьгангын сүрэг хошууг үүсгэн байгуулжээ.

Халхын зүүн өмнөд хэсгийн нутаг, Өвөр Монголын Авга, Сөнөд хошууны нутгаас чөлөөлөн сугалж, Дарьгангын сүрэг хошуунд олгожээ.

Дарьгангад анхандаа Манж хааны адуун сүрэг байснаа сүүлд нь тэмээ, хонин сүргийг нэмэн байгуулжээ.

Дарьганга эмэгтэй (1939 он)

Адуун сүргийн ноёноор Халхын Цэрэнжавыг томилж, түүнийг харьяат ардынх нь хамт Дарьгангад нүүлгэн суулгажээ. Дараа нь Галдан Бошигтын цэргээс Манжид олзлогдсон мал, хүмүүс болон Халхын ноёдоос Чин улсын хаан, цэрэгт бэлэглэсэн малыг ч Дарьгангад суурьшуулжээ.Гурван зуу орчим жилийн туршид халх, ойрад, өвөрлөгч хүмүүс нэгэн тодорхой нутагт хамт суун, нэг чиг үүрэгтэй ажил гүйцэтгэн, нэгэн засаг захиргааны нэгжид багтан захирагдаж явсаар Дарьганга нар гэх угсаатны бүлэг үүссэн байна. Дарьганга хэмээх нэр нь Дарь уул, Ганга нуурын нэрээс үүссэн бололтой. Дарьганга нарын хуримын зан үйл, хүн оршуулах ёс, малым им тамга, эхнэр хүний хувцас, толгойн чимэглэл зэрэг нь бусад монголчуудаас ялгарах өөрийн онцлогтой юм. Тэрчлэн дарьгангад мөнгөн эдлэлийн биеэ даасан ур хийц, сургууль буй болсон нь монгол даяар их алдаршжээ.

Дарьганга нарын тэрхүү орон нутгийн шинжтэй соёлын өвөрмөц чанар нь XVIII-XX зууны эхэнд бүрэлдэн тогтсон байна.

Үзэмчин нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Сэргэлэн, Булган суманд халхчуудтай хамт нутаглана.

Үзэмчин гэдэг нэр нь үзэм хэмээх жимсний нэртэй холбоотой. Аман домгоор бол, үзэмчин нарын өвөг дээдэс нь үзэм тариалдаг байснаас тийм нэр зүүсэн гэнэ. Үзэмчин нар XVI зууны үеэс зүүн Монголын харьяанд багтан, Чингис хааны угсааны ноёдод захирагдаж явжээ. Үзэмчин нар 1637 онд Чин улсад захирагдав. Манжийн эрх баригсад тэднийг хоёр хошуу болгон зохиогоод, Шилийн голын чуулганд захируулжээ. Тэднийг зүүн үзэмчин, баруун үзэмчин хошуу хэмээн нэрлэнэ.

Монгол улсын үзэмчин нар нь БНХАУ-ын ӨМӨЗО-оос хожим шилжин ирж суурьшсан аж. Дорнод аймгийн Сэргэлэн, Булган сумын үзэмчин нь Өвөр Монголын зүүн үзэмчинээс, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагааных нь баруун үзэмчинээс 1945 онд Монгол улсад нүүдэллэн ирж суужээ.



Үзэмчин эмэгтэй

Үзэмчин аман аялгууг эрдэмтэд цахараас зүүн Монголд шилжиж буй завсрын аялгуунд хамруулсан байна.

Түүхийн янз бүрийн үед олон шалтгааны улмаас монголчуудын дотор харь гаралтай аймаг, овгийн хүмүүс орж ирсэн нь удаан хугацаанд монголжин, өдгөө монголоор ярьдаг болсон байна. Үүнд хотон, хамниганыг дурдаж болно.

Хотон. Увс аймгийн Тариалан суманд бөөн сууна. Хотон нь түрэг гаралтай, монголжсон аймаг. XVII зууны сүүл үеэр Зүүнгар улсын хаан Галдан Дундад Азид довтлон Хотан хот хавиар нутагласан түрэг угсааны зарим хүмүүсийг эрхшээлдээ оруулж, өөрийн нутаг Ил голын хөндийд авчран суулгажээ. Тэдгээр хүмүүсийг хотон хэмээн нэрийдсэн аж. Хотон нар Ил голын хөндий дагуу тариа, хүнсний ногоо тарьж, Зүүнгар улсад нийлүүлж байв.

Галдан хаан Манж Чин улсын түрэмгийллийг эсэргүүцэн тэмцэх үедээ бас хотон нараас цэрэгт дайчилж байв. Галдан Бошигтын цэрэгт явсан тэдгээр хотон нарын зарим нь 1690-ээд оноос Улаангом, Хархираа голын орчноор цэргийн тариа тарьдаг байлаа. Тэд Хархираа голоос суваг татан тариагаа усалж байсны ул мөр одоо бий бөгөөд нутгийнхан түүнийг Бошигтын бух (шуудуу) хэмээнэ.

XVIII зууны дунд үеэр дөрвөд, баяд нар Зүүнгар улсын нутгаас зүүн тийш нүүдэллэн Алтайг давж ирэх замдаа хэсэг хотон хүнийг олзлон авчээ. Тэд анхандаа баяд, дөрвөд нарын хамт Заг, Түй, Байдраг гол орчноор нутаглаж байснаа дараа нь Увс нуурын баруун өмнүүр одож нутаглаад, урьд нь тэнд тариа тарьж агсан хотон нартай хамт суун, Чин ван Цэрэн увашийн хошуунд багтан, нэгэн сум болжээ. Тэр цагаас хойш хотон нар Хархираа гол, Улаангом, Тогтохын шилийн баруунаар нутагласаар иржээ. XVIII зууны хоёрдугаар хагасаас XX зууны эхэн хүртэл хотон нар хошуу ноёндоо тариалангийн бүтээгдэхүүнээр алба барьж, малыг нь малладаг байжээ. Тэд 1870-аад оны дунд үед 100 орчим өрх, 1930 онд 200 гаруй өрх байсан бол 2000 онд 9014 хүнтэй байв.

Хотон нар монголчууд дунд удаан суухдаа, монголжоод, одоо дөрвөд аялгуугаар ярьдаг болсон байна. Гэвч тэд өөрсдийгөө монголчууд биш гэдгийг мэддэг, XX зууны эхэн хүртэл монголчуудтай бараг ураг барилдаггүй байв.

Хотон эрэгтэй эмэгтэй (Увс аймаг, Тариалан сум. 1928 он)

Хурим болоод хүн оршуулах зэрэг ёс заншлын зүйлд нь ч эртний мусульман ёсны зарим зүйл үлдэж хоцорсон аж. Хотон нар өөрийн өвөрмөц дээл хувцас, өмсгөл зүүсгэл, гоёл чимэглэлийн зүйлтэй байсан бөгөөд тэдгээр нь хожим монголчуудын нөлөөний хүрээнд үүсэн бүрэлдсэн ажээ.

Хамниган. Хэнтий, Сэлэнгэ, Төв, Дорнод аймгийн буриад нар амьдардаг ихэнх сумдад тархуу сууна. Хамниган нь монголжсон эвенки нар юм. Эвенки нь эртнээс Өвөр Байгал, Хилго, Ингэдэй, Онон голын дунд, доод урсгал дагуу ой тайгаар нутаглан ан агнаж, бас зарим нь мал адгуулан аж төрж, монголчуудын өвөг дээдэстэй ойр дөт харилцсаар он уджээ.

Монголчуудын хойгуур зах залган нутагласан эвенки нар эртнээс янз бүрийн шалтгаанаар монголчуудын дотор уван цуван орж, монголжсоор иржээ. Донгойд зэрэг зарим хамниган овог бүр XIII зуунаас өмнө монголчуудын дотор орсон аж. XIII зууны эхэнд Их Монгол улс байгуулагдаж, Сибирийн ард түмнүүдийг эрхшээлдээ оруулах үед мөн эвенки нар монголчуудын захиргаанд орж, аажимдаа тэдний зарим нь монголжин хамниган нэр зүүсэн бололтой.

Минжийн гол дахь Хамниган айл (1920-иод он)

XVII зууны үед Монголын хамниган нар нь Ерөөгийн, Сэцэн ханы, Хэнтийн хөвчийн гэсэн гурван хэсгээс бүрдэж байжээ.

XIX зууны дунд үед Сэцэн хан аймгийн Дархан засгийн хошуу (Хэнтий аймгийн Хэнтий, Жаргалтхаан сум) Дайчин засгийн хошуу (Хэнтий аймгийн Батноров, Бэрхийн хороо, захиргаа бүхэлдээ, Норовлин сумын ихэнх), Жонон засгийн хошуу (Хэнтий аймгийн Биндэр, Баян-Адарга сум), Эрдэнэ засгийн хошуу (Дорнод аймгийн Баян-Уул, Цагаан-Овоо сум бүхэлдээ, Хэнтий аймгийн Норовлин сумын зүүн өмнөд хэсэг)-нд хамниганаас бүрдсэн тусгай багуудтай байжээ. Мөн үед Их шавийн харьяат хамниган нар Ерөөгийн эхэн урсгалын голуудын хөндийгөөр нутаглан сууж байжээ. Хамниган нар хожим хүртэл бөөгийн шүтлэгтэй, алдартай бөө, удган нар XX зууны эхэн хүртэл байжээ. Тэд баавгай, буга зэрэг тураг ан агнахад хийдэг тусгай ёсыг баримталдаг, эсгий зэрэг зүйлээр үнэг унасан хүн дүрслэн, хүүхдийн сахиул хийдэг заншилтай аж.

Хамниган бөө, удган нар хамниганаараа онгодоо дуудаж буудаг байсан гэнэ. Харин XIX зууны эцэс XX зууны эхээр Сэцэн хан аймгийн хамниганы дунд бурхны шашин дэлгэрч, зарим нутагт хамниган лам нарын хурлын дуган байгуулагджээ.

Монгол хамнигадын ихэнх нь өдгөө хамниган хэлээ мартаж, 1960-аад оны сүүлээр 60-аас дээш насны цөөн өтгөс уугуул хэлээ гадарлах төдий байжээ. Монголын хамниганы аялгуунд дундад эртний монгол хэлний аялгууны зүйл хадгалагдаж ирснийг судлаачид тэмдэглэсэн байна. Тэр нь хамниган нар чухам хэдийд монголчуудын дунд орж ирснийг тоймлон мэдэх нэгэн гэрч тэмдэг юм.

Хамниган нар монголчуудын дунд олон зуун жил суухдаа, өөрийн гэсэн хувцас хунар, өмсгөл зүүсгэл, орон сууцны зүйл, ёс заншил зэрэг соёлын зүйлийг бүтээн хэрэглэсээр иржээ. Тэдний соёлын зүйл нь орон нутгийн шинжтэй ажээ.

Цаатан. Хөвсгөл аймгийн Цагааннуур, Ринчинлхүмбэ, Улаан-Уул сумын ууланд нутагладаг. Тэд цаа буга адгуулан өсгөж аж төрдөг учир цаатан (цаа+тан) буюу цаа бугатан хэмээн нэрлэгджээ. Цаатан нар нь уугаа Тагна уулаар нутагласан тува нарын нэг хэсэг юм. Тэд Тувагийн Тожи хошуунд анхандаа багтаж явсан бөгөөд дараа нь Монголд харьяалагдан, Богд Живзундамбын дархад шавь нарын бүрэлдэхүүнд оржээ.

Цаатан нар нь XX зууны эхэн үе хүртэл цаа буга маллан, уул тайгаар нутаглаж, ан агнаж, аж төрж байв. Тэд модны холтос, үйс, хальсаар бүрсэн урц овоохойд суудаг байв. Хожим нь урцаа брезент, даавуугаар бүтээдэг, радио сонсдог болжээ.

Цаатан нар бөө мөргөлтэй. Тэд урцныхаа унинд бөөгийн онгодын хэц уяж, түүний доор цааны арьсан уутай онгод дүүжилдэг. Нүүх үед ууттай онгодыг сэтэртэй эр цаанд ачиж явдаг. Эл онгодын цааг гэрийн эзнээс өөр хүн унах ёсгүй байжээ. Сүүлдээ цаа бугын тоо толгой нь хорогдож, амин зуулгад хүрэлцэхгүй болсон ба бас ой тайгын амьдрал нь бөглүү зэргээс болоод тэдний нэлээд нь нам дор газарт бууж, мал маллаж, өөр ажил эрхэлж аж төрдөг болжээ.

Цаатнуудын урц

Өдгөө цаатан нар монголжин, монголоор ярьдаг болсон боловч тэд өөрсдийнхөө уг гарлыг мэддэг аж. Цаатан нар 2000 онд 565 хүнтэй байв.

Зарим харь гаралтай аймгууд нь Монгол улсын харьяалалд орж, монголчуудын дунд суусан боловч өөрсдийн уугуул хэл, соёл, угсаатны ухамсраа хадгалсаар байна. Тэд тийнхүү угсаатны өөрийн чанараа хадгалан үлдэхэд нь юуны өмнө монголчуудын дотор суусан хугацаа, бас өөрсдийнх нь хүн амын тоо, бөөн бүлгээрээ нэг дор суусан зэрэг нь нөлөөлжээ. Үүнд казах, тува нарыг оруулж байна.

Казах. Баян-Өлгий аймагт бөөнөөрөө оршин сууна. Монголын казах нь түрэг угсаатны нэгэн салаа юм. Монгол улсад буй түрэг угсаатны бүлгүүдээс хүн амаар хамгийн олон, өөрийн уугуул ёс заншил, аж байдлыг хамгийн сайн хадгалсан нь казах нар болно.

Анч бүргэдтэй хасаг гөрөөчин эрчүүд

Монголын казахуудын ойрхи үеийн дээдэс нь XIII зуунаас Монголын эзэнт гүрний захиргаанд зуутын зохион байгуулалтад орж явав. Тэр үеийн засаг захиргааны зохион байгуулалтын улбаа хожим хүртэл тэдний дунд байсаар байв. XVI-XVIII зууны эхэн хагаст тэд гурван зуут (жүз)-д хуваагдаж байв. Их зуут (улу жүз) нь Долоон усны газар, дунд зуут (орта жүз) нь Ишим, Эрчис голын хөндийгөөр, бага зуут (киши жүз) нь Өмнөд Казахстанаар нутаглаж байлаа.

XVII зуунаас Казахын хант улсын хүч нь сульдаж, зүүн талаасаа Зүүнгар улсад шахагдан, умардаас Бухар, Хивийнхэн цөмрөн түрэмгийлсэнд XVIII зуунаас тэдний зарим нь Оросыг түшиж, зарим нь Шинжианд ойн гарч, улмаар Манж Чин улсын эрхшээлд оржээ. Шинжианд нутагласан малчин казахуудын зарим нь 1870-аад оноос Алтайн уулыг давж, Монголын хязгаарт уван цуван нүүдэллэн ирж, Булган, Дэлүүн, Толбо орчмоор нутагласан нь өнөөгийн Баян-Өлгий аймгийн казахууд юм.

Монголын казахуудын ихэнх нь дунд зуутад багтаж явсан Абах керей аймгийнхны үр хойчис аж. Анхандаа тэд монгол урианхай нартай тохиролцон, нутгийн зарим хэсгийг нь түрээслэн нутаглаж байснаа аажимдаа бүрмөсөн суурьшсан байна.

Абах керейгээс гадна Монголд найман овогт казахууд бий. Тэд бол Кош-Агач, Чуй голоор нутаглаж байгаад монгол нутагт орж ирсэн юм. Тэднийг есөн туг найман гэх бөгөөд товчлон найман ч гэнэ. 1917 онд казахууд албан ёсоор Монгол улсын харьяат болж, шерүүч, шыбыр-айгыр, ботохари хэмээх 3 хошуунд хуваагдан захирагджээ. 1925 онд 5 хошуу болж өргөжив.

Монголын казахууд нь өдгөө хүртэл өөрийн хэл, хувцас зүүсгэл, гэр, орон сууц, ёс заншил, аман зохиол зэрэг зүйлүүдээ бүрэн хадгалан үлджээ. Казахууд 2000 оны байдлаар 102983 хүнтэй байв.

Тува. Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд казах нартай, Ховдын Буянт суманд монголчуудтай хамт сууна. Тэдний хүн ам 2000 оны байдлаар 4778 байв.

Тува нь түрэг угсаатны нэгэн салбар юм. Тува нар 2000 орчим жилийн өмнөөс Тагна, Алтайн уулаар нутагласаар иржээ.

XVII зууны эцсээс ойрад монголчуудын эрх баригсад тува нарын заримыг эрхшээлдээ оруулан авчээ. Ойрадын эрхшээлд орсон тэр тува нар нь XVIII зууны эхэн үед тэлэнгүд нэр зүүж, Зүүнгар хаант улсын нэгэн отог гэгдэж явав. Тэр үед уг отог нь 4000 орчим өрхөөс бүрддэг байжээ. Тэд тухайн үед Зүүнгарын хаанд шууд харьяалагдан, түүнд ангийн үс, бусад зүйлийг бэлтгэн нийлүүлдэг байв.

Манжийн эрх баригсад Зүүнгар хаант улсыг байлдан эзлэхдээ уг тува нарыг ч эрхшээлдээ оруулан аваад, 1762 онд тэднийг гурван хошуу болгон зохион байгуулаад, Алтайн монгол хэлт урианхайн дөрвөн хошуутай хамтатган, долоон хошуу болгоод, Ховдод суусан манж сайдын газарт захируулсан байна. Чин улсын эрх баригсад тува нарын 3 хошуунд үе залгамжлах ноён тавилгүй, бүгдийн дарга тавьжээ. Аман ярианд, эл тува гурван хошууг цагаан соёны, хар соёны, хөх мончоогын хошуу хэмээнэ. Манж Чин улсад булга, суусар зэрэг үслэг ангийн арьс, мөн гахай зэрэг ангийн махаар алба барьдаг байв. Тэд өөрийн уугуул шүтлэг бөө мөргөлийг шүтсээр XX зуунтай золгосон аж.

Тува нар хэдийгээр монгол, казах нарын дунд удаан суусан боловч өөрсдийн унаган хэл, хурим найр хийх, хүүхэд төрөх, хүн оршуулах үед хийдэг ёс заншлын зүйл, хувцас хунараа марталгүй хэрэглэсээр иржээ. Тэд өдгөө сууж буй монгол маягийн гэрээ ч эртнээс хэрэглэсээр ирсэн хэмээцгээнэ.

Одоо тува нарын ихэнх нь өөрийн хэлнээс гадна монгол, казах хэлээр ярьж байна. Тува нарын гол аж ахуй нь эртнээс өдгөө хүртэл мал байв. Тиймээс тэднийг бас малчин тува хэмээн зарим бичиг зохиолд нэрлэсэн нь бий.

А.Очир
С.Уранбилэг

Г.Одон "Уран сайханчид". (1972 он)

ХУВЦАС

Монгол үндэсний хувцас, гоёл нь монголчуудын эрхэлж ирсэн нүүдлийн мал аж ахуй, зан заншил, байгаль цаг уурын байдалд зохицон он удаан жилийн турш шалгаран, улам боловсронгуй болж, төрөл зүйл, загвар нь баяжиж иржээ. Монгол хувцас нь дөрвөн улирлын хувцас бөгөөд үүнтэй уялдан улирал улирлын хувцсыг хийх материал нь ч харилцан адилгүй байдаг. Монгол дээлний урдуураа битүү зөрдөг энгэр нь өврөөрөө салхи оруулахгүйн дээр, бүсэлж юм өвөртлөхөд зохицсон байдаг. Мөн дээл нь ташаа өргөн, хормой чөлөөтэй байдаг нь морь унах, малтай ноцолдоход саадгүй, бөх бат, морин дээрээ өвдгөө ороон суух, нөмөрч хэвтэх зэрэгт нэн тохиромжтой. Монгол дээлийн нударга нь гар хамгаалах, юм барих жийрэг болдог. Түүнчлэн гутал нь дөрөө дөрөөлөх, цомцойн суух, завилан суухад зохилдсон ажээ.

Судлаачид археологийн дурсгал, бичгийн сурвалжийн мэдээ, угсаатны зүйн хэрэглэгдэхүүнд тулгуурлан монгол хувцас хэрхэн хувьсан хөгжиж ирсэн түүхийг тодорхойлсон билээ.

Мал аж ахуй эрхэлж, морь унадаг нүүдэлчдийн хувьд эрт үеийн гол хувцас нь өмд, цээживч байсан бөгөөд хожим энгэртэй дээл хэрэглэх болжээ.

Лавтай мэдэгдэж буй эртний монгол хувцасны дурсгал нь монгол нутагт анхны төр улс байгуулсан хүннү нарын хувцас юм. Хүннү нар /НТӨ III зуун -НТ I зуун/ баруун, зүүн тийш зөрдөг энгэртэй дээл, ээтэн хоншоортой сөөхий маягийн гутал, агсарган бүс хэрэглэж байжээ.

Хүннүгийн халаагаа авсан сяньби нарын /НТ II-IY зуун/ хувцас хүннүгийнхтэй төстэй байв.

Жужан нар /НТ IY-YI зуун/ ч дээрхийн адил энгэртэй, нарийн ханцуйтай дээл, урт түрийтэй гутал өмсдөг байжээ.

Харин YI-X зуунд Монгол нутагт оршин тогтнож байсан түрэг угсааны аймгийнхны /түрэг, уйгур, хиргис/ хувцас нь дээрх монгол угсааны аймгийнхнаас өөр байжээ. Тэдний дээл нь урдуураа задгай, буруу зөрдөг энгэртэй байсны дээр гутал, малгай зэрэг нь бас ондоо ажээ.

Хятан нарын /X-XII/ хувцас нь дундад эртний монгол хувцасны үүсгэл болж, түүнд тулгуурлан монгол хувцасны хэв маяг төлөвшин буй болжээ. Тэр үеэс эхлэн монгол угсаатан нь зөв энгэртэй, түрэг угсаатан нь буруу энгэртэй дээл өмсөх болж монгол, түрэг угсаатны хувцасны зааг ялгаа тодорхой болсон аж. Монголчуудын дээл зөв, ташуу энгэртэй, гутал нь ээтэн хоншоортой, толгойн өмсгөл нь алчуур, юүдэн болон хив малгай байжээ.

XII-XIY зууны үеийн монголчуудын хувцасны хэв маягийг тэр цагийн өрнө дорнын сурвалж бичгийн мэдээ, зураг сэлт, эртний судлалын хэрэглэгдэхүүнээр баримжаалан мэдэж болно.

Монгол гүрний их хаад Мөнх, /1252 онд/ Хубилай /1275 онд/ нар тайлга ёслолын хувцасны дүрэм хуулийг тогтоосон бөгөөд чингэхдээ хуучин монгол янзыг хэвээр авч, гоёл чимгийг нь үлэмж болгожээ.

Тэр цагийн монголын нийт хүмүүсийн дээл нь ташуу мөөрөлжин, зөв энгэртэй байсан бөгөөд дээхнэ үедээ бүдүүн цэмбэ, арьсан дээл байснаа бөс торгомсог, алт хатгамласан торгомсог дээл өмсдөг болжээ. Дээлийнхээ солгой талд оноо хийж, баруун гар талдаа 3, зүүн гар талдаа 1 товч хаддаг байжээ.

XY-XYII зуунд дээлийн мөөрөлжин, дөрвөлжин энгэр хадгалагдсаар байжээ.

Тэр үед бий болсон нэгэн өвөрмөц хувцас нь лам хувцас болно. XVII зууны үеэс монгол лам нарын хувцасны үндэсний хэв маяг тогтжээ.

Манжийн үед монголын харчуул нь манж маягийн дөрвөлжин энгэртэй дээл өмсөх болсон авч, хувцасны ерөнхий маяг нь эртний монгол хувцасны уламжлалыг хадгалж байв. Чин улсын цагт монголд ташуу мөөрөлжин энгэртэй оноогүй дээл зонхилж байсны дээр дөрвөлжин энгэртэй дээлийг эр, эмгүй өмсөж байсан бололтой. XIII-XYI зууны үеийн монгол эхнэр голдуу богтог малгай өмсдөг, шулдан гэзэгтэй байснаа XYII зууны үеэс халх зэрэг ястны эхнэрүүд дэргэр үстэй, түнтгэр босоо мөртэй дээл өмсөх болсон байна. Бусад монголчууд голдуу эртний маягаа хадгалж байжээ. Халх бүсгүйчүүд үсээ хавчих болсноос үс нь дэргэр болж олон хавчаараар гоёх болжээ.

Манжийн төрөөс 1759 онд хувцасны хууль гаргаж, зэрэг дэвийн хувцсыг журамласан нь 1911 он хүртэл тогтвортой байжээ.

1911 онд Монгол улс тусгаар тогтнолоо олсноос хойш Манжийн үеийн албаны хувцасны хэв маягт өөрчлөлт оржээ. Монгол улсын хаад ноёдын хувцас хэрэглэлийг шинэчлэн тогтоож, тайж түшмэдийн зэрэг дэвийн хувцас хэрэглэлийг үндэсний онцлогт тохируулан журамласан байна. Мөн лам түшмэдийн албаны хувцасны маяг ч шинээр бий болжээ.

Тэр үед монгол цэргийн дүрэмт хувцасны маягийг тогтоож, албанаа хэрэглүүлэн заншуулжээ.

1921 онд хувьсгал ялснаар монголын хуучин ямбаны хувцас өөрчлөгдөх эх үүсвэр тавигдав. Энэхүү өөрчлөлт нь цэргийн хувцаснаас эхтэй гэж болно. Ардын журамт цэргийн малгай /жанжин малгай/, ардын намынхны анх өмсч эхэлсэн мухар ханцуйтай дээл нь орчин үеийн монгол хувцасны үүсгэл болжээ.

1921 онд ноёд түшмэдийн ямба, ёслолын хувцсыг халж, урт хүрэм, отго, жинс хэрэглэхийг болиулжээ.

Монгол дээлийн маяг хувьсаж, зах, эмжээр, суга, ташааг нарийн

хийх болж, эсгүүр хийц нь өөрчлөгдөв. Тухайлбал: Дээлийн энгэр захыг 2-3 тасамдан, энгэртээ 3-4, ташаанд нь 4-6 товч хадах буюу эмэгтэйчүүдийн дээлийн энгэр зах, сумыг өргөн хоргойгоор мөшгөөрлөн эмжих болжээ.

XX зууны хориод оноос хойш европ хувцас дэлгэрснээр монголчууд үндэсний хувцас хийгээд европ маягийн нийтлэг хувцсыг өргөн хэрэглэх болжээ.

Бөөгийн хувцас

Бөөгийн малгай

Монгол үндэсний хувцас

Монгол үндэсний уламжлалт хувцсыг зан үйлийн хувцас, ардын хувцас гэх мэтээр ангилж болно. Зан үйлийн хувцсыг дотор нь бөөгийн, чойжингийн, цамын бүжгийн, эрийн гурван наадмын гэх мэтээр ангилна.

Бөөгийн дээл

Хурдан морины хүүхдийн хувцас

Бөхийн зодог, шуудаг

Харин монголын олон ястны хувцсыг:

- Халх маягийн хувцас, гоёл
- Өвөрлөгч маягийн хувцас
- Ойрад маягийн хувцас
- Буриад маягийн хувцас
- Холимог маягийн хувцас хэмээн

судлаачид ангилжээ.

Монгол хувцасны үндсэн төрөл зүйл нь толгойн өмсгөл, дээл, ууж, хүрэм, хантааз, дотуур хувцас (өмд, цамц), хөлийн өмсгөлөөс бүрдэнэ.

Толгойн өмсгөл нь алчуур, тоорцог, юүдэн, маахууз, халбан малгай, 4 тал малгай, сэрүүн гэсэн хэдэн янз бөгөөд бас угсаатны бүлгүүдийн ялгавар бий. Халхад гозгор оройтой тойруулган болон сээтэн хивсэгтэй малгай ихэд дэлгэрсэн байхад ойрадуудын дунд хавтгай төгрөг оройтой малгай илүүтэй тохиолддог.

Алчуурыг их төлөв дулааны улиралд хэрэглэх бөгөөд эрт цагаас алчуур боож байжээ.

Сүүлийн үед Монгол улсын барга, мянгад эрчүүд алчуур боодог бөгөөд аль ч нутгийн бүсгүйчүүд алчуурыг хэрэглэнэ.

Тоорцог нь оройвч, хув тоорцог, чихтэй тоорцог гэсэн хэдэн төрөлтэй. Оройвч нь чихэнд хүрэхгүй бөөрөнхий оройн өндөг болно. Хув тоорцогийг хатуулгатай даавуугаар тал нийлүүлж хийгээд оройд нь бяцхан товч хадна. Гол төлөв бичгийн хүн, худалдааны хүмүүс өмсдөг. Монгол хув тоорцог нь улаан сампин, төв залаа, оройн хавчаар тоногтой байдаг онцлогтой.

Чихтэй тоорцог бол монголчуудын их өмсдөг хувцас мөн. Эрэгтэйчүүд дотрыг нь үелэсэн, үслэг, дөрвөн чихтэй тоорцог өмсдөг бөгөөд оройд нь тав сампин буюу хэрэмний сүүл хаддаг. Тоорцгийн нэг төрөл нь 4 чихтэй товь малгай (жанжин малгай) болно.

Харин эмэгтэй хүний тоорцог нь хавчаартай, хавчааргүй 2 янз. Торгууд зэрэг ойрад эмэгтэйчүүд хавчааргүй тоорцог өмсдөг байхад, хавчаартай тоорцгийг халхчууд өмсөнө.

Халх өвлийн булган тоорцог

Чантуу тоорцог

Ойрад тоорцог

Казах эмэгтэй тоорцог

Халхын шар илгэн тоорцог

Барга тоорцог

Ойрад хар тоорцог

Юудэн-лоовууз. Энэ нь их эртний хувцас бөгөөд хоёр талыг араар нь нийлүүлэн оёж, доторлосон малгай юм. Монгол юүдэн лоовуузны шил урт, чих өргөн, орой өндөр байдаг. Юүдэнтэй төстэй маахууз хэмээх углаа малгай байдаг. Үүнийг бас хэрмэн малгай, харцага малгай ч гэдэг. Энэ малгай нь Чингис, Хубилай зэрэг их хаадын өмссөн малгайн төрөл мөн.

Халх үнэгэн малгай

Лам хүний үнэгэн малгай

Халх эхнэрийн зуны хилэн малгай

Дөрвөн чихт шовгор малгай. Энэ нь монголчуудын язгуурын өмсгөл болно. Малгайн орой нь дуулгатай төстэй, сүүл нь туггай ойролцоо харагддаг учир тоорцог оройтой малгай, дуулга оройтой малгай , туг оройтой малгай гэж янз бүрээр нэрлэдэг. Ийм малгай олон монголчуудын дунд ихэд дэлгэрснээс халхад шовгор оройтой нь түгэж, түмбэгэр оройтой нь бусад нутагт тархжээ. Энэ малгайг халхад чихтэй малгай, халимагт бүчлээч, буриадад хацавчтай малгай гэж нэрлэжээ. Чихтэй малгайн чихийг голдуу сөхөж өмсөх тул сээтэн малгай ч гэж нэрлэдэг.

Халбан малгай. Энэ нь түмбэгэр буюу гозгор орой, дугариг хүрээ (хивсэг тойруул)-нээс бүрдэнэ. Түмбэгэр оройтой нь халимаг, буриад, өвөр монгол зэрэгт түгээмэл бөгөөд гозгор оройтойг нь халхчууд элбэг өмсөнө. Халхчууд хилэн малгай гэх ба барга, буриадад тойровши, ордос зэрэгт дугариг малгай гэнэ.

Лам хүний зуны хилэн малгай

Буриад зуны малгай

Халхын сээтэн малгай

Дөрвөд халбан малгай

Өөлд эмэгтэй зуны малгай

Эртний монголчууд эдгээр малгайнуудыг өмсөж байсан бөгөөд хөгжлийн явцад өвөрлөгчдийн халбан нь манж малгайтай, халимаг ойрадынх нь түрэг колбак малгайтай төстэй болжээ.

Сэрүүн малгай. Монголчууд дулаан улирлын малгайг сэрүүн малгай гэх бөгөөд үүнд цан малгай, тэнзэн малгай (дэрсэн малгай) багтана. Цан малгай нь XIII зууны үеэс монгол хаад язгууртан өмсөж ирсэн дэлбэгэр дүгэриг, хавтгай саравчин хүрээтэй, бөөрөнхий оройтой малгай болно. Энэ малгай хожим дэрсэн (тэнзэн) малгайтай бэлчирлэн ямбаны малгай болжээ.

Дээл. Монгол дээл нь баруун тийш дардаг ташуу болон дөрвөлжин өвөр, залгамал ханцуйтай, 2 ташаа бүхий их биетэй, дотуур гадуур энгэртэй хувцас юм. Монгол дээлний эртний маяг нь урдуураа эгц зөрлөгтэй, зөв тийш зөрдөг мөөрөлжин энгэртэй байгаад хожим (XY-XYIII зуун) дөрвөлжин энгэртэй болсон гэдэг.

Эрэгтэй дээл. Эрэгтэй хүний дээл нь халх, ойрад, өвөрлөгч, буриадад ижил бөгөөд гагцхүү дээлийн эмжээр, тоног зэргээрээ бага зэрэг ялгаатай юм. Тухайлбал: Халх эрэгтэйн дээлийн зах, энгэртээ дан эмжээртэй байхад буриад эрэгтэй дээлийн энгэр нь хурц омогтой, 3 өнгийн эмжээртэй, ханцуйдаа нударгатай байна.

Захчин, урианхай, баяд, торгууд, дөрвөд, хотон дээл нь хормойдоо оноотой, зах, сэрвээ, өвөр, сум, хормойгоороо өргөн эмжээртэй байдаг. Үүнийг цалам (торгуудууд тожоо гэдэг) гэнэ.

Урианхай (Алтайн) хувцас (МҮТМ)

Баяд хувцас (МҮТМ)

Хотон хувцас (МҮТМ)

Захчин хувцас (МҮТМ)

Торгууд хувцас (МҮТМ)

Дөрвөд хувцас (МҮТМ)

Халх хувцас (МҮТМ)

Дариганга хувцас (МҮТМ)

Харин өөлд, мянгад дээл оноогүй. Торгууд, урианхайгаас бусад нь эргэдэг нударгатай. Дөрвөд, баяд, захчин, торгуудын дээлийн оноо богино байхад урианхай дээл ташаанд хүрсэн оноотой байна.

Хотгойд, мянгад дээл нь халх ойрадын заврын маягтай юм. Ялангуяа тэдний цагаан нэхий дээлний хар өнгийн хөвөө / хошоо/ нь ойрад дээлний цалмын үлдэгдэл болно.

Эмэгтэй дээл. Нөхөрт гараагүй залуу бүсгүйчүүдийн дээл нь эрчүүдийнхтэй бараг адил. Ойрад сэвгэр дээл нь цаламгүй байдгаараа эрчүүдийнхээс ялгаатай.

Харин монголчуудын эхнэр дээл нь ойрад болон зүүн монголын гэсэн ялгавартай.

Халх авгайн дээл нь өргөн тоногтой энгэртэй, түнтгэр босоо мөртэй, хоргой торгоор зүйж хийсэн алаг ханцуйтай байна.

Өөлд хувцас (МҮТМ)

Мянгад хувцас (МҮТМ)

Халх эхнэрийн дээл (МҮТМ)

Дархадын хувцас ерөнхийдөө халхжуу маягтай боловч нутгийн онцлог бас бий. Дархадын хойд нутгийнхан туватай төстэй хувцастай байхад өмнөд нутгийнхан нь халхажсан байна. Дархад дээлний алаг энгэр нь буриадтай төстэй юм.

Дорнодын барга нарын хувцас нь буриад мэт боловч халх, өвөрлөгчдийн байдлыг бас хадгалжээ.

Барга хувцас (МҮТМ)

Буриад хувцас (МҮТМ)

Үзэмчин хувцас (МҮТМ)

Халх хувцас (МҮТМ)

Өөлд, мянгад дээл эргэдэг нударгатай, торгууд, урианхай, захчин, дөрвөд, хотон, баядынх үл эргэдэг нударгатай байдаг. Захчин, торгууд, дөрвөд, баяд, урианхайн эхнэр дээл нь захаасаа дорогш эгц буун, баруун гар тийш хөндөлссөн энгэртэй. Харин өөлд, мянгад эхнэр дээл дөрвөлжин ташуу энгэртэй, бүсэлхийгээрээ хөндлөн тушаатай байна.

Өөлд хувцас
(МҮТМ)

Торгууд хувцас
(МҮТМ)

Урианхай (Алтайн) хувцас
(МҮТМ)

Захчин хувцас
(МҮТМ)

Дөрвөд хувцас
(МҮТМ)

Хотон хувцас
(МҮТМ)

Баяд хувцас
(МҮТМ)

Мянгад хувцас
(МҮТМ)

Торгууд, урианхай, захчин, дөрвөд, баяд эхнэр тэрлэг эргэдэг захтай бөгөөд давхар цагаан зах (мөрөвч) хийдэг. Харин өөлд эхнэр цагаан захыг цэгдэгтээ хийнэ. Гэтэл хотон, мянгадад ийм зах байдаггүй.

Буриад авгай дээлийн энгэрийг нэг нарийн эмжиж, гадаад дотоод хормойн доод биеэр, хормойн байр биеэр хар буюу бараан өнгийн эдээр хөвөөлөн өргөн эмждэг. Дээлийн цээж, хормой хоёрын залгаагаар хуниас гарган оёж, тохойг нь хоргой, торгоор өргөн эмждэг.

Дархад эхнэр дээл нь газар нутгийнхаа байршлаас болж хоёр янз байна. Хойд нутгийн эмэгтэйчүүд хирвээтэй дээл

Буриад хувцас (М ҮТМ)

Үзэмчин хувцас (М ҮТМ)

Дариганга хувцас (М ҮТМ)

Барга хувцас (М ҮТМ)

Буриад эхнэрийн дээл (М ҮТМ)

Барга дээл (М ҮТМ)

Урианхай дээл (М ҮТМ)

өмсдөг байхад, баруун нутгийн эхнэр түнтгэр мөртэй, халх маягийн дээлтэй байв.

Барга эхнэр дээлийн мөр нь эртний халх мөртэй төстэй дэргэр байдаг.

Харин дарьганга эхнэрийн дээл алаг ханцуйтай бөгөөд өвөрлөгч, тухайлбал цахар маягтай ажээ.

Ууж (Цэгдэг). Монгол эмэгтэйчүүдийн хувцасны нэг нь эхнэр дээлийн хамт өмсдөг ууж болно. Үүнийг ойрадууд цэгдэг гэж нэрлэнэ.

Халх ууж нь ханцуйгүй, энгэр нь голоороо тууш задгай байдаг. Ууж нь гоёлын, ажлын гэсэн 2 янз байхаас гадна цээж ууж (богино), урт ууж (хормойтой) гэсэн ялгаатай. Уужийг дээлнээс өөр өнгийн эдээр хийж, зах энгэрийг нь хоргойгоор өргөн эмждэг.

Захчин, торгууд, урианхай, баяд, дөрвөд эхнэрийн цэгдэг хатуулгатай дэргэр мөртэй бөгөөд бүслүүр нь ялгаатай байдаг. Захчин, өөлд, урианхай, дөрвөд цэгдэгний оноо нь ардаа, баядынх оноогүй байна. Харин торгууд цэгдэгний оноо нь ардаа, цээжний бэлийн хөвөөг хоёр хажуу, ар талд нь тасархай хийж, тэр бүрийд нь хар торгон залгаас 4 ширхэг оруулж хөвөөлдгөөрөө онцлогтой.

Буриад ууж нь ар нурууны хуниаснаас доош задгай оноотой, энгэр нь шулуун.

Хантаазнууд
(МҮТМ)

Халх ууж (МҮТМ) | Барга ууж (МҮТМ) | Захчин эхнэрийн дээл, ууж (МҮТМ)

Хүрэм. Хүрэм бол эгэл хүнд давхац, хэргэмтэнд ямбаны өмсгөл болдог. Хүрмийг ахмад настан голлон өмсөнө. Эгэл хүрэм нь товчхондоо дээлний цээж юм. Ямбаны хүрэм нь энгэргүй, өмнө голоороо хагархай, 5 товчтой байх ба урт (морин хүрэм), охор (саадган хүрэм) гэсэн ялгаатай байжээ.

Хантааз. Хантаазыг залуучууд болон албаны хүн өмсөнө. Хантааз нь ханцуйгүй, зах нь босоо, дээл мэт дөрвөлжиндүү энгэртэй, 2 ташаандаа оноотой байна. Товч шилбийг зах, энгэрийн хараа, суга, ташаан талд хадна. Эгц энгэртэй бол хараа болон хажуу ирмэгт нь товч хадна. Бас 2 тийшээ энгэртэй ч байна. Үүнийг ихэвчлэн ямбатан ихэс өмсөнө. Мөшгөөр эмжээртэй, цулгуй хантаазыг бичгийн хүмүүс өмсөх нь элбэг.

Хантаазнууд
(МҮТМ)

Бүс нь даавуун, агсарган (ширэн) гэсэн 2 янз. Үүнээс үлэмж дэлгэрсэн нь даавуун бүс болно. Халхчууд ихэвчлэн шар, улбар, ногоон, цэнхэр өнгийн бүс, ойрадууд голдуу хөх, бас ногоон, ухаа өнгийн бүс бүсэлнэ. Харин лам хүн шар, улбар 2 өнгийг эрхэмлэнэ.

Агсарган бүсийг харчууд ихэвчлэн бүсэлдэг. Энэ нь эртний монгол бүс бөгөөд их биеийг нь ширээр хийж, төмөр товруу хадан олом болон агсарга гархи хийдэг. Сүүлийн үед бас мөнгөн товруу хийх нь элбэг болжээ.

Дотуур хувцас

Цамц нь дээл мэт дөрвөлжин энгэртэй, нарийхан босоо захтай, урт ханцуйтай, их бие нь бүсэлхий өнгөрөм урт байдаг. Зах энгэр, суганд нь нэг нэг зангидмал товч, шилбэ хадна.

Харин лам цамц бол захгүй, хүзүү, энгэрээр нь 1 мөшгөсөн улаан өнгийн эмжээртэй байдаг.

Өмд нь улирлын байдалд зохицон дан, давхар, хөвөнтэй, заргаг (сармай арьс), нэхий өмд гэх мэтээр ялгаатай. Дан, давхар бөс өмдийг зун өмсөх бөгөөд хөвөнтэй, заргаг өмдийг хавар, намар, нэхий өмдийг өвөл өмсдөг.

Хөлийн өмсгөл-д ***гутал, оймс*** багтана. Монголчууд голдуу түрий, зулагтай ***гутал*** өмсдөг боловч зарим нутагт шаахай өмсөх нь ч буй. Нүүдэлчдийн амьдралд илүү нийцсэн нь монгол гутал болно. Монгол гутал нь урианхайн маага, дархад цаатангийн шормон гутал-годон гутал, буриадын шархи, сөөхий, халхын ээтэн гутал, өөлдийн хатуу госон, өвөрлөгчдийн сөөхий гутал, торгуудын тоохуу гэх мэт монголын ястнуудын онцлогийг тусгасан олон зүйлийн ялгавартай билээ.

Тэр дотроос халх "Ээтэн гутал" илүү онцлогтой байдаг. Энэ нь ээтэн хоншоортой, наамал болон эсгий ултай, шагай, зулаг, түрийндээ угалзтай, угалзгүй, ганц буюу 3 хавчаартай эсгий болон даавуу ширмэл оймстой байдаг. Халх гутал нь гоёлын, энгийн гэсэн хоёр янз байдаг бөгөөд угалз, чимэглэл ихтэйгээрээ онцлогтой.

Өөлд, дөрвөд, баяд, захчингууд нийтээр булигаараар хийсэн өөлд госон хэмээх гутал өмсөнө. Эрэгтэй хүний гутал нь хар, эмэгтэй гутал нь улаан өнгөтэй байна. Гутлын дотуур эсгий оймс өмсөнө.

Харин торгууд ястны өмсдөг нэгэн өвөрмөц гутал нь тоохуу хэмээх эсгий оймсон гутал юм.

(М ҮТМ)

Шар булигааран монгол гутал (М ҮТМ)

(М ҮТМ)

Бөхийн гутал (М ҮТМ)

32 угалзтай булигааран гутал (М ҮТМ)

Буриад гутал (М ҮТМ)

Монгол гутал оймсны хамт (М ҮТМ)

Хүүхдийн булигаар гутал (М ҮТМ)

Монгол ***оймс*** үндсэн хоёр янз. Ахрын эсгий алгадаж хийсэн, нимгэн эсгий өнгөлсөн оймсыг халбаган ултай оймс гэдэг. Харин нөгөө зузаан эсгийгээр хийсэн өвлийн оймсыг нохойн толгой ултай оймс гэнэ. Оймсны гутлаас дээш илүү гарах хэсгийг хараа гэх бөгөөд түүнийг савхи, булигаар, бөсөөр өнгөлж, хээ угалз хатгадаг.

Оймс (М ҮТМ)

Монгол эмэгтэйн гоёл чимэглэл

Монгол эмэгтэйн гоёл чимэглэл*-д* үсний чимэглэл, ээмэг, сүйх, бөгж, бугуйвч, энгэрийн гуу, бэл багтах бөгөөд үүнийг дотор нь халх, ойрад, буриад гэх мэтээр заaглаж болно. Тэдгээрийн дотроос халхын чинээлэг айлын эхнэр болон хатан хүний гоёл зүүсгэл нэлээд өвөрмөц, нарийн тансаг хийцтэй.

Халх эмэгтэйн гоёл чимэглэл. Халх эхнэр хүний үс эвэр янзтай. Энэхүү үснийхээ дунд хэсэгт мөнгөн хавчаар, угт нь зууван хавчиг зүүдэг. Хавчаар, хавчиг нь хээ угалзтай, мөн дээр нь шүр хатгасан байдаг.

Толгойн боолт нь бөмбөгөр, дугариг хэлбэртэй. Үүнийг мөнгө буюу алтан шармалаар үйлдэж, шүр сувд шигтгэн, гоёмсог хээ угалз гаргасан байдаг. Хатан хүний толгойн боолт нь хорол оройтой, дээгүүрээ битүү байдаг. Толгойн боолтны хоёр хажуу руу унжсан хэсгийг санчиг, татуур гэнэ. Авгайн далбан үсний нарийн үзүүр хэсэгт бөс гэр хийдэг. Энэхүү бөс гэрийн дээд хэсэгт мөнгөн угалзтай, давхар гэр байдаг. Хээний нөгөө талд буюу ард унждаг хамар, эвэр угалзын сийлбэртэй далбан мөнгийг орхиулга гэнэ. Хээ, үзүүрийн хавчиг хоёрын хооронд байх шүр буюу оюу шигтгээтэй мөнгөн чимгийг бөөрөвч буюу туйвны боолт гэдэг.

Сүйх, ээмэг. Эмэгтэй хүний чихэнд зүүх гоёлын зүүсгэлийг сүйх гэнэ. Сүйх нь хорол, загас хэлбэртэй гол зүүлтнээс шүр, мөнгөн унжлага салаалуулж үйлдсэн хэрэглэл юм. Энэ нь эхнэр хүний төрийн хэрэглэл гэгдэх бөгөөд эхнэр болсны баталгаа ажээ. Халхад үлэмж дэлгэрсэн ээмэг нь сүүжин гэгдэх өрөөсөн үзүүрийг нь эргүүлсэн махир гархи юм. Ээмгийг алт, мөнгөөр хийж зүйл бүрийн үнэт чулуу шигтгэдэг.



Халх эхнэрийн алтан шармал толгойн гоёл (М ҮТМ)

Халх эхнэрийн толгойн гоёл (М ҮТМ)

Халх эхнэрийн толгойн гоёл (М ҮТМ)

Дариганга эхнэрийн үсний хавчаар (М ҮТМ)

Халх эхнэрийн энгэрийн зүүлт (М ҮТМ)

Бөгж, бугуйвч. Монгол эмэгтэйчүүдийн түгээмэл гоёл бол бөгж, бугуйвч билээ. Бөгжийг алт, мөнгө, гангаар, бугуйвчийг алт, мөнгө, зэсээр хийнэ. Бөгж нь цулгуй, дундаа ховил, гол, хонхорхой, хүрэмтэй гэх мэт олон янз байдаг. Бугуйвч нь мөн хээ угалзтай эсвэл цулгуй, төрөл бүрийн үнэт чулуун шигтгээтэй байна.

Бэл. Монгол авгай нарын түгээмэл чимэг нь хоёр ташаанд унжуулдаг бэл хэмээх дүгэриг хорол зүүлт болно.

Халх эхнэрийн бэл нь дээрээ шүрэн голтой эргүүлэгтэй байх ба доороос нь 5 өнгийн алчуур унжуулан зүүн талын бэлнээс хөөрөг, тамхины хавтага зүүнэ. Мөн баруун талдаа "таван саваагүй" зүүнэ. Мөн хэлний хусуур, зүү утасны сав зүүнэ.

Жирийн халх хүүхэн үсээ арагш нь ганц гэзэг болгон, хар өнгийн утсан цацаг сүлжинэ. Хүүхэн хүний толгойн боолт, үсний чимэг нь авгай хүнийхээс хийц загвар нь ондоо байдаг.

Үнэт чулуун шигтгээ бүхий сувдан сам, сувдан даруулга (МУТМ)

Ойрад эмэгтэйн гоёл чимэглэл. Ойрад эмэгтэйчүүдийн гоёл нь даруу, чимэглэл багатай болно.

Дөрвөд, баяд, урианхай, өөлд эхнэр 2 салаа гэзгээ нарийхан хар уут (үсний гэр)-нд хийж, доод үзүүрээс нь токик хэмээх цацаг унжуулна. Токик гэдэг нь дээрээ мяндсан утас, шүр болон мөнгөн зангилаа, мөнгөн дугтуй, модон толгойтой утсан цацаг юм. Дөрвөд, баяд авгайчууд үсний гэрийн доод талыг, торгууд, захчин, урианхай нар хоёуланг нь тоног хийж гоёно.

Харин өөлдүүд үсний гэрийн дээд хэсгийг улаан хоргойгоор хөвөөлж, доод хэсгийг нь чимэгтүй үлдээдэг. Торгуудууд үсний гэрэндээ мөнгөн зоос, эрвээхэй, ланз, зоосон хээ чимэг хадах буюу цацаг зүүдэг.

Харин нөхөрт гараагүй хүүхнүүд (сэвгэр) үсний гэрийн оронд тана, боодгийг хэрэглэдэг. Тана гэдэг нь хар хилэн дэвсгэр дээр танан товч, шүр, явуу хадаж, захаар нь саатай утсаар зүү ороож чимсэн эдийг хэлнэ. Тананы доороос боодог залгана. Боодог нь өнгийн утас ороосон, олон салаа хар мяндсан цацаг юм. Тана боодгийг ар шилнээсээ гутлын өсгий хүртэл урт хийж, бүсэндээ алчуураар дарж тогтооно.

Захчин, торгууд сэвгэрүүд тана, боодог хоёуланг нь, харин урианхай, өөлд сэвгэрүүд тана үгүй боодог зүүнэ.

Ойрадууд ээмгийг сийк гэнэ. Залуу эхнэрүүд шүрэн бөөртэй том мөнгөн сийк, хорь хүртэлх насны охид жижиг сийк, өндөр настай эмгэд хөнгөн, даруу сийк зүүдэг. Мөн цацагтай сийкийг баяр ёслолын үед зүүнэ. Сийк нь хорол, арслан, хаан бугуйвч, хатан сүйх гэх мэт олон янзын толгойтой байна. Цацаг нь ихэвчлэн сондгой тоотой байна.

Ойрад авгай нар бэлнээсээ зүүний гэр (зүүвч), хэгч (хавтага) гэх мэтийг зүүдэг.

Буриад эхнэрийн гоёл чимэглэл. Буриад эмэгтэйн гоёл зүүсгэл нь шивэргэл, туйв, татуур (даруулга), хавчиг, гархи, гуу, бэл зэрэг болно. Үсийг халхалдаг гэрийг шивэргэл гэдэг.

Буриад авгай гэзгээ 2 хэсэг болгон, туйв (нарийн мод) хийж гоёдог. Үсний туйвыг хоёр шанаанд хөндлөн хийнэ. Мөн гэзгэндээ шүр, сувд алагласан мөнгөн даруулга зүүдэг.

Мөн хүзүүндээ хоолойн гуу зүүнэ. Авгайчууд чихэндээ цагираг, сүүжин, цэцэг, шилбэ ээмгийг нарийн мөнгөн гинжээр холбож зүүнэ. Гартаа бөгж, бугуйндаа бөөрөнхий буюу хавтгай бугуйвч хийж гоёдог.

Буриад авгай, басгад ташаандаа бэл зүүх бөгөөд баруун ташаандаа хэт, зүүний гэр, ховол, шүдний чигчлүүр, зүүн талдаа хутга, чимхүүр зэргийг зүүдэг.

Дөрвөд сийк (МУТМ)

Буриад эхнэрийн үсний туйв (МУТМ)

Барга эмэгтэйн гоёл (МУТМ)

Буриад эмэгтэйн [illegible] (МУТМ)

Эрэгтэйчүүдийн эдлэл зүүсгэл

Эрэгтэйчүүдийн эдлэл зүүсгэл-д хэт хутга, гаанс, тамхины хавтага, сэтгүүр соёо, хөөрөг, хөөрөгний даалин, мөнгөн аяга, аяганы уут зэрэг багтана.

Хөөргийг янз бүрийн үнэт чулуу, шил, шаазан, металл, мод, яс, эвэр зэргээр хийдэг. Мөн хөөргөн дээр элдэв дүрс, хээ угалз сийлж, шүр, оюу шигтгээ хаттах нь ч буй. Хөөрөгний толгойг голдуу шүрээр хийж, алт, гуулиар нуух гаргадаг. Хөөрөгний даалинг бөс, хоргой торго, булигаар, савхиар хийж, түүн дээр элдэв хээ угалз хатган гоёх буюу хоргой торгоор хөвөөлөн эмждэг.

Хөөргөөр тамхилж буй нь

Манан хөөрөг (МҮТМ)

Шүрэн толгойтой мөнгөн туурхэцтэй зэс хөөрөг (МҮТМ)

Сийлбэртэй шүрэн хөөрөг (МҮТМ)

Хөх саарал хаш хөөрөг (МҮТМ)

Ногоон хаш чулуун хөөрөг (МҮТМ)

Үлэнцэр хөөрөг (МҮТМ)

Шар хуван толгойтой шар чулуун хөөрөг (МҮТМ)

Шүрэн толгойтой номин хөөрөг (МҮТМ)

Үндсэн хөөрөг (МҮТМ)

Манан хөөрөг (МҮТМ)

Есөн эрдэнэ суулгаж шигтгэсэн танан хөөрөг (МҮТМ)

Шаргал манан хөөрөг (МҮТМ)

Цагаан шүрэн хөөрөг (МҮТМ)

Хаш хөөрөг (МҮТМ)

Монгол эр хүний чухал гоёл нь ***хэт, хутга*** билээ. Хэт хутгыг бүсэнд зүүх оосрын чимгийг бэл гэдэг. Бэлийг төмөр, мөнгө, гуулиар хийдэг. Эргэн тойрон хажтай, заримдаа дугуй шүрэн шигтгээтэй байдаг. Бэлийн дээд талыг нь голдуу үүлэн, эрвээхэй, эвэр хээ хэлбэртэйгээр хийсэн байдаг.



Алтан шармал мөнгөн хэт хутга, бэл (М ҮТМ)

Хэт хутга, бэл (М ҮТМ)

Хэт хутга, бэл (М ҮТМ)

Болдыг давтаж, сэнж сурвалж тогтоон хадаад, шир булигаар мэтээр улавч тавьж хийсэн гал ноцоох хэрэгслийг хэт гэдэг. Хэтний хээ угалзыг төмөр, мөнгө, сувдаар хийнэ.

Хутганы ишийг яс, үйс, сум мод шахаж, алаглан хийх нь буй. Хутганы хуй, иш, ирний ховилыг хээлдэг. Энэхүү хээ угалзыг ган, мөнгөөр хөөлгөж хийнэ. Бас алтаар шарж болдог. Мөн хээн дээр нь сувд шигтгэх нь буй.

Хэтийг бүсэнд тээглүүлдэг хаш, мөнгө, ган тээглүүр гэж байдаг.

Гаанс нь толгой, мод (их бие), соруул зэрэг хэсгээс бүрдэнэ. Гаансны толгойг ган, гууль зэргээр хийдэг бөгөөд дээр нь гонзгой цэцэг, гөрмөл дэл тохом хээ гарган гоёдог. Гаансны их биеийг модоор хийнэ. Заримдаа гаансыг бүхэлд нь ясаар хийх нь буй. Гаансны аманд зуух хэсгийг соруул гэх бөгөөд

Гаанс, шүдэнзний хайрцаг, тамхины уут, соёо цохилуур (М ҮТМ)

хамгийн эрхэм үнэтэй нь хаш соруул болно. Тамхины хэрэглэлд мөн гаансны соёо (сэтгүүр), цохиур, тамхины уут зэрэг багтана. Сэтгүүр, цохиурыг мөнгөн утсаар тамхины савтай холбодог. Сэтгүүр, цохиурт нэлээд хээ угалз гаргадаг. Тамхины уут нь эрвээхэй, арслан, луу, гарьд, загас, цэцэгний дүрс гаргаж урласан хавчаартай байна.

Ц.Цэрэндорж
С.Уранбилэг
Э.Амарбилиг

ГЭР, ОРОН СУУЦ

Монгол угсаатны уламжлалт үндсэн сууц бол гэр юм. Балар эртний хүмүүс эхлээд байгалийн бэлэн тогтоц хад цохионы нөмөр агуй, хонхор гуу жалгыг хэвтэш, сууц болгон ашиглаж байсан гэдэг. Байгалийн бэлэн орчинг засаж сэлгэн сууц болгон ашигласны нэг жишээ эрүкэ буюу нүхэн гэр юм. Гэвч энэ байгалийн бэлэн "сууц" хүний хэрэгцээ шаардлагыг цаг үргэлж хангаж байж чадсангүй. Байгаль цаг уурын болон нийгмийн орчны өөрчлөлт, хүний оюун ухаан, хэрэгцээ сонирхол, хэрэгцээт зүйлээ олж авах аргын хөгжлийн улмаас тэд өөрсдийн орон сууцаа өөрсдөө зохион бүтээх арга замыг эрэлхийлэх болжээ.

Ийм "хиймэл" сууцны анхны нэг хэлбэр бол урц, овоохой юм. Урц гэдэг орц буюу ордог юм, овоохой-овгор юм гэсэн утгатай. Чухамхүү энэ урц овоохой бол гэрийн өвөг хэлбэр байжээ. Урц овоохой хөгжлийн тодорхой шатыг дамжин ханат гэрийн тооно, унь хананы бүр анхны хэлбэрийг бий болгосон гэж үздэг.



Гэрийг дүрсэлсэн хадны сүг зураг Сибирь, Монголын Говь-Алтай аймгийн Цагаан гол, Өмнөговь аймгийн Гурвансайхан, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Архангайн Чулуут сумын нутгаас олджээ. Эрдэмтэд эдгээр сүг зургийг хүрэл зэвсгийн үед холбогдоно гэж үздэг. Нэн эртнээс одоогийн Монгол улсын нутгийн байгаль цаг уурын нөхцөл нь мал аж ахуйг нүүдлийн аргаар эрхлэхтэй ан гөрөөг хослуулан аж төрөхөд илүү тохиромжтой байжээ. Тийм болохоор нүүдэлчдийн үндсэн сууц гэр нүүдлийн мал аж ахуй, нүүдэлчдийн нийгмийн хөгжилтэй нягт уялдаатай үүссэн гэж хэлж болно.

Эсгий гэрийн тухай бичгийн анхны мэдээ Хүннүгийн үед холбогддог. Эртний Хятадын түүхч Сыма-Цянь (МЭӨ 145-МЭӨ 86 оны орчим) "Түүхийн тэмдэглэл" (Ши-Цзи) зохиолдоо Хүннүчүүд Хунлу буюу бөмбөгөр гэр сууцтай байсан тухай тэмдэглэжээ.

Хүннүтэй удам угсаагаараа холбоотой дараагийн үеийн аймаг улсууд болох Сяньби, Ухань, Моюн, Тоба, Жужан нар ч гэр сууцтай байсан бөгөөд эрдэмтэд тэдний гэр хүннү гэртэй адил юм уу адилавтар байсан гэж үздэг. Эсгий гэр буюу ханат гэрийг уламжилан авч үндсэн орон сууцаа болгон ашигласаар ирсэн ард түмэн бол хүннүчүүдийн залгамж болох Түрэг, Монголчууд юм. Тэгэхдээ түрэг гэр, монгол гэр хоорондоо бага боловч ялгаатай.

Түрэг угсаатны гэрийн хана өндөр, унь нь уг хэсгээрээ матигар байдаг учир монгол гэрээс ерөнхийдөө багтаамж ихтэй, барьсан хойно нь гаднаас нь харахад өндөр овгор том харагддаг.

Түрэг гэрийн унийг ханатай нь бөхлөхдөө уяагаар уяж бөхөлдөг. Эрдэмтэд эртний хүннү нарын гэрийн төрхийг түрэг гэр илүү хадгалж үлдсэн гэж үздэг.

Монгол гэрийн бүрдэл хэсгийг ерөнхийд нь яс мод, бүрээс, оосор бүч гэж гурав хувааж болох юм. Яс мод нь тооно, унь, хана, хаалгаас бүрдэнэ.

Гэрийн тооно. Монгол гэрийн тооныг цамхраа буюу гадна талын том хүрээ /цагираг/-ний дотор байдаг тооныг бөмбөгөрдүү болгож өгдөг хийцээр нь бөгжин цамхраатай, хорол цамхраатай гэж ангилахаас гадна хийсэн аргаар нь матмал тооно, зүймэл тооно, сархинаг тооно гэж хувааж болох юм. Бөгжин цамхраа гэдэг нь тоононы хүрээ дугуйн голоор бага зэрэг бөгтөр болгож матсан гурван савх модыг хооронд нь ижил зайтай паралель байдлаар бэхэлж, түүнээ дараулан мөн адил гурван савх модыг тэгш өнцөгт үүсгэн зөрүүлж бэхэлсэн байдаг.

Сархинаг тооно

Хорол тооно

Хорол цамхраатай тооно нь тоононы тэг дунд жижиг дугуйтай байдаг бөгөөд том хүрээ, дотор жижиг дугуйгаа диаметрээр нь яг адил дөрөв хуваасан байдлаар хоёр хөндлийг бие биейг нь огтлолцуулан бэхэлж өгнө. Ер нь тоононы голын жижиг дугуй нь том хүрээнээс тодорхой түвшинд дээш товойж байралсан, хөндөл мод нь гадагши товгордуу байдаг учир тооно бөмбөгөр болж өгдөг. Тооныг тойрог гэж үзвэл голоор нь огтлолцуулж бэхэлсэн хоёр хөндөл нь тооныг дөрвөн сигмент болгон хувааж өгдөг юм. Тэгвэл энэ сигментүүдийг яг голлуулан тоононы голын дугуйг, гаднах том хүрээ (цагираг)-тай холбосон холбоос мод хийж өгдөг бөгөөд түүнийг даага гэж нэрлэдэг. Тоононы гадна хүрээнд унины үзүүр орох нүх (хоног) гаргаж өгдөг ийм тооныг хатгуур тооно гэнэ.

Матмал тооно гэдэг нь тоононы гадна, дотор дугуйг хийхдээ гол төлөв нарийвтар хус модыг матаж хийдэг. Тоононы гадна хүрээг хийхдээ бэлдэц хэсгийг ашиглан, бие биений нь уулзварыг даруулсан байдлаар зүйж хийх явдал нилээд хожим үүссэн бөгөөд энэ нь хөдөлмөр хөнгөвчлөх үүднээс суурь машин (станок) өргөн ашиглах болсонтой холбоотой юм. Зүймэл тоононы хүрээ нилээд өргөн байдаг учир жингээр хүнд болдог. Гэвч хээ угалз тавьж чимэхэд тохиромжтой. Орчин үеийн тооно ихэнхдээ зүймэл болжээ.

Тоононы цамхраа өндөр нам хоёр янз байжээ. Өндөр цамхраа, 13-р зуун түүнээс өмнөх үеийн хүзүүт гэрээс улбаатай гэж үздэг.

13-р зуун түүнээс өмнөх үеэс бидний үед уламжлагдаж ирсэн тэрэгт гэрийн зураг мэр сэр байдаг. Түүнд гол төлөв хүзүүтэй тоонотой гэр дүрсэлсэн байдгаас үзэхэд тэр үед гэр голдуу хүзүүтэй тоонотой байжээ гэж бодогдохоор байдаг.

Хүзүүтэй тоонотой гэрийн бидний үед уламжлагдсан нэг дурсгал бол Өвөр Монголын Ордос дахь Чингисийн онгоны гэрүүд юм. Бас Дундад Ази, Афганистанд аж төрдөг, монголчуудтай удмын холбоотой Хазаруудын гэр өндөр шовгор тоонотой байдаг тухай ном зохиолд дурдсан байдаг. Эд бүгд нь эрт үед гэрийн тооно өндөр хүзүүтэй байсны гэрч юм.

Сархинаг тоононы гол онцлог нь хоёр тал дугуй болон дундуураа салдаг, унь нь тоононоосоо салдаггүй хэлхээстэй байдагт оршино. Энэ онцлогоосоо болоод бүтэц, хийх арга нь ч бас ялгаатай. Сархинаг тоононы голын хэсэг нь хорол тоонотой адил боловч гадуурхи том хүрээ (цагираг) байдаггүй. Харин дээрээс нь доош хос хосоор ойрхон, бүгд зургаа, төгсгөл хэсэгт хажуунаас нь нэг нүхэлсэн хуруу модыг дугуйруулж өрөөд толгой хэсгийг нь дотор гадна талаас нь хагас дугуй матсан хоёр эгнээ бургасаар хавчиж, үдэж бэхлэнэ. Мөн унины толгойг доош унжуулахгүй байх зорилгоор хуруу модны дунд хэсгээр дотор талд нь хагас дугуй матсан нэг бургасыг барьж үдсэн байдаг. Хуруу модны төгсгөл хэсэг нь хоорондоо нь унины толгой орохуйц зайтай байдаг бөгөөд түүгээр унины толгойгоор шургуулдаг. Унины толгойг хажуу талаас нь хөндлөн нүхэлж унины толгойг хуруу модтойгоо хялгасаар хэлхэдэг учир тооно унь хоёр салахгүй болдог. Сархинаг тооно дундуураа хоёр тал дугуй болон салдаг боловч гэр барихдаа хооронд нь нийлүүлж оньслоод, сур, дээсээр бэхэлдэг. Сархинаг тоонотой гэрийг ганц хүн ч барьж болдогоороо давуу талтай.

Гэрийн яс модны нэг бүрэлдэхүүн бол унь юм. Түрэг угсаатан гэрийнхээ унийг төгсгөл хэсгээр нь махийлгаж матдаг тухай дээр хэлсэн. Тэгвэл Монгол гэрийн унь шулуун байдаг. Унины төгсгөл хэсэгт хажуунаас хөндлөн нүхэлдэг. Үгээр нарийн сүлжсэн хялгасан гогцоо сүвэлсэн байдаг. Энэ хялгасан гогцоо унийг ханын толгойтой бэхлэх үүрэгтэй бөгөөд үүнийг сагалдрага гэж нэрлэдэг.

Гэрийн унины тоо гэрийн том жижигээс буюу тоононы нүх, ханын толгойн тооноос шалтгаалж олон цөөн байдаг. Бургасан унь, цуулбар унь, зүсмэл унь гэж хийсэн аргаараа ялгагддаг. Сүүлийн үед унины толгой талыг дөрвөлжлөн засаад өнгө ялган будах, хээ угалз тавих, бүр сийлбэр хийж гоёх явдал их болжээ. Хуучин цагт Монголчууд гэрийн унь тооноо улаан, улбар зосон буюу шороон будгаар будах явдал элбэг байжээ. Энэ нь янз бүрийн будаг ховор байсантай холбоотой. Харин өнгө алаглуулан будах, эрээлж хээлэх, сийлбэрээр гоёх явдал ихэс ноёд, хүрээ хийд хот сууринаас эхтэй бөгөөд хүмүүсийн соёл, амьдралын түвшин, хотшилтой холбоотой улам бүр дэлгэр болсоор байна.

Дашрамд дурдахад голлож ердийн хөсгөөр нүүдэг байхад гэрийн модыг аль болох авсаар хөнгөн байлгахад анхаардаг байсан бол орчин үед автомашин, техник ахуй амьдралд өргөн нэвтэрсэнтэй холбоотой энэ талын шаардлага төдий л чухал биш болсоор байна.

Монголчууд гэрийн тооно, унь хоёроо нийлүүлээд гэрийн цээж мод гэж нэрлэдэг.


Унь

Унины толгой

Ханыг хийсэн материалаар нь бургасан, хар модон гэх мэтээр ангилахаас гадна бас хийсэн аргаар нь бургасан, цуулбар, зүсмэл гэж ялгадаг. Гэрийн ханаы дээд тал буюу унь бэхэлдэг хэсгийг ханын толгой, доод талыг ханын шийр гэдэг. Гэрийн том жижиг байх нь хананы тоо, нэг ханан дахь толгойн тооноос шалтгаална.

Хана

Монголчууд 4 ба түүнээс цөөн ханатай гэрийг жижиг, дундаж гэр 5 ханатай, 6-10, түүнээс дээш ханатай гэрийг том гэрт тооцдог. Хананы толгойн хувьд бол 12, 15 гэх мэт байдаг. Гэрийн хаалга хуучин цагт дөрвөн яс мод, эсгий үүдтэй байсан. Сүүлдээ эсгий үүдний дотор талд хоёр модон самбартай болсон бол сүүлдээ зургаан яс модтой дан самбартай хаалга гарчээ. Бүр сүүлдээ гаднаа нэг өргөн, дотроо хоёр самбартай хаалга ялангуяа хот суурин газар нэлээд хэрэглэх болжээ. Ийм хаалга хүнд боловч хамгаалалтын талаасаа ч, дулаан хадгалах үүднээс ч давуу байдаг.

Гэрийн багана бол, агаарын даралт салхи шуурганы нөлөөнөөс болж гэр дотогш цөмрөх, хазайхаас хамгаалдаг тулгуур юм. Мөн эртний үед гэрийн гал голомтыг төлөөлөх шүтлэгийн учир холбогдолтой байв. Багана гэр барих, буулгахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хуучин цагт тоононы гадна хүрээ нарийн, бөөрөнхий байхад гол төлөв ацтай багана их байсан бол тооны хүрээг зүйж хийдэг өргөн болсонтой холбоотой алхан толгойтой багана их хэрэглэдэг болсон. Алхан толгойтой баганыг дан, давхар толгойтой гэж ангилдаг. Мөн хацартай хацаргүй багана ч гэж бий. Баганы толгойн хэсгийг хээ угалзаар гоёж чимдэг.

Гэрийн дотор хэсгээс

Багана

Гэрт модон шал хийх явдал хот суурин газраас эхтэй бөгөөд улам дэлгэрсээр байна. Гэрийн шалыг голдуу нарс, хар модоор хийдэг. Гэвч малчид бүтэн шал хэрэглэх нь ховор байдаг. Зөвхөн хаалганы өргөнтэй адил өргөнтэй, уртаараа гэрийн хоймрын урд зах хүрэх банзыг хаалгаа голлуулан тавиад, бусад зайд хөм, ширмэл ширдэг, хивс дэвсдэг. Сүүлийн үед шалны хулдаас их дэвсдэг болжээ.

Эсгий бүрээс-ийг хонины ноосоор хийнэ. Гэрийн дээд буюу цээжин талын бүрээсийг дээвэр гэнэ. Дээвэр нь дээд хэсгээрээ нарийн, хормойн талаараа өргөн, уртаараа тоононы гадна хүрээнээс ханын толгойг давахаар урт буюу ерөнхийдөө унины уртаас бага зэрэг урт байдаг. Нэг гэрт 4-6 дээвэр ордог. Туурга бол ханыг тойруулан бүрэх зориулалттай, өндөр нь ханын өндөрөөс 30-40см өндөр байдаг. Туурганы дээд хэсгийг танаж, гэрийн дугуй хэлбэрт тохируулна. Гэрт 6-9 туурга орно.

Гэрийн тооныг дөрвөлжин эсгийгээр бүрнэ. Түүнийг ***өрх*** гэнэ. Өрхөөр шөнийн цагт тооноо бүтэн, өдрийн цагт урд хэсгийг нь сөхөж, хагас бүтээнэ. Өрх, дээвэр, туурганы эсгийг урагдах, сунаж хэлбэрээ алдахаас сэргийлж захыг нь томсон дээс, хялгасаар зээглэдэг. Мөн оосор бүч хадаж өгдөг.

Гэрийг бат тогтвортой, салхи шуурганд хөдлөхгүй байхад бүслүүр, чагтага, оосор бүч чухал үүрэг гүйцэтгэнэ.

Гэрийн ханыг тойруулж татсан өргөн уяаг бүслүүр гэдэг. Бүслүүрийг хялгасаар хийдэг. Бүслүүр бол гэрийн тооно, унь, дээврээс болон салхи, шуурганаас хананд ирэх ачааллыг дааж, ханын суналтыг хязгаарлаж, нэг хэвд барьж байхад гол үүрэг гүйцэтгэдэг учир гэрийн бат тогтвортой байхад чухал нөлөөтэй. Гэр бүрээсийнхээ дотор тал ханан дээрээ 1-2, бүрээсийн гадна талаар 2-3 бүслүүртэй байдаг.

шуурганд гэр хийсч унахаас хамгаалж өгдөг. Гэрийн яс модыг босгож дуусаад тооны дөрвөн тал дахь оосроо даруулж уядаг энэ тооно эргэж гажихаас хамгаалдаг. Мөн гэрийг бат тогтвортой байлгахад баруун зүүн талд гадас хадаж, урт олс дээсээр тоононы голоор даруулж өгдөг.

Үүнээс гадна ханын боолт, дээвэр туурганы оосор бүч зэрэг нь цөм л өөр өөрийн үүрэгтэй. гэрийн бэхлэнэ. Мөн хаалга хана хоёроо адил өндөртэй байхаар тохируулж, дотуур бүслүүрээ татна. Үүний дараа тооноо баганаар тулан босгоод нэг хүн барьж байхад дөрвөн талаас хэд хэдэн унь хатган тогтвортой болгон улмаар бүх унийг урд голоос эхлэн өлгөж дуусгаад, тоононы дөрвөн талд байх чагтагыг дөрвөн тийш татаж уяна. Үүний дараа цаваг буюу дотор талын дээврийг урд талаас нь эхлэн

Өрхний дөрвөн хошуунд дөрвөн оосор хадаж өгдөг бөгөөд түүний хойт, баруун, зүүн талын оосрийг гэрийн бүслүүрт бэхлэн, ханын шийргээс юм уу, эсвэл тусгай ачаа зүүж даруулж уяна. Урд талын оосрыг өрхийг татах, сөхөхөд ашигладаг учир байнга уяж бэхэлдэггүй.

Гэрийг бат тогтвортой байхад чухал үүрэг гүйцэтгэдэг нэг зүйл бол чагтага юм. Тоононы голд, мөн дөрвөн талд нь бэхэлсэн оосорыг чагтага гэнэ. Ерийн цагт тоононы голын чагтаганы сул үзүүрийг өлзий хээ гарган гэрийн зүүн талын хэдэн унинд хавчуулсан байдаг бөгөөд салхи шуургатай үед буулгаж, чанх доош нь унжуулан чагтаганаасаа хүндрүүлэх ачаа дүүжилж өгдөг. Энэ нь гэрийн багана, хана, бүслүүрт ирэх ачааллыг нэмэгдүүлж, салхи бүрээс хөдлөхгүй, салхи шуурганд яргадаж унахгүй байлгах зориулалттай.

Сүүлийн үед гэрийн гадна талаар битүү даавуун бүрээс хийж, нөмөргөдөг болсон нь гэрийн эсгий бүрээсийг салхи шуурганд хөдлөхгүй байлгахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Одоо гэрийг хэрхэн барих талаар хэдэн үг хэлье. Гэр барихын тулд эхлээд барих газараа сонгож, цэвэрлэнэ. Монголчууд гол төлөв гэрээ өмнө, зүүн өмнө зүгт үүдийг нь харуулж барьдаг. Энэ нь Монгол орны салхи ихэвчлэн умар зүгээс байдагтай холбоотой.

Гэр барихын тулд эхлээд гэрийн доторхи том тавилгаа гэр дотор оруулна. Дараа нь баруун хатавчны хананаас эхлээд бүх ханаа дугуйлж, ханыхаа амыг зөв нийлүүлж, ам бүрийг ханын боолтоор боож

Гэр барьж буй нь

Бүрээсгүй гэр

Монголын олон гэрт хэмжилт хийгээд гэрийн бүтэц хэсгийн дундаж харьцааг гаргасныг үзэхэд:

-Гэрийг барьсан үеийн хананы өндөр буюу хаалганы өндөр сандал дээр суусан хүний өндөртэй харьцангуй тэнцүү;

-Хаалганы өргөн нь тоононы голчтой харьцангуй тэнцүү;

-Гэрийн диаметр тоононы диаметрээс 4 дахин их;

-Гэрийн өндөр нь хаалганы өндрийг бүтэн хагас (1.5) дахин авсантай харьцангуй тэнцүү байх жишээтэй.

Өрнөдийн уран барилгачид, сүм дуган, орд харш барихдаа хүний биеийн харьцааг харгалзан үздэг нэгэн өвөрмөц арга "алтан огтлол"-ын зарчим Монгол гэрт мөрдөгдөж байсан гэж зарим судлаачид үздэг юм.

нөмөрнө. Дараа нь урд талын цавагны захыг хойд цавагны зах дарж байхаар хойд цавагаа нөмөргөнө. Дараа нь туургаа хатавчнаас эхлэн нөмөргөнө.

Дээврийг цавагны адил дараалалаар урд талаас нь эхлэн нөмөргөнө. Дээвэр туургаа нөмөргөж дуусгаад гэрийн гадна талын бүслүүрүүдийг татна. Үүний дараа гэрийн өрхийг тавьж гурван тийш татаж уяна. Гэр барих дэс дараа ерөнхийдөө ийм байдаг.

Гэрийг яагаад нүүдэлчдээс хүн төрөлхөтний соёл иргэншилд оруулсан хувь нэмэр гэж үздэг юм бэ. Гэр бол Төв Азийн /Монголын/ задгай ширүүн салхинд тогтвортой, хүйтэнд дулаан, халуунд сэрүүн болгож болдог, ус чийг сайн даадаг, гэрэл гэгээ ихтэй тул саруул, агаарын солилцоо сайн, дотор нь аж төрөхөд тохиромжтой, ашигтай талбай ихтэй, бат бэх, хийхэд хялбар, хэмнэлттэй, эрүүл ахуйн шаардлагыг хангасан, нүүж зөөхөд хялбар зэрэг давуу талтай. Гэр Монгол нутгийн их салхи, догшин шуурга, ширүүн бороо, газар хөдлөлт зэргийг ер ажирдаггүй.

Гэр дугуй, дээд тал нь конус хэлбэртэй байдаг нь чухам монгол орны ширүүн салхинаас ирэх ачааллыг хялбар зайлуулж чадах хамгийн тохиромжтой хэлбэр мөн.

Монголчуудын мал маллагаа, гэр аж ахуйн үйл ажиллагаагаа цагийн нарийн хуваарьтай явуулж ирсэн тэгэхлээр цагийн баримжаа авах явдал чухал хэрэгтэй байсан.

Түүнийг гэрийн тооноор тусах нарны туяаны хөдөлгөөнөөр тооцдог байжээ. Өөрөөр хэлбэл нарны цагаар хэмжиж байлаа.

Сүүлийн үед Монгол гэрийн хийц хэсгийн хоорондын харьцаа уялдаа хэмжээг уран барилгын онолын үүднээс судлах ажил хийгдэж байна.

Майхан

Даавуун сууцнууд. Нүүдэлчин малчин аймгуудын нэлээд түгээмэл хэрэглэж байсан орон байрны нэгэн төрөл болох энэхүү сууц нь V зууны үеэс түгээн дэлгэрчээ.

Даавуун сууцны хийцийн гарал үүсэл нь маш балар эртний үед хамаарагдах боловч хүмүүсийн амьдралд хэрэглэгдэж орон сууцанд ашигласан явдлыг ихэнх судлаачид сүлжмэл зүйл хийдэг болсон цаг үетэй холбон тайлбарлах бөгөөд даавуун сууцыг цацар, цачир, асар, майхан, жодгор гэх зэргээр нэрлэдэг.

С.Идшинноров
С.Уранбилэг

ИДЭЭ, УНДАА

Монголчууд эрт дээр цагаас мал аж ахуйг нүүдлийн аргаар эрхлэн аж төрөхдөө, ан агнаж, тариа будаа тарьж, хүнсэнд хэрэглэдэг зэрлэг ургамлын зүйлийг түүж ашигласаар иржээ. Иймд идээ ундааны үндсэн материал нь эрхлэдэг аж ахуйтай нь нягт холбоотой байжээ. Түүнээс гадна импортын материал ч хоол хүнсэнд зохих байр эзэлдэг байв.

Монголчуудын хоол хүнсний чухал бүрэлдэхүүн бол малынхаа сүү шимийг боловсруулан гаргаж авдаг цагаан идээ юм. Сүүнээс бөгсөөсөн ууриг болон сүү, өрөм, зөөхий, цөцгий, хусам, шар тос, цав, цагаан тос зэрэг бүлэг идээ гаргаж авдагаас гадна исгэх аргаар анхны боловсруулалт хийж, үхрийн болон ингэний ундаа, хоормог, гүүний айраг, үхэр, хонь, ямааны тараг, хоормог, бог малын сүүний цөрөм, таргийг буцалгаж аарц, сүүг ээдүүлж ээдэм, бяслаг, ээзгий, аарцыг шүүгээд, ааруул, хурууд, цагааг нэрж архи, ээрэм зэрэг олон зүйл идээ ундаа хийдэг.

Бөгсөөсөн ууриг. Таван хошуу малаас адуунаас бусад малын ууригийг ашигладаг.

Саяхан төллөсөн малын гал ууригийг тусгай саванд хийж, тогоотой усанд дүрж тавин, усыг буцалгаж болгоно. Ингэхдээ тогоотой ус, уурагтай савны амыг хальж, орохгүй байхыг анхаарах хэрэгтэй. Мөн ууригийг жигнэж болгоно. Ууриг халж өтгөрөн бяслаг мэт болдог. Ингэж боловсруулахыг ууриг бөгсөөх гэнэ. Бөгссөн ууригийг зүсэж иднэ. Бөгссөн ууриг чихэрлэг сайхан амттай, зохимж сайтай идээнд тооцогддог.

Хэлгий ууриг. Үхэр, бог малын ууриг төллөснөөс хойш 2-3 хоногт шингэрч бөгсөхөө больдог. Ийм ууригийг хэлгий ууриг гэнэ. Ууриг хэлгийтэх үед боловсруулах арга нь өөр болдог. Хэлгий ууригийг тогоонд хийж зөөлөн галаар буцалгахдаа олон дахин самарна.

Ууригийг хөөрүүлэх. Гол төлөв говь нутагт ингэний ууригийг хурааж аривжуулан, бага зэрэг эсэж ирмэгц зөөлөн гал дээр тасралтгүй самран хөөрүүлээд ууна.

Хуурсан ууриг. Ууригийг тогоонд хийж шууд зөөлөн гал дээр буцалгаж, агшаана. Энэ аргаар боловсруулахад бөгсөөсөн уургаас хатуувтар болдог. Гэвч галыг нь сайн тохируулахгүй бол түлэгдэж гэмтэх талтай.

Ууригийн ээзгий. Бог мал, үхрийн ууригийг тогоонд хийж буцалган ээдүүлж, шар усыг нь шүүж авалгүй ширгээн ууригийн ээзгий хийдэг.

Ууригийн ааруул. Бог малын ууригийг хурааж нөөцлөөд, үнээний сүүтэй хольж ээдүүлэн буцалгана. Ингэж боловсруулсан ууригийг цөрөм гэнэ. Үүгээр ааруул хийж, цөрөмийн ааруул гэж нэрлэнэ. Бас намар болж, бог малын сүү ширгэх дөхөхөд, сүү нь уурагшин өтгөрдөг. Түүнийг хурааж нөөцлөн цөрөм хийх явдал ч бий.

Ууригийн бяслаг. Гал ууригийг хэлгий уурагтай хольж ээдүүлэн бяслаг хийж иддэг. Уургаар хийдэг хоол ундаа нь намар болж сүү цагаан идээ ховордох үеэс эхлэн, хавар мал төллөж, сүү цагаан идээ элбэгших хүртэл завсрын шилжилтийн шинжтэй учир хоол ундааны нэмэр сэлбэг төдий байжээ.

Сүү. Монголчууд гол төлөв сүүг хөөрүүлж болгон ууна. Хөөрүүлж болгосон сүүг хоол ундааны сэлбэг болгон тун бага хэмжээгээр хэрэглэдэг. Гол төлөв өглөө, оройн цагаар сүү хөөрүүлэх үедээ ганц нэг аягаас илүүгүй ууна. Харин цай сүлэх, хярам, цийдэм хийх зэргээр уух нь элбэг. Мөн эсгэж айраг, тараг бусад идээ хийнэ.

Сүү бол цагаан идээний үндсэн түүхий эд мөн. Сүү боловсруулж хийх цагаан идээний төрөл олон.

Хувинтай сүү

Зөөхий. Сүүг хөөрүүлж, зөөхий байлгаж хамж аван шинээр нь идэхийн зэрэгцээ нөөцөлж хураадаг. Зөөхийг ид зуны цагт сүү цагаан идээ элбэгтэй үед боловсруулж авна. Зөөхийг дангаар нь идэхийн зэрэгцээ нунтаг ээзгий, болсон будаа, гоёо, арвайн гурил зэрэгтэй хольж иднэ.

Модон торхтой зөөхий

Өрөм. Өрөм байлгах нь монголчуудын дунд өргөн дэлгэрсэн арга юм. Хонь, ямаа, үнээний түүхий сүүг буцалтал халааж хөөрүүлээд олон арван удаа самрахад сүүний цөцгий ялгаран дээд талд нь хөөсөрдөг. Тэгээд сэрүүвтэр газар тавьж хөөсийг нь замхраан хөргөхөд сүүний дээд талд өрөм цоохортон тогтоно. Үүний дараа хөөрүүлсэн сүүгээ дахин зөөлөн галаар халааж, өрмийг нь дөвийлгөн, галаас гаргаж загсаадаг. Өрөм байж гүйцэхэд өрөмний тогоотой наалдсан захыг хусуураар тогоог дагуулан хусч салгаад дотор талд буюу цөцгийтэй талаар нь хавсран авч шинээр нь идэх буюу хавтгай самбар дээр тавьж хатааж, хөлдөөж хүнсэнд хэрэглэнэ. Мөн тусгай саванд хурааж нөөцлөнө.

Өрмийг уулын цагаан төмс, шар, цагаан будаа, чангаамал, арвайн гурил, ааруул, хурууд, ээзгий, тараг, хоормог, мэхээр, боов, боорцогтой хольж иднэ. Мөн чихэр жимсээр амталж хүнсэнд хэрэглэнэ.

Цөцгий. Өрөм байлгах аргаар сүүний цөцгий тосыг ялгаж авахаас гадна сүүг хөөрүүлэлгүй сэрүүн газар тавьж хөргөхөд сүүний цөцгий дээд талд царцангитан тогтдог. Түүнийг хамж аван хүнсэнд хэрэглэнэ.

Хутгууш. Шинэ нойтон өрөмийг нунтаг ээзгийтэй хольж хутган иддэг. Үүнийг зарим газар "хутгамш" гэж нэрлэнэ.

Хайлмаг. Хурааж нөөцөлсөн өрөм зөөхийг хайлж, ээзгий, ааруулын нунтаг, гурилтай хольж хайлмаг хэмээх цагаан идээний нэгэн төрлийг хийнэ. Мөн чихэр, үзэм жимсээр амтална.

Цагаан (хайлсан) тос. Намар оройхон зун хурааж нөөцөлсөн өрөм зөөхийгөө хайлж шар тосыг нь ялган аваад үлдсэн цөвийг ээзгийтэй хольж, хонины гүзээнд хийж царцаан өвлийн хүнсэнд нөөцөлдөг. Үүнийг цагаан тос, хайлсан тос, хольсон тос гэх мэтээр нэрлэдэг. Чихэр, мэхээр, бүүргэнэ, ямаахай, мойл зэргээр амталж, аривжуулдаг. Сэрүүн бүсийн нутагт хураасан өрөм гашилах нь бага байдаг тул хайлж, холихгүй шууд гүзээнд хийж нөөцлөх явдал бий. Бас цагаан тос гэнэ.

Хайлмаг

Шар тос. Шар тосыг гаргаж авах үндсэн хоёр арга байдаг. Үүнд:

Өрөмнөөс шар тосыг гаргаж авахдаа хураасан өрөм зөөхийг хайлуулж тос холиход, түүнээс шар тос нь ялгардаг. Ялгарсан шар тосыг халбагаар хутган авч тусгай саванд хуримтлуулна. Түүнийгээ тусгай сав, олгойд хийж хадгалан хүнсэнд хэрэглэнэ.

Түүхий сүүний айргийг бүлээсгэн удаан хугацаагаар бүлэхэд тос нь ялгаран хөвдөг. Түүнийг хамж аван хайлуулахад шар тос гарна. Шар тосыг хуймаг, бин, далан давхар, шарвин хайрах, цай хийцлэх, цайнд самрах, боовны зуурмагт хийх, боов чанах, хуушуур хайрах, тарианы болон элдэв зэрлэг ургамлын гурил зуурч идэх зэрэгт өргөн ашиглахаас гадна элдэв өвчин хууч засахад эмчилгээний зориулалтаар хэрэглэдэг.

Шар тос

Хусам. Сүүг хөөрүүлэхэд тогооны ёроолд хайрагдаж тогтсон хэсгийг хусам гэнэ. Хусамын өнгөн хэсэг цагаан, түүний дор бор, бүр доор нь их түлэгдсэн хар хусам байдаг. Хар хусамыг иддэггүй. Дээр дурдсан цагаан идээг ихэвчлэн сүүг хөөрүүлэх замаар гарган авдаг. Үүнээс гадна сүүг эсгэх, ээдүүлэх замаар олон идээ ундаа бэлтгэдэг.

Тараг. Болсон сүүг бага зэрэг халааж тарагны хөрөнгөө хийж, сайтар самран тусгай саванд юүлэн, дулаавтар газар тавьж эсэлдүүлдэг. Сэрүүн цагт тараг бүрж буй саваа юмаар хучина.

Модон тагтай тараг

Таргийн хөрөнгө нь гол төлөв шүүсэн тараг байх бөгөөд зарим газар ялангуяа жилийнхээ анхны таргийн хөрөнгөнд нүдэж нунтагласан ааруул, ааруц, гишүүнэ зэрэг эсгэлэн ургамал ашиглах явдал байдаг. Таргийг үхэр, хонь, ямааны сүүгээр бүрдэг. Тараг нь зун цагт оройн хоолонд гол үүрэгтэй байжээ. Дулаан цагт таргийг удаан хадгалахад улам эсэлдэн ихээхэн хүчтэй болдог.

Хоормог (айраг, ундаа). Хоормог гэдэг нь эссэн таргийг борив, хөөрцөгт хийж сүүгээр шингэлж, амталж ундаа бэлтгэхийг хэлнэ. Бас зарим нутагт үхэр, тэмээ, бог малын сүүгээр айраг эсгэдэг. Үүнийг голдуу айраг гэхээс гадна зарим газар хоормог ч гэнэ.

Цагаа. Хонь, ямаа, үнээ, ингэний айраг, тараг, хонь, ямааны цөрмийг чанаж буцалгасныг цагаа гэнэ. Цагааг бэлтгэх зорилгоор зориуд айргийг буцалгахаас гадна, архи нэрэх зорилгоор буцалгаж цагааг гаргана. Цагааг тэр чигээр нь уухаас гадна шүүж, ааруц болгон нөөцлөх, ааруул хурууд тавьж хүнсэнд хэрэглэдэг.

Ээрэм. Бод, бог малын ундаа (айраг)-аар архи нэрэх үед бүрхээрийн доод талын дотор, гадар, архины тосгуурын доод талд хусамтаж наалдсан цагааг ээрэм гэдэг. Ээрмийг дангаар нь идэхээс гадна, болсон сүү, цагааны хөөстэй хольж ааруул тавьж нөөцөлдөг.

Ааруц. Буцалгасан тараг, цагааг даавуун уутанд хийж шар усыг нь шүүснийг ааруц гэнэ. Ааруцаар ааруул хурууд тавихаас гадна буцалгаж уух, хоол амтлах, хөлдөөж нөөцлөх зэргээр хүнсэнд хэрэглэдэг.

Ааруул, хурууд. Шүүж нягтруулсан ааруцыг утсаар зүсч, эсвэл гараар базаж ааруул хурууд тавьж хатааж нөөцлөнө. Ааруулыг амт сайхантай, тослог зөөлөн болгохын тулд цагаандаа сүү нэмж буцалган шүүдэг. Ааруулыг чихрээр амталж хийж болдог. Мөн ааруцыг шүүрэн шанаганы нүхээр шахаж гоожуулах замаар хорхой ааруул хийх явдал бий.



Хөхүүртэй айраг



Базмал ааруул

Хорхой аарууль

Ааруул, хурууд

Бяслаг. Голдуу түүхий сүүг эдүүлэх аргаар хийдэг цагаан идээний нэг төрөл. Бяслаганд том жижгээс нь хамаарч орох сүү, эдүүлэг нь харилцан адилгүй их бага байдаг. Ер нь бяслаганд нилээд их сүү ордог. Бяслаг хийх сүүгээ зөөлөн галаар халааж дээр нь шар сүү, тараг зэрэг эдүүлгээ бага багаар тойруулан хийж сүүгээ эдүүлэн, ээдмээ биелж ирэхэд бөс даавуун уутанд хийх юм уу ам даавуун дээр гаргаж, дөрвөлжин хэлбэртэй болгон даавуугаараа нягт ороож, хоёр хавтгай самбарт хавчин дээр нь хүндрүүлэгч тавьж шахаж, шар усыг шавхана. Бяслаг шахахад сүүний халуун, эдүүлгийн их багыг сайтар тохируулахад анхаарах хэрэгтэй. Эдүүлэг ихэдвэл бяслаг гашуун исгэлэн амттай, сүү хэт халуун, эдүүлэг багадсан байвал ээдэм бага унаж, дэмий сүүний гарз болдог. Бяслагийг өрөм, зөөхийтэй хольж иддэг. Гэвч өдөр тутмын хоолонд хэрэглэх нь элбэг биш. Гол төлөв аян жинд явах, айлчин гийчин ирэх, найр хурим, баяр ёслолын үед тавгийн идээ засахад бяслаг зүсч тавганд тавьж идне.

Ээдэм. Үхэр, бог малын хөөрүүлсэн халуун сүүн дээр бага шиг тараг хийж ээдүүлэн шар сүүнээс нь ялган авч (бяслаг шиг шахалгүй) иднэ. Ээдмийг сүү, өрөм, зөөхийтэй хольж иднэ.

Боз. Ихэвчилэн говь нутгийнхан ингэний сүүн дээр бага зэрэг цагаа (айраг) хийж тасралтгүй самран буцалгаж хөөрүүлж уудаг. Үүнийг буцалгаа, зуурмаг гэх зэргээр нэрлэх нь бий.

Ээзгий. Ээзгий хийхэд сүүг бяслаг шахахтай адил ээдүүлэн, харин шар сүүг нь шүүж ялгалгүй, зөөлөн галаар буцалган ээдэмд шингээн ширгээдэг. Ээзгийг хатааж их хэмжээгээр нөөцөлж өвлийн хэрэгцээндээ зориулахаас гадна, цагаан тос холих, өрөм зөөхийтэй хольж, цайнд хийж дэвтээж идэх зэргээр хэрэглэнэ.

Ээзгий

Гүүний айраг. Монголчуудын түгээмэл хэрэглэдэг ундааны зүйл. Гүүний хөргөсөн саамыг үхрийн ширэн хөхүүрт хийж, сайтар бүлж исгэдэг ундаа юм. Зуны цагт насанд хүрсэн эрэгтэйчүүд айраг их хэмжээгээр уудаг бөгөөд тэр нь ундаа бас хоол ч болно.

Айргийн анхны хөрөнгийг айргийг хөлдөөж, эсвэл хатааж хадгалах замаар нөөцлөхөөс гадна ямааны тараг, шар будаа, гишүүнэ цулхир зэрэг ургамлын зүйлийг ашиглах явдал ч байдаг. Зарим нутагт гишүүнийг айргана гэж нэрлэдэг. Гүүний айраг бол тэжээллэг сайтай амтат ундаа төдийгүй эмчилгээний чухал ач холбогдолтойг эрдэмтэд судлан тодруулжээ. Айргийг өдөр тутам хэрэглэхээс гадна найр наадам, өрх гэр, төр шашны ёслолд эрхэм хүндтэй ундаанд тооцож өргөн дэлгэр хэрэглэдэг.

Махан хоол

Эртнээс нааш эрхэлж ирсэн мал аж ахуй, ан агнуурын олзвор нь хоол ундны нь чухал бүрэлдэхүүн махан хоолны эх сурвалж болсоор иржээ. Махан хоолны дотор тураг махан хоол чухал байртай. Намар цагт голдуу ангийн мах, өвлийн тэргүүн сараас өөрөөр хэлбэл, өвөл цагийн идшээ нөөцөлснөөс эхлэн малын мах монголчуудын хоолонд зонхилдог байжээ.

Монголчууд ангийн махыг малын махтай адил эвдэж чанаж идэх, хуурч хайрч идэх болон бусад хольцоор амталж янз бүрийн хоол хийж идэх явдал их байсан. Гэвч тарвага зэрэг зарим ангийн махыг арьсыг нь хуулалгүй, харин ч махыг нь арьсанд нь дагуулан ясыг нь авч тулман дотор нь чулуу улайсган хайрч, мөн гаднаас нь галаар төөнөх замаар болгон иддэг. Үүнийг боодог гэж нэрлэнэ. Малын махыг үелж жижиглэн чанаж идэх явдал элбэг байсан бөгөөд бүхэл махан хоол гэдэг.

Мал болон ангийн тураг махаас гадна гэдэс дотроор олон төрлийн хоол хийдэг. Гэвч ангийн дотор махаас элэг, сэмж, бөөр, зүрхийг хоолонд хэрэглэх явдал нилээд дэлгэр байжээ. Монголчууд махыг нь хүнсэнд хэрэглэдэг гол ан бол зээр, гөрөөс, аргал, янгир, хулан, хавтгай, гахай, туулай, тарвага, зурам, буга, хандгай, бөгөөд шувуу загасны махыг бага хэрэглэдэг.

Монголчууд таван хошуу малын гэдэс дотрыг цэвэрлэж чанаж идэх, хонь, ямаа, үхрийн цусыг гэдсэнд цутгаж чанаж идэхээс гадна, уушиг гүзээ хоёрыг борцолж, хоолны хольц болгох, цутгасан цусыг зүрх, бөөр, элэг, дотор өөх зэрэгтэй хольж гүзээнд нь хийж хөлдөөн хярамцаг хийж шөлтэй хоол хийж иддэг. Хярамцагны шөлөнд гурил, будааг хольц болгодог.

Хонь, ямааны толгой шийр, үхрийн тагалцаг, хонь ямааны өвчүү, хонины сүүлийг арьстай нь аваад үсийг нь хуйхалж, хярваслан чанаж идэх буюу махыг шулж янз бүрийн хоол хийж иддэг. Үхэр, хонь, ямаа, тэмээний махыг урин дулаан цагт идэхээр нөөцлөх өвөрмөц арга бол борцлох явдал юм. Өвөл борцолсон мах уриншиж хатан ухаа шаргал өнгөтэй болдог. Борцоор гол төлөв шөлтэй хоол хийж иддэг. Мөн махыг зөөлөн галаар өөрийн нь шүүсэнд болгон шүүсийг нь маханд нь шингээн ширгээж, бал гардаггүй саванд нягт дарж хадгалдаг. Үүнийг шууз гэж нэрлэнэ.

Монголчууд мах, гурил, ногоо, ургамлын холимог хоолыг нэлээд өргөн хэрэглэдэг. Холимог хоолны төрөлд тураг мах хөшиглөсөн, эсвэл хярамцаг хөшиглөж хольцонд элдэж хэрчсэн гурил, будаа, хүнсний ногоо, зэрлэг ургамлын үр (хөц) хийсэн шөлтэй хоол, хуурга, гурилаар хучиж сонгино, сармис, халуун ногоогоор амталсан бууз, хуушуур, банш зэрэг татшин хоол хийнэ. Мөн бантан, зутан зэрэг нь холимог хоол юм.

Ёслолын зоог

Бууз

Сүү цагаан идээгээр сүүтэй будаа, гурилтай сүү, ааруц зэрэг холимог хоол бас хийдэг. Хоолонд тарималнагооноос гадна уулын сонгино, халгай, таана, хөмөл, гогод, мангир, халиар, бивлэн, цагаан мөөг зэрэг зэрлэг ургамлыг хольц болгон ашигладаг.

Цай, ундаа. Монголчуудын жилийн дөрвөн улиралд хамгийн нийтлэг уудаг унд бол цай юм. Цайг сүүтэй цай, хар цай (сүлээгүй) гэж хоёр ангилж болно. Цайгаа буцалгаж идээшүүлээд сүлж сүүтэй цай болгодог. Зарим газар давс хийж амтална. Үүнээс гадна хийцтэй цай, цоргисон цай, хорхоглосон цай зэрэг тусгай аргаар чанаж, амт оруулсан цайг хийж уудаг. Мөн будаа, сулхир, шар тос, өрөм зэрэг хийсэн цай уудаг. Цайг чанасан арга хольц, амталсан зүйлээр нь өөр өөр нэрлэдэг.

Цай ховор үед нохойн хошуу, уулын цай, сөд өвс зэргээр цай чанаж уудаг байжээ. Мөн хүүхдэд буцалсан усыг сүлж хярам, халуун цагт түүхий цэвэр усан дээр сүү хийж цийдэм хийж уулгадаг байжээ.

Хөлчүүрүүлэх ундаа. Монголчуудын өргөн дэлгэр хэрэглэж ирсэн хөлчүүрүүлэх ундаа бол цагаа (айраг)-аар нэрсэн архи юм. Үүнийг монгол архи, нэрмэл архи, сүүний архи гэх зэргээр нэрлэнэ. Бас дарсыг нилээд хэрэглэдэг байсан бөгөөд одоо ч хэрэглэсээр байна. Сүүлийн үед пиво буюу монголчуудын нэрлэдгээр шар айраг өргөн хэрэглэх болжээ.

XX зууны эхэн үеэс үйлдвэрийн аргаар өндөр градустай архи, дарсыг дотооддоо үйлдвэрлэх болсон. Хөлчүүрүүлэх ундаанд гүүний айргийг багтааж болох юм. Намар цагийн ялангуяа говь нутгийн айраг согтоох чанар илүү байдаг. Урьд цагт архийг онцгой тохиолдолд найр наадам, баяр ёслолын үед хэмжээтэй хэрэглэдэг байжээ.

Ёслолын зоог шүүс. Монголчууд шинэ жил цагаан сар, улсын баяр наадам, уул овоо тахих, хүндэт зочин хүлээн авах, үдэх зэрэг төр шашны болон иргэний томхон баяр наадмаас гадна шинэ гэр барих, хурим хийх, хүүхэд угаах, хүүхдийн сэвлэг үргээх, унага барих, үрс гаргах, эсгий хийх зэрэг хүний амьдралын онцгой үе, мөчлөг, аж ахуйн холбогдолтой олон баяр тэмдэглэдэг. Тэр бүхэнд зориулж хүндэтгэлийн тусгай зоог шүүс бэлтгэдэг. Ийм зоог шүүс нь өдөр тутмын хоол идээнээс ялгаатай.

Хүндэтгэлийн шүүст хонины мах тэргүүлэх шинжтэй байдаг. Баяр ёслолын цар хэмжээ зэргээс хамаарч шүүсэнд бүхэл хонины мах юм уу, хонины махны зарим хэсгийг тавьдаг.

Төр шашны их баяр, уул усны их тайлга тахилга, эрхэм хүндтэй зочныг дайлах, шинэ гэр барьж хурим найр хийх зэрэгт бүхэл хонины шүүс засдаг. Бүхэл хонины шүүсэнд ууц, дөрвөн мөч мах, хүзүү, сээр, дал дөрвөн өндөр, хавирга, эрүүгүй толгой ордог.

Ууц засах буюу таваглахдаа чанаж загсаасан хонины бүхэл махыг том тэвш буюу царан дээр амьд байхдаа хэвтэж байгаа байдлаар дөрвөн мөч махыг нь тавьж, дунд нь сээр, хүзүү орж, түүний дээр бүхэл ууцаа сүүлэн талыг нь гадагш харуулан тавьж, түүний дээр толгойг голлуулан тавьдаг.

Шүүсийн ууцыг ахмад настан эсвэл гэрийн эзэн хөндөсний дараа хүндэт зочин болон найр хуриманд оролцогсодод хувь хүртээдэг.

Баяр ёслолын хоолонд цагаан идээ, гурилан боов, чихэр жимс болон элдэв амтатнаар тавгийн идээ засдаг. Мөн цагаалга, айраг, сүү чухал байр эзлэнэ. Түүнчлэн банш, бууз, хуушуур зэрэг махан таташаар хийсэн амтат хоолыг эрхэм хүндтэй хоолонд тооцдог. Ийм төрлийн хоол нь хятадаас гаралтай боловч "юугаар элбэг түүгээрээ дайлна" гэгчээр бараг махаар хийдгээрээ жинхэнэ монгол хоол болж чадсан юм.

Монголчууд өрх гэртээ зочилж ирсэн хүнд бас мөчилж жижиглэсэн мах чанаж өгч дайлдаг. Энэ нь ч бас учир холбогдолтой. Нуруу, сээр, дал дөрвөн өндөр, өвчүү, шаант зэргийг чанаж өгдөг нь зочныг хүндэтгэж буйн илрэл билээ.

XX зууны үед Монгол улсад Орос-Европын соёлын нөлөө хүчтэй болсонтой холбоотой Монголчуудын өдөр тутмын болон ёслол хүндэтгэлийн шүүс, зоог, түүнтэй холбоотой ёс заншилд багагүй шинэчлэл гарсан бөгөөд цаашдаа ч хувьсан өөрчлөгдсөөр байх биз ээ.

С.Идшинноров
С.Уранбилэг
З.Амарбилиг

ТОГЛООМ НААДГАЙ, ҮНДЭСНИЙ СПОРТ

Монгол тоглоом наадгай бол үе үеийн бүтээлд тулгуурласан, тоглох арга, агуулга хэлбэрийн хувьд төгс боловсорсон оюуны соёлын чухал өв билээ. Монголчуудын тоглоом наадгй нь тэдний амьдралын гол сурвалж болсон мал сүргээ маллаж өсгөх, ан гөрөө хийх, ах зах, хүндлэх ёсыг хэвшүүлэхийг үлгэрчлэн харуулсан хүүхдэд хөдөлмөр, ёс суртахууны хүмүүжил олгодог байснаараа онцлогтой.

Монгол тоглоомын дотор эртний хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааны шууд тусгал болон зохиогдсон тоглоом олон байдаг. Тухайлбал "чулуугаар бай онох", "чулуу өнхрүүлэн уралдуулах", "чулуугаар ус алгадуулах" зэрэг тоглоом нь ан агнах, араатнаас биеэ хамгаалах үйл ажиллагааны тусгал юм. Анх чулууг гараар барьж шидэх тоглоомтой байснаа хожим амьтны арьс ашиглан дүүгүүр хийсэн нь одоо хүртэл хэрэглэгдсээр байна. Түүнчлэн бөх барилдах, морь уралдуулах зэрэг тоглоом нь их эртний болох нь тэдгээрийн хөдөлгөөний зохицолоос харагддаг.

Монголчуудын тоглоом наадгайг насанд хүрэгсдийн ба хүүхдийн, залуучуудын гэж ангилж болох ба тэдгээрийг шагайн тоглоом, хөдөлгөөнт тоглоом, хөлөгт тоглоом, зурагт тоглоом, гэр барих тоглоом, гогцоо гаргах тоглоом, чулуун ба аман тоглоом гэсэн ангид хувааж болно. Насанд хүрэгсэд шагалцах, мөсөн шагай харвах, шагай харвах, цүү хаях, хорол, үйчүүр, шатар зэрэг тоглоомоор тоглодог байв. Хүүхдийн тоглоом гэвэл шагайгаар морь уралдах, чулуугаар гэр барих, чоно тарвагацах зэрэг сэтгэхүйн болон хөдөлгөөнт тоглоомоор тоглодог байжээ.

Тоглоом наадгайн зүйлээр тоглох цаг хугацаа, тоглох, тоглохгүй үе харилцан адилгүй улиралын шинж чанартай байв. Тухайлбал цагаан мод хаях тоглоомыг баруун аймагт үнээнд бух гүйхгүй үед зэлний ойролцоо тоглодог байсан бол халхад малын өвчин гарсан үед, зарим амуу будаа эрхэлсэн нутагт намрын анхны хяруу унагаахгүй гэж будаа тарьсан газрын ойролцоо тоглодог байжээ. Цагаан сарын битүүний үдэш шагайгаар алаг мэлхий өрж тоглодог байхад даалуу тоглох хориотой байв. Түүнчлэн тэнгэр дуугарч, бороо орж байхад ямар нэгэн тоглоом тоглохыг цээрлэдэг байв. Цагаан мод хаях, цагаан тэмээцэх зэрэг тоглоомыг зуны цагт, шагай, хорол, шатарын төрлийн тоглоомыг аль ч цаг улиралд тоглож болдог байжээ.

Хөлөгт тоглоомын эртний хэлбэр болох "бажи" гэдэг тоглоомыг Өвөрхангайн Хар-Хорин, Архангайн Хотонт сумдад одоог хүртэл тоглож байна. Монголын бүх нутгаар тархсан тоглоомын тоонд шагайн төрлийн тоглоомууд, цагаан мод хаях (цүү хаях), шатар, хорол зэргийг нэрлэж болно. Эдгээр тоглоомын тоглох арга зарчим ерөнхийдөө нийтлэг боловч нутаг нутагт өөр өөр нэрээр ялимгүй өөр дүрэмтэй тоглодог байна. Тухайлбал шагайгаар "Цагаан ямаа арлуулах" тоглоомыг Булганд "Аргалан хурга гүүр-гийлэх", Завханы Нөмрөгт "Хув цагаан ямаа гүйлгэх", Хөвсгөлийн Бүрэнтогтоход "Шарга ямаа гүйл-гэх" гэхчлэн нэрлэдэг байна.

Шагайн тоглоом. Монголчууд шагайгаар үлэмж олон төрлийн тоглоом зохион тоглож иржээ. Шагайн тоглоом бол монгол хүний өсөхөөсөө өтлөх хүртлээ үргэлжлэн тоглодог хамгийн дуртай тоглоо-мын нэг бөгөөд монголчуудын амьдралын өвөрмөц чанарыг хадгалсан нь тун гайхамшигтай билээ. Шагайны 4 талыг хонь, ямаа, үхэр, адуу (зарим нутагт тэмээ гэдэг) гэж нэрлэн тоглоом наадамд өргөн хэрэглэхдээ нүүдэлчин ард түмний амьдралыг тэтгэгч мал аж ахуйг төлөөлөх бэлгэдлийн гол хэрэгсэл болгож харуулсан нь Монгол-чуудын сэтгэлгээний хөгжлийн нэг илэрхийлэл болсон төдийгүй оюуны соёлын чухал баримт юм.



Шагай

Шагайгаар малаа төлөөлүүлэн хүүхдээ малд дуртай дөртэй болгон хүмүүжүүлдэг. Айл болгон шагайг цэвэрлэж тусгай уутанд хийж хадгалдаг нь монголчуудын заншил болсон байна. Шагайгаар наадаж байхад шагайн дээгүүр алхаж гарвал шагайг хүндлээгүй, эрхэмлээгүйд тооцож хүүхэд дээгүүрээ алхсантай адилд үзэж ихэд цээрлэдэг. Шагайгаар дөрвөн бэрх орхих, лан цэн бодох, морь уралдуулах, шагай таалцах, бөх барилдуулах, гурван шагай хаях, дөрвөн зүс нийлүүлэх, цагаан ямаа арлуулах, бөгцөг няслах, төгс хаях, таван хошуу өрөх, мал үнэлэх, есөн ухаан, андгайцах, тэмээ ботголуулах, алаг мэлхий өрөх зэрэг олон зүйлээр наадлаг.

Шагай няслах. Энэ нь олон шагайг ширдэг дээр цацаж ижил буусныг нь хооронд нь хонийг хониор, морийг мориор няслахдаа гурав дахь шагайг шүргэх төдийд

юм уу оноогүй тохиолдолд дараагийн хүн нясалдаг. Ингэж нясалхдаа өөр шагайг оновол нэг шагай буцааж тавьдаг. Шагай нясалх нь зөвхөн хэсгийг нөгөөгөөр онохоос гадна бөөн шагайг хооронд нь нясалж авсаар эцэст нь олон янзын байрлалаас нясалдаг. Ингэж нясалхыг нясамдах, нясанцах, харвах гэж нэрлэх нь байдаг.

Нууцгай барих. (шагай таалцах) Хүүхэд бүр гартаа хэдэн ч хамаагүй шагай нууцаар таслан атгаж эхний хүүхэд бүх хүүхдүүдийн гарт буй шагайны нийлбэрийг тааж хэлэхийг хичээдэг. Энэ тоглоомыг бас жижиг чулуугаар ч тоглодог. Эхний хэлсэн хүний тоог дараагийн хүн давтахгүй. Таасан хүүхэд бүх шагайг нийлүүлэн авдаг. Мөн нэг шагай гартаа нуун атгаж олон хүүхэд гараа зэрэгцүүлэн сууцгааж ээлжээр нэг нэгээрээ олж тоглох нэг хэлбэрийг цагаан ямаа арлуулах гэж нэрлэдэг.

Алаг мэлхий өрөх. Алаг мэлхийгээр хэдэн ч хүүхэд тоглож болно. Алаг мэлхийг шагайгаар өрж дүрслээд тоглогчид ээлжээр шоо орхино. Хэрэв шоо хоёр нүхээрээ буувал тэр хүн 2 нүд, эсвэл 2 чих, 2 бөөрний аль нэгийг авна. Дараагийн хүн шоог 6 нүдээр нь буулгавал хүзүү, нурууны аль нэг эгнээний 6 шагайг авна. Хэрэв тооны нүх аваад дуусчихсан юмны тоогоор буувал тэр тоотой юмыг буцааж өрнө. Энэ мэтээр тоглосоор байгаад хамгийн олон шагай авсан хүн нь түрүүлдэг. Яст мэлхийн эрхтэн нь: хүзүү 6 шагай, нуруу 6 шагай, тавхай 5 шагай, шилбэ 4 шагай, сүүл 3 шагай, толгой 3 шагай, бөөр 2 шагай, чих 2 шагай, нүд 2 шагай, зүрх, давсан тус бүр 1 шагай нийт 92 шагай байна. Шагайг өрөхдөө нутаг нутагт ялимгүй өөр тоотойгоор өрж байгаа боловч өрдөг арга хэлбэр, ерөнхий зарчим адил байна. Алаг мэлхий нь голдуу цагаан сарын битүүний үдэш гэр хотлоороо тоглодог бэлгэдэлт тоглоом билээ.

Морь уралдуулах. Энэ тоглоомоор хэдэн ч хүүхэд тоглож болно. Тоглох хүүхдүүд шагайгаа зүслэн хичнээн ч морь уралдуулж болдог. Уях морь болгох шагайгаа сонгож аваад тус тусынхаа уяанд уяцгаана. Үлдсэн шагайгаа морь болгон цувуулж өрнө. Цувруулж өрсөн шагайнаасаа ард мухар сөөм зайнд уралдах морьдоо хойш нь харуулж зогсоодог. Хүүхдүүд ээлжээр 4 шагай ээлжлэн орхиж морь буусан тохиолдолд морины тоогоор морио эргүүлж ахиулан тавьдаг. Ганц ч морь буухгүй бол морь эргэхгүй. Ингэж орхисоор хамгийн түрүүнд барианд үсэрч хүрсэн морь түрүүлдэг.

Шагай харвах. Төв халхад их дэлгэрсэн шагай харвах тоглоом бол эртнээс насанд хүрэгсдийн нийтийн тоглоом байсан юм. Одоо хүртэл жил бүр 2 өдөр тогтмол сайн дураараа хоол хүнс, орон майхантайгаа цуглардаг "Бад бөөрийн шагайн тойром", "Хонхор нуурын шагайн тойром" гэх мэт байдаг нь тус тусынхаа газрын нэрээр нэрлэсэн сайн дурын шагайн нийгэмлэгүүд юм. Шагайн тойром нь "шагайн терин" гэсэн үг байжээ.

Эртний түрэг хэлний "терин" (нийгэмлэг) гэсэн үгтэй ижил язгууртай "төөрөг" гэсэн монгол үг одоог хүртэл уламжилж ирсэн нь энэ тоглоомын эртний нийтийн тоглоом байсныг гэрчилнэ. Шагай харвахад гутлын шагайн тус газар улан дээр шагайгаа тавьж харвах, өвдгөн дээрээ ясан годил тавьж харвах, хашлага сумаар хасан харвах олон төрөл наадам бий. Бас мөсөн дээр үхрийн шагай харваж наадаг мөсөн шагай харвах гэдэг сонин цэнгээн наадам бий.

Шагай харвах тоглоом бол эртний "бөг барилдах" тоглоомын сайжирсан хувилбар юм. Шагай харвах тоглоомын эртний хэлбэр



Алаг мэлхий
(М ҮТМ)

Шагай харвах хэрэгсэл
(М ҮТМ)

Говь-Алтай, Завхан, Ховд, Увс, Баянхонгор зэрэг баруун аймгуудын сумдад эдүгээ хүртэл байна. Монгол бөх барилдахдаа нэг нь унаж, нэг нь босоо үлддэг тэр хэлбэрийг хуулбарласан загвар юм. Уг тоглоомыг тоглохдоо томхон хавтгай чулуун дээр гурван шагайны нэгийг бөг (хожмын нэрээр хонь) болгож тавиад, нөгөө хоёр шагайг "таа" болгон хоёр талд нь хөндлөн тавиад, түүнээс 13 тохой зайнаас гарынхаа алган дээр нэг шагайг тавьж нөгөө гарынхаа дунд хуруугаар нясалж дунд нь тавьсан бөгийг оновол 2 оноо, хоёр талын шагайны аль нэгийг оновол 1 оноо гэхчилэн тоглодог.



Шагай харвах хэрэгсэл
(МҮТМ)

Чулуун тоглоом. Монгол хүүхдүүдийн дунд үлэмж дэлгэрсэн тоглох дуртай тоглоомын нэг нь чулуугаар гэр барих ардын уламжлалт тоглоом юм. Чулууг тойруулан өрөөд гэр болгон тоглодог. Тэрхүү чулуун тойргийн урд талд нь завсар гаргаад хаалга болгоод дөрвөлжин хэлбэртэй чулуугаар авдар, гонзгойгоор ор, шаазангийн хэлтэрхийгээр аяга, болгох зэргээр гэрийн янз бүрийн эд агуурсыг төлөөлүүлэн орлуулж зохих газарт нь байрлуулж тоглодог. Хонины хорголоор хонь ямааг, адууны хомоолоор адууг, адууны хомоолыг 2 хувааж үхэр зэргийг дүрслэн төлөөлүүлж гэрийнхээ гадуур тал дүүрэн бэлчээж байрлуулдаг. Чулуун гэр барьж айл орон болж тоглохдоо гэрийн ойролцоо голын эрэг, уул хаданд элдэв өнгө дүрсийн чулуугаар тус тусын гэр хороо, таван хошуу мал, нохой сэлтийг орлуулж мөн ах эгч бологсод нь дүүгээ асран хүмүүжүүлж эцэг эхийн юу гэж хэлж сургадаг, хүүхдээ хэрхэн энхрийлдэг, сайн явдлыг хэрхэн сайшаадаг, буруу хэрхэн шийтгэдэг, өглөө эртлэн босч цайгаа чанах, адуу малаа саах бэлчээрлүүлэх зэрэг нэг өдрийн бүхэл ажлыг орлуулан наадаг. Энэ нь амьдралын хэрэглээний ерийн нэг хуулбар төдийгүй монгол хүний аж байдал, ахуйн хэв заншлыг тусган таниулж байгаа анхан шатны аж төрөх ёсны сургууль нь болж байдгаараа онцлогтой.

Аман тоглоом. Хүүхдийн тоглоомууд дотроос тогтсон ёс журам, үг хэллэг бүхий уламжлалт аман тоглоом наадам олон бий. Хүүхэд хэлд орсон наснаасаа эхлэн зугааүг, аман тоглоомоор тоглодог. Тэдгээр нь ардын аман зохиолтой хосолсон байдаг онцлогтой. Ийм тоглоом наадам нь хүүхдийн аман зохиолын нэлээд нарийн бүтэц бүхий хэлбэр бөгөөд зөвхөн зугаа цэнгэлийн учир холбогдолтой бус бодит байдлыг тусган танилцуулах, бие оюуны авхаалж самбаа, ажигч гярхай чанар, үг хэллэгийг зүгшрүүлэх хүмүүжлийн ач холбогдолтой юм.

Эдгээр тоглоомын явцыг эхлэл, өрнөл, төгсгөл гэж хуваах болох зохиомжийн хэсгүүд ч бий. Олонхи тоглоомын эхэнд шоодох үг хэлэлцдэг. Энэ нь хэн түрүүлж тоглоомыг эхлэх, аль талд нь хэн хэн оролцох, хэн нь юу болох зэргийг тодруулах зорилготой байдаг. Тухайлбал, чоно тарвага болох тоглоомд тоглоход хэн хэн чоно тарвага болохыг тодруулахдаа "чи бол" гэж хэн нэгэндээ оноодоггүй харин шодох үг хэлж хамгийн эцсийн үг таарсан нь чоно болох жишээтэй. Шодох буюу тоог хэлж байхдаа сүүлийн үгээ хэнд тааруулахаа бодож тохируулдаг нь бас ухаан бодлогын сорилт болдог гэж хэлж болох юм. Ийм үгэнд:

Хээлий бээлий
Хэрмэн зэрмэн
Тоодог тогоруу
Тос гялс

Манас бүлтэс гэх мэтийн үг хэллэг байна. Шодох үг хэлэхэд тоог өөр үгээр орлуулан хэлэх явдал цөөнгүй. Мөн гарын таван хурууг ашиглаж:

Пагваадай
Пагдан хөөрөг
Өндөр өөжин
Өсгий зөөхий

Өнчин бөөхий гэх буюу хэмээн өөр үгээр орлуулан хэлэх уламжлал байдаг нь шодох зугаа үгтэй холбоотой байж болох юм. Түүнчлэн олуулаа тоглож байгаад хэн нэг нь булхай гаргаад өөрөө хүлээгээгүй үед эзнийг нь батлах гэж:

Хэн булхайдав
Хэлж өг
Хэлмин жулмин
Дээлий мээлий
Дэвчин гувчин
Хорголоо морголоо

Могодгос гэж сүүлийн үгийг тааруулж хэлдэг.

Энэ нь хүүхдийн ой тогтоомжийг хөгжүүлэх нөлөөтэй байдаг. Тоог өөр үгээр ёгтлон нэрлэсэн нь шодон тоглох явцыг улам зугаатай сонирхолтой болгодог байна.

Хөлөгт тоглоом

"Бажи" хөлөгт тоглоом (МҮТМ)


Шатар

Өндөр хангайн буга. Энэ тоглоомын хөлөг 101 буудалтай. 4 бугын эсрэг 64 хүү тоглодог. Энэ төрлийн тоглоомын ерөнхий шинж нь эсрэг талаа хааш нь ч нүүх нүүдэлгүй болгон шахаж хожих явдал юм. Тоглоход буга барьсан хүн дөрвөн бугыг хэвтэш дээр байрлуулна. Хүү барьсан хүн 32 хүүг хүүгийн байранд тавиад үлдэх 32 хүүг гартаа барина. Тоглохдоо буга барьсан хүн эхэлж нүүдэг. Буга барьсан хүний зорилго бол аль болох олон хүүг идэхэд оршино. Хүү барьсан хүн нь аль болох цөөн хүүгээ идүүлж 4 бугыг хорьж барихыг хичээнэ.

Ижил буга. Энэ тоглоомын хөлөг 75 буудалтай, 6 бугатай, 48 хүүтэй. Тоглохдоо 6 бугыг хэвтэш дээр байрлуулж 16 хүүг хүүгийн байр дээр тавина. Үлдэх 32 хүүг гартаа барина. Буга барьж тоглосон хүн хүүг аль болох олныг идэхийг хичээнэ. Хүү барьсан хүн нь бугыг нүүдэлгүй болгож барихыг хичээнэ. Бугын төрлийн хөлөгт тоглоомуудын ерөнхий зарчим ийм байна.

Гар хуруугаар тоглох тоглоом. Монголын ихэнх нутагт хүүхдийг ухаан сууж нэлээд юмны аливаа учир зүйг олох болсон үеэс эхлэж дунд хуруу олох, сүмбэр уул босгох, хомхой хуруу барих зэрэг гараар тоглох тоглоомоор тоглуулдаг. Дунд хурууг олохдоо баруун гараар зүүн гарын таван хурууг нийлүүлэн зөвхөн өндөгнүүдийн үзүүрийг цухуйлган атгаж "дунд хуруугаа ол" гэнэ. Дунд хурууг ологч тэдгээрээс нэг хурууг заагаад олж чадвал олсон хуруугаа барьж зугаа үгсээ харилцан хэлэлцдэг байна.

Хомхой хуруу барьж тоглоход зүүн гарын чигчий хуруун дээр баруун гарын чигчий хурууг өндгөөр нь тохож тавиад дараа нь зүүн гарын дунд, ядам хуруунууд дээр мөн баруун гарын дунд, ядам хоёр хурууг давхарлан тавьж эцэст нь зүүн гарын эрхий долоовор хоёрыг баруун гарын долоовортой өндгөөр нь нарийхан мод чимхэж уулзуулна. Ингээд хомхой хуруу баригч хүн зүүн гарын эрхий долоовор хоёрын хоорондох зайнаас (хаалга гэнэ):

Гал авъя гэхэд нөгөө хүн нь хар буур хавшаад хөөнө гэнэ. Ингэхлээр хомхой хуруу баригч хүн хоёр дахь нүхнээс:

Хужир авъя гэхэд эмгэн хэдрэгээ бариад элдэнэ гэж хэлнэ. Дараа нь гурав дахь нүхийг зааж:

Давс авъя гэхэд хар нохой хуцаад хөөнө гэх мэтээр цааргалж зугаа үгс харилцан хэлэлцдэг.

Хөдөлгөөнт тоглоом. Цагаан тэмээцэх, чоно тарвагацах, цагаан мод хаях, буур ботгон болох зэрэг олон төрлийн тоглоом бий. Үүнээс нийт монгол даяар хамгийн их дэлгэрсэн нь *цагаан мод хаях* тоглоом юм. Цагаан мод хаях тоглоомыг халхад цүү хаях, шүүр шидэх, барга буриадад шур шидэх гэж нэрлэдэг. Цагаан мод хаях хугацаа, дэг ёс нарийн юм. Малын үхэл гарсан үед үхлийн эзнийг айлгах, хотондоо ирүүлэхгүй гэж шөнө дөл болтол олон хүн мал удаан үймэлдэж үхсэн малынхаа ястай шийрийг гэр хотон дээгүүрээ шидэж хоттой малаа үргээдэг байгаад хожим нь цагаан мод хаядаг тоглоом болж домын утга чанараа алдаж залуучуудын хүч тамирын цэнгээнт тоглоом болж уламжлагджээ.

Цагаан тэмээцэх. Олон хүмүүс гар гараасаа барилцан дугуйран зогсоцгоож хүрээн дотор нэг хүнийг (цагаан тэмээ) оруулж түүнийг барих ёстой хүнийг хүрээний гадна зогсоодог. Тэгээд "чагттай, ногттой, буйлтай, ээзн цагаан буурыг тавилаа" гэхтэй зэрэг хүрээн доторхи хүнийг (тэмээг) барихаар гаднаас дайрч хөөцөлдөхөд дугуйрч зогссон хүмүүс тэмээ барихаар яваа хүнийг хашиж хаах маягаар тоглоцгоодог.

Гэр барих тоглоом. Гэр барих тоглоом бол XIX зууны үеэс монголд дэлгэрсэн бөгөөд даалууны төрлийн тоглоом юм. Жил, хорол, өлзий, тахил гэх мэт олон төрөл байдаг. Эдгээр тоглоомуудаас жишээ болгож хоролын тухай өгүүлье.

Хорол бол 100 гаруй жилийн түүхтэй тоглоом юм. Хоролыг анх зохиохдоо 12 жил дээр дөрвөн төрлийн мод нэмж бүгд 64 мод болгосон байна. Зүүн аймгийнхан хоролыг "амар баясгалан" гэж нэрлэдэг. Зарим нутагт "зэндмэнэ" ч гэнэ. Хоролыг ахлах модноос нь эхлэн жагсаавал: гарын модонд хорол, зэндмэнэ, хангарьд, арслан,

газрын мод нь хулгана, үхэр, бар, туулай, луу, могой, морь, хонь, бич, тахиа, нохой, гахай. Эдгээр мод тус бүр дөрөв дөрөв байна. Хоролын өөр нэг хувилбарт гарын мод нь зэндмэнэ, хас, хангарьд, газрын мод нь 12 жил, харин нохой, гахай тус бүр 2 бүгд 60 мод байжээ.

Хоролоор тоглох явдал бараг аймаг бүхэнд ялгаатай. Архангайд хорол, зэндмэнэ, хангарьд, хасын дараагаар хулганаар эхэлсэн 12 жилийн амьтдаар нэгийг нөгөөгөөр ахлуулан идэж тоглодог. Дундговьд эдгээр модны дараа үхрээр эхэлсэн 12 жилээр тоглодог гэх мэт олон янз байна. Лам нар харин модыг олон болгож дүг, бадам, жанцан, дун нэмж тоглож байжээ. Эдгээр тоглоомуудаас гадна хөзөр, үйчүүр, төгс жаргал, тахил гэх мэт зурагт тоглоомоор наадаж иржээ.

Хөлөгт тоглоомууд (МҮТМ)

Хорол тоглоомууд (МҮТМ)

Үүчүүр. Үүчүүрийг шоо хаяж тоглох ба цагаан сарын шинийн нэгэнд тоглодог ихэд хүндтэй тоглоом юм. Шинийн нэгэнд үүчүүр тоглоод хоёр тал тэнцвэл гурван жилээ даалаа гэж ихэд бэлэгшээдэг ба гурван жил тэр үүчүүрээ тоглолгүй хадгалж гурван жилийн дараа тоглосон хүмүүс дахин цуглаж хайнаа хагалдаг. Үүчүүрийг 7х10 см-ийн чанартай цаасан дээр бэх, түшээр зурж будгаар будаж 6 ширхэг шоотой тоглоно. Үүчүүрийг тоглохдоо хүн сондгойрвол дутуу тал нь бэлэг дэмбэрэлтэй нэр өгч нэг хүн төлөөлж орхино. Дүрсийг лангаар үнэлнэ. Шооны нүд болгон нь урам зориг, хийморь бэлгэдлийг илэрхийлдэг ба улайлганы амьтдаас бусад бүх дүрснээс нэг нэгийг авч тоглоно. Энэ тусгалд тан гэж дахин нэг удаа орхидог.

Үүчүүр
(МҮТМ)

Харцага, туулай дэгдэх. Харцага туулай дэгдээд аз хийморьтойд тооцож харцага барьж дэгд дэгд гэж хоосон буутал орхино. Хэрэв сангийн хогшил дуусвал байгаа дүрснээс лан бодож авна. Ямар нэг дүрс дуусссан үед тэр дүрс буувал байгаа дүрснээс лан бодож авна. Жишээ нь нохой дуусссан үед нохой буувал 12 шувуу, эсвэл 6 туулай, эсвэл 4 хүдэр, эсвэл 1 буга, 2 туулай гэхчлэн авна.

Улайлгах. Сангийн хогшил дуусаад ирвэс, бар, хангарьд, арслан үлдэхэд бичсэн дарааллаар улайлгаж авна. Улайлгах нь ирвэсийг 2 орхиж бар, хангарьд, арсланг гурав орхиж нийлбэр улаан хонхороор бодож авдаг. Олон хүн тоглоход улайлгыг 2 тал салаавчилж орхино. Цөөхөн хүн тоглоход 2 тал нар зөв тойрч орхино.

Оньсон тоглоом. Монголчуудын модоор урласан оньсон тоглоомын хийц, тоглох арга тун гайхамшигтай. Оньсоор тоглох тоглоомыг том, жижиг янз бүрийн хэмжээ, хийцтэй урлаж гогцоо тайлах, эвлүүлэх, сүлжих зэрэг уран аргаар сэтгэж эвлүүлэн наадаг нь сэтгэн бодох чадварыг дээд зэргээр хөгжүүлэх ач холбогдолтой байдаг.

Оньсон тоглоом
(МҮТМ)

Нум сум харвах, бөх барилдах, морь уралдах. Монголчуудын уламжилж ирсэн соёлын өвийн нэг хэсэг эрийн гурван наадам нь дээр өгүүлсэн баяр цэнгэлийг бодвол нийгмийн шинж чанараар ялгаатай бөгөөд бөх, сур, морь уралдах үндсэн гурван төрөлтэй. Эрийн гурван наадмын үүсэл нь эртний үед хамаарах бөгөөд улам бүр боловсорсоор иржээ. Долоо хошуу наадам, Богдод мандал өргөх даншиг наадам гэж хийдэг байгаад эдүгээ улс хувьсгалын ойн баяр болгон эрийн гурван наадмыг тэмдэглэдэг болжээ.

Нум сум харвах. Монголчууд нум сум харвах талаар нэн эртний уламжлалтай улс билээ. Нум сум нь эрт дээр овгийн байгууллын үед ан агнуурын буюу хөдөлмөрийн багаж зэвсэг, дараа нь цэрэг дайны зэр зэвсэг, сүүлийн үед холч мэргэнээ сорих наадмын нэгэн төрөл болж иржээ. Нум сум харвах тэмцээнийг Хүннүгийн үед хамгийн хол харвасныг нь шалгаруулан явуулдаг байжээ. Үүнийг "зэв нүүлгэх" наадам гэдэг байв. Түүнчлэн арьсан бөмбөгийг модонд цувруулан өлгөж морины эрч хурдаар давхих үед бөмбөгийг харваж онох, хонины буюу үхрийн арьс модонд тэлж татаад дөчин нумын газраас хорин сум цуваа харвуулан оноог шалгаруулдаг сарампай харвах зэрэг олон янзын хэлбэрээр хөгжиж иржээ.

Сурын харваа

Д.Дамдинсүрэн "Наадам" (ДУМ)

Бөх барилдах. Эрийн гурван наадмын зонхилох суурийг бөхийн барилдаан эзэлдэг. Бөхчүүд цолны эрэмбэ дараагаар эхэлж ам уггуулаа сонгодог заншилтай. Бөхийн засуулууд нь барилдааны олон төрлийн мэх аргыг сайн мэддэг туршлагатай уран цэцэн, далд утгаар бөхдөө зөвлөж чадах цээл сайхан хоолойтой цол дууддаг хариуцлагатай хүн байдаг. Хөлийн цэц бөхийн дэвжээний өмнө талд байрлана. Монголчуудын бөхийн барилдааны журам нь бие өвдөгийг газар хүргэвэл хаясанд тооцдог. Монгол бөхийн онцлог нь нас, биеийн жин харгалзахгүй барилддаг бөгөөд дуртай барьцнаасаа барьдаг. Бөхийн дэвэлт нь харцага, шонхор, начин болон хангарьдын гараа, дэвэлт, шавалтыг дуурайлган бөхийн сүр хүчийг илтгэн дуурайсан хөдөлгөөн хийдэг. Дэвэлт нь бага, дунд, хангал, их гэж ялгадаг. Харцага шонхорын дэвэлтээс начны дэвэлт хүртэлх дэвэлтийг дунд дэвэлт, начны дэвэлтээс дөрөвт үлдэх хүртэлх дэвэлтийг хангал дэвэлт, түүнээс дээших дэвэлтийг их дэвэлт гэдэг. Бөхийн наадамд хоцорч ирсэн монгол хүн бөхчүүдийн дэвэлтийг хараад хэд дэхь даваа буюу хэдээс дээш үлдсэн бөхчүүд барилдаж байгааг асуултгүй мэддэг байжээ. Барилдаад давсан бөх нь дэвэн гурвантаа ёслоод унасан бөх дээр ирж тахим авна. Наадамд таваас дээш давсан бөхөд цол олгодог. Тав давбал начин, долоо давбал заан, түрүүлбэл арслан, аварга гэж дэс дараатай цол олгодог. Эдгээр амжилтаа давтвал чимэг нэмж өгнө. Начинд идэр, үнэн хүчит, хичээнгүй, нягт, заанд бол харилтгүй нэмэх, бат жавхлант, маш гайхамшигт, арсланд онц хүчит, өнөд нэмэх, өрнөн дэлгэрэх, аваргад олныг баясгагч, улс даяар дуурсагдах, далай даян, дархан аварга гэх мэт чимгийг нэмдэг нь цолны хүч чадлыг илтгэнэ.

Бөхийн барилдаан

Хурдан морины уралдаан

Морь уралдах. Монголчууд хурдан морьдыг уяж сойх маш нарийн журамтай байжээ. Морь уяхад юуны түрүүн газрын зай, өвс усыг тохируулах, үсэргэх, хөлөргөх, унах хүүхдийн нас жин, эмээл зэргийг чанд тохируулдаг. XX зууны хоёрдугаар хагас хүртэл их нас, соёолон, хязаалан насны морь уралдуулдаг байснаа нэлээд хожим азарга, шүдлэн, жороо морь нэмж уралдуулах болжээ. Морины нас бүрээс тэргүүн таван морийг айргийн тав хэмээж цолыг нь дуудаж унасан хүүхдэд айраг, боорцог хүртээж морины толгой, биеийг айргаар мялаана. Морины цолны эхэнд хаанахын хэний адуун сүргийн унага болохыг тодорхойлно. Дааганы уралдаанд сүүлдэж ирсэн даагыг "баян ходоод" гэж өхөөрдөн цоллож айргийн тавд ирсэн морины бай өгдөг нь угтаа энэ жилийн наадмын сүүл, ирэх жилийн наадмын түрүү магнай гэж бэлэгшээсэн хэрэг юм.

Б.Бадам-Оюу
С.Уранбилэг

БҮЛЭГ V

- ТЕАТРЫН УРЛАГ
- ДУУ, ХӨГЖИМ
- БҮЖГИЙН УРЛАГ
- КИНО УРЛАГ
- ЦИРКИЙН УРЛАГ

ТЕАТРЫН УРЛАГ

Дэлхий дахины театрын хөгжлийн замналаас үзэхэд театрын урлаг нь үзүүлбэр, үзвэр, хамтлагийн тоглолт, үзэгчид нэгэн үндсэн тогтолцоотой болох нь тодорхой байна. Монголын театр ч тийм тогтолцоог тойрч гарсангүй.

Монголын театрын урлаг нь синкретизмын буюу нийлмэл хэлбэртэй байсан үзүүлбэрээс уран сайхны тодорхой хэмжээний боловсруулалт бүхий үзвэрт аажимдаа шилжин хамтлагийн тоглолт болтлоо төгөлдөржин хөгжсөөр өнөөгийн оргил хэлбэртээ хүрсэн юм.

Монголын театрын эртний уламжлал

Монголын театрын анхдагч илэрхийлэл нь жүжигчин, дуучин, хөгжимчин, бүжигчин зэрэг мэргэжлийн нарийн ялгаа гараагүй нийлмэл байдалд байсан биеэр үйлдэн тоглох үзүүлбэр юм. Монголчууд биеэр үйлдэж тоглох урлагийн өнө эртний уламжлалтай ард түмэн билээ.

Судлаачдын мэдээллээс үзэхэд биеэр үйлдэн тоглох үзүүлбэр МЭӨ II зууны үед Хүннү нарын дунд байсан бөгөөд тэд нар найр наадам хийхдээ дуу дуулж, хөгжим тоглож, бүжиг бүжиглэж байсан байна. Хүннүгийн ор суурийг аргын тооллын I зууны үед залган авсан Сяньби нар "төрийн хэлний жинхэнэ дуу", "Төрийн хэлний эзний дуу" хэмээх хоёр номтой байсан мэдээ буй.

Монголчуудын соёлд ихээхэн нөлөө үзүүлсэн Уйгур нар дуу, хөгжим, бүжгийн явдлыг хөгжүүлж байжээ. Энэ тухайд БНМАУ-ын түүхэнд дурдахдаа: Уйгарууд бүжиглэх найр наадам хийх дуртай бөгөөд тэдний дунд дуу хөгжим их дэлгэрсэн байв гэжээ.

Дээр өгүүлсэн жишээ баримтууд нь монгол газар монголчуудын театрын урлагийн анхдагч илэрхийлэл болох биеэр үйлдэн тоглох үзүүлбэр, эрт дээр үеэс эхлэн нэлээдгүй хөгжиж байсныг гэрчилж байна. Иймэрхүү үзүүлбэр нь аажимдаа үзвэрийн шинж чанартай хэлбэрт шилжжээ. Тухайлбал:

Марко Пологийн (1257-1324) бичсэн "Орчлонгийн элдэв сонин" номд Хубилай хааны ордонд олон алиалагч ба бүжигчин ирж эрдэм чадлыг үзүүлдэг байсан гэж дурджээ. Энэхүү баримтаас үзэхэд монголын их хааны ордны дэргэд уран сайхны томоохон хэсэг байсан бөгөөд түүний тоглолт тодорхой хүрээний хүмүүст зориулсан үзвэрийн шинж чанартай байжээ. Хубилай хаан хөгжмийн хэргийг онцгойлон анхаарч хөгжүүлж хөгжмийг хаан төрийн ёслолд хэрэглэж байхыг зарилагдаж байжээ. Юань гүрний үед бүжиг наадам, ший жүжгийн хэргийг анхаарч үзэж, хөгжүүлснээр тэр нь урдаас бэлтгэж боловсруулсан үзвэрийн хэлбэртэй болжээ.

Монголчуудын уламжлалт театрын урлагийн хөгжил нь ард түмний дунд олон зуун жилийн турш бүрэлдэн тогтож уламжлан хөгжиж ирсэн ардын урлагтай салшгүй холбоотой билээ. Үндэсний театр хэлбэржин тогтох явцад нүүдэлчдийн соёл иргэншлийн нөхцөлд нэн тохирсон монголчуудын ардын урлагийн төрөл зүйл болох үлгэрч, туульч, ерөөлч, магтаалчдын нэг хүний театр, ардын харилцаа дууны бичил театр чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Олон зуун жилийн түүхэн уламжлалтай ардын туульч, үлгэрч, ерөөлч, магтаалчдын урлаг нь биеэр үйлдэн тоглодог үзвэрийн төрөл зүйлд хамрагдах бөгөөд хайлан хүүрнэж буй магтаал, туулийнхаа утга санааг сонсогч олонд ойлгомжтой, тод томруун хүргэхийн тулд уран чадварлаг тоглолт, дүрслэн бодолт, дүрд хувирах чадвар, дүрийн зураглалыг гаргах гол хэрэглүүр болох нүүрний болон сэтгэлийн хөдөлгөөн зэрэг тайзны урлагийн уран сайхны дүрслэн илэрхийлэх арга хэрэглүүрүүдийг чадварлаг ашигладаг байна. Жишээлэхэд 1930-аад оны үед

Бөмбөгөр ногоон театр (1930-аад он)

манай оронд ажиллаж байсан оросын хөгжим судлаач П.Берлинский ардын ерөөлч, туульч Ө.Лувсан хуурчийн тухай номондоо үлгэрч, хуурчдын урлагийн уран сайхны онцлогийг тодорхойлохдоо "Тэд нар цөөн хүнтэй бяцхан байранд үлгэрээ театрчлан жүжиглэдэг байсан бөгөөд үүнд жүжигчний уран чадварын өндөр төлвийг эзэмшсэн байдаг байлаа. Тэд зохион бодолт өргөн, сэтгэлийн хөдөлгөөн өндөр, өөр өөр дүрд хувилах арга нь чадмаг байсан юм" хэмээсэн бий.

Ө.Лувсан хуурч
(1885-1943)

Их эрдэмтэн Ц.Дамдинсүрэн ардын эдгээр уран авъяастнуудаас нийгмийн амьдралд гүйцэтгэж байсан үүргийг тодорхойлохдоо, үлгэрч, хуурч нар монгол оронд үзэх жүжиг, сонсох хөгжим, унших ном гурвуулангийн үүргийг гүйцэтгэж байсан хэмээн тэмдэглэсэн байдаг.

Монгол ардын аман зохиолын арвин баялаг өв сангийн охь дээж бол тууль юм. Түүнийг хүүрнэж, хайлж, сонсогч олон түмэнд хүргэж байдаг туульч нар бол театрын урлагийн олон талт хөдөлмөрийг өөртөө шингээсэн жүжигчин хүн юм. Туульч хүн хүүрнэн хайлж буй туулийн үгийг зөвхөн цээжлэн, давтан өгүүлэгч хараахан биш бөгөөд туулиа амилуулахын тулд биеэр үйлдэн хайлах урлагийн уран сайхан дүрслэн илэрхийлэх арга хэрэглүүрүүдийг амжилттай хослуулан хэрэглэж чаддаг, ардын дундаас төрж гарсан уран авъяаст жүжигчин даруй мөн. Туульч, үлгэрч, ерөөлч, магтаалчдын урлагт театрын урлагийн уран сайхан өвөрмөц онцлог болох нийтлэг шинж чанар илэрч байгаа юм. Тэдний урлагт жүжигчин, дуучин, хөгжимчин, хөгжмийн зохиолч, найруулагч, зураач зэрэг уран бүтээлчдийн хөдөлмөр нэгдэн шингэжээ.

Туульч, үлгэрч, ерөөлч, магтаалч нар тоглолтод ардын хөгжмийн хөг аялгуут өргөн ашиглахын хамт үзүүлбэртээ хэрэглэх ая дуу, хөгжмөө өөрсдөө зохиодог байна. Жишээлэхэд алдарт Ө.Лувсан хуурч тууль хайлан хүүрнэхдээ нэг удаад нэг зуун далан янзын ая ашигладаг байжээ. Үүнээс үзэхэд, ардын тэдгээр уран авъяастнууд тоглолтдоо хөгжмийн ая эгшгийг чадварлагаар ашигладаг нэг ёсны авъяас төгөлдөр хөгжмийн зохиолчид, хөгжимчид ажээ. Тэд тоглолтынхоо арга маяг, нүүрний болон сэтгэлийн хөдөлгөөн тэргүүтнийг сонгон авч найруулгажуулдаг, нэг ёсны өөрийн тоглолтын найруулагч юм.

Туульч, үлгэрч, ерөөлч, магтаалч нар тоглолтоо уран сайхан, намбалаг, үзэгч сонсогчдод сонирхолтой болгохын тул ёслол төгөлдөр хувцас хунар тааруулан өмсөх, морь амьтны дүрсийг хүүхэлдэйн адил утсан татлагаар хөдөлгөөн оруулан ашиглах зэргээр чимэг оруулан баяжуулдагаараа тэд өөрсдийн тоглолтын зураач болж байгаа юм.

Энэ бүхнээс үзэхэд туульч, ерөөлч, үлгэрч, магтаалчдын урлаг нь театрын урлагийн нийтлэг шинжийг нэгэнт агуулж байгаа нь илэрхий.

Нүүдэлчин монголчуудын бүтээн буй болгосон соёлын нэгэн гайхамшигт дээж бол ардын харилцаа дууны бичил театр юм.

Харилцаа дуу маш эртний гаралтай байна. Харилцаа дууны гарал үүсэл XIII зуунд хамрагдаж байна.

Монгол ардын харилцаа дууны сэдэв, агуулга өргөн хүрээтэй байгаа билээ.

Монгол ардын харилцаа дууг цогцлуулан бүтээгч "Тулгын гурван чулуу" нь үг, ая, дуучин (жүжигчин) юм. Харилцаа дуунд уран үг, дуу хөгжим, жүжигчний урлаг гэсэн бие даасан гурван үндсэн төрөл зүйлийн зохист нэгдлийн үр дүн шингэжээ. Монгол ардын харилцаа дуун нь зохиомж, хэлбэр, бүтцийн хувьд өөр өөрийн үзэл бодол, хүсэл эрмэлзэл бүхий тодорхой зураглалтай дүрүүд бүхий бичил жүжгийн зохиол юм. Ардын харилцаа дуунд драмын зохиолын бүтвэрийн үндсэн махбод болох үйл явдлын эхлэл, өрнөл, оргил, тайлал бүгд байгаагийн дээр тодорхой дүр, үйл явдал, үйлдлийг дүрслэн гаргадаг болно.

С.Буяннэмэх "Харанхуй засаг" жүжгийн хэсгээс
(1933 он)

Харилцаа дуу нь ардын драмын жүжгийн нэгэн өвөрмөц хэлбэр юм. Драмын урлаг дахь дүрслэлийн өвөрмөц чанар нь зөрчил, зөрчилдөөн дэх хүмүүсийн үйлдэл байдаг, ардын харилцаа дуунд дүрслэгдэх баатрууд үйлдэгч нар мөн.

Ардын харилцаа дууны уламжлал нь манай орны орчин цагийн үндэсний театрын урлаг үүсч бүй болох түүхэн явцад чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Учир нь чухамхүү харилцаа дууны уламжлал, хэлбэр ая дээр үндэслэн 1920-1930-аад оны үеийн монголын театр Д.Нацагдоржийн "Учиртай гурван толгой", Ш.Аюушийн "Хатан Долгор, харц Дамдин", "Говийн хүүхэн Гүндэгмаа" зэрэг дуулалт жүжгүүд зохиогдсон байна.

Монголын уламжлалт театр

Хорьдугаар зуун эхлэх зааг дээр манай оронд ордны шинж чанартай, хагас мэргэжлийн театр ажиллаж байв. Энэ бол 1830-1919 оны үед хуучин Говь Мэргэн вангийн хошуу, одоогийн Дорноговь аймгийн нутагт говийн догшин ноён хутагт Д.Данзанравжаагийн өргөөнд "Саран хөхөө" дуулалт жүжиг тоглож байсан явдал юм. Энэхүү театр нь тоглолт хийхэд зориулсан хоёр давхар байртай, тоглолтод хэрэглэдэг тусгай хувцас, тайз засал, дуу-чимээний хэрэглүүрүүд (бороо, цас орох, салхи тавих, аянга цахилгаан цахих мэтийг дүрсэлдэг) бүхий байв. Тоглолтын үргэлжлэх хугацаа нь жүжгийг бүтнээр тогловол нэг сар, гүйлгэж (товчилж) тогловол 3-15 хоног суурин тоглолт хийхийн зэрэгцээгээр нүүдэллэн тоглодог театр байжээ. Жишээлэхэд, одоогийн Өмнөговь аймгийн нутагт байсан Цагаан толгойн хийдэд нүүдлийн тоглолт хийхэд 40 жүжигчин, 60 тэмээ ачаатай очиж байсан гэдэг мэдээ бий. Жүжгийг жилд нэг удаа тоглодог, театрын тоглолтод дуучин, хөгжимчин, бүжигчин, ерөөлч, хуурч зэрэг нийт наяад хүн оролцдог байсны дотор гучаад нь хөгжимчид байсан байна. Бараг наяад жил тоглолтоо хийсэн энэхүү театр XIX зуунаас XX зууны эх гэхэд манай оронд театрын үзвэрийн зүйл нилээд өндөр түвшинд хөгжиж байсны нэг гэрч болж байгаа юм.

Хоёр зууны заагт дээр манай орны алс хязгаар нутгуудад театрчилсан хэлбэрийн тоглолтууд нилээд хийгдэж байжээ. Тухайлбал: XIX зууны үед Сэцэн хан аймгийн хошуу (Одоогийн Дорнод аймгийн Халх гол сум) захирсан ноёд, түүхэнд То ван хэмээн алдаршсан Бат-Очирын Тогтохтөрийн өргөөнд түүний санаачилсан "Хөгийн найман багачуудын дэг" хэмээх нэртэй бүжиг, дуу, хөгжим бүхий театрчилсан тоглолт хийдэг байжээ. Энэхүү тоглолтын бүрэлдэхүүнд 8 хөгжимчин, 8 бүжигчин оролцдог, "Үлэмжиийн чанар", "Асарын өндөр", "Ач төгс" зэрэг дуу дуулж, бүжиглэдэг байсан байна.

Мөн халхын Засагт хан аймгийн Ханхөхийн уулын хошуу одоогийн Увс аймгийн Өндөрхангай, Цагаанхайрхан сум ноён Лувсандондовын хошууны наадам дээр "өвгөн шувуу хоёр" харилцаа дууг театрчилсан тоглолтын хэлбэрээр дуулж наадаг байжээ. Үүнд тусгай зассан тавцан дээр хуурч сууж нэр бүхий дууг дуулж эхлэхийн хамт, цагаан хунг дүрсэлсэн хувцас бүхий эмэгтэй гарч ирж бүжиглэх бөгөөд энэ тоглолтын үед цэнхэр өнгийн хувцас бүхий зургаан эмэгтэй бас тоглолтод оролцдог байжээ. Драмын урлаг дахь дүрслэлийн өвөрмөц чанар нь зөрчил, зөрчилдөөн дэх хүмүүсийн үйлдэл байдаг, ардын харилцаа дуунд дүрслэгдэх баатрууд үйлдэгч нар юм.

Энэ мэтээр XIX зууны эцэс, XX зууны эхээр Монголын зах хязгаар нутгийн хаад, ноёдын ордонд бүжиг наадам, дуу, хөгжим оролцсон театрчилсан хэлбэрийн тоглолтууд хийж байсан байна.

Орчин цагийн монголын театр

1921 оны хувьсгалын эхний 10 жилд монголын театр сайн дурын буюу сонирхогчдын театр байснаа улмаар мэргэжлийн театр болон хөгжсөн юм.

Бүр 1921 онд цэргийн газарт ший жүжгийн анхны бүлгэм байгуулагдсан байна. Тэрхүү бүлгэмд Ч.Лувсансодном, Ч.Раднаабазар, Г.Сундуй, С.Буяннэмэх зэрэг хорь шахам хүн оролцож монгол ардын харилцаа дуун дээр түшиглэж зохиосон "Сумъяа ноён" дуулалт жүжиг, мөн баатарлаг туульсын сэдэвт Гэсэрийн тууж"-ийн Нандулам хааны хэсгээр зохиомжилсон жүжиг зэргийг тоглож байжээ.

Үүний дараа 1922 онд хувьсгалт залуучуудын эвлэлийн түр цагийн төв хорооноос сэдэн санаачилсан үндсэн дээр "Бүх монголын хувьсгалт залуучуудын эвлэлийн жүжгийн хүрээлэн" нэртэй жүжгийн бүлгэм байгуулсан юм. Тэрхүү бүлгэмийн үйл ажиллагаанд шинэ цагийн урлагийн анхны зүтгэлтнүүд болох Ч.Лувсансодном, Ц.Гомбожав, Д.Нацагдорж, С.Буяннэмэх, Л.Дамдинбазар, Д.Ичинхорлоо, Д.Ишдулам, Ц.Амгалан зэрэг хүмүүс идэвхийлэн оролцжээ. Энэхүү бүлгэмийн анхны томоохон бүтээл нь С.Буяннэмэхийн "Ойрхи цагийн товч түүх" хэмээх жүжиг байлаа.

Нэр бүхий бүлгэмийнхэн монгол ардын аман зохиолын сэдвээр "Бэлэн сэнгэ", "Мянган Ёндон", мөн орчин цагийнхаа сэдвийг тусган

Э.Оюун "Амарсанаа" жүжгийн хэсгээс (1944 он)

У.Шекспир "Отелло" жүжгийн хэсэгээс (1978 он)

харуулахыг эрмэлзсэн жүжиг, үзэгдлүүд тоглож байжээ. Ший жүжгийн хэргийг цаашид бэхжүүлэх зорилгоор Улаанбаатар хотод 1924 онд Д.Сүхбаатарын нэрэмжит клуб, 1926 онд Ардын цэнгэлдэх хүрээлэнг байгуулж, театрын тоглолт хийх зориулалттай "Бөмбөгөр ногоон" хэмээн алдаршсан шинэ барилга барьж ашиглалтад оруулсан нь хувьсгалын эхний жилүүдийн урлагийн амьдралд гарсан томоохон үйл явдал болжээ.

Ардын цэнгэлдэх хүрээлэн нь С.Буяннэмэхийн "Марал шар", Ц.Гомбожавын "Өнчин хүү", Л.Дамдинбазарын "Түлээчин хүү" зэрэг жүжиг тоглож байжээ.

Ийнхүү хувьсгалын эхэн үед театрын сайн дурын хэд хэдэн хамтлаг байгуулагдан ажиллаж байсан нь жүжиг жүжиглэхүйг шинэ нөхцөл байдалд хөгжүүлэх үндэс суурийг тавьж, жүжгийн бүлгэм дугуйланд оролцогчдыг жүжиглэхүйн ухаанд сургах, авьяас бүхий нөхдөөс жүжгийн зохиол туурвин бүтээхэд хүчээ сорих, театр, жүжгийн хэргийг зохион байгуулах дадлага сургуультай болгох зэрэг эхлэлүүдийг тавьж өгсөн байна.

Монголын театрын урлагийн хөгжил 1930-аад онд шинэ хэлбэр байдалд шилжиж, Монгол оронд анх удаа мэргэжлийн театр байгуулагдсан онцлогтой. Энэ үйл хэрэгт Ардын цэнгэлдэх хүрээлэнгийн дэргэд 1929 онд Зөвлөлт Оросоос уригдан ирсэн мэргэжилтэн, найруулагч А.Ефремовын удирдлагаар байгуулагдсан театрын студи-сургууль чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Л.Намхайцэрэн "Оролмаа" жүжгийн тайз (1978 он)

Театрын студи-сургуульд суралцагсад энэ үед С.Буяннэмэхийн "Үнэн", "Арван жил", "Усгүй хар архи". Ц.Гомбожав, Ё.Шаравдоо нарын "Мопр" зэрэг жүжиг тоглосон нь амжилттай болжээ.

Театрын студи-сургуулийн сургалт амжилттай болж, улмаар 1931 оны 10 дугаар сард "Ардын цэнгэлдэх хүрээлэн"-г "Улсын төв театр" болгон өргөтгөн зохион байгуулжээ. Мэргэжлийн анхны театр байгуулагдан хөгжсөн 1930-аад он бол манай орны тайзны урлагийн үйлдийн хувьд уран бүтээлийн идэвхтэй эрэл хайгуулын жилүүд байлаа. Энэ жилүүдэд монголын театрын уран бүтээлийн түүхэнд олон чухал үйл явдал болов. Тухайлбал: Монгол Улсын Төв Театр 1933 онд Москва хотод болсон олон улсын хувьсгалт театруудын олимпиад хэмээх их наадамд С.Буяннэмэхийн "Харанхуй засаг" жүжиг тоглож үзүүлсэн нь амжилттай болжээ. "Харанхуй засаг" жүжиг орчин цагийн монголын мэргэжлийн театрын урын сан дахь драмчлагдсан жүжиглэлийн дээж бүтээл болон үндэсний театрын түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.

Энэ жилүүдэд Д.Нацагдоржийн "Учиртай гурван толгой" (1934), Ш.Аюушийн "Хатан Долгор, харц Дамдин" (1935) зэрэг дуулалт жүжгүүд тоглогджээ.

Үндэсний театрын хөгжлийн дараачийн үе шат бол үндэсний мэргэжлийн театрууд шинээр байгуулагдан өргөжиж, мэргэжлийн жүжигчдийн залуу халаас эх орондоо бэлтгэн, театрын урлагийн төрөл зүйлийн хүрээ нэмэгдэн, тоглолтын уран сайхны түвшин мэдэгдэхүйц

Л.Гаваа "Учиртай гурван толгой" дуурийн хувцас (1976 он)

Д.Намдаг "Шарай голын гурван хаан" (1941 он)

дээшилж, театруудын тоглолтын урын сан илт баяжиж арвижсан 1950-70-аад оны үе юм.

Монголын театр дэлхийн II дайны жилүүдэд хэсэг зохиолчдын хувьсгал, түүхийн сэдэвт "Талын баатар"(1943), "Хатанбаатар Магсаржав" (1943), "Амарсанаа" (1944), "Ах дүү нар" (1945) зэрэг бүтээл зохион тогложээ.

Ч.Дододамба "Гарын таван хуруу" (1967 он)

Дайн дууссан энх цагийн бүтээн байгуулалтын үе эхлэхийн хамт театрын урын сангийн чиглэлд зохих өөрчлөлт гарч, 1946-1960-аад онуудад Ч.Ойдовын "Зам" (1947), "Далан худалч" (1948), Л.Ванганы "Эмч нар" (1953), "Тожоо жолооч" (1954) зэрэг жүжиг тогложээ.

Монголын театрын хөгжилд 1950-70-аад онд хэд хэдэн томоохон өөрчлөлт гарав. Үүнд:

1.Театрын уран бүтээлийн ажлыг зохион байгуулдаг гол хүмүүс болох анхны мэргэжлийн найруулагч нар бэлтгэгдэж, Л.Ванган, С.Гэндэн, Д.Лхасүрэн, С.Галсанжав, Ц.Раднаа, Б.Жамъяандагва зэрэг хүмүүс уран бүтээлийн урт замдаа гарав.

2.Театрын тайзны зураг чимэглэлийг үйлдэх мэргэжлийн анхны зураач нартай болж Л.Гаваа, Л.Намхайцэрэн, Ц.Доржпалам, Л.Махвал, Д.Сүхбаатар зэрэг зураачид уран бүтээлийн гараагаа эхлэн, улмаар үндэсний театрын сценографийн урлагийн үндэс суурийг тавьсан байна.

3.Театрын урлагийн байгууллагын хүрээ, төрөл хэлбэр өргөжиж, хэд хэдэн шинэ театр байгуулагдав. Тухайлбал: 1947 онд Улсын төв театрыг хөгжимт драмын театр болгон өргөжүүлэн зохион байгуулсны дээр Ховд, Дорнод, Баян-Өлгий зэрэг аймагт театр байгуулагдав.

4.Энэ хугацаанд үндэсний урлагийн түүхэнд анх удаа бие даасан хөгжмийн театртай болов. Урлагийн төрөл бүрийн мэргэжлийн боловсон хүчин сургаж бэлтгэсний үр дүнд 1963 онд Улсын хөгжимт драмын театрыг Улсын драмын театр, Улсын дуурь бүжгийн театр гэсэн биеэ даасан хоёр театр болгон зохион байгуулав. Чухамхүү энэ өөрчлөлтийн үр дүнд манай орны үзэгчид У.Шекспирийн "Отелло" (1958), "Лир ван" (1964), П.Чайковскийн "Евгений Онегин" (1963), Ж.Пуччиний "Чио Чио Сан" дуурь, Л.Минкусын "Дон Кихот" (1971), Ц.Пуний "Эсмеральда" (1967) бүжгэн жүжиг зэрэг дэлхийн урлагийн их мастеруудын гандан буурштгүй суут бүтээлүүдтэй танилцах бололцоотой болсон билээ.

Б.Лхагвасүрэн "Тамгагүй төр" (1998 он)

5.Үүний хамт улс орон даяар урлагийн төрөлжсөн театрууд бий болов. Тухайлбал: 1948 онд Дорнод, 1950 онд Ховд, 1956 онд Баян-Өлгий аймагт хөгжимт драмын театр, 1951 онд Улсын хүүхдийн театр, 1948 онд Улсын хүүхэлдэйн театр тус тус байгуулагджээ.

С.Жаргалсайхан "Хаан түүх" (2001 он)

Б.Дамдинсүрэн, Б.Смирнов "Учиртай гурван толгой" дуурийн хэсгээс

бэхжиж, улмаар үндэсний театрын урлаг тогтвортой хөгжлийн замд орсон юм.

Энэ үед манай орны мэргэжлийн урлагийн байгууллагуудын хүрээ өргөжиж, бүх аймаг хөгжимт драмын театр буюу ардын дуу-бүжгийн чуулгатай болсон билээ.

Энэ жилүүдийн үндэсний театрын томоохон амжилтын нэг бол жүжгийн зохиолчдын бүхэл бүтэн эгнээтэй болсон явдал юм.

Бүр 1930-аад оны үед Д.Нацагдорж, С.Буяннэмэх, Ш.Аюуш, М.Ядамсүрэн, Д.Намдаг, 1940-1960-аад онд Б.Бааст, Ц.Цэдэнжав, Э.Оюун, Ч.Ойдов, Ч.Лодойдамба,

Улсын симфони найрал хөгжмийн тоглолтын хэсгээс

Л.Ванган, Ч.Чимид зэрэг жүжгийн зохиолчид төрөн гарч, 1970-аад оноос хойш тэдний халааг Д.Мягмар,Д.Батбаяр, Б.Нямаа, С.Жаргалсайхан, Х.Зандраабайдий зэрэг авъяастнууд залган авчээ.

Үндэсний театрын хөгжлийн энэ үед найруулга зүйн

Үндэсний театрын урлагийн хөгжлийн дараачийн үе шат тайзны урлагийн ирмүүн хөгжлийн үе болох 1980-1990 оны үе юм. Энэ үе нь үндэсний театрын урлаг урьд жилүүдийн уран бүтээлийн ололт амжилт дээр түшиглэн туурвин гаргаж буй бүтээлүүдийн уран сайхны чанар

П.И.Чайковский "Евгений Онегин" дуурийн хэсгээс

өндөр түвшинд хүрч, жигдэрсэн он жилүүд байлаа. Энэ жилүүдэд үндэсний найруулагч, жүжгийн зохиолч, удирдаач, бүжиг дэглэгч, театрын зураач гэх зэрэг уран бүтээлийн удирдах ажилтан, мөн дуучин, хөгжимчин, бүжигчин, драмын жүжигчин зэрэг гүйцэтгэх уран бүтээлчдийн эгнээ нэгэнт батжин

Д.Лувсаншарав "Хар хорум" дуурийн хэсгээс

Б.Шарав "Чингис хаан" дуурийн хэсгээс (2003 он)

урлаг батжин бэхжив. Найруулагч нарын шинэ үе өсөн өндийж өөрсдийн уран бүтээл, урлах эрдмийн өвөрмөц дүр төрх бүхий найруулагчид, Б.Мөнхдорж, Г.Доржсамбуу, И.Нямгаваа зэрэг хүмүүс уран бүтээлээ туурвиж эхэлжээ. Түүнчлэн үндэсний театрын сценографийн урлагийг баяжуулан, хөгжүүлсэн Ч.Гунгаасүх, Б.Төмөрхуяг зэрэг тайз, чимэглэлийн авъяаслаг зураачид төрөн гарчээ.

Монголын театр байгуулагдсан цагаас хойш өнгөрсөн хугацаанд жүжигчдийн хэд хэдэн үе тайзнаа ур чадвараа сорьсон байна. Театрын мэргэжлийн анхны жүжигчид 1930-аад онд чухамхүү бэлтгэгдэн гарсан нь орчин цагийн үндэсний театрын жүжигчний урлагийн эх суурь болсон билээ. Үндэсний театрын жүжигчний урлагийн дэг сургуулийн гол цөм болсон Ц.Цэгмид, Д.Ичинхорлоо, Н.Цэгмид, Д.Цэрэндулам, Ё.Шаравдоо, Ч.Долгорсүрэн, Г.Гомбосүрэн, А.Цэрэндэндэв, Ч.Цэвээн зэрэг жүжигчид энэ үеэс эхлэн театрын тайзнаа ур чадвараа сорьж эхэлсэн бөгөөд тэд 1940-1960-аад оны тайзны урлагийн гол ачааг нуруундаа үүрсэн, урлагийн "алтан үеийг" төлөөлж байв. 1960-аад оны эхэн үеэс үндэсний дуурийн болон драмын театрын жүжигчдийн залуу халаа өсөн бойжиж, Ц.Пүрэвдорж, Г.Хайдав, А.Загдсүрэн, П.Цэрэндагва, Х.Уртнасан, Ц.Гантөмөр, Л.Жамсранжав, О.Ганбаатар, Ю.Оюун, зэрэг дараа үеийн уран авъяастнууд үндэсний театрын урлагт орж ирсэн билээ.

П.И.Чайковский "Хунт нуур" бүжгийн жүжгийн хэсгээс

Өнөө үед үндэсний тайзны урлагийн уран бүтээлчид үндсэндээ шинэчлэгдэн залуужиж тайзны уран дүр туурвин бүтээх их хөдөлмөрт амжилттай оролцож байна.

Тайзны урлагийн олон үеийн уран бүтээлчдийн нөр их хөдөлмөрийн үр дүнд үндэсний жүжигчний урлагийн дэг сургууль нэгэнт бүрэлдэн тогтжээ. Тэрхүү дэг сургуулийн онцлог нь монголчуудын ардын жүжиг наадмын тоглолтын өргөлтөт, намбалаг төрх байдал болон өрнө зүгийн тайзны тоглолтын дэг сургуулийг хослуулан хэрэглэж, үг бие, сэтгэхүйн үйлдлийг хослуулан тоглож, амьдралыг бодит үндэслэлтэй үнэмшилтэй дүрслэн харуулдаг реалист арга барилтайгаараа онцлог юм. Орчин үед манай оронд драм, дуурь, балет, хүүхэлдэй гэх зэрэг дэлхийн театрын урлаг дахь тогтвортой үндсэн төрлүүд амжилттай хөгжиж байна. Түүний зэрэгцээгээр театрын урлагийн шинэ хэлбэрийн туршилт хийгдэж, улсын чанартай томоохон театруудаас гадна хувийн хэвшлийн ("Хошин урлагийн театр", Р.Чойномын нэрэмжит нэг хүний театр гэх мэт) театрын хэлбэрүүд үүсэн буй болж байна.

Л.Минкус "Дон Кихот" бүжгийн жүжгийн хэсгээс

Ж.Мэнд-Амар "Үйлийн гурван толгой" бүжгийн жүжгийн хэсгээс

Өнөөдөр манай орны мэргэжлийн театруудын урын санд өөрийн орны зохиолчдын бүтээл туурвил зонхилж буйн дээр дэлхийн уран сайхны соёлын алтан санд мөнхрөн үлдсэн сонгодог драм, дуурь, балет, хөгжмийн бүтээлүүд чухал байр эзэлж байгаа юм.

Өнөөгийн шатанд урлаг, уран бүтээлийн үйлчид ардын урлагийн үнэ цэнэтэй, дэвшилтэт бүхнийг өвлөн хөгжүүлж, нийт хүн төрөлхтний урлагийн дээжистэй зүй зохистойгоор хослуулан хөгжүүлэх чиг бодлогыг баримталж байна. Манай орны драм, дуурь, балет, хүүхэлдэй, дуу хөгжмийн аль ч хамтлаг тухай тухайн чиглэлээрээ дэлхийн дахины аль ч улс орны урлагийн байгууллагуудын урын санд буй, сонгодог болон орчин цагийн бүтээлүүдээс тоглох чадвартайн дээр дэлхийн аль ч улс оронд очиж тоглолтоо сонирхуулах бүх талын чадамжтай болсон байна. Энэ нь тэдгээр уран бүтээлчдийн ур чадварын түвшин дэлхий дахины жишигт ойртсоны илэрхийлэл болж байгаа билээ.

П.И.Чайковский "Нойрсож буй гоо бүсгүй" бүжгийн жүжгийн хэсгээс

Үндэсний театрын урлагийн өндөр хөгжлийн нэг жишээ бол манай уран бүтээлчид дэлхий дахины нэр хүнд бүхий томоохон тэмцээнүүдэд байнга оролцохболсон явдал юм. Тухайлбал: Ю.Оюун, О.Ганбаатар, Б.Норовсамбуу, Ц.Пүрэвдорж зэрэг уран бүтээлчид дэлхийн чанартай тэмцээнүүдэд удаа дараа оролцож, шагнал авч байлаа. Түүнчлэн ДБЭТ, УДЭТ, УАДБЭТ, Улсын хүүхэлдэйн театр, зарим аймгийн театрын уран бүтээлчид гадаад орнуудаар аялан тоглож, үзэгчдийн зүгээс өндөр үнэлэлт авч байдаг нь үндэсний театрын урлагийн амжилттай хөгжлийн нэгэн баталгаа болох билээ.

С.Прокофьев "Ромео, Жульета" бүжгийн жүжгийн хэсгээс

С.Цэрэндорж
Э.Амарбилиг

ДУУ, ХӨГЖИМ

XX зууны Монголын хөгжмийн соёлын салбарт олсон хамгийн том ололт бол үндэсний хөгжмийн зохиолчдын эгнээ болж төлөвшсөн явдал юм. Монголын хөгжмийн зохиолчид энэхүү дэг сургуулийг төлөвшүүлэн тогтоохдоо, нэг талаас, таван эгшигтийн тогтолцоо бүхий монгол ардын уламжлалт хөгжмийн өв, нөгөө талаас орос-зөвлөлтийн болон өрнөдийнхний сонгодог хөгжмийн зохиолчдын туурвин бүтээх арга туршлага, олон хоолойн зарчим, бичлэгийн ур зүйд тулгуурласан байна.

Уламжлалт хөгжим. Монголчуудын уламжлалт хөгжмөө туурвин бүтээж ирсэн арга, туршлага, уран сайхны сэтгэлгээний онцлог нь тэдний шууд зохиох билиг авъяасаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл тэд гэр орондоо үйл мэтгэж үр хүүхдээ бүүвэйлж суухдаа, малчны хотонд үр төлөө голсон эх малыг ая дуугаар уярааж нялх төлийг нь авахуулахдаа, байгалийн үзэмжит хүрээлэл дунд эрдэнэт мал сүргээ хариулж түүгээрээ бахархаж явахдаа, алс хол аян жин тээж замын уртыг туулахдаа, аргамагийн хурдаар амрагийн болзоог зорихдоо, ардын найр олны дунд наргиж цэнгэж дуу хөгжим, бүжиг үүсгэх үедээ, ер нь хаана бол хаана сэтгэл хөдөлж, онгодын хур буусан бол төрсөн сэтгэгдлээ дуу хуур, бүжиг биелгээ, яруу найргаар шууд л илэрхийлнэ.

Энэ бол малчин монголчуудын нүүдэллэн амьдрах, аж төрөх ёс, жилийн дөрвөн улиралд мал аж ахуйгаа эрхлэх хөдөлмөрийн онцлог, уран сайхны сэтгэлгээний арга барилтай холбоотой юм. Нүүдэлчдийн энэ ахуй орчноос монгол хөгжмийн олон төрөл үүсчээ.

Хөдөлмөрийн дуу. Үүрийн гэгээгээс үдшийн бүрий хүртлэх малчны хөдөлмөрийг хөдөлмөрийн элдэв дохио, уриа, аялга дуудлага байнга дагалддаг юм. Малчны хөдөлмөрийн аялга, уриа дуудлагыг мал аж ахуйн, ан авын гэж хоёр хэсэгт хувааж болно.

Анчдын дохио, уриа дуудлага нь зэрлэг ан амьтныг өөрийн нь хэлээр "дуудан ирүүлж" сонголт хийж агнах боломж олгодог бол таван хошуу малын холбогдолтой уриа дуудлага нь мал сүргээ бэлчээрт гаргах, хурааж хотлуулах, эдлэж хэрэглэх, сүү шимийг нь нэмэгдүүлэх, үр төлийг нь авахуулах зэрэг төрөл бүрийн зориулалтаар ашиглана.

Бүүвэйн дуу. Нялх үрээ энхрийлэн бүүвэйлж суугаа эх хүний сэтгэлийн догдлол уянгын аяар илэрч гарсныг бүүвэйн дуу гэнэ. Бүүвэйн дууны уянга бялхам ая нь хүүхдийн оюун сэтгэхүйг амраах, тайвшруулах, нойрсуулахад зориулагджээ. Бүүвэйн дууны аяыг бүүвэйн аман аялгуу, бүүвэйн дуу гэж ангилж болно. Бүүвэйн аман аялгуу нь тухайн эх хүний сэтгэлийн гүнээс урган гардаг бол бүүвэйн дуу нь эхлээд өрх гэрийн хүрээнд зохиогдож дараа нь айл саахалтын хүрээнд тархаж сүүлдээ нийт олны хүртээл болдог ажээ.

Урт, богино дуу. Монголын уламжлалт хөгжмийн хамгийн түгээмэл, хамгийн нийтлэг төрөл бол дууны уран бүтээл юм. Дууны уран бүтээлийг үүсэл хөгжлийн хувьд хөдөлмөрийн дуунаас монгол ардын сонгодог уртын дуу хүртэлх үе шатаар, үүрэг зориулалтын хувьд аж байдал зан үйлийн дуу, магтаал дуу, тууль дуу, түүхэн дуу, домогт дуу, харилцаа дуу гэх мэт төрөл зүйлээр, угсаа гарвалын хувьд халх, өөлд, торгууд, захчин, дөрвөд, урианхай, баяд, хотон, дархад, хотгойд, буриад, барга, үзэмчин гэх мэт угсаатан ястнаар, сэдэв агуулгын хувьд шог хошин, янаг амрагийн, аав ээж ахан дүүсийн, таван хошуу мал сүргийн, хурим найрын, төр шашны, хаад ноёд, ихэс дээдсийн дуу гэх мэтээр төрөлжүүлэн ангилж болно.

Уртын дуу бол манай ард түмний ардын урлагийн нэгэн гайхамшиг юм.

Үлгэр туульсын хөгжим. Монголчуудын бүтээсэн уран сайхны соёлын нэн эртний хэлбэр бол үлгэр туульсын хөгжим юм. Яруу найраг, дуу хөгжим, дуулах хөгжимдөх, жүжиглэх урлаг нэгдэн нийлсэн энэ урлагийг анчин малчны удамтай монголчуудын дундаас төрж гарсан үлгэрч туульч нар сурч эзэмшин амнаас ам, гэрээс гэрт, үеэс үед өвлүүлэн уламжилсаар өнөөгийн бидэнд өртөөчлөн авчирсан юм. Тэд хэдэн мянган шад бадгаас бүтсэн туулийг хөгжмийн зэмсэггүй хүүрнэн хэлэх, хөгжмийн зэмсэг хэрэглэн хайлан дуулах аргыг хослуулдаг ажээ. Туулийг гол төлөв өвлийн улиралд хайлна. Чухамхүү өвлийн улирал малчдад биеийн болон оюуны алжаалаа тайлж амрах боломж олддог юм. Өвгөд өтгөс өвлийн шөнийн уртад үүх түүх, үлгэр домог ярьж, тууль хайлж ертөнцийн үүсэл, хүн амьтны жаргал зовлонгийн учрыг ач гуч нартаа ухааруулж "унших ном, сонсох хөгжим, үзэх жүжиг"-ийн үүргийг зэрэг гүйцэтгэж иржээ.

Нүүдэлчдийн хөгжмийн энэ ахуйгаас "Гэсэр", "Жангар", "Хан харангуй", "Бум эрдэнэ" зэрэг хөлгөн их туульс, түүнийг өвлөн тээгч аугаа их туульчид-жангарчид төржээ.

Ардын дан хөгжмийн тоглолт

Ардын дан хөгжим. Ардын дан хөгжмийн аливаа бүтээл нь ямагт тайлбартай байдаг. Үлгэр домог юмуу бодит амьдралаас эх ундрагатай тэрхүү хөтөлбөр-тайлбар нь дан хөгжмийн зохиол төрж гарах үндэс шалтгаан болдог төдийгүй ардын хөгжимчний ургуулан бодох ухааныг өрнүүлж, туурвин бүтээх онгод сэтгэлгээгий нь урин дууддаг байна. Иим учир шалтгаанаар монгол ардын төрөл бүрийн хөгжмийн зэмсэгт зориулсан дан хөгжмийн бүтээл буй болжээ.

Ардын хөгжмийн хэсгийн тоглолт

Төв халхад морин хуурт зориулсан "Жонон хар" буюу "Жороо морины явдал "Улган шар" зэрэг аялгуу түгээмэл байдаг бол баруун монголд "Ээвийн голын урсгал", "Дөрвөн өөлдийн ураа", "Балжин хээр", "Өрөөлтэй шарга", "Яриг цагаан ингэний сариг цагаан ботго", "Бухын явдал", "Бугын урам" зэрэг икэлийн ая татлага, зүүн монголд "Могой хээр", "Харцага зээрд", "Богдын борлог", "Амар явдалт", "Говийн халтар", "Хүүхэн Цэмбэл", "Шөргийн ат" зэрэг морин хуурын татлага дэлгэр тархжээ.

Улсын драмын эрдмийн театр
Улсын ардын дуу бүжгийн чуулга

Малчин монголчууд хөгжмийн уран бүтээлээ урсгалаар бус үндсэн хоёр хэлбэрээр түгээн дэлгэрүүлж ирсэн байна. Үүний эхнийх нь гэрийн уламжлалт сургалт, нөгөөх нь ардын найр, наадам юм.

Гэрийн сургалт, багш шавийн холбоо, найр наадам. Гэрийн уламжлалт сургалт нь багш шавийн холбоогоор дамжиж хэрэгжих бөгөөд түүнд үлгэрлэн үзүүлэх, дагалдуулан сургах арга барил зонхилно. Харин найр наадамд олныг хамарсан эчнээ сургалтын хэлбэр давамгайлна.

Ийнхүү XX зууны хоёр дахь арван жил гэхэд монголчуудын бүтээсэн уламжлалт хөгжмийн баялаг өв, оюуны үнэт зүйлс, Монгол орны бүх нутаг, угсаатан ястны хүрээнд, уугуул шинж, уламжлалт урын сан, нутаг нутгийн дуулах хөгжимдөх донж маягаа хадгалан бат тогтвортой уламжлагдаж ирсэн байна.

Шинэ цагийн хөгжим. 1921 онд Монгол оронд хувьсгал ялснаар монголын нийгмийн байгуулал, улс төрийн тогтолцоонд төдийгүй уран сайхны соёлын амьдралд үндсэн эргэлт гарав. Шинэ нийгэм, шинэ үзэл санаа, хувьсгалт өөрчлөн байгуулалт монголын уламжлалт хөгжмийн урлагийг шинэ агуулга хэлбэр, төрөл-зүйлээр баяжуулав.

Шинэ цагийн хөгжим бүтээх үйл ажиллагаа шулуун дардан байсангүй. Анхны хөгжмийн зохиолчид шинэ бүтээлээ туурвихдаа, ардын уламжлалт хөгжмийн төрөл зүйлээс эшлэх, тэдгээрийн тодорхой ая нугалбарыг боловсруулж ашиглах арга барилаас бие даасан уран бүтээлч болж өсөв. Иим арга туршлагаас хөгжмийн зохиолч М.Дугаржав, Ж.Дорждагва, Л.Мөрдорж, С.Гончигсумлаа, Б.Дамдинсүрэн, Лха.Дорж, Ц.Намсрайжав, Э.Чойдог, Ж.Чулуун, Г.Бирваа, З.Хангал, Н.Жанцанноров, Ц.Нацагдорж, Б.Шарав, Х.Билэгжаргал нар төрж гарсан юм.

Дуурийн хөгжим. Хөгжмийн зохиолч С.Гончигсумлаа, Л.Мөрдорж, Б.Дамдинсүрэн нар бол шинэ цагийн нийтийн дууны гол төлөөлөгчид төдийгүй, орчин цагийн хөгжмийн театрын болон концертын урын санг буй болгоход авъяас билиг, эрдэм мэдлэг, ур чадвараа зориулж үндэсний дуурь, бүжгэн жүжиг, симфони бүтээлийн үндэс суурийг тавилцсан гавъяат үйлстэн билээ.

Б.Дамдирсүрэн, Б.Смирнов
"Учиртай гурван толгой" дуурийн хэсгээс

Билгийн Дамдинсүрэн /1919-1992/ 1942 онд ЗХУ-ын хөгжмийн мэргэжилтэн багш Борис Федорович Смирновын хамт (Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн нарын цомнол) "Учиртай гурван толгой" дуурь бичиж Улсын Хөгжимт Драмын Төв Театрын тайзнаа Д.Бат-Очирын найруулгаар тавьсан нь үндэсний дуурийн анхдагч нь болов.

Б.Дамдинсүрэн 'Учиртай гурван толгой"-гоос гадна "Жаргалын зам", "Амарсанаа", "Мартагдашгүй 42 хоног" дуурь бичсэн юм. Б.Дамдинсүрэн "Учиртай гурван толгой" дуурьтаа монголчуудын хөгжмийн ахуй сэтгэлгээнд төлөвшиж тогтсон хэлбэр, аялга хэмнэл, өнгө будгийг олж дуурийн гол баатруудаа дуун дүрээр амилуулж чадсан бол "Жаргалын зам" дуурьтаа "Өвгөн баатар"-ын "Хамаг ард биднийг" үглэл дуу (ари), Халиуны "Бодол болсон талын дээгүүр" үглэл дуу, Борын "Хөвчийн өндөр ууланд" үглэл дуу, "Амарсанаа" дуурьт Амарсанаагийн "Саруул нутгаа гэхээс" үглэл дуу, "Мартагдашгүй 42 хоног" дуурьт Хасбаатарын "Хүний хүүгийн сайныг үзнэ" үглэл дууг тус тус бүтээсэн юм. Энэ бол монголын дуурийн хөгжмийн драматургийг бүтээхэд цоо шинэ эрэл хайгуул, зоригтой туршиц болсон төдийгүй дэлхийн дуурьтай хөл нийлүүлэх анхны гараа байлаа.

Л.Мөрдорж "Хөхөө Намжил" дуурийн хэсгээс

Үүн лүгээ нэгэн адил хөгжмийн зохиолч Сэмбийн Гончигсумлаа (1915-1991) "Үнэн" (Д.Сэнгээгийн цомнол зохиол") дуурьтаа дэлхийн сонгодог дуурийн хэлбэр, зохиомжийг бүтээлчээр ашиглаж дуурийн дуулаачийн төрлийг монгол аялга хэмнэлээр амилуулж, үзэгч сонсогчдын сэтгэлд шингэсэн үглэл дуунуудыг бүтээсэн юм. Энэ бол "Үнэн" дуурийн гол баатар Гонгорын үглэл дуу, Ядмаагийн үглэл дуу байлаа.

Ийнхүү Б.Дамдинсүрэн, С.Гончигсумлаа нарын билиг авъяас, боловсрол мэдлэг, ур чадвараар монголын дуурийн хөгжимд гараагаа эхэлсэн үглэл дуу Д.Лувсаншаравын дууриар дамжин Х.Билэгжаргал, Ц.Нацагдорж нарын дуурьт төгөлдөржин боловсорсон юм.

Бүжгэн жүжгийн хөгжим. Монголд орчин цагийн бүрэн хэмжээний бүжгэн жүжгийн хөгжмийг (балет) өрнө дахины сонгодог дэг сургуульд ойртуулж бүтээх эхлэлийг манай ахмад хөгжмийн зохиолч С.Гончигсумлаа, Б.Дамдинсүрэн, Э.Чойдог нар тавьсан юм.

С.Гончигсумлаа "Ганхуяг" бүжгийн жүжгийн хэсгээс

Энэ үйлсийг С.Гончигсумлаа (балетмейстер Д.Лхасүрэнгийн дэглэлт) "Ганхуяг"-аар эхлүүлсэн билээ. Үүний дараа С.Гочигсумлаа "Хошуу наадам", "Сүнжидмаа", Б.Дамдинсүрэн "Шуурга", "Нуурын домог", Э.Чойдог "Шарилжин дундах цэцэг", "Мөнхийн найрамдал", "Мөнгөн залаа", Ж.Чулуун "Уран хас" бүжгэн жүжиг бичиж монголын бүжгэн бүжгийн хөгжмийн өгүүлэмж (драматурги)-ийг төгөлдөржүүлэхэд тус тусын хувь нэмрийг оруулсан юм.

Энэ хувь нэмрийг бүжгэн жүжгийн хөгжмийн үндсэн үзүүлэлт болох адажиогоор тодорхойлж болно. Тухайлбал С.Гончигсумлаа Ганхуяг бүжгэн жүжигтээ:

Ганхуяг, Мөнгөнтуяа нарын адажиог бичсэн бол "Хошуу наадам" бүжгэн жүжигтээ Хайдав, Чулуун нарын хоршил бүтээжээ.

Энэ эхлэл Б.Дамдинсүрэнгийн "Нуурын домог" бүжгэн жүжиг"-т Цэрмаа, Ноён хоёрын хоршлоор. Э.Чойдогийн "Шарилжин дундах цэцэг" бүжгэн жүжгийн Урангоогийн адажиогоор, Ж.Чулууны "Уран хас" бүжгэн жүжигт Хас, Хандармаа нарын хоршлоор тус тус баяжсан билээ.

Монгол симфони. Монгол улсын циркт хөгжмийн мэргэжилтнээр ажиллаж байсан С.С.Гальпериний шавь Лувсанжамбын Мөрдорж (1919-1996) ЗХУ-ын Москва

Морин хуур

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр

Монгол үндэсний хөгжмийн зэмсэг. Монголчуудын хөгжмийн зэмсгийг ардын, ордны, шашин, сүм хийдийн гэж хэд хэд ангилдаг.

Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа эхлэн хүн, байгаль, адгуус амьтны янз бүрийн дуу, чимээг дууриалган дуу авиа гаргадаг олон төрлийн хөгжмийн зэмсгийг бүтээж, улам боловсронгуй болгон хөгжүүлж иржээ.

Эрт үеэс монгол нутагт оршин суугчдын дунд хэрэглэгдэж байсан хөгжмийн зэмсэг, дуу, хөгжим, бүжгийн тухай холбогдох бичгийн сурвалж мэдээ ховор боловч тэр үеийн хүмүүсийн бүтээж хэрэглэж байсан хөгжмийн зэмсгийн талаар археологийн олдвор, хадны сүг зураг, хөгжимт аман зохиолын нэн эртний хэлбэрүүд болон бусад хэрэглэгдэхүүнээс тоймлон мэдэж болох билээ. Тус орны нутагт тохиолдох хадны сүг зургийн заримд нь дэлүүр хөгжим цохиж, нийтээрээ хөл гараа өргөн тойрон бүжиглэж, дуулж буй хүмүүсийн дүрс хадгалагдан үлджээ. Тэдгээр зурагт ан ав хийж яваа буюу

хотын П.И.Чайковскийн нэрэмжит хөгжмийн дээд сургуулийн хөгжмийн зохиогчийн ангийг төгсөхдөө "Миний эх орон" хэмээх бүрэн хэмжээний симфони бичсэн нь Монголын симфони хөгжмийн алтан хараацай болсон юм. Монгол симфонийн шинэ гарааг П.И.Чайковскийн нэрэмжит хөгжмийн дээд сургуулийг төгсөгч хөгжмийн зохиолч С.Гончигсумлаа (1915-1991) I, II, III, IV, V симфониудаараа даацтай хөгжүүлсэн юм. Энэ хугацаанд Л.Мөрдорж "Октябрь" хэмээх II симфони, Ардын наадам хэмээх III симфони, "Залуучууд" хэмээх IV симфонио бичсэн билээ.

Монголын симфонийн тулгын чулууг тавилцсан ахмад хөгжмийн зохиолч Л.Мөрдорж, С.Гончигсумлаа, Ц.Намсрайжав нарын халаас Свердловск хотын хөгжмийн дээд сургуулийг төгсөгч хөгжмийн зохиолч Ц.Нацагдорж I, II, III, IV симфониороо, мөн сургуулийг төгсөгч Б.Шарав I, II симфониороо туушта залгамжилж Монгол үндэсний дан хөгжмийн сэтгэлгээний цар хүрээ, гарвал зүйн үндсийг симфони бичлэгийн орчин үеийн арга барил, найруулгаар баяжуулсаар байна.

Ц.Намсрайжавын "Халуун элгэн нутаг" дуунд зориулан босгосон хөшөө

Шашны зан үйлтэй холбоотой хөгжмийн зэмсгүүд

Ятга

малаа тууж, адгуулж яваа хүмүүсийн дүрсээс гадна гал голомтоо тойрон бишрэл хүндэтгэлийн зан үйл хийж байгаа болов уу гэмээр дүрслэлүүд ч тохиолддог.

Эрт цагт хүмүүс чулуу модоор ямар нэгэн алх дөшний маягийн цохих, дэлдэх багаж зэвсэг хийж, ахуй амьдралдаа хэрэглэж байсан нь яваандаа цохиур хөгжим үүсэхэд түлхэц болжээ. Мөн дэлдэх цохих зүйлсээсээ гарч буй дуу чимээний хэм хэмнэлд тохируулан үсэрч харайх, дэвхцэж цовхчих, зэрлэг амьтдыг үргээх, саатуулах, тойрч бүслэх зэрэг хөдөлгөөнөөс бүжгийн үндсэн хөдөлгөөн, чоно үнэг зэрэг араатан амьтны улих, хуцах, жигүүртэн шувуудын гуаглах, донгодох зэрэг олон зүйлийн авиаг дууриалган үйлдсэн өнөөгийн шүгэл, эвэр бүрээ зэрэгтэй төсөөтэй дуу авианы хэрэгслээс үлээвэр хөгжмийн анхны зэмсэг үүсчээ.

Энэ бүх дуу, авианы хэрэгсэл нь аажимдаа ардын аа дуунд хадгалагдан язгуур зориулалт, хэлбэр дүрсээ өөрчилж, жинхэнэ хөгжмийн зэмсэг болон хөгжиж иржээ. Баруун монголын урианхай ардын дуу нь хагас өнгөний гулсалт ихтэй авиаг дуурсгадаг. Мөн тагнай таших, уруул товших, хэл бүлбийдэх зэрэг нь хөгжмийн зэмсгийн ямар нэгэн дуурьслыг санагдуулам ая эгшгийг бий болгодгоос үүдэн тусгай зан үйлийн аман хөгжмийн "зэмсэг" үүсчээ.

Эртний хүмүүсийн шүтлэг болон аж байдлын зан үйл ан агнуурын болон мал аж ахуйн хэрэгцээтэй шууд холбоотойгоор олон төрөл хөгжмийн зэмсгийн өвөг хэлбэрүүд үүссэн тухай судалгааны шинэ шинэ мэдээ баримт олдож, монголчуудын хөгжмийн түүхийн талаархи бидний мэдлэгийг баяжуулсаар байна. Монгол угсаатан дээр үеэс хааны ордон төрийн ёслолт найр наадам, ан ав, цэрэг дайн, шашны болон иргэний аж байдлын зан үйлүүдэд хөгжим үүсгэн дуулж, бүжиглэдэг байсан талаар "Монголын нууц товчоо" болон түүхийн бусад сурвалжуудад олонтаа тэмдэглэсэн байдаг. Энэ асуудлыг дотоод, гадаадын эрдэмтэн, судлаачид нарийвчлан судалсаар байгаа билээ.

Монгол ардын хөгжмийн зэмсгийн дотроос хамгийн эртнийх нь *цуур* хулсан хуур, төмөр хуур, гэж үздэг. Хүн өгүүлэхийн эрхтнээрээ хөгжмийн зэмсэг хийж исгэрэх, хөөмийлэх, авиаг эгшиглүүлэхэд амны хөндий, хэл шүд зэрэг эрхтнүүд маш чухал үүрэг гүйцэтгэдэг юм.

Цуур бол үлээхийн зэрэгцээгээр давхар хөөмийлэн эгшиглүүлдэг хөгжмийн зэмсэг юм. Хөгжмийн түүхэнд холбогдох ном судрт цуурыг "монгол цуур", "модон цуур" гэх зэргээр цохож нэрлэсэн байдаг.

198 онд холбогдох нэгэн хятад сурвалжид дурдсанаар хятадын Зүүн Хан улсын эзэн хаан Лин Ди Хүннү нарын кунхоу, лимбэ (ди) хөгжим, мөн бүжгийг ихэд ташаан сонирхдог байсан гэнэ. Энд дурдан байгаа кунхоу гэдэг нь чухам хаанаас гаралтай ямар хөгжмийн зэмсэг байсныг олон орны эрдэмтэд дундад азийн орнууд, түрэг, хүннүгийн хэл, түүх соёлын сурвалж хэрэглэгдэхүүнийг харьцуулан судлаад кунхоу гэдэг нь монгол түрэг гаралтай хөгжим бөгөөд түүнийг түргээр хунхау гэдэг мөнөөхөн кунхоу гэдэг нь монгол хэлний "хуур" гэдэг үгний нэн эртний дуудлага байж болно гэж үзэж байна. Энэхүү кунхоу гэдэг хөгжмийн зэмсгийг судалсан олон эрдэмтэд түүнийг хятадынх биш харин Хан улсын үед хятадад гаднаас дэлгэрсэн гэдэг талаар санал нэгтэй байгаа ажээ.

Монголчууд манай тооллын өмнөх зуунаас цэргийн бүрээ, хэнгэрэг, модон цуур, хуур, бийба гэх мэт чавхдаст, нумт болон товшуур хөгжим, хэл хуур зэрэг олон төрлийн хөгжмийн зэмсэг бүтээн хэрэглэж байжээ.

Ёочин

Ж.Энэбиш
Л.Эрдэнэчимэг
С.Уранбилэг
Э.Амарбилиг

Домбор *Хун хуур* *Хуур* *Хуучир* *Шанз*

БҮЖГИЙН УРЛАГ

Монголчуудын бүтээсэн уламжлалт бүжгийн баялаг өв санг хөдөлмөр, зан үйлийн бүжиг, угсаатан ястны ардын бүжгийн дэг сургууль, хаадын ордны бүжгийн төрөл зүйлээс судлан мэдэж болно.

Монголчуудын зан үйлийн бүжгийн эртний хэлбэр нь бөөгийн бүжиг, сүүлчийн хэлбэр нь цамын бүжиг юм.

Бөөгийн бүжиглэл нь утга санаагаа онгон сахиус, сүнс сүлд зэрэг оюун санааны ертөнцтэй харьцах зан үйлээр дамжуулж илэрхийлдэг бол цамын бүжиглэл нь буддын шашны гүн ухааны агуулгатай багт бүжгийн төрөл юм.

Бөөгийн бүжигт бөөгийн хэц хэнгэрэг, төмөр хуур гол үүрэг гүйцэтгэдэг бол, цамын бүжигт цан, хэнгэрэг, бүрээ, бишгүүр зэрэг цохивор болон үлээвэр хөгжмийн зэмсгүүд голлож оролцоно. Цамын бүжиг хэдийгээр Энэтхэг, Төвд орноос үүсэлтэй боловч монгол ахуй, зан үйлд дасан зохицож монгол цам болтлоо хувьсан өөрчлөгджээ. Тухайлбал XX зууны эхэн үед Хүрээ цамд "Хангарьдын бүжиг", Гэсэр цамд "Нум сумтай 32 баатрын бүжиглэл", Ялгуусан гэгээний хийдийн цамд "8-12 хүүхдийн бүжиг" тус тус дэглэж тавьж байсан нь дээрх санааг нотолж байна.

Монгол бүжгийн намба төрх, монгол хүний сэтгэл хөдлөлийн онцлог чанарыг угсаатны бүжиг, бий биелгээс ангид авч үзэхийн аргагүй юм. Төв халхын бүжигт монгол хүний эрхэмсэг зан чанар, ёслол хүндэтгэлийн намба төрх, гунхах ганхах, суялзах хөдөлгөөн голлодог бол баруун монголын захчин, торгууд, урианхай, дөрвөд, хотон, баяд, өөлд ястны бүжигт

Цамын бүжиг

С.Тараа, Б.Алтанцэцэг "Хэнгэрэгийн ай"

Ц.Сэвжид "Хөдөө нутгийн залуус"

гарын болон цээж биеийн огцом түргэн хөдөлгөөн, дал мөрний хаялга, цохилго, сугсралт, солбилт зэрэг нийтлэг намба төрх давамгайлна. Харин буриад бүжигт бол "Ёохор", "Еэхэр", "Ээрэмших", "Ниргэлгээ" зэрэг тойрон бүжгийн дуут хэлбэр, зүүн монголын бүжигт уян налархай хөдөлгөөн, сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал зонхилно.

"Мянгад бүжиг"

"Монголын нууц товчоо"-нд Хуталыг хаанд өргөмжлөх үед Хорхонагийн саглагар модны дор хавирга газрыг халцартал, өвдөг газрыг өлтөртөл наадан бүжиглэж хуримлав гэж гаргадаг нь монголчуудын эртний зан үйлийн бүжиг XIII зууны Монгол хаадын ордны бүжигт өргөмжлөгдөн дэвшиж Төрийн тайлга ёслолд хэрэглэгдэж байсныг гэрчилнэ. Энэ тухай Юан улсын сударт: "Өвгөдийн сүмийн их танхимд янз бүрийн хөгжмийн зэмсэг барьсан 312 хөгжимчин ордны найрал хөгжмийн бүрдэл болж 312 эрэгтэй эмэгтэй бүжигчид тэр хөгжмийн аянд бүжиглэнэ. Эмэгтэй бүжигчид хошуурсан урт ханцуйтай, гар буюу цээжин бие нэвт гэрэлтсэн, алтан утас сүлжмэл сиймхий торгон саа хувцсаа өмсөцгөөн гартаа мандарваа цэцгийн баглаа болон эрхи барин тэнгэрийн дагинасыг дүрсэлнэ. Эрэгтэйчүүд нь нөгөө талын шаталсан өндөрлөгөөс бүжгийн удирдагчийн дохиогоор хангарьдын жигүүртэй тогосын гялалзсан өд, өнгөт шилэн эдлэлийн чимэгт хувцастай, далавчаа дэвэн хангарьдын бүжиг хийгээд буцаж байрандаа очиж зогсоно" хэмээн өгүүлжээ.



С.Тараа, Б.Алтанцэцэг "Ногоон Дара-Эх"

Ж.Эрдэнэхорлоо "Ордны бүжиг"

Монгол хаадын ордны бүжгийн уламжлал үл тасран үргэлжилсээр XX зуунтай золгосны тодорхой жишээнд Халхголын То вангийн ордон дахь "Ногоон морины дуут бүжиг", Ховдын хязгаарт Торгуудын Мичин вангийн хүрээний "Бий биелгийн дэг, Увс аймгийн Луу жанжин гүний өргөөн дахь "Өвгөн шувуу хоёр" хэмээх дуут бүжиг, Говийн Догшин хутагт Данзанравжаагийн "Саран хөхөөний намтар" дуулалт жүжиг, одоогийн Сэлэнгэ аймгийн нутаг дахь Гүн галуутайн "Асрын наадам" хэмээх дуут бүжгийн тоглолтуудыг тус тус нэрлэж болно. Ийнхүү монголчуудын бүтээсэн хөдөлмөр зан үйлийн бүжиг, угтсаатны

Ц.Намсрайжав, Ц.Сэвжид "Аягат бүжиг"

Д.Лувсаншарав, С.Сүхбаатар "Цэцгийн дэлбээ"

Ц.Сэвжид "Ээрүүлт бүжиг"

уламжлалт бүжиг, ордны бүжиг, түүний намба төрх, дэг сургууль нь XX зууны шинэ Монголын бүжгийн урлаг үүсч хөгжих шимт хөрс болж орчин цагийн концертын бүжиг, балетын жүжиг, үндэсний бүжгийн жүжиг төрж гарах үндэс суурийг тавьж өгсөн юм.

Шинэ цагийн бүжиг. Монгол оронд шинэ цагийн театр, чуулга, мэргэжлийн урлагийн байгууллагууд үүсч олширохын хирээр тэдгээрийн урын санд үндэсний бүжгийн үзүүлбэр зайлшгүй шаардагдав. Тэрхүү орон зайг эхний ээлжинд

Ц.Сэвжид "Жалам хар"

үндэсний бүжиг дэглээчдийн концертын бүжгүүд зэзлж байв. Харин 1950 оноос шинэ цагийн үндэсний бүжгэн жүжгийн эхлэл тавигдав. Энэ эхлэлийн анхдагч нь Г.Жамъянгийн хөгжим, Ц.Раднаагийн дэглэлт "Манай нэгдлийнхэн" (1953) бүжгийн чуулбар юм. Үүний дараа С.Гончигсумлаагийн "Ганхуяг" (1958) хэмээх бүрэн хэмжээний үндэсний бүжгэн жүжиг (балет) гарав.

Л.Идэрбат, Б.Баярбаатар "Их тахилгын ай" үндэсний бүжгэн жүжгийн хэсгээс

Ж.Мэнд-Амар, Б.Баярбаатар "Хүрээ тансаг"

Тэр цагаас хойш өнөө хүртэл хөгжмийн зохиолч С.Гончигсумлаа, Э.Чойдог, Б.Дамдинсүрэн, Ж.Чулуун, В.Боролдой, Ц.Нацагдорж нарын 30 гаруй бүжгэн жүжиг бичигдэж Дуурь бүжгийн эрдмийн театрын урын санг баяжуулсаар байна.

Үндэсний бүжгэн жүжгийг үүсгэн хөгжүүлэх санаачлагыг зөвхөн хөгжмийн театрууд хошуучлаад зогсоогүй, ардын дуу бүжгийн томоохон чуулгууд ч гартаа авав. Түүний сүүлчийн жишээ бол 1990-2000 онд Улсын ардын дуу бүжгийн чуулгын тайзнаа тавьсан С.Сүхбаатарын дэглэлт, Д.Лувсаншаравын хөгжим "Нарны домог", Д.Мэнд-Амарын хөгжим "Монгол бөхийн дуулал", "Монгол сурын дуулал", Б.Шаравын хөгжим "Чингисийн алтан ураг" үндэсний бүжгийн жүжгүүд юм.

Д.Лувсан шарав, С.Сүхбаатар "Нарны домог" үндэсний бүжгэн жүжгийн дараа (Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулга)



Н.Жанцанноров, Д.Баярбаатар
"Мэргэнд буусан чоно"

Д.Лувсан шарав, С.Сүхбаатар
"Нарны домог" үндэсний бүжгэн жүжгийн хэсэг

Монголын хөгжмийн театрууд үндэсний уламжлалт бүжгээ шинэчлэн хөгжүүлэхийн сацуу дэлхийн сонгодог балетийн урлагаас амжилттай суралцаж хүн ардынхаа хөгжмийн боловсрол, гоо сайхны хүмүүжилд хүчтэй нөлөө үзүүлж байна. Тухайлбал, Дуурь бүжгийн эрдмийн театрын тайзнаа П.И.Чайковскийн "Хунт нуур", "Щелкунчик", А.Аданы "Жизель", Л.Минкусын "Дон Кихот", Ц.Пунийн "Баядера" зэрэг 10 гаруй сонгодог балетийг тавьсан нь Монголын бүжгийн урлагийн гарамгай амжилт, балетийн найруулагч, жүжигчдийн ур чадварын томоохон үзүүлэлт болов.

Б.Алтанцэцэг
С.Уранбилэг

Б.Шарав, С.Сүхбаатар "Чингисийн алтан ураг"
үндэсний бүжгэн жүжгийн хэсэг

КИНО УРЛАГ

19-р зууны сүүлчээр урлагийн нэгэн шинэ төрөл болон хүчтэй гарч ирсэн кино урлаг дэлхийн олон улс орны ард түмний гайхал бишрэлийг төрүүлж байхад монгол орон тэр "ер бусын" давалгааны урсгалд хараахан ороогүй байлаа. Энэ нь олон учир шалтгаантай байсан нь мэдээж. Анхнаасаа бизнесийн чухал хэрэгсэл болсон киног бүтээгчид дэлхийн томоохон орнуудаар төлөөлөгчдөө илгээж багагүй хөрөнгө мөнгө хуримтлуулж байсан нь түүх болон үлджээ.

Нөгөө талаар киноны тоног төхөөрөмж нь тухайн үедээ цөөхөн байсан нь ч үнэн юм. Гэвч 20-р зууны арваад оноос нийслэл хүрээнд Оросын "Бирж" буудалд кино гаргаж эхэлсэн тухай баримт бидний олж мэдсэн хамгийн эхний тодорхой баримт юм. Түүнээс Богдхааны болон зарим томоохон ноёдын орд өргөөнд орос кино гаргах болсон баримт байдаг юм.

Оросын киночид Монгол оронд ирж өөрсдийн бүтээлийг үзүүлээд зогсохгүй 1925 онд хэсэг уран бүтээлчид Монгол орны тухай кино бүтээж байв.

Монголын хувьсгалт Засгийн газраас 1925 онд тогтоол гаргаж тус улсын нутаг дэвсгэрт кино гаргах бүрэн эрхийг Сүхбаатарын нэрэмжит клубт өгчээ.

30-40-өөд оны үеэс Зөвлөлтийн киночдын шилдэг бүтээлүүд Монгол орны дэлгэцэнд олонтаа гарах болжээ.

1933 оны 8-р сарын 10-нд БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол гарч "Кино зургийн хороо" хэмээх байгууллага байгуулсан нь монголын кино үзвэрийн газрын эх үндэс боллоо. Ийнхүү монголчууд кино урлагтай өргөн дэлгэр танилцах үүд хаалга нээгджээ.

1935 оны 10-р сарын 11-ний өдөр БНМАУ-ын СнЗ-өөс үндэсний кино үйлдвэр байгуулах тухай тогтоол гаргасан нь үндэсний кино урлагийг бий болгон хөгжүүлэх чухал үйл явдал болжээ.

1936 онд Зөвлөлтийн киноны хэсэг мэргэжилтнүүд С.Гусевийн удирдлаган дор ирж монголын кино үйлдвэрийг байгуулж, үндэсний киноны анхны мэргэжилтнүүдийг сургаж, эхэлснээр монголчууд өөрийн кино уран бүтээлчдийн уран бүтээлтэй танилцах боломжийг нээж өгсөн юм.

Түүх -хувьсгалын сэдэвт кино

1921 оны ардын хувьсгал Монгол орны нийгмийн амьдралд эргэлт болсон нь урлагийн аливаа бүтээлд тусгалаа олсон билээ.

Монголын кино урлагийн дөчөөс ерээд оны олонхи бүтээл түүх-хувьсгалын сэдвээр бүтээгдсэн нь үүнийг гэрчилнэ. 1942 онд оросын кино найруулагч А.Зархи, И.Хейфриц нар "Сүхбаатар" киногоороо энэ төрлийн сэдэвт бүтээлүүдийн анхны шанг татжээ.

"Сүхбаатар" киноны хэсгээс

Энэ кинонд Оросын нэрт жүжигчин Л.Свердлинтэй хамт зөвлөлтийн ардын жүжигчин И.Черкасов, М.Штраух нар тоглосны дээр монголын театр, киноны алтан үеийн жүжигчид Ц.Цэгмид, Ө.Рэнцэнноров зэрэг уран бүтээлчид тоглосон юм. Энэ уламжлалыг үргэлжлүүлэн тавь,

"Монгол хүү" киноны хэсгээс

жараад онд "Ардын элч", "Төгсгөл", "Үер", "Өглөө", "Тэмцэл", "Түмний нэг", "Хүний мөр" зэрэг шилдэг бүтээлүүд олны хүртээл болжээ. Монголын түүх-хувьсгалын сэдэвт киноны томоохон төлөөлөгчдийн нэг кино найруулагч Д.Жигжидийн найруулан бүтээсэн анхны бүтээл нь "Ардын элч" кино байлаа. Ардын

"Ардын элч" киноны хэсгээс

хувьсгалыг бэхжүүлэхэд жирийн нэгэн иргэний хувь нэмэр ямар их үүрэг гүйцэтгэснийг уран сайхны

"Үер" киноны хэсгээс

"Түмний нэг" киноны хэсгээс

бүхий л хэллэг дүрслэлээр нарийн зурж харуулснаараа энэ бүтээл үзэгчид, судлаачдын анхаарлыг татаад зогсохгүй гадаадын кино наадмаас томоохон шагнал хүртсэн билээ. Жигжидийн түүх-хувьсгалын сэдэвт гол бүтээлүүд нь "Түмний нэг", "Хүний мөр", "Өглөө", "Тэмцэл", "Үер" кинонууд юм. Эхний хоёр кинонд ардын хувьсгалын өрнөл хөгжлийг Сүхбаатарын үйл амьдралтай холбон далайцтай харуулжээ.

"Өглөө" киноны хэсгээс

Д.Жигжид орчин үеийн болон түүхийн сэдвээр олон кино бүтээсэн нь түүх-хувьсгалын сэдэвт кинонуудаас нь дутуугүй олны анхаарлыг татаж байсан юм.

Монголын кино урлагийн нэрт уран бүтээлчдийн нэг төдийгүй түүх-хувьсгалын сэдэвт киноны өөр нэг томоохон төлөөлөгч бол кино найруулагч Равжаагийн Доржпалам (1931-1990) билээ. Доржпалам олон төрлийн сэдвээр сонирхолтой олон бүтээл туурвисан боловч гол бүтээл нь "Тунгалаг Тамир" хэмээх туульсын том кино байлаа. Зохиолч Ч.Лодойдамбын зохиолоор бүтээсэн энэ кинонд хувь хүний эрдрээтэй амьдралаар дамжуулж ардын хувьсгал хэрхэн хөгжин бэхжсэн түүхийг сэтгэлд хоногштол дүрслэн харуулжээ. Энэ бүтээл нь монголын кино урлагт түүх-хувьсгалын сэдвийг хэрхэн боловсруулах, түүнийг уран сайхны хэллэг, дүрслэлээр хэрхэн харуулах, өргөн дэлгэцийн арга хэлбэрийг хэрхэн хэрэгжүүлэх зэрэг олон асуудлыг шийдэхэд чухал хувь нэмэр оруулснаараа онцлог бөгөөд чухамхүү үүнд эл бүтээлийн ач холбогдол оршиж байна.

"Тунгалаг Тамир" киноны хэсгээс

Р.Доржпалам "Харуул занги", "Тэмцлийн оч" зэрэг бүтээлүүдээ мөн түүх-хувьсгалын асуудалд хандуулсан нь дээрхи бүтээлүүдээсээ дутуугүй ач холбогдолтой болсон юм.

Түүх-хувьсгалын сэдвээр монголын олон кино найруулагчид бүтээл туурвисны дотроос Ц.Цэрэндоржийн "Талын цуурай", Г.Жигжид-сүрэнгийн "Хатанбаатар", Х.Дамдингийн "Улаан дарцаг", "Мандах нарны туяа" зэрэг бүтээлүүд ардын хувьсгалын янз бүрийн цаг үе, хүмүүсийн үзэл бодол, сэтгэл санаанд гарсан өөрчлөлтийг тод томруун үзүүлснээрээ тэмдэглэлтэй юм.

Ийнхүү ардын хувьсгалын бүхий л үйл явцыг тал бүрээс нь харуулах зорилтыг өмнөө тавьсан тухайн цаг үеийн бүтээлүүд өөрсдөө түүх болон бидний үед хүрч иржээ.

Монголын кино урлагийн нэг чухал сэдэв нь өөрийн орны баялаг түүхийг дэлгэцийн хэлээр дүрслэн харуулахад чиглэж байлаа.

1945 онд монголын киноны уран бүтээлчид Беларусын нэрт найруулагч Ю.Таричийн хамт "Цогт тайж" киног бүтээснээр эх орныхоо олон үеийн түүх домгийг дэлгэцнээ харуулах их аянаа эхэлсэн юм. Б.Ринчений зохиолоор бүтээсэн энэ кино нь XVII зууны үеийн нэрт яруу найрагч, эх оронч Цогт хун тайжийн баатарлаг тэмцэл, үйл амьдралын дүр зургаар монголын эх орончдын амь хайргүй тэмцлийг төлөөлүүлэн харуулжээ. Найруулагч, зураглаачид гол баатрын сэтгэл санааны ертөнцийг илэрхийлэхдээ дүрслэл хэллэгийг оновчтой ашиглаж, дүрийн мөн чанарыг гаргахдаа ихэд анхаарсан нь ажиглагддаг. Ардын жүжигчид Ц.Цэгмид уран авъяасаараа агуу их эх оронч Цогт тайжийн дүрийг хүн бүрийн зүрх сэтгэлд мөнхөлсөн юм.

"Талын цуурай" киноны хэсгээс

"Хатанбаатар" киноны хэсгээс

"Цогт тайж" киноны хэсгээс

гол дүрийн жүжигчин, зураглаач, зураач зэрэг гол бүтээлчид нь төрийн шагнал хүртсэн юм. Монголын кино урлагийн түүхэнд ганцхан киноноос ийм олон уран бүтээлчид төрийн хишиг хүртэж байгаагүй нь уг бүтээл ямар хэмжээний бүтээл болсныг давхар харуулж буй хэрэг.

"Мандхай сэцэн хатан" киноны хэсгээс

Түүхийн сэдвээс XIII зууны үеийн асуудал руу уран бүтээлчид нилээд хожуу үеийг хүртэл хандаж зүрхэлдэггүй байлаа. Энэ нь үзэл суртлыг тээг, эдийн засгийн боломж зэрэг олон зүйлтэй холбоотой байсан. Гэвч найруулагч Бэгзийн Балжинням "Мандухай сэцэн хатан" туульсын бүтээл туурвиснаараа түүхийн сэдэвт киноны том төлөөлөгч болон гарч ирсэн юм. "Мандухай сэцэн хатан" кино нь түүхэнд домог болон тэмдэглэгдэж үлдсэн эх оронч хатны эмгэнэлтэй боловч бахархалтай амьдралыг уран сайхны хэллэг, дүрслэлийн төгс боловсронгуй хэлбэрээр харуулснаараа монголын кино урлагийн хөгжилд дэвшил болсон юм. Энд найруулгын өвөрмөц арга барил, зураг авалтын олон янзын хувилбар, гэрлийн утгачилсан шийдэл, жүжигчдийн сэтгэл булаам тоглолт зэрэг олон шилдэг зүйлс цогцолжээ. Тиймээс ч энэ бүтээлийг бүтээхэд оролцсон зохиолч найруулагч,

Б.Балжинням "Мөнх тэнгэрийн хүчин дор" туульсын зохиолоороо Чингис хааны амьдрал, тэмцлээр дамжуулан XIII зууны түүхэн зурвас үеийн өргөн дэлгэр зургийг дэлгэцнээ харуулсан. Хэдий энэ кинонд зарим нэг учир дутагдалтай зүйл байдаг боловч гүн ухааны аястай түүхийн том бүтээл болсноороо монголын кино урлагийн түүхэнд хүндтэй байр эзлэх нь дамжиггүй.

Ойрхи цагийн болон дундат зууны үеийн түүх манай кино уран бүтээлчдийн анхаарлын төвд байсаар ирсэн нь "Гологдсон хүүхэн", "Нүгэл буян", "Ард Аюуш" зэрэг бүтээлүүдээс харагддаг. Эрдэмтэн зохиолч Ц.Дамдинсүрэнгийн нэг нэрт зохиолоор найруулагч Д.Чимид-Осорын найруулан бүтээсэн "Гологдсон хүүхэн" кинонд хувьсгалын өмнөх болон дараахи үеийн монгол орны нийгмийн амьдрал, хүн ардын оюун санаанд гарсан их өөрчлөлтийг тусган харуулжээ. Энэ бүтээл уран зохиолын сонгодог



"Төрсөөр төрөлдөө" киноны хэсгээс

"Цагаан дуганы гэгээ" киноны хэсгээс

Д.Чимид-Осор нэрт зохиолч Д.Намдагийн зохиолоор "Нүгэл буян" киног бүтээж, монгол орны хувьсгалаас өмнөх түүхэн үеийн хүмүүсийн сэтгэл санаа, үзэл бодлын дүр зургаар тухайн цаг үеийн нийтлэг шинжийг товойлгон харуулсан юм. Энэ киноны гол дүр Тоо хуарын маш их зөрчилтэй, эмгэнэлт төрх байдлыг ардын жүжигчин Д.Ичинхорлоо уран сайхны өндөр түвшинд бүтээсэн билээ.

"Их замын эхэнд" киноны хэсгээс

"Мөнх тэнгэрийн хүчин дор" киноны хэсгээс

Найруулагч Н.Нямдаваагийн "Хоньчин Найдан" кино хувьсгалын өмнөх Монгол орны үй түмэн хүүхдийн ядуу дорой амьдралын нийтлэг дүр зургийг сонирхолтой харуулснаараа тухайн сэдвээр бүтээгдсэн тэмдэглэлтэй бүтээлийн нэгэнд зүй ёсоор ордог юм.

"Гарьд магнай" киноны хэсгээс

Орчин үеийн сэдэвт кино

Киноны орчин үеийн сэдэв нь харьцангуй ойлголт билээ. Орчин үеийн бүтээлүүд нь цаг хугацааны эрхээр түүх болж, тухайн цаг үеийнхээ гэгээн дүр болж үлддэг. Энэ хуулийн дагуу авч үзвэл тавиад онд бүтээгдсэн найруулагч Ц.Зандраагийн "Шинэ жил" кино тухайн цаг үедээ шинэ үеийн дүр зураг болж байсан бол эдүгээ хагас зуун жилийн өмнөх нийгмийн үнэтэй баримт болон үлджээ.

"Хөхөө гэрлэх дөхлөө" киноны хэсгээс

Энэ бүтээлд тэр үеийн ажилчин ангийн үүрэг зорилт, хүсэл эрмэлзэл, хамт олон, нөхөрлөлийн утга учрыг харуулсан бол "Гэм нь урдаа" кинонд малчдын ахуй амьдрал, ажил бүтээл, хүмүүсийн зан суртахууны зөрчил тэмцлийг товойлгон үзүүлжээ. Манай киноны уран бүтээлчдийн бүтээсэн орчин үеийн сэдэвт кинонуудад хүмүүсийн ёс суртахууны асуудлыг гол төлөв хөндөж байсан нь тухайн үед хүн ардыг коммунист үзлээр хүмүүжүүлэхэд нам, засгаас ихээхэн анхаарал тавьж байсантай холбоотой байжээ. Орчин үеийн сэдэвт кинонууд нь уран сайхны олон хэлбэрээр бүтээгдэж байсан. Драмын төрөл зүйлээс гадна инээдмийн төрлөөр цөөнгүй бүтээл гарсан. Энэ үеийн инээдмийн киноны гол төлөөлөгч нь Б.Жамсран юм. Түүний "Хөхөө гэрлэх дөхлөө", "Нийслэл хүү", "Аман хуур" зэрэг кино нь утга санаа, уран сайхны хувьд монголын инээдмийн киноны хөгжилд томоохон хувь нэмэр болсон бүтээлүүд билээ.

"Анхны алхам" киноны хэсгээс

Орчин үеийн сэдэвт кинонд хүүхэд-залуучуудын сэдэв бүхий бүтээл багагүй чухал байр эзэлдэг. Энэ төрлийн бүтээлүүдийн гол төлөөлөгчдийн нэг нь Х.Дамдин юм. Тэрээр "Улаан дарцаг" кинондоо ардын хувьсгалын үйл хэрэгт манай өсвөр үеийнхэн хэрхэн оролцож байсныг үзүүлсэн бол, "Мартагдашгүй намар" кинондоо оюутан залуучуудын энгэл жирийн амьдрал, хайр дурлалын түүхийг уянгалаг өнгө аясаар харуулсан юм. Дамдин "Зуслангийн найзууд", "Нэг ангийн хоёр" зэрэг кинондоо хүүхдүүдийн үерхэл нөхөрлөл, зохион бүтээх хүсэл эрмэлзлэлийн аятайхан харуулсан юм.

"Би чамд хайртай" киноны хэсгээс

Хүүхэд-залуучуудын сэдэвт киноны өөр нэг төлөөлөгч нь Н.Нямдаваа юм. Түүний бүтээсэн "Уулзалт", "Сүхболдын яриа", "Дэгдээхэй нас", "Хоньчин Найдан" зэрэг кинонууд нь хүүхэд багачуудын сэтгэхүйг сайн харуулаад зогсохгүй, түүгээр дамжуулж тэдэнд хүмүүжлийн ихээхэн нөлөө үзүүлэхүйц хэллэг дүрслэлийг олонтаа янз бүрийн хувилбараар ашигласан нь түүний ур чадварын илэрхийлэл болж байдаг. Тиймээс ч Оросын кино судлаач К.Огнев "Н.Нямдаваа "Хоньчин Найдан" киногоо бүтээхдээ киноныхоо дүрийн бэлгэдлийн талыг маш их баяжуулж өгсөн нь тэрхүү гол дүрийн өсвөр үеийн хүүхдийн мөн чанарыг сайн гаргахад их чухал зүйл болж гэж хэлүүштэй юм" гэж үнэлэн бичсэн байдаг. Түүний "Уул усны үр сад" кино нь гүн ухааны өгүүлэмжтэй, уран чадварын өндөр түвшинд бүтээгдсэн сайн бүтээл болсон билээ.

Орчин үеийн сэдэвт киноны нэг том төлөөлөгч Г.Жигжидсүрэн бол маш олон төрлийн сэдвээр олон бүтээл туурвисан уран бүтээлч юм. Түүний гол бүтээлийн нэг нь "Хатанбаатар Магсаржав". Ардын хувьсгалын үйл хэрэгт оролцож явсан тэрхүү домогт эрийн үйл амьдралыг түүхэн өргөн цар хүрээтэй, уран сайхны өндөр түвшинд үзүүлсэн. Жигжидсүрэнгийн орчин үеийн сэдвээр бүтээсэн "Анхны алхам", "Говийн нүдэн", "Суварган цэнхэр уулс", "Нарны унага" зэрэг бүтээлүүд нь янз бүрийн мэргэжлийн хүмүүсийн ажил амьдрал, хөдөлмөр бүтээлийг өөр өөр хэлбэр, дүрслэлээр харуулж үзүүлснээрээ онцлог юм.

Сүүлийн үед монголын кино урлагт шинэ залуу уран бүтээлчид олноор орж ирлээ. Тэд уран бүтээлийн эрэл хайгуул хийж алдахдаа алдаж, онохдоо онож маш олон төрлийн сэдвээр кино бүтээж байна.

Дү.Мягмарсүрэн
Э.Амарбилиг

"Шинэ үсгийн багш" киноны хэсгээс

ЦИРКИЙН УРЛАГ

XX зуунд үндэсний урлагийн төрөл зүйл баяжсаны нэг нь цирк юм. Үндэсний уламжлалт жүжиг наадам, алиа хошигнол, бүжиг, хүч тамир, хөдөлмөр зан үйлд төрөл ялгамжаагүй нийлэг шинжтэй уламжилж ирсэн урлаг уран сайхны хэлбэр нь тус оронд орчин үеийн мэргэжлийн цирк үүсэн хөгжих шимтэй хөрс болов. Үүнд амьтан сургахуй, алиалал, илбэ жилбэ, үсрэх-дүүлэх, тулах тэнцвэр, гүү саахуй (жонглёр), уран нугараа, хүч тамир зэргийг нэрлэж болно.

Монголчууд эрт цагаас мал аж ахуй эрхэлсээр ирсэн болохоор моринд гарамгай эрчүүд морь уургалах, эмнэг хангал сургах, явдал янз оруулах, морь булгиулах, хурдан жороо морь уралдуулах, уяа сойлгыг тааруулах (дасгалжуулах) эрдмийг нийтийн өмнө илтгэдэг нь нэгэнт тогтсон заншил байв. Энэ нь хэдийгээр ахуйн хэрэглээний шинжтэй боловч нөгөөтэйгүүр, биеийн тамир, спорт, улмаар уран сайхны театрчилсан үзүүлбэр, тэр тусмаа циркийн морьт наадмын нэгэн эх бүтэц байв.

1921 оны долдугаар сард ардын их баяр наадмаар жанжин Д.Сүхбаатар өөрөө олны өмнө морин сургууль хийж үзүүлж, морьтон эрийн ид хавыг илтгэж байжээ. Моринд гарамгай бөгөөд зэвсгийн эрдэмд төгс тэрбээр морины хурд дунд газраас юм шүүрэх, сэлэм амандаа зуугаад морин дээр босоо зогсож хар хурдаар давхиулах, давхиут дунд нь морин дээр харайж мордох, үсэрч буух, хойш урагш харж суух, хоёр тийш харайж савах нь нүдэнд оногдмооргүй түргэн байсан гэдэг.

Эртнээс наaш монгол хаадын ордонд хөгжөөн баясгагч алиа салбадай нар заавал байдаг байв. Монгол цамд гардаг алиа наргианч цагаан өвгөн бол циркийн урлагт түгээмэл байдаг багт алиалагчийн нэгэн сонин хувилбар гэхэд болно.

Урлагийн алтан үеийн жүжигчид наргиадын циркэд (1941 он)

Цагаан өвгөн

Тэвгэ өшиглөх, гүү саах, шагай шүүрэх зэрэгт жонглёрын үндсэн дэг жаяг агуулагдаж байв. Нөгөөтэйгүүр үсрэх, харайх, дүүлэх ур эрдэм, уран нугарах увдист үзүүлбэр бас байв. Энэ тухайд Хөвсгөлийн дархад ястан, нутагтаа "Мушгиа" гэж цууд гарсан нугараач Шаравсамбууг дурдаж болно. Энэхүү ховор авъяастан XX зууныг хүртэл сэрүүн тунгалаг байж, жар гаруй насалсан хойноо ч чөлөөтэй нугарч, дураараа мушгирч чаддаг байсан гэдэг.

1921 оны хувьсгалаас хойш урлагийн бусад төрөл зүйлийн нэгэн адил тус оронд орчин цагийн циркийн урлаг сонгодог арга барил, суурин хэлбэрээр, мэргэжлийн түвшинд хөгжиж эхлэв.

Монгол циркийг үндэслэгч Ж.Раднаабазар, Л.Нацаг, Д.Гомбо нар (1941 он)

Монголын анхны циркийн сургууль төгсөгчид багш, мэргэжилтнүүдийн хамт (1941 он)

Тэмээтэй акробат

1941 оны долдугаар сарын есөнд орчин үеийн монголын цирк нээгдэж анхны жүжигчдийн уран чадварын тоглолт нь үзэгч түмний өмнө урлагийн шинэ гайхамшгийг нээжээ. Монголын цирк хүндээс хөнгөн, хүч тамираас хөгжөөн цэнгээн, агаарын нисэлтээс морьтны гайхамшиг, тулах тэнцвэрээс илбэ жилбэ, монгол морь, хангайн сарлаг, говийн тэмээнээс жигүүртэн шувуу, тайгын баавгай, уулын арслан, халуун орны сармагчин хүртэлх сургуультай амьтан оролцуулсан олон төрөл зүйл бүхий үзүүлбэртэйгээр хөгжиж ирэв.

Циркийн жүжигчдийн уран чадвар жилээс жилд үсрэнгүй ахиж, шинэ шинэ төрөл зүйлийг эзэмшин эх орны төдийгүй, дэлхийн тавцанд нэр сүрээ мандуулах болжээ. Дэлхийн залуучууд оюутны удаа дараагийн их наадмууд, Монте Карло, Гавана, БНАСАУ, БНХАУ,



Шидэх банзнаас үсрэгчид

Монголын циркийн анхны агаарын гимнастикч Т.Цэнд-Аюуш, жүжигчин Ц.Батхүү нар (1940-өөд он)

"Үүрийн цолмон" тоглолтоос

Монголын циркийн уран бүтээлийн үндсэн төрөл зүйлийн нэг нь акробат юм. Дан ба хос акробат, шидэх тэнцвэр, газрын ба агаарын гимнастик, агаарын нислэг зэрэг олон хувилбарыг хэлж болно. Улсын гавъяат жүжигчин Ж.Дамдинсүрэн ахлагчтай Ё.Дорж, Д.Жигмиддорж, Х.Намхай, Л.Даян, С.Лувсандаш, С.Дангаа, Д.Батхүү нарын нисэлттэй акробат үзэгч олныг шуугиулсан шилдэг бүтээл байв. Тэд зэрэгцэн зогссон зургаагаас есөн тэмээн дээгүүр үсрэн гардаг байлаа. Мөн жүжигчин Ц.Сандагийн удирдлагаар Г.Ирина, Т.Цэнд-Аюуш, Ё.Дорж, Д.Жигмиддорж, мөн Н.Намхай, П.Шаравдорж,

Шведэд болсон олон улсын циркийн наадмаас монгол циркийн үзүүлбэрүүд алт, мөнгө, хүрэл медаль, тусгай шагнал олныг авсан байна.

Жонглёрчид



Тулах тэнцвэр (Перш)

Г.Бадарч, Ж.Сандаг нар тэшиж яваа тэмээн дээр үсрэн дүүлэх, тонгорцог эргэх, гүү саах, акробат хийх зэрэг тэмээт үзүүлбэр бүтээсэн нь монголоор зогсохгүй, ерөөс циркийн урлагт шинэ зүйл болсон юм.

"Үүрийн цолмон" нэртэй агаарын нислэг монголын циркийн сор бүтээл болон үлджээ. Францад анх үүсч олон оронд түгэн хүрээд жүжигчний уран чадвар, эр зоригийн шалгуур бологч циркийн урлагийн хамгийн сүрлэг, сэтгэл булаагч жавхлант төрлийн нэг хэмээгддэг энэ үзүүлбэрийг монголын сод билигт жүжигчид чадварлаг эзэмшсэн юм. Акробат гимнастикийн авъяаслаг жүжигчин М.Ганболдоор ахлуулсан П.Нарантуяа, Д.Ягаанцэцэг, Д.Сүхбаатар, Д.Цэдэнбал (Цээе) нар үүнийг бүтээж эр зориг, уран чадварын гайхамшгийг илтгэжээ. 13 метрийн өндөр тавцангаас үсрэн дүүлж агаарт хоёр эргэлдээд нөгөө талаас тосон уггагч жүжигчинд дүүлэн хүрч гар гараасаа барилцан эрчлэн савлана гэдэг эмэгтэй хүний хувьд нэн хэцүү бөгөөд даанч ховорхон үзэгдэл ажээ. Монгол улсын гавъяат жүжигчин Д.Ягаанцэцэгийн ийм үзүүлбэр Монголын циркийн түүхнээ мөнхрөн үлджээ.

Б.Норовсамбуугийн "Цэцгэн дээрх нугаралт"

Тэмээтэй жонглёрчид

Илбэчин Х.Цэнд-Аюуш

Эрэгтэй уран нугарагчид

Тэмээтэй жонглёрчид

Тулах тэнцвэр, амьтан сургалт, жонглёр, илбэ ухаан, алиалал, уран нугаралт зэрэг олон төрөл зүйл амжилттай хөгжиж байгаагаас уран нугаралтыг онцгойлон дурдалтай.

1940өөд оны үеэс мэргэжлийн өндөрлөгт хүрэх эх үндэс нь тавигдаж, 1947 онд Прага хотноо болсон Дэлхийн залуучууд оюутны их наадмаар олон улсын тавцанд гарсан уран нугаралт дэлхийн циркийн урлагийг шинэ төрөл зүйлээр баяжуулсан билээ.

Уран нугаралт



Дөчөөд онд төрийн шагналт ардын жүжигчин Т.Цэнд-Аюуш, тавь жараад онд төрийн шагналт, гавъяат жүжигчин Д.Мажигсүрэн, мөн А.Доржпалам, дал наяад онд төрийн шагналт, ардын жүжигчин Б.Норовсамбуу, наяад онд Я.Оюунчимэг, Э.Эрдэнэтуяа, Л.Энхцэцэг, Л.Наранцэцэг, Ж.Эрдэнэчимэг нарын зэрэг үе үеийн гарамгай нугараач жүжигчид төрөн гарснаар уран нугаралт бол акробатын нэг төрөл төдийхэн биш, харин биеэ даасан эрхэмсэг урлаг мөнийг нотлов.

Уран нугаралт бол циркийн урлагт монголчууд, монголын дэглээч багш нар, монголын уран нугараач жүжигчдийн оруулсан гандан буурашгүй гарамгай хувь нэмэр мөн.

Циркийн урлагийг хүмүүнлэг, цог золбоолог, хөгжүүн баясгалантай болгодог алиалал монгол циркийн нэг чухал төрөл болж хөгжсөн юм. Циркийн урлагийн энэ төрлөөс БНМАУын Ардын жүжигчин Ж.Данзан, Гавьяат жүжигчин Б.Содном, Д.Батсүх мөн Д.Цэдэнбал (Цээе), Т.Латиф нарын зэрэг олон авьяаслаг жүжигчид төрж гарсан билээ.



Хос уран нугаралт
Б.Норовсамбуу, Л.Энхцэцэг нар

Алиалагч Ж.Данзан, Б.Содном нар
(Зүүн гараас)

Алиалагч Д.Цэдэнбал (Цээе),
Т.Латиф нар (Баруун гараас)

Парис хотноо болсон олон улсын залуу циркчдийн уралдаанаас 1983 онд Монгол Улсын гавъяат жүжигчин Л.Энхцэцэг алтан медаль, 1989 онд жүжигчин Т.Одгэрэл, 1990 онд жүжигчин Т.Ундармаа нар мөнгөн медаль хүртэв. 1987 онд жүжигчин Я.Оюунчимэг, Э.Эрдэнэтуяа нар дэлхийн циркийн урлагийн хамгийн том бөгөөд хамгийн нэр хүндтэй тэмцээн болсон Монте Карлогийн олон улсын циркийн их наадмаас "Мөнгөн алиалагч" шагнал хүртсэн явдал монголын циркийн урлаг, түүний дотор уран нугаралтын дээд амжилтыг илтгэн харуулав. Монголын уран нугараачид Монте Карло, Гавана, БНАСАУ, БНХАУ-д болдог олон улсын урлагийн наадмаас мөнгө, хүрэл, тусгай шагнал байнга авч байна.

Алиалагч нар

Монгол циркийн нэрийг олон улсын тавцанд өргөж яваа төрлийн нэг нь хүч тамирын үзүүлбэр бөгөөд энэ талаар БНМАУын Гавьяат жүжигчин Д.Дамдин, Я.Амаржаргал, жүжигчин Г.Хишигдаваа нарын зэрэг жүжигчид гарамгай амжилтад хүрсэн юм.

Я.Амаржаргал ахлагчтай хүнд жингийн гайхамшиг



Тэмээтэй тоглолт

Д.Амгалангийн ямаатай тоглолт

Д.Норовцэрэн "Морьтны гайхамшиг"

Арслан, баавгай, адуу, тэмээ зэрэг янз бүрийн амьтдыг сурган циркийн үзүүлбэрийг баяжуулсан БНМАУын Гавьяат жүжигчин Ц.Цэрэндорж, Я.Амаржаргал, Д.Амгалан жүжигчин Ц.Сандаг, Ү.Саруултөгс нарын зэрэг олон авьяастан монгол циркийн хөгжилд чухал хувь нэмэр оруулсан билээ. Циркийн урлагийн энэ төрлөөс БНМАУын Гавьяат жүжигчин Д.Норовцэрэнгийн удирдсан "Морьтны гайхамшиг"-ийг онцлон тэмдэглэвэл зохино.

Ц.Цэрэндоржийн сарлагтай тоглолт

Арслантай тоглолт

1990 оноос хойш монголын цирк хөгжлийнхээ шинэ мөчлөгт шилжив. Зах зээлийн жамын дагуу монголын циркийн янз бүрийн хамтлаг, хувь уран бүтээлчид гадаад орнуудад гэрээгээр болон соёлын харилцааны шугамаар урт богино хугацаагаар ажиллаж үндэснийхээ циркийн урлагийн амжилтыг дэлхий дахинд танилцуулж байна.

Г.Ринченсамбуу

С.Уранбилэг
Э.Амарбилиг



Ю.Цэндтогоочийн тэмээтэй тоглолт

Монгол цирк



БҮЛЭГ VI

- УРАН ЗУРАГ
- УРАН БАРИМАЛ
- ГОЁЛ ЧИМЭГЛЭЛИЙН УРЛАГ
- НОМ ХЭВЛЭЛИЙН УРЛАГ
- ХОТ БАЙГУУЛАЛТ, АРХИТЕКТУРЫН ХӨГЖИЛ



УРАН ЗУРАГ

Монгол нутагт орших буй уран зургийн хамгийн эртний дурсгал нь профессор А.П.Окладниковын "Ориньяк маягийн урлаг" гэж тодорхойлоод, Испаний Алтамирынхтай эн зэрэгцэнэ хэмээн үнэлсэн Ховд аймгийн Манхан сумын Хойт Цэнхэрийн агуйн хадны зураг билээ.

Монгол үндэстний уран зургийн нэгэн хосгүй дурсгал нь Уйгур, Турфаны ханын зураг юм. Тэдгээр зургийг Монгол улсын Ардын зураач Б.Гомбосүрэн 1978 онд хуулбарлан зуржирснээр өдгөө монголын дүрслэх урлагийн музейн хөмрөгт хадгалагдаж байна.

Цэнхэрийн агуйн хадны зураг

1948 онд Орос-Монголын шинжилгээний анги Хархорум хотын туурийг малтахад бурхан шашны болон хаад язгууртны сэдэвтэй ханын зураг олджээ.

Өвөр монголын Баарин аймгийн дудаг Цагаан суварганы ойролцоо буй Хятаны (1023-1035) хаадын бунханаас ордны Хятан түшмэд, цэргийн жанжин, харц иргэд гэх мэтийн дал гаруй хүмүүсийг багтаасан язгууртны ёслолын байдлыг харуулсан сэдэвт зураг, мөн дорнод монголын хангай нутгийг ан амьтан, жигүүртэн шувуутай нь багтаан, жилийн дөрвөн улирлыг дүрсэлсэн зураг олджээ.

XIII-XIV зууны уран зурагт аян дайн, ав хомрого, нүүдэлчдийн түүх, ахуй амьдралыг харуулсан зураг зонхилж, орон зайн чөлөөт хүүрнэл эрихэн зохиомж болон, өнгийн өвөрмөц таашаал тод ажиглагддаг.

Хятаны хөрөг зургийн уламжлалын нөлөөгөөр энэ үед хөрөг зураг, тухайлбал дээдсийн дүр зонхилох хандлагатай болжээ. Үүний тод жишээ нь Юань улсын үеийн ордны зураач Хорихосоны зурсан монгол хаад, хатдын хөрөг болно.

Уйгурын хөгжимчид

Хятан түшмэлийн хөрөг

XV-XVI зууны монголын уран зургийн дурсгалын нэг бол Алтан хаанаас Мин улсын хаанд илгээсэн захидлын хавсралт зураг юм. Сайхи зурагт Түмэд нутгаас Бээжин хот хүрэх зам зуурт тохиолдох хот орон, хэрэм гүүр, байшин барилга зэргийг харуулахын хамт, Алтан хаан, хатан, шадар түшмэд, ордны хөгжимчид зэргийг бодит байдлаар нэн үнэмшилтэй дүрслэн үзүүлсэн байна.

Энэтхэг, Түвэдийн урлахуй ухааны судар, шастирын билгийн дэг сургууль XVII зууны уран зурагт нөлөөлөх болжээ. Монгол зураач, урлахуй ухаантан нар Ганжуур, Данжуураас эхтэй "зургийн билиг чанар", "дүрс, хөргийн хэмжээний билиг чанар", "туулсан бурханы номлосон биеийн дүрс, хөргийн хэмжээний тийн тайлбар хэмээгдэх" зэрэг судар шастирыг орчуулан, бүтээл туурвилдаа баримталж байлаа.

Тухайлбал бурханы тиг хэмжээний онолын талаар Ажаа гэгээн Лувсандамзангийн : "Урлахуйд хялбар ам", Сүмбэ хамба Ишбалжирын "Бие, зарлиг, сэтгэлийн шүтээний үндэсн ба тийн тайлбар зүүлт, цэцгийн үзэсгэлэнт эрхи", Жадарын



Д.Гэндэндарам "Улаан сахиус"
(153х108 см, МДУМ)

"Хаянхярваа"
(140х107 см, БХОМ)

хамба Агваанхайдав ахмад бурханч, хурц билэгт Агвааншаравын хүссэнээр Энэтхэг, Монгол, Түвэдийн мэргэдийн зохиолоос түүвэрлэн "Утга төгөлдөр уран үйлдэгч тэнгэрийн сайн зам" зэрэг зохиолоо туурвин, уран сайхны сэтгэлгээний гүйлгээнд оруулсан байна. Жанжаа хутагт Ролбийдоржийн (1717-1756) оршил бичиж, улаан шунхаар Бээжинд дармалдсан "Гурван зуут", Агвааншарав зэрэг зураачдын загвараар хүрээнд "Таван зуут" бурхдын цомог гарчээ.

XIX зууны дундаас XX зууны эхэн үеийн монголын уран зургийн туурвил зүйд төрөл зүйлийн тод ялгараа гарч, монгол үндэстний уламжлалт уран зураг урьд өмнө үсрэнгүй хөгжсөн юм. Мөн энэ үед "нагтан" (хар дэвсгэрт), "мартан" (улаан дэвсгэрт), "гартан" (цагаан дэвсгэрт), "сэртан" (шар дэвсгэрт) алтан сийдмэл зураг хэдэн мянганы уламжлалт "зээгт наамлын урлаг"-тай арсалдан хөгжиж, аль аль нь гайхамшигтай амжилтад хүрсэн юм. Энэ үед Ганжуур, Жадамба зэрэг бурхны ном шастирыг нагтан аргаар есөн эрдэнээр бүтээх үйл дэлгэрчээ. Тухайлбал: Их хүрээний Гэндэндамба унзадын туурвисан "Улаан сахиус" (Жамсран) хэмээх мартан зураг, нэр үл мэдэгдэх зураачийн бүтээсэн "Хаянхирваа" бурхны мартан дүр монголын дүрслэх урлагийн музейд хадгалагдаж байна. Түшээт хан

Очирваань
(МДУМ)

"Ямандаг"
(260x191 см, БХОМ)

аймгийн Дайчин бэйлийн хошуу одоогийн Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын харьяат Их хүрээний Тойсүмлин аймгийн алдарт зураач Цэндийн удирдлагаар хэсэг хатгамалчид аврага том хэмжээний (12x16 м) "Очирваань" бурханы зээгт наамал туурвин бүтээсэн нь өдгөө Монголын дүрслэх урлагийн музейд үзэгчдийн талархал хүлээдэг юм. Тэр үед их хүрээний Зоогой аймгийн алдарт зураач Жүгдэр "Мягмарын улаан сахиус" хэмээх зээгт наамлаа бүтээсэн юм.

Энэ үеийн уран зургийн нэрт төлөөлөгчдийн нэг нь зохиолч, гүн ухаантан В.Инжаннааш (1837-1892) бөгөөд тэрээр "Тэргүүлэгч цэцэг ба болжмор", "Цагаан үүл", "Гэр хүрээлэнгийн үзэмж" зэрэг олон арван зураг бүтээжээ.

1877 онд Чойнхорлин аймгийн унзад Балдангомбо, Маягийн аймгийн Хурц Цэрэндорж, хүү Ширбазар нарын хамтран бүтээсэн "Гомбо Шалши", "Дандарли" зэрэг нь музейд байдаг. Богд хааны ордон музейд буй "Нандув Чойжоо" хэмээх хар дэвсгэрт зураг хүрээний Сангай аймгийн алдарт зураач М.Данжины (1861-1942) "Дамдин", "Аюуш", Өндөр Жанрайсигт зориулан бүтээсэн "Арван зургаан найдан" зэрэг олон бүтээл энэ үеийн уран зургийн томоохон төлөөлөл болон үлджээ.

Алдарт зураач бурханч Тавхай Бор, Данжин, Балдангомбо, Хасгомбо, Гэндэндамба нарын Их хүрээний уран хатгамалчдыг толгойлон урласан "Гомбо махагал", "Охин тэнгэр", "Улаан сахиус", "Шалшийн ганзай", "Жигжид" зэрэг шашны урлагийн гайхамшигт бүтээлүүд бий болжээ.

Агваанщарав "Нэгдүгээр Жибзундамба"
(138x150 см, МДУМ)

Цэнд "Махагал"
(157x108 см, МДУМ)

Цагаанжамба "Гүнжинлхам"
(77x107 см, МДУМ)



Дамба "Заяын хүрээ"
(22.5x79 см, МДУМ)

XIX зууны эцэс, XX зууны эхэн гэхэд монгол үндэстний зээгт наамлын урлаг оргил үедээ хүртэл хөгжиж, есөн эрдэнэс товойлгон урлах эрдэнэт хэрэглэгдэхүүнд шүтэн, тухайн үеийн уран зургийн урлагтай зэрэгцэх өндөр хэмжээнд хүрсэн түүхтэй.

Б.Шарав "Их дагина"
(110x84 см, БХОМ)

"Цамба"
(169x124 см, БХОМ)

Харин бурхан дүрслэлийн тиг хэмжээнд тэр бүрий захирагдахгүй, бодит амьдралын адал явдал, уламжлалт тоглоом хөзөр үүчүүр дээр чөлөөт сэдвээр хүн, амьтан дүрслэх, гар бичмэл номын зураг чимэглэл зэрэг уран зургийн чөлөөт хэлбэр хөгжихийн зэрэгцээгээр нууц тарнийн ёсны сэдэвт зураг, ялангуяа егөөдөл хошигнолын аястайгаар тухайн үеэ дүрслэн үлдээх талаар Б.Шарав, Лодой, Цагаанжамба зэрэг зартай сайн зураачид төрөн гарсны дотор монгол зургийн уламжлалыг шинэчлэн хөгжүүлсэн их зураач Марзан Шаравыг онцлон тэмдэглэлтэй. Б.Шарав "Нэг өдрийн явдал", "Үрс гарч байгаа нь" зэрэг бүтээлдээ монголчуудын амьдралын утга учрыг гайхамшигтай дүрслэн илэхийлсэн бол, "Лувсандондов лам", "Балдан Гачин", "Наймдугаар Богд Жавзандамба", "Эх дагина" зэрэг хөрөг бүтээлээрээ монгол зурагт шинэчлэл хийж, дорвитой хувь нэмрээ оруулсан юм.

Б.Шарав "Үрс гарч байгаа нь"
1911-1919 он
(135x170 см, МДУМ)

Энэ үед Сүнгийн уран Намсрайн 1918 онд бүтээсэн "Пагва лам Лодойжалцаны хөрөг", нэр нь үл мэдэгдэх зураачийн "Долоон хошуу данщиг" Жүгдэрийн "Их хүрээ, Дамбын Заяын хүрээ", Г.Доржийн "Сайн ханы хүрээ" бүтээлээс үзэхэд хот, байгалийн зургийн төрөл амжилттай хөгжжээ. Эрдэнэзуу хийдээс Дэндэвийн хуулж ирсэн Автай сайн ханы хөрөг өдгөө Дүрслэх урлагийн музейд бий. Монгол оронд байсан 75О гаруй сүм хийдээс үлдэж хоцорсон арваадхан сүм хийдийн ханы туурганы зураг монгол зургийн алдартай дурсгалыг хадгалж байгаагийн дотроос Эрдэнэ зуу музей дэх "Аюуш", "Улаан сахиус", "Цамба" бурхны хангагч эрдэнэ зэрэг бүтээлүүд гайхалтай нарийн ур гүйцэтгэлгээ, цэцэн мэргэн зурааслаг бүтээлийг Долдугаар ширээт лам Лувсандагвадаржаа бүтээсэн гэдэг.

XX зууны хорь гучаад онд Азийн орнууд, түүний дотор Монголд өрнөдийн уран зургийн төрлүүд нэвтэрсэн юм. Шинэ уран зураач бүрэлдэхэд манай оронд арван гурван жил амьдарч олон арван зураач бэлтгэсэн К.И.Померанцевийн гавьяа их билээ. Түүний шавь Л.Гаваагийн "Шарын шашин", Ү.Ядамсүрэнгийн "Чойбалсангийн хөрөг", "Ударник Ичинхорлоо", "Өвгөн хуурч", "Д.Сүхбаатар", О.Цэвэгжавын "Азаргын ноцолдоон", "Эмнэг сургалт", "Ууланд", Л.Гаваагийн "Алтайн уулс", "Булган гол", "Кино механик", Н.Цүлтэмийн "Талын айл", Л.Намхайцэрэнгийн "Заг", "Тоглолтын өмнө", Г.Одонгийн "Ажлын дараа", А.Сэнгэцохиогийн "Марзан Шарав", Б.Чогсомын "Хорго", "Тайхарын дэргэд", "Говьд", С.Дондогийн "Хуурч Жамьян", "Мөр", "Говьд", Б.Гомбосүрэнгийн "Шинэ цагийн ээзд ирлээ", Д.Амгалангийн "Жаахан шаргын нутагт", "Улаан тоос", Г.Дунбүрээгийн "Монгол

Ү.Ядамсүрэн "Өвгөн хуурч"
(1958 он, 79х59,5 см, МУЗГ)

О.Цэвэгжав "Азаргын ноцолдоон"
(МУЗГ)

транс" зэрэг дорвитой бүтээл гарсан юм. Дал наяад онд залуу уран бүтээлчдийн эгнээ тэлж, манай зураачид бодит дүрслэлээс болзолт хэллэг лүгээ чиглэн, сэтгэлгээний урлаг, модернист чиглэлээр эрэл хайгуул хийж Ё.Өлзийхутагийн "Талын ээзд", Монгол улсын Төрийн шагналт зураач Б.Пүрэвсүхийн "Талын баатрууд", До.Болдын "Усчин" гээд олон бүтээл гарчээ.

Д.Дамдинсүрэн "Адуучин"
1952 он
(73,5x135 см, МУЗГ)

Г.Одон "Ажлын дараа"
(1953-54 он
МУЗГ)



Л.Гаваа "Кино механикч"
(МУЗГ)

Д.Амгалан "Улаан тоос"
(МУЗГ)



А.Сэнгэцохио "Марзан Шарав"
(1962 он, 85x70 см
МУЗГ)



Б.Чогсом "Тайхарын дэргэд"
(МУЗГ)

Н.Цултэм "Талын айл"
(МУЗГ)

90-ээд оноос Монгол улсын төрийн шагналт зураач Ц.Цэгмидийн "Сартай шөнө", "Салхин сүүдэр", "Цагаан зохиомж", "Тэмээн гүрвэл", Ц.Энхжаргалын "Улааныхан, харынхан", "Морин төвөргөөн", Ц.Энхжингийн "Нүүдэл", "Цонх" Ч.Болдбаатарын "Транспозиц-11", "Зохиомж" бүтээлүүд нь монголын уран зурагт олонургалч байдлын нөхцөлд янз бүрийн үзэл баримтлал, арга барил, дэг сургууль, урсгал чиглэл чөлөөтэй нэвтэрч байгааг харуулав. Сүүлийн үес Ц.Ганхүү, М.Эрдэнэбаяр зэрэг олон арван залуу зураачид уран бүтээлийн үзэсгэлэнтэйгээ түрэн орж ирлээ.

Дүрслэх урлагийн бие даасан төрөл болсон зураасан зургийн урлаг Монгол нутагт нэн эрт үүсэж, хөгжсөөр өнөө хүрсэн юм.

Азийг төрөлжин салбарлаагүй нийлэг (синкретик) урлагийн хэвлий гэвээс зураасан зургийн эх үндэс болсон ГовьАлтайн Цагаан гол, Өвөрхангайн Тэвшийн хадны зураг, Архангайн Чулуутын хадны зураг гэх зэрэг хэдэн километр үргэлжилсэн хадны зургийн цогцолборуудаараа Монгол улс хамгийн баялаг нь болно.

Дээд чулуун зэвсгээс, шинэ чулуу, хүрлийн үеийг дамжсан хадны зураг дүрслэлд гурван тивийн байгуулалтыг зураглан дүрсэлсний үндсэн дээр бүхий л чулуун хөшөөний эх загвар, уран сайхны тэмдэгзүй бүрэлджээ.

Хадны зураг эртний бичиг үсгийн үүсвэр бөгөөд дохио тэмдгийн үүрэг гүйцэтгэдгээр нь Төв Азийн нүүдэлчид хадны зургийг бичиг, тухайн хад, агуйн зургийг бичиг буюу бичигт хэмээн нэрлэсээр иржээ.

XIV зууны үед Чойжи-одсэр "Бурхны арван хоёр зохионгуй" номоо эртний Энэтхэгээс уламжлалтай жатака буюу цадиг хэлбэрээр бичиж модон бараар дармалласнаас гадна гар бичмэлээр хичээнгүй,таталган, самнаа, хураангуй, сунган бичих

С.Саранцацралт "Хайр"
(1989 он, 126x100 см, МУЗГ)



Ц.Цэгмид "Орхон"
(1993 он, 200x191 см, Фукуокагийн Азийн дүрслэх урлагийн музей)

До.Болд "Одот тэнгэр"
(1990 он, 164x215 см, МУЗГ)



Говь-Алтайн Цагаан голын хадны зураг

зэргээр уран гоё үсгийн төрлийг дэлгэрүүлж байсан мэдээ монголчууд зурагтай ном хэвлэсэн хамгийн эртний дурсгал болно. XVII-XVII үед бурхан шашны судар, шастир их хэмжээгээр хэвлэгдэж, номын зураг чимэглэл дэлгэрснээр барахгүй, ардын гоёл чимэглэлийн урлагийн бүхий л арга, алт мөнгө, есөн эрдэнээр номыг бүтээх болсноор өдгөө Монгол улсын номын бүхэл бүтэн музей бий болжээ.

Тэдгээрийн дотор XVIII-XIX зууны зурагт "Молон тойны судар", "Тамын зурагт ном", XIV зууны үед Чойжи-Одсэр "Бурханы арван хоёр зохионгуй" гэдэг номоо эртний Энэтхэг зохиолчдын "Жатака" монголоор (цадиг) маягаар бичсэн бөгөөд зурагтай ном хэвлэсэн анхны ном байлаа.

Перс-Монголын зургийн арга барилыг тод өгүүлэх баримт бол Рашид-ад-Дины "Сударын чуулган" номын зураг болно. XVII-XVIII зууны үед бурханы шашны ном зохиол их хэмжээгээр хэвлэгдэж, номын зураг чимэглэлд олон янзын арга барил дэлгэрч, ялангуя ардын гоёл чимэглэлийн урлагийн бүхий л төрлийг хамарсны дотор хар дэвсгэр дээр есөн эрдэнэн дээр хэмэрлэг будгаар бичих, бүр цаашлаад мөнгөн хуудсан дээр алтаар товойлгон урлахаас судар, шастирын тахилын хуудасны хоёр талд бүхэл бүтэн бурхан шүтээн товойлгон сийлбэрлэж алтдан урлах хэмжээнд боловсросныг "Жадамба", "Сандүйн жүд" зэргээс үзэж болно.

"Дээрээс тогтоосон дүрс нэг бүрийг бүртгэсэн бичиг", Тамын зурагт ном" (Цэвэлванчигдорж), "Хутагт Молон тойны эхийн ачийг хариулсан судар" зэрэг олон судар, шастирт эртний модон барын уламжлалыг сэргээн хөгжүүлжээ. Тэдгээрийн нэг "Элбэг олон үгт, алиа хиа Сандагийн хэлсэн үг оршвой" хэмээх 17 зохиол цөм зурагтай гар бичмэл ном Санкт Петербургийн Азийн ард түмний хүрээлэнгийн хөмрөгт хадгалагдаж байна.

XX зууны хорь гучаад он бол "Монголын Үнэн" сонины анхны дугаарт гарсан зураач Б.Шаравын "Уриа" зургаар эхэлсэн хэвлэлийн зураасан зургийн хөгжил 1921-24 онд зурагт хуудасны төрөлд дорвитой бүтээлүүд гарч, зохиолч С.Буяннэмэх зөвлөж байв.

Тавиад онд Д.Чойдогийн "Барилгачин Намсрай", Д.Лувсанжамцын "Монгол улс" зэрэг зурагт хуудас гарч тухайн үеийнхнээ хөдөлмөр бүтээлд уриалан дуудаж байв.

Орчин үеийн монголын зураасан зураг жар, далаад оноос мод, хулдаас, чулуун барын суурь, зураасан зураг, зурагт хуудас, шог зураг, монотип зэрэг шинэхэн төрөл зүйл, арга хэрэгслээр баяжиж, Б.Балдангийн "Мөөг түүгч", "Эртний баатар", Ц.Доржпаламын "Өвгөний хөрөг", "Эрэгтэйн хөрөг" мөн модон бараас аваад Д.Амгалангийн "Сайн байна уу ээж ээ", "Атарт", "Уралдаан", "Бэлчээрт", "Сургуульдаа", С.Нацагдоржийн "Лимбэчин", "Адуун сүрэг", "Унага", зураач С.Жамцын "Айраг" хулдаасан барын зургууд, О.Нямсүрэнгийн "Голын дэргэд", "Адуучин" зэрэг чулуун барын зургууд, А.Гүрсэд, В.Одгийв нарын шог хошин зургууд нь нүүдэлч малчдын ажил амьдралын тухай олон түмний зүрх сэтгэлд хүрсэн бүтээлүүд болсон юм.

Наяад оны монголын зураасан зурагт урьдын уламжлалыг гүнээ эрхэмлэхийн сацуу төмөр бар, холимог техник, монотипийн аргаар урлан бүтээх хандлага залуу уран бүтээлчдийн авъяас билиг дайчилж Д.Гунгаагийн "Гурван үе", Он зууны алдартнууд", "Борооны дараа", О.Дарамбазарын "Түүхийн хуудас", "Говь Хянганы замаар" зэрэг эх орноо батлан хамгаалах тухай сэдэв, Р.Алтанхуягийн "Газар, тариа, талх", Я.Оюунчимэгийн "Гийнгоо", О.Дарамбазарын "Амьдрал" зэрэг аж байдлын сэдэвт төмөр барын бүтээлүүд, М.Бүтэмжийн "Монгол", С.Төгс-Оюуны "Хүнд жилүүдийн дуртгал" монотип, Ц.Байды С.Цогтбаяр зэрэг авъяаслаг шог зураачдын бүтээл үзэгчдийн нүдийг хужирлаж, сонорыг мялаажээ.

Ардчилалын Цагаан морин жилээс хойш монголын зураасан зургийн уран чадвартнууд уран бүтээлдээ чөлөөт сэтгэлгээг эрхэмлэх болж, шинэ эрэл хайгуул хийсээр байна.

Л.Батчулуун

С.Уранбилэг
Э.Амарбилиг

Д.Амгалан "Ээжээ сайн байна уу"

Д.Гунгаа "Газар дэлхийн түүх"

УРАН БАРИМАЛ

Эртний буган чулуу, хүн чулуунаас аваад уран барилга, хөшөө пайлуур, жижиг чагц бурхнаас аврага том гуулин хөөмөл цутгамал, шавар баримал, аймшигт догшин дүртэй цамын шуумал баг, ардын аж байдлын жижиг дүрс, үнэт чулуу, яс модон сийлбэр хүртэл Монголын уран баримал маш олон төрөл зүйлээс бүрдэж байна.

Бидэнд мэдэгдэж байгаа нэн эртний уран баримлын дурсгал гэвэл Дорнод аймгийн Норовлин уулнаас олдсон чулуун онго юм. Уртаараа 22,5 см, өргөнөөрөө 4 см, гонзгой зууван хэлбэртэй, цайвар саарал өнгөтэй, том нүдийг хонхойлгон, хамар амыг зураасаар тодруулсан энэ онгоныг судлаачид чулуун зэвсгийн сүүлч үеэр төв Азиар нутаглаж байсан эртний палеоазиат маягийн хүн гэж магадалж байна.

Өрнө Еврази, Төв Азийн нутгаар өргөн дэлгэрсэн бугын дүрст урлагийг амьтны загварт урлаг гэж нэрлэн, дүрслэлийн шинж байдлаар нь хэд хэдэн төрөл болгож хуваадаг. Монгол улсын нутагт таван зуугаад буган чулуу байдгийн ихэнх нь хойт, баруун хойт зүгт тархмал байна. Дунджаар 3-5 метр өндөр, 50-60 см өргөнтэй, түүнийг тал хуваасны дайтай зузаан хавтгай дөрвөлжин саарал, шаргал голдуу өнгийн засмал боржин чулуун дээр хонхойлон цоолтворлож гаргасан бугын сүүдэр дүрс нэлээд уран бөгөөд тод сайн харагддаг юм.

Чулуун зэвсгийн үеэс үлдсэн хадны сүг зураг дээр балар эртний хүмүүс дэлхий ертөнцийг дээд-тэнгэр, дунд-газар, доод-лус гэсэн гурван тивийн байгуулалтаар төсөөлөн ойлгож, түүнийгээ нар, сар, туурайт амьтад, могой, загасны дүрсээр төлөөлүүлэн тэмдэглэдэг байв.

Дулааны говийн шинэ чулуун зэвсгийн дурсгал

Цагаан агуйн хуучин чулуун дурсгал

Рашаан хадны хуучин чулуун дурсгал

Чулуун хонь (МДУМ)

Чулуун хөшөө (Говь–Алтай аймгийн Чандмань сум)



Буган хөшөө
(Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Уушигийн өвөр)

Төмөрийн түрүү үеийн дурсгал хүрэл чичлүүр хутга, амьтны загварт баримлууд
(Увс аймгийн Улаангом сум, Чандманий булш)

Тэр ёсоор бугын чулууны дээд хэсэгт амьдралын эх булаг болсон нарыг дүрсэлж, дундуур нь удам гарвалийн сүлд, эх болсон буга, бусад туурайтан амьтдыг дүрсэлж, доод хэсэгт энэ бүгдийн эсрэг тал үхэл мөхлийн тэмдэг болсон нум сум, хутга, илд зэрэг хөнөөх зэвсэг дүрсэлсэн нь ертөнцийн мөнх эргэх хөдөлгөөнийг илэрхийлсэн санаа юм.

Аргын тооллын өмнөх II мянган буюу хүрлийн үед хүмүүс нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг, төмөрлөг хайлуулдаг болж Төв Азийн урлагт амьтдыг голчлон дүрсэлдэг амьтны загварт урлагийн өвөрмөц чиглэл бий болсон нь уран баримал дээр мөн л өргөн дэлгэрсэн байна.

Давхарласан хүрэл морь
(Баянхонгор аймгийн Бууцагаан сум, Баянхонгор аймгийн музей)

Чонын дүрслэлт хүрэл арал
(Өвөрхангай аймгийн Гучин-Ус сум, Ц.Батсайханы хувийн цуглуулга)

Буган хөшөө
(Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум, Цагаан гол)

Амьтны загварт хүрэл баримлууд
(ДГАМ)

Хүрэл чонын толгой
(Төв аймгийн Хараагийн
Ноён уулын булш,
МҮТМ)

Янгирын толгойн
чимэгтэй хүрэл илд
(Өмнөговь аймаг,
МДУМ)

Хүрэл хүн онго
(С.Бадралын хувийн
цуглуулга)

дээлэн дээр ялтастай бүс бүсэлсэн, баруун ташаандаа хавтага, зүүндээ чичлүүр хутга зүүсэн, баруун гараа нугалж хундага аяга энгэр тушаагаа барьсан, зүүн гараараа бүс, хутганыхаа бариулаас барьснаар дүрсэлсэн байдаг.

Энд баатар эрсийн цогцсыг оршуулж, тэдний хөргийг чулуугаар үйлдэн, өмнө нь нэг, хоёр эгнээгээр газарт зоосон "бал бал" гэдэг олон чулууг түүнд ялагдсан дайсны тоогоор босгодог байжээ гэсэн мэдээ бий.

Ганц нэгээрээ буюу хос, мөн олноороо нэг доор байдаг эдгээр хүн чулуу нь тухайн цагийн баримлын урлаг, уран сайхныг төдийгүй, тал, хээр нутгийн байдалд нийцүүлэн бүтээсэн Төв Азийн нүүдэлчдийн урлагийн сонгодог дурсгал юм.

Тэр нь Монгол газар төвлөрч, Өмнө зүгт Хятадад, умар зүг Сибирт нэвтэрсэн гэж судлаачид үздэг. Эдгээрээс гурван мянгаад жилийн өмнөх үед хамаарагдах "Скифийн буга" гэдэг олон салаа эвэртэй, шувууны хошуу мэт шөвгөр хоншоортой, сэрвээн дээрээ бөх мэт овгортой бугын дүрс ч Ази тивийн төв Монгол оронд үүсэж дэлгэрсэн нь ялангуяа уран баримлын төрөлд гол сэдэв болж байжээ. Ноён уулын булшнаас Хүннүгийн үеийн эд агуурс, урлагийн олон зүйл гарсны дотроос дугариг хэлбэртэй мөнгөн ялтсан дээр товойлгож хөөгөөд алтадсан ингэмэл мөнгөн онгон дээр хангай нутгийн ойд зогсож байгаа савга үс нь сагсайсан сарлагийг ямар нэгэн хүний хөрөг мэтээр нүүрийг эгц өмнөөс сүртэй байдлаар харуулсан нь энэ гүрний аль нэгэн тэргүүлэх омгийн онго бололтой.

Хуягласан морьт цэргүүд
(Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Цамбагарав уулын
Хар хадны зураг)



Хүн чулуун хөшөө
(Сүхбаатар аймаг, Хөнт-Ухаа)

Ясан дээр сийлсэн эмээлтэй морь
(Төв европ, Югослав)

Бор нурганы хүн чулуу
(Увс аймгийн Давст сум)

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дахь эртний нэгэн булшнаас мөн товойлгож цохисон хүний хөрөг бүхий зоос мэт жижиг алтан чимэг зүйл олдсоныг хүннү нарт хамааруулж үздэг.

Эртний улсуудын дотроос манай газар нутагт уран баримлын хамгийн баялаг дурсгал үлдээсэн улс бол түрэг юм. Тэд эртний буган чулууны адил хэмжээний хэдэн зуун хүн чулуун хөшөөг Алтай, Хангайн нутгаар үлдээсэн байна. Түрэгүүд хүн чулууг өвөг дээдсийн шарил дээр наран ургах зүг харуулан босгохдоо гол төлөв шовгордуу хэлбэрийн оройвчин малгайтай, зөв тийшээ ташуу захтай

Хүн чулуу
(Баян-Өлгий аймгийн Ногооннуур сум)

Тусгайдаа олдсон Кюльтегиний хөрөгт жигүүрээ дэлгэсэн бүргэд шувууны дүрс, сүлд сийлсэн өндөр малгайтай, дөч эргэм насны эрэлхэг зоригтой шийдэмгий, хатуужилтай, дайчин баатар эрийн дүрийг гаргасан байна.



Овгор Хяргасын хүн чулуу (Увс аймгийн Хяргас сум)

Төв Азийн эртний улсуудын дотроос VIII-IX зууны үед мандаж байсан Уйгурын хөшөө дурсгалууд манай нутагт цөөнгүй буй. Архангай аймгийн Хотонт сумын нутаг, Орхон голын зүүн хөвөөн дээрх Хар балгасны ойролцоо 745 оны үед уйгурын хаан сууж байсан Алп-Кутлуг Улуг Билгэ тэргүүтэн 6 хааны баатарлаг үйлсийн тухай өгүүлсэн түрэг, согд, нанхиад бичигтэй гэрэлт чулууны хэлтэрхий байдаг. Цагаан саарал боржин чулууны дээд ирмэгийг засч хүрээн дагуу зэрэгцсэн гурван луут Хятадын уламжлалт дүрслэлээс эрс өөр, гүрвэлийн маягтай, талын хүмүүсийн төсөөлдөг эртний хэлбэрээр дүрсэлснээрээ онцлог байна. Мөн тэрчлэн Сэлэнгэ мөрний Байбалыгийн балгасаас олдсон, одоо Байгалийн түүхийн

Хүн чулуу бүтэн босоо, цээж голдуу байдаг боловч Булган аймгийн Могод сумын Асгатын хөшөө нэлээд өвөрмөц юм Том хавтгай саарал чулуун дээр гурван хүнийг ингэмлээр товойлгон цохиж гаргаад дээр нь шувуу, янгирын дүрс тэмдэг, доогуур нь зөрж гурвалжилсан хамар угалзаар чимэглэсэн байна. VIII зууны буюу Орхоны Түрэгийн үед хамаарагдах уран баримлын хоёр том цогцолборын нэг нь Налайхын ойролцоо байдаг Тоньюкукийн хөшөө, Архангайн Хашаат сумын Хөшөө цайдамд байдаг Кюльтегин жанжны бунхны иж бүрэн дурсгал юм. Цайдмын цогцолборыг үзэхэд гадуураа 2 м гүн сувагтай, дээрээ ваарaн хучлагатай, 1 м зузаан шавар ханаар хүрээлэгдсний дунд 12 баганан тулгуур бүхий хоёр давхар барилга дотор гантиг чулуугаар цоолтворлож хийсэн Кюльтегин, түүний хатан, суугаа, босоо бусад хэд хэдэн хүний баримал байжээ.

Шатар чулуу
(Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сум)

Бугатын гэрэлт хөшөө
(ААМ)

Моюунчурт зориулсан гэрэлт хөшөө
(Булган аймгийн Сайхан сум)

Хүн чулуу
(Булган аймгийн Ингэт толгой)

Луун чимэглэлт гэрэлт хөшөө
(Архангай аймгийн Хотонт сум)

музейд байгаа хүрмэн чулуун хоёр арслан уламжлалт дүрсээс өөр, илүү эртний маягтай, их тоймлог, цэвэр Төв Азийн хэлбэртэй байгаагаараа содон юм.

Санкт Петербургийн "Эрмитаж"-д байгаа "Чингисийн чулуу" Монгол улсын Үндэсний түүхийн музейд байгаа Мөнх хаанд зориулсан гэрэлт хөшөө бол Монгол бичиг сийлсэн нэн ховор дурсгалууд бөгөөд Хархоринд байгаа алдарт чулуун мэлхий ч тийм хөшөөнд зориулсан суурь юм. Чита хотын ойролцоо байдаг Хөндийн ордны хоёрдугаар давхартай холбосон хайсанд боржин чулуугаар сийлсэн луу, матрын толгойг суулгасан нь тал нутгийн уран барилгын түүхэнд урьд тохиолдоогүй шинэ үзэгдэл болжээ.

Хүн чулуу
(Өвөрхангай аймгийн Уянга сум)

Монгол гүрний үед холбогдох уран баримлын зүйл ховор үлдсэн боловч хүн чулуу, бичигт пайлуур, уран барилгын чимэглэл, чулуун цоолтвор баримлын зүйл мэр сэр байна. Сүхбаатар аймгийн Дарьганга суманд байдаг хүн чулуунуудыг урьдах үеийн баримлалтай харьцуулахад малгай хувцас, зүүлт, чимэгнээс эхлээд, түшлэг, тохойвчтой суудал дээр сандайлж суулгасан зохиомж эрс өөр байдалтай хийц ажиллагаа ч нарийн байдаг.

Чулуун бар
(МҮТМ)

Сац суварга
харуулын цамхагийн чимэглэл,
ингэмэл хагас товгор баримал
(ӨМӨЗО-ны Хянганы нурууны орчим)

Урьд хөлөө цээжиндээ эвхэж үсрэхээр мяраажхэвтэх маягтай хөдөлгөөнөөр толгойг гадагш харуулан цухуйлгасан 150 ийм луу байснаас 102 нь олдоод байна.

Хүн чулуу (МҮТМ)

Ийнхүү төв Азийн нүүдэлчид, эртний улсуудын үед бүтээн цогцлуулсан соёл урлаг өргөн хүрээтэй байсны дотроос уран баримал бүх талаараа биеэ даасан төрөл болон хөгжиж, бүтэн, хагас баримал зузаан, нимгэн төвгөр, ингэмэл зэрэг олон хэлбэрээр зуу зуун жилээр халуун, хүйтэн, нар, салхинд тэсвэрлэн Монголын эрс тэс цаг улиралд зохицсон урт настай чулуун цоолтвор баримлын төрөл зонхилж хөгжсөн онцлогтой байна.

XVI зууны хоёрдугаар хагасаас Монголд хүчтэй дэлгэрсэн буддын шашин, түүний олон сүм хийд, бурхан дүрслэл Монголын уран баримлын бүх төрөл салбараараа хөгжихөд ихээхэн нөлөө үзүүлсэн юм.

Чингис хаан ба Өгөдэй хааны зөвлөх сайд Юлай Цуцайн чулуун хөшөө (БНХАУ, Бээжин хот)

Монголын зураач урчууд хүний биеийн харьцаа хэмжээнээс аваад бурхан дүрслэхтэй холбогдсон онолын бүх асуудлаар хоёр мянгаад жилийн тэртээ бүрэн боловсорсон эртний Энэтхэгийн урлахуй ухаан, уран сайхны мэдлэгийг эзэмшсэн байсан гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Чулуун мэлхий (Өвөрхангай аймгийн Хархорин сум)

Хархорины малтлагаар олдсон хоёр эмэгтэйн толгойн дүрс хэдийгээр жижиг боловч Монгол гүрний үеийн бодит уран баримлыг төсөөлөхөд нэмэр болж байна, Зөөлөн инээмсэглэлээр уруулаа дутуу жимийж, цэцэгтэй хэлхээ чимэг үсэндээ зүүсэн даруу том нүдтэй баясгалант царайтай энэ эмэгтэйн дүр Турфаны уйгурын баримлын урлагийн уламжлалт сургуулийг санагдуулдаг. Нөгөөх нь бүүр ч зөв харьцаатай сайхан монголжуу царайтай эмэгтэйн дүр юм. Энэ хоёрын аль аль нь буддын бурхан дүрслэлийн дагина, бодисадын тиг хэмжээнд баригдаагүй жинхэнэ бодит хүний дүрийг гаргаснаараа тухайн цагийн монгол баримлын уран чадварыг харуулахад тусалж байна.

Амитаба (Хүрэл алт шармал)
ДУМ

Хэдийгээр бурхан дүрслэлийн үндсэн онолын хувьд, Энэтхэгийн сургаалыг баримталж байсан болович жинхэнэ урлан бүтээх дэг сургуулийн хувьд хожуу үеийн Түвэдийн уран дүрслэлийн тиг номыг (канон) шүтэн дагаж байсан нь ойлгомжтой. Тэгэхдээ манай өнгөрсөн үеийн шашны урлагийг бүхэлд нь зөвхөн харийн урлаг соёлын хуулбар төдийгөөр өрөөсгөл үзвэл ихэн эндүүрэл болно.

Ногоон Дара-Эх
(МДУМ)

Монголчуудын түвэд хэлээр бичсэн олон зуун боть зохиолын дотор уран барилга, дүрслэх урлагийн төрлөөр Монгол эрдэмтэн лам нарын зохиосон ном, бүтээл арвин байдаг юм. Тэдгээр олон мэргэдийн дотроос уран бүтээлээрээ тодорч, Монголын шашны сонгодог урлагийн дэг сургуулийг үндэслэгч нь Чингисийн угсааны сурвалжтай, Халхын Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазар (1635-1723) юм. Өндөр гэгээн Г.Занабазар "Номын Их Хүрээ" (одоогийн Улаанбаатар) "Баруун хүрээ", "Төвхөн" зэрэг Төв

Майдар
(МДУМ)

халхын алдартай хийдүүдийг үндэслэн байгуулж, Монголын "Соёмбо бичиг" зохиож, хэл, уран зохиол, дүрслэх урлагийн хэд хэдэн төрөл дээр гарамгай бүтээл туурвисан шашин-соёлын нэрт зүтгэлтэн байв. Занабазар урлагийн олон төрөл дотроос уран баримал дээр онцгой тодорч, 1680-аад оны үед Их Хүрээний гол шүтээн "Очирдар", "Язгуурын таван бурхан", "Хорин нэгэн Дара эх", том хэмжээний "Цэвэгмид" тэргүүтэн алтан цутгамал маш олныг бүтээсэн тухай түүний түүх намтарт бичсэн байдаг. Мөн цаашилбал Их Хүрээний таван нандин гэж алдаршсан эхийн "Зуу" (Будда),

Өндөр гэгээн Занабазарын хөрөг
XVII-XVIII зуун
(Богд хааны ордон музей)

"Аюуш", "Намсрай", "Манал", "Барайшир" (Сосорбарам), Эрдэнэ зуу хийдэд байсан магнай дээрээ хумсны толионы дайтай сувд шигтгээтэй "Очирдар", баруун Хүрээний гол сахиус "Махгал", гурван настай хүүхдийн дайтай "Хажид" зэрэг Халх даяар цуутай хэдэн бүтээлээс бусдыг одоогоор тодорхой бүртгэж гаргаагүй байна. Гандантэгчэнлин хийдийн гол шүтээн, Занабазарын бүтээсэн Очирдар бол тарнийн ёсны бясалгалын бурхан бүгдийг хураангуйлан цогцолсон дээд бурхан бөгөөд аргыг очир, билгийг хонхоор төлөөлүүлсэн хоёр мутраа зөрүүлсэн нь арга, билиг салшгүй гэсэн санааг илэрхийлжээ. Занабазарын Очирдар, Язгуурын тав, бусад бурхадыг харахад үс гишүүн тэгш чийрэг, залуу мяраатай, маш зөөлөн тэгшхэн мөртэй, шулуун мөчтэй, бөөрөнхий бэлхүүстэй гэх зэргээр тэмдэглэдэг бурханы биеийн дүрслэлийн гучин хоёр бэлгэ, наян найргийг багтаасан жинхэнэ гоо сайхан хүний байдлаар дүрслэгдсэн байдаг. Занабазар хүний биеийн харьцааны талаар Данжуурт заасан сургаал номын дагуу гол төлөв эртний Энэтхэгийн "Дашатала" гэдэг арван алганы харьцаа хэмжээгээр бүтээлээ урлаж байжээ.

Ер нь хүнлиг энэрэнгүй үзэлтэй орон орны суут бүтээлчдийн нэгэн адилаар хүний орчлонд дүүрэн байдаг аливаа нүгэл хилэнцийн үндсийг арилгахын төлөө цуцалтгүй тэмцэл хийж бүтээсэн Занабазарын Очирдар, Язгуурын таван бурхан, Дара эх, бусад олон бүтээл нь муу бүхнийг ялах дотоод хүчний ялалтыг илэрхийлсэн лам хувраг хүний чин сүжигт бишрэлийн дуулал байсан учир монголын зураач, баримлчид гурван зуун жилийн туршид түүнээс суралцаж, сонгодог сургуулийг нь үлгэр болгон үргэлжлүүлсээр ирсэн юм.

Өндөр гэгээнтний дэг сургууль дээр тулгуурласан монголын баримлчдын хүрэл, зэс, гуулиар цутгасан Будда, Авалокитешвара, Аюуш, Манжушри, Цагаан, Ногоон Дара эх тэргүүтэн олон бурхад, суврагууд нь эргэн тойрсон битүү бадраатай дугариг голдуу суурьтай, биеийн харьцаа хэмжээ зөв тохирсон, төв байдалтай, илүү чимэг багатай, хүний хараа сэтгэлд хоногших уран сайхны өвөрмөц чанараараа хэзээд ялгаран танигддаг юм. Харин XVIII зууны II хагасаас газар сайгүй байгуулагдсан олон хийд, дуган, сүмийн шаардлагаар гарч ирсэн тоо томшгүй бурхан тахилын хэрэгслийг Долонуур зэрэг умард Хятадын хотуудад олноор захиалан хийлгэдгээс болж, урлагийн хийц чанар нь ч эрс суларсан байна. Ялангуяа Их Хүрээний Майдар, Жанрайсэг гэх мэтийн зэс, гуулин хуудсаар хөөж өнгө шарлуулсан том хэмжээний бурхад харьцаа хэмжээ муутай, монгол урлагийн шинж чанар бага тусгагдсан, зөвхөн шашин шүтлэгийн шаардлагын дагуу хийгдсэн зүйлүүд байлаа.

Аливаа дуган, сүмд хөдөлбөргүй байх гол бурхан шүтээн, дөрвөн Махаража зэргийг гол төлөв муутуу цаас хольж биежүүлсэн шавраар уг байран дээр нь шаваж бариад, гадаргыг байтуудан цардаж, энгийн будгаар ялган будаж, заримыг алтадсан байдаг. Харин шавар урлагийн талаар тэмдэглэлтэй зүйл бол томоохон хийд, хүрээ, нөлөөтэй том лам, хутагт хувилгаад жижиг чагц бурханыг олноор хийж, өөрийн шавь нар, өглөгийн эзэд тараадаг байсан нь монголын бага хэлбэрийн баримлын урлагийг ихэд баяжуулсан юм. 1-10 см хэмжээний дугариг, гонзгой хэлбэрийн талбай дээр догшин дүртэй Чойжин сахиус, насны гурван бурхан, бусад олон бурхадыг маш уран чадварлагаар зохион байрлуулсан эдгээр ингэмэл медальонууд тусгай жижиг гуунд хийж хүзүүнээсээ зүүхэд зориулагдаж байжээ. Гуулин хэвэнд дарж олшруулсан эдгээр нарийн уртай миниатюр ингэмлүүдийн заримыг өнгөөр ялгаж, алтадсан байх нь ямар ч том бүтээлээс ялгагдахгүй биеэ даасан урлагийн төрөл байв.

Уран баримлын бас нэг томоохон төрөл болсон цаасан шуумал нь том, жижиг, бүтэн баримал, ингэмэл болон гол төлөв цамын баг хийхэд тохиромжтой байжээ. Нэг иж бүрэн цам гэхэд Чойжин сахиус голдсон зуугаад бурхан, амьтдын баг шаардагдана. Хүрээ цамын шинэ багууд ерөнхийдөө магшгар дөрвөлжин хэлбэртэй, тиг харьцааг зөв олсон сахиус бурхад, хүн, амьтдын дүрийг үнэмшилтэй сайхан гаргасан байдаг. Тэдгээрийн дотроос Тавхай борын урласан Жамсрангийн (Бэгзийн) багийг цаасаар шууж, гадуур нь нүүрний мах булчингийн ширхэг дагуу том жижиг улаан шүрээр битүү шигтгэж урласан нь хосгүй сайхан урлаг болсон бөгөөд иймэрхүү хэд хэдэн баг одоо Улаанбаатарын музейнүүдэд хадгалагдаж байна.

Бурхан багш хоёр шавийн хамт XIX зууны сүүлч (Чулуун цоолбор, БХОМ)

Шашны уран баримлд холбогдох нэг сонин төрөл бол тосон баримлын урлаг юм. Шарын шашны бурхан сахиусанд өргөдөг гурилан балин дээр тосоор хийсэн цэцэг, навч, эрдэнэ, хүн амьтны дүрсийг дагнаасаар алаглуулан нааж, хажуу ирмэгээр нь бадарч байгаа галыг мөн өнгө алаглуулан нааж маш гоёмсог баримал урлаг болгодог байв.

Монгол үндэсний дуу хөгжим, уран зохиол, уран зураг дээр шашны урлагийн зэрэгцээгээр ардач чиглэлтэй иргэний урлаг биеэ даасан байдаг ёсоор уран баримлд ч мөн тиймэрхүү бага хэмжээний ардын урлагийн төрөл байх нь мэдээж.

XIII зууны үеийн модон морь (Баянхонгор аймгийн Ламын гэгээний хийд)

Уран баримлын ойлгоц бүхий донж төрхийг тааруулсан төв хийцтэй хүн, мал, амьтны дүрсийг цаастай шавраар барих буюу модоор сийлж, өнгөөр ялгаж будсан байдаг. Дүрслэх урлагийн музейд байдаг гаанс, тамхиа барьж суугаа ноён, эрхээ эргүүлэн суугаа догшин дүртэй хатан, хөнгөмсөг зантай чинээлэг эхнэр, ажилсаг даруу цагаан сэтгэлтэй эхнэр, сүм хийдийн дуулгавартай банди зэрэг нийгмийн янз бүрийн давхаргын хүмүүсийг зан төрх, хэлбэр донжийг нь олж ёгт үнэн байдлаар дүрсэлсэн байдаг.

Монголчууд сайхан морь, хурдан хөлөг, таван төрлийн эзэг малыг сийлүүлж гэртээ тавих дуртай, сийлбэрч баримлчид нь ч мал амьтдын анатоми, үе мөчний харьцаа, хурдан, жороо морины хэлбэр, галбир, гоо сайхны бүх шинж төрхийг сайн мэддэгийн хувьд маш чадварлаг гаргасан, тэр бүхэнд нь малчин хүний хайр сэтгэл шингэсэн байдаг юм. Ардын жижиг баримлын төрөлд бараг айл бүхэнд байдаг монгол шатар зонхилох байр эзэлдэг. Ялангуяа тэдний ноён, бэрс

Чулуун арслан.
XIX-XX зууны эх эн
(БТМ)

Нэр үл мэдэгдэх ардын урчууд, баримилчдын тэдгээр бүтээл ямар нэг тиг, хэвшилд баригдаагүй, бүтээлчийн хувь шинж, уран чадварыг илэрхийлж, монгол хүний оюун сэтгэлгээ, ертөнцийг сэтгэн ойлгох үзлийг шингээсний хувьд манай уран баримлын үндэс суурь болсон жинхэнэ сонгодог урлаг мөн гэж үзэх ёстой.

XX зууны Монголд өрнөдийн соёлын нөлөө хүчтэй болж, нийгэм-эдийн засаг, улс төр, оюун санааны амьдралд гарсан огцом өөрчлөлтүүд үндэсний уран баримлын хөгжил, уламжлал шинэчлэлд гүнзгий ул мөрөө үлдээсэн билээ. Ардын хувьсгалын эхний жилүүд, ялангуяа 1930-аад оноос бурхан шашны чиглэлтэй уран баримлын төрөл зүйлүүд утга соёлын хэрэглээнээс бараг бүрэн хасагдаж, баримлын урлагт түүх, хувьсгалын сэдэвтэй хөшөө дурсгалууд зонхилох байр суурьтай болж байв.

1929 онд Улаанбаатар хотод хуучнаар Намын дээд сургуулийн өмнөх талбайд жанжин Д.Сүхбаатарын хөшөөг босгосон нь шинэ цагийн анхны хөшөөний эхлэл болжээ. Мөн халх голын ялалтын дурсгалд зориулсан дурсгалуудыг дайны талбар болж байсан газруудад босгож байв. Лам байсан залуу авьяастан С.Чоймбол 1930-аад оны сүүлчээр цэцэрлэг талбайд босгох цэрэг, эх орон, биеийн тамирын сэдэвт

тэмээ, тэрэг, морьдыг хичнээн жижиг хэмжээтэй ч байлаа гэсэн ерөнхий тойм дүрсийг олж гаргасны хувьд ямар ч хөшөө дурсгалын баримлаас дутахгүй монументаль томируун хэлбэрийг олсон байдгаараа онцлог юм.

С.Чоймбол "Д.Сүхбаатарын хөшөө"
1946 он
(Хиймэл чулуу)

уран баримлуудыг бүтээж эхэлсэн нь манай шинэ үеийн уран баримлын урлаг өөрийн гэсэн хөгжлийн чиг хандлагаа тодорхойлж болохыг харуулав.

1930-аад оны сүүлч 1940-өөд оны үед Монгол уран баримлын нэг төрөл болох сийлбэрийн урлаг ихээхэн хөгжиж байв. 1931 онд хуучны Ламын гэгээний нутгаас Өвөрмонголд дүрвэж, 1945 онд Дорноговь аймгаар буцаж ирсэн агуйн лам хэмээх хувилгаан Жамбалзундуйн дэргэд байсан бурханч, сийлбэрч Цэрэннадмид гэдэг уран сийлбэрчний сийлсэн морин хуурын толгой, чимэглэлийн сийлбэр үнэхээр хосгүй, хуурдахад мориных нь чих, нүд хөдөлдөг байсан гэлцэнэ. Уран сийлбэрч Цэрэннадмидын сийлсэн сийлбэртэй модон шатар эдүгээ Дүрслэх урлагийн музейн фондод бий. Хэнтий аймгийн нэр үл мэдэгдэх сийлбэрч савхны толгойд 4-5 мм-ийн хэмжээнд 12 жилийг багтаан уран чадмаг сийлснийг зөвхөн өсгөдөг шилээр үзэж болдог ажээ.

Х.Дагвадорж, Б.Чимид нарын гуулин цутгуурын урлал, Д.Дүйнхэр дархны хагас төвгөр хөөмөл нь тэр үеийн уран баримлын нэг өвөрмөц нарийн урлалыг илэрхийлж байв.

1946 онд зураг урлагийн газрын дэргэд уран баримлын урлан байгуулагдсан нь тухайн төрлийн урлаг цаашид амжилттай хөгжихөд чухал түлхэц болсон юм. Тэнд С.Чоймбол, Б.Чимид нарын зэрэг уран барималчид ажиллаж байв.

1946 онд Ардын Хувьсгалын 25 жилийн ойгоор уран барималч С.Чоймбол өөрийн загвараараа залуу барималч Н.Жамбаа, Д.Дамдимаа нарын хамт жанжин Сүхбаатарын морьт хөшөөг Улаанбаатар хотын төв талбайд босгосон нь орчин үеийн сүрлэг сайхан том хэмжээний хөшөө дурсгалыг бие даан бүтээж чадахыг баталж өгсөн байна. Жанжин Сүхбаатарын энэхүү хөшөө нь хуучин цагийн сийлбэр, шуумал баримлын уламжлалт дүрслэлийг өвлөн хөгжүүлсэн жинхэнэ монгол хөшөө болсон бөгөөд манай ард түмний сэтгэлд гүн их хүндэтгэлтэйгээр хоногшин үлдсэн билээ.

Дэлхийн II дайны дараа манай улсад нэг хүнийг тахин шүтэх Зөвлөлтийн загварт суртал ноёрхсоноос Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин, И.В.Сталин Д.Сүхбаатар Х.Чойбалсан нарын том, жижиг хөргийг гипсээр цутгаж улаан булан, хурлын танхим, албан тасалгаанд байрлуулдаг нь хэвшил болов.

Н.Жамбаа "Эмнэг сургагч"
(Зэс, Улаанбаатар хот)

Манай барималчид 1940-өөд оны сүүлч, 1950-аад оны эхээр нийслэлийнхээ барилга байшин, цэцэрлэг, гудамж талбай, амралт сувиллын газруудад малчин ардын сэдэвт баримлуудыг бетон, хиймэл чулуугаар бүтээж байснаас Н.Жамбаагийн "Эмнэг сургагч", "Саальчин" (1949), "Анчин" (1951) зэрэг бүтээлүүдийг нэрлэж болно. Эдгээр бүтээлд монгол хүний ахуй амьдралын үнэн дүр байдлыг тодорхой гаргасан байдаг. Мөн уран барималч С.Чоймбол, Л.Гүрдорж, Д.Дамдимаа, А.Доржготов, А.Даваацэрэн, Л.Дашдэлэг, С.Дамдинжав, Л.Махбал нарын энэ үеийн бүтээлүүд ардын хувьсгалын партизан, түүхт хүмүүсийн хөрөг дүрийг тусгаж байв. Тэдгээр хөрөг баримлуудад хүмүүсийн зан байдал, ажил үйлсийн онцлогийг тодорхой гаргаж өгсөн байна.

А.Даваацэрэн "Эцгийн гэрээс"
(Гипс)

Нэрт уран барималч А.Даваацэрэн Ленинград хотноо И.Е.Репиний нэрэмжит уран зураг, уран баримал, уран барилгын дээд сургуульд уран баримлын мэргэжлээр суралцаж ирсэн нь гадаадад төгссөн дээд боловсролтой мэргэжлийн уран барималчдын анхных нь болсон билээ. Түүний сургуулиа төгсөх үед хийсэн жанжин Сүхбаатарын амьдралын сэдэвт "Эцгийн гэрээс" хэмээх дипломын ажил нь мэргэжлийн өндөр хэмжээнд бүтээгдсэн гэж оросын судлаач үнэлсэн байдаг.

1956 онд хүрэл цутгуурын тасаг байгуулагдаж манай барималчид бүтээлээ хүрлээр цутгах болсон нь энэ салбарт гарсан нэг том дэвшил болсон байна. Уран барималч Л.Махбалын "Партизан", С.Дамдинжавын "Аавын малгай", Н.Жамбаагийн "Айраг" зэрэг бүтээл энэ үед бүтээгдсэн бодит амьдралын сэдэвт чамбай сайн ажлууд юм.

Монгол оронд нэгдэлжих, атрыг эзэмших хөдөлгөөн нэгэнт бодит үйл явдал болсон бүтээн байгуулалтын үеэс уран барималчдын ур дүрслэл өсөж, уран сайхны түвшин дээшилж, сэдвийн хувьд ч өргөжин баяжиж, хөшөө дурсгал, уран барилгын чимэглэл, хээ угалз болон гудамж талбайд босгох баримлыг хийхэд уран барималчид идэвхтэй оролцох болсон байна.

Мөн С.Доржпалам, Л.Дашдэлэг, П.Зулзага, Б.Жамъяншарав, Ү.Болд, Д.Санжаа, М.Минжир, Ч.Дашзэвэг, Ц.Доржсүрэн нар Монгол-Зөвлөлтийн ард түмний найрамдал, түүх, хувьсгал, ажилчин, малчдын сэдвээр бүтээлээ туурвиж байв.

Уран барималчдын зэрэгцээ мод, яс, чулуун сийлбэрийн бүтээлээр Д.Гэвшээхүү, Д.Дорж, С.Сэнгээ, Л.Чуваамид, Б.Жамъяншарав, Н.Лувсанцэрэн, Т.Жамбал зэрэг

олон алдартай сийлбэрчид ажиллаж өөрсдийн арга ухаанаа шавь нартаа өвлүүлж байлаа.

Энд онцлон тэмдэглэмээр нэг зүйл бол Энэтхэгээс авчирсан зааны соёонуудаар алдартай сийлбэрүүд хийсэн С.Сэнгээ, Л.Чуваамид нарын бүтээлүүдийн ихэнхийг гадаадын зочид төлөөлөгчдөд бэлэг дурсгал болгон гаргаж байсан нь харамсалтай.



Д.Санжаа "Академич Б.Ренчиний хөрөг"
(Гантиг.
МУЗГ)

Я.Уржнээ, Ц.Доржсүрэн
"Зөвлөлтийн дайчдад зохиулсан хөшөө" (Бетон)
1976 он
Улаанбаатар Зайсан толгой

Р.Энхтайваны "Баавгай", "Эмээ өвөө хоёр", "Энхийн мод", С.Бадралын "Тэмээ", Д.Батжаргалын "Савлууртай баавгай", Д.Баяраагийн "Ямаа", Х.Болдын "Олон бөхтэй тэмээ", гар урлалын үйлдвэрийн сийлбэрчдийн бүтээл, хүүхдийн паркад А.Даваацэрэнгийн урласан "Үлгэрийн баатрууд" хэмээх том хэмжээний модон баримал, сийлбэрүүд, Монументаль чимэглэлийн үйлдвэрийн хэсэг баримлачдын зэсээр бүтээсэн үлгэр гүрвэл зэрэг хот чимэглэлийн баримлууд нь хийсвэр хэтрүүлэгт хэлбэр дүрслэл бүхий сонин шийдэлтэй, орчин тойронтойгоо зохицсон чамбай сайхан бүтээлүүд болжээ. Тэрэлж дэх амралт, жуулчлалын бааз орох замд хөдөө хээр уул хадны дунд аварга том үлэг гүрвэлүүдийн баримал босгосон нь хол ойрын жуулчдын нүдийг баясгаж, эртний үлэг гүрвэлийн эх нутагт ирсэн сэтгэгдлийг төрүүлсээр байна. 1981 онд монгол хүн сансарт ниссэн нь манай баримлачдын урын санд цоо шинэ сэдэв нэмэрлэв. Энэ сэдвээр Ц.Доржсүрэн, Ц.Амгалан зэрэг баримлачид олон бүтээл хийжээ.

Р.Энхтайван "Эмээ, өвөө хоёр"
1987 он
(Хиймэл чулуу.
МУЗГ)

1971 онд Ардын хувьсгалын 50 жилийн ойгоор Улаанбаатар хотын урд хэсэгт Богд хан уулын ар хормойд орших Зайсан толгой дээр Зөвлөлтийн дайчдын дурсгалд зориулсан сүрлэг том уран барилга, уран баримлын цогц байгууламж бүхий хөшөөг бүтээжээ. Уран баримлачдаас Ц.Доржсүрэн оролцжээ. Энэхүү аварга том цогцолборыг уулын оройд байрлуулсан нь нэг талаар бодвол монголчуудын уламжлалт овоо тахилгатай төстэй боловч Зөвлөлт орны хөшөөний хэлбэр дүрслэлээс үлгэр авсан ажил болсон билээ.

1980-аад оны эхээр Монументаль чимэглэлийн үйлдвэр байгуулагдаж, хотын зүлэг талбай, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэнд чимэглэлийн орчин үеийн баримлуудыг хийх болсон нь тухайн үед монголын уран баримлад гарсан шинэлэг зүйл болов. Үүнд уран баримлач

"Монголын нууц Товчооны" 750 жилийн ойд зориулсан уран бүтээлийн үзэсгэлэнд Г.Сэрээтэрийн "Хөрөг", Н.Аргайсүхийн "Чингис", Ч.Угтаабаярын "Миний Монгол" зэрэг бүтээлүүд тавигдаж үзэгч судлаачдаас өндөр үнэлэлт авч билээ. Мөн онд тус ойд зориулж, засгийн газраас ивээн тэтгэж, боржин чулуугаар 3 м өндөр хөшөөг Хэрлэнгийн Хөдөө аралд босгов. Хөшөөнд Чингис хааны дүр, овог аймгийн тамганы дүрс, монгол бичгийг сийлжээ. 1995 онд баригдсан зураач, баримапчдын урлан нь баримапч уран бүтээлчдэд бие даан бүтээлээ туурвих сайхан боломж олголоо.

Л.Болд "Хатан"
2000 он
(Хүрэл,
МУЗГ)

Манай баримапчид 1994 онд 80 тохой өндөр Мэгжиджанрайсэг бурхныг хуучин байснаар нь шинээр бүтээн зэсээр хөөж гагнан алтдаж, эрдэнийн чулуугаар шигтгээ хийж урласан бөгөөд энэ нь сүүлийн үед бүтээгдсэн том хэмжээний уран баримал болно.

1990 оноос хойш уран баримапч Л.Болд хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан хөшөөг Үндэсний түүхийн музейн өмнөх талбайд Зураг урлал компаниас, мэлхий чулууны дурсгалыг нийслэл хотын шав тавьсан газар Төв цэцэрлэгт уран баримапч Б.Хийморь Булган аймагт Чин ван Ханддорж, Архангайд Вандан аваргын хөшөө, Улаанбаатарт ерөнхий сайд Цэрэндоржийн суугаа баримал, С.Саранцацрал "Эх" боржин чулуун баримал, Л.Ганхуяг "Ю.Цэдэнбал"-ын хөшөөг тус тус бүтээжээ.

Л.Ганхуяг "Ю.Цэдэнбалын хөшөө"
2001 он
(Хүрэл, чулуу,
Улаанбаатар хот)

С.Бадрал "Тэмээний уралдаан"
1992 он
(Металл хайлш,
МУЗГ)

"Мэгжид Жанрайсаг бурхан"
1994 он
(Зэс, алт шармал,
Гандантэгчилэн хийд)

Монголын уран барималд өөрийн арга барил, хэлбэр дүрслэл, сэдвээрээ өвөрмөц ялгарах сайн уран бүтээлчид төрж, сүүлийн үед Дүрслэх урлагийн дээд сургуулийг төгссөн залуу уран баримачид чамбай бүтээл туурвиж байна.

Мөн манай уран баримачид уран бүтээлээ янз бүрийн урсгал чиглэлээр хийж, бие даасан үзэсгэлэн гаргаж байгаа нь монголын уран баримлын хөгжлийн түвшин, чиг хандлагыг тодорхойлж байна.

Ийнхүү эртний нүүдэлчдийн босгосон буган чулуу, хүн чулуунаас эхлээд төв Азийн соёл урлагийн хүрээнд багтаж, монголчуудын шүтлэг бишрэл, зан үйл, оюун сэтгэлгээг шингээсэн шашны болон иргэний сэдэвтэй уран баримал бүх төрлөөрөө жигд хөгжиж ирсэн түүх сонирхолтой бөгөөд өвөрмөц байдлаараа олон орон, үндэстний соёл, уран баримлын урлагт өөрийн гэсэн онцлог, байр сууриа эзлэх болсон байна.

С.Балрал
Л.Батчулуун
С.Уранбилэг
Э.Амарбилиг

ГОЁЛ ЧИМЭГЛЭЛИЙН УРЛАГ

Монголчуудын эд өлгийн болон утга соёлын чухал бүрэлдэхүүн хэсэг болсон гоёл чимэглэлийн урлаггүйгээр тэдний орон сууц, хувцас хунар, эдлэл хэрэглэл, зэр зэмсэг, ахуйн хэрэглээний бүхий л зүйлсийг сэтгэшгүй юм.

Тэр нь хэдэн мянганы турш ан ав, мал аж ахуй эрхэлж, нүүдэллэн амьдрах ёсны онцлогоор бий болж, жирийн хэрэглээний зүйлээс жинхэнэ урлагийн бүтээл болтлоо төгөлдөржин өнөөг хүрчээ. Эртний шүтлэгийн онго сүлд болон амьтны донжийг тун нарийн гярхай мэддэг монгол хүний тэдгээр бүтээл эрт үеийн хадны зургаас уран хийсвэрлэл-гоёл чимэглэлийн урлаг эхээ авсан ажээ.

Дорнод аймгийн Булган сумын шинэ чулуун зэвсгийн үеийн булшнаас олдсон сийлбэр чимэг бүхий ясан эдлэл, гоёл чимэг, хүрэл урлалаас аваад Дундговь аймгийн Дулааны говийн шинэ чулуун зэвсгийн суурингаас чулуун загас, гоёл чимэглэлийн бусад зүйл олсон, Балжийн голын саваас гурван амьтны толгойн нэгдмэл дүрст хүрэл товруу зэргээс үзэхэд а.т.ө. II мянганы II хагас буюу хүрлийн үед төмөрлөг цутгуур, амьтны загварт урлаг хөгжиж байжээ. Тэр үед хүрэл хутга, илдний бариул, гоёл чимэглэлийн зүйлд том нүдтэй, соотон чихтэй, угалзалж гогцоорсон том эвэртэй буга, янгир, хонин гөрөөсний дүрс урлах дэг тогтсон байв.

Өмнөговь аймгийн нутгаас олдсон урт чичлүүр хүрэл хутганы бариулыг тэхийн толгойгоор чимэглэж, сүрлэг байдлаар шийдэжээ. Дүрслэх урлагийн музейн хөмрөгт буй хүрэл бугыг жинхэнэ урлагийн бүтээлд тооцож болно. Цагариг сэнжин дээр цомцойн зогсож, бүх биеэ хураан, хүзүүгээ өндөрт өргөж соргогоор алсыг харуулдан байгаа тэр бугын эрхэмсэг дорвилог дүр, зургаагаар салаалж, үзүүрийг матийлган нийлүүлсэн хүчирхэг хос эвэрээ үүрч, морин хэлбэрийн урт хоншоороор урагш тэмүүлсэн хөдөлгөөнийг гайхалтай илэрхийлсэн байдаг. Бие эрхтнийг тэнцвэрлэн уран чадварлаг ерөнхийлсөн хэтрүүлэг, цутгаврын ур дүй нь тэр үед урлахуй ухаан, гүйцэтгэх чадвар гойд боловсорсныг харуулна. Хэнтий аймгийн Биндэр сумын нутаг Асгатаас морины дүрстэй хүрэл товруу, зүүлт олдсон нь эртний хадны зураг дүрслэлийн уран сайхны хийсвэрлэл, хэтрүүлэл хүрэл цутгуурын ур ухаанд өвлөгдсөний жишээ юм. Эртний гоёл чимэглэлийн урлаг, ялангуяа хүрлийн үе, төмөр зэвсгийн түрүү үеийн амьтны загварт урлагийн дурсгалууд Монгол нутгаас үлэмжхэн олддог билээ.

Тамсагийн шинэ чулуун зэвсгийн булшны олдвор



Ноён уул, Тахилтын хотгорын булшны олдвор (Хүннүгийн үе) (МҮТМ)

Булган аймгийн ОНС музейн үзмэрт буй буга, тэмээ, гахайн дүрстэй хүрэл чимэг нь Монгол нутагт энеолит, хүрэл зэвсгийн үе ба хүннү нарын урлагт нэгэн амьтны дүрд хэд хэдэн амьтан, эрхтнийг дүрсэлж, амьтны уран сайхны дүрийг бүтээдэг байсны баримт юм. Эрдэмтэн судлаачид хүрэл, төмөр зэвсгийн үеийн гоёл чимэглэлийн урлагийн олдворуудыг гоёж чимсэн арга барил, хийц маягийг бусад үетэй харьцуулан судалсан юм. Сүхбаатар аймгийн ОНС музейн хөмрөгт буй ишнийхээ нэг талд хоёр адуу, нөгөө талд нисч яваа шувууны дүрстэй хүрэл хутга, Ордос нутгаас олдсон амьтны дүрст хүрэл хутга зэргийн дүрсийг хадны улаан зосон зурагт буй амьтдын дүрстэй

харьцуулан судалсны үр дүнд Монгол, Өвөр Байгалд өргөн тархсан амьтны загварт урлагийн нийтлэг шинж төрхийг тогтоосон билээ.

1972-1975 онд монгол зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн хүрэл, төмөр зэвсгийн дурсгал судлах анги Увс аймгийн төв Улаангом хотын дэргэдэх Чандмань уулнаа а.т.ө. VII-VIII зуунд хамаарах 50-иад булш малтан шинжилж эртний судлалын арвин баялаг хэрэглэгдэхүүн илрүүлэн нээсний дотор амьтны сэдэв дүрст шавар ваар, ясан эдлэл зэрэг гоёл чимэглэлийн урлагийн дурсгал олсон юм.

Тэрэлжийн дөрвөлжин балгас, Хараалчийн хэрэм, Гуа дов, Өндөр дов зэрэг Хүннүгийн үеийн дурсгалаас үзэхэд хүрэл цутгавар, чулуу, мод зэрэг олон төрлийн хэрэглэгдэхүүнээр гоёл чимэглэлээ урладаг арга ухааныг залган хүрэл, төмрийн үеийн амьтны загварт урлагийн их ололтыг өвлөн хадгалсан нь илт харагдана. Жишээлбэл: гөрөөс барьж байгаа араатны дээрээс буун тэмцэлдэж буй тас шувууны дүрст ялтас, ноцолдож байгаа адууны дүрст урлал Дэрстийн хүнну булшнаас олдсон болой.

Тэрхүү амьтны загварт урлагийн дотроос хамгийн сонирхолтой нь Ноён уулын хүнну булшнаас олдсон 2,6x1,95 м хэмжээний эсгий ширмэлийн хийц үр юм. Түүний төв хэсэгт дан зураасаар усан хээ тасралтгүй үргэлжлүүлэн утсаар ширж, гаднах өргөн хүрээнд тэмцэлдэж байгаа 9 хос амьтадын туйлын хэтрэнгүй уран сайхан зохиомж бүхий дүрс урлаж, хооронд нь саглагар модыг өнгө ялган утсаар ширжээ. Тэнд сарлаг, буга, араатан бар далавчаа дэлгэж, сүүл босгосон тас шувууг хос хосоор нь урлаж, нөгөө нэг хос дүрслэлд ширэлдэн бөөгнөрсөн савга сүүлтэй сарлаг түүний хүзүүнээс нь хазан зууралдаж байгаа дэлт барын эрүүн доороос хурц эвэрээрээ олин мөргөж байна. Араатан, адгуус амьтны амь өрссөн тэмцэл, эрч хүчийг ийнхүү ёгт бөгөөд аймшигт байдлаар гаргасан энэ бүтээл гоёл чимэглэлийн хүрээнээс аль хэдийн хэтэрч, жинхэнэ утга төгөлдөр том зээгт хатгамал, ширмэл бүтээлийн цар хэмжээнд хүрсэн байжээ. Хүннүгийн урлаг ийнхүү араатан амьтны төрх байдал, хөдөлгөөн, тэмцлийг нарийн илэрхийлж, улам бүр сүр жавхаа оруулан урнаар хэтрүүлэн чимж, өнгө зохирулсан төдийгүй тэр үеийн урчууд наах, зээглэх, хатгах, ширэхдээ гарамгай байсныг гэрчилнэ.



Ваар

Нарны хаалтны оройн тээг (голч нь 14,4 см)

Модон аяга

Ноён уулаас олдсон олдворууд (МУТМ)

Ширмэл ширдэг
Төв аймаг, Батсүмбэр сум, Ноён уул
Хүннүгийн үе
(МУТМ)

Нүүдэлчид гоёл чимэглэлийнхээ урлагийн зүйлийг чингэж гүн утга, агуулга оруулан бүтээдэг байснаар дүрслэлийн сонгодог арга, хэлбэрүүд бий болох чухал алхам болжээ. Архангайн Хүнүй голоос малтсан хүннү булшнаас нар, сар дүрсэлсэн алтан ялтас, хуудас алт олдсон нь сайхь үеийн гоёл чимэглэлд алт товимол аргыг хэрэглэж байсны тод шинж юм. Ер нь хүннүгийн үед алтан урлал нэлээд үсрэнгүй хөгжсөний жишээ бол хүннүгийн хааны эрдэнийн чулуу шигттэмэл алтан титэм юм. Эл алтан титэмний дээрх шувууны толгойг оюу номингоор хийсэн нь үргэлж хөдөлж байдаг ур гүйцэтгэлгээтэй ажгуу. Энэ үед цутгамал гоёл чимэглэл зонхилж байсны нотолгоо бол Ю.Д.Талько-Гринцевичийн шинжилсэн хүннү булшнаас гарсан авсны ханан дахь ноцолдож буй адгуусны дүрст хүрэл ялтсууд юм.

Малгайн чимэглэл
(АХ)

Барилгын материалууд
Хүннүгийн үе.
Төв аймгийн Баянжаргалан сум, Гуа дов,
Мөнгөнморьтсум, Тэрэлжийн Дөрвөлжин,

Ухуанийн гар урлалын талаар нанхиад сурвалж бичигт бичсэн нь:

"Ухуань их ахлагч нум сум, эмээл хазаар хийж, алт, төмөр хайлдаг, цэргийн зэвсэг хийдэг, арьс боловсруулдаг, хээлдэг, хатгадаг, торго утас ноосон бөс нэхдэг байсан гэжээ.

Өвөрмонголын Улаанцав аймгийн Лянчансяниас 1956 онд малтаж гаргасан Тобагийн алтан гоёл чимэглэл, амьтны дүрс гаргаж, эрдэнийн чулуу шигтгэсэн зүйлийг үзэхэд ур хийц өвөрмөц гоё байдаг.

Түрэгийн үед зэр зэвсэг хийж алтдах, мөнгөлөх, хүрэл сав, суулга хийх уран дархны үйл нэлээд дэлгэрч, давтмал мөнгөөр хээтэй цар, таваг, дарсны домбо хийж, тэдгээрийг тахируулан татсан буюу шугаман хээ, цэцэг навч, амьтны дүрсээр гоёж чимдэг байжээ.

Саххитын булшны олдвор
Төв аймаг, Батсумбэр сум
Хүннүгийн үе
(МҮТМ)

Хүннүчүүд шавар ваар савыг гар ажиллагаа, оньсон хүрд эргүүлэх арга хослон хийдэг байжээ. Тэдгээр нь нэлээд олон зүйл хэлбэртэй байсны дотор өндөр нарийн хүзүүтэй, дөрвэгэр амсартай, мөрөөр нарийн, гэдэс цунхгэр, ёроол шувтан, долгио болон бүслүүр хээтэй ваар үндэсний түүхийн музейд бий. Хүннүгийн барилгын дээврийн чимэглэлийн шахмал тэргэл хэлбэр, нүүрэндээ эрвээхэй, тагнай урладаг хийц маяг нэн эртний уламжлалтай. Ер нь Өрнө, Дорны хүчирхэг улстай зэрэгцэн оршиж, хүрэл хутганаас аваад олон зүйлийн сэдэвт цутгамал бүтээлийн эх загвар бүй болгосон Хүннү гүрний уламжлал өнөө үе хүртэл үнэтэй өв болсоор байна.

Сяньбичуул арьс шир, нэхий үслэгээр эгнэсэн дээл, арьс ширэн цоолбор хээ угалзтай богц, ачмаг, дашмаг, үхрийн эвэр наамал нум сум зэргийг олон янзаар гоёж, чимж хэрэглэдэг, эмэгтэйчүүд нь шүр сувд хадмал бухий өндөр богтаг малгай өмсдөг байжээ.

VIII зууны дундуур түрэгийг бут цохиж мандсан уйгур нар урлагийн түүхэнд мөрөө үлдээсэн их соёлтой бөгөөд Орхон голын саваар нутаглаж гоёл чимэглэлийн урлагт усан давалгаа хээтэй дэвсгэр, үргэлж угалз ихэд дэлгэрчээ. Монгол, түрэг олон аймгийг нэгтгэсэн арван уйгур буюу он уйгур, есөн уйгур буюу тогуз уйгур хэмээх хоёр том аймаг өвөрмөц соёлтой байсныг Хар балгас, Хужирт шанхын булшнаас олсон алтан ээмэг, цагирган зуузайтай амгай, шургуулган хээтэй ваар зэргээс мэдэж болно.

911-1115 он хүртэл 200 гаруй жил мандан цэцэглэж байсан Хятан гүрэн мал аж ахуй, газар тариалангийн хажуугаар дүрслэл чимэглэлийн урлагийн бүхий л төрөл зүйлийг дорвитой хөгжүүлж байсан юм. Хятан нар урлаг үйлдвэрлэлийг төрийн бодлогын хэмжээнд авч үздэг байсныг онцлууштай. Тэд аймгийн тэргүүнээр нум сум, эмээл, хазаар, элдэв зэвсэг хийж чадах, хүн ардын маргааныг тасалж чадах цэцэн мэргэн баатар хүнийг сонгодог байжээ. Хятанд төмөрлөгөөр аж ахуйн багаж, сав суулга, цэрэг дайны зэр зэвсэг зэргийг урлах, зоос, бурхан цутгах ажил нэлээд дэлгэрсэн байна. Хятан улсад чулуучин олон байсан нь XI зууны олон хотын ор үлдэлд байгаа урлан зассан чулуун чимэглэлийн зүйлс, мөн үлэмж олон тээрмийн чулуу зэргээс мэдэгдэнэ. Үүний зэрэгцээгээр шатаамал шавар ваарын урлаг нэлээд үсрэнгүй хөгжиж, зөөлөн галаар шатаасан ногоовтор паалан, ногоон, шар, хар хээтэй шаазан, тахианы залаат домбо, хүзүүт ваар, гарьд хүзүүт ваар, урт болон дөрвөлжин цар зэргийг гоё сайхан урладаг байжээ.

Мөн хятан нар дээдсийн бунхны хана туургыг ихэд эрээлэн чимэглэдэг байв. Өвөрмонголын Цагаан суварганы ойролцоогоос 1932 онд олдсон Шарилын сүмийн олон арван ханын зураг чимэглэл үүнийг гэрчилнэ.

Чингисийн их гүрний үед унаган монголын уламжлалт гоёл чимэглэлийн урлаг харийн ур дархны бүтээлээр баяжиж, хаад ноёдын орд харш, эд агуурсыг гоёж чимж байв. Гүег хаан ширээнд суух ёслолыг үзсэн хүний тэмдэглэлд Хааны ширээ нь зааны ясаар сийлсэн гайхамшигтай уран гоё сийлбэртэй, алт, эрдэнэс чулуу шигтгэмэл, ардаа дүгрэг түшлэгтэй байсан тухай өгүүлсэн байдаг. Ордны чимэглэл зөгнөлт утга санаа бүхий хээ угалз, ёгт хэтрэнгүй байдалтай араатан амьтны дүрсийг торго магнаг, эсгий, арьсан дээр захируулан наагаад, зээглэн оёж урласан хөшиг нөмрөгөөр төлөв бүрдэж байжээ. Энэ тухай Плано Карпини бичихдээ "Эндээс ойролцоо уулын хоорондуур гол урссан гоёмсог хөндийд модон баганатай, алтан хуудсаар бүрхэж, алтан хадаасаар хадсан хана туургыг торго магнагаар бүрсэн нэг асар байсныг алтан ордон гэж нэрлэж байсан" гэжээ. Их Монгол улсын томоохон хотуудад гоёл чимэглэл, хийц шийдлээрээ гайхам сайхан орд харш олон байжээ. Үүнийг Хархорум хот, Түмэн амгалант ордноор төлөөлүүлэн үзэж болох юм. Энэ бүхнээс үзэхэд монголчууд нэг талаас нүүдэлчин амьдрал хэв заншилтай холбоотой уламжлалт гоёл чимэглэлийн урлагийнхаа өвөрмөц байдлыг хадгалан хөгжүүлж, нөгөө талаас дорно, өрнийн сонгодог урлагийг унаган монгол уламжлалын шимт хөрсөндөө өөриймшүүлэн, үндэсний соёлоо баяжуулж ирсэн байна.

Эрдэнэзуу хийд

Монгол их гүрний задралын дараа олон жил үргэлжилсэн ужиг дайн самууны хөлд үндэсний соёл, хот суурин нэрвэгдэн сүйдэж байсан боловч гоёл чимэглэлийн урлаг бүрмөсөн сөнөж, төрөл арилжсан нь огт үгүй, харин ч шашин номын зан үйл, сүм дуганы зориулалт бүхий гоёл чимэглэлийн зүйл ихэд дэлгэрчээ, үүний зэрэгцээгээр ардын гоёл чимэглэлийн урлаг дүрслэх урлагийн бусад төрлөөс гоцлонги хөгжиж уран хийсвэрлэл, хээ угалзалсан донж дүрслэл, уран хэтрэнгүй хэл, хэллэг, утга бэлгэдлийн өнгө зүс, тоон болон хэлбэрийн утга хөдөлгөөний агуулгатай болж боловсорсоор байв.

Монгол цэргийн хөө, хуяг, нум сум XIII-XIV зуун (МҮТМ)

XIX-XX зуун уламжлалт гоёл чимэглэлийн ур ухааны хөгжлийн эрчимжлийн үе байв. Монгол орон 1911 онд Манж гүрний ноёрхлоос салж, тусгаар тогтносон улс байгуулсаны дараа Өндөр Жанрайсиг, Дүйнхорын Лойлон, Хүрээ цамыг шинэтгэх зэрэг нүсэр том үйлсийг бүтээсэн юм. Богд хаант Монгол улсын үед зүүн хүрээний Сангайн аймгийн оёдлын модон гэрт дөрвөн аймаг, шавь тавын урчууд цугларч, Богд хаантны хэрэглэх хувцас хунарыг оёдог, тэдгээрийг бүдүүн, нарийн үйлчин гэж хоёр ангилдаг байв. Нарийн үйлчид дээл хувцас, малгай гутал, бас бурхан шүтээн оёж хатгадаг байжээ. Энэ үеийнхнээс нэрд гарсан бурханч Хасгомбо, Тавхайбор, эсгүүрч Пунцаг, уран оёдолч Алтангэрэл, Равданцэрэн, Байжав, Цэрэн, Сэрээчулуу, Сэрээжав, Сарангэрэл, Оюун, Лхамжав, Дарьсүрэн зэрэг олон алдарт урчуудыг нэрлэж болно.

Үнэт чулуун шигтгээ бүхий малгай
(БХОМ)

Богд хааны сэнтий
(БХОМ)

Ноён хүний дээл
(БХОМ)

Ясаар чимэглэсэн цамын гутал
(БХОМ)

1926 онд гаргасан бүрэн бус мэдээгээр, энэ зууны эхээр Монголд мөнгөний дархан 255, төмрийн дархан 297, модны дархан 590, уран хаттамалч 85, бүгд 1200 гаруй хүн бүртгэгдсэн нь тэр үеийн хүн амтай харьцуулахад чамлашгүй тоо юм. Дээр заасан гоёл чимэглэлийн үндсэн төрлөөс өөр чиглэлээр ажиллаж байсан урчуудын тоо энд оролцоогүй байна.

Жинхэнэ ардын урлагийн чадвартны ихэнх нь хөдөө орон нутагт байж, урлагийн ямар нэг төрлөөр орон даяар алдаршсан нутаг хошууд цөөнгүй байсан юм. Энэ зууны эхээр Баруун монгол, Урианхайн хязгаараар аялсан Оросын эрдэмтэн Г.Грумм-Гржимайло Монголд гар урлагийн дотроос төмрийн дархлал хамгийн хүндтэй байсан тухай өгүүлэхдээ, үйлээ хийж байгаа дархан хүн түшмэл орж ирэхэд босож ёсолдоггүй нь дархны урлагийг түшмэдээс урьд бий болсон эрхэм ажил үйл гэж хүндэтгэдэг байсных гэжээ. Далай вангийн урчууд хатаасан буюу гантай төмрийг цоолборлож, сийлбэрлэж гарамгай сайн өнгөлснөөрөө бусад нутгийн нийтлэг төмөр урлагаас ялгаатай болж, тухайн үедээ хийц, үнэлгээгээрээ дээгүүрт тооцогдож байжээ. Дээр үеийн мөнгөний дархчуул голдуу зэс, төмөр дээр халиа, зувцаа, мөнгөлөх, алтдах аргаар урладаг байсан бол энэ зууны эхэнд шижир алт, цэвэр мөнгийг давтан хөөмөллөх, цутгах, утсан сүлжмэл, эгээмэл аргаас цул мөнгөөр ухаж сийлэх аргад шилжин, давхар ухалттай хийц хэрэглэснээрээ Дарьгангын мөнгөний дархны урлаг цойлон гарч, уран сайхны давтагдашгүй өндөр хэмжээнд хүрч, Далайчойнхорын ган сийлбэрийн урлагтай өрсөлдөн хөгжиж байжээ.

Билгэ хааны дурсгалын цогцолбороос олдсон алт мөнгөн эдлэл (МҮТМ)

Мөнгөн бүслүүртэй домбо (МДУМ)

Гуц, даш (МДУМ)

Мөнгөн хувин (МДУМ)

Мөнгөн аяга, суурь (МҮТМ)

Дарьгангын мөнгөн аяга

Дун хэнжин (МҮТМ)

"Бойпор" (Ерөнтэй дархан) (МДУМ)

XIX зуун гэхэд Хөвсгөлийн Мөрөн, Завханы Өндөрхангай, Өвөрхангайн Уянга, Бат-Өлзий, Их хүрээ мод сийлэх, хээлэх талаараа алдартай болжээ.

Өнгөрсөн зууны шувтаргаар нэртэй сайн сийлбэрч, дархчуулыг цуглуулж хүрээ Ганжуур, Данжуурын 300 гаруй боть номын бар, Дүйнхорын Лойлон зэргийг бүтээсэн түүхтэй. Монгол улсын үндэсний номын санд хадгалагдаж байгаа уран Жамбын удирдан алт, мөнгөөр бүтээсэн ном, Вангай аймгийн уран Минжүүр аграмба, Доржбат дархан толгойлон бүтээсэн Жадамбын зэс бар зэрэг нь монголын уламжлалт гоёл чимэглэлийн урлаг бүхий л төрлөөр хөгжлийн өндөр хэмжээнд хүрсний нэг нотолгоо мөн.

Уран дарх, монгол зураг, мод хээлэх, сийлэх урлаг, баримал, шуумал, нэхмэл, хатгамал, эсгий ширмэл, арьс ширэн урлал зэрэг гоёл чимэглэлийн урлагийн үндэсний шинж төрх ялгаран хөгжиж, нутаг ус бүрийн зартай хийц найруулгатай болж боловсорсон юм. Түүний тод илрэл бол Далайчойнхорын ган сийлбэрийн урлаг, Батноров, Ноён Сэврэй, Дарьганга, Арчуул хийцийн мөнгөний урлаг, Уянга, Ханхөхүйн гэрийн мод хээлэх, сийлэх урлагийн хийц, зээгт наамал хатгамлын урлаг, Ламын гэгээн, Егүзэрийн хивсний урлаг мөн бөгөөд хувцас, нэхмэл, хатгамал, эсгий алгадмал, ширмэл зэрэг урлахуй ухааны асар олон төрөл нийт Монгол даяар тархмал байв.

Зэс бар
(УТНС)

Хээ угалз бүхий сийлбэртэй тооно
(БХОМ)

Ном, бурхан барлаж яс, мод, хув зэрэг хэрэглэгдэхүүнээр гоёл чимэглэлийн зүйл урладаг авьяас билэгтнээс Завханы уран Сүрэн зартай билээ. Ясыг буцалган тосыг шүүж цагаан болгоод цамын хувцсанд хэлхээлэн зүүдэг дошил ружин холбоо чимгийн угалзнуудыг уран гоё сийлбэрлэсэн нь дүрслэх урлагийн музей, Чойжин ламын музейд бий.

Жадамба судрын нэгэн хэсэг
(УТНС)

Хээ угалзаар чимсэн арьсан дашмаг
(МҮТМ)

Хээ угалз бүхий модон шүүгээ
(БХОМ)

Монголын нийгэмд нүүдлийн сонгодог мал аж ахуй голлон байсан болохоор гоёл чимэглэлийн урлаг ч түүнд шүтэлцэн, өрх гэрийн чанартай хөгжсөөр байсан боловч XX зууны эхэнд уран дархны ажил мал аж ахуйгаас тусгаарлах хандлага нэлээд хүчтэй болжээ. Ялангуяа 1930-аад онд орон даяар байгуулсан гар үйлдвэрийн артель монгол сийлбэр, дархны урлагийн уламжлалт ур ухаанаас эзэмших, өвлөн хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Нэрт сийлбэрч хээч О.Дорж, С.Сэнгээ, Д.Гэвшээхүү, Д.Дорж, Д.Гэлэгдандар, алдарт хээч Чойндон, Гялав, Д.Цэрэндулам, Д.Гэндэнжамц, Э.Галсан, зураач А.Сэнгэцохио, У.Ядамсүрэн, Д.Манибадар зэрэг олон уран бүтээлчид уран бүтээлийн их өвөө ард түмэндээ үлдээсэн юм. Энэ бүгдээс онцолж монгол түмний хээ угалзны цуглуулгаараа Д.Манибадар, үндэстний хувцасны цомгоороо У.Ядамсүрэн манай гоёл чимэглэлийн урлагт үнэтэй хувь нэмрээ оруулсан билээ. Энэ бүтээлч замаар цаашид ч урчуул замнаж байна. Энэ үед С.Сэнгээгийн зааны ясан сийлбэр, Оргодлын чулуун сийлбэр зэрэг үзэсгэлэн, музейн зориулалттай удаан хугацаа, нөр их ур чадвар шаардах төрлүүд үлэмж сэргэн хөгжсөн юм.

Өвөг хүннүгийн хутган зооснoос эхлээд Жужан, Сяньби, Хятан, Их Монгол гүрний үес нүүдэлчдийн амьдралд зоос мөнгөний үйлдвэрлэл чухал үүрэгтэй байж, их хаадын алтан тамга, тэмдгийн хажуугаар Чингис хааны гэрэгэ гарч байсан уламжлалаас сурч, өдгөө зоос гоёлын зүйлийн үйлдвэрлэл хөгжиж байна.

Хасгомбо "Махгал бурхны тахилга"
(Торгон дээрх хатгамал)
(МДУМ)

У.Ядамсүрэн, Я.Люня "Урил"
(Торгон дээрх хатгамал)
(МДУМ)

Түрэгийн үеийн зоос

Хятаны үеийн зоос

Бурханы дүр бүтээхэд голлон зориулдаг байсан зээгт наамлын урлаг хэмжээ тэдийгүй, уран сайхны гүйцэтгэлгээрээ XIX зууны сүүлчээр хөгжлийнхөө сонгодог хэмжээнд хүрч, XX зууны эхээр иргэний хандлагатай дүр дүрслэлд шилжин Б.Цэрмаа, А.Цэрэнхүү, Я.Люня, Б.Норолхоо зэрэг хатгамалчид олон арван бүтээлээ задгай утсан хатгамал, зүү ороомол, зээгт наамлын аргаар урлаж, тэдний шавь нар ч бүтээлч эрлээрээ өсч байна.

1945 онд байгуулагдсан Монголын дүрслэх урлагийн дунд сургууль дүрслэл чимэглэлийн урлагийн мэргэжлийн 1000 гаруй уран бүтээлч бэлтгэснээр өвөг дээдсээс өвлөсөн гоёл чимэглэлийн урлагаа хөгжүүлэхэд найдвартай халаа болж байна. Улаанбаатар хот дахь Гэрлэх ёслолын ордон, Монголын хүүхдийн ордон, Сонгодог урлагийн академик театр, Үндэсний жүжгийн академик театрын барилгын дотоод засал чимэглэлээс үзэхэд гоёл чимэглэлийн урлаг монументаль чимэглэлээр амжилттай хөгжиж байна.



Хивс, арьс шир, эсгий ноос, шаазан ваарын үйлдвэр зэрэг орчин үеийн машинт үйлдвэрт хэрэглээний гоёл чимэглэлийн үлэмжхэн зүйл хийж нийтийн гоо сайхны хэрэгцээг хангаж байгааг тэмдэглэвэл зохино.

Монголын эд өлгийн ба утга соёлын арвин их өв санг гоёл чимэглэл, ур хийцгүйгээр авч хэлцэшгүйн нэгэн адил гоёл чимэглэлийн урлагийг хээ угалзнаас гадуур авч үзэх аргагүй юм.



Хээ угалзаар чимсэн хивс

Монгол хээ угалзны уран сайхны бүтэц, шинж чанарын онцлогийг цухас авч үзье.

Хадны зураг дүрслэл, эртний гоёл чимэглэлийн баримтаар болохул, монгол хээ угалзны өвөг дүрс нь цэг зураас буюу ямар нэгэн эгэл дүрс байжээ. Шинэ тутам үүсэж байсан хэрчлээс зэрэг өвөг хээнцэр гоо сайхны шинжээр төдийлөн гойд бус, гол төлөв зан үйл, дом мэдээллийн чанартай байснаар онго сүлд сүнс, дохио тэмдгийн зориулалттай болжээ. Цэг, шулуун тахир, муруй зураас нь яваандаа гурвалжин, дөрвөлжин, дугуй элдэв хэлбэрийг үүтгэж, тэдгээрээр дамжин хүний орчин тойрны элдэв юмс үзэгдлийг дам холбоослон дүрслэх болж, цаашдаа улам баяжин олон янзаар хувилбарлаж, бүхэл бүтэн чуулбар (компиляци) болон хөгжсөн байна.

Хээ угалз дотоод хөгжлийнхөө явцад утга санаа зориулалт, нэр томъёо нь хувьсан өөрчлөгдөж, хэв найруулга нь улам бүр боловсронгуй болж, ерөнхийлөл, уран сайхны хийсвэрлэл давамгайлан, унаган төрхөөсөө үлэмж ондоошин хувьсаж, шинэ шинэ бүрдүүлбэр гарч ирдэг зүй тогтолтой ажээ.



Адууны дүрст чулуун хөшөө

Монгол хээ угалзны уран сайхны бүтэц, шинж чанарын онцлогийг цухас авч үзье.

Хадны зураг дүрслэл, эртний гоёл чимэглэлийн баримтаар болохул, монгол хээ угалзны өвөг дүрс нь цэг зураас буюу ямар нэгэн эгэл дүрс байжээ. Шинэ тутам үүсэж байсан хэрчлээс зэрэг өвөг хээнцэр гоо сайхны шинжээр төдийлөн гойд бус, гол төлөв зан үйл, дом мэдээллийн чанартай байснаар сүлд сүнс, дохио тэмдгийн зориулалттай болжээ. Цэг, шулуун тахир, муруй зураас нь яваандаа гурвалжин, дөрвөлжин, дугуй элдэв хэлбэрийг үүсгэж, тэдгээрээр дамжин хүний орчин тойрны элдэв юмс үзэгдлийг дам холбоослон дүрслэх болж, цаашдаа улам баяжин олон янзаар хувилбарлаж, бүхэл бүтэн чуулбар болон хөгжсөн байна.

Хээ угалз дотоод хөгжлийнхөө явцад утга санаа зориулалт, нэр томъёо нь хувьсан өөрчлөгдөж, хэв найруулга нь улам бур боловсронгуй болж, ерөнхийлөл, уран сайхны хийсвэрлэл давамгайлан, унаган төрхөөсөө улэмж ондоошин хувьсаж, шинэ шинэ бүрдүүлбэр гарч ирдэг зүй тогтолтой ажээ.

Монгол хээ угалз нь цөөн тооны эх дүрсээс салбарлан мөчирлөсөн хээнцрүүдээс бүтнэ. Тэдгээр нь хээн хээнцэр, угалзанцар хоёроос хээ угалз болон төгөлдөржжээ. Жишээлэхэд: Ноён уулын хүннү булшнаас гарсан ширмэлийн хөвөөнд зээглэж урласан чагтан хээ хөгжлийнхөө явцад олонтаа давтагдан сүлжилдсээр түмэн насан хэмээх олон хувилбартай хээ угалзны бие даасан төрөл болон дэлгэрчээ.

Монгол хээ угалз нь төгс зохицонгуй хувьсан өөрчлөгдөж байдаг учир амьдрал, байгаль, ертөнцийг уран сайхнаар тусгаж, эгэл болхи хэлбэрээс улам төгөлдөржин геометрийн, ургамлын, амьтны хэмээх үндсэн гурван чиглэлээр хөгжиж ирэхдээ хүн амын хувцас хунар, орон сууц, эдлэл хэрэгсэл, онго шүтээн, зэр зэвсэг, хөшөө дурсгал, бичиг ном, ерөөс хүний

гараар бүтээгдсэн бүхэнд уусч шингэн тоо томшгүй олон төрөл зүйл, хэлбэр хувилбартай болсон байна. Зөвхөн алхан хээ гэхэд л битүү, задгай, ташуу алхан хээ, бэл алхан хээ, алхан толгой, мухар алх, хугархай нуруутай алх зэрэг тус бүрдээ нэр ус, утга бэлгэдэл бүхий 300 гаруй хувилбартай болж, эдүгээ хүртэл хэрэглэгдсээр байна. Мөн хээ угалзны ер төвд дүрсэлдэг, эрхэм дээддээ өргөн залдаг өлзий нь давхар өлзий, туухай өлзий, бажий өлзий, түмэн өлзий, тоонот өлзий, зайтар өлзий зэрэг 400 гаруй дүрс хувилбартай. Өлзий хээг монгол урчуул бүтээж, эд өлгө болон утга соёлын дурсгал, гоёл чимэглэлдээ хадгалж хэрэглэсээр иржээ. Энэчлэнгээр эвэр, хамар угалз, нүд сахал зэрэг эд эрхтэн, луу, могой, эрвээхэй, загасан хээ зэрэг амьтны төлөөлөл болсон хээ угалзыг 200 гаруй хувилбартай гэж судлаачид тоолж гаргасан байна.

Монгол хээ угалзны төрөл зүйлүүд чөлөөтэй нэгдэж, хосолсоор даруй 7000 орчим хувилбар дүрстэй болсон ажээ.

Монгол хээ угалз нь шашин шүтлэг, итгэл бишрэл, зан үйл, бэлгэдэл, гүн ухаан, уран сайхны гүн гүнзгий агуулгатай утга соёлын онцгой төрөл зүйлийнхээ хувьд нийгмийн амьдралын олон талыг өөрийн хэлээр дүрслэн зөвхөн гоёл чимэглэлийн төдийгүй ерөөс эдийн ба утга соёлын хэрэглээнд гүн нэвтэрсэн байдаг.

Монгол хээний эртний өвгийн нэг нь сүлдэн хээ юм. Гүн нарийн утга, нандин бүтэцтэй, чуулбар дүрстэй сүлдэн хээ нь овгийн тамга, хүн амьтны дүрст онго тэмдэг, од эрхис, эвхмэл үсэг, тамга, сүлд зэрэг олон хэлбэрээр тархжээ. Сүлд тэмдгэн хээ боловсрох явцыг эртний өвөг дээдсийн онго, сүлд бишрэн тайж тахьдаг лус савдаг, чоно, жигүүртний дүрээс харж болно.

Хээгээр чимж урласан шашны зан үйлийн төмөр Пүрэв (БХОМ)

Монгол угсаатан гарал овгийнхоо хамаарлыг илтгэсэн онго тэмдгийг зүүдэг байсны дээр ихсийн орд, өргөө, сүм хийдүүд сүлд тэмдэгтэй байжээ. Сүлдэн хээний уран сайхны онцлог бол хийсвэр ойлголтыг тодорхой дүрс хэлбэрээр бэлгэдэн дүрсэлдэгт оршино. Итгэл бишрэл, өв заншлын эрхэм эд зүйлийг хээ угалзаар дүрсэлдэг эрхэм утгат гэрэгэ, сүлд, онгыг араатан хүчтэний өргөмжлөл дүрээр илтгэдэг уламжлал төрийн тамга, тэмдгэнд ч туссан байдаг. Нэн эрт цагаас газар тэнгэр шүтдэг монгол туургатнууд нар, сар, од гаригийг хээ угалзны хэмнэлд оруулан дүрсэлж, хүндлэн дээдэлж иржээ. Дэлхий ертөнц, сансар хорвоог ухааран танихынхаа хэрээр одот ертөнцийн сэдэвтэй хээ угалзыг хавтага сав, хэт бэл зэрэг гал гаргах хэрэгсэл, онго тэмдэг зэрэг эрхэм зүйлдээ дүрсэлдэг заншилтай билээ.

Монгол үндэстэн гал бол амьдралыг дулаацуулан тэтгэгч цөм буюу ариутган бадраагч чанартай зүйл хэмээн үздэг учраас галан хээ ихэд дэлгэрчээ. 'Гал өөдөө" хэмээн бэлгэшээдэг монгол хүн муу муухайг ариусгахын үндэс галан хээг сайн сайхан, аз заяа, хүч чадлын бэлгэдэлд тооцож ирсэн байна. Монгол хээ угалзанд галын гурван дөл нь мөнхийн гурвалын утга санааг агуулжээ. Голдуу бие бие рүүгээ харж гал хамгаалсан хос луут хэт бэлд дүрсэлсэн байдаг нь гал голомтоо үүрд хамгаалах утгатай бөгөөд гал төвлөн шүтэгч нүүдэлчин ард түмний унаган хээний нэг юм.

Эх байгалийн гоо үзэсгэлэн, сүр хүч, жам хуулийг тусгаж, тэдгээрт хандсан итгэл бишрэл, хайр хүндэтгэлийг гүн гүнзгий, цогц мэргэн санаагаар илэрхийлдэг нь монгол хээ угалзны нэг гайхамшиг юм. Нэн эртний угшилтай байгалийн дүрст хээ угалз нь уулан хээ, үүлэн хээ, долгион хээ зэрэг олон төрөл бөгөөд тэдгээр тус бүр нь дотроо олон хувилбарт хуваагдан задрах ажээ. Нүүдэлчид аливаа зүйлийг амьтанчлан ухаардаг онцлогтой учраас үүлэн хээгээр зөвхөн үүлийг төдийгүй, аргаль угалз, луу, бар, арслан, тэмээ малыг ч дүрсэлсэн нь олонтаа тохиолддоно. Долгион хээ хүннүгийн үед холбогдох бөгөөд эрчилсэн хөдөлгөөн, тэмүүлэл, байгалийн юмс, үзэгдлийн мөн чанарыг уран гоё хэмнэлээр илэрхийлдэг байна.

Д.Энхдаваа "Төрийн их ган тулга"

Мөн солонгон хошоо хэмээх дагнааст хээ, хажлага, туузан хээ, үүлэн толгой зэргийг тооноложин 4-5 дэлбээт цэцгэн хэлбэрээр уран гоё хийц найруулга оруулан урлаж иржээ.

Цэцгэн хээ, навчин хээ зэрэг ургамлан хээ эх дүрсээсээ ондоошиж, болзолт уран гоё найруулгатай болж, хийсвэрлэгдэх тутам тойм дүрслэлээс илэрхийллийн тал руугаа ойртон хөгжжээ. Хөгжлийнхөө эхний үед бүдүүвчилж, хурааж дүрсэлж байснаа бүр нарийвчлан тусгаж жинхэнэ цэцэг ургамал гэж танигдашгүй уран хийсвэрлэлээр хувьсан, шугаман байгууламжтай болсныг ажиглаж болно. Монгол хээ угалз нарийн нягт ур хийц төдийгүй, тоон утгаараа янз бүр, баялаг олон хувилбартай байдаг.

Хээ угалз нь чухамхүү ард түмний бодол санаа, хүсэл зорилгыг шингээсэн байдаг. Тухайлбал, алхан хээ нь эцэс төгсгөлгүй мөнхийн орчил хөдөлгөөнийг, өлзий утас, түмэн насан зэрэг нь эцэс төгсгөлгүй үргэлжлэх, элбэг дэлбэг, мөнхийн сайн сайхныг бэлгэдэх жишээтэй юм. Хээ угалзны нөхөх бүтэц нь давталт, тусгаарлал, хамтатгал гэсэн гурван үндсэн цогцсоос бүрдэх бөгөөд нөхөх ба үл нөхөх гол зарчим монгол хээ угалзны энгийн хээнцэр махбодоос ярвигтай дэлгэр зохиомж хүртэлх бүх бүтээлийн амин сүнс болж ирсэн ажээ. Монгол түмний бүтээсэн дизайны дохио тэмдгийн тогтолцоот урлаг болсон хээ угалз нь түүнд тусч буй гадаад оногдохуй, хүний дотоод ертөнцийг дүрс тэмдэгчлэн үзүүлэх дохио тэмдгийн тогтолцооны хувьд юмсын мөн чанарт нэвтэрч, орчин тойрноо ухааран сэтгэлдээ тунгаан тусгаж, тоймчилсон загвараар дамжуулж, хураангуйлж, нэгтгэн дүгнэсний үр дүн юм.

Л.Батчулуун
С.Уранбилэг

Тамгын дөт, мөнгөн хайрцаг
(Үндэсний урлагийн сан)

НОМ ХЭВЛЭЛИЙН УРЛАГ

Монголчууд эрт дээр үеэс хад чулуу, хөшөө дурсгал дээр түүхэн үйл явдлуудыг тэмдэглэн бичиж үеийн үед үлдээсээр иржээ. Хад чулуун дээр бичихдээ бичиг сийлэх хэсгийнхээ гадаргууг засч тэгшлэн үг үсгийг нь ухаж сийлэн бичсэн байхаас гадна будаг, зосоор ч бичиж байжээ.

I.Гэрэлт хөшөөнүүд, бичээс

Чингисийн чулууны бичиг. 1225 онд босгосон энэ хөшөөн дээрх 5 мөр 20 гаруй үгтэй бичээс нь одоогоор олдоод байгаа монгол бичгийн хамгийн эртний дурсгал юм. Уг хөшөөг 1818 онд Оросын судлаач Спасский Хархираа голын хавиас олжээ. 1832 онд энэ хөшөөг Петербург хотод аваачсан бөгөөд одоо Эрмитаж музейд хадгалагдаж байна. Хөшөөний өндөр нь 2 м, өргөн нь 74 см, зузаан нь 22 см.

Хөшөөний бичиг нь: "Чингис хааны Сартуул иргэн дагуулж бууж, хамаг монгол улсын ноёдыг Буха-Сочихай хуригсанд Есүнхэй онтудрун гурван зуун гучин таван алдас дур онтудлаа" гэжээ.

Чингисийн ач хүү Есүнхэй 335 алд зайд харвасан амжилтыг мөнхжүүлэн босгосон хөшөө хэмээн судлаачид үздэг бөгөөд "Чингис хааны. . ." хэмээн эхэлсэн бичээстэй тул Чингисийн чулуу хэмээн алдаршжээ.

Мөнх хааны хөшөөний бичиг

"Чингисийн чулуу" хөшөө



Мөнх хааны хөшөөний бичиг.1257 онд босгосон энэ хөшөөг 1955 онд Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг Дэлгэр мөрний хөвөөнөөс газар зүйч О.Намнандорж олсон. Энэ хөшөөнд 3 мөр 20-иод үгтэй монгол бичээсээс гадна хятад үсгээр бичсэн бичиг бас бий. Монгол бичээс нь "Ургийн ургаар хэдэн хэдэн үест Мөнх хаан түмэн, түмэн насалтугай хэмээж Барс түгэ босгуулах хүртэл тэдэнд учралт буян хүртүгэй" гэжээ. Хятад бичээсийн төгсгөлд "Улаагчин могой жилийн зуны сүүл сарын хорин тавны өдөр сүсэгт тавнан Балиту, гүнж Есүхэй нар босгон тэмдэглэв" гэжээ.

Цогтын хадны бичиг. Халхын Цогт хунтайж 1621 оны намар Хангай ханы Цэцэрлэг ууланд авлаж яваад нэгэн шүлэг зохиосныг хамт явсан Эрх хиа бичин авч, 1624 онд Дайчин хиа Гүенбаатар хоёулаа тэр шүлгийг хаданд сийлжээ. Энэ бичээс одоо Төв аймгийн Дэлгэрхаан сумын Дуутын хар чулуу хэмээх газар бий.

Монгол бичгээр долоон бадаг хорин найман мөр шүлэг энэ бичээсэнд байгаа нь тэр үеийн монгол шүлгийн нэгэн өвөрмөц дурсгал болдог. Бичээсийн төгсгөлд "... хэмээн өгүүлснийг нь Эрх хиа тогтоож сударлан авсныг хойно дөрвөн жил болоод мөн хулгана жилийн нэгэн сарын арван найманаа Дайчин хиа, Гүенбаатар хоёр хаданд бичвэй" гэжээ.

Цогтын хадны бичиг

Данжуурын гэрэлт хөшөө. Энэ хөшөөг Монгол Данжуурын 226 ботийг 1925 онд монгол улсын нийслэлд залж авч ирсний дурсгалд зориулан 1929 онд Судар бичгийн хүрээлэнгийн ажилтан Дэндэв (1891-1960) урлан бүтээжээ. Хөшөө нь суурь, титэм, бичээс бүхий гол самбар гэсэн 3 хэсгээс бүрдэх бөгөөд хоорондоо чулуун углуургаар холбогддог. Хөшөөний суурийн урт нь 71 см, өргөн нь 38 см, өндөр нь 60 см бөгөөд нийт өндөр нь 248 см юм. Хөшөөний суурь, титэм хэсгийн хээ угалзыг 13 см хүртэл гүн ухаж сийлсэн бөгөөд хөшөөний гол хэсгийн өвөр талд 13 мөр, ар талд 6 мөр бичгийг сийлжээ.

Хөшөөний титэм хэсэг болгон, бие биеэ ороосон 2 лууны дүрсийг 71 см өндөр, 62 см өргөн, 26 см зузаан хэмжээтэй сийлжээ. Энэ хөшөө нь номонд зориулагдсанаараа дэлхийд нэн ховорт тооцогдоно.

Хөшөөн дээр монгол Данжуурыг монгол улсын нийслэлд шилжүүлэн залах тухай Халхын Сайн ноён хан аймгийн засаг хошой чин ван Наянтай монгол улсын судар бичгийн хүрээлэнгийн дарга Жамъян гүний 1924 онд хийсэн гэрээ бичгийг сийлсэн байна.



Данжуурын гэрэлт хөшөө

Күл-Тегинд зориулан босгосон хөшөөний түрэг бичээс. Монгол нутагт буй олон арван түрэг бичээсүүдээс хамгийн түрүүнд судлаачдын анхааралд өртөж судлагдсан энэ хөшөө Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдам гэдэг газарт буй. Эртний түрэг бичгээр 68 мөр бичсэн энэ жишиггүй том дурсгалыг 1889 онд Оросын ШУА-ийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд оролцож явсан Н.М.Ядринцев анх нээн олжээ.

Тонькукт зориулан босгосон хөшөөний түрэг бичээс. Төв аймгийн Баян сумын нутагт Налайх хотоос зүүн тийш 20 км орчим зайд орших энэ хөшөөний бичээс нь эртний түрэгийн гурван хаанд зөвлөхийн үүрэгтэй байсан Цэцэн Тонькук гэгч цолд өргөмжлөгдсөн хүн тэр үеийнхээ нийгмийн байдлыг өөрийн намтартайгаа холбогдуулан өгүүлсэн агуулгатай юм.

Уг бичээсийг зассан хоёр чулууны найман талд 62 мөр болгон бичсэн бөгөөд 1-р чулууны өндөр нь 1 м 70 см, үүнд 1-37 мөрийг 2-р чулууны өндөр нь 1 м 60 см, үүнд 38-62 дугаар мөрийг бичсэн байна. Энэ бичээсийг 1897 онд Е.М.Клеменц гэдэг эрдэмтэн олж шинжлэх ухааны эргэлтэнд оруулжээ.

Күл-тегинд зориулан босгосон хөшөө

Тонькукт зориулан босгосон хөшөө

Оройг нь эвхэрсэн хоёр луугаар чимэглэж, янгирын дүрсийг ухаж сийлсэн энэ хөшөөний өндөр нь 3.33м, өргөн нь 1.32м, зузаан нь 0.46м гурван талдаа нийт 68 мөр бичээстэй. Судлаачид 1-13 мөр бичээсийг нь бага бичээс, 14-68 мөрийг нь их бичээс гэж үздэг. Бичээсийн үсэг зурлага жигд, хэв сайтай, их бичээсийн төгсгөлд "ийм бичиг зохиолыг Күл-Тегиний ач Йолуг-Тегин бичлээ би. Хорин өдөр сууж энэ чулуунд энэ хөшөөнд бүгд Йолуг-Тегин би бичив" гэжээ. Энэ хөшөөнд өгүүлэгдэх Күл-Тегин нь Табагачийн эсрэг бослого гаргагчдын нэг Элтирис хааны отгон хүү бөгөөд 16 настайгаасаа эхлэн төрийн хэрэгт оролцож өөрийн ах Билгэ хааныг хаан ширээнд суух үест хүчин зүтгэж явсан, олон тулалдаанд оролцон, олон овог аймаг улсыг дайлаар мордож явахдаа ямар морь унаж, хэрхэн тулалдсан тухай нарийн дэс дараатай өгүүлсэн байна.

Билгэ хаанд зориулан босгосон хөшөө

Билгэ хаанд зориулан босгосон хөшөөний түрэг бичээс. Түрэг бичээс бүхий хөшөөнүүдийн дотроос бичээсийнхээ агуулга, хэмжээ далайцынхаа хувьд хамгийн томд тооцогдох энэхүү дурсгал нь Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдам гэдэг газар Күл-Тегинд зориулан босгосон хөшөөнөөс 1км орчим зайтай байдаг. Энэ хөшөөг эртний түрэгийн Элтирис хааны хүү цэргийн нэрт жажин Күл-Тегиний ах Билгэ хаанд зориулан босгожээ.

Нийтдээ 80 гаруй мөр бичээсээс бүрдэх энэхүү дурсгал нь Билгэ хааныг хаан ширээнд сууж байсан 711-734 оны хоорондох үйл явд-луудын тухай, тухайлбал дөрвөн зүгийн улсыг хүчээр номхотгон, түүнийг харшлах

сэтгэлгүйгээр дагасан бусад олон хаадын үйл явдал, тухайн үедээ Билгэ хаан ихээхэн нөлөөтэй нэр хүндтэй байсан тухай өгүүлжээ. Хөшөөний үгийг түүний ач Йолиг Тегин дөрвөн сар, дөрвөн өдөр бичиж чимсэн "газарт тогтоон хойч үеийнхэндээ гэрч болгон соёрхуулав" гэжээ.

II. Захидал, тамга гэрэгэний бичиг

Монголын эртний бичиг үсгийн нилээд дурсгал монголын хаадаас гадаад улсад илгээсэн бичиг, захидал, уг бичигт дарсан тамга, хааны элчид олгож байсан алт, мөнгөн гэрэгэ дээр үлдэж хоцорчээ.

Гүюг хааны тамгын бичиг. Энэ тамгыг Гүюг хаанаас Европын Пап ламд 1246 онд илгээсэн бичиг дээр дарсан байна.

Энэхүү тамга бүхий бичгийг 1920 онд эрдэмтэн лам Кирилл Каралевский Ватиканы нууц архиваас олж гэрэл зурагт буулган авснаар түүний тухай судалгаа эхэлж 1923 онд Францын монголч эрдэмтэн П.Пеллио уг тамганы бичгийг "Монголчууд ба католик шашны төр" бүтээлдээ нийтлүүлснээр эрдэм шинжилгээний эргэлтэнд оржээ. Тамганы хэмжээ: 14.5x14.7 см. Бичиг нь: "Мөнх тэнгэрийн хүчин дүр их монгол улсын далай хааны зарлиг эл булха иргэн дүр хүрвээс биширтүгэй, аюутугай" хэмээжээ.

Гүюг хааны тамга

Дээрх тамгыг Чингис хааны тамга мөн хэмээн нилээд эрдэмтэд үздэг бөгөөд энэ саналын нь гол үндэс бол Чингис хааныг нас барснаас хойш Гүюг (1246-1248 онд их хаан ор суусан)-ийг хаан суух хүртэлх 18 жилийн хугацаанд монголын эзэнт улсын тамга үрэгдээгүй гэдэг.

Аргун хааны захидал. Монголын Илхаан Аргун (1284-1291 онд хаан суусан)-аас 1289 онд Францын Гоо Филипп хаанд илгээсэн энэ захидлыг Дорно дахины судлалын нэрт эрдэмтэн Абел-Ремюза Францын Үндэсний архиваас олж 1824 онд өөрийнхөө номд худам монгол бичигт буулган тайлбарын хамт чулуун бараар хэвлүүлжээ.

Эрдэмтдийн судалгаанаас үзвэл энэ захидал нь 182 см урт, 5 см өргөн хэмжээтэй хуйлмал олсон цаасан дээр хар өнгийн бэхээр бичсэн 34 мөр бичээстэй, мөрүүдийн хоорондох зай нь 5 см юм. Улаан дардас бүхий хаяш хаашаа 14.5 см хэмжээтэй дөрвөлжин тамгыг уг захидалд гурав дахин даржээ.

Энэхүү захидал нь Илхаан Аргунаас Египетийн мамелукуудтай дайтах тохиолдолд туслах цэрэг хөдөлгөн илгээх тухай Францын хааны амлалтанд өгсөн хариу юм. Энэ амлалтыг Ромын пап болон Өрнөдийн вангууд Илхааны элчээр очсон несторион шашны гэлэн Бар Саума гэгчээр дамжуулсан юм байжээ. Чухамдаа Францын хаанд цэргийн төлөвлөгөөг нь сайшааж байна гэдгээ мэдэгдэх үүднээс Аргун захидлаа бичжээ.



Аргун хааны захидал

Өлзийт хааны захидал. Иранд суух монголын Илхаанаар 1304 онд өргөмжлөгдсөн Өлзийт хаан (Аргун хааны хөвгүүн) 1305 онд энэ захидлыг Францын хаан Гоо Филиппт явуулжээ. Энэ захидлын эхийг 1289 оны Аргун хааны захидлын хамт Абел Ремюза Францын үндэсний архиваас олж 1824 онд чулуун бараар хэвлүүлжээ.

Өлзийт хааны захидал

Эдгээр захидал нь монголын сонгомол бичгийн хэл буй болохоос өмнөх үед холбогдох бөгөөд өдгөө бидэнд мэдэгдэж буй хамгийн чухал дурсгалуудын нэгэн болохын хувьд монголын түүх, хэл шинжлэл, дипломатын түүхэнд онцгой ач холбогдолтой юм.

Захидлыг хуйлмал олсон цаасан дээр хар өнгийн бэхээр 42 мөр болгон бичсэн бөгөөд өргөнөөрөө 48 см, уртаараа 3 м хэмжээтэй. Уг захидалд улаан өнгийн дардастай хаяш хаашаа 13 см хэмжээтэй том дөрвөлжин тамгыг уртааш нь тав дахин дарсан байна.

1304 оны тавдугаар сарын 17-нд нас барсан Газан ахаа залгамжлан хаан ширээнд суугаад хэдхэн сар болсныхоо дараа (1304 оны 7-р сарын 21) Өлзий хаан Гоо Филиппт энэхүү захидлыг бичжээ.

Өлзийт захидлаа төгсгөхдөө Францын султан нар хоорондоо хэл амаа ололцсоныг сонсоход таатай байв гэдгээ илэрхийлээд "Эдүгээ, Бидэнтэй ч, та бүхэнтэй ч үл найрамдах этгээдтэй бид Тэнгэрийн хүчин дор бүгдээрээ хамсран тэмцэхийг Тэнгэр мэдтүгэй" гэжээ.



Өлзийт хааны захидал

Мөнгөн гэрэгэний бичиг. Оросын Днепр мөрний орчмоос 1845 онд Монгол бичигтэй энэхүү Мөнгөн гэрэгэ олджээ. Монголын хаант улсын цэргийн ноён, элчид олгож байсан албан ёсны баталгаа тэмдэг бөгөөд тэдний хэргэм зэрэг, албан тушаалыг нь харгалзан алт мөнгөөр үйлддэг байжээ.

Гэрэгэний бичгийн нүүр талд:

"Мөнх тэнгэрийн хүчинд
Их суу залийн ихээхэнд"

Ар талд:

"Авдуллын зарим хэн үл бишрэх хүн алдах үхэх" гэжээ. Гэрэгэний хуулбар Үндэсний түүхийн музейд бий.

Мөнгөн гэрэгэний бичиг

III. Модон бар, түүгээр хэвлэсэн ном судрууд

Хүн төрөлхтөн бичиг үсэгтэй болж ном зохиол бичиж эхэлснээс хойш олон мянган жил өнгөрч, бичмэл ном хүмүүсийн хэрэгцээг хангаж чадахгүй болж ирэхэд ном судрыг хэвлэн олшруулах хэрэгцээ шаардлага гарч иржээ. Манай дэлхийн хаана ч ном хэвлэдэг оньсон техник бий болоогүй байх үед эртний дорно дахинд, түүний дотор монголд бичсэн номоо хувилан олшруулах хялбар нэгэн үйлдвэрийн арга олсон нь модон барын хэвлэл юм.

Түүхийн мэдээ баримт, судлаачдын бүтээлээс үзвэл монголжин аймгууд X зуунаас, монголчууд XIII зуунаас модон бараар ном хэвлэж байжээ. Тэдгээрээс Ачлалт ном (1308 он), Бодичарияа аватара (1312 он), Долоон өвгөн нэрт одны судар оршив (1330 он) гэх мэтийн олон ном өнөөдөр олдож эрдэмтдийн судалгаанд орсон байна.

Модон бараар ном хэвлэнэ гэдэг нь чанаж, шүүслээд сайтар хатаасан модон хавтсан дээр номынхоо үг үсгийг сийлээд, дараа нь түүн дээрээ хуудас хуудсаар цаас тавьж хэвлэдэг гар үйлдвэрийн арга юм. Энэ үйлдвэрлэлд модоо бэлтгэх, модон хавтсан дээрээ үгээ сийлэх үйл ажиллагаа хамгийн чухал нь юм. Нарийн ширхэгтэй, давирхай багатай, хатуу мод хусыг номын бар хийхэд өргөн хэрэглэж байв. Залуу хус модыг зуны цагт бэлтгэн банз болгон хатааж бар сийлэхдээ хэрэглэж байсан бөгөөд модоо хатаах, үг сийлэх зориулалтын олон багажийг бар сийлэгчид өөрсдөө хийж хэрэглэж байжээ. Зарим номын бар УТНС-д хадгалагдаж байна.

Модон бар

Монголчууд модон бараар хэдхэн хуудастай жижиг номоос эхлэн хэдэн зуун мянган хуудастай Ганжуур, Данжуур хэмээх их хөлгөн судруудыг хүртэл олон мянган номыг модон бараар хэвлэсэн бөгөөд модон бараар ном судар хэвлэх ажил Халх, Буриад, Өвөрмонголын олон хүрээ хийдэд хийгдэж байжээ. Иймээс ч монгол модон барын ном Ази, Европ, Америк, Австралийн соёл шинжлэх ухааны том том төвүүдийн номын санд хадгалагдаж байна.

Бодичарияа авадарагийн тайлбар. XX зууны эхээр Германы шинжилгээний анги хятадын Шинжааны Турфан нутгаас олон зүйлийн ном бичгийн дурсгал олж аваачсаны дотор Чойжи-Одсэрийн зохиосон энэхүү Бодичария авадарагийн тайлбарын сүүлчийн 12 хуудас олдсон байна. Сүүлийн хуудсан дээр 167 гэсэн хуудасны дугаар буйгаас үзвэл энэхүү 167 хуудас 334 нүүр бүхий томоохон номыг монголчууд 1312 онд барлан хэвлэж байжээ. Энэ 12 хуудас дотор Чойжи-Одсэр бандида Бодичария авадарагийн тайлбар зохиолыг хэрхэн туурвиж, хэвлэн нийтлүүлсэн тухайгаа 28 мөр төгсгөлийн шүлэг бичсэн байна. Бодичария авадара гэдэг нь эртний Энэтхэгийн гүн ухаантан Шантидевагийн зохиосон шүлэглэсэн зохиол бөгөөд түүнийг 1305 онд Чойжи-Одсэр монгол хэлээр орчуулсан ажээ.

Чойжи-Одсэр Бодичария авадараг орчуулаад зогсохгүй түүний тайлбар хэмээх энэхүү зохиолыг 1311 онд бичиж дуусаад 1312 онд модон бараар хэвлүүлсэн байна.



Бодичарияа авадарагийн тайлбар

Монгол Банзрагч судар. Буддын шашны энэ номыг 1308 онд эрдэмтэн Чойжи-Одсэр монгол хэлнээ орчуулсан. Үүнээс хойш хэд хэдэн удаа орчуулагдсан эртний монгол орчуулгын нэг. Энэ хөлгөн судартхүнд тохиолддог ад тотгорыг арилгах тухай бурхан багш нэгдүгээр биеэс өгүүлсэн байдаг. “Бие, хэл, сэтгэлийн нүглийг хэзээ ч бүү үйлд. Хамаг амьтны хамаг аюулт ад тотгорууд арилтугай. Хамаг амьтан энх эсэн болтугай” хэмээн олонтоо өгүүлэх бөгөөд “хамаг амьтны хүссэн мөрөөдсөн бүхэн сэтгэлчлэн бүтэж байх”-ын ерөөлийг тавьжээ.

Чойжи-Одсэр орчуулгынхаа эцэст томоохон төгсгөлийн үгийг шүлэглэн бичсэн байна. Тухайлбал 1686 онд модон бараар хэвлүүлсэн Банзрагчийн төгсгөлийн шүлэг нь нийт 39 бадаг буюу 156 мөр юм.

Монгол Банзрагч судар

Монгол Алтангэрэл судар. Алтангэрэл бол буддын шашны эртний судруудын нэг бөгөөд анх санскрит хэлээр бичигдсэн байна. Энэ судар мянга орчим жилийн өмнө уйгур хэлээр орчуулагдсан бөгөөд энэхүү уйгур Алтангэрэлийг Оросын эрдэмтэн Малов 1910 онд Ганьсу мужаас олж авсан байна. 1330 онд монголын эрдэмтэн Шаравсэнгэ уйгур төвд эхээс монгол хэлэнд орчуулжээ. Тэгэхдээ төвд, санскрит хэл мэдэх энэтхэгийн эрдэмтэн Буниа Бадра буюу Гива Содномтой зөвлөж орчуулав гэж Шаравсэнгэ төгсгөлийнхөө үгэнд бичсэн байна. Түүний орчуулсан Алтангэрэлийн бичмэл, дармал хэдэн эх бичиг монгол улсын төв номын санд байна. Дармал Алтангэрэлийг 1659 онд модон бараар хэвлэжээ. Энэ Алтангэрэл бол хамгийн хуучин орчуулга болохоос гадна хамгийн сайн орчуулга бололтой байна хэмээн академич Ц.Дамдинсүрэн дүгнэсэн байдаг.

Энэ номонд бурхан шашны агуулгатай үлгэр домгууд нилээд байдаг. Алтангэрэл нь 9 хэсэг, 24 бүлэгтэй, “Ном бол өглөгийн дээд өглөг” хэмээн номлосон энэ судрыг бариваас, уриваас, уншваас тэр хүний хамаг сэтгэсэн бүгд үтэр түргэн бүтнэ гэжээ.

Дөрвөн хэлний хадмал Жамбалцанжид. Улсын төв номын санд хадгалагдаж буй нилээд эртний номын нэгэнд энэхүү Жамбалцанжид хэмээх модон барын нугалбар судар зүй ёсоор орно. Энэхүү судрыг санскрит, төвд, монгол, хятад дөрвөн хэлээр хадаж 1502 онд модон бараар хэвлэжээ.



Монгол Алтангэрэл судар

Энэ ном нь монголын сонгодог бичгийн хэлний өмнөх дурсгал төдийгүй, нугалбар номын нэгэн өвөрмөц төлөөлөгч болдгоороо монгол үсэг бичгийн түүх, ном судлалд чухал ач холбогдолтой дурсгал юм.

Энэ номыг Түмэдийн Алтан хааны ач эрх Баягууд баатар дай хун тайжийн зарлигаар түүний хүү Чойжамц тойн цагаан туулай жил буюу Мин улсын Хун Жы хааны 15 дугаар онд хэвлэсэн тухай мэдээ бий.

Монгол шунхан барын Ганжуур. Монголчууд Ганжуурын доторхи зарим зохиолыг дээр үеэс орчуулж эхэлсэн болович бүрэн нэгтгэн орчуулах ажлыг Лигдэн хааны (1604-1634) зарлигаар бандид Гунгаа-Одсэр, дархан лам Самдансэнгэ, Билигт Эрдэнэ Дай гүүш, тойн Санрав нарын 50 гаруй орчуулагч 1629 онд хийж дуусгажээ.



Дөрвөн хэлний хадмал Жамбалцанжид

Монгол шунхан барын Ганжуур

Энэхүү Ганжуур 100 шахам жил гар бичмэлээр дэлгэрч байгаад Энх-Амгалан хааны зарлигаар 1717-1720 оны хооронд модон бараар хэвлэгдсэн байна.

Ганжуур доторхи номууд нь ихэвчлэн Шигэмүни бурхан, түүний шавь нарын зохиосон шашны зарлиг сургаал юм. Мөн түүний дотор ардын үлгэр домог, аман яруу найргаас эх үндэстэй элдэв домог цадиг, сургаалын шүлэг тэргүүтэй уран зохиолын зүйл ч бий.

Ботийн тоо 108. Хуудасны хэмжээ 23х72.5 см болно.

Монгол шунхан барын Данжуур. 226 боть төвд Данжуурын доторхи нилээд номыг XIV зууны үеэс эхлэн монгол хэлэнд орчуулсаар ирсэн боловч 1740-өөд оноос бүх монгол нутгаас 200 орчим орчуулагч нарыг цуглуулан ихээхэн хүчин чармайлт тавьсны дүнд 1749 онд Данжуурыг бүтнээр нь орчуулан дуусгаж 226 ботиор модон бараар хэвлэн гаргажээ. Данжуур нь гүн ухаан, учир шалтгааны ухаан, анагаах ухаан, урлах ухаан, дуун ухаан зэрэг шинжлэх ухааны олон салбарыг хамарсан 3427 нэр төрлийн ном, зохиолыг багтаасан 107839 хуудастай их хөлгөн судар юм. Хуудасны хэмжээ 23 х 72.5см.

Данжуурыг орчуулагч нарт аливаа ухааны нэр томъёог нэгэн мөр болгон орчуулахад хялбар дөхөм болгож "Мэргэд гарахын орон" нэрт төвд-монгол нэр томъёоны толь бичгийг Жанжаа хутагт Ролбийдорж удирдан зохиож 1748 онд модон бараар хэвлэн гаргажээ.

Ганжуур Данжуурыг монгол хэлэнд орчуулах, хэвд сийлэх, бичээч, урчуудын хүнс, ажлын хөлсөнд нийт 41600 гаруй лан мөнгө орсноос 31200 лан мөнгийг монголчууд сайн дураар тусалж, бусдыг нь улсын сангаас гаргажээ.

IV. Хулсан үзгийн бичмэл ном

Монголчуудын дунд нилээд өргөн хэрэглэгдэж байсан эртний уламжлалт бичгийн хэрэгсэл бол үнсэн самбар, хулсан үзэг юм. Үнсэн самбарыг тэгш харуулдан зассан модоор хийж гадаргуут нь тослон аргалын үнсээр өнгөлж бичиг бичихэд бэлэн болгоно. Энэхүү самбар дээрээ үзүүрлэсэн хулс модоор бичих бөгөөд үзэгний үзүүрээр үнс нь зурагдан бичиг гарна. Бичсэн бичгээ дахин үнсээр арчихад үсэг нь арилж шинээр үг бичихэд бэлэн болдог. Ийм самбар үзгийг хүүхдэд бичиг заах, модон бар сийлэхэд өргөн хэрэглэж байсан бөгөөд самбарыг нэгээс эхлэн хэд хэдэн хуудастайгаар хийсэн байдаг. Хулсан үзгийг бэхэнд дүрж болгомол цаасан дээр ном бичих арга монголд нилээд эрт үеэс дэлгэрч олон зуун номыг бичсэн нь өнөө хүртэл хадгалагдан үлджээ.

Үнсэн самбар, хулсан үзэг

Монгол шунхан барын Данжуур

Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч оршвой

XVII зууны монголын эрдэмтэн, гүүш Лувсанданзан энэхүү шастирыг 1657 онд зохиож, Чингис хаанаас эхлээд Лигдэн хаан хүртэлх үеийн Монголын түүхийг хамран өгүүлжээ. Эрдэмтдийн дунд "Лу. Алтан товч" хэмээн алдаршсан, монголын түүхийн нэн чухал энэ дурсгал

бичигт Монголын нууц товчооны 282 зүйлээс 233 зүйлийг бараг тэр хэвээр нь агуулсан учир монголын нууц товчооны монгол үсгээр үлдсэн нэгэн эх бичиг гэж үзэж болно.

"Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч оршвой" хэмээх энэхүү гар бичмэл нь 19 x 61.4 см хэмжээтэй болгомол цаасан дээр хулсан үзгээр бичсэн 177 хуудастай юм. Энэхүү гар бичмэлийг монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн Анхны дарга Онходын Жамъян гүн (1864-1930) Дорнод аймгийн Баянтүмэн хошууны Еншөөбү овгийн тайж Дарь гэдэг хүнээс олж Улсын номын санд оруулжээ.

Алтан товчид монголын нууц товчоонд байдаггүй XII, XIII зууны үеийн монголын түүхийн материал цөөнгүй байдаг.

Монгол бичмэл Ганжуур. Энэтхэгийн санскрит хэлнээс төвд хэлэнд орчуулсан бурханы шашны бүх номыг Төвдийн эрдэмтэн Будон Ринчиндүв XIV зууны үед эмхэтгэн цуглуулж Ганжуур Данжуур хэмээх 2 их цоморлиг болгосон байна. Энэхүү хоёр их хөлгөн судар бол Бурханы шашны утга зохиолын хоёр том цоморлиг бөгөөд шашин, шинжлэх ухааны хосгүй чухал дурсгал юм.

Ганжуурт эртний энэтхэгийн гурван аймаг савын ном үндсэндээ багтдаг бол Данжуурт түүний тайлбар чанартайгаар Энэтхэг, Түвэдийн эрдэмтдийн бичсэн их бага арван ухааны шастирууд ордог байна. Ганжуур нь монголоор "Зарлигийн орчуулга" гэсэн утгатай үг бөгөөд 1260 гаруй нэр төрлийн номыг багтаасан 108 боть, бөгөөд түүний дотор орсон нилээд номыг XIV зууны эхэн үеэс монгол хэлэнд орчуулж эхэлжээ. Ганжуурыг 1629 онд монгол хэлээр орчуулж дуусгаад 113 ботиор анх бичмэлээр нь эмхэтгэн гаргажээ. Энэхүү монгол бичмэл Ганжуурыг бага зэрэг засварлан 1717-1720 онд модон бараар хэвлэсэн байна.

Монгол улсын төв номын санд энэхүү модон үзгээр, хар бэхээр бичсэн монгол Ганжуур 76 боть хадгалагдаж байна. Энэ бичмэл Ганжуурыг монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн захирал Онход Жамъян Түшээт хан аймгийн Балдан засгийн хошууны нэг сүмээс авчирсан байна.

Монгол бичмэл Ганжуур

Анагаах ухааны судар. Монголчууд ном зохиолдоо элдэв зураг оруулан бүтээдэг уламжлалтай. Барын болон гар бичмэл аль ч номд гоёмсог сайхан зураг олныг оруулж өгүүлэн буй зүйлийнхээ утга агуулгыг улам тодорхой болгодог байв. Ялангуяа хүний биеийн бүтцийг харуулсан судар, элдэв зүйлийн эмийн судруудад хүний биеийн эд эрхтэн, ургамал, амьтан эрдсийн зүйлийн зургийг олонтоо оруулдаг. Тухайлбал хорь буриадын Худай овгийн увш Ванчигийн 1847 онд бичсэн "Элдэв зүйлийн эмийн нэр тодотгосон бичиг" хэмээх гар бичмэлд хүний биеийн байдал, эмчлэх аргыг:

- ясны зүйл
- хумсны зүйл
- махны зүйл
- үсний зүйл
- цусныз үйл
- өөхний зүйл
- тархины зүйл
- зүрхний зүйл
- арьсны зүйл гэх мэтээр ангилан тодорхой зурагнуудаар харуулснаас гадна эмийн зүйлүүдийг зураг тайлбартайгаар оруулжээ. Номын хэмжээ 39.5 x 55 см.

Анагаах ухааны судар

IV. Бийрийн бичмэл ном судрууд

Монголчуудын өргөн хэрэглэж байсан бичгийн хэрэгсэл бол бийр юм. Зөөлөн үсээр хийсэн бийрийг хар, улаан зэрэг өнгийн бэхэнд дүрж ихэвчлэн муутуу цаасан дээр бичиж байжээ. Бийрээр бичих нь хулсан үзгээр бичихийг бодвол хурдан, татлан бичихэд тохиромжтой байдаг тул ном судар бичихээс гадна өдөр тутмын албан хэрэг, бичиг захидал бичихэд өргөн хэрэглэж байжээ.

Юан улсын судар

Юан улсын судар нь XIII, XIV зууны үеийн Монголын түүхийг судлахад гол хэрэглэгдэхүүн болох түүхийн том хэмжээний бүрэн зохиол юм. Уг номыг 1368 онд байгуулсан Мин улсын хаан Жу Юань Жаны зарлигаар Сун Лянь (1310-1381), Ван Вэй (1322-1373) нарын ерөнхий удирдлагын доор 30 гаруй хятад түшмэд эрхлэн зохиожээ. Чингис хаанаас хойшхи монголын түүхэнд холбогдох 165 жилийн түүхийг энэ сударт хамруулжээ.

Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн жинхэнэ гишүүн, нанхиадач Дандаа Чинсан хэмээн алдаршсан эрдэмтэн Чимидийн Дэмчигдорж (1863-1932) Юан улсын судрыг бүрэн эхээр нь 5 жил орчуулан дуусгажээ. Дандаагийн орчуулсан энэхүү монгол эх нь 26.5 x 27.5 см хэмжээтэй 210 дэвтэр болгон үдсэн, муутуу цаасан дээр хар бэхээр бийрээр бичсэн гар бичмэл бөгөөд өдгөө Монгол улсын төв номын санд хадгалагдаж байна.

Чингис хааны угийн бичиг.Одоо байгаа баттай баримтаас үзвэл монголчууд VIII зууны үеэс удам угсаагаа амаар болон бичгээр үр хойчдоо дамжуулан уламжлуулсаар иржээ. Үүний үр дүнд улсын төв номын санд болон үндэсний түүхийн архивт олон зуун угийн бичиг өнөө хүртэл хадгалагдаж байна. Эдгээрээс хамгийн эртний бөгөөд олон хаадын тухай мэдээлэл агуулсан нь Чингис хааны бүр дээд өвөг Бөртэ чино, Гоо марал хоёроос эхэлсэн монгол хаадын угийн бичиг болно. Энэ угийн бичиг нь Бида хэмээх монгол улсын анхны ноён болгон өргөмжилсөн Бөртэ чиноос эхлэн Түшээт хан Гомбодорж, Сэцэн хан Шолой нарын үр хүүхдүүдийг хүртэл 42 үеийн угсаа гарлыг хамарсан бөгөөд 100 x 352см хэмжээтэй давхарлан наасан муутуу цаасан дээр хар, улаан бэх хэрэглэн бийрээр бичсэн гар бичмэл юм. Бидэнд уламжлан ирсэн энэ бичмэлийг 19-р зууны үед хуулан бичсэн нь бичгийн хэв, доторхи мэдээллүүдээс нь харагдаж байна. Энэ бичмэлд хүний үе бүрийг тасархай улаан шугамаар заагла дээрээс нь доош цувруулан хар бэхээр бичжээ.

Зарим ноёдын үр хүүхдүүдийн нэрийг дурдалгүй, Тэдний хүүхдүүдийн захирч байсан хошуудыг дурдсан зүйл түгээмэл байна. Жишээ нь: Тэмүүжин Чингис хааны дүү хавт Хасар гээд түүний үр Жирмийн чуулганы: Хорчин 6 хошуу, Жалайд нэгэн хошуу, Дөрвөд нэгэн хошуу, Горлос 2 хошуу, Зуун удын чуулганы: Ар хорчин нэгэн хошуу, Улаан цавын чуулганы: Дөрвөн хүүхэд нэгэн хошуу, Урад 3 хошуу, муу мянган нэгэн хошуу гэх мэтээр бичжээ.





Чингис хааны угийн бичиг

Монголын аймаг хошуудын газрын зургууд. Монголчууд эрт дээр үеэс газар нутгаа тодорхой хуваарь хязгаартай эзэмшиж, өөрийн газар нутгийнхаа байр зүйн зургийг үйлдэж байсны гэрч болсон олон зуун газрын зураг УТНС-д хадгалагдаж байдаг юм. Эдгээр зургийн дотор монголын бүх аймаг, хошууд, хилийн харуулын зураг байна.





Зураг дээрх мөрөн, нуур, уул нуруу, суурин газруудын нэрийг хар бэх хэрэглэн бийрээр хичээнгүйлэн бичсэн байна. Мөн тухайн нутаг хошууны хилийн овоодын нэрийг бүрэн бичихийг эрмэлздэг байсан ба уг зургийг хэдийд үйлдсэнийг заавал бичдэг байжээ. Газрын зургуудын хэмжээ харилцан адилгүй бөгөөд зарим нь 400x350 см хүрдэг. Монголчууд хошуу нутгийнхаа газрын зургийг зурж хадгалахаас гадна уг зургаа тайлбарласан шинжтэй цэсүүдийг дэвтэрчлэн бичиж үлдээсэн нь олонтаа тохиолдоно.

Энэ газрын зургийг муутуу цаасан дээр юмуу даавуун дээр олон өнгө хослуулан уул, нуруу, гол мөрөн, нуур, гүвээ толгод, ой мод, сүм хийд хот суурины хүртэл бодитой дүрслэн гараар зурсан байдаг.

VI. Алт, мөнгө, есөн эрдэнээр бүтээсэн ном судрууд

Жалзэ Тэмбэн Ганжуур. Төвдийн түүхч Бүдон Ринчиндүв (1290-1364)-ийн дахин шүүсэн Гарчгийг дагаж Жалзэгийн хаан Равдангүнсэнпаг Нартан Ганжуурыг уг эх болгоод Жалзэ тэмбан гэж алдаршсан энэ Ганжуурыг бүтээжээ. Төвдийн тэмбон гэдэг үгийг "босго тэвчих", "босго давуулан гаргахыг тэвчих" гэсэн утгатай үг гэж зарим эрдэмтэд үздэг. Үүнд энэ Ганжуурыг Жалзэгийн хааны зарлигаар босгоор гаргахгүй хадгалах нандин шүтээн болгож байсан учир тэгж нэрлэсэн гэдэг. Гэтэл зарим төвд сурвалжид энэ Ганжуурыг сайтар арчутган магадалж гарчгийн тэмдэглэл бичгийг нэг мөр болгон зохиохдоо дээд зэргээр шалган байцааж гэрч тэмдэг болгон барьсан тул тэмбанма буюу "гэрч тэмдэг" гэж алдаршсан гэдэг. Мөн энэ Ганжуурыг төвдөд гарсан хамгийн анхны бичмэл ганжуур ч гэж тэмдэглэсэн зүйл байдаг.

Монголын эрдэмтэн төвдөч Л.Хүрэлбаатар "тэнбанма" гэдэг нь босго тэвчих гэсэн үг огт биш, харин "байцаан шалгасан гэрч тэмдэг" гэсэн үг гэдгийг баталсан байна. Одоо улсын төв номын санд хадгалагдаж буй Жалзэ тэмбан хэмээх бичмэл Ганжуур нь 111 боть хуудасны хэмжээ нь 70.5 x 25.0 см.

Энэ Ганжуурыг 1671 онд Өндөр гэгээн Занабазар V Далай лам Лувсанжамцаас халхад залж ирсэн түүхтэй.

Түүхийн сурвалж бичгүүдээс звэл монголчууд маш эрт үеэс алт, мөнгөөр ном бичиж байжээ. Тухайлбал Юан улсын судрын 30-р дэвтэрт: "Алтан үсгийн төвд ганжуур бичүүлэв", 35-р дэвтэрт: "Алтан уйгур үсгийн Аюуш бурханы ном мянган боть бичүүлэв", "Нухмал алтаар бурханы ном нэгэн сав бичүүлэв" гэж дурдсан байна. Монголчууд XVIII, XIX зууны үед алтаар ном бичдэг энэхүү эртний уламжлалаа улам бататган болгомол хар цаасан дээр алтаар бичсэн олон ном одоо хүртэл хадгалагдаж үлдсэн байна.

V богд Жавдандамба XIV жарны төмөр үхэр (1841) жилийн эхээр өөрийн зарлигаар их сангаас хөрөнгө гарган бүтээлгэсэн "Алтан үсгийн Ганжуур"-ыг Гунгаачойлин дацанд өргөсөн нь одоо Гандантэгчинлин хийдийн номын санд байна. Энэ бол төвд хэлээр бийрээр бичсэн гар бичмэл болой. Харин монгол үсгээр алтаар Ганжуурыг бичиж бүтээж байсан түүх бас бий. Тухайлбал Лигдэн хааны

Алтан Ганжуурын эхний боть

зарлигаар 1629 онд орчуулж дууссан монгол Ганжуурыг Хөх хотын Ширээт зууд Лори Ай гүүш, Мэргэн билэгт, Сүрэн, Баян тэргүүтэй уран бичээчид биндэрьяагийн өнгөт хөх цаасна алтан үсгээр бүтээж 213 ботиор сударлан тахилын шүтээн болгосон гэдэг. Эдгээр ботиудаас үрэгдсээр одоо 19 боть нь Өвөрмонголын нийгмийн Шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд хадгалагдаж байна. Алтан ганжуур нь боловсруулсан хар цаасан дээр алтан үсгээр бичсэн 101 боть ном бөгөөд одоо Гандантэгчинлин хийд, УТНС-д хадгалагдаж байна. Цаасны хэмжээ 75 x 21см, эх бичгийн хэмжээ 60 x 14см. Нэг хуудсанд 8 мөрөөр бичжээ. Төвд хэлээр бийрээр бичсэн гар бичмэл ном.

Жалзэ Тэмбэн Ганжуур

Алтан Данжуур. Болгомол хар цаасан дээр алтан үсгээр бичсэн 212 боть төвд үсгийн бичмэл Алтан Данжуур одоо УТНС-д хадгалагдаж байна. Цаасны хэмжээ 64 x 21см, эх бичгийн хэмжээ 55 x 15см. Нэг хуудсанд 9 мөрөөр бичжээ.

Энэ ном нь монгол улсад байгаа ганцхан хувьтай номуудын нэг болно. Улсын төв номын санд буй энэ алтан Данжуурыг хэзээ хаанаа бүтээсэн тухай судалгааны ном зохиолуудад тэмдэглэгдэн үлдсэн зүйл байхгүй байна.

Алтан Данжуур

Энэ судрын хавтсан доторхи тахилын хуудсанд төрөл бүрийн хээтэй 5 өнгийн торгоор хөшиг хийсэн байна. 355 хуудастай.

Уран барилгын багана, таазны хээ, бурхан тахилын ширээ, бурхан номын үсгийг бичих зэрэг модон эдлэлийн чимэглэлд сийлбэрийг төлөөлүүлж хийдэг зүмбэр хэмээх нэгэн сонин урлаг монголчуудын дунд бие даасан хэлбэрээр хөгжсөн байна. Зүмбэрийг талхалсан шаазан буюу гантиг чулууны нунтгийг элсэн чихэр, цавуутай ус зэргээр найруулан зуурч цөцгий мэт нэгэн төрлийн өтгөвтөр зуурмаг болгож, тусгай нарийн үзүүртэй гуурсаар зургийнхаа дагуу гоожуулан зурдаг. Бас өөхөн цагаан, шаазан, гантигийн элсэн нунтгийг хуурайгаар нь тосон будагтай хольж янз бүрийн өнгө гаргаад нарийн үзүүртэй гуурсаар гоожуулж бичиж байжээ.

Зураг дээр хавтасны дотор талын үгийг зүмбэрлэж чимэглэсэн, алтаар бичсэн "Жадамба" судар. Хуудасны хэмжээ 21x75см. Ягаан өнгийн хатуу цаасан хуудасны бичиг бичих хэсгийг боловсруулан хар болгоод түүн дээрээ алтаар бичсэн байна.

Монгол үсгийн алтан Жадамба. Болгомол хар цаасан дээр алтан үсгээр бичсэн 17x53.5см хэмжээтэй 356 хуудас бүхий бичмэл судар. Нэг хуудсан дээр 30 мөрөөр бичсэн.

Монгол алтан үсгээр бичсэн номуудаас одоогоор хамгийн том нь энэ судар болой."Арван зүгийн гурван цагийн хөвүүн сэлт ялгуугсадын эх, гүн билэг барамидын эрхэм дээд найман мянгат хэмээн алдаршсан гайхамшигт дэвтэр их эрдэнэ ... үүнийг бэйс ноён хатанд барилдсан ... Пүрэвжав хийгээд амарлингуй хоёул ... дурдаж ... алтаар бичигтүн хэмээн зарлиг болсонд ... Намсрайжав бээр сайтар бичив" гэсэн төгсгөлийн үгтэй. Улсын төв номын санд хадгалагдаж байна.

Монгол үсгийн алтан Жадамба

Сандуйн жүд. Монголын нэрт дархан Дагва тэргүүтэй урчууд XIX зууны сүүлчээр цалин цагаан мөнгө, шижир алтаар Богд хан уулын өмнө орших Манзуширийн хийдэд урлан бүтээсэн ганц хувь судар. Уг судрыг монгол дарханы хөөмөл, шармалын аргыг хэрэглэн цэвэр мөнгийг 59 х 15см хэмжээтэй хуудас болгон давтаж, энэхүү хуудсан дээрээ номынхоо үгийг хөөлгөн цохиж, алтаар шарсан байна. Судрын эхний болон төгсгөлийн хуудсанд номын үг, үсгийг шижир алтаар үйлдэн мөнгөн хуудсан дээрээ тогтоожээ. Эхний хуудасны алтан үсгийн хэмжээ нь дан үсэг 1.5 х 2 см, давхар үсэг нь 1.5 х 4 см, эцсийн хуудасны (110-р хуудас) алтан үсгийн хэмжээ нь дан үсэг 1 х 1 см, давхар үсэг 1 х 1.3 см юм.

Ингэж үйлдсэн 2 мөнгөн хуудсыг ар араар нь нийлүүлэн модон хүрээ жаазанд бэхэлжээ. Жаазыг хийхдээ хус модыг тагнайлдах углуургаар углуургадаж, хоёр талд нь хүрэн сум модыг эв нийлүүлэн наасан байна. Ийнхүү 222 мөнгөн хуудсыг 111 жаазанд суулгаж жааз бүрийн дугаарыг мөнгөөр үйлдсэн аж. Сандуйн жүд судрын зарим хуудсанд 3, зарим хуудсанд 2 бурхан гэх мэтээр нийт 50 бурханыг хөөмлийн аргаар бүтээж заримыг нь алмааз, шүр, сувд тэргүүтнийг шигтгэн чимэглэжээ. Номын нэг хуудас нь 1.2-3.7кг жинтэй бөгөөд нийтдээ 1460 лан буюу 52 кг 560 г цэвэр алт мөнгө орсон.

Номын хуудасны урт нь 73.8 см, өргөн нь 21.9 см, зузаан нь дунджаар 2.3 см болно. Энэ номын эхний 4 хуудас нь хоёр давхар хөшигтэй, гадна талын хөшгийг төвд хоргойг ногоон торгоор хоёр давхарлан доторлож хийсэн. Дотор талын хөшгийг хөх торгон дээр тахилын охин тэнгэрийн 4 дүрийг өнгө өнгийн торгон утсаар хатгамал хийж бүтээсэн. Нийт 4 торгон хөшиг дээр 16 тахилын охин тэнгэрийн дүрийг маш урнаар хатгамал хийж урлажээ.

Хөшигний хэмжээ 15 х 58.5 см.

Энэ номыг Манзуширийн хийдэд хутагт Цэрэндорж хэрэглэж байгаад VIII богд Жавзандамбын номын сангаар дамжин 1924 онд Улсын төв номын санд иржээ.

Сандуйн жүд

Доржжодба. Доржжодба хэмээх хөлгөн судрыг мөн цалин цагаан мөнгөн хуудсан дээр шижир алтаар урласан 32 хуудастай Улсын төв номын санд хадгалагдаж байна.

Уг судрыг урласан арга, үсгийн хэлбэрийг харвал Сандуйн жүдийг урласан дархчууд энэ жижиг номыг туршилтын журмаар Сандуйн жүдийн өмнө бүтээсэн гэж үзэж болмоор байна.

Эхний хоёр хуудасны үсгийг шижир алтаар урлаж мөнгөн хуудсан дээр бэхэлсэн, шүрэн чимэглэлтэй таван бурхантай. Судрын хуудасны хэмжээ 74.3 х 22.3 см.

Доржжодба

Эхний хуудасны алтан үсгийн хэмжээ нь дан үсэг 2 х 2.3 см, давхар үсэг 2.8 х 3.5 см юм.

Хоёр мөнгөн хуудсыг ар араар нь нийлүүлэн хус модоор углуургадаж хийсэн жаазанд суулгажээ. Судрын бурхадыг мөнгөн хуудсан дээр хөөлгөн урлаж, өнгө ялгасан, нэгдүгээр хуудсан дээр 3 бурхан бий. Үүний баруун гар талын бурхан 15 х 12.4 см, дундахь бурхан 15 х 13 см, зүүн гар талын бурхан 15 х 12.3см хэмжээтэй, хоёрдахь хуудасны баруун гар талын бурхан 14 х 11см, зүүн гар талын бурхан 15.5 х 12.4см байна.

Хуудасны ирмэгийг нь чимэглэсэн алтан Жадамба. Монголоор "Хутагт билгийн чанад хязгаарт хүрсэн найман мянгат хэмжээгдэх хөлгөн судар оршив" гэдэг нэртэй энэ судрыг хар хөх цаасыг боловсруулан бичих хэсгээ гялгар хар болгоод алт найруулан бийрээр уран гоё бичсэн 369 хуудастай. Хуудасны хэмжээ 13.3 x 53 см. Бүх хуудасны эх бичгийг тойруулан давхар хүрээ татаж дунд нь хээ угалз байрлуулсан. Эхний 3 хуудасны баруун зүүн гарт бурхадын хөргийг өнгө ялган зурсан. Хавтасыг нь халуун орны хатуу модоор хийсэн, дээд хавтасны төв дунд ланз үсгээр ум маани бад мэ хум гэдэг үгийг алтаар бичсэн. Судрын дөрвөн талын ирмэг хүрээг тод өнгийн цэцэгс ургамлаар чимэглэж, хойд урд талын чимэглэл дунд 8 тахилыг бадма цэцгэн суурьтай зуржээ. Зүүн гар талын хажуу ирмэгт ум маань бад мэ хум гэдэг үгийг ланз үсгээр эвхэж зурсан, баруун гар талын хажуу ирмэг дээр дүрэлзэж буй галын дөл дотор чандмань эрдэнэ зурж чимэглэсэн байна. Судрын төгсгөлийн үгэнд "Агваанчойдог найруулж, Чүлтэмчойнпэл алтан үсгээр бичлээ" гэжээ.

Хуудасны ирмэгийг нь чимэглэсэн алтан Жадамба

Есөн эрдэнээр бичсэн Ганжуур. Монголчууд зөвхөн алт, мөнгөөр ном бичээд зогсолгүй 9 эрдэнэ, 7 эрдэнэ, 5 эрдэнээр олон ном бичсэн нь өнөөдөр уламжлан иржээ. Алт, мөнгө, шүр, сувд, оюу, номин, тана, зэс, ганг тусгай технологиор найруулан бэх болгож бийрээр бичсэн номыг 9 эрдэнээр бичсэн ном гэдэг.

9 эрдэнийн Ганжуурыг боловсруулсан хар цаасан дээр мөнгө, оюу, шүр, сувд, дун, алт, зэс, номин гэх мэт 9 эрдэнээр үсэг, мөр сэлгүүлэн бичжээ. Судрын цаасны хэмжээ 16.5 x 70.5см, эх бичгийн хэмжээ 12 x 50см. Энэ ганжуурыг урьд нь Улаанбаатар хотод буй Дашчойнпэл дацанд залж байсан бөгөөд уг дацанг хаагдахад УТНС-д шилжиж иржээ. 9 эрдэнээр бичсэн энэхүү бичмэл Ганжуурыг Төвдийн Далай ламаас тавдугаар Богдод өргөсөн юм. Одоо УТНС-д 108 боть хадгалагдаж байна.

Есөн эрдэнээр бичсэн Ганжуур

Есөн эрдэнээр бичсэн Ганжуур. Монголчууд зөвхөн алт, мөнгөөр ном бичээд зогсолгүй 9 эрдэнэ, 7 эрдэнэ, 5 эрдэнээр олон ном бичсэн нь өнөөдөр уламжлан иржээ. Алт, мөнгө, шүр, сувд, оюу, номин, тана, зэс, ганг тусгай технологиор найруулан бэх болгож бийрээр бичсэн номыг 9 эрдэнээр бичсэн ном гэдэг. 9 эрдэнийн Ганжуурыг боловсруулсан хар цаасан дээр мөнгө, оюу, шүр, сувд, дун, алт, зэс, номин гэх мэт 9 эрдэнээр үсэг, мөр сэлгүүлэн бичжээ. Судрын цаасны хэмжээ 16.5 х 70.5см, эх бичгийн хэмжээ 12 х 50 см. Энэ ганжуурыг урьд нь Улаанбаатар хотод буй Дашчойнпэл дацанд залж байсан бөгөөд уг дацанг хаагдахад УТНС-д шилжиж иржээ. 9 эрдэнээр бичсэн энэхүү бичмэл Ганжуурыг Төвдийн Далай ламаас тавдугаар Богдод өргөсөн юм. Одоо УТНС-д 108 боть хадгалагдаж байна.

VII. Монголчуудын хэрэглэж байсан бичиг үсгийн дурсгалууд

Монголчууд түүхэндээ хэд хэдэн бичиг үсэг зохиож тодорхой цаг хугацаанд хэрэглэж байсан юм. Эдгээрээс дөрвөлжин үсэг соёмбо үсэг, тод үсэг, хэвтээ дөрвөлжин үсэг, вагиндрагийн үсгүүдээр бичиж хэвлэсэн номууд хадгалагдан үлджээ.

Монголын нууц товчоо. XIII зууны монгол хэл, утга зохиол, түүхийн хосгүй үнэт дурсгал бол Монголын нууц товчоо юм. Түүнийг 1240 онд зохиогдсон гэж олон эрдэмтэд үздэг боловч анхны эх бичиг нь одоо болтол олдоогүй. Анх монгол хэлээр бичигдсэн монголын нууц товчоог монгол хэлээр хятад үсгээр Жан Юан Цзе, Маша Ихэ гэдэг хоёр эрдэмтэн буулгаж бичээд үг бүрийн нь хажууд хятад орчуулгыг хадаж 1382 онд хэвлэн гаргажээ.



Энэ эх нь бидний үед уламжлан ирсэн юм. Монголын нууц товчооны энэхүү эхийг Оросын эрдэмтэн Кафаров Бээжинд сууж байхдаа Манжийн хааны номын сангаас нэг танил эрдэмтнээр сэм авахуулан зөвхөн хятад орчуулгаас Орос хэлээр дам орчуулаад 1866 онд хэвлүүлснээр дэлхийн олон нийт "Монголын нууц түүх" хэмээх энэ алдарт бүтээлийг мэдэх болсон юм. Монголын нууц товчоо бол XIII зууны үед монголын их улс мандах цагт монгол орны дотор болсон үйл явдлуудыг чухам үнэнээр нь өгүүлсэн учир түүхийн хосгүй үнэт дурсгал болно. Нэгэнт тэр үеийн үйл явдлыг уран яруу дүрслэн бичсэн болохоор бас монгол хэл, уран зохиолын маш чухал дурсгал бичиг юм.

Ийм учир монголын нууц товчоог дэлхийн олон хэлээр орчуулж, түүний талаар судалгааны олон зуун бүтээл хэвлэгдээд байна. Монголын нууц товчоонд Чингис хааны дээд язгуур Бөртэ Чинуа, Гоо марал хоёроос эхлэн Чингис хааныг нас барж, Өгөөдэйг хаан болсон үеийг хүртэл Монголын түүхийг өгүүлсэн байдаг.

Дөрвөлжин үсгийн Субашид. Монголын Хубилай хааны зарлигаар Төвдийн эрдэмтэн Пагба лам Лодойжалцан (1235-1280) 1260 онд зохиож, 1269 онд хааны зарлигаар Юан гүрний төрийн бичиг болгожээ.

Үсгийн хэлбэр нь төвд үсэгтэй ойролцоо бөгөөд дээрээс нь доош бичдэг монгол бичиг, хятад үгийг ч бичих боломжтой юм.

Саж бандида Гунгаажалцан (1182-1251) XIII зууны эхэн үед Субашид гэдэг шүлэглэлт зохиолыг төвд хэлээр зохиожээ. Энэ зохиол нь монголд их дэлгэрсэн бөгөөд XIII зууны үед Сономгара гэдэг хүн орчуулснаас гадна өөр хэд хэдэн орчуулга бий. 9 бүлэгтэй энэ зохиол нь бурхан шашны ном биш, ардын уран цэцэн үгийн түүвэр чанартай яруу найргийн зохиол юм.

XIII зууны эцэс XIV зууны эхээр Монголын дөрвөлжин үсгээр Субашидыг хэвлэж байсны баримт болох энэхүү тасархай хуудсуудыг 1906 онд Финляндын нэгэн жуулчин Дорнод Туркистаны нутгаас олсон юм. Эдгээр тасархайнуудыг Финляндын монголч эрдэмтэн Рамстедт, түүний шавь Аалто нар судалж Субашид гэдэг номын хуудас болохыг баталжээ. Энэ тасархай хуудсууд Хельсинкийн номын санд хадгалагдаж байна.

Дөрвөлжин үсгийн Субашид

Тод үсгийн ном. Тод үсгийг Ойрадын Зая бандида Намхайжамц (1599-1662) монгол бичгийн цагаан толгойд ижил хэлбэртэй байдаг ха, га, да, та, за, жа, ча, ца, о, у, ө, ү зэрэг үсгүүдийг ялгаатай болгон 1648 онд зохиожээ. Зая бандид тод үсгийг зохиосны дараа 1650-1662 оны хооронд 12 жилийн дотор төвд хэлнээс 177 ном зохиол орчуулсан нь бичмэл, дармалаар олдсоор байна. Тэдний дотор болгомол хар цаасан дээр алтаар бичсэн Жадамба судар ч бий.

Тод үсгээр "Очроор огтлогч", "Алтангэрэл", "Жадамба", "Үлгэрийн далай", "Субашид", "Молон тойны тууж", "Саран хөхөөний намтар" зэрэг орчуулгын зохиолуудаас гадна "Хан харангуй" тууль, "Жангарын тууль", "Убаши хун тайжийн тууж", "Зая бандидын намтар сарны гэрэл" зэрэг монголын уран зохиолын олон ном бичигдэж өнөө хүртэл уламжлан ирсэн юм.



Тод үсгийн номын хуудас

Соёмбо үсгийн ном. Соёмбо үсгийг Халхын Өндөр гэгээн Занабазар (1635-1723) 1686 онд Энэтхэгийн ланз үсэг дээр тулгуурлан зохиосон. Цагаан толгой нь 90 үсгээс бүрдэнэ. "Соёмбо үсгийн утгыг нээгч Занабазарын таалын чимэг оршив" хэмээх гар бичмэл номонд "Занабазар төмөр барс жилийн (1686 он) өвлийн дунд сарын шинийн арван гурванд гадагш гарах үед ланз үсгийн дүрстэй адил үсэг огторгуйд олноор үзэгдсэнийг үндэс болгон соёмбо үсгийг зохиосон" гэж бичсэн байдаг. Соёмбо гэдэг нь өөрөө гарсан гэгээн үсэг гэсэн утга бүхий санскрит үгнээс гаралтай. Соёмбо үсгээр бичиж хэвлэсэн ном цөөн бий.

Соёмбо үсгийн цагаан толгой, Соёмбо үсгээр хэвлэсэн "Итгэл" хэмээх судар

Вагиндрагийн үсгээр хэвлэсэн ном. Буриадын Агваан хамба (1853-1939) 1905 онд Буриадын шинэ үсэг буюу Вагиндрагийн үсгийг зохиожээ. Вагиндра гэдэг нь Агваан гэдэг төвд нэрийн санскрит орчуулга юм. Энэ бичигт монгол бичгийн а-э, о-у, ө-ү, г-х, т-д зэрэг ижил дүрстэй үсгүүдийг тод бичгийн нэгэн адил өөр өөр хэлбэртэйгээр тодорхой болгохыг зорьсон байна.

Мөн тухайн үед монгол бичигт байгаагүй зарим үсгүүдийг нэмсэн бөгөөд үгийн эхэн, дунд, адагт үсгийн хэлбэр өөрчлөгдөхгүй байхаар зохиосноороо монгол тод үсгээс ялгаатай. Энэ бичиг нь төдий л дэлгэрч чадаагүй учир түүгээр бичсэн цөөхөн дурсгал үлджээ.

"Бурхан багшийн гэгээний хураангуй намтар болон буян хан хөвүүний намтар оршив" хэмээх 19 хуудастай хорголжин бараар орос цаасан дээр хэвлэсэн ном УТНС-д хадгалагдаж байна.

Вагиндрагийн үсгээр хэвлэсэн ном

Хэвтээ дөрвөлжин үсгээр хэвлэсэн номын хуудас. Энэ бичгийг 1686 оны гал барс жил Өндөр гэгээн Занабазар соёмбо үсэгтэй хамт нэгэн дор зохиожээ. Хэвтээ дөрвөлжин бичгээр бичсэн хэдэн зүйл хэсэг бусаг цагаан толгой, нэгэн зүйл тарни, ханын чимэг зэрэг цөөн дурсгал үлджээ.

VIII. Монгол номын зарим төрөл зүйлээс

Хуйлмал ном. Хуйлмал ном нь монгол гар бичмэл номын нэг сонин төрөл бөгөөд зохицсон, уутанд хийж ганзагалах, ханын толгойноос зүүж хадгалахад ихэд тохиромжтой. Уг номыг бичихдээ жигд хэмжээний өргөнтэй цаасан дээр хэсэг хэсгээр нь бичиж дуусаад, бичсэн олон хуудсаа дэс дараагаар нь угсруулан нааж гүйцсэний дараа хоёр талын үзүүрт нь номынхоо хуудаснаас арай урт нарийн бөөрөнхий мод тогтоож хийдэг байжээ. Эцсийн хуудасны адагт тогтоосон модоо ороож номоо хуйлсаар эхний хуудасны эхэнд хадсан модонд хүргэж 2 модоо уулзуулан аль нэгд нь байдаг цацагтай уягаар уяж хуйлмал номыг хадгалдаг бөгөөд ийм номыг уншихдаа хуйлаасыг ухраан задалж, уншсан хэсгээ эхний


Хэвтээ дөрвөлжин үсгээр хэвлэсэн номын хуудас

Хуйлмал ном

үзүүрийн модонд ороон хуйлдаг байсан ажээ. Хуйлмал номыг цаас даавуун дээр бичдэг. Даавуун дээр ихэвчлэн бага хэмжээний өргөмжлөл мэтийг бичдэг байсан бол цаасан дээр томоохон хэмжээтэй номыг бичиж байжээ. Жишээлбэл Улсын төв номын сангийн фондод 1662 онд саган Сэцэний зохиосон "Эрдэнийн товч"хэмээх ном хадгалагдаж байна. Энэ номыг муутуу цаасан дээр хар бэхээр бийрээр маш сайхан бичсэн байна. Номын хэмжээ нь 21 см өргөн, 71м урт юм.

Хатгамал ном. Зүү ороож оёх урлаг нь Монголчуудын дунд ихэд дэлгэрсэн гайхамшигтай урлаг юм. Модон барын номд хүртэл зүү ороон оёж номын гарчиг хийж байжээ. Жишээ нь: "Цагаан лянхуа нэрт их хөлгөн судар оршив" хэмээх монгол үсгийн номын гарчгийг торгомсог хүрэн даавуугаар бүрсэн хавтасны гол дунд цайвар ногоон торгон дээр саатай тод хүрэн утсаар зүү ороон оёж хийжээ. Энэ аргаар зөвхөн номыг гарчиг, хавтасны чимэглэл хийгээд зогсохгүй бүхэл бүтэн номыг оёж бүтээсэн байна. Зураг дээр хар торгон дээр шар торгон утсаар зүү ороон оёсон Итгэл хэмээх судар. Энэ номыг XIX зууны сүүлчээр Түшээт хаан аймгийн ар долоон гөрөөчин овгийн уран хатгамалч Должин урлажээ. Монгол улсын төв номын санд хадгалагдаж байгаа энэ номын үсгүүдийг болон эх бичгийн Гадуурх шугамыг шар торгон утсаар урласан байна. Харин бичиг бүхий хоёр торгон хуудсаа ар нуруугаар нь нийлүүлсэн ирмэгийг нь улаан торгон утсаар хөвөрдөн оёж нэг хуудас болгожээ.

Хатгамал ном

Ногоон дар эхийн тууж. Монголын нэрт эрдэмтэн толь зүйч, төвдөч С.Шагж XX зууны эхээр 1914 онд хялгасаар бичсэн гар бичмэл. 5.5 х 5.5см хэмжээтэй цаасан дээр ногоон дар эхийн туужийг төвд үсгээр багтаан бичсэн.

Ногоон дар эхийн тууж

Энэ ном бол монгол улсын хамгийн жижиг номын тоонд ордог.

Шагж гуай энэ номыг бичихдээ зуны аагим нартай өдөр гэрийнхээ өрхийг битүүлэн татаж, өрхний завсраар өчүүхэн зай гарган түүгээр туссан нарны хурц гэрэлд бичсэн гэдэг. Энэ номыг Шагж гуай бичихдээ томруулдаг шил хэрэглэлгүй бичсэн бөгөөд түүнийг энгийн нүдээр унших аргагүй жижиг үсэгтэй тул өсгөдөг шил хэрэглэн уншиж болно.

Шар торгон өргөмжлөл. Богд эзэн хаан болон Манжийн эзэн хаанаас шашин, төрийн үйл хэрэгт гарамгай гавьяа байгуулсан хүмүүст гавьяа зүтгэлийг нь үнэлж цол хэргэм олгож шар торгон өргөмжлөл гардуулан шагнадаг байсан ажээ. Ийм өргөмжлөл УТНС-д нилээд хадгалагдаж байгаагаас наймдугаар Богд Жавзандамбын шар торгон өргөмжлөлийг төлөөлүүлэн үзүүлэв. Төвд монгол хэлээр бичсэн энэ өргөмжлөлийн хэмжээ нь 240 х 72см юм.

Шар торгон өргөмжлөл

Үйсэн дээр бичсэн ном. Монголчууд эрт үеэс хус модны үйсэн дээр ном судар бичиж байсан баримт нилээд олджээ.

1930 онд ОХУ-ын Ижил мөрний хөвөөнөөс XIII зууны сүүл үеэр монгол уйгур бичгээр бичсэн 25 хуудас үйсэн дээр бичсэн бичиг олдсон нь "Алтан ордоны үйсэн дээрх бичиг" хэмээн алдаршсан юм. 1970 онд Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг дахь Хар бухын балгасны чулуун суваргаас Х.Пэрлээ нарын эрдэмтэд нилээд олон тооны үйсэн дээр бичсэн бичгүүдийг олжээ. Эдгээр бичгийн дотор XVI зууны хоёрдугаар хагасаас эхлэн XVII зууны 40-өөд он хүртэлх хугацаанд Халхын дөрвөн хошуу, зургаан хошуу, долоон хошууны ноёдын 18 удаагийн чуулганаар хэлэлцэн тогтоосон 18 цаазын хураамж-хуулга байсан байна. Эдгээр цаазны хуулгын үйсэн хуудсын хэмжээ 10х14 см. Хусны үйсний өнгөн талыг хуулан цэвэрлэж, дэвтэрлэн утсаар үдсэний дараа ар өвөр талд бичгээ бичжээ. Бичгийн хэв зурлага нь XIV зууны үеийн уйгаржин бичгийн хэвийг санагдуулна.

Үйсэн дээр бичсэн ном

Зэс бар. XX зууны эхээр монголын нэрт сийлбэрчин бор Чүлтэм, Тунгийн Шар тэргүүтэй дархчуудын зэсээр сийлж хийсэн номын бүрэн бар. Жадамба хэмээх энэ номын 13.5 х 63.5см хэмжээтэй 1494 хуудас зэс бар уг бараар хэвлэсэн номынхоо хамт УТНС-д хадгалагдаж байна.

Зэс барын эхэнд соёмботой, ард сүм, суврага, бурхны зурагтай, эргэн тойрон хээ угалз сийлбэрлэсэн хос шугаман хүрээтэй. Мөн номын үйл явдалтай холбоо бүхий олон зураг сийлсэн байна. Энэ барыг сийлэхдээ зузаан зэс хуудсаа үнс, элс, модны давирхай зуурч хийсэн лавтай модон хашлагад хадаж тогтоогоод түүн дээрээ бараа ухаж сийлжээ.

Зэс бар

Чулуун бар. XVIII зууны үед Германд анх чулуун бараар ном хэвлэснээс хойш энэ нь хэвлэлийн үйлдвэрт ном хэвлэдэг нэгэн төрлийн арга болжээ.

Монголчууд саарал баргилт, зөөлөн цагаан чулуугаар чулуун бар хийдэг байжээ. Чулуун бар нь өө сэвгүй толийлгон зассан чулуун дээр бичих зүйлээ бичиж буулгаад дараа нь тусгай хороор идүүлж үсгээ тогтоогоод түүнээсээ цаасан дээр хэвлэн гаргадаг арга юм.

УТНС-д "Номын өглөг барагдашгүй гарахын угсаа дээд Данжуур ринбүүчийн хэвийг сонсгож мэдүүлэх луугийн дуу хэмээгдэх оршив" гэдэг чулуун барын ном байна. Энэ номыг муутуу цаасан дээр нэг талд нь хэвлээд нугалан дэвтэрлэж, эрчилсэн бүдүүн шар утсаар үджээ.

Тугал хурганы арьсан баринтаг. Ном судрыг ус чийг авахуулахгүй, хугарч нугарахгүй хадгалах нэгэн өвөрмөц арга монголчуудад байсан нь энэ юм. Хурга тугалын арьсны үсийг хусч гөлгөр болгоод, бүрэн элдэж зөөлрүүлэлгүй хагас хатуугаар нь ном судрынхаа хэмжээнд тохируулан нугалж хэлбэр гарган хийдэг байжээ. Хэмжээ нь 42.5х14 см.

Тугал хурганы арьсан баринтаг

Эсгий шогол. Монголчууд хониныхоо ноосыг боловсруулан эсгий болон гэр ахуйн олон эдлэл хэрэглэл хийж байсан бөгөөд эсгий дээр олон төрлийн хээ угалз гарган ширж эсгий ширмэлийн урлаг бий болгосон байна. Үүний нэг нь эсгийгээр 6 тал гарган дөрвөлжин хэлбэртэй хийсэн номын шогол юм. Энэхүү эсгий шогол одоо УТНС-д хадгалагдаж байна. Шоголын хэмжээ 55 х 11 х 13 см юм.

20-р зууны монгол ном. 1912 онд "Монгол хэвлэлийн хороо" хэмээх хэвлэх үйлдвэрийг тугалган үсэг өрж хэвлэдэг 1 гар машин 3 ажилчинтайгаар байгуулж монгол үсгийн ном хэвлэж орчин үеийн хэвлэлийн газрын үндэс суурийг тавьжээ. Энэ үеэс "Бага хөвгүүдийн сургуулийн сурах бичиг", модны шастир, усны шастир, цаасан шувууны үлгэр, оюун түлхүүр зэрэг номуудыг хэвлэж эхэлжээ. Мөн монгол улсын анхны сэтгүүл "Шинэ толь", "Нийслэл хүрээний сонин бичиг", "Монголын үнэн" сонинуудыг хэвлэж байжээ.

1921 онд "Монгол үсгийн хэвлэлийн хороо" байгуулснаар монгол ном олноор хэвлэгдэх боломж нээгдсэн байна.

Монголын түүхийн 5 боть

1930 оноос хэвлэн гаргах номын тоо, нэг номын хэвлэх хувь өсч орос зэрэг гадаад хэлнээс ном орчуулан хэвлэх ажил улам өссөн байна.

Ард нийтийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэхэд чухал түлхэц болсон С.Шагжийн "Үсгийн дүрмийн товч толь бичиг", "Монгол үсгийн дүрмийн толь бичиг", А.Амарын зохиосон "Монголын товч түүх" (1934 он) хэвлэгдэн гарав. 1945 онд Ж.Самбуугийн "Мал аж ахуй дээрээ яаж ажиллах тухай ардад өгөх сануулга сургаал" ном өнгөт зураг чимэглэлтэй хэвлэгдсэн байна. 1959 оноос эхлэн монголын эртний утга зохиол, түүхийн сурвалж бичгүүдийг фото офсет хэвлэлийн аргаар хэвлэх ажил эхэлжээ.

1960-аад оноос монгол улс бүх нийтээрээ бичигтэн болж унших ном хэвлэлийн хэрэгцээ асар их нэмэгдэв. 1940-50-иад оноос бүх аймагт хэвлэх үйлдвэр байгуулагдаж аймгийн сониноос гадна ном товхимол хэвлэх болжээ.

1990-ээд оны сүүл үеэс Монгол улсад хувийн олон хэвлэх үйлдвэр бий болж, хэвлэлийн ажилд орчин үеийн шинэ техник технологи нэвтрүүлснээр орчин үеийн ямар ч номыг чанар, өнгө үзэмж сайтай хэвлэх, хэвлэлд бэлтгэх боломжтой болов. Үүний үр дүнд "Монгол улсын түүх" 5 боть, Л.Түдэв "Бүтээлийн чуулган", 25 боть, Монголын 100 хаан, 8 богдын намтрын 33 боть цуврал, "Монголын нэвтэрхий толь" 2 боть, "Монголын их бага хаад болоод засаг төрийн тэргүүнүүд" альбом, С.Лувсанвандан "Түүвэр зохиол" 9 боть, "Монголын уран зохиолын дээжис" 108 ботийн 90 ботийг хэвлэн гаргаад байна.

Ж.Сэржээ

С.Уранбилэг
Э.Амарбилиг

ХОТ БАЙГУУЛАЛТ, АРХИТЕКТУРЫН ХӨГЖИЛ

Монголчууд эрт дээр үеэс эсгий гэрт сууж нүүдэллэн амьдрахын хамт зарим хэсэг нь нүүдэлчдийн онцлог бүхий хот суурин байгуулж тэдгээрт аж төрж ирсэн билээ.

Монгол нутагт үүсэн бий болсон эртний хотуудыг цэрэг, засаг захиргааны, худалдаа арилжааны , соёл шашны төвүүд гэж ангилж болно. Гэхдээ зарим хот эдгээр шинжүүдийг хамтад нь багтаах нь олонтаа байв. Тухайлбал, Уйгарын нийслэл Харбалгас, Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум, хожмын үеийн Улиастай, Ховд, Өргөө (Улаанбаатар) хотуудыг дурдаж болох юм.

Судлаачид Монголын архитектурыг орон сууцны, тахил шүтээний барилгын, орд харшийн барилгын, шарил хөшөө дурсгалын архитектур гэж ангилдаг. Монголын хот байгуулалт, архитектурын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн түгээмэл орон сууц болох гэр өөрийн өвөрмөц нөлөөг үзүүлсээр иржээ. Ялангуяа аян дайны үед хот хүрээ байгуулж нүүдэллэн явж байсан үед болон шарын шашин дэлгэрч шашны томоохон хүрээ хийдийн суурин газар байгуулахад гэр, гэрийн зохион байгуулалт, хэлбэр маяг онцгой үүрэг гүйцэтгэж байв.

Монголын эзэнт гүрэн байгуулагдахаас өмнөх үед эртний нүүдэлчин Хүннү, Сяньби, Тоба, Түрэг, Уйгар, Хятан улсын үеийн хотууд нь гол төлөв хаадын орд харшийг дагалдсан хамгаалалтын хэрэм цайз, цамхаг бүхий цэрэг-засаг захиргааны үүрэгтэй хорооллоос бүрдсэн бүтэцтэй байв. Мөн энэ үед уран барилга хөгжиж, нүүн зөөх сууц болох гэрийг боловсронгуй болгон хэрэглэхийн хамт ялангуяа шавар хэрэм цайз, хаадад зориулсан орд харш, шүтээн тахилгын барилга байгууламж барих талаар их амжилтад хүрч байсныг сурвалж бичгүүдэд олонтаа дурджээ.

Сүүлийн үед явуулсан эртний судлалаар Хүннү улсын үед хамаарах хэдэн хэрэм хотын туурь олдсон байна. Тухайлбал, Хэрлэн мөрний савд Төв аймгийн Баян жаргалан сумын нутагт буй Гуа дов, Баяндэлгэр суман дахь Өндөр дов, Мөнгөнморьт суман дахь Бэрхийн дөрвөлжин, Тэрэлжийн дөрвөлжин, Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт буй Баянбулаг, Буриадын нийслэл Улаан-Үдээс ойрхон Сэлэнгэ мөрний хөвөөнд "Иволгийн балгас" зэрэг эртний хэрэм хотуудын туурийг нэрлэж болно.

Гуа довын туурь нь малталт хийх үед урд, хойд талдаа их хаал-ганы ор бүхий дөрвөлжин шороон хэрэмтэй, хэрмийн төв хэсэгт 3 м өндөр, 4 м өргөн 56 м урт хэмжээтэй том барилгын ор үлдэцтэй, хэрэм нь хойноос урагш 367 м, баруунаас зүүн тийшээ 360 м, өргөн нь 3,5-7,5 м, өндөр нь 50- 70 см байсан ажээ.

Дээр нэр дурдсан бусад хотуудын туурь нь голдуу эргэн тойрон дагтаршуулсан хэрэмтэй, хэрмийн төв дунд ямар нэг орд юмуу барилгын ор үлдэцтэй ажээ. Үүнээс үзэхэд тэр үед хаадад зориулсан орд харш, мөргөл шүтээний барилга барьж, хэрмээр хамгаалах болсон бөгөөд түүнийг дагалдан хот суурин байгуулагдан хөгжиж байсан нь илт бөлгөө.


Гуа-Дов хотын туурийн дэвсгэр зураг

Бурхийн дөрвөлжин хотын туурийн дэвсгэр зураг


Өндөр довын туурийн дэвсгэр зураг

Түрэг улсын үед хаадын орд барьж, хот байгуулж байсан түүхэн мэдээ сэлт байгаа боловч өнөөг хүртэл тэдгээрийн үлдэц туурь тогтоогдоогүй байна. Харин түргүүд орд харш барьж байсан туршлагаа түшиглэн тахилга тайлга, оршуулгын томоохон цогцолборуудыг байгуулж, дурсгалын бичигт хөшөө босгож байсан нь тэр үеийн Төв Азийн түүх соёл, архитектур, хот байгуулалтын гайхамшигт дурсгал болон мөнхөрчээ.

Хөшөө Цайдамын гэж алдаршсан тахилга шүтээний бунхант дурсгалын цогцолбор нь Архангай аймгийн Хашаат сумын нутагт, мэргэн сайд Тоньюкукт зориулсан тахил шүтээний цогцолбор Налайх хотоос холгүй байна. Өнөөгийн судалгааны байдлаар өөр хоорондоо 1 км орчим зайд орших Культегин жанжин болон Билгэ хаанд зориулсан 2 бунхант дурсгал, тэдгээрийг тойрсон хэнд зориулсан нь үл мэдэгдэх 2 жижиг дурсгал, мөн Культегений дурсгалаас баруун хойно 150 метрт орших шинээр нээн илрүүлсэн дурсгалууд болон бичигт хөшөөнөөс зүүн тийш 3 км үргэлжлэх "Бил бал" босоо чулуун хөшөөнүүд байна.

Культегинд зориулсан Онгон шүтээний дурсгал



Культегинд зориулсан дурсгалын цогцолборын дэвсгэр зураг

Мэргэн сайд Тоньюкукт зориулсан Онгон шүтээний дурсгал

Культегинд зориулсан онгон шүтээний дурсгалын туурийг тэр үеийн тахилга шүтээний архитектурын дурсгалын төлөөлөл болгон авья.

Зүүнээс баруун тийш 67x31 м гонзгой хэрэмтэй шуудуун хүрээтэй тэр дурсгалын зүүн хананд байгаа хаалганы 2 талд өөдөөсөө харсан хонины гантиг чулуун баримал байсан байна. Шавар хэрмийг шохойдоод дээд талыг ваараар өнгөлжээ. Байгууламжийн төв хэсэгт шороо дагтаршуулан барьсан 13 х 8 м тавцан байгаа бөгөөд эргэн тойрон саарал тоосго наан бөхөлжээ. Хэрмийн доорхи бүх талбай, шалыг хөх тоосгоор дэвсэн бүрхсэн байв. Тавцан дээр 10,4 х 10,8 м талбайтай 0,65 м зузаан ханатай барилгын суурь буй. Энэ барилгыг тахилын сүм байжээ гэж үздэг. Сүмийн ханыг цагаанаар шохойдож түүнийгээ улаан будгаар хээлж, дээврийг ваараар өнгөлж, луугийн дүрс зэргээр чимэглэсэн байсан гэж тогтоожээ. Гол хаалганаас сүм хүртэлх замын 2 талаар хүний дүрс баримлуудыг чулуугаар хийж байрлуулсан нь хүндэт харуулуудыг төлөөлүүлсэн санаа бололтой.

Сүмийн зүүн талд 3,33 м өндөр 1,32 м өргөн, 0,46 м зузаан гэрэлт хөшөө байна. Хөшөөний гурван талд "Орхоны " түрэг, нэг талд нь хятад бичээстэй. Нийт 68 мөр, 10,000 шахам үсэгтэй энэ бичээсэнд VIII зууны эхэн үе хүртэлх Түрэгийн түүхийг өгүүлж, Билгэ хааны дүү Культегин жанжны баатарлаг гавъяа, үйлийг магтан бичсэн байна.

Хөшөө Цайдамын цогцолбор дурсгал нь тухайн үеийн хот байгуулалт, архитектур, дүрслэх урлагийн ололт, бичиг үсэг, түүхийн ховор нандин сурвалжийг агуулсан үнэт дурсгал юм.

Культегин болон Билгэ хааны тахилга шүтээний цогцолборыг барьж байгуулахад шатаасан тоосго шавар шохой, зуурмаг хэрэглэсэн төдийгүй ус дамжуулах шавар вааран хоолой хэрэглэсэн нь туйлын сонирхолтой. Барилгын зарим хийц, тухайлбал дээврийн ус зайлуулах хоолойг Европын улс орнуудаас дутахааргүй хэрэглэж байсны баримт ч илэрчээ.

Монголын нутагт Уйгурын хаант гүрэн 100 орчим жил тогтнож байсан үед хот суурин, архитектур цэцэглэн хөгжсөн бөгөөд хэмжээ нь тэлж, зохион байгуулалт нь төгөлдөржиж иржээ. Үүнийг өнөөдөр Уйгур улсын нийслэл байсан Хар балгас хот болон Байбалык хотын туурийн археологийн дурсгалууд бүрнээ нотолж байна.

Хар балгас хотын туурийн археологийн дурсгал нь Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвөөс баруун хойш 25 км зайд байна. Хар балгас нь барагцаагаар 50 гаруй $км^2$ талбай эзэлсэн том хот байжээ.

Их хотын баруун хэсэгт Уйгурын хааны орд харш байрлаж байсан ба тэр хэсгийг 0,6 х0,6 км хэмжээ бүхий дагшруулсан шороон хэрмээр хүрээлсэн байна. Хэрмийн нурангийн өндөр одоо 10 м хүртэл байгаа юм. Түүний эргэн тойронд харуулын цонжууд барьжээ. Хэрмэн ханын буланд налуулан

Хар балгас хотын туурийн дэвсгэр зураг

Хар балгас бол Уйгарын эзэнт гүрний нийслэл бөгөөд Хэрмэн бэхлэлт бүхий хааны орд өргөө, цэргийн хуаран, дэлгүүр, тариачид гар урчуудын дүүрэг, шашны сүм хийд бүхий хот байжээ. Тэр үед Хар балгасаас гадна нэлээд олон хот байсны ор үлдэц илэрсэн бөгөөд тэдгээрээс Хар балгасны туурь барьсан тусгай том цонжийг цэргийн зориулалттай гэж үздэг. Хэрмийн төвд том цайз байсан бөгөөд түүний үлдэцийн өндөр нь 14 м орчим байна. Хэрмийн хоёр хажуугаар эгнүүлсэн байдлаар нэжгээд суварга барьсны ор үлдэц одоо ч байна.

Уйгарын хааны ордны туурь

Байбалык хотын туурь

овор хэмжээ, хот төлөвлөлтийн арга ухаан, архитектурын үнэ цэнээрээ хамгийн сонирхолтой, ач холбогдолтой нь юм. Хар балгас өнөөдөр 1000 гаруй жилийн тэртээх сүр жавхаа, үзэсгэлэнт төрхөө нэгэнт алдсан хэдий ч тэр үеийн төв Азид байсан хэрмэн бэхлэлт хотуудаас харьцангуй хамгийн сайн хадгалагдан үлдсэн, түүх, соёлын ховор дурсгал билээ.

Хар балгасны туурийн үлдэгдлээс эртний Уйгар улсын төдийгүй Төв Азийн нүүдэлчин гүрнүүдийн хөгжил цэцэглэл, архитектур, хот байгуулалтын хүрсэн түвшин, өвөрмөц онцлогуудыг дүрслэн харж болно. Туурийн үлдэгдэл нь тэр үеийн хот төлөвлөлтийн ерөнхий зарчим, дэг журам, барилга байгууламжийн хэлбэр, хэмжээ, хийц, хэрэглэгдэхүүний онцлогийг илтгэн харуулж байгаа билээ.



Хар Балгас хот дахь хааны ордны цогцолборын туурийн дэвсгэр зураг

Хэрмийн гол хаалгаар гарахад шавар ханаар хүрээлсэн том талбай байх бөгөөд үүнийг судлаачид цэцэрлэгт хүрээлэн байжээ гэж үздэг. Үүний зэрэгцээ хааны шүтээн байсан бололтой хэрэмтэй дугана сүм байсны ор үлдэц байх ба энэ хавьд Уйгарын хаадад зориулсан Уйгар, Хятад, Орхон-Енисейн бичээстэй гэрэлт хөшөөнүүдийн эвдэрсэн хэсгүүд олдсон болно.

Хар Балгас хотын хааны ордны хэрмэн доторхи Цонжийн үлдэгдэл

Хятан улсын үед Монгол аймгуудын нутагт цэргийн бэхлэлт хотууд байгуулан сууж байсан тухай түүхийн сурвалж бичгүүдэд дурдсаны 10 орчим нь Эртний судлалаар нотлогдоод буй билээ. Тэдгээрийн дотроос Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт байгаа Чинтолгойн балгас, мөн Харбухын балгасын туурь, Дорнод аймгийн Цагаан Овоо сумын нутагт буй Их суварга бүхий Хэрлэн барс хэмээх хэрэмт хотын туурь, Хэнтий аймгийн Мөрөн сумын нутаг дахь Зүүн хэрэм хэмээх хотын үлдэц туурь, мөн аймгийн Батширээт сумын нутагт буй Өглөгчийн хэрэм зэрэг нь нэлээд илүү судлагдсан нь болой.

Хятаны үеийн хот байгуулалтын төлөвлөлт нь Түрэг, Уйгарын уламжлалыг ерөнхийд нь хадгалж байсан хэдий ч 1-6 м зузаан дагтаршуулсан шороон хэрэм бүхий бэхлэлт цайзанд олон давхар цамхаг барих, хэрмэн хашаан дотуур усан суваг татаж унд болон усалгаанд хэрэглэх болсон зэргээрээ онцлог сонирхолтой юм. Хэрлэн барс хот, Хар бухын балгасын өндөр цамхагууд болон Чин толгойн орой дээрхи байгууламжийн үлдэц туурь нь дээр дурдсаныг илтгэн харуулж байна. Хэрмийн гадна гаргасан гудамжнаас чинагш оршин суугчдын хороолол, гар урчууд, дархчуудын дархны газрууд байсан байна.



Чин толгойн балгас

Хар бухын балгасын туурь



Хэрлэн барс хотын долоон давхар цамхаг суварга

Монгол нутаг дахь Хятаны үеийн хотын харьцангуй хадгалагдан үлдсэн томоохон дурсгалын нэг бол Хэрлэн барс-1 хотын туурь мөн. Барс Хот-1-ийн их хэрмийн дотор ба зүүн /гадаа/ талд 5 ба 7 давхар суваргатай байжээ. Хэрмийн баруун өмнөд хэсэгт өндөр шороон довжоон дээр чулуугаар барьсан бага хэрмийн дотор 4 байшингийн суурьтай юм. Энэ бага хэрмийн орчин тойронд 5-6 метрийн хэмжээтэй дөрвөлжин барилгын ор 10 гаруй байна.

Цамхаг суваргын дотоод байдал

Хэрлэн Барс хотын хөх тоосгоор барьсан тав ба долоон давхар хоёр суварга хийц маягийн хувьд Энэтхэг суваргатай төстэй бөгөөд 1940 -өөд он хүртэл хананд нь бурхны томоохон зураг байсан аж. Таван давхар цамхаг суварга нь 1940- өөд онд нуржд, долоон давхар цамхагийн үлдэц ор одоо байгаа болно.

Монголын нутагт Монгол аймгууд Хятан гүрэн мөхсний дараа ч хот хэрэм тасралтгүй байгуулж байсан тухай мэдээ түүхийн сурвалжуудад бий. Ван хан Тоорил өөрийн орд харш, хот суурьнд сууж байсан талаар Рашид-ад-Дин, Марко Поло нар бичжээ.

Монголын эзэнт гүрний болон феодалын бутралын үед Монгол нутагт хот байгуулалт, архитектур цэцэглэн хөгжиж байжээ.

Монголын эзэнт гүрний үед хот суурин, ялангуяа түүний нийслэл Хархорум хот цэцэглэн хөгжиж, Ази Европын олон үндэстний хүмүүс хөлхсөн цэрэг, улс төр, худалдаа арилжаа, шинжлэх ухаан, соёл, уран барилгын хөгжлийн зангилаа төв болж байсан билээ.

Хархорум хотын туурь нь Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвийн дэргэд Орхон голын хөвөөнд байна.

Эзэн Богд Чингис хаан 1220 онд "Хорум" хотыг Их Монгол улсын нийслэл хэмээн зарласан ажээ. Хаан эцгийн хүслийн дагуу Хархорум хотыг жинхэнэ нийслэл болгох их ажлыг 1228 -1241 онд төр барьж байсан Өгөөдэй хаан гүйцэтгүүлжээ. Хамгийн сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд Хархорум нь нийтдээ 8х8 км талбай эзэлж байсан ба түүний төв хэсэг нь 1450 орчим метр, хойд тал нь 1150 орчим метр, урд тал нь 600 гаруй метр урттай зузаан шавар хэрмээр хүрээлэгдсэн томоохон хот байсан байна. Хэрмийн дөрвөн хаалгыг чиглэсэн том том гудамжтай байсан нь дэвсгэр зургаас харагдаж байна.

Их хэрмийн баруун урд өнцөгт тусгай дөрвөлжин хэрмэн дотор том орд харшийн цогцолборын туурь байна.

Энэ нь Өгөөдэй хааны үед "Түмэн амгалант" хэмээх том орд бариулж тойруулан хэрэм цогцлоосны үлдэц мөн юм. "Түмэн амгалант" харшийн цогцолборын гол Ордон нь тусгайлан зассан өндөр довжоон дээр чулуунд суурилсан 64 багана бүхий их танхимтай байсныг тогтоожээ. Мөн ордны үүдэн хэсэгт Францын дархан Вильгельм де Бушегийн урласан орой дээрээ бишгүүр үлээсэн Лха тэнгэрийн дүрстэй Мөнгөн мод байсан бөгөөд найр наадмын үед бишгүүр нь уянгалан дуугарч, дөрвөн арслангийн амнаас дөрвөн зүйлийн тансаг амттан гоожиж, түүгээр зочдыг дайлдаг байсан тухай жуулчин Рубрук тэмдэглэн үлдээжээ.

Өгөөдэй хааны Түмэн амгалант ордны мөнгөн мод
(Зураач Б.Пүрэвсүх)



Хархорум хотын туурийн дэвсгэр зураг

Ордны баруун, зүүн талд хоёр хоёроор цувж байрлуулсан гонзгой дөрвөлжин байшингууд байсан аж.

Хотод Хятад, Орос, Франц, Англи, Мажаар зэрэг

Хархорум хотын чулуун мэлхийнүүд

дэлхийн олон орны хүн суудаг, Будда, Христос, Лалын шашны 12 сүм дуганд хурал хурж, мөргөл үйлддэг байсан байна. Их хэрмийн дотор гадна гар урчууд, жижиг үйлдвэр эрхлэгчид, худалдаачид, цэргийн хүмүүс амьдардаг байсныг эртний судлалын мэдээ, сурвалж бичгүүд нотолж байна.

Хубилай хаан 1260 онд Монголын Их гүрний нийслэлийг Хятад оронд шилжүүлсэн хэдий ч Хархорум хот XIV зууны сүүлч хүртэл Монгол орны улс төрийн нэг төв хэвээр байсан юм.

Эртний Хархорум хотын туурь нь Монголчуудын төдийгүй Дэлхийн нийтлэг үнэ цэнэ бүхий түүх, соёлын гайхамшигт дурсгал мөн.

Монголын эзэнт гүрний үед нийслэл Хархорумаас гадна Чингис хааны ордууд, Өгөөдэй хааны бариулан сууж байсан орд өргөө, хотууд байснаас гадна Чингис хааны бусад хүүхдүүд их хаад болон тэдгээрийн залгамжлагчдын байгуулсан орд өргөө хотууд нэлээд байдаг байна. Тэдгээрээс Чингис хааны 4 ордны нэг их орд болох Аургын орд, Мөнх хааны орд хот, Өгөөдэй хааны хэд хэдэн ордны нэг Гэгээ цагаан ордтой суурин хот, Хавт Хасарын хүү Есүнхэ мэргэний (Чита хотын ойролцоо) байгуулсан Көндийн хот, Монгол Хятадын хил орчим орших Хар хот, Хубилай хаан ширээнд суусны дараа барьж байгуулсан Шанду хот, мөн Хубилай хааны зарлигаар Юань гүрний нийслэл болгосон Да-ду зэрэг хотууд хот байгуулалт архитектурын хувьд баяжин урд үеэсээ улам боловсронгуй болон хөгжжээ.



Хар хотын дэвсгэр зураг



Көндийн хотын туурийн дэвсгэр зураг



Шанду хотын туурийн дэвсгэр зураг

Аургын ордны туурь
(Хэнтий, Дэлгэрхаан сум)

Хубилай хааны цэргийн хотын туурь
(Өвөрхангай, Хайрхандулаан сум)

1368 онд Юань гүрэн унаж Монгол нутагт феодалын бутрал газар авч, гоё сайхан орд харш бүхий олон зарим суурин газруудыг мөхөлд хүргэжээ.

Хархорум хот хоёр ч удаа Хятадын дайралтад өртөн шатаалгасны зэрэгцээ түүнийг дотоодын дайн самууны үед түйвээсэн нь дахин сэргэлгүй мөхөхөд хүргэсэн байна.

Харин XVI зууны үеэс Монголд хот суурин байгуулах явдал сэргэж эхэлсэн бөгөөд Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт Туул голын савд "Цогт тайжийн Цагаан балгас" түүний нэг гэрч болно.

Цогт тайжийн Цагаан байшин, Гэрэлт хөшөө

Цогт тайжийн Цагаан байшингийн хана

Халхын Цогт Хун тайж 1601-1617 онд энэхүү ордоныг бариулсан байна. Цагаан байшинг хуучин барилгын суурь дээр барьж хэрмийн дундаас дээш хэсгийг тоосгоор, доод хэсгийг чулуугаар үйлджээ. Хэрэм, цагаан ордноос гадна жижиг сүм, сууцны барилгуудын ор үлдэц байх бөгөөд тэдгээр нь өнгө өнгийн паалантай гоёмсог чимэгт ваараар чимэглэгдсэн байсан аж. Түүний ойролцоо Монгол, Төвөд бичээс бүхий чулуун хөшөө одоо ч байгаа билээ.

Манжийн дарлалын болон тусгаар тогтносон Богд хаант Монгол улсын үеийн хот байгуулалт ба архитектур нь өөрийн онцлогтой байдаг.

Энэ нь: Нэгд, Монгол улс Манжийн эрхшээлд орохоос өмнө 1577 онд буддын шашныг Монголын албан ёсны шашин болгосон нь XVII-XX зууны Монголын хот байгуулалт, архитектурын хөгжилд шашин шүтээний архитектур гол чиглэл нь болж шинэ үе гарах нөхцөл бололцоог бий болгожээ.

Хоёрт, Манж улс ноёрхлоо бэхжүүлэх зорилгоор хэд хэдэн цэргийн цайз байгуулсан нь хожим үедээ цэрэг, худалдаа арилжаа, соёлын төв болон өргөжин хөгжсөн байна. Тийм цайз хотуудын тоонд Ховд, Улиастай зэрэг хот орно.

Гурав, Монгол тэр үед дөрвөн аймагтай байсан бөгөөд зарим аймгийн толгой ноёд орд харш бариулан суудаг байсан байна. Тухайлбал Сайн ноён хан Дондовдорж, Засагтхан Гомбосүрэн нар орд бариулан амьдарч байв. Гэхдээ ноёдын орд харш барих ажил нэг их түргэн дэлгэрээгүй бөгөөд харин Богд гэгээн тэргүүтэй шашны толгой лам нар ордны цогцолборууд бариулж байсан нь өнөөдөр зарим нь хадгалагдан үлдсэн байна. Их хүрээн дэх Богд гэгээний өвлийн ногоон ордон үүний жишээ болж чадах билээ. Энд Европ маягийн хоёр давхар сууцны барилга болон нэлээд хэдэн сүм баригдсан байна.



Цогтын цагаан байшингийн туурийн дэвсгэр зураг

Бурханы шашныг албан ёсоор хүлээж авсны дараахан 1586 онд Ар Монголын Түшээт ханы ураг болох Автай сайн хан Эрдэнэзуу хийдийн Гол зуу сүмийг бариулснаар Монголын архитектурын хөгжлийн энэхүү шинэ үеийг эхлүүлсэн байна. Тэр үеэс сүм дуган, хийдийн тоо жил жилээр нэмэгдсээр 1937 он гэхэд 4000 гаруй сүм дугана, суваргын барилга бүхий 750 орчим бага, том хийдийн цогцолбор баригдсан байв.

Бурханы шашны зан үйлийг эхэн үедээ эсгий гэрт, дараа нь нүүдлийн модон сүм дуганд үйлддэг байснаа аажмаар суурьшмал томоохон сүм хийдүүдэд хийх болжээ.

Өнөөдөр түүх, шашин, соёл, хот байгуулалт,



Эрдэнэ зуу хийд



Эрдэнэ зуу хийдийн дэвсгэр зураг



Эрдэнэ зуу хийд дэх Гурван зуу

архитектурын дурсгал болон зарим хэсэг нь хадгалагдан үлдсэн болон зарим нэг ор үлдэц нь байгаа хэдхэн хүрээ хийдийн дотроос Эрдэнэзуу хийд, Амарбаясгалант хийд, Гандантэгчилэн хийд, Заяын хүрээ, Гэсэр сүм, Дамбадаржаалин хийд, Төвхөн хийдийн үлдэц, Баруун хүрээний үлдэц, Чойжин ламын сүм, Бэрээвэн хийдийн үлдэц, Дэмчигийн хийдийн үлдэц, Их хүрээний үлдэц-гэр хэлбэрт модон дуганууд, Үнстийн хийдийн үлдэц, Хөгнө Тарнийн хийдийн үлдэц, Онгийн хийдийн үлдэц зэргийг дурдаж болох юм. Мөн Өвөр Монголын Хөх хотод Их зуу, Бага зуу, Тунсан зуу, Равжа зуу зэрэг цогцолборууд, Буриадын нутагт Галуут нуурын дацан зэрэг нь Монголчуудын бурхан шүтлэгийн архитектурын дурсгал болон үлджээ.

Монголчууд үндэсний уран барилга, хот байгуулалтын тухай мэдлэг арга ухааныг Дорно дахины архитектурын онол, арга зүйн ололтоор баяжуулан хөгжүүлж ирсэнийг бичээч цорж Агваанцэрэнгийн "Сүм дуган барих ба засах ёсон" "Аахар шаахар" зэрэг ном бүтээл, Сүмбэ хамба Ишбалжирын бичсэн "Бие зарлиг сэтгэлийн шүтээний тиг хэмжээний үндсэн бай тайлбар зүүлт, цэцгийн үзэсгэлэнт эрхи" зэрэг зохиол бүтээлүүд тодхон харуулж байна.

Дээр дурдсан Монголын сүм хийдүүдийн архитектурын үлдэж хоцорсон үнэт дурсгалууд, тэдгээрийн талаархи түүхэн баримт, эх бичгүүд, архивийн гэрэл зургууд болон дээрх эрдэмтдийн бичсэн ном зохиолуудыг судлан үзэж XVI-XIX зууны үед давамгайлж байсан сүм хийдийн архитектур, зохион байгуулалтын ерөнхий дүр төрх, өвөрмөц онцлог болсон үндсэн зарчмуудыг харуулж болох юм.

Монголын сүм, дугана зэрэг барилгын архитектурт гэрийн хэлбэр зохиомж, хийцийн зарчмуудыг хэрэглэх явдал түгээмэл байв. Ялангуяа шашин шүтлэгийн барилгын архитектурт гэрийн архитектурыг өөрчлөн хэрэглэхэд Өндөр гэгээн Занабазар гэр хэлбэрт болон гэрийн зохион байгуулалтыг тусгасан тиг зургийг бүтээж хэрэгжүүлсэн нь их нөлөө үзүүлжээ. Суурин хүрээ хийд байгуулах болсон нь сүм дуганы барилгыг чулуу, тоосго, ваар ашиглан бүтээх нөхцөлийг бий болгожээ. Ийнхүү гэр маягт дугуй модон барилгыг гэр маягийн, олон өнцөгт түүний дотор дөрвөн өнцөгт бөмбөгөр, асран маягт оройтой барилга болгон барих болжээ.

Монгол үндэсний хэлбэрийн сүм дуганыг гурван төрөл болгон үзэж болох юм. Үүнд:

1.Шовгордуу буюу бөмбөгөр оройтой дугуй хэлбэртэй сүм

Өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн гэр хэлбэрт дуганууд (Зүүн хүрээ)

2.Бөмбөгөр оройтой дөрвөлжин сүм

3.Бөмбөгөр буюу шовгордуу оройтой олон тал бүхий дугуй сүм эдгээр болно.

Дугуй гэр хэлбэртэй модон сүм дуган бол Монголын архитектурын үндсэн онцлогийг хадгалж байгаагаараа үнэ цэнэтэй билээ. Одоо Их Хүрээний (Зүүн хүрээ, өргөө) 10 дацан, 30 аймгийн дотроос Эрхэм тойны Вангаа болон Эх дагины аймгийн гэр хэлбэрт дуганууд гэр хэлбэрийн үндэсний архитектурын дурсгал болон хадгалагдан үлджээ.

Мөн Чойжин ламын сүм музейн хашаан дотор тоосгоор барьсан гэр хэлбэрт дугана үлдсэн нь архитектурын хувьд Монголын гэр хэлбэрт тоосгон барилгын ховорхон дурсгал болно.

Гэр дуганы гол хийц загвараар барьсан дөрвөлжин сүм, дуганууд Монгол архитектурын нэгэн ололт мөн. Үүний үлгэр загвар болсон барилга бол Өндөр Гэгээн Занабазар тиг зургийг нь гаргасан Баруун хүрээний Батцагаан хэмээх цогчин дугана ажээ. Батцагаан цогчин нь цацар хэлбэртэй том барилга юм. Түүний голын 4 багана нь дээврийн үндсэн хэсгийг тулж байх ба хоёрдугаар эгнээнд хөндлөн дам нурууны 12 баганатай гуравдугаар эгнээний багана нь түүнээс арай өндөр бөгөөд нийт 108 баганатай болно. Энэ дуганы хийцийн онцлог нь тулгуур багана хөндлөн дам нурууг нэмэх замаар багтаамжийг нь ихэсгэхээр зохиосонд оршино. Анх 42х42 м хэмжээтэй байсныг хожим нь 51х51 м болгон өргөтгөсөн байна.



Батцагаан дуган
(М У-ын Ардын зураач Н.Чултэм)

Монгол хийцийн сүм дуганы томоохон дурсгалууд гэвэл Өргөө дэх Зүүн хүрээний Цогчин дуганаас гадна мөн энэ хүрээний Амдо нарын аймгийн дугана, Хэрлэн голын хөвөөн дэх Зүүн хүрээний цогчин дугана, Гандангийн цогчин дугана зэрэг болно.

Монголын архитектурын хөгжлийн энэ шинэ үед Монголчуудын Түвэд, Хятад, Энэтхэг, Оростой явуулж байсан улс төр, соёлын болоод шашны харилцаа холбоо чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Монголын уран барилгачид Түвэдээс чулуун дугана барих, хавтгай дээвэр хийх, Хятадаас доу-гун хэмээх онцгой хэлбэрийн дээвэртэй барилга барих, Энэтхэгээс суварга байгуулах, тэрчлэн Оросоор дамжуулан Европ болон Оросын уран барилгын арга ухааныг бүтээлчээр эзэмшиж, үндэсний барилгын өвөрмөц урлагийг хөгжүүлсэн байна.

Монгол нутагт энэ үед дээр дурдсан үндэсний уран барилгын зэрэгцээ Хятад, Төвд, Энэтхэгийн уран барилгын арга, хэлбэрээр сүм дуганаудыг маш олноор барих болсон байна. Ялангуяа Манж Чин улсаас Монголд шарын шашинг дэмжих бодлого хүчтэй байснаас Хятадын уран барилгын загвар бүхий орон сууцны болон томоохон хийдүүдийн цогцолборууд баригдсан байна. Тийм сүм хийдүүдийн жишээнд Амарбаясгалант хийд /1728-1735/, түүний сүм, дуганууд, Богд хааны ногоон ордон/1893-1906/. Гүнжийн сүм, Гэсэр сүм, Дамбадаржаалин хийд, Чойжин ламын сүм зэргийг дурдаж болох юм.

Хятад маягийн сүм дуганы архитектур нь энгийн дээвэртэй болон олон хэлбэрт дээвэртэй байдаг. Дээвэр нь налуу бөгөөд /доу-гун/ дэрвийсэн хэлбэртэй байшингийн нүүрэн талын зураг чимэглэлийг хамгаалсан байдалтай байх аж. Нүүрэн талын дээврийг модон баганаар тулах бөгөөд тэдгээрийн тоо нь тэгш байдаг байна. Ийм барилга голдуу 1-4 давхар байхын хамт давхар бүхэн гоёмсог вааран асар дээвэртэй байв. Хятад маягийн хийдийн зохион байгуулалт нь сүм дуганаудыг том хэрмэн хашаан дотор бас дахин хамарлан барьсан хашаануудад байрлуулсан байх нь олонтаа.



Амарбаясгалант хийдийн зураг

Амарбаясгалант хийд

Амарбаясгалант хийдийн Цогчин дугана

Богд хааны Ногоон ордон

Монголд Түвэд маягийн барилгын дурсгалын тоонд Бэрэйвэн хийдийн их дугана, Манзуширийн хийдийн Цогчин дугана, Заяын хүрээний Гүншиг дацан зэргийг дурдаж болох бөгөөд өнөөг хүртэл бүрэн бүтнээр хадгалагдан үлдсэн нь Эрдэнэзуугийн лавиран юм. Энэ байшинг Эрдэнэзуугийн бүх барилга байгууламж дотроос хамгийн гоё үзэмжтэй нь гэж судлаачид үздэг.

Эрдэнэзуугийн Лаврин дугана

Монгол үндэсний архитектурын зэрэгцээ Төвд, Хятад архитектур нэвтэрч хөгжсөн нь аажимдаа Монгол-Хятад, Монгол-Түвэд, Хятад-Түвэд зэрэг холимог хийц маягтай сүм, дуганууд, заримдаа орон сууцны барилга ч баригдах болсон байна.

Монгол Хятад барилгын хийц маяг хоорондоо улам бүр холилдон нийлж бие даасан шинэ хэв маяг, хийц зохиомж бий болжээ.

Монгол, хятад хэв маягийн архитектурын барилгын дээд талыг хятад, доод талыг монгол барилгын хэлбэр хийцийг оруулан барьж, нэгэн цогц хэв загвар болгож чадсан байна.Тэдгээр нь голдуу 2-3 давхар дөрвөлжин байгуулалттай дээрээ гонхонтой,1 дүгээр давхар нь банзан болон тоосгон ханатай юм. Хүрээний нэлээд хэдэн аймгийн дуганууд, мөн Дэчин галбын сүм, Вангийн хүрээний Цогчин дугана нь Монгол-Хятад архитектурын барилга байсан бөгөөд эдүгээ Гандан хийдийн гурван суваргын дугана (одоогийн Цогчин) энэ архитектурын дурсгал болон үлджээ.

Монгол-Түвэд архитектур нь Монгол-Хятад хэв маягаас өөр бөгөөд Монгол хийц маяг нь Түвэд хийц маягтай нийлж үзэмж төгөлдөр цогц болдог ажээ.

Монгол-Түвэд архитектурын томоохон жишээнд Хүрээнд байсан Майдарын сүм Онгийн голын хийдийн Майдар дацан орох юм. Харамсалтай нь энэ хэв маягийн сүм дугана бидний үед дурсгал болон хадгалагдан үлдэж чадсангүй.



Онгийн голын хийдийн Майдарын дацан



Гандан хийдийн Цогчин дугана

Түвэд-Хятад архитектурын онцлог бол Хятад архитектурын хийц зохиомж нь Түвэдийнхээс эрс ялгагдан харагдаж байдаг боловч үнэхээр гоёмсог байхын хамт сүрлэг даацтай харагддаг билээ. Тийм барилга Монголд цөөнгүй баригдаж байсны тоонд Галбын говийн хийдийн дугана, Заяын хүрээний цогчин дугана болон Шар дацан, Жанжин чойрын хийдийн дугана, Жанрайсиг бурхны сүм энэ архитектурын үнэт дурсгал болон үлджээ.

Дэчингалбын сүм (зүүн хэсэг)

Мэгжид Жанрайсагийн сүм

Монголын тахил шүтээний уран барилгад эртний энэтхэгийн бурхны шашны "ступа" хэмээх шүтээний өвөрмөц барилгын хийц загвараар бүтээж байсан суваргын барилга байгууламж тодорхой байр эзэлнэ. Монгол нутаг дахь Хүрээ хийдүүдэд тийм суваргуудыг олноор байгуулж байсны дурсгал болон хэдхэн тооны суварга хадгалагдан үлдсэн байна. Тухайлбал, Эрдэнэзуу дахь Бодь суварга, түүний 108 цагаан суварга, мөн Автай сайн хаан, Түшээт хан Гомбодоржид зориулсан суварга-бунхан, Булган аймгийн төвийн өмнө хэсэгт байсан Лигжиддонгойлин хийдийн том цагаан суваргын үлдэц зэрэг нь тийм дурсгалын тоонд зүй ёсоор орно.

Автай сайн ханы бунхан-суварга

Энэ үед томоохон хийдүүд байгуулж эхэлсэн нь шашны төв төдийгүй иргэний, засаг захиргааны хот байгуулалтын хөгжилд түлхэц үзүүлсэн байна. Шашны төвүүд, хүрээ хийд болон зарим үед засаг захиргааны төв байгуулахдаа үндсэн хоёр арга хэрэглэж иржээ. Энэ нь нэг талаас монгол уламжлалаас үүдэлтэй "хүрээ" төлөвлөлт, нөгөөтэйгүүр түвэд уламжлалаас үүдэлтэй, гол шүтээн (сүм)-ээс доош шатлан байгуулах төлөвлөлт юм.

Монголд XX зууны эх хүртэл хот суурин байгуулахдаа гол төлөв уламжлалт "Хүрээ" төлөвлөлтийг хэрэглэж байсан бөгөөд Баруун хүрээ (1647). Да хүрээ (1651), Заяын хүрээ (1616), Зүүн хүрээ (1711) зэрэг шашин, засаг захиргааны төвүүдийг байгуулсан байна.

Эрдэнэзуу хийдийн Бодь суварга (Алтан суварга)



Хүрээ төлөвлөлтийн ерөнхий зарчим

Эрдэнэзуу хийдийн 108 цагаан суварга

1911 оны үеийн Их хүрээний ерөнхий байдал

Харин дээрээс шатлан барих төлөвлөлтийн зарчмыг Мандширын хийд , Бэрээвин хийд, Заяын хийд, Хөгнө тарины хийдийг байгуулахдаа

баримталсан байна.

Үүний зэрэгцээ цайз, хэрэм бүхий хот байгуулалт ч давхар хөгжиж ирсэн байна. Манж Чин улсаас Монголд ноёрхлоо хадгалж байх зорилгоор байгуулж байсан нэлээд тооны цайз хэрэмт хотуудын тоонд Ховд, Улиастай хотууд орно.

Ховд хотын хэрмийн үлдэц

Монгол улс тусгаар тогтнолоо олж, Богд хаант улс байгуулсан үеэс эхлэн, ялангуяа 1921 оны хувьсгал ялснаас хойш манай улс Орос орон, түүгээр дамжуулан өрнөдийн орчин цагийн соёлт орнуудтай өргөн харилцах болсон явдал Монголын хот байгуулалт, архитектурын хөгжилд цоо шинэ үеийг нээсэн билээ.

Боловсролын Их сургууль

Монголын хот байгуулалт, барилга архитектурын түүхэнд төрөөс анх удаа нийгэм ахуйн барилга байгууламж барилах нэгдсэн бодлого явуулж шинжлэх ухааны төлөвлөлт, зураг төслийн зарчмыг нэвтрүүлж эхэлсэн нь үр дүнгээ өгсөн байна.

Ардын засгийн анхны жилүүдээс 1940 он хүртэл төв хөдөөд иргэний сургууль, эмнэлэг, соёлын

Монгол Улсын Их сургууль

барилга байшин олноор баригдсаны олонхи нь төмөр дээвэртэй, пийшин халаалттай тоосгон болон дүнзэн байшин байжээ. Гэхдээ энэ үед ЗХУ-ын зураг төсөл болон шинэ материал, хийц, техникийн боломжийг ашиглан Монгол Трансын контор, Дотоодыг хамгаалах газар, Улсын банк, "Бөмбөгөр ногоон" хэмээх театр, Радио шуудан хороо, одоогийн Боловсролын Их сургуулийн барилга болон зарим орон сууц зэрэг орчин үеийн конструктивизмын зарчимд тулгуурласан барилгуудыг барьсан байна. Мөн энэ үед үйлдвэрийн барилга байгууламж барьж эхэлсний гэрч жишээ нь Аж үйлдвэрийн комбинатын барилга юм.

Монголд 1940-өөд оноос 1960 он хүртэлх хугацаа нь хот байгуулалт, барилга, архитектурын хөгжилд ололт амжилтын жилүүд байв. Тухайлбал, 1940-1949 онд Улаанбаатар хотыг сайжруулах төлөвлөгөө зохиосны хамт 1952 онд Улаанбаатар хотыг хөгжүүлэх I ерөнхий төлөвлөгөө, 1954 онд Улаанбаатарыг хөгжүүлэх 20 жилийн хэтийн төлөвлөгөө боловсруулж баталгаажуулсан нь хот төлөвлөлтөд эргэлт гаргасан төдийгүй цаашид хөдөө, орон нутагт хот байгуулах үлгэр дууриал болсон байна. Улаанбаатар хот нь энэ хугацаанд сүм хийд, жижиг худалдаачдын хашаа хороо, явцуу нарийн гудамж бүхий жижигхэн хот

Улсын банкны барилга (Одоогийн Голомт банк)

Засгийн газрын ордон

байснаа дэлхийн улс гүрнийг холбосон зам, тээврийн чухал зангилаа, монгол орны улс төр, эдийн засаг, соёлын төв болж орчин үеийн томоохон хот болон хөгжжээ. Энэ хугацаанд Сүхбаатарын талбай, Засгийн газрын ордон, Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн театр, Элдэв-Очирын нэрэмжит кино театр (одоогийн Монголын Хөрөнгийн бирж), Монгол Улсын Их сургууль, Алтай зочид буудал (одоогийн Нийслэлийн засаг даргын тамгын газар), Улсын Төв номын сан, Гадаад Хэргийн яам, Улсын Биеийн Тамирын Индэрт стадион, "Улаанбаатар" зочид буудал, Улсын Их дэлгүүр, Их тэнгэрийн амны харшийн барилгуудыг барьж байгуулсан байна.

Энэ хугацаанд Архитектур төлөвлөлтийн газрыг Улсын барилгын зургийн институт болгон өргөтгөн байгуулсан, барилгын үйлдвэрлэлийн бааз суурь хөгжин бэхжсэн, дээд боловсролтой үндэсний барилгын инженер, уран барилгачид олноор бэлтгэгдсэн зэрэг нь Монгол улсад хот байгуулалт, барилга архитектурын ажил өргөн далайцтай хөгжих нөхцөл бололцоог нээсэн байна.

Манай оронд 1960-аад оноос барилгын зураг төслийн байгууллагууд тус орны 300 гаруй хот суурины байршил, хөгжлийн төлөвлөгөөг хот

Гадаад Хэргийн яам

"Баянгол" зочид буудал

"Улаанбаатар" зочид буудал

Монголын Үндэсний түүхийн музей

байгуулалтын орчин үеийн зарчмын үндсэн дээр боловсруулсан юм. Эдгээр төлөвлөгөөнүүдийг үндэслэн аймгийн төвүүд, Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг орчин үеийн хотууд, 300 гаруй сумын төвд засаг захиргаа, соёл, боловсрол, эрүүл мэнд, нийгэм ахуй, үйлдвэр үйлчилгээний зориулалттай олон зуун барилга байгууламж болон зам, гүүр барьж байгуулжээ.

Энэ үед хэд хэдэн яамдын барилга, Политехникийн Дээд сургууль, Баянгол зочид буудал, МҮЭ-ийн төв ордон, Гэрлэх ёслолын ордон, Соёлын Төв өргөө, Лениний музейн барилга мөн гурилын үйлдвэр, хивсний үйлдвэр, сүүний үйлдвэр, гутлын үйлдвэр зэрэг томоохон үйлдвэрийн зориулалттай

Соёлын Төв өргөө

Орон сууцны хорооллын нэгэн хэсэг

ӨНГИЙН БИРЖ

Худалдаа хөгжлийн банк

Гэрлэх ёслолын ордон

"Континенталь" зочид буудал

Гурилын үйлдвэр

барилга байгууламжууд, олон орон сууцны хорооллуудыг барьжээ.

Ийнхүү нэг талаас барилгын үйлдвэрлэл хөгжиж, хот байгуулалт түргэссэн боловч нөгөө талаас тэр үед социалист бүх оронд дэлгэрч байсан нэг стандартын, ур хийц сайнгүй барилга байгууламжууд их баригдсаныг дурдах нь зүйтэй юм. Иймээс ч манай уран барилгачид хот байгуулалт, архитектурт үндэсний байгаль, соёлын онцлогийг харгалзах, архитектурын үндэсний уламжлал, хэлбэр, чимэглэл, зохиомжийг тусгах талаар хүчин чармайлт гаргаж иржээ. Энд тухайлбал, Энх тайвны ордон, Ан олзворын ордон, Хувьсгалын болон Лениний музей, Соёлын төв өргөө, Гэрлэх ёслолын ордон, Найрамдал зуслангийн барилга байгууламжуудыг дурдаж болно.

1990 оноос Монгол улс хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг замд орж, дэлхий дахинд нээлттэй болсноор монголын хот байгуулалт, архитектурт бас нэгэн шинэ үе эхэлсэн юм. Зах зээлийн эдийн засаг, уран бүтээлийн нээлттэй бодлого, уран барилгачдын эрх чөлөө нь Өрнө, Дорнын уран барилга, хот байгуулалтын орчин үеийн ололт, хэв загвар, хийц бүтээл, шинэ технологи, материалыг монголд түргэн нэвтрэхэд таатай нөхцөлийг бий болгосон билээ.

Н.Уртнасан

С.Уранбилэг

Э.Амарбилиг

БҮЛЭГ VII

- ГҮН УХААН, НИЙГЭМ-УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ӨВ
- БӨӨ МӨРГӨЛ
- БУРХАНЫ ШАШИН, СОЁЛ

ГҮН УХААН, НИЙГЭМ-УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ӨВ

Монголчууд өнө эртнээс нүүдэлчин ард түмний аж байдал, нийгмийн хөгжлийн онцлог болон хүрээлэн байгаа байгаль орчныг оюун ухаандаа тусган илэрхийлж байсны үр дүн болсон гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний баялаг өв сантай билээ. Гүн ухааны үзэл санаа нь хүмүүс ертөнцийг бүхэлд нь ямар нэг хэмжээгээр танин барьж, хүний өөрийн амьдралын утга учрыг өвөрмөцөөр ухаарах, улмаар байгаль дэлхийн уялдааг мэдрэн зохицох, төр улсаа байгуулан хөгжүүлэх, үндэсний онцлог бүхий ёс зүйн болон гоо зүйн үзэл ойлголтыг боловсруулан мөрдөж ирэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэж, тэр бүхнээр дамжин илэрч байжээ.

Энэхүү өв сан бол монголын ард түмэн нэг талаас хөрш зэргэлдээ болон эртний соёлт улс орны өв сангаас авч, нөгөө талаас дэлхийн болон юуны урьд Төв Азийн улс түмний соёл, сэтгэлгээний хөгжилд өөрийн хувь хандивыг нэмэрлэж, өвөрмөц бүтээлээ туурвиж байсны үр дүн мөн.

Монголын гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийг ерөнхийд нь:

-Эртний монголчуудын ертөнцийг үзэх төсөөлөл,

-Монголын эзэнт гүрний үеийн нийгэм-улс төрийн сэтгэлгээ,

-XV-XVIII зууны үеийн нийгэм-улс төрийн сэтгэлгээ,

- Монголын буддын гүн ухаан,

-Монгол дахь феодлын байгуулал задрах үеийн үзэл санааны урсгалууд,

-1921 оны ардын хувьсгалаас хойшхи үеийн ард түмний сэтгэхүйд гарсан өөрчлөлт гэсэн 6 үед хувааж үздэг.

Эртний монголчуудын ертөнцийг үзэх үзэл нь нэг талаас байгаль, юмс үзэгдлийг байгаа байдлаар нь бодитой авч үзэж, ахуй амьдралдаа хэрэглэх объектив төсөөлөл, эрхэлж буй мал аж ахуйтайгаа холбогдсон орчлонгийн тухай туршлагын тойм мэдлэг, нөгөө талаас байгалийн үзэгдлийг цаанаа эзэнтэй гэж хүнчилж, амьчилж үзэх домгийн болон шашны төсөөллийн давамгайллаар илэрч байжээ.

Монголчууд бусад ард түмний нэгэн адил арвин баялаг домгийн сэтгэлгээгээр ертөнцийн тухай үзэл ойлголтоо илэрхийлж, юмс үзэгдэлд хандаж байлаа. Байгаль ертөнцийн болон хүний өөрийн гарал, овог аймгийнхаа үүсэл, амьдралын утга учир, хувь зохиолын тухай зэрэг өргөн утга санаа монголчуудын домогт туссан байдаг. Жишээлэхэд, анхны эх захгүй бөөмнөрлөөс хүнд өтгөн нь аажмаар доош суун тунарч, Этүгэн (газар) болж, хөнгөн шингэн нь дээш хөөрөн дэгдсээр Тэнгэр болж тогтсон гэж домогт өгүүлнэ. Ингээд монголчууд Тэнгэр эцэг, Этүгэн эх гэж өргөмжлөн биширдэг билээ. Иймхүү Тэнгэр, Газрыг хооронд нь барилдуулж, суу заль, арга билгийн шүтэлцээгээр авч үзэж тайлбарласан нь байгалийн зохист уялдааг танин барих, хүн түүнд өөрийгөө захируулах монголчуудын билиг ухаан юм.

Монгол домгийн сэтгэлгээ нь өөрийн агуулга, хөгжлийн түвшнээр Энэтхэг, Грек, Хятад зэрэг домгийн сонгодог сэтгэлгээ бүхий орнуудын ухааны түвшинд байсан гэж эрдэмтэд үздэг.

Монголчууд эртний шашны хэлбэрүүдийг, тухайлбал амьчлах үзэл (анимизм), онгон шүтэхүй (тотемизм), цалигчлахуй (мистицизм) зэргийг мөн тойроогүй, дайрч гарсны ул мөр хадгалагджээ. Гэхдээ домгийн болон анхны шашны үзэл санаа, ойлголтууд ерөөс тус тусдаа ялгаран "цэврээр" орших бус, нэгэн цул нэгдмэл байдалтай, уялдаж барилдсан байдаг билээ.

Эртний монголчууд өөрийгөө ямар нэг араатан амьтнаас гаралтай гэж үзэж, түүнийг шүтэн эрхэмлэдэг байжээ. Эртний хад чулууны сүг зураг, аймаг овгийн нэрс, түүхэнд тэмдэглэгдсэн овгийн зарим сүлд үүнийг харуулдаг.

Байгалийг амьчилж үздэг, уул, ус, мод, ургамлыг эзэн савдагтай гэж үзэн тахиж, шүтэж биширэх үзэл ёс заншил эрт үеэс тогтож ирсэн бөгөөд эдүгээ ч уламжлагджээ. Энэ нь нөгөө талаар байгаль орчноо шүтэн хамгаалж, онгон дархнаар хадгалж ирэхэд тус нөлөө үзүүлсэн эерэг үзэгдэл байв.

Энэ үзлээс улбаалан гарсан монголын язгуурын шашин нь бөө мөргөл юм. Бөөгийн шашин бол юуны өмнө тэнгэр шүтэх шүтлэг болно. Бүхнийг цаанаа эзэн тэнгэртэй гэж итгэж, тэнгэрийг дотор нь сайн муу үйлийн эзэн гэж ангилан үзэхийн дээр зүг, зовхисыг эрхшээсэн эрхт, атаа тэнгэрүүд, галын, ан гөрөөний, эд баялгийн, мал сүргийн, дайны эзэн тэнгэр гэх зэргээр ялгадаг нь бөөгийн шашин бол олон тэнгэрт ёс (политеизм) болохыг харуулж байна. Гэхдээ хөгжлийн явцад тэр бүхнийг төлөөлсөн, бүхний үндэс болсон тэнгэрлэг чанарыг шүтэх ёс бий болж, Мөнх Тэнгэрийн тухай ойлголт гарчээ. Энэ нь бөөгийн шашин олон тэнгэрт ёсноос нэг тэнгэрт ёсонд (монотеизмд) шилжиж байсныг гэрчилнэ. Эл үзэгдэл Монголын нэгдсэн гүрний гол шашин, эзэн Чингис хааны үзэлтэй холбоотой, түүгээр илэрч байв.

Монголын эзэнт гүрний үеийн гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний үндсэн чиглэл нь эв нэгдлийн үзэл, феодлын нэгдсэн гүрэн байгуулах тухайн үеийн дэвшилтэт үйл явцыг бүх талаар үндэслэн зөвтгөх үзэл, нэгдсэн төрийг хэрхэн тогтоон бэхжүүлэх тухай үзэл санаа байв. XIII зууны



"Монголын нууц товчоо"-ны" хятад үсгийн эх

түүх, соёлын гайхамшигт дурсгал болсон "Монголын нууц товчоо"-нд нэгдэл нягтралын үзлийг хамгийн голд тавьж, монголчуудын нэг нэгдмэл байхын чухлыг гарал үүсэл, үзэл баримтлал, цэргийн бодлого, ахуй, соёл бүх талаар үндэслэсэн бөгөөд үүгээрээ уг зохиол монгол туургатны эв санааны нэгдлийн дуулал болжээ. Олон монгол овог, аймагтныг нэг нэгдмэл удамтай гэж гарал зүйн үүднээс тайлбарлан, Чингис хаанаас дээших 26 үеийг тоочин өгүүлнэ. "Монголын нууц товчоо"-нд үйл явдлыг болсон байдлаар нь шууд бичихдээ үзэл санааны хувьд бол нэгдсэн төр байгуулах талаар Чингис хааны явуулж байгаа үйл ажиллагааг ёс суртахууны эерэг үнэлэмжид тохирох, харшлахыг үл харгалзан зөвтгөж, түүний эсрэг хандсан буюу харшилсан бүхнийг буруутгаж харуулсан байдаг.

Тэр цагийн төрийн илэрхийлэл нь энэ тэргүүнд эзэн хаан байлаа. Эзэн гэгээн, сайд мэргэн, түмэн иргэн эвэргүү гэсэн зарчим нь тухайн үеийн монголын төрийн үзлийн гол санаа байсан агаад эл зарчмыг тууштай барьж хэрэгжүүлэх нь мандах төрийн шинж гэж үзэж байв. Төр хийгээд Эзэн хаанаа тэнгэрлэг чанартай гэж үзэх нь Мөнх тэнгэрийг шүтэх үзэлтэй холбоотой. Энэ нь угтаа Тэнгэр агаар, Газар дэлхийгээсээ үндэстэй, түүнд шингэмэл байх Түгээмэл чанарыг эрхэмлэн шүтэж, түүнийгээ Эзэн хаан, Эрхт төртэйгээ холбон дээдэлсэн тэнгэрлэг чанартай дүйцэж, түүнийг хадгалан байх гэсэн чармайлт нь төрөө төр шиг барьсан хаан шиг хаан байхад хөтлөн дуудаж, дайчлан зоригжуулсан хүчин зүйл болж байв.

Төрийг төвшитгөн явуулахад Эзэн хаан гэгээний зэрэгцээ сайд түшмэд нь мэргэн төвшин байхыг онцгойлон үзнэ. Монголын нэгдсэн гүрэн байгуулах үед Чингис хаан захирах, захирагдах, зохион байгуулагдах нарийн дэг журамт тогтолцоог бий болгож, өрлөг жанжин, ноёд түшмэд зэрэг төрийн зүтгэлтэн нарын хувьд монголын уламжлалт нөхрийн ёсыг ашиглажээ. Нөхрийн ёс нь санаа адил, ёс адилыг үндэс болгон харилцан үнэнч байхад тулгуурласан агуу хүнд журам байв.

"Эрдэм өршөөлт сайн Эзэн улсын эрдэнэ Эрх ухаант сайн түшмэл төрийн эрдэнэ" гэсэн зарчмыг баримталж, хан хөвгүүд, сайд түшмэдийг бэлтгэж хүмүүжүүлэх, шилдэг иргэдийг төрийн албанд тохоон зүтгүүлэх, цэргийн жанжин, түшмэдийг зөв сонгон олох нь Монгол төрийн онцгой анхаардаг зүйл болж байв. Монголчууд төрөө оройд тавин дээдэлдэг, төрийн сүлдээ бишрэн шүтдэг, төрийн хууль зөрчихийг "цаазад халдах" гэж ховор тохиол, хүнд ял болгон үздэг байв. Бүгд Төр улсаа урьдал болгож байснаас улс орон нь мандан бэхжиж байжээ.

Чингис хаан болон түүнийг хүрээлсэн төрийн хийгээд цэргийн зүтгэлтнүүд төрийн бодлогод суу залийг нэгтгэн барих, ухааны гүн, сэтгэлийн уужмаар хандахыг онцгойлон үзэж байв. "Бие бөх бөгөөс ганцыг ялъюу, сэтгэл бөх бөгөөс олныг ялъюу" гэж их хаан сургаад овог овгийн хүмүүс чухам юу бодож, сэтгэж байдгийг олж мэдэх, эзэлсэн аймаг харь улсуудын аж байдлын эх сурвалжийг хөндөлгүй хадгалах, зан заншил, шашин шүтлэгийг хүндэтгэх нь чухал, ер хүнийг дагуулна гэдэг сэтгэлийг дагуулахын нэр, сэтгэлийг алдваас бүгдийг алдана гэж Чингис хаан үзэж байв.

Хубилай хаан төвч мэргэнээр харах төрийн бодлогыг ард иргэдээ билгийн хурц, сэтгэлийн энэрэнгүйд хүргэх буддын шашны номын ёстой хослуулах бодлого, хос ёсны сургаалыг боловсруулан барьжээ. Хос ёсны үзлийг үндэслэн номлосон "Арван буянт номын цагаан түүх" зохиолд төрийн бодлого, үйл ажиллагааг гурван их үйл, дөрвөн их төр, зургаан их үлгэр, долоон их бии, есөн их бэлгээр тодорхойлжээ. Төрийг тэгш төвшнөөр засан явуулахын учир номын ёсоор засаж амгалан байлгах, төрийн ёсоор засаж жаргал эдлүүлэх, хамгаалах явдлыг хичээж улсыг сахин бататгах гурван их үйлийг зорилт болгоод, түүндээ Монгол төрийн түүхийн үлгэр дууриалыг авах, Бурхан багшийн сургаал, номын ёсны дууриалыг дагах, оршин буй цаг үеэ өнгөрсөн хийгээд ирээдүйтэй холбон уг үндсээр нь таних, тухайлбал өнгөрснийг хөөж онох, ирээдүйг угтаж харах, битүүг тааж ухаарах, эдүгээг бүрэн шинжих, билиг эрдмийг эзэмшин түүгээр төрийг залах зэргийг ангилан өгүүлсэн байна. Хубилай хаан эл бодлогыг баримтлан хэрэглэж

чадсанаар Монголын Их эзэнт улс-Юань гүрний төрийг 30 гаруй жил бататгасан билээ.

XV-XIX зууны үе буюу Монголын нэгдсэн гүрэн задарсны дараахь үеийн Монголын гүн ухаан, нийгэм-улс төрийн үзэл санааны гол чиглэл нь нэгдүгээрт, улс орны төрийн нэгдлээ сэргээн тогтоохыг эрхэмлэсэн эв нэгдлийн үзэл санаа, хоёрдугаарт, хөрш зэргэлдээ улсын зүгээс заналхийлж байсан эзлэн түрэмгийлэх бодлого болон харийн дарлалын эсрэг хандсан тусгаар тогтнолын үзэл санаа байлаа.

Энэ үе бол Монголын түүхэнд тарж бутрах, өөр зуураа сөргөлцөн тэмцэлдэх дайн самууны үе, улмаар тусгаар тогтнолоо алдан харийн дарлалд нэрвэгдсэн хүнд бэрх цаг үе байсан билээ. Ийм үед нийгэм улс төр, гүн ухааны үзэл санаа буурч арилсангүй, харин ч тухайн үеийн нийгмийн байдлыг тусган, цагийн Тэр үеийн сэтгэгчид цаг үеэ "цөвийн цаг" гэж нэрлэсэн байна.

Монгол Улсыг задлан бутаргах гэсэн ноёд түшмэдийн үйл ажиллагааны эсрэг эх нутаг, улс орноо нэгтгэн нягтруулахын төлөө хааны үйл ажиллагааг сайшаан дэмжсэн үзэл санаа тухайн үеийн хамгийн дэвшилтэт үзэл байв. Энэ үзэл түүх, уран зохиол, хууль цаазын дурсгалт бичгүүдэд тод тусчээ. Ийм бүтээлийн дотор хураангуй "Алтан товч", Лувсанданзангийн "Алтан товч", "Шар тууж", "Асрагч нэртийн түүх", Саган Сэцэний "Эрдэнийн товч", Рашипунцагийн "Болор эрхи", Гүн Гомбожавын "Гангын урсгал", Жамбадоржийн "Болор толь", Галдан туслагчийн "Эрдэнийн эрхи" зэрэг түүхийн зохиолууд, "Хув Нагваралын тууж", "Монголын Убаши хун тайжийн тууж" зэрэг уран зохиолын бүтээлүүд, "Монгол-Ойрдын хууль", "Халх журам" зэрэг хууль эрхэмжийн бичгүүдийг нэрлэж болно. Тулгуур бичгүүдэд хааны эрх мэдэл, байр суурь, нэр төрд халдсан аливаа явдлыг буруушаан шүүмжилж, хааны эрхийг хамгаалахыг хамгийн дээд төр ёс, монгол хүний үндэсний ухамсар, зан суртахууны шалгуур гэж үзэж байв. Тэр үеийн сэтгэгчид Чингис хааны үеийн нэгдсэн гүрний үзэл санааг эрхэмлэж, эрт цагийн эв нэгдэл, сүр хүчийг санагалзан мөрөөдөж, түүнийг үлгэр дууриал болгон тавих, тэр үзлээр нийтийг ухамсарлуулахыг зорьж байлаа. Тэд өөрийн бүтээлдээ улс орны

Хубилай хаан
(1215-1294 он)

бутралын эзэд болсон ноёд түшмэдүүд нь улс нийтийн бус, гагцхүү амин хувийн ашиг сонирхлыг хөөцөлдөж, үндэсний эрх ашигт хохирол учруулж байгааг тодоор шүүмжилж байв.

Монголын буддын гүн ухааны хөгжил нь XVII зууны үеэс XX зууны эхэн үеийг хамарна. Буддын шашин, сэтгэхүй эрт цаг, аргын тооллын өмнөх үеэс монголчуудын өвөг дээдсийн (хүннү нарын) дотор нөлөөлж, Жужан улсын үед төрийн шашнаар өргөмжлөгдөж байсан тухай мэдээ бий ба Монгол гүрний үед төрийн хос ёсны нэгэн багана болж, хаад ноёдын дунд өргөн дэлгэрч байсан боловч, нийт ард олны сүсэг болж, нийгмийн амьдралын бүх талд хүчтэй нөлөөлсөн нь чухамхүү XVI, XVII зуунаас эхэлнэ.

Эртний Энэтхэгийн Буддын гүн ухааны дөрвөн үндсэн урсгал байдгийн дотроос монгол оронд хамгийн гүн дэлгэрч, монгол эрдэмтэн мэргэдийн эрхэмлэн дээдэлж, судалж хөгжүүлсээр ирсэн онол нь чухамхүү мадхъямака хэмээх төв үзлийн гүн ухаан юм.

Төв үзэлтний гүн ухааны онол I зууны эцэс, II зууны эхээр үүсчээ. Түүнийг үндэслэгч нь энэтхэгийн их сэтгэгч Нагаржуна (Монголд Наган-зана багш гэж алдаршсан) болно. Төв үзэлтний гүн ухааны үндсэн зарчим нь үнэхээр эс бүтэхүй, шүтэн барилдахуй хоёр юм гэж үзэж байна. Нагаржуна хийгээд түүний сургаалыг баримтлагчид үзэхдээ ертөнцийн яанагуухи юмс үнэхээр бүтээгүй, үнэхээр бие даан бүтэж, эгнэгт орших юм гэж байхгүй, тэгэхдээ юмс үгүй биш, гагцхүү шүтэн барилдах болсон гэдэг.

Төв үзэлтнүүд бүхний үндэс, ертөнцийн уг язгуурыг хоосон чанар гэж тодорхойлсон юм. Үүгээрээ буддын бусад чиглэлээс онцгой ялгагдана.

Юмсын язгуур үндэс нь хоосон чанар юм. Харин хоосон чанар гэдэг оргүй хоосон гэсэн үг биш, тодорхой баригдах, тодорхойлогдох шинжгүй чанар, шүтэлцэх харилцаа гэсэн утга болно.

Алтан товч

Билгийн хүчээр ертөнцийн мөн чанарыг ухаараад ирэхлээр төв үзэл, баримтлалд гарцаагүй хүрч, хүн амьтныг асрах нигүүслэх, байгаль дэлхийдээ улам дотносох сэтгэл төрнө. Билгээр танин мэдсэнийг ертөнцийн ёсонд буулган ухаарч хэрэглэхэд арга нэн чухал юм. Арга билгийн нэгдлээр үнэн мөнд, зөв үйлд хүрч чадна гэж төв үзэлтнүүд, түүний дотор монгол сэтгэгчид үзэж байв.

Монголчууд төв үзлийн онолын бүхий л гол шастир, судруудад тайлбар хийх, сурах бичиг, гарын авлага зохиох, онолын асуудлуудаар тухайлсан зохиол бичиж туурвих ажлыг өргөн хэмжээтэй өрнүүлж иржээ. Монгол сэтгэгчид ийнхүү буддын гүн ухааныг хүлээж аваад зогсоогүй, түүнийг номлох, судлах, хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмрийг оруулсан юм. Одоогийн байдлаар бид гүн ухааны асуудлаар тусгайлан ном зохиол бичиж, модон бараар хэвлүүлсэн 70 гаруй эрдэмтний нэрийг тодруулж, зохиолыг сурвалжлаад байна.

Төв үзлийн гүн ухаан нь монгол мэргэдээс мэдлэгийн бүхий л салбараар шинжилгээ хийх, ном бүтээл туурвихад арга зүйн нэгдмэл үндэс болж байв. Хэл бичиг, уран зохиолын онол, анагаах ухаан, урлаг, зурхайн асуудал зэрэг олон салбараар ном бүтээл бичиж байсан нэрт зохиогчид төв үзлийн гүн ухааны арга зүйг баримтлаад зогсохгүй, уг онолын талаар тусгайлсан зохиол бичих нь ч нийтлэг байжээ. Монгол сэтгэгчдийн ихэнх нь 3-5 боть бүтээлтэй, түүнээс дээш 10, 20 боть ном туурвисан мэргэд ч цөөнгүй.

Монгол сэтгэгч мэргэд төв үзлийн гүнзгий нарийн гүн ухааныг ташаагүй ухаарч, цаашид хөгжүүлж байсны нэгэн жишээ нь XIX зууны нэрт гүн ухаантан Агваанбалдангийн бүтээл туурвил юм.

Тэрбээр зургаан боть ном зохион туурвисны дотор түвэдийн нэрт эрдэмтэн гүнчэн Жамъяншадавын бичсэн буддын гүн ухааны дэлгэрэнгүй түүхийн зохиолыг нарийвчлан үзэж, өөрийн өвөрмөц онол ухаарлыг дэлгэр өгүүлсэн "Их тогтсон таалын зүүлт тайлбар, бэрх аньсны зангилааг тайлагч тод оюутны энхрий эд", төв үзлийн нэрт онолч Чандракиртийн зава (үндэс) болсон хураангуй зохиолыг ухаж тайлбарласан "Төв үзэлд орохуйн" үгийн тайлбар сайн номлолыг дагагч", буддын гүн ухааны дөрвөн урсгалд яанагуухуй болон үнэмлэхүйг хэрхэн авч үздэг тухай гүн ухааны нарийн асуудлыг дэлгэрэнгүй номлосон "Дөрвөн тогтсон таалын ёсон дахь хоёр үнэний ялгал" зэрэг томоохон хэмжээний сонгодог бүтээлүүд орж байна.

Ертөнц хийгээд түүний үндсийг бүхэлд нь яг байгаагаар нь зөв цэх онон барьж чаддаг төв үзлийн хэтрүүлэгчийн суут онолыг гарамгай сэтгэгч Агваанбалдан ташаагүй онож, ном зохиолдоо нэвт шингээн хөгжүүлж байсан нь монгол сэтгэгчдийн агуу ихийг илтгэн харуулна.

Төв үзлийн онол монгол мэргэдийн оюуны хүчээр монгол хөрснөө шимлэн хөгжсөн байна. Энэ нь уг сургаал монгол сэтгэлгээний төв голч язгуур чанартай бүрнээ нийлж, түүний онолын үндэслэл болж чадаж байсных буй заа.

XIX зууны хоёрдугаар хагас, XX зууны эхэн үед Монгол орон томоохон өөрчлөлт, шинэчлэлд тулж ирсэн байлаа. Нэг талаас, Манжийн дарангуйллын эсрэг чиглэсэн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн үүсэн идэвхжиж, нөгөө талаар хямран доройтож буй феодалын байгууллыг халж өөрчлөх чиг хандлага тодорч байв. Энэ үед янз бүрийн анги, бүлгийн эрх ашиг, санаа бодлыг илэрхийлсэн нийгэм-улс төрийн сэтгэлгээний олон төрлийн урсгал чиглэл үүсэн гарч, сүлжилдэн байлаа.

Өгүүлэн буй үеийн монголын нийгмийн ноёлогч анги болсон феодлууд нийгэм-улс төрийн янз бүрийн үзэл бодол бүхий хэд хэдэн бүлэгт хуваагдаж байлаа. Тэдний үзэл санаа феодлын эх орончи болон феодалын үндсэрхэх үзлээр илэрч байв.

Феодлын үндсэрхэг үзэл тэр үеийн нийгмийн янз бүрийн хэсэгт хамгийн их нөлөө үзүүлсэн бөгөөд монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг тэр үед үндсэрхэх үзэлтэй хүмүүс толгойлсон билээ. Тэдний дотор Сайн ноён хан Намнансүрэн, Далай лам Цэрэнчимэд, чин ван Ханддорж, Жалханз хутагт Дамдинбазар нарын зэрэг төр, шашны томоохон зүтгэлтнүүдийг нэрлэж болно.

Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд оролцож байсан дэвшилт үзэл бүхий

Лувсанданзан "Алтан товч"

Асрагч нэртийн түүх

"Эрдэнийн товч"

"Билэг эрхи"



"Хүв Нагваралын тууж"



"Эрдэнийн эрхи"

зүтгэлтнүүдийн дотор тогтон буй нийгмийн байгууллаа зарим талаар шинэтгэх, аж ахуйн амьдралыг удирдах шинэ арга журам луу тэмүүлэх хандлагатай хүмүүс ч байжээ. Энэ нь үнэн хэрэгтээ цагийн эрхээр алсын хандлага нь тодорч байсан хөрөнгөтний шинэтгэх сэтгэлгээ, гэгээрүүлэх үзлийн шинж бүхий байв. Үүнд XIX зууны эхээр Орос, Хятадын хөрөнгөтнүүдээс монголын уншигчдад зориулан монгол хэлээр хэвлэн гаргаж байсан сонин бичгүүд ч нөлөөлсөн тал бий.

Нийгмийн өөрчлөлт хийж, феодалын байгууллыг халахад чиглэсэн үзэл номлол бүхий профессор Ж.Цэвээн, Бадрахбаатар, Д.Бодоо, Дорж мээрэн зэрэг хүмүүсийн үзэл бодол, бичиг зохиолоор эл гэгээрүүлэх үзэл илэрч байв. Гэгээрүүлэх үзэл нийгэм-улс төрийн шинэ сэтгэлгээ бүрэлдэн тогтоход чухал үүрэг гүйцэтгэж, улмаар монголын эрх чөлөөний хөдөлгөөний онолын үндэслэлийн нэн чухал бүрэлдэхүүн хэсэг болжээ.

Монголын хөдөлмөрчин ард түмний бодол санаа, хүсэл эрмэлзлэлийг илэрхийлсэн нийгмийн сэтгэлгээний ардач чиглэл харийн түрэмгийлэгчид болон нийгмийн шударга бус ёсны эсрэг монголын ард түмнээс явуулж ирсэн тэмцлийн янз бүрийн нөхцөлд илрэн хөгжиж байлаа. Энэ үеийн ардач үзэл монголын гэгээрүүлэх үзэлтэн, их бичгийн хүн В.Инжаннаши, XX зууны эхэн үеийн томоохон сэтгэгч Ч.Дэмчигдорж нарын бүтээлд тод тусчээ. В.Инжаннаши манж-хятадын дарангуйллыг эсэргүүцэн шүүмжлээд зогсохгүй, монголын феодал язгууртнууд өөрсдөө ялзран доройтож байгааг хурц шүүмжилж байв. Тэрбээр монголын нийгмийг хоцрогдол, доройтлоос гаргахын тулд соёлжин гэгээрүүлэх, дундад эртний феодал-шашны бурангуй ёс, номлолыг даван туулахын чухлыг онцлон заа ж байлаа. Ч.Дэмчигдорж амьдралаар дэвшин гарсан нийгмийн асуудалд хариу өгөх шаардлагыг тусган илэрхийлсэн, нэлээд боловсорч хөгжсөн ертөнцийг үзэх үзэлтэй байсан бөгөөд тэр нь гүн ухаан, нийгэм-улс төр, зан суртахуун, сурган хүмүүжүүлэхүйн асуудлуудыг өргөн хамарсан байлаа.

XIX зууны эцэс XX зууны эхэн үеийн Монгол оронд олон янзын үзэл санаа, ойлгоц ухаарал сүлжилдэж, тэгэхдээ тэр бүгдийг үндэсний тусгаар тогтнолын үзэл санаа нэгтгэж байсан ба тэдний ихэнх нь шашны хэлбэрээр илэрч, шашны нэгдлийг харийн дарлалын эсрэг тусгаар тогтнолын төлөө тэмцлийн гол нөхцөл болгож байжээ.

Тухайн үеийн үзэл баримтлалуудын зүй ёсны зохицол болж тодорсон дэвшилтэт гол үзэл санаа нь монголын үндэсний ардчилсан үзэл байлаа. Монголын үндэсний ардчилсан үзлийн гол агуулга нь:

- харин дарлалаас чөлөөлөгдөн үндэсний биеэ даасан төр улсаа сэргээн бататгах;
- улс үндэстнээ бусад дэвшингүй орны зэрэгтэй хөгжүүлэх арга замыг илэрхийлэх;
- нийгмийн шударга ёс, ардчилсан эрх чөлөөг тогтоох бататгах;
- ард түмнээ соён гэгээрүүлж, олон зууны хоцрогдлыг даван туулах;
- уламжлалт шашнаа байх ёсоор нь ариунаар мандуулах үзэл бодлогоор илэрч байжээ.

Үндэсний ардчилсан үзлийн эл зорилтуудыг амьдралд хэрэгжүүлэх шаардлагыг тусган тэр үеийн нийгмийн тэргүүний дэвшилтэт хэсэг зохион байгуулагдсан нь Монгол Ардын нам байв. Ардын намын удирдагчид С.Данзан, Д.Бодоо, Д.Сүхбаатар, Д.Догсом, Х.Чойбалсан нарын зүтгэлтнүүд монголын үндэсний ардчилсан үзлийг аль нэг хэмжээгээр баримтлан илэрхийлж байлаа.

1921 оны Монгол Ардын Хувьсгалаас хойшхи үеийн гүн ухаан нийгэм улс төрийн сэтгэлгээ нь үндэсний ардчилсан үзлийг, хувьсгалт ардчилсан үзэл болгон хувиргаж, улмаар марксист гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээ Монгол оронд дэлгэрэн хөгжиж байсан түүхэн явцаар голлон тодорхойлогдож байлаа.

Тэр үеийн улс төрийн зүтгэлтнүүд төр улсаа бататган цаашид хөгжин дэвшихэд аль нэг том гүрнийг түшиглэх нь зүйтэй гэж сонголт хийхдээ Орос, Америк, Япон гурвыг сонирхон тандаад Орос улсыг түшиглэх замыг түүхийн эрхээр сонгожээ. Хэрш зэргэлдээ Орос орныг түшиглэхийг Монголын үндэсний эрх чөлөөний зүтгэлтнүүд эртнээс илүүтэйд үзэж авай. Ханддорж чин ван, Сайн ноён Намнансүрэн, Да лам Цэрэнчимэд, Жалханз хутагт Дамдинбазар нар хэн хэн нь үүнд нааштай хандаж байсан баримтууд бий.

Монгол орон Орос орныг дагаснаар орчин үеийн иргэншил өөд түүхэн их дэвшил хийсэн ба улс үндэстний тусгаар тогтнолоо хадгалж чадсан юм.

Ардын хувьсгалын дараахнаас монголын үндэсний ардчилсан үзэл хувьсгалт ардчилсан үзэлд шилжих явц эхлэв. 1925 онд Монгол ардын намыг Монгол ардын хувьсгалт нам хэмээн нэрлэх болж Маркс, Ленинийн зохиолоос орчуулж хэвлэх зэргээр Марксизм-Ленинизмын үзэл санааг сурталчилж дэлгэрүүлэх ажлыг алхам алхмаар хийж эхэллээ. Монголын малчин ард, түүний сэхээтний хувьд Марксизм нь бодит онолын үндсээрээ харш байсангүй. Марксизм монгол төрийн хос ёсны оюун сэтгэхүй, ёс суртахууны үзэл, хүмүүжлийн талыг илэрхийлж байв. Харин улс орны удирдлагын зүгээс Марксизм-ленинизмын сургаалын улс төр, үзэл суртлын талыг илэрхий давамгайлан авч хэрэглэсэн ажээ. Нөгөө талаар Монголд марксизм дэлгэрч хэрэгжих үйл явц гадны, тухайлбал ЗХУ-ын шууд нөлөөллөөр явагдаж, Зөвлөлт орны шинэ нийгэм байгуулалтын явц, туршлагыг хуулж хэрэглэх, дууриах хандлага газар авч, бүтээлч уур амьсгал илт дутагдаж байлаа.

Монголд марксист-ленинист үзэл сургаал дэлгэрч хэрэгжихдээ феодал-шашны үзэл суртлыг няцаан давах, хөрөнгөтний үндсэрхэх үзлийн нөлөөллийн эсрэг тэмцэх, жижиг өмчтний үзэл дадал, урсгал нөлөөг даван туулахын төлөө чармайлт тавих, ийм үндсэн үе шатуудыг дамжсан билээ.

Бүх улс түмний эв санааны нэгдлийн үзэл санааг гол болгон хэрэгжүүлж, түүгээр олон түмнийг хүмүүжүүлэх их хэмжээний ажлыг зохиохдоо үндсэрхэн явцуурах үзлийн эсрэг тэмцлийг идэвхжүүлж, энэ явцад нам, төрийн удирдах зүтгэлтэн, уламжлалт үзэл санаа бүхий сэхээтний дотор гарсан улс үндсээ бодох үзэл суртал, үйл ажиллагааг МАХН-ын доторхи "Баруун хэлбэрэл", Марксизм-Ленинизмд харш үндсэрхэх үзлийн том илрэл хэмээн үзэж, онолын хувьд ч, улс төрийн хувьд ч буруутган няцаасан билээ. Гэтэл "Баруун хэлбэрэл" гэдэг нэрийг зүүсэн үзэл санааны эл урсгал нь үнэн хэрэгтээ улс орноо шинэ үеийн ардчилсан хөгжлийн замаар дэвшүүлж, тэгэхдээ үндэсний өвөрмөц байдал, зан заншил, шашин шүтлэгээ хадгалан үлдэх гэсэн үндэсний ардчилсан үзлийн илэрхийлэл байлаа. Ийм үзэл санааны илрэлүүдэд тухай бүр няцаалт өгч байснаар үндэсний ардчилсан үзэл санаа цаашид гүнзгийрэн хөгжих боломжгүй болж, түүний оронд нийгмийн үзэл санаа ухамсраас эхлээд амьдралын бүх салбарт өөрчлөлт шинэчлэлтийг үсрэнгүй маягаар шуурхайлан хийх хувьсгалт ардчилсан үзлээр дамжин социалист үзэл санаанд хүрэх зам нээгдсэн билээ.

Нийт улс үндэстний эв санааны үзлийг эрхэмлэн барих, хүн ардын өнийн хүсэл мөрөөдлийн илэрхийлэл болсон социалист үзэл санаанд хүрэх нь түүхийн дэвшилттэй, зэрэг явц мөн боловч, түүнийгээ үндэсний өвөрмөц хөрс суурин дээр шимлэн авч чадаагүй нь нэг тийш хэлтийсэн өрөөсгөл баримтлал үйл ажиллагаа болжээ. 1960-аад оноос марксист-ленинист онол, үзэл суртлыг улам гүнзгийрүүлэн дэлгэрүүлэх ажил шинэ шатанд гарч, улс оронд хийгдсэн нийгэм-эдийн засгийн суурь өөрчлөлтүүдтэй холбогдон уг ажлын гол чиглэлийг жижиг өмчтний хувиа бодож, амиа аргацаах үзэл санаа, дадал заншлын эсрэг чиглүүлж, нийт хөдөлмөрчдийг хамт олонч, нөхөрсөг нийтэч үзэл санаагаар хүмүүжүүлэхэд гол анхаарлыг тавьж байв. Энэ нь нийгмийн ёс суртахууны дэвшилтэт бөгөөд монголын ард түмний уламжлалт хамтач нийгэмсүү үзэл дадалд нийцсэн үйл ажил байлаа.

XX зууны сүүлийн 30-аад жилд монголын нийгмийн байгуулал, бүтэц, хөгжлийн асуудал, түүний зүй тогтлын хандлага, хүмүүсийн үзэл санаа, ёс суртахууны хүмүүжил, монголын ард түмний гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүх зэрэг чиглэлээр судалгааны олон бүтээл гарав. Эл бүхий түүхэн явцын үр дүнд монгол оронд шинжлэх ухааны философийн сэтгэлгээ төлөвшин хөгжиж ирсэн нь манай орны нийгмийн сэтгэлгээний томоохонололт даруй мөн.

Харин гүн ухааныг хэт үзэл сурталжуулж байснаас марксист гүн ухааны үндэслэлүүд, түүнийг тайлбарласан улс төрчдийн үзлийг ганц зөв гээд, бусад үзэл ойлгоцыг алдаатай дутмаг гэж үзэн ойшоодоггүй байдал газар авсан байлаа. Монголын гүн ухааны уламжлалт сэтгэлгээ, соёлын өвийг хоцрогдсон харш зүйл гэж хайнга хандах, зарим талаар боож хаах бодлого ч явж байсан нь эргээд сэтгэлгээний хөгжилд сөрөг нөлөө үзүүлжээ.

Ардчилсан өөрчлөлтийн өнөөгийн хөгжилд гүн ухааны сэтгэхүйнололт, аливаа үзэл онолыг нэгэн адил судлах, өөрийн ухаан бодлоор шүүн үзэх олон ургалч үзэл бий боллоо.

Дорно дахины, түүний дотор эн тэргүүнд монгол сэтгэлгээ, монгол сэтгэгчдийнхээ уламжлалт өв санг судалж, түүнийг орчин үеийн сэтгэхүйн ололтоор баяжуулж хэрэглэх, улмаар үндэсний гүн ухаан-нийгмийн сэтгэлгээний цогц сургаалыг боловсруулан баримтлах хандлага идэвхижлээ. Орчин үеийн онолын сэтгэлгээнд нийгмийн гүн ухаан чухал байр эзэлж байна.

Сүүлийн үеийн Европжсон уламжлалыг барих өрнийн сэтгэхүйг эрхэмд үзэн, түүнийг судлан хэрэглэх хандлага нэлээд дэлгэрч байгаа бөгөөд түүнд прагматик үзэл давамгайлж байна.

Энэ хоёр хандлагын аль алиных нь чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийгдэж байгаагийн зэрэгцээ сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний агуулгад тусгалаа олж байна.

Г.Чулуунбаатар
С.Уранбилэг

БӨӨ МӨРГӨЛ

Монголчуудын оюун санааны амьдралд эртний гарал үүсэл бүхий шүтлэгийн зарим хэлбэрүүд, тэдгээртэй холбогдох зан үйлийн уламжлал, төсөөлөл өнөөг хүртэл хадгалагдсаар байгаа билээ. Үүний нэг бол монгол бөө мөргөл юм. Бөө мөргөл бол Монголчуудын язгуур шүтлэг юм. Одоо мэдэгдэж байгаагаар шинэ чулуун зэвсгийн үеэс монголчуудын өвөг дээдэс бөөгийн өмнөх шүтлэгийн хэлбэрийг буй болгон шүтэж түүнийгээ баяжуулсаар ирсэн байна. Олон мянган жилийн настай бөөгийн ёс нь үлэмж баялаг олон талтай бөгөөд монголчуудын соёлын хөгжилд гүн гүнзгий ул мөрөө үлдээсэн билээ.

Бөө мөргөлийн үүслийн тухай асуудал бол хүн байгалийн буюу өөрөөр хэлбэл байгалийн амьтан-хүн, эх байгальтайгаа харьцах харьцааны тухай асуудалтай нэлээд нягт холбогдсон байдаг. Эртний хүмүүс хүрээлэн байгаа байгаль орчныхоо сонин содон тогтоц, илрэл бүхий үзэгдлийг бусдаас онцгойлон салгаж, түүндээ бишрэн шүтэх болсон хийгээд овог аймаг бүр өөрсдийгөө аль нэгэн амьтан буюу ургамлаас гаралтай гэж ойлгон тэр ургамал амьтанаа өөрийн овог аймгийн шүтээн болгож байв. Хүн байгалийн харьцааг зохицуулах үйл явцад хамгийн анх удаа өртсөн шүтлэгийн зүйл болох байгалийн элдэв амьтан, ургамал, хад чулуу, үзэгдэл юмсыг шүтэх тотемизмын үндсэн дээр бөөгийн мөргөл үүсэн хөгжжээ. Улмаар хүмүүс юмс үзэгдлийг сүнс сүлдтэй амьд зүйл гэж ойлгон итгэн бишрэх амьдчилах үзэл буй болжээ. Эдгээр нь эртний бөөгийн өмнөх шүтлэгийн үндсэн хэлбэрүүд болдог. Энэхүү эртний шүтлэгийн хэлбэрүүдийн ахин дэвшсэн шат нь бөөгийн мөргөл билээ.

Өдгөө бөө мөргөл Монгол улсын Хөвсгөл аймгийн дархад, цаатан ард зэрэг угсаатны бүлэг, Говь-Алтай, Ховд аймгийн зарим сумдын урианхайчууд, мөн Дорнод аймгийн зарим сумдын буриад ард түмний дунд тодорхой хэмжээгээр хадгалагдан үлджээ.

Монгол бөөгийн түүхэн хөгжил

Орчин үед бөө мөргөл нь угсаатны бүлэг тус бүрийн онцлог байдалтай, зарим ойлголт өөр нэртэй боловч бүгд нэг л ойлголт болох тэнгэр, нар сар, од гариг, газар усны эзэд, гал голомт, өвөг дээдсийн сүнс сүлдийг эрхэмлэн шүтдэгээрээ нийтлэг байдаг.

Монгол бөө мөргөл нь үүссэн цагаасаа эхлэн хөгжлийн олон үеийг туулан өнгөрүүлжээ.

Бөөгийн мөргөлийн хөгжлийн эхэн үе нь Монгол нутагт анхны төр улс байгуулагдах хүртэл үргэлжилжээ. МЭӨ 209 онд Модун шаньюю Хүннү улсыг мандуулсан үед бөөгийн мөргөл нийгэмд тодорхой байр суурь эзлэх болжээ. Хүннү гүрний төрийн үзэл суртал нь бөө мөргөл байв. Хүннүчүүд Нангиадын түүхэн сурвалжид дурдсанаар "цагаан сараар (жилийн эхэн сард) ханы өргөөнд бүх дарга тэргүүлэгчид бага хуралдайд цугларч тахилга тайлга үйлдэнэ. Тавдугаар сард Луу сууринд Их хуралдайд цугларч өвгөд, тэнгэр, дэлхий, онгон хайрхадад тахилга өргөнө. Намар морь таргалахаар Дайлинд Их хуралдайд цуглардаг"... мөн "Шаньюю өглөө ордноос гарч ургах наранд, орой саранд мөргөнө. Шаньюгийн бие чилээрхлээ гэж Хятадын олзлогдсон жанжнаар бөө нар хойллого хийж" байжээ. Өдгөө хүртэл монголын дархад, цаатан, буриад бөөгийн "онгодын тайлга", "онгод уяж сэргээх", "сэтэр шинэлэх" зэрэг гол тайлга нь энэ цаг хугацааг баримталдаг нь дээр дурдсан Хүннү нарын тайлга тахилгын уламжлалын цаг хугацаа, утга зориулалтын хувьд авцалдаж байгаа юм.

Дархад зайран

Дархад удган

Бөөгийн мөргөлийн хөгжлийн дараагийн үе нь МЭ II зуун хүртэл үргэлжилж, эзэн тэнгэр, гурван ертөнц, сүнс сүлдний тухай ойлголтууд болон зан үйлийн тал нь сонгодог хэлбэрээ олжээ. Хүннүгийн дараа Төв Азид тогтсон монгол ба монгол бус угсааны улсуудын төрийн гол үзэл суртал бөөгийн мөргөл хэвээр байв. Сүмбэ нар Таньшихуйн үед Жаоле гол дээр очиж их тахилга үйлддэг байсан, Их Нирун улсын хаан Ингүдэйд Тэнгэрийн, Амгайд Тэнгэрт мэндтэй хэмээх өргөмжлөл тус тус хүртээсэн, Тоба нар зургадугаар сарын хуучдаар олноороо Иньшань ууланд очиж хур бороо гуйх зэргээр уул усаа тахидаг, Хятанчууд дайн дажны үеэр бөө нараар төлгө буулгуулдаг, үхэр мориор тэнгэр, газрыг тахих их ёслол хийдэг байсан зэрэг нь бөө мөргөл энэ үеүдэд үлэмж хүчтэй хэвээр байсан болохыг нотлон харуулж байгаа юм.

XIII зууны Их Монгол улсын үед төрийн бодлого үйл ажиллагаанд бөөгийн мөргөл томоохон үүрэг гүйцэтгэж байв. Чингис хаан ба түүний залгамжлагчид онгод тэнгэрийн ер бусын хүчинд итгэж сүсэглэдэг бөө мөргөлтөн байсан бөгөөд тэр дундаа хоёр дахь хөвүүн Цагаадай нь хатантайгаа хоёул бөө байсан талаар өдгөө монгол бөө нарын дунд домоглон ярьж, тэднийг онголон шүтэж:

Цагаадай бөөгийн цахиж асаасан гал

Цанхулан удганы үлээж хөгжөөсөн голомт...гэх мэтээр дуудлагадаа оруулан дууддаг байжээ.

XIII зууны үеийн монголчууд тэнгэр-эцэг, газар-эхэд бишрэн шүтэж, мөнх тэнгэрийн хүчээр нь оршин амьдарч, энэ тэнгэрийн дор оршигч газар орон иргэдийг эзлэн захирч байна хэмээн ухаарч байв.

Энэ үед жирийн айл өрхөөс эхлээд хааны орд өргөөнд хүртэл бөөгийн шүтээн онгод хамгийн хүндтэй байранд залардаг байв. Монгол даяар болон их хааны өргөө ордны дэргэд олон бөө удган цугларч, тэдний нэг нь бусдыгаа толгойлон хаан бүх онгон шүтээн, тайлга мөргөлийн асуудлыг хариуцдаг байв хэмээн В.Рубрук цохон тэмдэглэсэн байдаг. Их монгол улсын эхэн үед энэ мэтчилэн зан үйлээс гадна Тэв тэнгэр буюу Хөхөчү бөө бусдаасаа илүү эрх дарх эдлэн нэр нөлөө, суу залиараа бусдыг дагуулж байжээ.

Гэвч удалгүй бөө мөргөл хаан төрийн улс төрийн болоод, үзэл суртлын хэрэгцээ шаардлагыг үл хангах болсон байна. Энэ нь улс гүрэн өргөжин тэлэхийн хирээр нийгмийн хөгжил хурдсаж, түүний хэрэгцээ шаардлагыг бөө мөргөл хангахаа больж, нөгөөтэйгүүр улс гүрний бүрэлдэхүүнд олон янзын шүтлэгтэй улс гүрнүүд багтах болж, шашны олон урсгал нэвтэрч эхэлжээ. Их Монгол улсын нийслэл Хархорумд бөө нараас гадна бурханы шашны сүм хийд, лалын болон христосын шашны сүм хийд зэрэгцэн оршиж байв.

Чингис хааны залгамжлагчид яваандаа бөө мөргөлийг төрийн нэгдмэл үзэл суртал болгох боломжгүй болохыг ухаарч бусад шашныг чиг баримжаагаа болгох болсон юм.

Юань гүрний үед төрийн хос ёс, бурханы шашин хөгжин дэлгэрсэнээр бөө мөргөл нь бүх гүрний хэмжээнд бус, зөвхөн уугуул монгол нутгийн нүүдэлч малчдын хүрээнд үйлчлэх болов.

Улс төрийн бутралын үед бөө мөргөл нь бие биеэ даасан хан, ноёдын гол шүтээн хэвээр байсан бөгөөд харин XY зууны сүүл, XYI зууны эхээр задран бутрах болжээ. Энэ үеэс монгол нутагт бурханы шашныг зохион байгуулалттайгаар дэлгэрүүлэн, төрийн үзэл суртал болгож, бөө мөргөлтөн, бөөгийн онгод шүтээнийг шахан хавчих болсоноор бурханы шашинд өөрийн орон зайгаа тавьж өгөх болжээ.

Бурханы шашин бөө мөргөлийн монголын нийгмийн орон зайд эзэлж байсан байр суурийг булаан авахдаа:

1.Төрийн албадлагын хүчийг ашигласан, тухайлбал, шашны хуврагуудын эрх ямбыг нэмэгдүүлэн хуульчилсан, бөө мөргөлийн хуучин зан үйлийг хүчээр хориглох зэрэг арга хэмжээ авсан,

2.Бурханы шашин бөө мөргөлийн зан үйл номлолын суурин дээр өөрийн үйл ажиллагааг уялдуулж, бөө нарын зан үйл, оюун санааны уламжлалыг бурханы шашны үүднээс өөрчлөн дотоод агуулгыг нь хэвээр хэрэглэх зэрэг арга хэмжээг авч явуулжээ. Бурханы шашин бөөгийн зан үйлээс олон зан үйлийг авч өөриймшүүлсэн байдаг.

Энэ мэтчилэн бөө мөргөл нь XY-XYII зууны үеэс бурханы шашинд өөрийн монголын нийгэмд эзлэж байсан онцгой байр сууриа тавьж өгсөөр XX зууны эхэн болоход хэсэг бусаг, орон нутгийн шинжтэй шүтлэгийн үлдэгдэл болон хувирсан юм. Энэ үеийн бөө нар нь дотроо шашныхаа язгуурлаг шинжийг авч үлдсэнийг харын бөө, язгуур шинжээ алдаж бурханы шашинд уусаныг шарын бөө, бурханы шашны улааны урсгалтай холилдсоныг чойжин-гүртэм хэмээх лам бөө гэж хуваагдсан ажээ.

1920-иод оны хувьсгалын жилүүдээс хойш 1990-ээд он хүртэл бөө мөргөл нь үндсэндээ устах шатандаа орсон бөгөөд харин 1990-ээд оноос өөрчлөлт шинэчлэлтийн жилүүдэд дахин сэргэх хандлагатай байна.

Монгол бөөгийн ертөнцийг үзэх үзэл

Монголын бөө нарын үзлээр хүмүүн бидний оршин амьдарч буй дэлхий ертөнц бол нэгэн үед нэгдмэл нэгэн цул зүйл байгаад хожим газраас тэнгэр салах үед гал үүссэний дээр тэнгэр нь амь оруулж эр үүтгэл, газар нь хэлбэр дүрс өгсөний учир эм үүтгэл болсоноор газар тэнгэр бий болсон гэж үздэг. Энэ утгаараа газар тэнгэр хоёрыг бүхнийг бүтээн туурвигч эхлэлүүд мөн хэмээн үзнэ. Үүнээс тэнгэр бол юмсыг бүтээгч анхдагч эр идэвхтэй эхлэл, газар бол хоёрдогч эм идэвхгүй эхлэл юм. Тэнгэрийг мөнх хөх тэнгэр, тэнгэр эцэг гэхчлэн нэрлэнэ. Үүний эсрэгээр газар дэлхийг ихэвчлэн газар эх, этүгэн эх, хөрс этүгэн, дайр этүгэн гэх зэргээр нэрлэнэ.

Эртний монголчуудын шүтлэгийн уламжлалд байгаль, ертөнц, хүн амьтдын цаана тэд бүхнийг харж хандаж байдаг тусгай

эзэн тэнгэр нуугдаж байдаг гэсэн ойлголттой байв. Чухамхүү энэхүү ойлголт нь бөө мөргөлийн ертөнцийг үзэх үзлийн гол үндэс бололтой. Бөөгийн дээд шүтээн нь тэнгэр юм.

Зайран хүний бүрэн хэрэглэл (МҮТМ)

Эртний монголчуудын шашны үзэл нь байгалийн энгийн тодорхой юмс үзэгдлийг шүтдэг байснаасаа цааш гарч, хийсвэрлэн улмаар тэнгэр хэмээх хийсвэр ойлголт буй болгон шүтэх болжээ. Тэнгэр хэмээх ойлголтонд байгалийн харагдах ба үл харагдах бүх хүчийг хамруулан үзэж байсан. Эхлээд тэнгэрийг газар усны нэгэн адил тодорхой үзэгдлийн утгаар шүтэж байснаа сүүлдээ харагдах тэнгэрээс үл харагдах хийсвэр тэнгэрийг шүтэхэд хүрсэн байна. Улмаар тэдний үзэл бодолд өөрсдийнх нь аж төрж явсан орчин тойрон болох газар ус, ургамал амьтан, тэнгэрийн эрхэс, байгалийн элдэв үзэгдэл, мал аж ахуй, ан гөрөө, газар тариалан, отог, овгийн өвгөд дээдэс зэрэг хамаг юм, үзэгдэл бүхний цаана тэд бүхнийг харсан тусгай эзэн тэнгэр нуугдаж байдаг гэсэн ойлгоц бий болжээ. "Монголчууд зөвхөн гагц Тэнгэрт итгэх бөгөөд түүнийг үзэгдэгч ба үл үзэгдэгч бүх амьтан юмсыг бүтээгч хийгээд ертөнцийн аливаа жаргал, зовлонгийн эзэн хэмээн үзнэ" гэж эрт цагт Монголд ирж байсан гадаадынхан гярхай ажиглан бичсэн байдаг.

Иймээс тэрхүү дээд шүтээн нь өөртөө бусдын хувь заяаг хариуцдаг олон тооны эзэн тэнгэрийг агуулж байдаг онцгой ертөнц болдог байна. Монгол бөөгийн мөргөл ёсоор огторгуйд нийт 99 тэнгэр байх бөгөөд тэдгээр тэнгэрээс хүнд тус дэм хайрладаг баруун зүгийн 55 тэнгэр, хортой муу бүхнийг хийдэг зүүн зүгийн 44 тэнгэр тус тус байдаг хэмээн итгэж ийнхүү тайлбарладаг байна. Энэхүү баруун зүгийн 55 тэнгэрийн 50 нь залбирдаг, 5 нь тахидаг тэнгэр аж. Тахидаг таван тэнгэрийн эхнийх нь аливаа амьтны амь, сүнсийг сахидаг Хисан улаан тэнгэр, хоёр дахь нь, Цахилгаан цагаан тэнгэр, гурав дахь нь, Одон заяан тэнгэр, дөрөв дэх нь хүн малд хишиг хайрладаг Хөх манхан тэнгэр, тав дахь нь, Заяач тэнгэр гэнэ.

Бөөлж буй удган (МҮТМ)

Харин зүүн зүгийн 44 тэнгэрийн 40 нь залбирдаг, 4 нь тахидаг тэнгэр байдаг ажээ.

Эдгээр тахидаг 4 тэнгэр нь нэгд, идээ хишиг өгөгч Гүжир тэнгэр, хоёр дахь нь, элдэв өвчнөөс авран хамгаалагч Боом махаш тэнгэр, гурав дахь нь, морин эрдэнэ бэлэглэдэг Атаа улаан тэнгэр, дөрөв дэх нь, эвэртэй малын хишиг өгөгч Годил улаан тэнгэр байдаг гэнэ. Ингээд баруун болон зүүн зүгийн тэнгэрүүд хоорондоо үргэлж тэмцэлдэн байдаг ба энэ тэмцэлээс орчлон ертөнц дэх сайн, муу үйлүүд хамааран хэлбэлзэн өөрчлөгдөж байдаг хэмээн үзнэ. Тэнгэр бүр ертөнц ахуйн тодорхой нэг зүйл салбарыг хариуцан эзэгнэдэг байна. Тухайлбал, аянга цахилгааны эзэн Мөндөр тэнгэр, хурын эзэн Зад цагаан тэнгэр, хүн малын үр төлийг тэтгэгч Охин хар тэнгэр, ан гөрөөсны эзэн Манахан тэнгэр, галын эзэн Галайхан тэнгэр гэх мэт олон тэнгэр буй. Нэг үгээр хэлэхэд байгаль ертөнцийн бүх юм үзэгдэл, хүний аж амьдрал, сэтгэл ухамсрын тодорхой салбар бүрийг хамарсан эзэн тэнгэр байж, түүний тогтоон тодорхойлсон заяа тавилангаар бүх юм болно гэж бөө мөргөлд үздэг.

Эртний бөө нарыг дотор нь хар зүгийн бөө, цагаан зүгийн бөө гэж хоёр хувааж үздэг байна. Энэ нь бөө нар сөрөг мууг сүүдэртэй гэж хараар, эерэг сайныг гэрэл гэгээтэй гэж цагаанаар төлөөлүүлдэг, бас баруун ба өмнө зүгийг ээлтэй сайн зүг, зүүн зүгийг муу зүг гэж үздэгтэй ямар нэгэн хэмжээгээр холбоотой бололтой. Энэ үед хар домын шившлэгээс үндэслэн, дээд тэнгэр, газар усны эздийг "номхон", "догшин" хэмээн хоёр ангилан үзэж, догшидыг бүхэлд нь хар тэнгэрүүд хэмээн тахин шүтэх болсон байна. Ийм учраас дан ганц хар тэнгэр, хар онгодоор хөллөсөн бөөг тэр онгодын байрладаг зүг чигээр нь хар зүгийн бөө гэж нэрлэдэг. Үүний нөгөө талд сайныг зөгнөсөн, сайн дом шившлэгийн зан үйл хөгжсөн хэлбэр нь цагаан зүгийн бөөгийн зан үйл даруй мөн. Цагаан зүгийн номхон эзэд цагаан тэнгэрүүдтэй харьцдаг цагаан зүгийн бөө баруун зүг хандаж залбирал үйлддэг ёс эрт цагт бүрэлджээ. Цагаан зүгийн бөө нар харьцангуй олон болж байжээ.

Монгол бөөгийн ертөнцийг үзэх үзлийн бас нэг ойлголт бол Гурван ертөнц буюу тив хэмээх ойлголт юм. Бөө мөргөлтнүүд дэлхий ертөнцийг дээд дунд, доод гэж гурван давхар болгон үзнэ. Дээд тив буюу ертөнц бол ариун сайхан, энэрэнгүй ертөнц, дунд ертөнц бол

хүн амьтан оршин амьдарна, доод ертөнц дээр үхээрийн шулмасууд хуран сууж, өвчин тахлыг тараан байдаг хэмээн үздэг. Эл гурван ертөнц тивийн тухай төсөөлөл нь өөр өөрийн онцлогоос улбаалан сүсэг бишрэлийн янз бүрийн илрэлийг бий болгожээ.

Бөөгийн индэр

Монгол бөө нар хүн зөвхөн ганц сүнстэй биш зуурдын хоёр, үүрдийн нэг сүнстэй гэж үздэг. Тэр гурав нь бөө нарын үздэгээр эхээс заяасан махан бодийн сүнс, эцгээс шингэсэн ясны сүнс, тэнгэр сүнс гэж байдаг. Хүн үхэхэд мах цусны сүнс нь биед нь гурван жил болдог. Өөрөөр хэлбэл тэр хүний бие бүрэн эвдэрч үгүй болтол байж л байна. Ясны сүнс нь сүүжний ясанд байдаг. Сүүжний яс хэдийд алга болно тэгэхэд хамт үгүй болдог. Эцэст нь тэнгэр сүнс нь яс махны сүнсүүд алга болоход энэ сүнс дэгдээд явдаг хэмээн үздэг байна.

Халх бөө нар

Монгол бөөгийн зан үйл

Монгол бөөгийн зан үйл нь өөрийн онцлог шинжтэй байдаг. Тэр онцлог нь орон зай, нүүдэл суудлын адилгүйгээс гадна яс овгуудын ялгаатай байдал, бусад шашны нөлөөлөл зэргээс шалтгаалдаг.

Бөө болох явдал үе залгамжлах, нийгмийн дотроос сонгон тодруулах гэсэн хоёр янз хэлбэртэй байдаг ба монгол, буриад бөө нар голдуу тодруулах журамтай байжээ. Гэхдээ монгол бөө нарын ихэнх нь удам дамждаг, цөөнх нь удмын биш бөө нар байдаг. Гэхдээ монголын бөө нарын ойлголтоор бөө удган болох хүнд заавал дээд угийн онгод сахиус шүглэж, ухаан санаа уймрах зэрэг бөөгийн өвчин тусдаг гэдэг. Ийнхүү бөөгийн өвчнөөр өвдсөн хүнийг бөө болох хүн хэмээн үзэж 15-аас дээш жил бөөлсөн сайн бөөгөөр багшлуулдаг. Бөө болох хүний хэрэгсэлүүдийг багш бөө бэлтгэх бөгөөд хээр зэлүүд газар бөөлөх ёс, дуудлагууд, дуудах онгодыг нь зааж цээжлүүлдэг байна. Бөөлөх энэхүү сургууль нь шавь бөөгийн авъяас чадвараас шалтгаалан 15 хоногоос 2 сар хүртэл үргэлжилдэг байна. Энэ бүхний эцэст тогтсон өдөр болоход багш бөө шавь бөөгийнд ирж хэц, хэнгэрэг, өмсгөл, гутал, малгайг амилуулж өгсөний дараа шавь онгодоо залан бөөлдөг байна. Бөө болсоны дараа гэртээ онгод сахиусаа залан бөөлөхөөс биш, айлд уригдах, хээрийн онгод тахин бөөлдөггүй байжээ. Таван жил бөөлсөний дараа заллаганд очиж бөөлөх эрхтэй болдог байв.

Бөөлөх. Эрт цагт бөө хүн сар бүрийн сондгой тоотой өдрүүдэд бөөлдөг байжээ. Бөөлөхийн өмнө өмсгөлөө өмсөлгүй хэнгэрэгээ галд эгшээн хатааж, дуу оруулаад онгодын өмнө идээ будаа сөгнөнө. Үүний дараа өмсгөл хувцасаа өмсөж хэнгэрэгээ барин онгодын өмнө сөхрөн сууж тамлагаа дууддаг байна. Онгод залсаны дараа гал голомтонд өргөх тамлагаа дуудаж, гэрийн эзэн тамхилж, бэлтгэсэн цай идээнээс амсан өнгөрсөн үйл явдлын тухай онгод тэнгэрийн хэлсэнээр дамжуулан хэлэлцдэг ажээ.

Гэрийн онгод тахих ёс. Монгол бөө нар шинээр бөө болсоноос хойш гурван жилийн дараа анх бөө болсон өдрөө тохиолдуулан гал голомтондоо бие даан бөөлдөг. Энэ нь шинэ бөөгийн үйлдэж буй гэрийн онгод тахих анхны зан үйл болдог. Ингэж бөөлөхдөө шинэ бөө тодорхой зан үйлийг үйлдэж, идээ будаа бэлтгэнэ. Ингээд үдшийн цолмон гармагц онгодын өмнө дэвссэн цагаан эсгий дээр сөхрөн бөөлж онгод тэнгэртээ цацал цацан, арц уугиулж бөөлдөг байна.

Хээрийн онгод тахих ёс. Нас барсан өмнөх үеийн бөө нарын сүнсийг түүний өмсгөл хэрэгсэлийн хамт олон үеийн турш хүндэтгэн, тусгай байранд онголон тахисаныг хээрийн онгод хэмээн нэрлэдэг. Хээрийн онгод нь гэрийн онгод үүсэх урьтал юм. Бөөг өөд болсоноос хойш гурван жилийн дараа тэр бөөгийн сүнсийг онголон босгосноор харын бөөгийн ёсонд хээрийн шинэ онгод бий болдог. Хээрийн онгодыг идээ цагаа элбэг намрын улиралд тахидаг. Хээрийн онгод тахих зан үйл нь тухайн айл өрх өвлийг өнөтэй давах, хүн малын гарз, өвчин зовлонгүй байхыг даатган бөө хүнээр хийлгэдэг байжээ.

Онгод тэнгэрийг хөрөглөх ёс. Монгол бөө нар эртнээс нааш эрхэмлэн шүтдэг юм бүхнийхээ сүнсийг хийсвэрлэн дүрсэлж, түүнийгээ малын үс ноос, эсгий бөс даавуу, мод зэргээр дүрслэн бүтээж иржээ. Энэ нь монгол бөөгийн онгод тэнгэрийн хөрөг дүрсийн үндсэн хэлбэрүүд болдог.

Сэтэр онгод
(МҮТМ)

Монгол бөө нар онгод тэнгэрээ хөрөглөн бүтээж байсан гурван үндсэн хэлбэр байжээ. Үүнд,

-Мод чулуун дээр сийлбэрлэх, чулуу, мод, бөс даавуу, эсгий, ноос, өвс зэргээр тусгай бие болгон хүүхэлдэй маягаар дүрслэн бүтээсэн дүрс онгодын хэлбэр

-Ямар нэгэн хүн амьтан юмыг дүрслэлгүй олон өнгийн даавуу хадаг, булга, хэрэмний арьс зэрэг

эдээр хийсэн урт богино бүхий дүрслэл сэтэр онгодын хэлбэр

-Дүрслэн бүтээх, хийсвэрлэн бүтээх хоёрын хэлбэрийг хослуулан хэрэглэсэнийг хэц онгодын хэлбэр гэдэг.

Хэц онгод
(М УТМ)

Овоо тахих ёс нь Монгол бөөгийн нэгэн өвөрмөц зан үйлийн нэг юм. Монголчуудын газар усаа тахиж, шүтэж бишрэх, байгаль дэлхийтэйгээ зохицон амьдрах нэгэн төрлийн шүтлэг юм. Уул усаа тахина гэдэг нь хүний сэтгэл санааг засаж, хийморийг сэргээх сэтгэлийн ариусал болдог. Энэ зан үйл нь бас уул ус цаанаа эзэнтэй байдаг гэсэн монголчуудын бөө мөргөлийн нэгэн үзлийн улбаа юм. Газар ус, байгаль дэлхийгээ бишрэн шүтэх хамгийн өргөн тархсан хэлбэр нь овоо тахилга байсан ба овоог томоохон уул, даваа, гол ус нуурын дэргэд босгодог байна. Овооны онго гэж тусгай онго байдаг. Бөө удган нар овоо тахиж бөөлөхдөө юуны урьд овооны онгыг урин дуудаг. Овооны онго бол бүх онгоны тэргүүн юм. Тиймээс овоо тахилга нь бөөгийн тахилгын зан үйлийн гол тахилын нэг байсныг илтгэж байгаа юм.

Монголчууд овоог голчлон зуны эхэн сард болон 7, 8-р сард тахидаг. Монголын бөө нарын үзлээр овоо бол онгод, хайрхадын дамжлага бууц, буудаг газар нь, эргэн тойрдог тэнгэр лусын оромж гэж үздэг. Монгол хүн овооны дэргэдүүр шууд өнгөрдөггүй. Заавал мориноосоо бууж мөнгө төгрөг, хадаг яндар, идээ будаа цацах буюу мориныхоо дэл сүүлнээс тасалж овоон дээр тавих, чулуу нэмэх заншилтай.

Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн үеэс уламжлалт бөө мөргөлийн овоо тахилгын зан үйл, дэг ёсонд ихээхэн өөрчлөлт гарч, шинээр дэг ёс нэвтрэх болжээ. Овоо тахилгын зан үйлийг хуучин цагт бөө, удган нар дагнан үйлддэг байсан бол хожмоо бурханы шашны лам нар, сүм хийд үйлдэх болж, овоог шинээр босгох дэг журам зохион, овооны эзэд савдагийг бурхадаар төлөөлүүлэх болжээ. XX зууны эх гэхэд Монгол орны аймаг, хошуу сум, хүрээ, хийдийн болон бүх нийтээр тахих уул, овоо гэх мэтээр шатлан дэглэсэн зэрэг дэв бүхий овоо тахилгын дэг ёс нэгэнт бүрэлдэн тогтжээ.

Буриад бөөгийн 13 овоо

Бөөгийн эмчилгээ. Хүмүүст тохиолдсон өвчин зовлон гай барцадыг анагаах, арилгах үйлст эрт цагаас хүчин зүтгэсэн хүмүүс бол бөө нар билээ. Бөө нар хүмүүсийн өвчин зовлон гай барцадын учрыг онгод тэнгэрээсээ асууж өвчин зовлонгийн шалтгааныг мэдэж тодруулдаг гэж үздэг. Ийнхүү учир шалтгааныг тодруулсаны дараа түүнд хийх элдэв заслын ажилд ордог байна. Бөө нарын эмчилгээ нь бүхэлдээ байгалийн гаралтай эмчилгээ байдаг бөгөөд далд, ил хоёр хэлбэрээр явагддаг. Далд хэлбэр нь нэг талаараа сэтгэл зүйн агуулгатай байдаг байна. Ил хэлбэр нь үндсэндээ арц, жодоо, агь, ганга зэрэг ургамлын анагаах, ариутгах чанарыг мэдэж, тэдгээрийг нэгтгэн эмчлэх эдгэрүүлэх чадварыг нэмэгдүүлэн ашигладаг байна. Түүнчлэн ханах, төөнөх зэрэг уламжлалт эмчилгээний аргуудыг бөө нар өргөн дэлгэр хэрэглэдэг байжээ.

Монгол бөөгийн хувцас, хэрэглэл. Бөөгийн ертөнцийг үзэх үзэл, шинж чанарыг нь судлахад хувцас хэрэглэл чухал байр эзэлдэг. Энэ ч утгаараа монголын угсаатны бүлгүүд болгоны бөө, удган нар бөөлөх үедээ өмсөх хувцас хэрэглэл нь тодорхой ялгамжтай байдаг хэдий ч басхүү хоорондоо нийтлэг зүйл их байдаг. Монгол бөө нарын өмсгөл хэрэглэлүүд дараах бүтэцтэй байна. Үүнд:

Дээл. Монгол бөө нар бөөлөх үедээ өмсөх хувцсаа хуяг хэмээн нэрлэдэг. Учир нь бөө хүн бөөлөх үедээ элдэв төрлийн дайрлага муу юмтай олонтой учирч байдаг учир тэдгээрээс хамгаалах халхавч нь дээл болдог байна. Эрт үед бөө нар дээл, өмсгөлөө бор гөрөөс, зээр, ямааны элдсэн арьсаар үйлддэг байв. Удганы дээл, бөөгийн дээл гэж ялгамжтай. Бөө дээл нь бие манжиг, мөргөл манжиг, хормой, хонхинуур, уяа, суга, бүч, сүүл, нуруу, суга, товч, ханцуй, далавч, хошмог, энгэр гэсэн хэсгүүдээс тогтоно. Эдгээр дээлийн бүрдүүлж буй хэсгүүд нь тус бүрдээ утга зориулалттай байдаг.

Бөөгийн дээл
(М УТМ)

Бөөгийн дээлийн
зэл хонх шуур
(М ҮТМ)

Бөөгийн дээлийн бие манжиг
буюу могойн дүрслэл
(М ҮТМ)

Бөө гутал бол бөөд ирсэн онгод буюу өөд болсон бөөгийн сүнс, лус хоёрын нийлбэрийг хоёр хөл нь бөөгийн гутал юм гэж харын бөө нар үздэг. Бөө гутлыг гурын элдсэн арьсаар үйлддэг. Монголын дархад, буриад бөө нар ийм гутал хэрэглэдэг бол урианхай бөө нар тусгайлан гутал хэрэглэдэггүй.

Монгол бөөгийн хэрэгсэл гэсэн ойлголтонд хэнгэрэг болон түүний цохиур, хуур, толь, таяг, сэвэр гэх мэт зүйлс хамаарагддаг. Бөөгийн хэрэгсэл нь бөөгийн онгодын унаа, онгод тэнгэрүүдийг баясгагч хөгжмийн зэмсэг, олон түмний хүсэлтийг онгод тэнгэрт дамжуулан хариу авах хэрэгсэл гэсэн ойлголтыг өөртөө багтаадаг.

Бөө малгай. Тухайн бөөд залагдан ирж буй онгод тэнгэрийн толгой хэмээн үздэг байна. Монгол орны ихэнх нутагт Оргой хэмээн нэрлэх нь бий. Бөө малгай нь нүүр самалга, нүүр буюу малгайн духны тус газар хүн амьтны нүүрийг дүрсэлсэн дүрс, малгайн өд буюу малгайг тойруулан шар шувуу болон бүргэд сойрын өд, хараа, чих зэргээс бүрдэх бөгөөд эдгээрийн байршил нь бөө нарын овгийн ялгааг тодорхойлохоос гадна малгайд хадсан бүргэдийн өдний тоо нь шавийн тоо ба удам угсаатны үеийн тоог илэрхийлдэг.

Бөө малгай буюу оргой
(М ҮТМ)

Бөө гутал
(М ҮТМ)

Бөөгийн хэнгэрэг гэдэг нь тухайн бөөд залагдаж ирсэн онгоны унаа нь болдог. Хэнгэрэг нь нэг талдаа битүү, нөгөө тал нь задгай амьтны арьсаар бүрж хийсэн байдаг. Монголын харын бөө нар хар зүгийн онгодтой харьцдаг хэнгэрэгээ чоно, баавгайн арьсаар, цагаан зүгийн онгодтой харьцдаг хэнгэрэгээ согооны ширээр бүрдэг заншилтай байв. Хэнгэрэгийг монголын дархад ясны бөө нар хэнгэрэг буюу аян саарал, буриадууд хэц, урианхайчууд дүнгэр хэмээн нэрлэх нь бий. Хэнгэрэг нь бөөгийн унаа нь болж өгдөг бөгөөд бөө унаагаа унаад тэнгэрт халин дүүлэн нисэж учрах онгонтойгоо уулздаг байна. Харин зарим монгол угсаатны дунд хэнгэрэг нь бөөгийн унаа бус харин залагдан ирж буй онгодын унаа юм гэж үзэх нь бий.

Цохиур бол хэнгэрэгийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хэнгэрэгийн цохиурыг монголын дархад, хуулар, тува бөө нар орба, буриад бөө нар тойбуур, халх бөөд ташуур, урианхай бөө нар малиа гэх мэтээр нэрлэдэг. Цохиур нь толгой, иш гэсэн хоёр хэсгээс тогтох ба онгод тэнгэрийн хөлгийн ташуур, онгодын хэлмэрч гэсэн үндсэн агуулгатай байдаг.

Бөөгийн хэнгэрэг
(МҮТМ)

Хэнгэрэгийн цохиур
(МҮТМ)

Хуур бол монгол бөөгийн нэгэн төрөл хөгжмийн хэрэгсэл нь юм. Шүдэндээ зуух буюу нааж баруун гарын дунд хурууг эрүүний тус газар тулгуурлан долоовор хуруугаар цохиж ая оруулан тоглодог зэмсэг юм. Үүнийг хэл хуур, аман хуур гэх мэтээр нэрлэдэг. Энэхүү хэл хуурыг бөө нар тайлбарлахдаа энэ бол онгод тэнгэрийн улаач, бөө хүн онгодын улаа нэхэж явахдаа унадаг морь унаа юм хэмээн үздэг. Тэрчлэн хуур бол бөө хүний зам заагч, хэлмэрч, онгодоо дуудах хэрэгсэл гэсэн үзэл ч байдаг.

Толь бол бөөгийн нэгэн чухал хэрэгсэл бөгөөд хүрэл юм уу гуулин хавтгай дугираг эдлэлийг хэлдэг. Бөө нар толийг хадгаар оосорлож энгэртээ юм уу, хүзүүндээ зүүж явдаг. Энэ нь элдэв хараал зүхэл, онгодын халдлагаас бөөг хамгаалах хамгаалагч болон явдаг гэсэн үзэл юм. Толийг бөө нар мэргэ төлгөнд ихэвчлэн хэрэглэдэг байна.

Бөөгийн таяг гэдэг нь Монгол улсын Хөвсгөл нуур орчмын монгол бөө нарын дунд дэлгэрсэн гурван ац бариултай хус модон хэрэгсэл юм. Энэ таягийг газар лусын хорлолоор бөө болсон бөө бөөлөхдөө хэнгэрэгийг орлуулан хэрэглэж байсан. Тэгэхдээ таяг нь хэнгэрэгийн адил бөөд хүрэлцэн ирсэн онгодын унаа бус харин лус савдагийн хөлөг гурван ац толгойтой могойн дүрс гэж үздэг. Бөө бүхэн таяг хэрэглэдэггүй. Зөвхөн лусын хорлолоор бөө болсон их ховор нөхцөлд лусын хөлөг могойг дүрсэлсэн таяг хэрэглэж, түүгээр хэдэн сар бөөлж байгаад дараа нь хэнгэрэг төхөөрч бөөлөх болдог. Таягаар бөөлж эхэлсэн бөөг их хүч чадалтай бөө болдог хэмээн ярилцдаг.

Модон онго (МУТМ)

Бөөгийн хэрэгслүүд (МУТМ)

Бөөгийн хусан таяг (МУТМ)

Сэвэр. Энэ нь долоон өнгийн торгомсог даавуу зүүж унжуулсан, дээрээ булцуу маягийн бариултай алчуур юм. Сэврийг бөө, удган нар баруун гартаа бариад хоёр гартаа ээлжлэн цохиж бөөлөн онгодоо дууддаг байна.

Монгол бөөгийн хувцас хэрэглэлүүдийг ажиглахад тэдгээр нь авсаархан, хөнгөхөн, хаа ч авч явахад тохиромжтой, хийц хэлбэр өвөрмөц байгаагаас гадна, бүхэлдээ онгод тэнгэрийг дуудах, урьж залахад зориулагдсан нь харагддаг. Бөө хүнийг ямар хувцас хэрэглэлтэй байгаагаас нь түүний хүч чадал, зэрэг дэвийг мэдэж болдог. Монголын олон ястнуудын хувцас, хэрэглэлд зарим нэгэн хэлбэр хийцийн ялгамжтай талууд болон нэр томьёоны зөрүү ажиглагдах боловч тэдгээрийн үүрэг зориулалт, утга бэлгэдэл нь адил байна.

Эдгээрээс үзвэл монголчуудын эртний шүтлэгийн зан үйлийн уламжлалд нутаг дэвсгэрийн байршил, эрхлэх аж ахуйн онцлог, оюун санааны амьдралын өвөрмөц байдал нөлөөлсөн хэдий ч монгол угсаатны өв соёлын нийтлэгийг илтгэх нь олонтаа билээ. Ийнхүү монгол бөөгийн зан үйлийн уламжлал нь тэдний ахуй байдалд хадгалагдан олон зууныг улиран ирэхдээ тэдний оюун санааны амьдралд багагүй үүрэг гүйцэтгэсээр иржээ.

Л.Эрдэнэболд

С.Уранбилэг
Э.Амарбилиг

БУРХАНЫ ШАШИН, СОЁЛ

Монгол нутаг дээр ээлж дараалан мандсан эртний нүүдэлч аймгууд, ялангуяа монгол угсаатны дунд бурханы шашин мандал буурлыг үзэн их бага хэмжээгээр дэлгэрэхдээ тэдгээрийн ахуй нөхцөл, соёл шүтлэгт зохицолдон нийлж, өвөрмөц шинж төрхийг олсоор байжээ.

Бурханы шашин Хүннү улсад анхлан нэвтрэн дэлгэрч, төр ёсны үзлийн үзэл суртлын үндэс болжээ. Одоогийн БНХАУ-ын Хөхнуур, Ганьсу орчмоор нутаглаж байсан Хүннүгийн Сючугэ вангийн шүтэж байсан 3 метр гаруй өндөр алтан хөрөг бол бурханы хөрөг мөн ажээ. Хүннү, Сяньби улсад бурханы шашин дангаар ноёрхож байсангүй, харин бөө мөргөл зонхилж байжээ.

Хүннүгийн дараах нүүдэлчин аймгуудын дотроос Тоба буюу Табгач аймгийнхны дунд бурханы шашин дэлгэрч, Тобагийн Вэй улс (386-534)-ын үед төрийн шашин болгож, Монгол нутаг дахь Жужан нарт дэлгэрүүлжээ.

Нирун улс бурханы шашныг төрийн хэмжээнд өргөмжлөн Энэтхэгтэй харилцаж, Энэтхэгийн эрдэм соёлын зарим ололтыг Монголд нэвтрүүлж байжээ.

Монгол нутагт мандсан Түрэгийн хаант улсын Тоба хаан (573-581) буддын сүм, суварга босгож, Ишпара хаан (581-587), Билгэ хаан (710-730)-ы үед ч Монголын төв хэсэгт бурханы шашин нэлээд дэлгэрч байжээ.

Уйгурын хаант улсын үед Хар балгас, Байбалык зэрэг хотод бурханы шашны сүм дугана байгуулан, санскрит, түвэд ном судар орчуулж байв.

IX-X зуунд мандаж асан монгол хэлтэн Хятанчууд эхний үедээ бурханы шашныг тэтгэн дэмжиж,Хойд Хятадад Ляо улсыг байгуулахдаа төрийн шашин болгожээ.

Чингэж монгол нутаг дээр ээлж дараалан мандсан эртний төр улсуудын үед бурханы шашин үе үе нэлээд дэлгэрлийг олж, эртний Энэтхэгийн шашин соёлыг Дундад Азийн улс түмнээр дамжуулан хүртэж, нүүдлийн өвөрмөц түүх соёлоо баяжуулан тэтгэж, цаашид гүнзгийрүүлэн монгол буддизм болон хөгжихийн эхлэлийг үүсгэжээ.

XIII зуун бол нүүдэлч монголчуудын үндэсний ухамсар, нийгэм, оюун санаа, ертөнцийг үзэх үзэлд гүн гүнзгий хувьсал тэлэлт орсон онцгой содон үе болой.

Пагва лам

Их Монгол улс байгуулагдсан нь нүүдэлчдийн дунд эртнээс уламжлалтай бурханы болон бусад шашны үйл ажиллагааг үлэмж идэвхжүүлжээ. Буддын шашин Монголд улам бүр нөлөөтэй болж, монгол хаад Түвэдийн хутагт дээд лам нартай харилцаж, бурханы шашныг тэтгэн дэмжих болжээ.

Чингис хаан Тангуд улстай харилцах явцдаа Түвэдийн лам нартай уулзаж, бурханы шашны талаар өргөн мэдээлэл авч байжээ. Өгөдэй хаан Түвэдийн Гүнтан (Цал гүнтан) хийдийн хутагт ламыг Монголд залан,Тулуй ноёны Сорхоггани хатан түүнийг хан хөвгүүдийн тахилын ламаар өргөмжилж, Хархорум хотноо суулгаж байжээ. Өгөдэй хааны үед Умард Энэтхэгийн Качи буюу Кашмирын Наму, Оточи хэмээгч ах дүү хоёр лам ирж, хаадын ордонд тахигдан, хожим Гүюг хаан Наму ламтныг тахилын багшаар өргөмжилжээ. Түүнийг мөн Мөнх хаан улсын багшаар өргөмжлөн гүрнийхээ бурханы шашны хэргийг захируулан хас тамга олгож байжээ. Энэхүү Наму багш Хубилай хааны үед Пагва ламын хамтаар Түвэдийн бурханы шашныг Юань гүрний төрийн шашин болгон бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Хубилай хаан 1253 онд Пагва ламыг тахилын ламаар залж, улмаар 1260 онд улсын багшаар өргөмжилж, бурханы шашныг нийт гүрний төрийн шашин болгож, номын ёсоор явагч лам нарыг улаа, алба, гувчуураас бүрэн чөлөөлж, сүм хийдэд элч буух, сүм хийдийн харъяаны газар, ус, эд юмсыг эдэлж эзэмшихийг хориглосон зарлиг гаргажээ. Пагва ламын үндэслэн номлож, Хубилай хааны хэрэгжүүлсэн хоёр ёсны үзэл баримтлалыг Юань гүрний хаад уламжлан хөгжүүлжээ.

Хубилай хааны төр ёсны шинэтгэл Монголын нийгмийн сэтгэлгээний түүхэнд энэ зууны эхэн хүртэл уламжлагдсан ертөнцийн засаг хийгээд номын засгийг тэгшид явуулах зорилго бүхий хоёр ёсны үзэл баримтлалаар тодорхойлогдож байна. Хэдийгээр Юань гүрэнд бурханы шашны сажава, гаржүдва зэрэг урсгалууд дэлгэрч байсан боловч Монголын язгууртны хүрээнээс халин дэлгэрч чадаагүй юм.

Монголын Юань гүрэн мөхсөний дараагаар бурханы шашны нөлөө ихээхэн суларч, нийгмийн оюун санаанд уугуул шүтлэг бөө мөргөлийн байр суурь бэхэжжээ. Тийн хэдүй ч бурханы шашны үүрэг нөлөө Түвэд болон Мин улстай ойр дөт оршиж байсан Монголын баруун болон өмнөд нутгаар байр суурьтай байв.

XVI-XVII зууны үеэс харийн түрэмгийллийг сэрэмжилж, тархай бутархай байдлаа гэтлэн давж, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхийн чухлыг Монголын алсын хараатай улс төрийн зарим зүтгэлтэн ухамсарлан мэдэрч, энэ үйл хэрэгтээ шинэ тутам дэлгэрч байсан бурханы шашныг ашиглахыг хичээж, нийгмийн хөгжлийн болон хүн ардын оюун санааны эрэлт хэрэгцээг тэр бүр хангаж чадахгүй болсон бөө мөргөлийн оронд түүнийг хоёр ёсны шинэ үзэл баримтлалаар баяжуулан, монгол газар, монгол ахуйд идээшүүлэн авах чиглэлийг баримтлан тэтгэн дэлгэрүүлж байв. Энэ бол Монгол оронд бурханы шашны XVI-XVII зууны үеийн дэлгэрэлтийн нэг гол онцлог болно.

XVI зууны эхэн үед Монголын хан ноёдын дотроос Түвэдтэй харилцаж бурханы, тэр дундаа шарын шашныг ихээр тэтгэн дэлгэрүүлсэн нь баруун гурван түмний Түмэд аймгийн Алтан гэгээн хан Ананда (1502-1582) болой.

Алтан хан (1507-1582), Ордосын Хутагтай сэцэн хунтайж нар 1570-аад оны эхээр шарын шашны 20 гаруй лам нарыг Түвэд орноос нь заримыг Хятадын Мин улсаар дамжуулан залан авчирч, хүмүүст бурханы шашны сургаал номлолын утга учрыг тайлбарлан таниулж, ухуулан сэнхрүүлэх үйлийг хийж байжээ.

Алтан хан Түвэдийн шарын шашны тэргүүн Содномжамц (1543-1589) хутагтыг 1578 оны билгийн тооллын 5 сарын 15-ны өдөр Хөхнуурын Цавчаал хэмээх газар

Тэгчинчойнхорлин хийдэд ёслол төгөлдөр угтан уулзалт хийжээ. Тэрхүү уулзалт дээр төр шашныг хослон явуулахын үүднээс Хубилай хааны үеийн "Арван буянт номын цагаан түүх" лүгээ тохируулсан хууль цааз хэлэлцэн баталсан нь Монголд бурханы шашныг албан ёсоор хүлээн зөвшөөрч, тэтгэн дэлгэрүүлэхийн хууль эрхийн үндэс болж өгчээ.

Чингэж тэр цагийн Монголын улс төрийн хамгийн нөлөө бүхий зүтгэлтэн Түмэдийн Алтан хан, Түвэдийн III далай лам Содномжамц нар харилцаа холбоо тогтоосон нь Монгол оронд бурханы тэр дундаа шарын шашин хүчтэй дэлгэрэх нөхцөлийг бүрэлдүүлж, Түмэн засагт хаан, Халхын Автай сайн хан, Ойрадын Байбагас хан зэрэг томоохон ноёд бурханы шашинд зэрэг зэрэг орж, өөр өөрийн нутагтаа тэтгэн дэлгэрүүлж эхлэжээ.

Түмэн засагт хаан (1558-1593) монголчуудын дотоод эв нэгдлийг сэргээн бэхжүүлж, улс орноо өөд татахын тулд Түвэдтэй шашин төрийн эвсэл холбоо байгуулах замаар бурханы шашныг тэтгэн дэлгэрүүлэх ажлыг хийж байв.

III далай лам Содномжамц жанч халж, түүний хойт дүрийг Түмэдийн Алтан ханы ач Сүмэр хун тайжийн Бааханзул хэмээх хатнаас мэндэлсэн хөвгүүнээр тодруулан залсан явдал бол XVII зууны эхэн үеийн Монголын бурханы шашны түүхэнд мөнхөрсөн сонин үйл явдал юм. IV далай лам Ендонжамц (1589-1616)-ыг Монголоос тодруулан залсан нь Монгол-Түвэдийн шашин соёлын харилцаа өргөжиж,монголчуудын дунд бурханы шашныг дэлгэрүүлэх үйл хэрэгт чухал нөлөө үзүүлсэн байна.

1604 онд хаан суусан Лигдэн(1598-1634) хутагт хаан Авга хар ууланд Цагаан балгас, Цагаан суварга байгуулан, төр шашны томхон төв болгож, Алтан ханы үеэс монголоор орчуулж эхэлсэн бурханы шашны хөлгөн их судар 108 боть ганжуурыг шинээр орчуулгаж, алтаар бүтээлгэх зэргээр шашин номын их үйл хэргийг өрнүүлж байсан билээ.

Халхын Автай сайн хан (1554-1588) түвэд лам багш нарыг залж ном сонсож, бацаг санваар сахин, өөрөө биеэр үлгэрлэн Халхад шашин дэлгэрүүлж эхэлжээ.

Лигдэн хутагт хаан
(Зураач Т.Мандир)

Автай сайн хан Түмэд, Ордос, Цахарын хан ноёдын нэгэн адил "гурван шүтээнийг бүтээх"-ийн тулд Зуу эрдэнийн сүм барих, Зуу шагимунийн гүсэг дүрийг бүтээх, бурханы ном зохиолыг орчуулгах гурван их үйлийг зэрэгцүүлэн хийж байжээ. Тэрбээр Эрдэнэзууг 1585-1587 оны хооронд байгуулаад, Түвэдээс шагжийн үндэсний Лодойнинбо хэмээх ламыг илгээснийг Зуугийн сүмд залж ирээд, номхотгох нэрт гал эм тахиа жил (1587)-д тэр лам равнай үйлдэхийн сацуу Батэрдэнэ зуу хэмээх нэр өргөжээ. Тэр үеэс Эрдэнэзуу хийд Халх Монголын улс төр, шашин, соёл, эдийн засгийн гол төв болж, сүсэгтэн монголчуудын эргэл мөргөлийн орон болж асан бөлгөө.

XVII зууны эхэн үе гэхэд Монгол оронд хүчтэй дэлгэрсэн бурханы шашин үзэл номлол, дэг жаяг, бүтэц зохион байгуулалтын талаар цэгцрэн, монгол түмний оюун санааны гол үндэс суртахуун болгох үйл хэрэгт Ойрадын Зая бандида Намхайжамц (1599-1662), Ламын гэгээн Лувсанданзанжанцан (1639-1703), Зая бандида Лувсанпэрэнлэй (1642-1715), Дарба бандида Содовжамц (1637-1702), Дөрвөдийн жидшод гэгээн Лувсанданзан-пэрэнлэй (1627-1672), Жалханзын хувилгаан Лувсанданзанжамц (1634-1654), Торгуудын Нэйж тойн

Автай сайн хан

Авид (1557-1653) зэрэг эрдэмт лам хутагт хувилгаад чухал үүрэгтэй байлаа. Монгол хутагт лам нарын ихэнх нь Амдо болоод Түвэдийн орноо одож, Далай лам болон Банчин-Эрдэнэ зэрэг эрдэмт лам нараар шашны номлол их бага таван ухааныг заалган гэгээрч, нутагтаа бурханы шашныг дэлгэрүүлэх, хүрээ хийд, сургууль дацан байгуулах, ном зохиол туурвих зэрэг үйлийг нэгэн зэрэг хийж байжээ.

Эрдэнэ зуу хийдийн суварга

Эрдэнэ зуу хийд дэх бурхад

Төвхөн хийдийн анхны сум 1654 онд баригджээ.

Шашны зан үйлээс хийж буй байдал

Өндөр гэгээн Занабазарын хөрөг
(ЧЛСМ)

Монголын бурханы шашны тэргүүн нь Богд Жибзундамба хутагт байсан бөгөөд бүгд найман Богд тодорсноос Өндөр гэгээн Занабазар, II Богд Лувсандамбийдонмэ (1724-1757) нар монгол, бусад хутагт нар нь түвэд үндэстнүүд байв.

II Жибзундамба хутагт
(МДУМ)

"Цагаан Дэмчиг"
(Занабазар)

"Майдар"
(Занабазар)

Өндөр гэгээн Занабазар бол 1686 онд "Соёмбо-зояди" буюу өөрөө гийсэн гэгээ хэмээх энэтхэг, түвэд, монгол хэлийг тэмдэглэж чадахуйц авианы нэгэн зүйл монгол шинэ үсгийг бүтээн, Очирдара, Майдар, Дара эх, Язгуурын таван бурхан, бурханы найман мөнгөн суварга тэргүүтэн бурхадын гайхамшигт цутгуураа хийж Их жанрайсиг тэргүүтэн өөрөө гарсан тавыг цагаан зандангаар бүтээж, "Цагийг тохинуулагч залбирал" буюу "Жанлавцогзолма", гүн ухаан онолын гол цөм болсон "Маанийг бүтээх гүн арга" зэрэг олон бүтээл туурвиж, бурханы шашны зан үйл, уншлагын ая данг монгол газар, нүүдэлчдийн ахуй ёс, зан заншил, сэтгэлгээнд хөгжүүлэн идээшүүлж уламжлуулсан шашин соёлын гарамгай зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч бөлгөө.

"Дара-Эх"
(Занабазар)

Өндөр гэгээн Занабазарын дугана
(Чойжинламын сүм музей)

VIII Богд Живзундамба хутагт

Цамын ёслол
(1937 он)

Цамын бужиг
(1937 оноос өмнө)

Монгол орон Манжийн эрхшээлд орсны дараагаар монгол нутаг дахь шашин сүм хийдийн бодлого цэгцтэй нэлээд төвлөрсөн голдирлоор явах болжээ.Манжийн төрөөс Монголыг баримтлан захирах талаар удаа дараа гаргасан хууль цаазын бичгүүдэд Монголын шарын шашин, том хутагт хувилгаад хийгээд сүм хийд, лам нар, шавь ардын эрхзүйн харилцааг зохицуулж баталгаажуулсан байдаг.

Майдар эргэх ёслол

Дамдин Чойжоо
(Дүрслэх урлагийн музей)

Шанага малгайт
(Дүрслэх урлагийн музей)

Монголд Живзундамба хутагтаас гадна олон хутагт хувилгаад байсан бөгөөд тэд угсаа гарал, эрдэм боловсрол, билиг авъяас, эрх ямба, үүрэг хариуцлага,

Майдар эргэх ёслол
(1937 оноос өмнө)

Майдар эргэх ёслолын
морины толгой

Майдар эргэх ёслолын тэрэг
(МДУМ)

нийгэмд эзлэх байр суурь, нөлөөгөөрөө харилцан адилгүй юм. Томоохон хутагтуудыг тамгатай, тамгагүй гэж хоёр ангилж, Их Журганаас 800-аас дээш шавь захирч, хошууны тамгын газраас 500 газраас алс бөглүү нутагшин буй хутагтад зохих журмын дагуу тусгай газар нутаг эзэмших эрх бүхий мөнгөн тамга, цол ямба тухайлан хүртээдэг. Тэдгээрийг тамгатай хутагт гэнэ. XX зууны эхэн гэхэд Ар Монголд Богдын Их шавийн 7, Сэцэн хан, Засагт хан, Сайн ноён хан аймагт бүгд 13 тамгатай хутагт байжээ.



Засаг захиргааны хуваарь, олон хутагтын шавийг О.Пүрэвийнхээр авав.

Ер нь 1900 оноос өмнө Монголд нийт 243 гэгээн хувилгаан байсны 147 нь Өвөр Монголд, 35 нь Хөхнуурт байсан гэсэн судалгаа ч байдаг.

XIX зууны сүүлч гэхэд Монголын лам нарын тоо нийт эрэгтэйчүүдийн гуравны нэгийг эзлэх болсон бөгөөд зөвхөн Ар Монголд 100 мянга гаруй лам байжээ. Лам нарын тоо гэнэт өссөнийг ганц мухар сүсгээр нь бус, бас XIX зууны түүхэн цаг үеийн нийгэм улс төр, эдийн засгийн байдал, аж ахуйгаа арай чөлөөтэй, ашигтай байдлаар эрхлэн хөтлөх гэсэн сэтгэлгээтэй нь холбон тайлбарлавал зохино. Лам нарын энэхүү механик өсөлтийн нөгөө талд сүм хийд, хурал номын газрын олшролт байв. Хошуудад сүм хийд байгуулахыг зөвшөөрч, нэр шагнан олгох болсон нь сүм хийд олшрох нөхцөлийг бүрдүүлж байв. Ар Монголд 940 гаруй, Өвөр Монголд 1800 гаруй сүм хийд хурал номын газар, 150 мянга орчим лам байжээ.

Бурханы шашны анхны хийд Эрдэнэзууг байгуулснаас хойш олон тооны хүрээ хийд буй болсон нь нүүдэлчдийн хот суурины түүхэнд гарсан шинэ үзэгдэл байв.

Амарбаясгалант хийд



Манжийн хаадын шууд оролцоо, идэвхитэй дэмжлэгтэйгээр бурханы шашны ном судрыг монгол хэлнээ орчуулах, хэвлүүлэн тараах, шашны сургууль байгуулж, Энх-Амгалан хаан (1662-1723), Лигдэн хааны үед орчуулагдсан бурханы шашны хөлгөн их судар Ганжуурыг 1718-1726 оны хооронд дахин монголчлон хэвлэх зарлиг гаргаж, Тэнгэрийн тэтгэсэн хаан (1736-1796) Ганжуурын тайлбар, Данжуурын 225 боть зохиолыг 1742-1749 онд монгол хэлээр орчуулж, түүний бэлтгэл ажил болгож, их бага таван ухааны түвэд-монгол нэр томъёоны жигдэлсэн "Мэргэд гарахын орон" толь бичгийг зохиосон нь өдгөө ч үнэ цэнэтэй байна.

Энх-Амгалан хаан, Найралт төв хаан (1723-1736), Тэнгэрийг тэтгэсэн хаадын үед нийт 230 гаруй боть ном судрыг түвэд хэлнээс монгол хэлнээ орчуулан Бээжинд модон бараар хэвлэн, Монголын хүрээ хийдүүдэд түгээсний ихэнх нь өдгөө уламжлагдан иржээ.

Шашны дээд сургууль (Гандантэгчилэн хийд)

Бэрээвэн хийд

Нийслэл Хүрээ, Улиастай, Ховд хотод манж, монгол бичгийн түр сургуульд цөөн тоогоор хүүхэд сургаж байсны дээр 1739 онд Бээжингийн Найралт найрамдахуйн ордонд шарын шашны сургууль сүм хийд байгуулж, монголоос 500 залуу лам нарыг сургаж байжээ.

Бурханы шашин зөвхөн Монголын төв хэсгээр зогсохгүй нийт Монгол туургатны дунд өргөн дэлгэрсэн юм. Жишээлэхэд, Байгалийн урд талын буриад аймгуудын дунд XVII зууны эхний хагас гэхэд бурханы шашин хэдийнээ дэлгэрсэн байжээ. Энэ цагт буриадууд нийт Монголын соёлын ертөнцийн тойрогт багтаж байсан бөгөөд монголын ард түмнээс тусгаарлаж биеэ даагаагүй, өөрсдийгөө ч туурга тусдаа гэж үздэггүй, түүх, шашны хувьд байнгын холбоотой байсан нь Монголын түүх, Буриадын он дараалын бичгүүдийн аль алинд нь туссан байдаг. Орчин үеийн буриадуудын нутаглан буй нутаг дэвсгэрт XVII зууны эхний хагасаас эхлэн Сэлэнгийн буриад, Нерчинскийн хамниган нарын дунд нүүн ирж нутаглах болсон зарим монгол аймгуудын угсаатны бүлгүүд бурханы шашныг анх оруулж ирсэн

Лхам бурхан
(ЧЛСМ)

гэдэг. Тэдэнтэй хамт нүүдлийн гэр-дуган, бурханы шашны лам нар хүрэлцэн ирснээр буриадын угсаатны бүлгүүдийн дунд бурханы шашин алгуур дэлгэрч эхэлсэн байна. Хаант Оросын зүгээс Орос-Хятадын (Монголын) хооронд хил тогтоож, буриадуудыг гадаад ертөнцөөс тусгаарлаж, хязгаарлахыг оролдож байсан боловч буриадууд монголчуудтай болон бурханы шашны ертөнцтэй байнгын харилцааг тогтоож чадаж байв. 1741 онд бурханы шашныг Орос гүрний албан ёсны шашны нэг хэмээн хүлээн зөвшөөрчээ. Хори буриадуудын дунд XVIII зууны дунд үед, Тункинскийн ба Аларын буриадуудын дунд XIX зууны үед л бурханы шашин дэлгэрч эхэлжээ. Ингэснээр XX зууны эхэнд буриадад 44 сүм, хийд дацанд ойролцоогоор 15 мянган лам сууж байсан ба үүнд хувраг банди, шавь нарыг оролцуулаагүй байдаг.

Дацан

Бурханы шашин буриадын соёлын хөгжилд гүнзгий нөлөөлсөн юм. Бурханы шашны тусламжтайгаар шашны уран барилга, бүтээн байгуулалт, бичиг үсгийн хөгжил, төвд монгол хэл дээр ном зохиол хэвлэх, дацан сургууль байгуулах зэрэг соёлын талууд эрчимтэй хөгжих болсон хийгээд шашны зан үйл, бурханы шашны арван эрдэм зэргийг гүнзгий судлах болжээ. Мөн бурханы шашны эрдэмтэн орчуулагчид, тайлбарлагчид, зураачид, уран барималч зэрэг жинхэнэ шашны өндөр боловсролтой хүмүүс төрөн гарах болов. Бурханы шашны мэргэжлийн болон хавсарсан

урлагийнхан, уран барилгачид, гар урлалын дархчууд ч бий болсон байна. Басхүү алдартай буриад эрдэмтэн лам нарын төлөөлөгчид төрөн гарчээ.

XX зууны 90-ээд оноос Буриадад бурханы шашин сэргэн мандах үйл явц эхэлсэн юм. Өнөө үед ОХУ-д 160 орчим буддын шашны байгууллага, эвлэл холбоо бүртгэлтэй ба нийт буриадын нутагт 40 орчим бурханы шашны сүм дацан үйл ажиллагаа явуулж байна.

Ар Монголд Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж, 1911 оны 12 сарын 28-нд VIII Живзундамба (1869-1924) хутагтыг Монгол улсын Олноо өргөгдсөн, наран гэрэлт түмэн наст богд хаанаар өргөмжилсөн билээ. Ийнхүү Монголын төр ёсны хоёр мянга шахам жилийн түүхнээ анх удаа бурханы шашны тэргүүн Богд Живзундамба Агваанлувсанчойжинямданзанванчуг хэмээх түвэд хутагт Монгол улсын хаан ширээнд өргөмжлөгдсөн юм.

Монголын хаад ноёд бурханы шашныг эрт дээр үеэс тэтгэн дэлгэрүүлэхдээ түүнийг гагц мухар сүсгээр бус, нүүдлийн соёл иргэншлийн түүхэн хөгжлийн жам хуулиар болон Дундад ба Төв Азийн улс түмэнтэй улс төр, эдийн засаг, соёл иргэншлийн харилцаандаа нээж таньсан оюун санааны ертөнц мөн бөлгөө. Бурханы шашин эртний Энэтхэгээс үүдэн хөгжиж, улмаар цаст Түвэдийн мэргэдээр тэтгэгдэн хээр талын нүүдэлчин түмний хүртээл болон ундран тэлэхдээ монгол газар, монгол ахуй, монгол ёс заншил, сэтгэлгээ, ухамсрын түвшинд сэлгэн хөллөж, нүүдлийн соёл иргэншлийн өвөрмөц онцлогоор сэлбэн баяжигдаад монгол буддизм болон төлөвшсөн юм. XIX-XX зууны эхээр бурханы шашны эрдэм оюуны гол төв нь Цаст Түвэдээс Монгол оронд шилжсэн бөгөөд улс түмний эрдэм соёлын алтан хэлхээ алдардаггүйн жамаар Монголын эрдэм соёлын суварган гүүр эргээд Дорно дахины, тэр дундаа эх ундаргаа авсан Энэтхэгийн болоод Түвэдийн ард түмний соёл иргэншилд эргэн нөлөөлж хөгжин дэвшсээр байна.

1930-аад оны сүүлчээр тухайн цагийн улс төрийн нөхцөл байдлын эрхээр Монгол дахь бурхан шашны сүм хийдүүд устгагдаж, лам хувраудын нэлээд хэсэг нь улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн юм.

Агийн дацангийн гол сүм

1980-аад оны сүүлчээс уламжлалт шашин шүтлэг, ёс заншлаа сэргээх хандлага буй болж, Монгол улсын Шинэ үндсэн хуулиар иргэдийн шүтэн бишрэх эрх чөлөөтэй болсноор эдүгээ судлаачдын гаргаснаар Монгол улсад буддын шашны 120 гаруй сүм хийд, хурал номын газар нээгдэн ажиллах болж, лам хуврагын тоо 3000 гаруйд хүрч, сүсэгтний тоо эрс өсч байна.

Д.Дашбадрах
С.Уранбилэг
Э.Амарбилиг





БҮЛЭГ VIII

- БИЧИГ ҮСЭГ, ХЭЛ АЯЛГУУ
- АМАН ЗОХИОЛ
- ХУУЧНЫ УРАН ЗОХИОЛ
- ОРЧИН ҮЕИЙН УРАН ЗОХИОЛ

БИЧИГ ҮСЭГ, ХЭЛ АЯЛГУУ

Монгол бичиг. Түүхэн сурвалжийн мэдээгээр шалгуур хийж үзвэл Чингис хаан Найман аймгийг байлдан дарах (1204) үеэр Таян хааны бичгийн түшмэл Тататунгааг тамганых нь хамтаар олзлон авч тамганы учрыг мэдээд (уйгаржин) монгол бичгийг ноёд түшмэддээ заан сургаснаар анх Монголын эзэнт гүрний төрийн албан бичиг болгосон гэж үздэг.

Гэвч (уйгаржин) монгол бичгийн хэл нь тухайн үеийн монгол хэлний дорнод, өмнөд, өрнөд зэрэг бичгийн дурсгал болон бидний үед уламжлан ирсэн гол аялгуунуудын алинтай нь ч адилгүй байна. Мөн сүүлийн үед эрдэм шинжилгээний эргэлтэнд орсон хятан хэлний баримт сэлтээс үзвэл уг хэл нь монгол бичгийн хэлнээс дундад үеийн монгол хэлэнд илүү ойр, хуучин байдлыг хадгалсан дагуур хэл, дөрвөлжин бичгийн хэлтэй төстэй байдаг байна. Энэ мэт монгол хэлний түүхэн баримт хэрэглэгдэхүүнтэй (уйгаржин) монгол бичгийн хэлний хэрэглэдэхүүнтэй харьцуулаад уг бичгийг Хятан гүрний үеэс бүр өмнө, магадгүй VII-VIII зууны үед уйгараас биш, тухайн үед Төв Азийн соёлжилтод гүнзгий нөлөө үзүүлж байсан Согдоос уйгар монгол хоёр ойролцоо үед авсан гэж таамагладаг болсон байна.

(Уйгаржин) монгол бичгээр бичсэн, одоогоор бидэнд мэдэгдээд байгаа хамгийн эртний дурсгал нь "Чингисийн чулууны бичиг" хэмээн алдаршсан, угтаа бол Есүнхэ мэргэн 335 алд газар харван байг оносон дурсгалд зориулан босгосон гэрэлт хөшөөний таван мөр бичээс байгаа.

"Чингисийн чулууны бичиг"-ийн хэсэг

Мөн зарим эрдэмтэд "Монголын нууц товчоо"-ны эхийг (уйгаржин) монгол бичгээр байсан гэж үздэг бөгөөд тухайн үед хэрэглэгдэж байсан уг бичгийн хэлбэр, үсгийн бүрэлдэхүүн зэргийг илтгэн тодорхой харуулсан дурсгал бол Гүюг хааны тамгын бичээс болно.

(Уйгаржин) монгол бичгээр бичсэн одоогоор олдоод байгаа дурсгалаас өнөөдрийг хүртэл хэрэглэгдэж байгаа үсгийн бичлэг, зурлагын хэлбэр дүрсийг гол болгон хоёр үндсэн үед хуваан үздэг байна. Үүнд:

а. Дундад эртний үеийн бичлэг: Энэ үе нь ерөнхийдөө (уйгаржин) монгол бичгийг авч хэрэглэсэн үеэс XVI зуун хүртэл үргэлжилсэн. Энэ үеийн бичлэг, үеийн журам нь уйгар, монгол бичиг үсгийн хэлбэртэй нэлээд төстэй.

б. Шинэ үеийн бичлэг: XVI зууны үеэс өнөөдрийн бидний үед хэрэглэсээр байгаа бичгийн хэлбэр.

Монгол бичгийн үсгийн махбод:
а. Үсгийн махбод
б. Үсгийн нэмэлт тэмдгийн зүйл
в. Цэг тэмдгийн зүйл

Дөрвөлжин бичиг. Олон хэлний улс түмнийг төрийн нэгэн жолоонд оруулж Их Юань гүрнийг байгуулах үест нэг талаас (уйгаржин) монгол бичиг аман ярианыхаа хэлнээс ихээхэн зөрүүтэй болж, нөгөө талаас шинэ тулгар байгуулагдсан Их Юань гүрний бичиг соёлын хэрэгцээг хангах гэсэн хоёр зорилгыг гүйцэлдүүлэх үүднээс Хубилай хаан (1215-1294) төвдийн эрдэмтэн Пагва хэмээгч Лодойжалцанг (1235-1280) урин залж "улсын багш" цолд өргөмжлөн, монгол хятад, төвэд, самгарди хэлний үсгийг адил тэгш тэмдэглэж чадах "төрийн бичиг" зохиох зарлиг буулгажээ. Энэ зарлиг ёсоор Пагва лам 1260-аад оны орчим "дөрвөлжин бичиг"-ийг зохиосныг 1269 онд их хаан зарлиг гарган нийт улс даяар хэрэглүүлсэн түүхтэй байна.

Дөрвөлжин бичиг нь тухайн үедээ Монголоос гадна Их Юань гүрний бүрэлдэхүүнд багтаж байсан улс үндэстнүүд хэрэглэж байсан учир түүнийг олон улс дундын бичиг гэдэг.

Уг бичиг гаднах төрх байдлаараа төвэд үсгийн хэлбэртэй адил боловч бичих байдал хийгээд ялангуяа эгшиг тэмдэглэсэн махбод зэрэг нь (уйгаржин) монгол бичгийн зарчмыг ашигласан гэж эрдэмтэд үздэг байна.

Төрийн бичиг хэмээн хааны зарлигаар тунхаглагдсан дөрвөлжин бичиг зуу шахам жил буюу Их Юань улсын турш хэрэглэгдэж байсан ба үүнээс хойш үед ч мэр сэр бас хэрэглэж байжээ.

"Дөрвөлжин бичиг"-ээ ийм урт удаан хугацаанд хэрэглэхдээ түүх

Буянт хааны зарлиг

шастир, төр ёс, хууль цаазны ном бичгийг бичсэн байж болох бөгөөд харин бидний үед жар орчим дурсгал уламжлагдан үлджээ.

Академич Д.Төмөртогоо дөрвөлжин үсгээр уламжлагдсан дурсгалуудыг дор дурдсан гурван зүйл болгон авч үзсэн байна. Үүнд:

а. *Хөшөө чулууны бичиг.* Бидний үед уламжлан үлдсэн дөрвөлжин үсгийн дурсгалуудын зонхилох хувь нь үүнд хамаарагдах бөгөөд тэдгээр бичээсийн ихэнх нь Хубилай, Буянт, Есөнтөмөр, Тогоонтөмөр зэрэг хаадын зарлиг байна. Эдгээр зарлигууд нь тогтсон тусгай загвартай байсан учир ихэнх дурсгалуудын зохиомж, үсгийн бүрэлдэхүүн нь ойролцоовтор байна.

б. *Ном бичгийн дурсгал.* Ул бичгээр төр ёс, хууль цаазын холбогдолтой ном бичиг хэвлэн гаргахыг даалгасан хааны зарлиг ёсоор уг төрөлд хамаарагдах олон судар хэвлэгдэн гарч байсан нь маргаангүй болвч олон зуун жилийн нүүдэл суудал, дайн байлдааны улмаас эдгээр дурсгалууд сүйдэн бидний үед арав орчим тасархай хуудас олдоож байна.

в. *Гэрэгэ бичиг.* Монголын их хаад элч зарахдаа зам зуур саад тотгоргүй явуулж байхыг сануулсан үгийг алт мөнгөн эдлэлээр хийсэн гэрэгэ бичиг үйлдэж байсан бөгөөд эдүгээ тийм гэрэгэ хэд хэд олдоод байна.

Монгол дөрвөлжин бичгийн дурсгалууд нь тухайн үеийн нийгэм түүх, хэл соёлыг судлах чухал сурвалж учир гадаад дотоодын олон эрдэмтэд судалсаар байна.

Тод бичиг. Түүхэн сурвалжийн мэдээллээр бол 1617 оноос эхлэн Түвэдэд хорь гаруй жил шавилан сууж "Таван ухаан"-ы номд шамдан суралцсаны учир Равжамба хэмээх цол хүртэн 1638 онд эх нутагтаа залран ирсэн ойрдын Зая бандида Огторгуй далай буюу Намхайжамц (1599-1662) "хулгана жилийн өвөл" буюу 1648 онд (уйгаржин) монгол бичгийг тодорхой болгох зорилгоор тод үсгийг зохиосон байна. Энэ тухайгаа "Үзгийн (үсгийн) найруулга" хэмээх зохиолынхоо төгсгөлийн үгэнд:

"... Омог Монгол улсын хувьтанд хялбар болгохын тулд

Олон адил дүрстэй үсэгнүүдийг

Онц тус бүр ангид хольцол үгүй гийгүүлэн ялгаж

Олохуйяа хялбар монгол үзэг (үсэг) зас хэмээн дурьдсанд..." гэх мэтээр өгүүлсэн байдаг.

Тод үсгээр бичсэн судар

Гэвч тод үсэг зохиох үед монголын нийгэм түүхийн байдал ихэд ээдрээтэй байсан тул Манж Чин улсын байлдан дагуулах бодлогын эсрэг эрх чөлөө тусгаар тогтнолынхоо төлөөх тэмцэл эрчимтэй өрнөж байсантай холбон юуны урьд дөрвөн Ойрдыг улс төрийн тэмцэлд нэгтгэх зорилгоор уул үсгийг зохиосон гэж зарим эрдэмтэд үздэг. Ингэж үзэгсэд нь тод үсгийг ойрдын аялгуунд тулгуурлан зохиосон гэж тайлбарладаг ба зөв бичих зүйг нь гол болгодог билээ. Гэхдээ тод үсэг нь монголын ойрд аялгуу төдийгүй Халимаг, Шинжаан мөн Хөх нуурын монголчуудын дунд дэлгэрсэн юм.



Тод бичигт (уйгаржин) монгол бичигт нэг дүрсээр тэмдэглэж байсан о-у, ө-ү, д-т, ч-ц, ж-з, х-г, к-г(э) зэрэг үсгүүдийг ялган тэмдэглэх болсны гадна урт эгшийг + удааны тэмдгээр, мөн хос эгшгийн нийлбэрээр тэмдэглэжээ.

Тод үсгийн махбод, тэдгээрийг нэрлэж байсан нэр томъёог үзүүлбэл:

а. Үсгийн махбод

б. Үсгийн нэмэлт тэмдэг

в. Цэг тэмдэг

Тод үсэг нь XVII зууны монгол хэлний тодорхой аялгууг бичигт тэмдэглэн үлдээж, мөн уул бичгээр монголын түүх, уран зохиол, бурхан шашны холбогдолтой олон ном зохиол туурвиж энэ хэрээр монголын соёлын түүхэнд чухал хувь нэмэр оруулсан гэж үздэг.

Соёмбо үсэг. Соёмбо үсгийг Анхдугаар богд Живзундамба хутагт буюу олны дунд «Өндөр гэгээн» хэмээн алдаршсан Занабазар (1635-1723) тавин хоёр насандаа Төвхөн хийдэд сууж байхдаа билгийн тооллын гал барс жил буюу аргын тооллын 1686 онд зохиожээ. Энэхүү үсэг нь олон нийтэд төдийлөн түгээмэл дэлгэрээгүй боловч монгол үсэг бичгийн түүхэнд гарсан тэмдэглэлтэй үйл явдлын нэг мөн.

Соёмбо үсгээр хэвлэсэн судар

Соёмбо

Монголын их соён гэгээрүүлэгч Өндөр гэгээн Занабазар 90 үсэг бүхий соёмбо үсгийг зохиохдоо эртний энэтхэгийн умард этгээдэд өргөн дэлгэрсэн ланз үсэгт дулдуйдан зохиосон ажээ. Ул «Соёмбо» хэмээх үгийн уг гарлыг мөшгөн үзвэл «svayambhu» буюу «өөрөө бүтсэн гэгээн үсэг» гэсэн утга бүхий эртний энэтхэгийн судрын хэлнээс гарал үүсэлтэй үг юм. Соёмбо үсгийг улс төр болон шашин номын тусгай зорилгын үүднээс зохиосон гэж судлаачид үздэг. Улс төрийн учир холбогдол нь гэвэл манжийн эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг үндэсний тусгаар тогтнол, өнө мөнхийн бие даасан байдлыг бэлгэдсэн гүн утгатай бол шашин номын учир холбогдол нь тухайн үеийн номын гурван чухал хэл болж байсан монгол, түвэд, самгарди хэлний үгийг бүрэн тэмдэглэж чадахуйц тогтолцоот үсэг болгон зохиох зорилго тавьсанд оршино.

Соёмбо үсгээр бичиж хэвлэсэн ном судар, дурсгалын зүйл нь монголын бусад үсэг бичигтэй харьцуулахад нэн цөөн ажээ. Соёмбо үсэг бол үсгийн урлал, ур чимэглэлийн хувьд онцгой сайн гэдгийг тэмдэглэн хэлбэл зохино. Халхын аман аялгууны амьд жишээ баримтыг тэмдэглэн үлдсэнээрээ үлэмж ач холбогдолтой билээ.



Соёмбо

Вагиндра үсэг. Буриадын Агваан Лхаарамба (1853-1938) ламтан 1905 онд Вагиндра үсгийг буриад аялгуунд зориулан зохиожээ. Агваан хэмээх төвд нэрийг самгарди хэлээр Вагиндра гэдэг байна. Агваан Лхаарамба эл үсгээрээ монгол хэлний хэлзүйн бичиг «Зүрхэн тольт»-ыг 1908 онд Санкт-Петербург хотноо хэвлүүлсэн байна.

Вагиндра үсгийн байдлыг авч үзвэл монгол бичгийн зурлагын үндсэн махбод болсон ацаг, гэдэс, шилбэ тэргүүтэн монгол тэмдэгтийн уламжлалыг өвлөхийн хамт буриад аялгуунд нийцүүлэн үсгийн журмыг шинэчилж, ойрадын тод үсгээс үлгэрлэн эгшиг үсгийг дүрс ялган сэлбэж, орос, латин зэрэг үсэг лүгээ ижилсгэн үгийн эхэн, дунд, адагт дүрс хувиргахгүй хийгээд төвд үсгийн адил их бага а-гаас бусдыг их, бага үсэг хэмээн ялгахгүй бөгөөд урт эгшиг, тагнайшсан гийгүүлэгчийг манж үсгийн адил дусал, бинт талбин ялгаж, орос үсгийг үсэгчлэн буулгах галиг үсэг нэмсэнээрээ ихээхэн өвөрмөц юм.

«Монгол буриад ном бичиг гаргах орон» хэмээх хэвлэлийн газраас 1906-1910 оны хооронд нэлээн хэдэн ном судрыг чулуун бараар хэвлэн гаргажээ.

Вагиндрагийн бичгийн цагаан толгой

Эгшиг үсэг

1.		a (а)	2.		o (о)
3.		u (у)	4.		i (и)
5.		e (э,е)	6.		ė (ы,е)
7.		ȯ (ө)	8.		u̇ (ү)

Гийгүүлэгч үсэг

9.		b (а)	10.		p (п)
11.		γ (г)	12.		x (х)
13.		g (г)	14.		k (к,х)
15.		t (т)	16.		d (д)
17.		z (з)	18.		ž (ж)
19.		s (с)	20.		š (ш)
21.		c (ц)	22.		č (ч)
23.		m (м)	24.		m (н)
25.		n (н)	26.		n (л)
27.		r (р)	28.		r (h)
29.		y (i)	30.		y (в)
31.		f (ф)	32.		f (у)
33.		j (ڊ,дж)	34.		j (дз)
35.		sc (щ)	36.		sc (нь)

Үсгийн нэмэлт тэмдэг

37.	тагнайшсны тэмдэг/бинт
38.	эгшгийн уртын тэмдэг
39	цэг (6,13,14,24,33,34,35-р үсэгт орно.)
40.	дэгээ (3,30,31-р үсэгт орно.)

Цэг тэмдэгтийн зүйл

41.	хуудас эхлэсний тэмдэг/бярга
42.	таслал
43.	цэг
44.	асуултын тэмдэг
45	анхааруулгын тэмдэг
46.	зураас
47.	цуваа цэг

МАХН-ын Төв хороо ба Сайд нарын Зөвлөлийн хамтарсан 17/13 дугаар хурлын тогтоолд «Латин үсгийн комиссоос төлөвлөн ирүүлсэн хорин есөн үсэг нь манай дууг тэмдэглэхэд хүрэлцэх ба тохирох тул хэвээр баталсугай» хэмээсэн байна. Хамгийн сонирхолтой нь гэвэл үүний дараа 1941 оны III сарын 25-ны өдөр хуралдсан МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчид ба Сайд нарын Зөвлөлийн хамтарсан 22/28 дугаар хурлаас гаргасан «Монголын шинэ үсгийг тогтоох тухай» тогтоолд заахдаа «монгол үсгийг латинчлахад мөнхүү латин үсэгт монгол хэлэнд хэрэглэгдэх тэмдэг дутагдалтай ба мөн хэвлэлийн талаар дутагдах зэрэг техникийн



Вагиндра үсгээр бичсэн номын хуудас

Латин үсэг. Монгол улсад 1930-1940-өөд оны үед латин үсгийг түр зуурхан хэрэглэж байсан ажээ. 1941 оны II сарын 21-ний өдөр хуралдсан

бэрхшээл тохиолдож байна» гэж онцлон тэмдэглээд, ганцхан сарын өмнөх тогтоолыг хүчингүй болгосон түүхтэй билээ.

Ардыг гэгээрүүлэх яамны дэргэд байгуулагдсан «латин монгол үсгийн зөвлөл»-ийн гаргасан латин үсгээр монгол хэлний авиаг тэмдэглэх цагаан толгой нь 29 үсэгтэй юм. Энэхүү латин үсгийн цэг цэглэлийн хэрэглээ нь одоогийн хэрэглэж буй кирилл үсгийнхтэй үндсэндээ адилхан байжээ.

Латин цагаан толгой

Шинэ латин үсэг	Тохирох кирилл үсэг	Шинэ латин үсэг	Тохирох кирилл үсэг
A a	А а	Oo	О о
B b	Б б	Öö	Ө ө
C c	Ц ц	P p	П п
Ç ç	Ч ч	Q q	(кю)
D d	Д д	R r	Р р
E e	Э э	S s	С с
F f	Ф ф	Ş ş	Ш ш
G g	Г г	T t	Т т
H h	(Н h)	U u	У у
I i	И и	Y y	Ү ү
J j	Й й	V v	В в
K k	Х х	W w	(давхар В)
L l	Л л	X x	(кс)
M m	М м	Z z	З з
N n	Н н	Z z	Ж ж

MINII NUTUG

Xentei xangai sayaanii öndör saixan nuruunuud,
Xoito zügiin chimeg bolson oi , xöbchi uulnuud
Menen sharga nominii örgön yexe gobinuud.
Ömönö zügiin manlai bolson elesen manxan, dalainuud,
Ene bol minii törsön nutug, mongoliin saixan oron
Xerlen , Onon tuuliin tungalag ariuun mörönüüd,
Xotolo olonii em bolson gorxo bulag rashiaanuud,
Xöbsögöl , obso boiriin gün cenxer nuuruud,
Xun maliin unda bolson toirom büridu usanuud,
Ene bol minii törsön nutug ,
mongoliin saixan oron.

Д.Нацагдоржийн "Миний нутаг" шүлэг (Латин үсгээр бичигдсэн байдал)

Кирилл үсэг. Кирилл үсгийг анх IX зууны үед Кирилл (826-869), Мефодий (820-885) хэмээгч ах дүү хоёр хүн үндэслэн зохиосон түүхтэй ажээ.

«Орос үсэг дээр үндэслэсэн монгол шинэ үсэг батлах тухай » Ардын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1941 оны V сарын 9-ний өдрийн хамтарсан 25/27 дугаар тогтоолд заахдаа «орос үсгээр үндэслэж монгол үсгийг бүгд 35 үсгээр баталсугай» гэжээ. Орос үсгийн 33 үсэг дээр монгол хэлний авиа зүйн онцлогийг тэмдэглэхэд зайлшгүй шаардлагатай ө, ү үсгийг нэмж зохиосон байна. Энэхүү кирилл үсгийг зарим судлаачид «оросжин шинэ бичиг» хэмээсэн нь буй. Академич Ш.Лувсанвандан (1910-1983) профессор 1965 онд хэвлүүлсэн «Кирилл үсэг авсны учир» хэмээх эрдэм шинжилгээний өгүүлэлдээ «Латин үсгийн тоо нь хэтэрхий цөөн тул монгол хэлэнд авч хэрэглэхэд нэмэлт үсэг олон хэрэгтэй болох; бас соёл элдийн засаг, улс төрийн талаар хамгийн гүн холбоотой орос үндэстэн нь латин үсэг хэрэглээгүй кирилл үсэгтэй, мөн дундад Ази ба Сибирийн олон үндэстэн сүүлдээ дээрх шалтгаанаар латин үсгээ орхиж кирилл үсэгт шилжин орсон, мөн бидний ах дүү болох буриад, халимагууд бас кирилл үсэгт шилжин орсон зэрэг шалтгаанаас манай Монголд эцэстээ хуучин монгол үсгээ кирилл үсгээр солихоор шийдсэн билээ» гэсэн байдгийг дурдалтай.

Шинэ үсгийн анхны дүрмийг 1942 онд академич Ц.Дамдинсүрэн (1908-1986) зохион гаргажээ. Ийнхүү монгол оронд бичиг үсэг үл мэдэх явдлыг устгаж, бичиг үсэг дэлгэрүүлэх үйл хэрэгт амжилт гаргасны учир 1970 онд ЮНЕСКО өндөр үнэлж, нэрт сурган хүмүүжүүлэгч Н.К.Крупскаягийн нэрэмжит шагналаар ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнг хөхүүлэн шагнасан байна.

Кирилл үсгийн цагаан толгой

А а	Б б	В в	Г г	Д д
Е е	Ё ё	Ж ж	З з	И и
Й й	К к	Л л	М м	Н н
О о	Ө ө	П п	Р р	С с
Т т	У у	Ү ү	Ф ф	Х х
Ц ц	Ч ч	Ш ш	Щ щ	ъ
ы	ь	Э э	Ю ю	Я я

Монгол хэл, аялгуу

Дэлхийн бөмбөрцөг дээр байгаа олон хэлнүүдийг гарал үүсэл нэгтэй эсэхээр нь шалгуур хийж бүлэглэн ангилдаг эрдэмтдийн саналаар бол монгол хэл нь манж-түнгүс, түрэг (жич: зарим эрдэмтэд солонгос, япон хэлийг оруулдаг) хэлтэй нэг гаралтай, өөрөөр хэлбэл эдгээр хэлнүүд нь эрт дээр цагт нэгэн өвөг хэлнээс салбарлан гарсан гэж үздэг бөгөөд уул хэлнүүдийг нэгдмэл байсан тэр хэлийг нь Алтай хэл гэж болзмолоор нэрлэдэг байна. Алтай хэлтнүүд хэдий үед хаагуур нутаглаж байсан талаар эрдэмтдийн санал харилцан зөрүүтэй байдаг ч Алтайн нурууны орчмоос Хянганы уулс, Байгал нуур орчмоос Хятадын Их цагаан хэрэм хүртэлх өргөн уудам нутагт байсан гэдэг талаар судлаачдын олонхи нь санал нэгдэж байна.

Монгол хэл нь Алтай хэлнээс салбарлан, авиазүй, үгзүй, өгүүлбэрзүй, үгсийн сангийн талаар бие даан хөгжиж ирсэн боловч хэдийд алтай хэлнээс салбарлан гарав гэдгийг ойролцоогоор тогтоох ямар ч боломжгүй гэж үздэг.

Төв Азийн нүүдэлчид дундаас МЭӨ II зууны үеэс түүхийн тавцнаа товойн гарч ирсэн Хүннүчүүдийн угсаа гарал, хэл соёлын хамаарлыг нь одоо болтол тогтоож чадахгүй байна. Тухайлбал Хүннүчүүдийн хэлийг зарим эрдэмтэд түрэг хэлний бүлэгт багтааж, нөгөө хэсэг нь монгол хэлний бүлэгт хамааруулан үздэг байна. Уг асуудлаар эрдэмтдийн санал ийнхүү зөрүүтэй байсан авч энэ үед түрэг, монгол, манж-түнгүс хэлнүүд нь тус тусдаа бие даасан хэл болсон байсан гэж үздэг билээ.

Монгол хэл нь Алтай хэлнээс салбарлан бие даан хөгжиж ирэхдээ тоо болон чанарын хувьд бие биеэсээ ялгаа бүхий хэд хэдэн үе шатуудыг дамжиж ирсэн нь тодорхой юм. Хэлний хөгжлийн тодорхой үе шат нь нэг талаар өмнөх үеийнхээ хөгжлийн үр дүн, нөгөө талаар дараа үеийнхээ хөгжих эх сурвалж болдог учир монгол хэлний талаар бидэнд уламжлан ирсэн түүхэн баримт байхгүй байгаа нөхцөлд төрөл хэлний болон дунд үеийн монгол хэлний баримт хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан байж сая эртний монгол хэлний ерөнхий шинж төрхийг тогтоож ирсэн байна. Энэ үед монгол хэлэнд а, ы, о, у гэсэн эр эгшиг, э, и, ө, ү гэсэн эм эгшиг байснаас гадна бараг бүх гийгүүлэгч эр, эмээрээ ялгарч байв. Орчин цагийн монгол хэлэнд эгшгээр эхэлсэн үгийн өмнө п~ф~х, эгшиг хоорондын к~г~б~в хадгалагдсаар байв. Үйл үг хүйсээр ялгарч тодотгол нь тодотгуулж байгаа үгтэйгээ тоогоор зохицдог байв. Гуравдугаар биеийн төлөөний үг тийн ялгалын бүх хэлбэрээр хувирч байсан гэдэг. Харин энэ үе нь хэдийгээс хэдий хүртэлх үеийг хамрах талаар судлаачид харилцан санал зөрүүтэй байдаг. Тухайлбал нэрт эрдэмтэн Б.Я.Владимирцов монгол бичгийн хэлний суурь болсон тухайн аялгуу хэвшин тогтсон тэр үед эртний монгол хэлийг хамааруулан үздэг бол академич А.Лувсандэндэв утга зохиолын хэлний үүслийг хөгжингүй бичиг үсэгтэй холбон үзэх гэсэн зарчимдаа тулгуурлаад монгол утга зохиолын хэлний хөгжлийн эртний үе нь үл мэдэгдэх цагаас барагцаалбал манай эриний V зуун хүртэл үргэлжилсэн бололтой гэж үздэг.

Түүхэн сурвалжийн мэдээгээр бол эртний монгол хэлээр ярилцагч уулаасаа Сяньби гаралтай Табагачи нар нь манай эриний 425 онд шинэ үсэг мянга гаруйг зохиож хэрэглэж байсан байна. Харин энэ шинэ үсэгт орохоосоо өмнө табагачууд орхоны руни бичиг хэрэглэж байсан гэж үздэг. Тухайлбал, унгарын монголч эрдэмтэн Рона-Таш ийм үзэлтэй байна. Мөн сурвалж бичгийн мэдээ нь табагачи нар ийн бичиг үсэгтэй болсноор нийгэм төрийн хэрэгцээнд үйлчилдэг утга зохиолын хэлтэй байсан төдийгүй, түүгээр бичсэн "Төрийн хэлний жинхэнэ дуу", "Төрийн хэлээр бичсэн эзэн хааны дуу", "Сяньби илгээлт, зарлиг, 1 бүлэг Чжоу улсын эзэн хаан У-дигийн зохиол", "Төрийн хэлний 18 бүлэг ойллого бичиг" зэрэг хэд хэдэн ном уламжлагдан иржээ. Эдгээр түүхэн мэдээнүүд нь үлэмж хөгжсөн утга зохиолын хэлтэй байсныг баталж байгаа хэрэг юм.



Монгол утга зохиолын хэлний түүхэн хөгжлийн хоёрдугаар үе нь барагцаалбал XVI зууны дунд үе хүртэл үргэлжилсэн гэж үздэг бөгөөд энэ нь дотроо хоёр өөр шаттай гэж үздэг. Нэгдүгээр шат нь V-XIV зуун хүртэл үргэлжилсэн байна. Энэ үеийн хэлний гол дурсгал нь "Монголын нууц товчоо", мөн дөрвөлжин үсгийн болон араб үсгээр бичсэн дурсгал зэрэг байна. Мөн хятад галигаар хятан хэлний нэлээд үг бий. Монгол утга зохиолын хэлний хоёрдугаар үеийн хоёрдугаар шат нь XIV-XVII зууны дунд үе хүртэл үргэлжилсэн гэж үздэг. Энэ үеийн монгол хэлний онцлогийг нэлээд нарийн тусгасан тод бичиг, соёмбо үсгийг энэ үед хэрэглэх болсон байна.

Энэ үед монгол, дагуур, монгор, баоань, дунсянь зэрэг хэл тасран гарч халимаг буриад хэлнүүд бие даан хөгжих хандлагатай болсон байна.

Монгол хэлний хөгжлийн хоёрдугаар үед эх хэлнээсээ тасран гарсан эдгээр хэлээр хэлэлцэгч монгол угсаатнууд нь эдүгээ Төв Азийн өргөн уудам нутаг, Европын зарим хэсэг нутагт тархан сууж, зарим нь нүүдэлчин, зарим нь суурьшмал аж байдлыг эрхлэн тэдний заримынх нь хэл үлэмж дээр үеийн байдлыг хадгалж, зарим нь их хөгжсөн зэрэг харилцан адилгүй байна. Одоо бие даасан монгол хэлнүүд нь хаана хаана байдаг, хэр зэрэг олон хүн ярилцдаг талаар товч өгүүлье.

Баоань хэл: Уг хэлээр ярилцагчид БНХАУ-ын Гансу, Цинхай мужаар оршин суудаг бөгөөд нийт хүн ам нь 1990 оны байдлаар 12000 гаруй байна.

Дунсян хэл: -ээр ярилцагчид нь БНХАУ-ын Гансу мужид буй бөгөөд нийт хүн ам нь 1990 оны байдлаар 374000 орчим байна.

Могол хэл: -ээр ярилцагчид нь Афганистаны Херат, Бадактан, Маймана зэрэг мужуудад оршин суудаг бөгөөд хүн амын нийт тоо нь одоо хүртэл тодорхой мэдэгдэхгүй байна.

Монгор: -чууд нь БНХАУ-ын Цинхай, Гансу мушид оршин суудаг бөгөөд нийт хүн ам нь 1990 оны тооллогоор 191000 гаруй байжээ.

Дагуур хэл: -ээр ярилцагчид нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймаг, Хар мөрөн мужийн Хайлар, Чичигар хот, Ноны голын хөндий, Шинжаны Кулжа зэрэг газраар оршин суудаг. Нийт хүн ам нь 1990 оны байдлаар 121000 гаруй болжээ.

Халимаг: -чууд нь XVII зууны эхээр баруун Монголоос өрнө зүг нүүн Ижил мөрний сав газар орчимд суурьшсан ойрд угсаатнууд юм. Халимгуудын зонхилох хувь нь ОХУ-ын Халимагийн өөртөө засах улсад оршин суух бөгөөд бас зарим нь Астрахань, Ростов, Дон, Волгоград мужууд болон Ставрополийн хязгаарын зарим нутагт суудаг. Мөн цөөн тооны халимгууд Киргизийн Иссык-куль нуурын орчимд оршин сууна. Тэднийг "Сарт-хальмаг" гэж нэрлэдэг байна. 1990 оны байдлаар халимаг улсад 174000 орчим хүн халимаг хэлээр ярилцах бөгөөд бусад газар байдаг халимгуудын тоо одоогоор тодорхойгүй байна.

Буриад хэл: -ээр ярилцагчид нь ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад улсад голлон амьдрах бөгөөд 1989 оны байдлаар 490000 орчим хүн ярилцана. Буриадууд нь ОХУ-ын Эрхүү, Чита муж, мөн БНКазак, БНКиргиз, Узбек улс, мөн Монгол, БНХАУ-д амьдардаг.

Монгол буюу Төв монгол хэл: -ээр ярилцагчдын зонхилох хувь нь Монгол улсад амьдрах бөгөөд нийт хүн ам нь 2 500 000 орчим байна.

Монгол утга зохиолын хэлний хөгжлийн гуравдугаар үеийн анхдугаар шат нь XVII зууны дунд үеэс хорьдугаар зууны дөчин хэдэн он хүртэл үргэлжлэв. Энэ үеийн эхэнд орчин цагийн монгол утга зохиолын хэлний хэлзүйн тогтолцоо бүрэлдэн тогтсон гэж үздэг. Уул хэлний гуравдугаар үеийн хоёрдугаар шат нь XX зууны дөчин хэдэн оноос эдүгээ хүртэл үргэлжилж байгаа бөгөөд энэ үеийг үндэсний хэлний үе гэж үздэг.

Үндэсний утга зохиолын хэлний хэлзүйн тогтолцоо нь халхын аялгуунихаас нэлээд ялгаатай байна.

Монгол үндэсний утга зохиолын хэлний үгсийн сангийн бүрэлдэхүүн нь монгол утга зохиолын хэлний үгсийн санг бараг бүхлээр нь хадгалаад үлдээсний дээр, манай орны амьдралд хувьсгалын жилд гарсан их өөрчлөлтүүд орчин үеийн шинжлэх ухаан, техникийн дэвшлийг тусгасан олон шинэ үг хэллэгээр баяжжээ.

Үндэсний утга зохиолын хэл нь аман ба бичгийн хэлний гэсэн хоёр үндсэн хэлбэртэй бөгөөд аман хэл нь олон нутгийн аялгуугаар илэрдэг. Эдүгээ монгол үндэсний утга зохиолын хэлээр ярилцагчид нь өөр хоорондоо их бага янз бүрийн ялгавар бүхий нутгийн аялгуугаар хэлэлцдэг бөгөөд эдгээр нь эртний болон дунд үеийн монголын олон аймгийн суурь дээр гарсан гэж үздэг боловч, нийгэм түүхийн нөхцөл байдалтай уялдан ойрхон байсан аялгуунууд холдох, хол байсан аялгуунууд ойртох зэрэг хувьсал багагүй гарсан байна.

Эдүгээ манай улсад байгаа нутгийн аялгуунууд нь өөр хоорондоо үлэмжхэн ялгаа бүхий халх, буриад, ойрд гэсэн гурван том бүлгээс бүрдэх бөгөөд эдгээр аялгуунууд нь дэд аман аялгуу болон цааш бас задрах боловч өөр хоорондоо нэгдэн шаталсан бүхэл бүтэн тогтолцоо үүсгэж байна.

Халх аялгуу нь авиа зүй, үг зүй, үгийн сангийн хувьд харьцангуйгаар нэлээд нэгдмэл, хамгийн олон хүн ярилцдаг, энэ чанараараа ч бусад аялгуунуудаасаа нэлээд давуу тул орчин цагийн утга зохиолын хэлний суурь болсон юм. Монголын түүх, хэл уран зохиолын сурвалжийн мэдээгээр бол XII зууны үед халх гэдэг тэмдэг үг тэмдэглэгджээ. Уул үгийн гарлыг эрдэмтэд халх, халхавч, хамгаалах гэсэн утгатай гэж үздэг бөгөөд XIII зууны үеэс өвөрмөц аялгуу, ёс заншил, хэв хуультай тодорхой ястан нар болсон байна. Эдүгээ халхын аман аялгуу нь зарим нэг авиа зүйн үгийн сангийн шинжтэй нутгийн аялгууны төдий ялгавар бүхий маш нэгдмэл нэг аялгуугаар хэлэлцдэг онцлогтой байна.

Халхын аман аялгуу, салбар аман аялгууг хуваах талаар эрдэмтдийн санал бодол зөрүүтэй байдаг ба ШУА-ийн Хэл Зохиолын хүрээлэнгээс явуулсан шинжилгээний ангийн хэрэглэгдэхүүн дээр түшиглэн хийсэн өөрийн орны эрдэмтдийн хийсэн ангилал нь:

- Төв халхын аман аялгуу.
- Баруун халхын аман аялгуу
- Зүүн халхын аман аялгуу юм.

Ойрд аялгуу. Үндэсний утга зохиолын хэлний өөр нэг аялгуу нь ойрдын аялгуу юм. Уг аялгуугаар хэлэлцэгчдийн уг удам нь МНТ-нд тэмдэглэгдсэн ойн иргэдээс улбаатай, язгуурын монгол аймагт тооцогддог гэж үздэг. Ойрдууд хожим Зүүн гарын хаант улсын бүрэлдэхүүнд багтаж байх үедээ тод үсэг хэрэглэж байжээ.

Эдүгээ ойрд аялгуу нь дунд үеийн монгол хэлтэй зарим талаар тохирох ба монгол бичгийн хэлэнд ойрхон харин буриад, халх аялгуунаас авиа зүй, хэл зүй, үгсийн сангийн талаар нэлээд зөрүүтэй юм.

Буриад аялгуу. Монгол хэлний буриад аялгуугаар Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр, Алтанбулаг, Шаамар, Дархан сумын нутагт хэсэг бусгаараа суугаа цонгоол, Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумын түнхин, санагын буриад, Булган аймгийн Тэшиг сумын буриад, Дорнод аймгийн Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо, Дашбалбар, Эрээнцавын ага, хорь, хамниган, Гурванзагал, Хөлөнбуйр суманд хэсэг бусгаараа суугаа барга, Хэнтий аймгийн Батширээт сумын Цонгоол, Худир болон Дадал, Норовлин сумын хорь буриадууд ярилцдаг.

Л.Болд
Э.Пүрэвжав

С.Уранбилэг
Э.Амарбилиг

АМАН ЗОХИОЛ

Монголчууд бол аман зохиолын өв уламжлалаар хамгийн баян ард түмний нэг бөгөөд ардын үгийн урлагийн төрөл зүйлийн тогтолцоог XX зуунд бүрэн бүтнээр нь хадгалж XXI зуунд уламжилж ирсэн билээ. Тун саяхан болтол аман зохиолын олон төрөл зүйлийн аж байдлын хэрэгцээ, нийгмийн үүрэг хэвээр байсан бөгөөд одоо ч гэсэн жүжигчний дуураймал байдлаар бус жинхэнэ тууль хайлж буй ардын авьяастныг зөвхөн монголоос л олж болно. Иймд аман зохиол бол монголчуудын оюуны соёлын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд эртний соёлыг танин мэдэх эх сурвалж юм.

Домог үлгэр. Эртний домог үлгэрийн сэтгэхүйн уламжлал үлгэр тууль, домог оньсого, зүйр цэцэн үг, дуу зэрэг аман зохиолын төрөл зүйлсэд хадгалагдан үлдсэн байдаг бөгөөд ялангуяа адгуусан амьтны үлгэрт түүний бүтвэр хэсэг бүр ч их бий.

Домог үлгэрийн сэтгэлгээ нь орчлон ертөнцийн аливаа юмс үзэгдлийн үүсэл гарал, учир зүйг танин мэдэж тайлбарлах гэснээрээ шинжлэх ухааны шинж чанартай, түүнийгээ уран сэтгэмжээр ургуулан бодож хийсвэр ойлголтыг тодорхой уран дүрээр илэрхийлснээрээ урлагийн шинжтэй, овгийн байгууллын үеийн хамт олны заагтгүй нийлэг ухамсар, ертөнцийг үзэх үзлийг тусган илэрхийлж байдгаараа онцлогтой.

Зан үйлийн яруу найраг. Гарал үүслээрээ ардын яруу найргийн хамгийн эртний төрөлд хамаарах бөгөөд овгийн байгууллын үеэс хүмүүсийг зан үйлийн ёслол, баяр наадмын чухал элемент бүтвэрийн үүрэгтэй хэрэглэгдэн тэдгээрийн учир утгыг нэмэн тодчилсоор ирсэн юм. Зан үйл дэг ёсны утгыг нэмэн тодочлох үгийн ид шидээр практик нөлөө үзүүлэх, тухайн зан үйлийн ёслолд оролцогчдын сэтгэлийн өнгө аясыг илэрхийлэх зориулалтаар түүний бүрэлдэхүүн хэсэг болсон шившлэг, хараал, зүхэл, цацал мялаалгын шүлэг, ерөөл, билгийн үг, магтаал тэргүүтнийг нийтэд нь зан үйлийн аман зохиолд хамааруулж болно.

Эдгээрээс эртний хүмүүсийн ид шидэд итгэх (магия) шүтлэгийн хэлбэр болж үүссэн шившлэг нь гарал үүслийн хувьд анхдагч бөгөөд бусад төрөл хэлбэрээ үүсэн төлөвших явцыг нөхцөлдүүлсэн юм.

Монгол шившлэгийг хэн дуртай хүн тохиолдлын ямар ч үед бус харин зайлшгүй шаардлага гарсан үед тодорхой цаг хугацаанд хэлдэг нь түүний практик хэрэглээний зориулалт зохилох шинжтэйг харуулж байна. Шившлэгийг дом шившлэг гэж нэрлэх нь ч бий. Дом гэсэн нь онцгой ид шидтэй гэж үзсэн үйл хөдлөл, эд юмсын нөлөөллийг нэрлэсэн бол шившлэг нь түүнийг хэлэх хүн зорилгоо илэрхийлсэн шүлгийн бүрдлийг ухаанаа төвлөрүүлэн амандаа шивнэн үглэж хэлэх утгыг илэрхийлжээ.

Хараал зүхлийн шүлэг нь урнаар өгүүлэхийн янз бүрийн аргыг сайтар ашигласан цэцэн цэлмэг үг хэллэгтэй байдаг нь үгийн урлагийн нэг төрөл хэлбэр болохын баталгаа мөнийн зэрэгцээ хүний сэтгэл санаанд хэлний яруу хэрэглүүрийн хүчээр нөлөөлөх практик зорилготой холбоотой. Хараал зүхэл хорон утга санааг илэрхийлэхдээ

1. Шууд хараах

Тэргээр эм уу

Тэмээгээр шөл уу

Уутаар эм уу

Ухнаар шөл уу гэх мэтээр өвчин эмгэгт баригдан үгүйрч хоосортлоо эм уу гэсэн санааг илэрхийлэх эсвэл:

2. Далд утгаар ёгтлох

Нар сарыг гэртээ мандуулж

Навч цэцгийг хотондоо дэлгэрүүлж

Явган нууж

Нуцгэн суун жарга хэмээн үгүйрч хоосор гэсэн санааг ёгт дүрслэлээр илэрхийлсэн байна.

Цацал мялаалгын шүлэг нь хөх тэнгэр, хөрст алтан дэлхий, орчны уул ус болон дээдэлсэн адгуус амьтан эд юмсад идээний дээж цай, сүү өргөн тусгай ёслол үйлдсэний хариуд өршөөл энэрлээ үзүүлж аж төрөхийн сайн сайхныг хүсэж гуйсан агуулгатай зан үйлийн шүлэг юм. Цацал мялаалгын шүлэг нь байгаль дэлхийгээс үгийн ид шидийн хүчээр хайр хишиг гуйсан гуйлтын чанартай бөгөөд энэ утгаараа шившлэгийн хөгжил хувьслын явцад үлэмж боловсорсон дэлгэрэнгүй хэлбэр гэж болох юм. Тухайлбал, өглөө үдэш бүр тэнгэр хангайдаа цайны дээжээр цацал өргөхдөө:

Сайн зүгийн минь тэнгэр

Сауул зүгийн минь заяа

Орохын олзыг нээн буулгаж

Гарахын гарзыг хаан боогтун

гэж хэлдэг нь цацал мялаалгын шүлгийн товч хураангуй шинжтэй.

Монголчууд цацлын ёслолыг тэнгэр, уул усанд хандан үйлддэг бол мялаалгыг шинэ гэр байшин барих, шинэ дээл өмсөх, тэрэг, уурга шинээр хийх, малын зэл хөгнө эхлэн татах зэрэг онцгой хүндэтгэлтэй эд юмсад зориулдаг. Иймд цацлын шүлэг, мялаалгын шүлэг гэж хоёр ангилж болох боловч эдгээрийн аль аль нь тухайн зүйлд зан үйл итгэл бишрэлийн үүднээс идээний дээж өргөн хишиг буян гуйсан агуулгаар ижил юм.

Ерөөл. Зан үйлийн шүлгийн том хэлбэрүүд төрөл хэлбэрийн хувьд бие даан төлөвшсөний нэг нь ерөөл юм. Ерөөл нь ард олны аж байдал, ажил хөдөлмөрийн янз бүрийн үзэгдлийг тусган магтаж ирээдүйн нь сайн сайхныг зөгнөн ерөөсөн утгаар зохиогдож иргэний ба олон

нийтийн баяр ёслолын үед хэлдэг зан үйлийн шүлэг юм.

Ерөөл хэлэхэд найрын дууны адил "Зээ" хэмээн эхэлдгээс гадна төгсгөлд нь хэлдэг тогтмол түрлэгийн үг бий. Халхад ерөөл хэлж дуусмагц найранд цугласан олон нийтээр "тэр ерөөл бат сайхан орших болтугай" гэж нийтээр түрэн хэлдэг нь амьдралын сайн сайхныг зөгнөн бэлгэдсэн ерөөлийн үгийг таашаан дэмжиж буйн илрэл юм.

Бэлэг дэмбэрэлийн үг нь ийнхүү ерөөлийн төгсгөлд бүрэлдэхүүн хэсэг болон ордгоос гадна янз бүрийн ёслол, ажил хөдөлмөрийн үйлсэд сайн сайхныг хүссэн сэтгэлийн илэрхийлэл болгон хэлдэг зан үйлийн богино шүлэг юм. Энэ нь гарал үүслийн хувьд янз бүрийн зан үйлийн учир утгыг нэмэн баяжуулдаг мэтээр ойлгож байсан үгийн ид шидэнд итгэх шүтлэгтэй холбоотой бөгөөд энэ шинжээрээ шившлэгтэй төстэй юм.

Магтаал нь анх эхлээд ерөөл билгийн үгийн адил зан үйлийн учир холбогдолтой, үгийн ид шидэд итгэх хандлагатай байв. Тайлга, тахилга зэрэг зан үйлийн тодорхой ёслолын үед магтаалыг ардын авьяастан хамт олны нэрийн өмнөөс нийтийн санаа бодлыг илэрхийлэн ерөөлийн нэг адил айзам хэмнэл бүхий тусгай хөг аялгуунд хэлдэг онцлогтой.

Монгол магтаал нь байгаль нийгмийн амьдралын олон талыг хамарсан баялаг агуулгатай, зан заншил, аж байдал, байгалийн зэрэг өргөн сэдвийг хамардаг. Магтаалыг сэдэв агуулгын талаар нь 1. Зан үйлийн магтаал, 2. Уул усны магтаал, 3. Аж байдлын магтаал гэж гурав ангилдаг.

Уул усны магтаал нь анхны гарал үүслийн хувьд үгийн ид шидийн хүчээр уул усны эзэд, лус савдгийг баясган өршөөл энэрлийг нь гуйсан зориулалттай, уул овоо тахих зан үйлийн учир холбогдолтой байв.

Оньсого нь юмсын төстэй, эсвэл ялгаатай талыг ажиглан мэдсэний үндсэн дээр тухайн зүйлийн нэрийг нуущлан, түүний гол шинж төрх төлөв, үүрэг зэргийг ёгтлон дүрсэлсэн буюу тоочин тодорхойлсон далд утгат уран шүлэг юм. Эрт дээр үеэс эхлэн оньсого таавар нь хүний эргэцүүлэн бодох чадвар, түүний авхаалж самбааны сорилт, оюун ухааныг хөгжүүлэх дасгалын үүргийг гүйцэтгэсээр ирсэн байна.

Оньсого таавар нь хүүхэд залуусын орчин тойрноо танин мэдэх, түргэн зөв сэтгэх чадварыг хөгжүүлэх үлэмжийн ач холбогдолтой юм. Ер нь оньсого таавны дотор юмыг адилтган жиших, сөргүүлэн тавих задлан ялгах, нэгтгэн дүгнэх, хураангуйлан дүгнэх зэрэг сэтгэн бодох үйл ажиллагааны элдэв үйлдэл хийж бодохыг шаардах, үгээр хүний оюун ухааныг нээгдүүлэх арга хэрэглүүр болсон зүйлс их байдаг бөгөөд таахын тулд оюуны зохих үйлдэл шаардсан асуулт мөний хувьд хүүхэд залуусын оюун санааг хөгжүүлэх арга, буюу нэгэн ёсны танин мэдүүлэх бодлогын хураамж буюу оюун ухааны гимнастикийн дасгалын чанартай билээ.

Хүний амьдралд сургамж болгох, үг яриаг чимэгтэй, хөгжүүнтэй уран цэцэн, товч хураангуй илэрхийлснийг зүйр цэцэн үг гэнэ. Зүйр цэцэн үгийг дотор нь гол шинжийн бүтцийн талаас нь 1. Цэцэн үг, 2. Зүйр үг гэж хуваана. Цэцэн үгэнд: Эзэн хичээвэл заяа хичээнэ хэмээн амьдралын туршлагын үнэн зүйлийг нэгтгэн дүгнэх байдлаар товч хураангуй илтгэсэн бол зүйр үгэнд:

Ам алдвал барьж болдоггүй

Агт алдвал барьж болдог гэх зэргээр аливаа юмны адил төстэй буюу эрс ялгаатайг жишин харьцуулах аргаар илэрхийлсэн байдаг.

Зүйр цэцэн үг оньсого таавартай адил төстэй мэт боловч бусад улс түмэнд бараг байхгүй монгол аман зохиолын нэгэн төрөл нь ертөнцийн гурав юм. Энэ өвөрмөц сонин төрлийг бас төрийн гурав, дэлхийн гурав гэхээс дархад ястанд тивийн гурав, буриадад бол таавар гурвалжин гэдэг байна. Энэ нь байгаль ертөнцийн юмс үзэгдлийн дотроос шинж төлвөөрөө нийтлэг төстэй гурван зүйлийг онцлон аж төрөл, нийгэм түүхийн туршлага танин мэдэхүйн дүгнэлтийг гурван мөрөөр илэрхийлэн зохиогдсон шүлэг юм.

Монгол үлгэрийг дотор нь 1. Адгуусан амьтны үлгэр, 2. Шидэт үлгэр, 3.Аж байдлын үлгэр гэж судлаачид үндсэнд нь ангилж байна.

Адгуусан амьтдын хоорондын харилцан явдлыг уран сэтгэмжээр хүнчлэн дүрсэлж үүгээрээ тэдгээрт хандах хандлага, гарах уран санаагаа илэрхийлсэн хүүрнэн өгүүлэх аман зохиолыг адгуусан амьтны үлгэр гэнэ.

Үнэн бодит баримт, түүхэн үйл явдлаас нь үндэс авч уран сэтгэмжээр баяжуулан үлгэр мэт болгон хүүрнэн өгүүлдэг домог нь монгол аман зохиолын нэг гол төрөл юм.

Домгийг дотор нь 1. Уг удмын буюу угсаатны холбогдолтой домог (Эргүнэ хун Хоридой мэргэний домог, гэрийн эзэнд архи эргүүлэн барих болсны учир, зурхайн самбар, монгол малгайн домог) 2. Түүхэн домог (Гурван зуун тайчуудыг дарсан домог, Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний цэцэлсэн шаштир, Мандухай цэцэн, Амарсанаа, Чингүнжав, Торой бандийн тухай болон хүчит бөхийн домог г.м) 3. Аж байдлын сэдэвт домог (Арвай хээр, Уртын сайхан хүрэн, Сайвар халтар зэрэг хурдан морьдын тухай болон Юндэн гөгөө, Эр бор харцага зэрэг дууны домог) хэмээн ангилдаг.

Тууль. Олон үеийн авьяас билэгтэн, мэргэжлийн туульч нарын амаас ам дамжин уламжлагдсан тууль бол овог аймгийн хамт олны ялагдашгүй хүч, сайн сайхан чанар, мөрөөдөл хүслэнгийн нь төлөөлөл болсон морьтон баатрыг магтсан баатарлагийн хүслэнгийн түүхэн дурьдатгал, туульсын төгөлдөр их найраглал юм.

Төв азийн туулийн сонгодог жишээ болсон монгол туулийн нийтлэг шинж бол морьтон баатрын хүч чадал, гавьяат үйлсийг үлгэр домгийн хүслэнгийн хэмжээнд магтан дүрсэлдэг бөгөөд олонхдоо баатарлаг гэрлэлтийн сэдэвтэй түүхэн тодорхой шинж чанаргүй, харин үлгэрлэг уран сэтгэмж ихтэй учир "үлгэрлэг тууль"-д хамаардаг ажээ.

Туулийн үйл явдлыг хөтлөх гол зүйл нь баатарлаг хүн байгалийн эрхшээл хоёрын зөрчилдөөн мөн бөгөөд иймч учраас туулийн баатар эрийн гол гавьяа нь байгалийн аймшигт хүчний хүншүүлсэн дүр болох мангастай халз тулалдан ялдаг, тэгэхдээ ид шидийн хүчээр биш, ирт зэвсгээр ч биш, гол төлөв ээж аавын бүтээсэн эгэм далаар буюу баатар биеийн хүч тэнхээгээр, тэвчээр хатуужлаар ялдаг байна. Монгол туулийн баатрын хатан гол төлөв гоо үзэсгэлэнтэй төдийгүй баатраасаа илүү ухаантай байж, унтахад нь сэргээж, умартахад нь сануулж зөвлөж буйгаар гардаг нь эхийн эрхэт ёсны тусгал юм.

Монгол туульд баатрын дотны хамсаатан, зөвлөх байдлаар дүрслэгдэх морь нь баатраасаа илүү ухаантай, цэцэн зөвлөгчөөр барахгүй тэнгэрийн дагиныг авчирч гэнэдэж алдсан буюу үхэж үрэгдсэн баатраа сэхээлгэж амь оруулах зэргээр эзнээ ивээгчийн байдлаар гардгийн үүсэл нь адгуусны хэлбэрийн тэнгэр нэрийн домогтой холбоотойн зэрэгцээ эрт цагт адгуусны тухай тууль, домог байсны гэрч юм. Эдгээр онцлог шинж нь үлгэрлэг тууль гэгдэх монгол туулийн үндсэн шинж юм.

Монгол туулийг үлгэрлэг, цоморлиг, туужлаг хэмээн ангилна.

Туужлаг туулинд монголын уран зохиолын гурван оргилын нэгэнд ордог Гэсэрийн тууж түүний зарим хувилбарыг оруулдаг. Энэ тууль нь ердийн үлгэрлэг туулиас ялгаатай. Агуулгын хувьд хошин шог аястай, мөн Гэсэр хаан гэсэн гол баатраар холбогдсон туужлаг баатарлагийн үлгэр маягтай зохиол юм.Туулийг бага наснаасаа тууль хайлах эрдэмд мэргэжсэн мэргэжлийн туульчид хайлан хэлж энэ эрдэм ухааныг улам боловсронгуй болгож үеэс үед уламжлан иржээ.

Жангарын тууль. Монгол туульчдын туурвисан үгийн урлагийн суут бүтээл Жангарын дуулал Халх Монгол, дөрвөн Ойрад, ялангуяа Ижил мөрний Халимагуудад өргөн дэлгэрчээ. Жангар туулийн дотор Алтайн нуруу, Эрчис мөрөн, Тагнын таван уул, Хүйтэн ширхэг, Шира гол зэрэг Төв азийн газар нутгийн нэр олонтаа тохиолдох учир эрдэмтэд энэ туулийг Халимагийг Алтай нутгаас нүүхийн өмнө зохиогдсон гэж үздэг байна.

Жангарын туулийг цоморлиг тууль гэж болно. Жангар бол энэ цоморлиг туулийн холбоосын үүрэг гүйцэтгэж байгаа гол дүр юм.

Жангарын агуулга бол бусад баатарлагийн туулинд гардгийн адил овог нийтийн анги нийгмийн шинжийг нэгтгэн төлөөлсөн баатар гарахгүй, харин зан чанар, мэргэжлийн аль нэг талаар бусдаас товойн ялгарах онцлог бүхий бие хүний үүсвэр шинжтэй баатрууд гарч Жангар туулийн нэг нэг бүлгийг эзэлсэн бие даасан тууль болсон байдаг. Тэр нь бие хүн ялгаран тодрохын уггал бэлэгдлийг үзүүлжээ. Төвлөрсөн засагт нийгмийн байгууллыг Жангар тусгасан гэдэг нь Жангарын баатрууд байлдаж ялж дийлсэн орноо мянга нэгэн жилийн албат болгож байгаагаар илэрч байгаа төдий бус, бас энэ тусгаар улс мэт өөр өөрийн түүхтэй буюу баатарлаг гавъяатай бие биеэсээ ялгагдах ядахдаа нэг хоёр содон онцлогтой баатар нь цөм Жангар гэдэг нэг төв удирдлагатай, түүнээс ерөнхийдөө шалтгаалах дагалдсан баатрууд байж зохиол бүтдэг болно.

Жангарын туульд илэрхийлсэн үндсэн санаа бол "Дээрээ ноёнгүй дэргэдээ дайсангүй, хүний хүчийг шилж хүлгийн шандас шалган миний чиний гэх юмгүй нийтээр нэг ёс тогтсон даарах хүйтэнгүй, халах халуунгүй өвөлгүй зунаараа байдаг" жаргалант орныг мөрөөдөн дүрсэлсэн байдагт гол утга нь зангилагддаг.

Алдарт туульч Мандиханы Парчин бол Баруун Монголын ард түмний олон туулийг залгамжлан хөгжүүлж туульчийн уран чадварыг төгс эзэмшин хойч үедээ уламжлуулан орчлон дахинаа алдаршуулж манай ард түмний дунд төдийгүй дэлхийн монголч эрдэмтдийн дунд нэрд гарсан туульч билээ. Алдарт туульч М.Парчин XIV жарны хөхөгчин туулай жил буюу 1855 онд хуучин дөрвөд Сайн Заяатын Зүүнгар Чуулганы Төгс хүлэг Далай ханы аймгийн арван баядын Саруул жанжин гүний хошуу, одоогийн Увс аймгийн Хяргас сумын нутагт Мандиханы 2-р хүү болон төрж 1926 онд далан нэгтэйдээ насан өөд болжээ.

М.Парчин угтаа Цорос овогтон "цагаан ястан" гаралтай гэх боловч амьдралын хувьд ядуу, жирийн нэг хохь тайж байжээ.

Боловсролын хувьд тод монгол бичиг сайн мэдэх бөгөөд тиймийн учир шүүх харуулын алба хаших зэргээр төрийн хэрэгт оролцож явсан байна.

М.Парчин бага ахуй цагаасаа ардын аман зохиолын баялаг дээжис ялангуяа Баруун Монголын туулийн сонгодог уламжлалтай танилцсан нь түүний туульч болоход чухал нөлөө үзүүлсэн билээ. Анх 9 настайдаа "Эргэл Түргэл" туулийг нутгийн нэрт туульч Сүгсүүгээр заалган сурчээ. Өөрийн авга ах Санжаагийнд очиж үсэг бичиг, үлгэр заалгахдаа, "Бүргэд хар" туулийг сурч улмаар Баяд туульч Буурал Сэсрэнгээс "Бум-Эрдэнэ", Шийраваас "Дайны хүрэл" Баядын Жалцан тайжаас

Туульч М.Парчин
(1855-1926 он)

"Хийгийн хүйтэн хөх төмөр зэв",Урианхай туульчаас "Догшин Чингэл", "Хаан Чинке", тод үсгийн бичмэлүүдээс "Эрийн сайн Хан Харангуй" зэрэг арав шахам туулийг сурч, жирийн айл өрхөөс эхлэн арван Баяд, Дөрвөд далай хааны Лу жанжин гүний хошуу болон урианхайн зах залгаа нутгаар уригдан туулиа хайлж "туульч тайж", "Туульч Парчин" хэмээн дуурсагджээ. "Бум-Эрдэнэ" хэмээх монгол туулийн томхон бүтээлийг хайлан хэлэх болсон үеэс Парчины нэр алдар улам түгжээ.

М.Парчин өөрийн хайлдаг туулиудаараа айл саахалт, хөрш зэргэлдээ нутаг хошуудын ард олны гоо сайхан таашаалыг татаж байсан төдийгүй тэр үеийн томоохон ноёд баячууд "Бум-Эрдэнэ" болон "Хан Харангуй" туулийг хэлүүлэхэд гэрийн барцад арилдаг гэж үздэг байсан учир Парчин туульчийг урьж тууль хэлүүлэн ууц тавин моринд эмээл тохож мордуулан хүндэтгэдэг байжээ.

Мөн М.Парчин үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд оролцон, авьяаслаг туульчийн хувьд бүтээлээрээ олон түмнийг тэмцэлд зоригжуулж байв.

Б.Я Владимирцов, А.В Бурдуков нар туульч Парчингийн уран бүтээл судлах ажлын эхлэлийг тавьсан юм.

Б.Я Владимирцов М.Парчины авьяас билгийг өндөр үнэлж "Олон газраар явж их юм олж тэмдэглэж авлаа. Сайн сайн туульч тааралдах юм. Гэхдээ их Парчин хавьгүй илүү юм" гэж тэмдэглэж байв.

Х.Самилдэндэв

ХУУЧНЫ УРАН ЗОХИОЛ

XIII-XIV зууны үеэс уламжлан ирсэн уран зохиолын дурсгал бичгүүдийг шинжилж үзвээс цэвэр үндэсний шинж чанараа ямар нэгэн хэмжээгээр гээж, бүс хоорондын утга зохиолын нөлөөнд орж эхэлсэн нь Перс, Гүрж зэрэг бусад улс үндэстний зохиолын дурсгалаас мэдэгдэнэ.

Бүс хоорондын утга зохиолын нөлөөнд төдийлөн ороогүй дундад эртний үеийн түүх, уран зохиолын хамгийн том дурсгал болбоос "Монголын нууц товчоо" болно. Монгол үндэстний түүх уран зохиолын энэхүү гайхамшигт дурсгал бичгийг дундад эртний үеийн нүүдэлчдээс дэлхийн уран зохиолын өв санд оруулсан үнэт хувь нэмэр мөн болохыг үе үеийн судлагчид үнэлсээр ирсэн юм.

"Монголын нууц товчоо" бол XII-XIII зууны үед зохиогдсон монголын түүх, уран зохиолын цорын ганц дурсгал биш гэдгийг судлагчид тэмдэглэсээр иржээ. Тухайлбал, академич Ц.Дамдинсүрэн: "Нууц товчоог арван гуравдугаар зууны үед зохиогдсон ганц яруу зохиол гэж үзэж болохгүй. Жишээлж хэлбэл халцгай цөлд ганц өндөр нарс ургадаггүй, өндөр нарс их ойн дунд, өндөр нам олон нарсны зэргэлдээ ургадаг биш үү. Тэрчлэн өндөр сайхан нарс мэт сүндэрлэсэн Нууц товчоо хэмээх зохиол бол тэр урьд цагт байсан яруу сайхан олон зохиолын нэг нь мөн гэж бодож болно" хэмээжээ.

XIII зууны үеэс уламжлан ирсэн монгол шүлэг найргийн нэгэн сонин дурсгал бол 1930 онд Ижил мөрний зүүн эрэг хавиас олдсон үйсний бичиг юм. Үүнийг судлаачид "Алтан ордны үйсний бичиг" гэж нэрлэж иржээ. Уг бичээсийн агуулгад алс нутагт бие биеэ санан мөрөөдсөн эх, үрийн сэтгэлийн харилцааг тусгасан юм.

Тэрчлэн дундад эртний үеийн түүхийн зохиолоор уламжлан ирсэн "Хоёр загалын тууж", "Гурван зуун тайчуудыг дарсан домог", "Аргасун Хорчийн домог", "Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шастир", "Оюун түлхүүр" зэрэг зохиолыг эрдэмтэн судлаачид агуулга, үзэл санаа, бичлэгийн хэлбэр байдлаар нь шинжилж үзээд XIII зууны үеэс уламжлан ирсэн зохиол гэсэн дүгнэлт хийжээ. Энэ тухай Б.Я.Владимирцов: "Нууц товчооноос хойш монгол туульсын зохиолын цуурай тасраагүй бөгөөд тэр нь зарим үед сургаалын зохиол, түүх, хууль эрхийн шинжтэй зохиолуудаар уламжлан дууриссаар ирсэн билээ." хэмээн тэмдэглэсэн байдаг.

Дундад эртний үеийн түүхэн зохиолоор уламжлан ирсэн дээрх домог, тууж, сургаалууд нь бүгд эзэн Чингис хааны үйл амьдрал, үзэл бодолтой ямар нэгэн талаар холбоотой байгаа нь огт санамсаргүй хэрэг биш бөгөөд энэ их хүний аугаа их үйл хэрэг нь дундад эртний монгол уран зохиолын гол сэдэв болсоор ирснийг батлан харуулж байна.

XIV зууны эхэн үеэс монгол уран зохиолд буддын шашны нөлөө хүчтэй нэвтрэх болсон байна. Тэр үеэс төвдийн сажийн чиглэл буюу улааны ёсны шажин Монголд алхам алхамаар хүчтэй дэлгэрч, Энэтхэг, Төвд хэлнээс бурхан багшийн зарлиг, шастирын олон номыг орчуулж, улмаар эх хэлээрээ бурханы сургаал номыг урих, хурах болжээ.

Монголчуудын байгуулсан их Юань улс 1368 онд мөхсөний дараа Монгол орон задрал бутралын замд орж, улс төр, эдийн засаг, соёлын амьдрал гүнзгий хямралд орсон нь уран зохиолын хөгжилд таатай нөлөө үзүүлсэнгүй. Уран зохиол бол нийгмийн амьдралын тусгал байдаг болохоор энэ үед монголчуудын өөр хоорондын эвдрэл, зөрчил тэмцлийн байдлыг тусгасан "Убаши Хун тайжийн тууж", "Хув Нагваралын тууж" мөн монгол түмний эв нэгдэл, баатарлаг тэмцлийг магтан дуулсан "Мандухай цэцэн хатны домог", "Зургаан түмэн монголын магтаал" зэрэг зохиол гарсан нь санамсаргүй зүйл биш юм.

Ялангуяа "Убаши Хун тайжийн тууж", "Хув Нагваралын тууж" хоёр бол Ойрад, Халхын хоорон дахь хагарал зөрчлийг шүүмжилсэн, ардын аман зохиолын хэв маягаар бичигдсэн сонирхолтой зохиолууд билээ.

Түмэдийн Алтан хаан (1507-1582)

XVII-XVIII зууны үеийн монгол уран зохиолд үндэсний онцлог шинжээ хадгалсан түүхэн уран зохиолын зэрэгцээ Энэтхэг, Төвдийн хос ёсны сургаал, хажлагат тууж, намтар цадигийн төрөл ирмүүн хөгжиж байлаа. Тухайлбал, монголын хуучин уран зохиолд чухал байр эзэлдэг олон сонин сургаалын зохиолууд голлуу энэ үед зохиогдсон ажээ. XVII, XVIII зууны үеийн монгол бичгийн мэргэд эртний Энэтхэгийн их эрдэмтэн Нагаржунагийн "Рашааны дусал",

Сажа бандидын "Субашид"зэрэг зохиолыг үлгэр загвар болгон "Орчлонгийн сав шимийн дуулал", "Тоть шувууны сургаал", "Нэгэн үсгийн эрдэм", "Сургаалын үгс тод сарны гэрэл", "Авах гээхийн дөрвөн мөрт шүлэг" тэргүүтэн олон сонин сургаалыг бичиж үе үеийн уншигчдыг утгын гүн санаа яруу тансаг үг хэллэгээр сурган хүмүүжүүлсээр иржээ.

Мөн энэ үед Энэтхэгийн Рамаяна, Панчатантра, Бигармижид хааны намтар зэрэг зохиолыг дууриалган чухам нүүдэлчин монголчуудын ахуй амьдралын өвөрмөц шинж төрхийг шингээсэн шинэ шинэ зохиолыг өөрийнхөө хэрсэн дээр чадамгай ургуулсан билээ. Ер нь энэ үеийн зохиол бүтээлийн дотор ардын үлгэр домгийн өгүүлэмжээс санаа авч найруулсан маягтай "Эндүүрэл хааны тууж", "Нарангэрэл дагиныг тууж", "Багмай хатны тууж" зэрэг зохиол аман ба бичгийн хувилбараар өргөн дэлгэрч байсныг дундад эртний үеийн уран зохиолын өвөрмөц дүр төрхтэй холбоотой үзэгдэл гэж хэлж болно.

Намтар зохиол бол Энэтхэг, Түвэдийн шажин номын мэргэдүүлийн нөлөөгөөр дундад эртний үеийн монгол уран зохиолд бие даасан төрөл болж хөгжсөн нь том хэлбэрийн хүүрнэл зохиолын нэг тодорхой жишээ юм.

XIV зууны үеэс монгол уран зохиолын төрөлд бий болсон тайлбар зохиолын нөлөөгөөр монгол уран зохиолын түүхэнд эртнээс нэвтрэн орж идээшин хөгжсөн сонирхолтой төрөл бол хажлагат тууж юм. Ертөнцийн амьдралын утга учрыг яруу найргийн хэлээр гүн гүнзгий дуртган санаалуулсан сургаалын шүлгийн утга санааг эгэл төрөлхийтний ой тойнд хүртээхийн тулд бичгийн мэргэд үлгэр домгийн зохиолоос утга нийцүүлж ишлэн өгүүлэх журмаар эл төрөл дэлгэрчээ.

XII-XVIII зууны үеийн монгол шүлэг найргийн дотор яруу найрагч Цогт хун тайжийн (1581-1637) уянгын шүлэг дуулал өөрийн өвөрмөц хэллэг, зохиомж, урлаг, уран сайхны шинж чанараараа гойд ялгаран харагддаг. Ийм ч учраас Цогтын "Дуутын хадны шүлэг"-ийг Б.Я.Владимирцов "Хээр талын анхилуун үнэрээр ялгарч байна" гэсэн нь санаандгүй хэлсэн үг биш юм.

Зохиогч аливаа үзэгдэл, юмсын төстэй болон ялгаатай шинжийг харьцуулан жиших аргаар өнгөн болоод далд утгын дагнаасыг маш чадамгай уялдуулан бичсэн нь энэ алдартай шүлгийн гол онцлог гэж хэлж болно.

XIX зууны эхэн үеэс монголын уран зохиол хөгжлийнхөө шинэ шатанд оржээ. Энэ үеэс уран зохиолын төрөл зүйл өргөжин тэлэхийн хамт тухай тухайн төрлийг дагнаж бичдэг үе үеийн төлөөлөгчид гарч ирсэн юм. Тухайлбал уянгын яруу найраг, сургаалийн шүлгээр их зохиолч Ноён хутагт Данзанравжаа (1809-1856) хийгээд Ишданзанванжил (1854-1907), Хишигбат (1849-1916), Лувсандондов (1854-1909), Гулранса (1820-1851) нарын зэрэг билигт найрагчид төрж гарсан бол, нийгмийн гэм буруүг хошигнон шоглосон шүүмжлэлийн аястай хуульч Сандаг (1825-1860), Ишсамбуу, Хайдав, Шагдар "солиот" нарын үг зохиол, үлгэр өгүүлэл, харилцан ярианы хэлбэртэй хошин өгүүллийн төрөл өрнөн хөгжжээ.

XIX-XX зууны заагт үеэр уншигч түмний сонирхолыг гойд татаж байсан өөр нэг төрөл бол ардын аман зохиолын хэв маягийг үлгэрлэн зохиосон ерөөл, магтаал, холбоо шүлэг, үлгэр өгүүллэгийн зохиолууд юм. Эдгээр төрөл зүйлсийн гол төлөөлөгчид нь ерөөлч Гэлэгбалсан (1846-1923), яруу найрагч Гамал захирагч (1871-1932), Гэндэн Мэйрэн (1820-1882), Дорж Мэйрэн (1878-1943) нар болно.

XIX зууны үеийн зохиолчид нь дээр дурдсанчилан тусгай төрлөөр дагнан бичихийн хамт уран зохиолын хэд хэдэн төрөлд авъяас билгээ сорьж амжилт гаргасан нь ч цөөнгүй бий. Жишээлбэл, их зохиолч Данзанравжаа 1000 гаруй эхтэй шүлэг зохиол бичсэн гэх ба "Саран Хөхөө" гэдэг дуулалт жүжиг дэглэн зохиож тоглуулж байсан нь монголчуудын театрын урлагийн түүхэнд гарсан гарамгай амжилтын нэг мөн болно. Равжаа бол үнэнхүү цагийг ээлсэн их найрагч байсан тул түүний туурвисан дуу, шүлэг нь ард түмний дунд ам, бичгээр уламжлан дамжсаар ихэнх зохиол бүтээл нь энэ үетэй золгож чадсан ажээ.

XIX зууны монголын уран зохиолын түүхэнд гарсан нэг томхон үзэгдэл бол их сударч Инжаннашийн роман зохиолууд юм. Зохиолч Инжаннаш эцэг Ванчинбалын үүсгэн эхэлсэн "Их Юань улсын мандсан төрийн хөх судар" хэмээх түүхэн романыг 1871 оноос 1891 оны хооронд хорин жилийн турш махран бичиж дуусгасан гэж үздэг.

Уг зохиолыг туурвих үед нэг талаас Инжаннашийн үзэл санаа, нийгмийн ухамсар төлөвшин тогтсоны дээр Манж Чин улсын ээлэн түрэмгийлэгчид соёлын талаар ч уусган хайлуулах хортой санаа өвөрлөж байсан нь монголчуудын өнгөрсөн түүхийнхээ алтан үеийг дуртган өгүүлсэн эл шастирыг бичихэд хүргэжээ.

Дээр өгүүлснийг дүгнэж хэлбэл, монголын хуучин уран зохиолын энэхүү баялаг өв уламжлал нь шинэ үеийн уран зохиолын цэцэглэн хөгжих шимтэй хөрс нь болсоор ирсэн байна.

Монголын нууц товчоо. Монгол туургатны оюуны бүтээлийн бахархал болсон "Монголын нууц товчоо" нь орчин үеийн соёлт хүн төрөлхтний сайн мэдэх эрхэм зохиолын нэг билээ. Эдүгээ энэхүү гайхамшигт дурсгал бичгийг монголын судлал хөгжсөн улс орнуудад өргөнөөр судалж байгаагийн дээр Англи, Герман, Орос, Польш, Солонгос, Түрэг, Унгар (мажар), Франц, Хасаг, Хятад, Чех, Япон зэрэг дэлхийн олон хэлээр орчуулсан байна. Эл алдартай дурсгал бичгийн 750 жилийн ойг тохиолдуулан НҮБ-ийн боловсрол Шинжлэх ухаан, Соёлын асуудал эрхэлсэн байгууллагын (UNESCO) гүйцэтгэх товчооноос "Монголын нууц товчоо"-г Дорно дахины түүх, утга зохиолын аугаа их дурсгал, уран сайхан гоо зүйд, яруу найргийн шинж чанар, хэлний баялагаараа монголын утга зохиолын түүхэн дэх хосгүй үзэгдэл, дэлхийн үгийн урлагийн нэгэн алтан сан хэмээн өндөр үнэлээд түүний орчуулгыг дэлхий дахины сонорт хүргэх тогтоол гаргажээ.

Бидний үед "Монголын нууц товчоо"-ны жинхэнэ эх уламжлан ирсэнгүй. Мин улсын үед хятад үсгээр галиглаж, орчуулсан хэд хэдэн хуулбар хүрч ирснийг үе үеийн эрдэмтэд нягтлан судалсаар уг дурсгал бичгийг амжилттай сэргээж чадсан байна.

"Нууц товчоо"-ны зохиогдсон он цагийн хувьд 1228 оны хулгана жилд эхний арван бүлгийг бичиж 1241

оны хулгана жил сүүлчийн 11, 12-р бүлгийг Өгөөдэй хааныг өөд болсны хойно нэмж туурвисан гэдэгт олонхи эрдэмтэд санал нэгдэх болжээ.

"Монголын нууц товчоо" бол эхнээсээ аваад монголчуудын маш эрт цагийн домог үлгэр (миф) онгон шүтээний (тотем) ойлголтыг уламжлан хадгалж ирсэн зохиол юм.

Академич Ц.Дамдинсүрэн "Нууц товчоог зохиосон хүн, монголын аман зохиол, домог, ардын уран цэцэн үгсийг ашиглан XIII зууны үеийн Монголын түүхийг уран зохиолын маягаар чимэглэн бичжээ" гэж хэлсэн билээ.

"Нууц товчоо" бол XII-XIII зууны үеийн монголын түүх бичлэгийн товч, дэлгэр олон зохиолоос бидний үед уламжлан ирсэн нь болно. Иим учраас XIII зууны үеийн монголын сударчид түүхэн зохиол туурвих нэгэнт уламжлан тогтсон тодорхой хэмжээний туршлага хуримтлагдсан байжээ. "Нууц товчоо"-г туурвигч нь түүхийн хэрэг явдлыг бүртгэн, тоочих аргаар биш, уншигчийн таашаал сонирхлыг татахуйц уран сайхны аргаар бичжээ.

"Монголын нууц товчоо"-г бүтцийн хувьд авч үзвэл уран зохиолын хүүрнэлт ба яруу найргийн үндсэн хоёр хэлбэрт багтах янз бүрийн төрөл, айд хамаарах жижиг жижиг хэсгүүдээс бүрдэж байгаа юм. Иим учраас "Нууц товчоо"-г яруу сайхны нь талаас судалсан эрдэмтэд хүүрнэл болоод яруу найргийн хосолмол хэлбэрийн дотор эртний домог үлгэрийн ойлголтоос аваад элдэв сонин өгүүлэмж бүхүй жижиг жижиг өгүүллэгүүд, зүйр цэцэн үг, магтаал дуулал, дом шившлэг, бэлэг дэмбэрэлийн үгс тэргүүтэн олон зүйлийн төрөл ай байгааг бүрсгэн судалсаар иржээ.

"Нууц товчоо" нь эхэн хэсэгтээ Чингис хааны язгуур гарвалыг угийн бичгийн аргаар бүрсгэн нэрлээд улс орны доторхи их бага аливаа содон сонин үйл явдлыг товч тодорхой, үнэмшилтэй өгүүлснээрээ нэгдсэн монгол улсын түүхийн хосгүй үнэт дурсгал болдог билээ. "Монголын нууц товчоо"-ны түүхэн хэрэг явдлын олон чухал үнэ цэнэтэй мэдээллүүд нь персийн түүхч Рашид Ад-диний "Судрын чуулган" хийгээд хожуу үеийн бусад сурвалжуудаар давхар батлагддаг юм.

"Нууц товчоо"-ны зохиогч нь түүхэн явдлыг үзүүлэхдээ зохиолоо нэн сонирхолтой болгох зорилгоор уран сайхны дүр, дүрслэлийн аргыг хэрэглэж бичсэн юм.

Эцэст нь дүгнэн хэлбэл 1. "Монголын нууц товчоо"-ны зохиогч нь тухайн үеийн үгийн урлагийн ололтыг түүхийн баримт материалтай чадамгай хослуулан ардын аман зохиолын баялаг уламжлалд тулгуурлан бичжээ.

2. "Нууц товчоо"-ны доторх уран хошин өгүүллэг, шигтгэл шүлэг хийгээд түүний хэл найруулгыг хянаж үзвэл уг түүхийг туурвигч нь буюу гол сударч нь туршлагатай зохиолч, авъяаслаг шүлэгч хүн байжээ.

3. "Нууц товчоо"-ны зохиогч нь түүхэн үйл явдлыг тухайн үеийн үгийн урлагийн ололт амжилттай чадамгай хослуулан туурвисны хувьд эл зохиол нь дундад зууны үеийн монголын түүх, уран зохиол, хэл соёлын үнэт дурсгал болж байна.

XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр. XIV зууны үест Чойжи-Одсэр хэмээгч их эрдэмтэн яруу найрагч байжээ. Түүний нэрийг зарим үед номын гэрэл гэж орчуулсан тохиолдоно.

Яруу найрагч Чойжи-Одсэр

Чойжи-Одсэр бандида 1305 онд монгол хэлний анхны журамлах хэл зүйн бичиг зохиосны дээр Энэтхэг, Төвд хэлнээс олон ном зохиол монгол хэлээр орчуулж байжээ. Мөн бичиж туурвисан ном зохиолынхоо оршил төгсгөлд бичсэн шүлэг хийгээд Турфаны цуглуулгаар уламжлан ирсэн Махагалийн магтаал зэрэг найраглалаас үзвэл, гарамгай яруу найрагч байсан гэж хэлж болно.

Монгол, төвд, хятад хэлээр бичсэн түүх, шастирт Чойжи-Одсэрийн тухай нэлээд мэдээ баримт байдаг байна.

Юань улсын судрын 24-р дэвтэрт түүний гавьяа зүтгэлийг үнэлж цаасан мөнгө түмэн хэсэг хүртээв гэсэн сонирхолтой мэдээ бий.

Чойжи-Одсэрийн уран бүтээл асар олон талтай байсны баримт бидний үед улам тодорсоор байна. Тэрээр судар, тарнийн олон номыг монгол хэлээр орчуулж магтаал, ерөөл мөргөл, тахил төгсгөлийн шүлэг дуулал бичиж байсны дээр Бурхан багшийн намтар буюу "Арван хоёр зохионгуй" хэмээх цадиг зохиож, эртний энэтхэгийн гүн ухаантан Шантидевагийн "Бодичария аватара" буюу "Бодь мөрийн явдалд орохуй" хэмээх гүн ухааны 10 бүлэг зохиолд утгын дэлгэр тайлбар бичиж Дадүгийн Цагаан суврагад нэг удаа мянган хувь хэвлүүлж байсан зэрэг олон баримтыг дурдаж болно.

Өөрөөр хэлбэл Чойжи-Одсэр бандида монгол үсэг бичгийн хувьсал шинэчлэлийнхээ дараагаар өөрийн туурвисан шүлэг дуулал, намтар цадиг, тайлбар тэргүүтэн олон арван бүтээлээрээ тухайн үеийн монгол уран зохиолын төрөл зүйлийг баяжуулсаар иржээ.

Эрдэнэ Зая бандида Лувсанпринлэй (1642-1715 он). Халх монголын оройн чимэг хэмээн хүндлэгдсэн гурван хутагтын нэг Эрдэнэ Зая бандида Лувсанпринлэй 1642 онд Халхын Сайн ноён хан аймгийн Хангай ханы Хасуйн голын Хужирт хэмээх газар буюу одоогийн Архангай аймгийн Цэцэрлэг сумын Мухар хужиртад эцэг Сунтар, эх Орхидайн хоёрдугаар хөвүүн болон мэндэлжээ . Удам угсааны хувьд их Чингис хааны алтан ургийн боржигон овогт хүн юм.

Лувсанпринлэй багаасаа ой ухаан саруул, эрдэм номд дуртай, эцгээ даган монгол бичиг, улмаар тэр цагийн боловсролын хэл болж байсан төвд хэл бичгийг сурч, 1660-1679 онуудад Цаст Төвдийн оронд номд суралцаж байхдаа Халхын багш нарынхаа зааврыг дагаж голдуу Дашлхүмбэ хийдэд шавьлан

суралцсан бөгөөд ингэхдээ өөрийнхөө намтарт тэмдэглэснээр түвэдийн аль билиг оюун, эрдэм чадвар өндөр багшийг шүтэж, ухааныг нь уудалж, увидасыг нь эзэмшихийг хичээн, судар тарнийн хамаг номыг таалалдаа болгоохыг эрмэлзэж байжээ.

Лувсанпринлэй ном эрдмээрээ цастын мэргэдийн дунд ихэд алдаршин, таван ухаанд төгс нэвтэрсний тул V Далай лам "Зая бандида" буюу "Ялгуусан бандида" хэмээх номын цол, зарлигийн шар өргөмжлөл, эрдэнийн тамга тэргүүтнээр соёрхон шагнагджээ. Зая гэгээнтэн 1679 онд нутаг усандаа эргэж ирээд, шашин ном дэлгэрүүлж, сүм хийд байгуулж, өвчтөн зовлонтныг анагаан эмчлэхийн сацуу бүтээн туурвих их ажлыг ч шамдан үйлдэж байлаа.

1696 онд өөрийн лавиран Гүдэн сүмийг байгуулсан бөгөөд түүний зүүн сүмийн тасалгаанд Ядам, Сономдоо мөн голын сүмд Чодог бурханыг тус тус тахиж жасаа хурал хурдаг байжээ. Хурлын хоёр мөр суудалтай үйлдэж, дээд давхрын тасалгаанд өөрийн алдартай номын санг байгуулж монгол, түвэд, хятад хэлээр буй эртний түүх, тууж, уран зохиол, шашны ном зохиолуудыг маш олон төрөл ангиар байрлуулан түүнийг нь дараа дараачийн хувилгаад, эрдэмт шавь нар нь баяжуулсаар иржээ.

Зая гэгээнтнийг Цастын орноос 19 хасаг тэрэг ном судар залж ирсэн гэлцдэг хийгээд ховорхонд тооцогдох машид баялаг сан хөмрөг бүхий алдартай номын сангаа үүсгэн байгуулсан нь Монголын соёл, боловсролын түүхэнд оруулсан түүний соён гэгээрүүлэлтийн их хувь нэмэр юм.

Зая бандида өөрөө ихэд эрдэмт хутагт байсан төдийгүй мөн олон сайн эрдэмт лам нарыг төрүүлэн гаргасан хийгээд монгол түвэдийн шашин, соёлын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж, дорно дахины их бага таван ухааныг судлан монголчуудын хүртээл болгон, Халхын Түшээт ханы намтрыг монгол бичгээр зохиосон юм. Тэрбээр түүх намтар, буддын гүн ухаан, яруу найргийн онол, шашны зан үйл тэргүүтний чиглэлээр олон зохиол туурвижээ. Тэдгээрээс хоёр ботийг нь Богд Зонховын утгын гучин таван чимэг, Янжинг баясгах дуун эгшиг, Банчин богдын төрөл дараалын залбирал сувд эрхи, Далай ламын төрөл дараалын залбирал хүслийг хангагч зэрэг залбиралууд, олон бурхадын магтаал, тарнийн зохиолууд, олон зүйл сангууд бүрдүүлдэг бол нөгөө 4 ботид ганжуур данжуурын тойм, нэрт эрдэмтэн бандида нарын намтрууд, бурхадын түүх, домог,номлолуудын тэмдэглэл багтжээ.

Яруу найрагч Данзанравжаа (1803-1856) олон нийтэд "Говийн ноён хутагт" буюу "Равжаа" гэдэг нэрээрээ ихэд алдаршжээ.

Ноён хутагт Равжаа бол монгол орон дахь шарын шашны мандал бууралтын зааг үед аж төрж явсан бурханы шашны улааны чиглэлийн нэрт төлөөлөгч хийгээд олон талын авьяас билигтэй том уран бүтээлч байлаа.

Равжаа Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошуунд (одоогийн Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт) 1803 онд ядуу ард Дулдуйтын хөвүүн болон мэндэлжээ. Эх нь түүнийг нялх цагт нас барсан тул эцгийнхээ хамт айл амьтнаас юм гуйж, баян чинээлэг хүмүүст зарцлагдаж амь зууж байв. Ийм учраас Равжаа багынхаа ядуу зүдүү амьдралыг хожим нь өөрийнхөө намтарт дурсан бичсэн байдаг. Равжаа багын цовоо сэргэлэн хүүхэд байсан тул 7-8 насны үед шүлэг зохиож олны анхаарлыг гойд татаж байжээ. Тэр цагт тусгай шалтгаанаар ноён хутагтын V дүрийг тодруулахыг Манжийн хаанаас хориглож байсан боловч нууц байдлаар цовоо сэргэлэн хүү Равжааг 8 настайд нь ноён хутагтаар өргөмжилсөн байна. Ноён хутагтаар өргөмжлөгдсөнийхөө дараагаар Өвөр Монголын Бадгар Хийд зэрэг газарт сууж Буддын гүн ухааны ном заалгаж байсны дээр, түвэдийн нэрт шүлэгч Ромбо Галдан Жамцын (1617-1677) зохиосон шүлэг, дууллыг сонирхон судалж байв. Равжаа багаас монгол, түвэд хэл бичигт сайтар суралцсан төдийгүй буддын шашны гүн ухаан, зан үйл, ёс горимыг ч сайн мэддэг болжээ.

Равжаа буддын шашны үзлийн хувьд улааны чиглэлийг баримталж байсан тул шарын шашны санваартан гэлэнгүүдээс онцлог шинжтэй юм.

Тухайлбал, Зонховын (1357-1419) шашны гэлэн хүний санваарт ноцтой харшлах архи дарс уух, эмс охидтой дуу хуур болох тэргүүтэн нь түүний амьдралын ердийн хэрэг байлаа. Равжаагийн энэхүү чөлөөт байдал нь ертөнцийн амьдралын мөн чанарыг зөвөөр таньж мэдэх, амьдралын үнэнийг уран бүтээлдээ тусган харуулахад таатай нөхцөл болж байв. Ийм учраас ямар ч лам хувраг төдийлөн бичээгүй янаг амрагийн сэдэвтэй олон сонин шүлгийг Равжаа зохиожээ.

Данзанравжаа
(1803-1856 он)

Одоогоор Равжаагийн шүлэг дууллаас 400 гаруй зохиол уламжлан хүрч иржээ. Үүнээс олон нийтэд өргөн дэлгэрч, үлэмж алдаршсан нь "Урьхан хонгор", "Салж ядах сэтгэл", "Сэргэлэн зант цагаанаа", "Духтай хурдан хүрэн", "Ертөнц авхайн жам", "Ичиг ичиг", "Үлэмжийн чанар", "Найман зүгтээ" зэрэг уянгын шүлэг дуунуудыг нэрлэж болно. Үүнээс гадна Равжаа эртний хос ёсны сургаалын уламжлалаар "Цаасан шувуу", "Сэтгэлийг амраагч", "Олон хөгшид хүүхдийн хэлэлцдэг үгсийн товч", "Хавар цагийн зугаа" зэрэг нийгмийн аж төрөх ёсны тухай олон сургаалийн шүлэг бичжээ.

Равжаагийн бичсэн шүлэг, сургаалын төгсгөлийн үгээс үзвэл олонх зохиолоо 1830-1840-өөд оны

үед зохиосон бололтой байна.

Равжаагийн шүлэг, дууны зарим нь ардын аман зохиолтой маш ойролцоо буюу бараг адил байгаа нь бидний ажиглалтаар хоёр талтай юм. Нэгд, Равжаа зарим шүлэг сургаалаа ардын аман зохиолын хэлбэрээр энгийн уран яруу үг хэлээр бичсэн нь олон түмний дунд ардын бүтээл мэт алдаршсан ажээ. Хоёрт, Равжаагийн удирдаж байсан уран сайхны хамтлаг маягийн дууч, хөгжимч нар газар газрын ардын дуунаас найруулан дуулж байсны зарим нь Равжаагийн нэртэй холбогдож түүний эмхтгэл түүвэрт орох болсон байна. Равжаагийн дуу, шүлэгт ардын аман яруу найргийн зүйлээс зохиолынхоо зохистой газар эвсүүлэн найруулж авсан мөр бадаг ч нэлээд бий.

XIX зууны үеийн бусад зохиолчдоос Равжаагийн ялгарах нэг онцлог бол говь нутгийн олон хийдүүдэд цам бүжиг, уран сайхны жүжиг үзэгдлийг шинэчлэн байгуулж театрын урлагийн эхлэлийг буй болгосон явдал болно. Түүний тайзны урлагийн гол бүтээл нь 1830-хэдэн оны үед Говь мэргэн вангийн хошууны Тулгатын хийд, Хамарын хийд, Галбын гурван хийд зэрэг газарт тоглуулж байсан "Саран хөхөөний намтар" хэмээх дуулалт жүжиг юм. Равжаа эл жүжгийн зохиолоо Төвдийн зохиолч Лувсандамбийжалцаны "Саран хөхөөний тууж" гэдэг зохиолоос сэдэвлэн зохиосон бөгөөд хошин шог үзэгдлүүдийнхээ хамт хорь гаруй бүлэгтэй томхон бүтээлийг дэглэж чаджээ.

Тэрээр дундад зууны үеийн монгол орны феодалын нийгмийн харьцааны хоцрогдол, шашны доройтол зэргийг сайтар ойлгож байсан нь түүний шүлэг сургаал жүжгийн зохиол тэргүүтнээс нь тод томруун харагддаг юм. Гэхдээ нийгмийн шударга бус явдал, гэм хорыг сургаалаар засах гэсэн санаархал нь уг бие хүний ангийн ухамсар хийгээд нийгмийн үзэл санаатай холбоотой болох тухай судлаачид тэмдэглэсээр иржээ.

Дээр өгүүлсэн зүйлээс дүгнэж үзвэл: Равжаа хэдийгээр шашны томхон төлөөлөгч, феодалын нийгмийг засан бататгах үзэл санааг баримталж байсан боловч авьяаслаг яруу найрагч, жүжиг найруулан зохиогч, нийгмийн дундах гэм бурууг шударгаар шүүмжлэгч, дэвшилтэт соён гийгүүлэгч авьяаслаг уран бүтээлч байжээ.

В.Инжаннаш нь 1837 оны 4-р сарын 15-ны өдөр Өвөр Монголын Жостын чуулганы баруун түмэд хошуунд хошуу туслагч Ванчинбалын 7-р хөвгүүн болон төрсөн. Түүний зохиолчийн авьяас тодрон үзэл санаа төлөвшихөд дэвшилт үзэлтэй соёлт гэр бүлд төрж өссөн ард түмний амьдралтай гүн холбоотой байсан нь чухал нөлөө үзүүлжээ. Эцэг Ванчинбал ба Инжаннашийн ах нар нь тухайн үедээ соёл түүхийн өндөр боловсролтой дэвшилт үзэлтэй түүхч, зохиолч, орчуулагч хүмүүс байжээ. Эцэг Ванчинбал нь "Согтсон сэтгэлгээ" зэрэг шүлэг зохион "Хөх судар" романы эхний найман бүлгийг бичсэн байна. Иймээс түүний хүүхдүүд эцгээсээ монгол эх оронч сэтгэлгээ, уран зохиолын үйлсийг залгамжлан авсан. В.Инжаннаш гэрийн багшаар монгол, манж, төвд, хятад бичиг заалган сурч түүх, уран зохиолын ном амтархан уншдаг байсан нь уран зохиолын авьяасыг нь дэгжээн гүн сэтгэгч болоход нь чухал нөлөө үзүүлжээ. Тэрбээр 20 хүртлээ эцгийн гэрт хангалуун амьдралд өссөн боловч язгууртны аж төрөх ёсонд автсангүй, харин голдуу ном уншиж ах нар болон найз нөхөдтэйгөө зохиосон шүлгээ шүүн хэлэлцэж байсан нь уран зохиолын авьяасыг нь дэгжээн бичгийн чадварыг нь төгөлдөржүүлэх нөхцөлийг бүрдүүлжээ.

В.Инжаннаш уран зохиолыг багаасаа сонирхсон бөгөөд арван хэдэн насандаа "Ээжийгээ мөрөөдсөн нь", "Цагаан өвөл", "Жигшмээр хүн", "Сайхан хур" зэрэг шүлэг зохион "Тэргүүлэгч цэцэг ба хос болжмор" гэдэг зураг зурж хориод насандаа "Улаан өнгөтний нулимс" гэдэг зохиол, "Эрдэнийн толь", "Гэрлийн тэмдэглэл" зэрэг тэмдэглэл бичиж, "Улаанаа ухилах тэнхим" хэмээх романаа туурвисан боловч энэ роман нь бидний үед уламжлагдаж үлдэж чадсангүй. Хожим "Чулуун дэрийн шүүмжлэл", "Номчийн хуурмаг", "Үзэл санааг нь эс мэдэв", "Язгуураас мартаж болохгүй" зэрэг шүлэг, өгүүлэл, уран нийтлэл бичжээ. Эдгээр нь В.Инжаннашийг монголын уран зохиолд шинэчлэлт хийсэн гол бүтээлээ туурвихын бэлтгэл болж өгсөн бөгөөд эцэг Ванчинбалынхаа эхний найман бүлгийг нь бичээд дутуу орхисон "Хөх судар" хэмээх түүхэн романыг 69 бүлэгтэйгээр бичиж өөрийн үеийн нийгмийн амьдралаас сэдэвлэн "Нэгэн давхар асар" гэдэг аж байдлын роман туурвисан нь монгол романы анхдагч бүтээл болж уран зохиолын түүхэнд үлдсэн юм.

"Хөх судар" романыг анх 120 бүлэг байхаар төлөвлсөн гэдэг мэдээ байх боловч одоогоор 69 бүлэг олдоод буй бөгөөд XIII зууны үед монгол тархай бутархай овог аймгуудыг нэгтгэн нэгдсэн төр байгуулдагдсан түүхэн үнэнийг уран сайхнаар дүрслэн харуулжээ. "Хөх судар" романыг бичсэнээр В.Инжаннаш монголын уламжлалт түүхэн товчоо буюу он дараалын бичгийн арга барилыг урагш ахиулж монголын феодалын уран зохиолд шинэчлэл хийсэн юм.

В.Инжаннаш "Нэгэн давхар асар" аж байдлын романаа эцэг эх, төрөл садан болон өөрийн амьдралаас сэдэвлэн бичиж феодалын аж төрөх ёс, засаг төрийн бодлогыг шүүмжлэн харуулжээ. Тэгэхдээ эцэг эх, төрөл садныхаа нэр төрийг бодож, бас феодал ноёд түшмэдийн мөрдлөг хавчлагаас болгоомжлон хүмүүсийн нэр, газар орныг өөрчлөн нэрлэсэн юм.

В.Инжаннаш бол зохиолч, зураач төдийгүй утга зохиол, урлагийн онолч хүн юм. Залуудаа "Тэргүүлэгч цэцэг ба хос болжмор" зэрэг уран зураг зурж байсан ба хожим зураг зурж сурахад гурван зүйлийн зам буй. Үүнд өөрийн сэтгэлээс төрөгдөж зурах, хоёрт багшийг даган ёсоор зурах, гуравт бодитойг барьж зурах энэ гурваас эрхэм нь санаанаасаа төрөгдөж зурах нь маш эрхэм болой гэж бичиж үнэнийг урнаар дүрслэн үзүүлэхэд бодит зүйл уран сэтгэмж хоёрын харьцааг онолын үүднээс тодорхойлж бодит байдлаас хийсвэрлэн нэгтгэн дүгнэх явдлыг эн тэргүүнд тавьсан нь түүний онолын түвшин аль хэр өндөр байсныг харуулж байна.

В.Инжаннаш зөвхөн Монголын анхны романыг бүтээснээрээ төдийгүй тухайн үеийн тэргүүний үзэл санааг илэрхийлэгч, улс үндэстний тусгаар тогтнолыг эрхэмлэгч ардчилсан дэвшилт үзэлтэй байснаараа монголын соёлын түүхэнд хүндтэй байрыг эзэлдэг.

Д.Цэрэнсодном
С.Уранбилэг

ОРЧИН ҮЕИЙН УРАН ЗОХИОЛ

1921 оны хувьсгал нь монголын нийгмийн амьдралд эрс өөрчлөлт оруулсан бөгөөд шинэ үеийн зохиолчид аман зохиолын уламжлал, Монголын нууц товчоо болон түүнээс уламжлан зохиогдсон түүхэн уран зохиол зэрэг үндэсний уран зохиолын уламжлалын зэрэгцээ хятадын роман, тууж, энэтхэг, түвэдийн уран зохиол ялангуяа дундад зууны шашны гоо зүйн нөлөө бүхий дорно дахины бүс нутгийн хүрээнд байсан монголын уран зохиолыг Европ зүгийн, тэр дундаа оросын реалист утга зохиолын нөлөөгөөр баяжуулж, XX зууны Монголын шинэ уран зохиолын арга зарчмыг үндэслэсэн юм. Монголын орчин үеийн уран зохиол үндэсний уламжлалаа баяжуулж дэлхийн жишигт хүрсний нэгэн гэрч гэвэл яруу найраг, үргэлжилсэн үг, жүжгийн зохиолын төрөл зүйл, дотоод хэлбэрийн бүхэл бүтэн тогтолцоог бий болгосон явдал юм.

Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгчид зүй ёсоор тооцогддог Д.Нацагдорж 1930-аад онд "Сэхээтэн", "Миний ээж", "Гайхалтай" зэрэг дөрвөн мөртөөс эхлээд "Нууц янаг ", "Хавар" , "Мөрөөдөл", "Янаг амрагаа мөрөөдөхүй" зэрэг уянгын болон "Дөрвөн цаг" зэрэг гүн ухааны шүлэг, улмаар монголын эх орны сэдэвт яруу найргийн мөнхийн дуулал болсон "Миний нутаг" алдарт найраглалаа туурвисан билээ.

Тэгвэл Ц. Дамдинсүрэн хошин шог аястай "Толь Гэндэн", эрдэм боловсролд шамдан шинэ цагийн сэхээтний сэтгэл зүй, эх үрийн ачлал, элбэрлийг нээн дүрсэлсэн "Буурал ижий минь" найраглал байгалийн гоо сайхныг урнаар нээн дүрсэлсэн "Зугаацахаар мордсон минь" мөчлөг шүлгүүдээрээ уянгын шинэ аясаар Монгол яруу найргийг баяжуулав.

Мөн Г.Сэр-Од дөнгөж 23 наслахдаа "Дөмөн" зэрэг уран тансаг дүрслэлтэй уянгын бүтээлүүдээрээ тодорч байлаа. Монголын орчин үеийн уран зохиолд туужийн төрөл түрүүлэн хөгжсөн бөгөөд 1926 онд ардын журамт цэргийн түүхэн явдлын тухай Ц.Дамбадоржийн "Толбо нуур" баримтат тууж нийтлэгдэж Ц.Дамдинсүрэн 1929 онд "Гологдсон хүүхэн" туужаа туурвиж, 1930 хэдэн онд С.Буяннэмэхийн "Малчин Товуудай", Д.Нацагдоржийн "Хөлхээгүй сувд" туужууд зохиогдов.

Өгүүллэгийн төрөл зүйлийн хувьд 1920 хэдэн онд шинэ үзэл санааг үлгэрийн хэлбэрээр илэрхийлсэн үлгэр өгүүллэгүүд гарч аман зохиолын уламжлалтай зууралдангүй байсан бол 1930-аад онд Д.Нацагдорж "Ламбугайн нулимс", "Харанхуй хад", "Хуучин хүү", "Соёлыг гайхав", "Шувуун саарал" зэрэг бичлэгийн олон арга барилаар туурвисан өгүүллэг гарч С.Буяннэмэх "Их тэнгэрийн дүлий", "Жинчин Пүрэвийн жигтэй явдал" өгүүллэгээ хошин шог хэлбэрээр бичсэн нь орчин цагийн өгүүллэгийн төрлийг эзэмших талаар хийсэн их дэвшил байлаа.

1922 онд С.Буяннэмэхийн "Сандо амбан" бүтээлээр гараагаа эхэлсэн жүжгийн зохиол 1930 хэдэн онд сэдэв, төрөл хэлбэрийн аль алинаар баялаг байсан билээ. Энэ үед Д.Нацагдорж "Би биш" инээдмийн болон "Нуугдсан эрдэнэ", "Их авхай" зэрэг драмын жүжиг бичиж 1935 онд "Монголын ардын суут" бүтээлээрээ Сүхбаатарын тухай жүжгийн зохиолын уралдаанд шалгарч улмаар монголын тайзны урлагийн мөнхийн бүтээл болсон "Учиртай гурван толгой" дуурийа туурвисан бол "Баатар хөвүүн Тэмүүжин", "Марал шар", "Шөнийн буг" зэрэг жүжгийн зохиол бичсэн С.Буяннэмэхийн "Харанхуй засаг" жүжгээр манай театрийн урлагийнхан 1935 онд Москва хотноо Олон улсын театрын наадамд тэргүүлж байсан нь монголын орчин үеийн жүжгийн зохиолыг өөрийн оронд төдийгүй дэлхий дахинаа хүлээн зөвшөөрч эхэлсний гэрч юм. Энэ үед жүжгийн зохиолын төрлөөр Ши.Аюуш, Д.Намдаг, Э.Оюун нар авьяасаа сорьж, бүтээлээ туурвисан ба 1920-иод оны сүүлчээр Герман оронд Д.Нацагдоржийн хамт суралцсан Д.Намдаг 1930 онд "Сүрэг чоно" зэрэг жүжгийн зохиолоо туурвиж улмаар 1980 хэдэн оныг хүртэл энэ төрлөөр дагнан бичихдээ жүжгийн зохиолд шинэчлэлийн өөрийн дэгийг бий болгож олон зохиолчийг араасаа дагуулсан юм. 1930 хэдэн онд гадна талаас нь дүрсэлж, хэв шинж голлосон хөрөг дүрээс тодорхой зан төрхтэй, сэтгэл зүйн шинжлэл бүхий уран сайхны дүр бүтээх шинэ шатнаа дэвшсэн, хүүрнэл зохиолд үйл явдалыг тоочин хүүрнэдэг туульсын зохиолын тогтсон загварыг эвдэж, уянгын болон сэтгэл зүйн аяс нэвтрүүлсэн шинэлэг аяс Д.Нацагдорж, М.Ядамсүрэн нарын өгүүллэг туужид тодорхой харагддаг. Ийнхүү монголын уран зохиолчид 1930 хэдэн он гэхэд реализмын аргаар бүтээлээ туурвин монгол үндэстний өвөрмөц хэв шинжийг төлөвшүүлсэн юм. 1940-1950-аад онд Ч.Чимид "Би монгол хүн", Д.Намдаг "Шөнийн бороо", Х.Пэрлээ "Цэнхэр дурдан алчуур" зэрэг утга уянгын шүлэг дуу, Ч.Лхамсүрэн "Хүрэн морь", Ц.Гайтав "Дамдины Сүхбаатар", Д.Цэвэгмид "Булшин дээр" найраглал, Ч.Лодойдамба "Манай сургуулийнхан" тууж, Ч.Ойдов "Далан худалч " гэх мэт шилдэг бүтээлээр монгол уран зохиолын эрдэнэсийн сан баяжиж Ч.Лодойдамба "Алтайд", Б.Ринчен "Үүрийн туяа" зэрэг орчин цагийн монгол романы анхны бүтээлүүд гарсан юм.

Түүнчлэн 1940-1950-аад онд зохиогдсон Ц.Дамдинсүрэнгийн "Бух гомбо", "Солийг сольсон нь", "Багш шавь хоёр" зэрэг ёс суртахууны сэдэвтэй, Ш.Гаадамбын "Тэрэгчний хүү", "Хөдөө талын баясгалан", "Элбэг дээл" зэрэг хөдөлмөрийн хүнийг гол дүрээ болгосон өгүүллэгүүд нь ёс суртахууны хурц асуудал дэвшүүлсэн байдал, бичлэгийн уран чадвар, уран сайхны төвшингөөрөө 1960-1970-аад оны өгүүллэг бие даан хөгжихийн уггал болсон юм. 1960-аад оноос хойших үе бол шинэ маягийн реалист уран зохиолын хөгжлийн маш чухал шат бөгөөд хөгжингүй уран зохиолд байдаг төрөл зүйлийн бүхий л тогтолцоо жигдрэн хөгжиж, урлах эрдэм, утга агуулгаараа дэлхийн реалист уран зохиолын жишигт дөхөж очсон юм. 1960-аад оноос хойш монголын уран зохиолын шинэ төрөл хэлбэрээр баяжсны тодорхой нэгэн жишээ нь роман юм. Энэ үед роман нь монголын орчин үеийн уран зохиолын голлох төрөл болон төлөвшсөн билээ. Ч.Лодойдамба "Тунгалаг тамир", Д.Намдаг "Цаг төрийн үймээн", Л.Түдэв "Уулын үер" романаа, Ж.Пүрэв "Аянга" орчин үеийн сэдвээр С.Дашдооров "Говийн өндөр" романаа туурвиж, орчин цагийн романы ээмших эрлийг хошуучилсан бөгөөд нийгэм аж байдлын сэдэвт олон роман гарч уншигч олны сонирхлыг татсан юм.

С.Буяннэмэх "Шөнийн бүг" жүжгийн хэсэг

1960-1980 хэдэн онд роман бичлэгт түүх хувьсгалын орчин үеийн сэдэвтэй, нийгэм аж байдлын роман зонхилж байсан боловч роман бусад хэлбэрийг эзэмших талаар монголын зохиолчид амжилттай эрэлхийлснийг Б.Ринчен "Заан залуудай", "Их нүүдэл", "Сандо амбан", Ш.Нацагдорж "Мандухай цэцэн хатан", С.Удвал "Их хувь заяа", Ж.Пүрэв "Зүрхний хилэн" зэрэг түүхэн роман, Ц.Цэдэнжав "Хаврын урь", С.Лочин "Үргэлжлэлтэй долоон өдөр", С.Эрдэнэ "Амьдралын тойрог" сэтгэл зүйн роман, Л.Түдэв "Бүгд найрамдах улсын анхдугаар он" улс төрийн роман, С.Лочин "Сүйрэл", Д.Маам "Гишгэх газаргүй хөл"зэрэг бүтээлүүд харуулна.

Үргэлжилсэн үгийн зохиолын бэсрэг, дунд төрөл зүйл болох өгүүллэг туужийн бичлэгт энэ хугацаанд шинэчлэл гарсан гэж болох бөгөөд өгүүллэгт С.Эрдэнэ, туужид Д.Мягмар нар уянга-сэтгэл зүйн аясыг нэвтрүүлэх талаар өөрсдийн туршлагыг бий болгон С.Дашдооров аж байдлын сэдэвт туужуудаараа, П.Лувсанцэрэн сэтгэл зүйн өгүүллэгүүдээрээ тухайн төрөл хэлбэрийг баяжуулж уран сайхны энэ эрэл нээлтийг залгамж үеийн зохиолчид баяжуулсан билээ. Үргэлжилсэн үгийн зохиолд 1970-аад оны сүүл 1980 хэдэн оны эхээр 1960-аад оных шиг шинэ давалгаан гарсан бөгөөд Д.Урианхай "Халуун зуны сүүдэр", С.Пүрэв "Уулын намар", Д.Батбаяр " Цахилж яваа гөрөөс",Ч.Галсан "Аянгат цагийн тууж", П.Баярсайхан "Хөх туурийн тал", "Сахиул", Д.Намсрай "Гандирсын хотын Хандармаа", Д.Төрбат "Могойн чуулган", Д.Энхболд "Шөр хөвийн дөрөлж" тууж, роман болон Б.Догмидын уянгын өгүүллэгүүд нь уянга-сэтгэл зүйн чиглэлээр тухайн төрөл хэлбэрийн өмнөх үеийн ололтыг баяжуулсан төдийгүй урлах эрдмийн хувьд зарим талаар давж гарсан юм. Ц.Доржготов, Ж.Барамсай, Шаг.Цэнд-Аюуш нар шог хошин өгүүллэг тууж бичиж тухайн төрлөөр дагнан мэргэжиж хувь хүний ёс суртахууны төдийгүй нийгмийн шогийн хэмжээнд үнэлэгдэхүйц уран бүтээлийн туршлагыг бий болгов.

1960-1970-аад оны яруу найрагт өнгөц магтаал, ерөнхий уриа тунхагийн бичлэгээс зайлсхийн уянгын аяс тууштай нэвтэрч, утгын гүнзгийрэл, уран санаа, тод дүрслэлтэй бичих талаар ахиц гарсан билээ. Үүнд уянгын яруу найргийн гоо сайхны маш нарийн мэдрэхүй, туйлын уянгалаг зөөлөн дуу хоолойтой, уран найруулгын тохирсон хөг аялгуутай Б.Явуухулангийн эрэл, уран сайхны нээлт үлэмжхэн нөлөө үзүүлсэн юм.

Тэгэхдээ тэр үед шүлэгч бүр өөр өөрийн өвөрмөц бичлэгийн аргатай байсныг Ц.Гайтав, Ч.Чимэд нарын нийтлэл уянга, Д.Пүрэвдоржийн уран цэцэн шүлэглэх аяс, С.Дашдооровын хүүрнэл уянга, М.Цэрэндоржийн бодол бясалгалын сэтгэлгээ, М.Ширчинсүрэнгийн байгалийн болон аж байдлын уянга, Н.Нямдоржийн энгүүн агаад реалист дүрслэл, тэднийг залгамжилсан Ш.Сүрэнжав, П.Пүрэвсүрэн, Д.Нямаа, Т.Галсан, Р.Чойном, П.Бадарч, Ш.Дулмаа нарын өвөрмөц бүтээлүүд харуулж байна. Энэ үед уянга туульсын найраглалын олон хэлбэрээр бичих талаар Д.Пүрэвдорж өөрийн гэсэн туршлагыг бий болгосон юм.

1970-аад онд Л.Лувсандорж, Д.Цоодол, З.Дорж, С.Дулам нар тус тусын өвөрмөц авьяасаар тодров.

1980-аад оны эхээр яруу найргийн уран сайхныг эрхэмлэн өвөрмөц бичлэгээр тогтсон таалал, хэвшмэл байдлыг эвдэн шинэчлэл хийсэн шүлэгч бол Б.Лхагвасүрэн юм. Түүний "Уянгын тойрог" хэмээх шүлэг найраглалын анхны ном нь байгаль болон хүний сэтгэлийн гоо сайхныг нээсэн сонин содон дүрслэл, үгийн утгын харьцааг шинээр нээсэн хурц тод чимэг

Д.Нацагдорж "Учиртай гурван толгой" (1950 он)

зүйрлэл бүхий цэцэн шүлэглэлээрээ тухайн үеийн яруу найргийн намжмал байдал, хэвшмэл загварыг эвдэн олон залуу шүлэгчийг араасаа дагуулж шинэ давалгааг үүсгэсэн юм. Мөн Д.Урианхай бодол эргэцүүллийн найргийг уран сэтгэмжтэй бичих талаар амжилт олж сэрж мэдрэхүйн уянгад байдаг шиг нүдэнд харагдах дүр бус сэтгэн бодохын яруу найргийн хийсвэрлэсэн оюуны дүр бүтээх эрэл хийсэн бол Д.Цоодол монгол найргийн уран тансаг, цэцэн цэлмэг шүлэглэлийн уламжлалыг Өрнө зүгийн сонгодог реалист найргийн сэтгэлгээтэй хослуулж, найргийнхаа урлах эрдмийг төгөлдөржүүлэн үгийн урныг төдийгүй утгын гүнзгийрлийг эрхэмлэн хүний хувь заяа, амьдарч буй эрин цагийнхаа тухай эргэцүүллээ уран тод дүрслэлд шингээн олон шилдэг шүлэг, дууль бичсэн билээ.

Түүнчлэн удтал хамгийн ховорт тооцогдож байсан шог хошин төрөл элбэгших төлөв орж шог инээдэмт санааг Т.Галсан уран хэтрүүллээр, И.Цэрэнжамц уран дүрслэлээр илэрхийлэх бичлэгийн өвөрмөц онцлогоороо энэ төрлийг баяжуулав.

1980 хэдэн оны дунд үеэр Д.Төрбат, Ц.Чимэддорж, Б.Дорж-палам, Д.Нямсүрэн, О.Дашбалбар, Г.Мэнд-Оосё, Ж.Сарантуяа, Б.Энхтуяа, Ш.Гүрбазар, Ч.Мягмарсүрэн, С.Батмөнх нарын зэрэг залгамж үеийн шүлэгчид уншигчидтайгаа танил болж бичлэг, дүрслэлийн өвөрмөц арга барилаараа яруу найргийг баяжуулав. О.Дашбалбар бурхан шашны мөргөл залбиралын аястай шүлгүүдээрээ яруу найргийн сэтгэлгээг баяжуулав.

1990-ээд оны босгон дээр орь залуу насны сэтгэлийн нандин уянгыг орчин үеийн яруу найргийн уран чадварын түвшинд урнаар илэрхийлж бичсэн Б.Ичинхорлоо, Ж.Болд-Эрдэнэ, М.Мөнхцэцэг, Ц.Хулан, Ш.Уянга, Д.Билгүүн нарын залуу шүлэгчид тодорсон юм.

1960 оноос хойшхи хугацаанд монголын жүжгийн зохиолд чанарын том ахиц гарч, агуулга уран сайхан, төрөл зүйлийн хувьд баяжин, жүжгийн зохиол гэдэг ойлголт жинхэнэ учир утгаараа бүрэлдэн тогтсон юм. 1960-1980 хэдэн оныг хүртэлх хугацаанд Д.Намдаг, Л.Ванган, Ч.Чимид, Ч.Лодойдамба, Э.Оюун, Д.Мягмар, Д.Батбаяр, С.Жаргалсайхан нарын олон зохиолч энэ төрлөөр бүтээл туурвиж байсны дотор Л.Ванган, Д.Намдаг нарын уран бүтээл онцгой байрыг эзэлнэ.

Дашдоржийн Нацагдорж (1906-1936). Д.Нацагдорж 1906 онд Түшээт хан аймгийн Дархан Чин Вангийн хошуу эдүгээгийн Төв аймгийн Баяндэлгэр суманд ядуу тайж Дашдоржийн гэрт төржээ.

Д.Нацагдорж 1921-1930-аад онд "Цэнхэрлэн харагдана" ("Ушаан-дар" жүжгийн дуу) (1922 он), "Бүхий олон багачууд" (пионерийн дуу) 1925 он, "Улаанбаатараас Берлин хүртэл" (1929), "Алс газар сурахаар явагч" зэрэг яруу найргийн бүтээлээ туурвиж байсан ч уран бүтээлийн нь идэвхтэй үйл ажиллагаа нь 1930 хэдэн онд хамаарна. Тэрээр 1930-аад онд монголын орчин үеийн уран зохиолын эрдэнэсийн санд орсон "Миний нутаг" найраглал, "Дөрвөн цаг" мөчлөг шүлгүүд, эрүүл энхийн сэдэвтэй ухуулгын шүлгүүд, "Харанхуй хад", "Ламбугайн нулимс" зэрэг өгүүллэгүүд, "Учиртай гурван толгой" дуурь зэрэг шилдэг бүтээлүүдээ туурвиж явжээ.

Шинэ монголын уран зохиолын үндэс суурийг тавигч Д.Нацагдорж нь яруу найраг, үргэлжилсэн үг, жүжгийн зохиолын бүх төрөлд шинэ хэлбэр, шинэ агуулгын замыг анх түрүүн нээгчдийн нэг байлаа.

Д.Нацагдоржийн авъяас билэг нь яруу найрагт хамгийн ихээр тодордог бөгөөд юу бичивч үргэлж л яруу найрагч байдаг хэмээн хэлэхэд төдий л хэтрүүлэл болохгүй гэж бодогдном.

Д.Нацагдорж (1906-1936 он)

Д.Нацагдорж "Ламбугайн нулимс", "Хөдөө талын үзэсгэлэн", "Шувуун саарал", "Харанхуй хад", "Хэлхээгүй сувд" тууж зэргээрээ сонгодог зохиолчийн зиндаанд хүрч ардын үлгэр, хууч яриа домгийг эс тооцвол монгол бичгийн уран зохиолд үргэлжилсэн үгийн богино төрөл сонгодог утгаараа төдий л хөгжөөгүй нөхцөлд тухайн төрөл хэлбэрийн жишгийг тогтоосон юм. "Майн нэгнийг хөрөнгөтний газар үзжээ", "Ээрхэг түрэмгий байлдаан", "Аугаа хүчтэн" нийтлэл тэмдэглэл, "Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе", "Өвлийн хүйтэн янагийн халуун", "Хоёр ишиг" зэрэг зураглал, "Цагаан сар ба хар нулимс", "Ламбугайн нулимс", "Соёлыг гайхав", "Үзэгдээгүй юм", "Хуучин хүү", "Шувуун саарал" өгүүллэг, "Харанхуй хад" тууръ, "Хэлхээгүй сувд" тууж зэрэг төрөл хэлбэрт хуваан ангилж болно.

Тэрбээр 1930 хэдэн онд "Учиртай гурван толгой" эмгэнэлт дуурь, "Би биш" инээдмийн жүжиг "Монгол ардын суут", "Нуугдсан эрдэнэ", "Ондоо хүмүүжил", "Их авхай" зэрэг жүжгийн зохиолын олон төрөл хэлбэрээр туурвиж 1935 онд "Монгол ардын суут" бүтээлээрээ Д.Сүхбаатарын тухай жүжгийн зохиолын уралдаанд шалгарч байлаа. Ялангуяа түүний "Учиртай гурван толгой" дуурь (1934) монголын жүжгийн зохиолд шинэ замыг нээсэн билээ.

Цэндийн Дамдинсүрэн (1906-1986). Монголын шинэ үеийн уран зохиолын анхны төлөөлөгчдийн нэг ардын уран зохиолч, нэрт эрдэмтэн, академич Цэндийн Дамдинсүрэн 1908 онд хуучин Сэцэн хан аймгийн Матадхан уулын хошуу одоогийн Дорнод аймгийн Матад сумын нутагт малчин ардын гэр бүлд төржээ.

Ц.Дамдинсүрэн анхны боловсролыг өвөг эцэг Эрэгзэндоной, эцэг Цэнд нарын ачаар гэрийн сургуулиар олж, монгол аман болон бичгийн уран зохиол, дорно дахины үгийн урлагийн дээжистэй багаасаа танилцсан байна.

1933-1938 онд ЗХУ-ын Ленинградын (хуучин нэрээр) дорно дахиныг судлах дээд сургуульд, 1946-1950 онд аспирантурт суралцан, 1957 онд профессор цол, 1970 онд докторын зэрэг хүртэн, 1961 оноос ШУА-ийн жинхэнэ гишүүн (академич)-ээр сонгогдон, 1986 онд БНМАУ-ын ардын уран зохиолч цол хүртжээ. Төр засгаас уран бүтээлд нь төрийн шагналыг гурван удаа олгосон байна. 1970 онд Фин-Уйгорын нийгэмлэгийн сурвалжлагч гишүүн, 1973 онд Унгарын Чома де Керешийн нэрэмжит дорно дахины нийгэмлэгийн хүндэт гишүүнээр сонгогдсон байна. 1950 хэдэн онд Дэлхийн энх тайвны зөвлөлийн тэргүүлэгч гишүүнээр сонгогдож байлаа.

Ц.Дамдинсүрэн нь Д.Нацагдорж, С.Буяннэмэх нарын хамт монголын шинэ утга зохиолын үндсийг тавилцсан билээ. Уран бүтээлийнхээ анхны гараат 1927 оноос үлгэр-өгүүллэгүүдээрээ эхэлж, шинэ монголын хувьсгалт утга зохиол анхны алхмаа хийж байсан 1929 онд дөнгөж 21 насандаа түүний бичсэн "Гологдсон хүүхэн" тууж бол ард түмний дүрийг гол баатар болгон дэвшүүлжээ. 1930 хэдэн онд "Буурал ээж минь", "Зугаацахаар мордсон нь" зэрэг шүлэг, найраглал, 1940-1960-аад онд "Солийг сольсон нь", "Хэлдэг гурав хийдэг ганц", "Чемодантай юм", "Хачин хурим", "Хоцрогдсон эмгэнийг сурвалжилсан нь" зэрэг өгүүллэг бичсэн нь монголын шинэ үеийн уран зохиолын шилдэг бүтээлийн тоонд ордог.

Ц.Дамдинсүрэн гарамгай орчуулагч бөгөөд ялангуяа оросын их найрагч А.С.Пушкины "Олег цэцэний дуулал", "Алтан загасны үлгэр" зэрэг зохиолуудыг чадамгай сайн орчуулсан нь ард түмний дунд

Ц.Дамдинсүрэн
(1906-1986)

ихэд дэлгэрч нэг ёсондоо ардын уран бүтээл болсон юм.

Академич Ц.Дамдинсүрэн бол Монголд утга зохиолын түүхийн шинэ судлалыг үндэслэн, түүнийг тогтолцоотой шинжлэх ухаан болгон, мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлэхэд бүхий л амьдралаа зориулж, хэл бичгийн ухаанд дорвитой хувь нэмэр оруулсан шинжлэх ухааны ахмад зүтгэлтэн юм.

Ц.Дамдинсүрэн эрдэм шинжилгээний гол ажлаа монголын хуучин утга зохиолын түүхийн судлалд зориулсан юм. Монголын хуучин уран зохиолын гурван оргилын нэг гэж алдаршсан алдарт дурсгалт бичиг "Монголын нууц товчоо"-г эртний монгол хэлнээс өнөөгийн монгол хэлнээ утгыг алдахгүй, урыг гээгдүүлэхгүй иш үндэс болгон хөрвүүлж, 1947 онд дуусган, судалгааны оршилтойгоор хэвлүүлсэн нь түүний эрдэм судлалын ажлын анхны том үнэлэлт болсон юм.

Ц.Дамдинсүрэн "Гэсэр"-ийн туужийн олон хувилбарыг хэвлүүлсний зэрэгцээ 1956 онд "Хоёр загалын тууж", "Чингис хааны есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шастир", "Убаши хун тайжийн тууж", 1957 онд "Хуульч Сандагийн зохиолууд", 1958 онд "Оюун түлхүүрийн тайлбар", "Мандхай сэцний домог" зэрэг эртний уран зохиолын дурсгалт бичигт эх бичгийн судалгаа хийн оршил тайлбартайгаар хэвлүүлсэн билээ. Үндэсний утга зохиол, соёлын өв уламжлалыг судлан нээж, эрдэм шинжилгээний хүрээнд оруулах талаар хийсэн томхон бүтээл нь 1959 онд хэвлүүлсэн "Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой" хэмээх дээж бичиг юм. Үүний зэрэгцээ монголын уран зохиолын хөгжлийн ерөнхий зүй тогтол, гол зангилаа асуудлын талаар "Хуучин уран зохиолын доторхи ардчилсан чиглэл" (1955), "Монголын утга зохиолыг судалсан түүхээс" (1956), "Монгол хэл бичгийн тухай" (1957), "Соёлын өвийг хамгаалъя" (1958), "Монголын уран зохиолын судлалын зарим асуудал" (1959), "Монголын хуучин уран зохиолын тоймыг зохиосон туршлагаас" (1974) зэрэг уран зохиолын хөгжлийн ерөнхий зүй тогтлыг тодруулсан онол түүхийн зангилаа чухал асуудлаар олон ном өгүүлэл туурвисан билээ. Ц.Дамдинсүрэн "Монголын уран зохиолын тойм"-ын нэгдүгээр дэвтрийг зохиосон нь 1956 онд хэвлэгджээ.

"Монголын уран зохиолын тойм"-ын хоёр, гуравдугаар ботийг Ц.Дамдинсүрэн бичилцэн, эрдэм шинжилгээний удирдагч, редактороор ажиллажээ. Мөн монгол энэтхэгийн эртний уламжлалт харилцаа холбооны асуудалд зориулан бичсэн "Рамаяна Монголд дэлгэрсэн нь" гэдэг зохиолдоо монголын судлалд урьд өмнө мэдэгдээгүй байсан төвөд монгол эх бичгүүдийг уншигч, судлаач нарт танилцуулан, энэтхэгийн алдарт тууль Рамаяна монголд эрт дээр цагаас нэвтэрч, түгээмэл дэлгэрч байсныг тодруулжээ.

Мөн орчин цагийн монгол хэлний авиазүй, үгзүйн бүтцийг оновчтой зөв тусган ярианы болон бичгийн хэлийг аль болохоор ойртуулсан шинэ үсгийн дүрэм, зөв бичих зүйн толийг анхлан боловсруулсан билээ.

Академич Ш.Лувсанвандангийн хамт "Орос-Монгол толь" (1942), А.Лувсандэндэвтэй хамт дэлгэрэнгүй "Орос-Монгол толь" (1965-1968, 1983), Германы монголч эрдэмтэн П.Фитце нарын хамт Герман-Монгол толь" тус тус зохиосон нь толь зүйн төдийгүй үгсийн сангийн судлалын хувьд үнэтэй томоохон бүтээлүүд болж, хөдөлмөрчдийн гадаад хэлний боловсролыг дээшлүүлэхэд чухал хэрэглэгдэхүүн болж байна.

Х.Сампилдэндэв
С.Уранбилэг

Ном зүй

1. Бадамхатан.С. Хөвсгөлийн цаатан ардын аж байдлын тойм. УБ 1962.
2. Бадамхатан.С. Хөвсгөлийн дархад ястан. УБ 1965.
3. Бадрал.С. Монголын эртний чулуун баримал. УБ 2001.
4. Бадрал.С. Хүннүгийн дүрслэх урлагийг ажиглан шинжихүй. УБ 1997.
5. Бадрал.С. Монгол хиймори салхин хүлэг. УБ 2003.
6. Бадрах .Г. Монголын хөгжмийн түүхээс УБ 1960.
7. Бира .Ш. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. I. УБ 1977. II.Токио 1994. III.УБ 2001.
8. Болдбаатар.Ж., Лүндээжанцан.Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ 1997.
9. Гаадамба.Ш., Сампилдэндэв.Х. Монгол ардын аман зохиол. УБ 1988
10. Гэрэлбадрах.Ж. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ 2002
11. Гонгор.Д. Халх товчоон. I боть УБ.1970. II боть УБ.1976
12. Далай.Ч. Монголын түүх. I дэвтэр УБ 1992. II дэвтэр УБ 1994. III дэвтэр УБ 1996.
13. Далай.Ч. Их монгол улс (1206-1260).УБ. 1994.
14. Дашбадрах.Д. Монголын хутагтууд. УБ 2004.
15. Дашдондог.Ч. Монгол киноны түүхэн тэмдэглэл. УБ 1971.
16. Дашдондог.С. Жаран жилийн шаштир (Монголын орчин үеийн театрын урын сангаас) УБ 1974.
17. Дамдинсүрэн.Ц. Монголын уран зохиолын тойм. УБ 1958.
18. Жамсран нар. Монголын түүхийн бага нэвтэрхий толь. I боть УБ 1998. II боть УБ 2000. III боть УБ 2002.
19. Жүгдэр.Ч. Монголд феодализм тогтох үеийн нийгэм, улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ 1972.
20. Жүгдэр.Ч. XIX-XX зууны зааг үеийн Монголын нийгэм, улс төр, философи сэтгэлгээний хөгжилт. УБ 1972.
21. Жигжидсүрэн.С. Монгол орны малын тэжээлийн ургамал. УБ 2003.
22. Ишжамц.И. Монголын нэгдсэн улс байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ 1974.
23. Ишжамц.И. Монголын төр ёсны уламжлалын асуудал (Дорно дахины судлалын асуудал.) 1986, 33,42,47-51 дэх тал.
24. Майдар.Д. Монголын архитектор ба хот байгуулалт. УБ 1972.
25. Монголын уран зохиолын тойм. II боть УБ. 1968 III боть УБ 1976.
26. Монголын орчин үеийн уран зохиолын түүх. I боть УБ 1995. II боть УБ 1998.
27. Монголын хөгжим судлал. УБ 1989.
28. Монголын цэргийн түүхийн товчоон. I боть, II боть. УБ 1996.
29. Монгол улсын түүх. Тэргүүн боть, дэд боть, гутгаар боть, дөтгөөр боть,тавдугаар боть. УБ 2003.
30. Монголын нэвтэрхий толь. I боть,II боть. УБ 2001.
31. Монголын нууц товчоо. УБ 1990, 202 дугаар зүйл.
32. Монгол орны байгаль орчны төлөв байдал. УБ 2000.
33. Монголын улаан ном. УБ 1987. 1997.
34. Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас. УБ 1979.
35. Монгол улсын угсаатны зүй. Тэргүүн дэвтэр. УБ 1987. дэд дэвтэр. УБ 1996. гутгаар дэвтэр. УБ 1996.
36. Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал. УБ 1999.
37. Монголын соёлын түүх. тэргүүн боть, дэд боть, гутгаар боть. УБ 1999.
38. Монголын сайхан орон. УБ 1981.
39. Нацагдорж.Ш. Халхын түүх. УБ 1963.
40. Нацагдорж.Ш. Монголын феодализмын үндсэн замнал. УБ 1987.
41. Нямбуу.Х. Монгол хувцасны түүх. УБ 2001.
42. Очир.А. Монгол улсын ойрадуудын түүхийн товч. УБ 1993.
43. Очир.А. Дисан.Т. Монгол улсын өөлдүүд. УБ 1999.
44. Очир.А. Гэрэлбадрах.Ж. Халхын засагт хан аймгийн түүх. УБ 2002.
45. Оюун.Э. Монголын театрын түүхэн замнал. УБ 1989.
46. Өлзийхутаг.Н. Монгол орны ургамлын аймгийн тойм. УБ 1989.
47. Пэрлээ.Х. Монгол ард улсын эрт, дундад үеийн хот, суурины товчоон. УБ 1961.
48. Пэрлээ.Х. Монгол тумний гарлыг таамгаар хайж судлах нь. УБ 1975.
49. Пэрлээ.Х. Хятан гүрэн,тэдний монголчуудтай холбогдох нь. УБ 1959.
50. Сампилдэндэв.Х. Монгол яруу найргийн товчоон. УБ 1996.
51. Сампилдэндэв.Х. Монголын уран зохиолын зарим асуудал. УБ 1998.
52. Санждорж.М. Ардын төрийн түүх. УБ 1974.
53. Санждорж.М. Монгол төрийн түүхээс. УБ 1998.
54. Соёлын өв хадгалагч. Соёл урлагийн газар. УБ 1999.
55. Сумъяа.Б. Монголын нүүдэлчдийн соёл. УБ 1998.
56. Сүхбаатар.Г. Сяньби. УБ 1971.
57. Сүхбаатар.Г. Монголчуудын эртний өвөг. УБ 1980.
58. Сүхбаатар.Г. Монгол Нирун улс. УБ 1992.
59. Төмөржав.М. Бэлчээрийн монгол мал. УБ 1989.
60. Төмөртогоо.Д. Монгол хэлний түүхэн хэлзүй I. УБ 1992.
61. Үндэсний атлас (БНМАУ). УБ 1990 Москва.
62. Хүрэлбаатар.Л. Сонгодог уламжлал, Монгол яруу найраг. УБ 1989.
63. Хүрэлбаатар.Л. Монгол орчуулгын товчоон. УБ 1995.
64. Цэвээндорж.Д. Монголын эртний урлагийн түүх. УБ 1999.
65. Цэвээндорж.Д. Монголын археологийн судалгаа. I боть, УБ 2002. II боть, УБ 2003.
66. Цэрэнсодном.Д. Монголын уран зохиол. Бээжин, 1983.
67. Цэрэнсодном.Д. Монголын бурханы шашны уран зохиол. УБ 1997.
68. Шагдарсүрэн.Ц. Монголчуудын утга соёлын товчоон. УБ 1991.
69. Шагдарсүрэн.Ц. Монголчуудын үсэг бичгийн товчоон. УБ 2001.
70. Шүгэр.Ц. Монголчуудын ном хэвлэдэг арга. УБ 1976.
71. Энэбиш.Ж. Монголын хөгжмийн уламжлал шинэчлэл. УБ 1991
72. Владимирцов.Б.Я. Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм. Ленинград, 1934.
73. Гумилев.Л.Н. Древняя Русь и Великая степь. Москва, 1989.
74. Грумм-Гржимайло Г.Е. Западная Монголия и урянхайский край. Т-II. Ленинград 1926
75. Деревянко.А.П., Дорж.Д., Василевский.Р.С., Ларичев.В.Е., Петрин.Б.Т. Археологические исследования в Монголии. Новосибирск, 1990.
76. Дорж.Д. Неолит Восточной Монголии. УБ, 1971.
77. Доржи Банзаров. Собрание сочинений. Улан-Удэ, 1997.
78. Златкин.И.Я. История Джунгарского ханства. Москва, 1983.
79. Кара Доржи. Книги монгольских кочевников. Москва, 1972.
80. Майдар.Д. Архитектура и градостроительство Монголии. Москва, 1971.
81. Михайлов.Т.М. Бурятский шаманизм. Новосибирск, 1987.
82. Окладников.А.П. Центрально-азиатский очаг первобытного исскуства. Новосибирск, 1972.
83. Позднеев.А.М. Монголы и Монголия. Т-I, СПб., 1896.
84. Потанин.Г.Н. Очерки Северо-Западной Монголии. СПб., 1886.
85. Радлов.В.В. Атлас древности Монголии. СПб.,1911.
86. Ткачёв.В.Н. История монгольской архитектуры. Москва, 1989.
87. Цултэм.Н. Искусство Монголии. Москва, 1984.
88. Щепетильников.Н.М. Архитектура Монголии. Москва, 1960.
89. Ala-Al-Din Ata-Malik Juvairu. The History of the World Conqueror. Translated by J.A.Boyle. Manchester, 1958.
90. Bawden.Ch. The modern history of Mongols. London, 1964.
91. The Mongol World Empire 1206-1370. London 1977.
92. Lattimore.O. Inner Asian frontiers - defensive empires and conquest empires. London, 1962.
93. D'Osson. Histoire des Mongols. Paris, 1824.
94. Howorth.H. History of the Mongols from the 9th to 19th century. Tomus I-III. London, 1876.
95. History of Civilizations Central Asia. UNESCO Publishing, T-I, 1992; T-II, 1998, T-IV, 1998.
96. Morgan.D. The Mongols. Oxford, 1986.
97. Mongolia: Politics, economics and society. Historical dictionary of Mongolia. London, 1996.

ISBN 99929-5-989-4

[illegible]